

ПОЛИТОЛОГИ III

Эрдэм шинжилгээний бичиг

¹ ... (...)

Сэтгүүлийн зөвлөл:

Эрхлэгч:	Ш.Содном, доктор, тэргүүлэх профессор
Нарийн бичгийн дарга:	Ж.Төртогтох, доктор, дэд профессор
Гишүүд:	Д.Содномгомбо, доктор, зөвлөх профессор Ц.Ганболд, доктор, тэргүүлэх профессор С.Базарпүрэв, доктор, профессор Ё.Довчин, доктор, профессор А.Юндэндорж, доктор (Sc.D), профессор А.Жамбал, ШУА, ФСЭХ-ийн дэд захирал, хүрээлэнгийн профессор
Дугаарыг эрхэлсэн:	Д.Содномгомбо, Ж.Төртогтох
Компьютерт шивсэн:	Д.Түмэнжаргал

Хаяг:

Улаанбаатар хот, Залуучуудын өргөн чөлөө
МУИС-ийн хичээлийн II байр
Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Улс төр судлалын тэнхим, Орчин
үеийн улс төрийн судалгааны төв

Утас: 312659, 318641

Факс: 976-11- 328890

ПОЛИТОЛОГИ III

Эрдэм шинжилгээний бичиг
1 ... (...)

Хэвлэлтэнд 2007 оны IX сар
Цаасны хэмжээ 60*90 1/8
Хэвлэлийн хуудас ...
Хэвлэсэн тоо ... ширхэг

Улаанбаатар 2007 он
МУИС-ийн Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ПОЛИТОЛОГИ III

Эрдэм шинжилгээний бичиг

¹ ... (...)

АГУУЛГА

4 Өмнөх үг

Улс төрийн шинжлэх ухааны түүх, онолын асуудал

6 Г.В.Ф. Гегелийн улс төрийн сургаал
А. Жамбал, Ж.Жаргал

15 Улс төрийн философийг тоймлох нь
Д.Содномгомбо

19 Нам төвтэй улс төрийн системийн талаарх өрнөдийн шинжээчдийн үзэл
бодол
А.Юндэндорж, Ю.Ганболд

25 Улс төрийн соёл: институциональ хэмжээс
Ё.Довчин

36 Монгол улсад улс төрийн шинжлэх ухаан үүсэн төлөвшиж байгаа нь
А. Жамбал

51 Францын улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн үндсэн хандлага ба улс
төрийн засаглалын үзэл баримтлал
Г.Цэнд-Аюуш

57 Орчин үеийн төрийн бюрократ удирдлага, түүний уламжлал,
шинэчлэлийн чиг хандлага
Ц.Батболд

Улс төрийн шинжлэх ухааны судалгаа, сурталчилгаа

79 Монгол дахь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны сургалт
судалгааны зарим асуудалд
Ц.Ганболд

- 85 Монгол дахь авилгалын түвшинд нөлөөлөгч хүчин зүйлс: баримт бичгийн ба тоон судалгааны анализ
Ж.Төртогтох, Д.Оюунчимэг, Ч.Өлзийсайхан
- 101 Монголын улс төрийн системийн өөрчлөлт ба элитүүд
Ч.Өлзийсайхан
- 120 Монголын улс төрийн системийн бүрдэлжилт
Ю.Атар
- 127 Залуучууд ба засаглал
Г.Цэнд-Аюуш
- 137 Улс төрийн астрологи - улс төрийн прогнозчлолын арга болох нь
Д.Мягмарсүрэн
- 145 Сонгуулийн тогтолцоо ба улс төрийн тогтвортой байдлын шүтэлцээний асуудалд
Б.Энхмандах
- 152 Ядуурал, тэгш бус байдал нийгэм - улс төрийн мөргөлдөөний сурвалж болох нь
Р.Болд
- 165 Эмэгтэй улс төрчийн имиж бүрдүүлэлт
Д.Оюунчимэг
- Улс төрийн шинжлэх ухааны мэдээлэл, танилцуулга, туршлага***
- 172 Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны дэлхийн XX их хурал
Ц.Ганболд
- 179 Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны хөгжил, улс төр судлаач бэлтгэх асуудалд
С.Базарпүрэв
- 184 Итгэл алдрахуй: эмэгтэйчүүд ба гүйцэтгэгч
Я.Төгөлдөр
- 190 Төрийн зүтгэлтний судалгааны асуудалд
Б.Долгор
- 196 Улс төр судлалын сургалтын агуулга, хөтөлбөр: Сөүлийн Үндэсний Их Сургуулийн жишээн дээр
Ж.Төртогтох
- 206 Нийтлэлийн шаардлага, стандарт

ӨМНӨХ ҮГ

Сэтгүүлийн зөвлөл

Д.Содномгомбо, доктор, зөвлөх профессор

Нийгмийн урагшлах хөдөлгөөний аясаар боловсролын систем бүхэлдээ өөрчлөгдөн шинэчлэгдэж, дэгжин дэвшиж байна. Энэхүү үйл явцад өнгөрсөн үеийн түүхэн шилдэг уламжлал сэргээгдэх, нэгэнт буй болсон үндэс суурь батжиж бэхжих, үндэсний багшлах боловсон хүчнүүдийн санал, санаачлага, зохиол бүтээл, гадаадын шилдэг туршлага практикт нэвтэрч хэрэгжих, агуулга гүнзгийрэх, хэлбэр баяжих ариун үйл дэлгэрч байна.

Ерөнхий боловсролын систем шинэ үе шатанд гарч байна. Суралцагч хүүхэд залуучууд ачит багш нарынхаа зааж сургасан эрдмийн үр шимийг хийж гүйцэтгэсэн ажлынхаа цалин хөлсөөр дамжуулан хүртдэг болж байна.

Монгол улсын дээд боловсролын систем өргөжин тэлж, олон хөвгүүд, охидыг суралцуулан төгсгөж байгаа нь сайшаалтай хэрэг. Хэрэв улсын болон хувийн их, дээд сургуулиуд сонгосон мэргэжилдээ эзэн болсон, төгсөөд олдсон ажлыг чанартай хийж гүйцэтгэж чаддаг мэргэжилтэн бэлтгэн гаргадаг бол бүр ч их сайн баймаарсан. Тооноос чанарыг, хувь хувийн олз ашигаас улс орны хэрэгцээ, шаардлагыг эрхэмлэх нь чухал.

Дээд боловсролын системийн эхлэл болсон Монгол Улсын Их Сургуулийн хувьд байдал өөр байна. Нэг талаар төр, засаг, түүний дотор БСШУЯ-ны удирдлага, анхаарал халамж, нөгөө талаар сургуулийн удирдах зөвлөл, Ректорын зөвлөл, Эрдмийн зөвлөлийн шинжлэх ухааны үндэслэлтэй удирдлага-зохион байгуулалт, хамт олны санал санаачилга, идэвхи зүтгэлийн ачаар их сургууль маань өргөжин тэлж, түүний сургалтын техник хэрэгсэл, номын сан шинэчлэгдэн арвижиж, орон байрны хангамж сайжирч, багш нарын эгнээ шинжлэх ухааны түгээмэл ба нарийн гүн гүнзгий боловсрол, соёл, сургалт, заах арга, судалгааны авъяас чадвартай, шинийг сэдэж санаачилдаг, нээлт гаргадаг, зохиож бүтээдэг шижгэр залуусаар өргөжиж, залуу, дунд, ахмад үеийнхний залгамж холбоо бэхжиж, бие биесээ харилцан нөхөн сэлбэлцэж байна. Тэдний нээлт, бүтээлүүд улс орны төдийгүй олон улсын практикт нэвтэрч байгаа нь бахархалтай хэрэг юм.

Сүүлийн жиүүдэд МУИС-ийн бүрэлдэхүүн хэсгүүд, багш, эрдэм шинжилгээний ажилтнуудын дунд амжилт, бүтээлээрээ өрсөлдөх уур амьсгал буй болсныг түүнийг манай удирдлага хөхүүлэн дэмжсээр ирлээ. Зүй ёсны шударга өрсөлдөөнд улс төр судлалын тэнхим ч мөчөөгөө өгөлгүй ажиллаж ирлээ. Түүний нэгэн жишээ бол шаталсан сургалтын агуулгын гүнзгийрэлт, хэлбэрийн баяжилт, эрдэм шинжилгээний нэг бүрчилсэн, хамтарсан бүтээлүүдэд, гадаадын эрдэмтэдтэй хүч хавсарсан төсөл, гадаадын дээд сургуулиудын ижил мэргэжлийн өрнүүлж буй хамтын ажиллагаа зэрэг юм.

Тэнхимээс хичээлийн жил тутамд бэлтгэж, хэвлүүлдэг эрдэм шинжилгээний цуврал сэтгүүл бол манай эрдэм шинжилгээний ажлын нэг чухал хэсэг юм.

Сэтгүүлийн чанар чансаа жил ирэх тутам дээшилж ирсэн нь тэнхимийн өсөлт, бэхжилтийн үзүүлэлт мөн. Хэрэв сэтгүүлийн анхны дугаар улс төрийн

шинжлэх ухааны сурах, суралцах, бусад материалыг хялбарчилан ашигласан байдалтай байсан бол сүүлчийн дугаарууд нь бүтээлч чанарыг дээшлүүлэх зорилгоо үндсэндээ хангаж ирлээ.

Жишээ нь энэ 2007 оны дугаарт: нэг, орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүйн шинэхэн ололтыг боломжийн хэрээр тусгасан; хоёр, Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоо, Сөүлийн Үндэсний Их Сургуулийн үйл ажиллагааны зорилго чиглэл, арга, туршлага; гурав, тэнхимийн магистрант, докторантын судалгааны бүтээлээс оруулсан; дөрөв, улс орны нийгэм-улс төрийн амьдралын тодорхой, зарим талаар тулгамдсан асуудлын социологийн судалгааны үр дүнг харуулсан байна.

Сэтгүүлийн дурьдан буй дугаар манай орны нийгэм-улс төрийн амьдрал, тус салбарын ажилтан, мэргэжилтэн, судлаачид, багш, суралцагсдад ойр дөт болсоноор танин мэдэхүй, практикийн ач холбогдолтой юм.

Хариуцагчид сэтгүүлийнхээ энэхүү дугаарыг ямар ч өө сэвгүй болсон гэж үзэхгүй. Хэрэв түүнээс алдаа мадаг илэрвэл тэнхимийн хаягаар мэдэгдэж, манай ажилд гүн туслалцаа үзүүлэхийг уншигч эрхэм Танаас гүнээ итгэмжлэн хүсэж байна.

2007 оны IX сар

Г.В.Ф. ГЕГЕЛИЙН УЛС ТӨРИЙН СУРГААЛ

А.Жамбал

ШУА, ФСЭХ-гийн дэд захирал, хүрээлэнгийн профессор

Ж.Жаргал

Германы агуу их гүн ухаантан, улс төрийн сэтгэгч Георг Вильгельм Фридрих Гегель (1770-1831) Штутгарт хотод санхүүгийн томоохон албан тушаалтны гэр бүлд төржээ. Тюбингений их сургуульд шашны онолын факультетийг төгссөн ба хожим нь Берлиний их сургуульд философийн тэнхимийг толгойлох болсон байна. Түүний үзэл санаа Францын хөрөнгөтний агуу их хувьсгалын нөлөөгөөр төлөвшжээ.

Гегель улс төр, эрх зүйн асуудлыг амьдралынхаа бүтээн туурвих бүхий л шатанд чухалчлан авч үзжээ. Түүний улс төрийн ба эрх зүйн сургаал нь “Оюун санааны феноменологи” (1807), “Философийн шинжлэх ухааны нэвтэрхий толь” (1821), “Түүхийн философийн лекцүүд”, ялангуяа “Эрх зүйн философи” (1821) хэмээх томоохон зохиолуудад тусчээ. Гегелийн эрх зүйн философи ба улс төрийн сургаал бол дэлхий нийтийн хэмжээний улс төрийн ба эрх зүйн сэтгэлгээний түүхэнд том, онцгой байр суурь эзэлдэг, утга агуулгаараа нэн баялаг, нарийн нийлмэл сургаал мөн болно.

Гегелийн философийн систем нь бүхэлдээ хөгжлийн үзэл санаагаар нэвтэрхий билээ. Маркс Гегелийн философи бол аливаа диалектикийн үндсэн хэлбэр гэж үнэлжээ.

Гегелийн философи ёсоор бодит байдлын үндэс бол “дэлхийн оюун санаа” мөн бөгөөд түүний бүтээлч үйл ажиллагааг Гегель “туйлын санаа” гэж нэрлэжээ. Тэр нь үйлч, бүтээлч чанартай эхлэл ба өөрийгөө сэтгэхүйн хөгжлөөр илэрхийлж харуулна. Туйлын санаа нь байнга хувьсаж хөгжинө, тэр явцад өөрийгөө танин мэдэж ухамсарлна, хийсвэрээс тодорхойд шилжинэ. Тэрээр хөгжил, өөрчлөлтийн үндсэн гурван үе шат, төлөв байдлыг дамжина.

Туйлын санаа өөрийн хувийн дэвсгэр суурин дээр цэвэр сэтгэхүй буюу логикийн хэлбэрээр оршино. Туйлын санаа хөгжлийнхөө хоёрдугаар шатад өөр төлөв байдлаар, тухайлбал байгал, байгалийн үзэгдлийн хэлбэрээр илэрнэ, гуравдугаар шатад хүн төрлөхтөний түүх, оюун санааны түүхийн хэлбэрээр илэрнэ. Үүнийг Гегель оюун санааны философи гэж нэрлэжээ.

Гегелийн улс төрийн ба эрх зүйн сургаал нь түүний философийн системийн гурав дах хэсэг буюу оюун санааны философийн хэсэгт агуулагджээ. Гегелийн философийн системд оюун санаа нь дотроо мөн гурван үе шат, төлөв байдлыг дамжин хөгжиж өөрчлөгдөнө. Тэдгээр нь I. Субъектив оюун санаа, түүнд: антропологи, феноменологи, сэтгэл судлал, ухамсар, өөрийн ухамсар, оюун ухаан багтана. II. Объектив оюун санаа: эрх

зүй, ёс суртахуунт чанар (моральность), зан суртахуун, иргэний нийгэм, төр. III. Туйлын оюун санаа: урлаг, шашин, философи. Гегелийнхээр тийнхүү эрх зүй ба төр нь объектив оюун санааны байдлаар илэрнэ.

Эрх зүйн философи нь Гегелийн философийн системийн нэн чухал хэсэг юм. Төр ба эрх зүйг философийн үүднээс үзэж ойлгох явдалын гол зорилт бол төр ба эрх зүйг шинжлэх ухааны үүднээс судлан ойлгох явдал болохоос биш тэдгээр нь ямар байх ёстой, тэдгээрийг хэрхэн яаж өөрчлөх тухай асуудал огт биш юм. Төр ба эрх зүйг тийнхүү шинжлэх ухааны үүднээс танин мэднэ гэдэг бол төрийн үзэл санаа, эрх зүйн үзэл санааг илэрүүлэн гаргана гэсэн үг юм. Учир нь бодотой оршин буй төрийн үндэс, мөн чанар нь төрийн үзэл санаа байдаг.

Гегель тийнхүү эрх зүйн философийн судлах зүйл нь эрх зүйн үндэс болж байдаг үзэл санаа, тэр санаа эрх зүйгээр хэлбэржиж, хэрэгжин илэрч байгааг судлах явдал гэж үзжээ. Тийнхүү эрх зүйн философи нь хууль зүйн шинжлэх ухааны судалдаг батлан гаргасан хуулиас өөр зүйлийг, чухамдаа эрх зүйн үндэс суурь болж байгаа үзэл санааг судлах ёстой ажээ.

Гегелийн философийн системд суурь шинжтэй байдаг хамгийн гол чухал зарчим, санаа бол сэтгэхүй ба ахуй хоорондоо тохирч нийцэх тухай санаа, зарчим байдаг. Энэхүү гол зарчим түүний эрх зүйн философид илрэхдээ ухаалаг зүйл ба бодит байдал хоёр хоорондоо тохирох тухай санаагаар илэрчээ. Гэхдээ бодит байдал гэдэг нь бодитойгоор оршин буй бүх зүйл биш, харин зайлшгүйгээр оршин буй зүйл юм. Гегель эл үзэл санаагаа: “Юу, ямар зүйл ухаалаг байна уу, тэр зүйл бодотой байна, юу, ямар зүйл бодитой байна уу, тэр нь ухаалаг зүйл мөн” гэсэн томъёоллоор илэрхийлжээ.

Гегель улс төрийн сургаалаа эрх зүйг авч үзэж судлах явдалаас эхэлжээ. Эрх зүйн үзэл санаа бол эрх зүй ба түүний хэрэгжилт, биежилтийн нэгдэл юм. Гегелийн тодорхойлсоноор эрх зүй бол эрх чөлөөт хүсэл зоригийн бодит ахуй юм. Эрх зүйн үзэл санаа бол утгаа эрх чөлөө ажээ.

Эрх чөлөө нь объектив оюун санааны хүрээнд анх удаагаа бодит хэлбэртэй болж хэрэгжин биежнэ, төр ба эрхийн байдлаар хэлбэржинэ. Өөрөөр хэлбэл Гегелийнхээр эрх зүйн үзэл санаа нь жинхэнэ бодит эрх зүйн үндэс болж, түүнээс урьдчилан бий болох ба түүний дараа бодит эрх зүй бий болж хэрэгжинэ. Гегель тийнхүү бодит эрх зүйн бодит түүхийг эрх зүйн үзэл санааны түүх мэтээр ойлгожээ. Эрх зүйн үзэл санаа, эрх зүйн ойлголт нь бодит хэлбэртэй болж хэрэгжиж биежих явцад хийсвэр байдлаасаа улам бүр салж, улам бүр тодорхой чанар, тодорхой агуулгатай болдог. Гегель эрх зүй гэдэг ойлголтыг гурван янзын утга агуулгаар ойлгожээ. I. Эрх зүй бол эрх чөлөө мөн. Энэ нь эрх зүйн үзэл санаа гэсэн ойлголтоор томёологджээ. II. Эрх зүй нь эрх чөлөөний тодорхой үе шат, хэлбэр гэсэн утгаар ойлгож түүнийг “онцгой эрх” гэж томъёолжээ. III. Эрх зүйг хууль гэсэн утгаар ойлгож түүнийг “эерэг, позитив эрх зүй” хэмээн томъёолжээ.

1. Объектив оюун санааны түвшинд хөгжил хөдөлгөөн нь эрх чөлөөний үзэл санаагаар тодорхойлогдоно. Тиймээс эрх чөлөө ба эрх зүй нь ижил нэгдмэл утгатай байна. Энэ дагуу Гегелийн эрх зүйн философийг эрх чөлөөний философи гэж нэрлэж болох юм.

2. Эрх зүйн тогтолцоо нь хэрэгжин биелж бодит байдал болсон эрх чөлөөний ноёрхол мөн. Эрх зүй тийнхүү бодит эрх чөлөө болж хувирах явцад хийсвэр байдлаас тодорхой байдалд шилжиж онцгой эрх зүйн үе шат, зэрэг зиндааг бүрдүүлдэг байна. Онцгой эрх зүйн тэрхүү зэрэг зиндаа бүхий шатны оройд төрийн эрх оршиж байрлана.

3. Эрх зүй нь хууль тогтоох замаар хууль болж хувирах ба тэгсэнээрээ түгээмэл, нийтлэг шинжтэй болж чадна. Гегель тийнхүү эрх зүй ба хууль

хоёрыг хооронд нь ялган салгаж ойлгосон бөгөөд гэхдээ тэдгээрийг эсрэг тэсрэг тавих нь буруу гэж үзжээ. Эрх зүйг хууль тогтоох замаар хууль болгохдоо эрх зүйн угийн утга агуулга алдагдаж болох юм. Тиймээс хууль бүрийн утга агуулга нь эрх зүй байдаггүй.

Гегелийн философт эрх чөлөөний хэлбэржин биелэгдэх үндсэн гурван шат байдагт эрх зүйн үзэл санаа, эрх зүйн ойлголтын хөгжлийн үндсэн гурван шат тохирдог. Өөрөөр хэлбэл эрх зүйн үзэл санаа нь хувиран хөгжихдөө хоорондоо холбогдож дараалсан дараах гурван шатыг дамжина. Үүнд: нэгдүгээр шат бол хийсвэр эрх зүй; хоёрдугаарт ёс суртахуунт чанар, гуравдугаарт зан суртахуун юм. Эрх зүйн үзэл санаа эдгээр шатыг дамжин хөгжихдөө хийсвэрээс тодорхойд өгсөж шилжих, хувирах замаар явна. Нэгдүгээр шатад эрх зүй яагаад хийсвэр эрх зүй байдаг вэ гэвэл ер нь эрх зүйн үндэс бол ганц, тусгаар бие хүний эрх чөлөө байдаг. Энэ шатад бие хүний тэрхүү эрх чөлөө нь эд хөрөнгийг эзэмших эрхээр, түүнчлэн эд хөрөнгө, өмчийн асуудалтай холбогдож бусад хүмүүстэй харьцах харилцаагаар илэрч хэрэгжинэ. Тийнхүү энэ шатад өмч хөрөнгийн эрх зүйн харилцаа ба эрүүгийн эрхийн үндэс бүрэлдэнэ. Гегель хийсвэр эрх зүйн энэ шатад өмч, өмчийн харилцаа, түүнээс үүсэж гарах гэрээний асуудлыг авч үзжээ.

Эрх зүйн үзэл санааны хөгжилийн хоёр дах шатыг Гегель ёс суртахуунт чанар гэж нэрлэжээ. Энэ шатад бие хүн өөрийн үйлдэл, зан байдлыг буян нүгэлийн үүднээс үнэлэн цэгнэж ухамсарлна. Гегель үүнтэй холбогдуулж гэмт хэргийг авч үзсэн байдаг. Гегелийнхээр гэмт хэрэг бол эрх зүйг ухамсартайгаар зөрчсөн эрх юм. Тиймээс гэмт хэрэгтнийг шийтгэсэн шийтгэл нь угтаа зөрчигдсөн эрх зүйг сэргээж байгаа хэрэг төдийгүй уг гэмт хэрэгтний өөрийнх нь эрх мөн болно. Гэмт хэргийг зэмлэж шийтгэх нь ёс суртахуунт чанарт хүргэнэ.

Эрх зүйн үзэл санаа буюу эрх чөлөөний гурав дахь, хамгийн дээд шат бол зан суртахуун юм. Энэ шатад хүмүүсийн эрх чөлөө, эрх зүйн үзэл санаа нь уг хүмүүс нийгмийн янз бүрийн харилцаанд орох байдлаар, тухайлбал гэр бүл, иргэний нийгэм, төрийн хэлбэрээр илэрч хэрэгжинэ. Тийнхүү энэ шатанд эрх зүйн үзэл санаа нь нийгмийн бүхий л харилцааг өөртөө хамааруулж багтаана. Гегель үүнтэй холбогдуулж иргэний нийгэм ба төр гэсэн ойлголтыг авч үзээд тэдгээр нь хоорондоо ялгаатай болохыг харуулжээ. Иргэний нийгэм ба төр юунаас үүсэж гарсан бэ, тэдгээр нь үүсэхээс өмнө хүмүүс ямар төлөв байдалтай байсан бэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдана. Гегель энэ асуудлыг дараах байдлаар авч үзэж хариу тайлбар өгчээ. Төр үүсэхээс өмнөх үе буюу жам ёсны эрхийн онолыг баримтлагчдын нэрлэсэнээр байгалийн, жам ёсны төлөв байдал гэдэг нэр томъёоны оронд Гегель иргэний нийгэм гэсэн нэр томъёог хэрэглэжээ. Байгалийн төлөв байдал бол эрхгүй, дур зоргын төлөв байдал бөгөөд тиймээс хүмүүс түүнээс гарах хэрэгтэй юм. Энэ төлөв байдлаас төр үүсэх явцад гарч болно. Гэхдээ Гегель хүн ард байгалийн төлөв байдлаас гарахдаа, мөн төр үүсэхдээ нийгмийн хэлэлцээрээр гарсан, төр үүссэн гэсэн үзлийг буруушаажээ. Өөрөөр хэлбэл Гегель төр бол хүмүүсийн харилцан тохиролцоо, гэрээгээр үүссэн гэсэн үзэл баримтлал, онолыг няцаасан байна. Хүн ард зөвхөн төрт ёсны нөхцөлд л жинхэнэ эрх, эрх чөлөөтэй байж чадна. “Иргэн хүн бол зөвхөн төрийн хүрээнд, төрд эзлэх албан тушаалынхаа ачаар, төрийн хүрээнд эрхэлж эзэмшсэн мэргэжилийнхээ ачаар, мөн хөдөлмөрийн үйл ажилгааныхаа ачаар л нэр төртөй, нэр хүндтэй байж чадна” гэж Гегель заажээ.

Гегелийн үзлээр иргэний нийгэм бол дотроо зөрчил тэмцэлтэй, антагонист байдалтай, хүн бүхэн хүн бүхний эсрэг дайтсан шинжтэй байдаг. Гегель энд хүн төрлөхтөний түүхэн дэх бүх нийгэм нь антагонист шинжтэй

байсан бодит үнэнийг эш үндэс болгожээ. Иргэний нийгэм нь үндсэн гурван хэсэгтэй байна. 1) хэрэглээний тогтолцоо, 2) хууль зүй, шүүх, 3) цагдаа, эвсэл, нэгдэл бүхий корпораци. Гегель иргэний нийгмийн эдийн засгийн үндэс суурь, хэрэглээ, хөдөлмөрийн асуудлыг дэлгэрэнгүй авч үзжээ. Иргэний нийгмийн хэрэглээ нь хөдөлмөрөөр нөхцөлдсөн, хувийн өмчинд тулгуурласан, хүмүүс хэлбэрийн талаас буюу хууль зүйн хувьд тэгш байдалтай байна. Иргэний нийгэмд эдийн засаг чухал үүрэг гүйцэтгэнэ. Иргэний нийгэм хэдийгээр баян чинээлэг, эдийн засагийн хувьд чадалтай байсан ч гэсэн туйлын ядуу зүдүү байдалтай дангаараа амжилттай тэмцэж, даван туулж чадахгүй. Тиймээс иргэний нийгэмд ядуурал, хоосрол гарч ирнэ. Иргэний нийгмийн дотоод хүч чадал нь ядуурлыг даван туулахад хүрэлцэхгүй учраас тэрээр гадаад харилцаагаа өргөжүүлэх, гадаад худалдаа хийх, бусад улс орныг колончилж эзлэх шаардлага гарна. Гегель үүнтэй холбогдуулж тэр үеийн колончлолын асуудлыг хөндөн авч үзэж шүүмжилжээ. Эзэнт гүрнүүдийн хувьд колони орнуудыг чөлөөлөх нь асар их буянтай үйл хэрэг болохсон билээ гэж тэрбээр бичжээ.

Иргэний нийгэм нь хууль зүй, шүүх, цагдаа, цэрэггүйгээр оршин байж чадахгүй. Тэдгээр нь хувийн өмчийг хамгаалах үүрэг зорилготой юм. Хуулийг ил тод батлан гаргаж, түүнийг тууштай баримталж ил тод шүүн таслах ёстой. Гегель цагдаажсан төрийг шүүмжилжээ. Гэхдээ тэрбээр төр хүмүүсийн хувийн амьдрал, хувийн хэрэгт ямар хэмжээгээр хөндлөнгөөс оролцох вэ гэдгийг төдийлөн тодруулж заасангүй. Иргэний нийгмийн бүтэц нь гурван язгуур хэсгээс бүрэлдэнэ. 1) субстанциал язгуур буюу газар эзэмшигч тайж нар ба тариачид, 2) аж үйлдвэрийн язгууртан буюу фабрикын эзэд, худалдаачид, гар урлалчид, 3) түгээмэл язгууртанууд буюу төрийн албан тушаалтан түшмэд.

Төр бол иргэний нийгмийн зайлшгүй үндэслэл мөн. Гэхдээ Гегель төрийг объектив идеализмын дагуу авч үзэж төр бол оюун ухаан, эрх чөлөө, эрх зүйн үзэл санааны илрэл, хэрэгжилт мөн гэж үзжээ. Тэрээр “төр бол чухамдаа эрх чөлөөний ойлголтын биелэлт, зохион байгуулалт, байгууллага мөн, төр бол эрхэт тэнгэр (бурхан) энэ газар дэлхийд заларч ирсэний гэрч мөн” гэжээ.

Төрийн үзэл санаа хөгжилийнхөө явцад гурван удаа илэрч хэрэгжинэ. Нэгдүгээрт, тодорхой, бие даасан төрийн хэлбэрээр, хоёрдугаарт, төр улсуудын хоорондын харилцаанд олон улсын харилцааны эрхийн хэлбэрээр, гуравдугаарт, бүх дэлхийн түүхийн хэлбэрээр илэрч хэрэгжинэ. Төрийн үзэл санаа бие даасан аль нэг тодорхой төрийн хэлбэрээр илэрэхдээ засаглалыг хуваарилсан үндсэн хуульт хаант засгийн хэлбэртэй байна. Төрийн засаглал нь а) хууль тогтоох, б) засгийн газрын, в) эзэн хааны буюу дээд эрх мэдэлтний засаглал гэсэн гурван эрх мэдэлд хуваарилагдана. Гегель тийнхүү засаглал хуваарилах онолыг дэмжиж баримталжээ. Тэрээр хуваарилагдсан засаглалууд хоорондоо тэмцэлдэгч, сөргөлдөгч хүч байдаг гэж үзээгүй, засаглалыг хуваах нь олон нийтийн эрх чөлөөг хангах, хамгаалах баталгаа, нөхцөл болдог гэж үзжээ. Хуваарилагдсан засаглалууд хоорондоо нягт холбоотой, нэгдэлтэй байх ёстой. Засаглал тийнхүү нягт нэгдэлтэй байх нь төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхийг хангана. Гегель ард түмний бүрэн эрх мэдэл ба бүгд найрамдах засаглалыг шүүмжилж үе удам дамжсан үндсэн хуульт хаант засгийг талархан дэмжжээ.

Хууль тогтоох засаглал бол түгээмэл зүйлийг тодорхойлон тогтоогч засаглал юм. Тэр нь хоёр танхимтай хууль тогтоох хурлын хэлбэртэй байна. Дээд танхимын гишүүд үе удам дамжих зарчимаар эмхлэгдэж бүрэлдэнэ. Доод танхим нь янз бүрийн нэгдэл, холбоо, нөхөрлөлөөс төлөөлөгдөн сонгогдсон депутатуудаас бүрэлдэнэ. Танхимууд нь ил тод үг хэлэх, хэлэлцэх,

хэвлэн нийтлэх эрх чөлөөгөөр хангагдах ёстой. Засгийн газрын гол үүрэг бол нэгж, тодорхой, тусгай зүйлийг ерөнхий, түгээмэл зүйлд тохируулж шийдвэрлэх явдал мөн. Засгийн газар нь түүнчлэн эзэн хааны шийдвэр, заалтыг хэрэгжүүлж биелүүлэнэ. Засгийн газар нь түгээмэл язгууртан буюу албан тушаалтан, түшмэдээс бүрэлдэнэ. Гегель төрийн албан тушаалтнууд бол төрийн гол түшиг тулгуур мөн гэж талархан үзжээ. Эзэн хааны засаглал бол бусад хоёр засаглалыг өөртөө захируулсан дээд засаглал байна. Хуучны язгууртан тайж нарыг шинэ хөрөнгөтнүүдтэй эвлэрүүлж, эв нэгдэлтэй байлгах замаар германы нийгмийн улс төрийн байгууллыг аажим алгуур, реформын аргаар хөрөнгөтний нийгмийн байгуулалттай болгох үзэл санааг Гегель илэрхийлэн хамгаалж, засаг төрийн үлгэр жишээч хэлбэр бол үндсэн хуульт хаант засаг мөн хэмээн заажээ. Гегель бүхэлдээ нийгмийг хөрөнгөтний ёс журмын дагуу өөрчлөн шинэчлэх үзэл санааг дэмжсэнээрээ дэвшилт үзэлтэй байлаа. Тиймээс марксист утга зохиолд Гегелийг улс төрийн үзэлээрээ феодализмын номлолыг баримтлагч хэмээн үзэж шүүмжилж байсан нь ташаа юм.

Төрийн үзэл санаа хоёр дах удаагаа, дээд шатад илэрч хэрэгжихдээ төр улсуудын хоорондын харилцааны эрх зүй буюу олон улсын харилцааны эрх зүй болж илэрнэ. Олон улсын харилцааны эрх бол жинхэнэ, бодитой эрх биш, харин үүрэг хүлээх явдал юм. Харин тийнхүү хүлээсэн үүрэг нь бодотойгоор хэрэгжих эсэх нь улс орнуудын бие даасан бодлого, хүсэл зоригоос шалтгаална. Гэхдээ олон улсын харилцаа, төр улсуудын хоорондын харилцаанд зохих ёсны зарчим, гэрээ хэлэлцээр үйлчлэх ёстой. Төр улсууд бие биенийхээ тусгаар тогтнол, бүрэн эрхийг харилцан хүлээн зөвшөөрч, бие биенийхээ үйл хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх ёстой. Төр улсуудын хоорондын маргаан нь хэлэлцээр зөвшилцөлд хүрэхгүй бол дайны аргаар шийдвэрлэгдэнэ. Дайн бол хууль журамгүй байдал, хүчирхийллийн төлөв байдал мөн. Гегель энэ үүднээс И.Кантын өнө мөнхийн энх тайвны тухай үзэл санаа, сургаалыг үндэсгүй зүйл гэж үзэж шүүмжилжээ. Гэхдээ дайны нөхцөлд ч гэсэн төр улсууд бие биеэ хүлээн зөвшөөрөх хийгээд бусад зарчим, ёс суртахууны хэм хэмжээ тэдний хоорондын харилцаанд үйлчлэх ёстой. Дайн бол эцэстээ энх тайванд хүргэдэг, шилжимтгий чанартай үзэгдэл гэж Гегель заажээ. Дайн бол бүхэлдээ төр улсуудын хооронд явагдна. Нэг улсын зүгээс нөгөө улсын эсрэг чиглэсэн дайн нь аль нэг тодорхой, тусгай байгууллага, гэр бүл, хувийн амьдрал, хувь хүмүүсийн эсрэг чиглэгдэхгүй гэж Гегель заажээ. Одоогийн шинэ үеийн дайн нь өмнөх үеийнхээс арай хүнлэг байдалтай болж байна гэж Гегель талархжээ.

Тусгаар төр улс өөрийн тусгаар тогтнол, бүрэн эрхээ хангах, хамгаалах зорилгоор дайн хийж болно. Чухам үүнд дайны ёс суртахууны утга учир, зөвтгөл орших ба ер нь дайныг туйлын муу, туйлын нүгэлтэй зүйл гэж үзэж болохгүй. Дайн бол үндэстэн, ард түмний оюун санааг ариусгадаг, ард түмэн оюун санаа, ёс суртахууны талаар доройтож ялзрахаас сэрэмжилж хамгаалдаг, ард түмэн дайнаас хүчтэй, тэнхээтэй болж гарч ирдэг төдийгүй мөн дотоод сэтгэл санаа нь тайван тогтвортой болдог гэж Гегель заажээ. Гэвч эдгээр нь Гегель бүхэлдээ дайныг зөвтгөж дэмждэг байсан гэсэн үг огт биш юм.

Төрийн үзэл санаа өөрийгөө төгсгөлийн, гурав дахь шатад илэрхийлж хэрэгжүүлэхдээ дэлхий дахины түүхийн хэлбэрээр хэрэгжиж илрэнэ. Дэлхий дахины түүх бол нэгэн зэрэг дэлхий дахины шүүлт, шүүн тунгаалт байдаг. Бүх дэлхийн түүх бол хэрэг дээрээ тусгаар тогтносон, бүрэн эрхэт төр улсуудын дэвшил хөгжлийн түүх байдаг. Бүх дэлхийн түүх дотроо дөрвөн аймаг, хэсэгт хуваагдана. Тэдгээр нь: 1) дорнын, 2) грекийн, 3) ромын, 4) германы түүх юм.

Энэ дөрвөн аймаг тус бүртээ өөртөө тохирсон засаг төрийн хэлбэр, зохион байгуулалттай байна. Жишээлбэл, дорно дахинд шашин ба төр хослосон байх бөгөөд тэнд нэг л этгээд буюу эзэн хаан л эрх чөлөөтөй байна. Грект ардчилсан төр, Ромд язгууртны засаг төр тогтож байсан ба энэ үүднээс үзвэл эдгээр оронд бүх иргэд биш, хүн амын зөвхөн зарим нэг хэсэг нь эрх чөлөөтөй байлаа. Харин Германд үндсэн хуульт хаант төр оршиж буй бөгөөд бүх хүн эрх чөлөөтөй байна гэж Гегель үзжээ.


Бие даасан, тусгаар тогтносон төр улсуудын хоорондын харилцааны явцад, эдгээр орнуудын бие даасан, бүрэн эрхт хүсэл зориг хоорондоо тулгарч сөргөлдөх, харилцан нөлөөлөх явцад ертөнцийн санаа, дэлхийн оюун ухаан бүрэлдэж бий болно. Тэрбээр хамгийн дээд эрхийг эдэлж тусгаар улс орон, ард түмнүүдийн оюун ухаан, санааг шүүн тунгааж, үнэлэн цэгнэж захирна. Чухам энэ чанараараа бүх дэлхийн түүх бол бүх дэлхийн шүүлт байдаг.

Дэлхийн оюун санааны даалгавар, айлдварыг дэлхийн түүхийн тодорхой үе шатад ноёрхон оршиж буй ард түмэн хэрэгжүүлж биелүүлнэ. Дэлхийн түүхэнд тийнхүү ноёрхон эзэрхэж гарч ирэх бололцоо, аз завшаан тэр ард түмэнд нэг л удаа олдоно. Баруун европын түүхэнд Реформацын хөдөлгөөнөөр эхэлсэн шинэ эрин үе, түүхийн шинэ үе шат бол Германы ард түмний ноёрхолын эрин үе мөн гэж Гегель үзжээ. Тэрбээр германы ард түмэн гэдэг ойлголтод Баруун хойд Европын ард түмнүүдийг багтаан ойлгожээ. Гегель Орос улс, Хойд Америкийн нэгдсэн улс одоохондоо бүх дэлхийн түүхэнд өөрийгөө илэрхийлж харуулах болоогүй байна хэмээн үзжээ. Гегелийнхээр бүх дэлхийн түүх, түүний хөгжил дэвшил бол эрх чөлөөний ухамсарын хөгжил дэвшил юм.

Гегелийн улс төрийн сургаал хожмын үеийн нийгэм-улс төрийн сэтгэлгээнд ихээхэн нөлөө үзүүлсэн, нэн баялаг агуулгатай, үнэтэй өв сан юм. Тиймээс агуу их гүн ухаантны улс төрийн сургаалыг түүний гол зохиол бүтээлүүдийг нягт нямбай унших, голлох үзэл санааг нь ул суурьтай ойлгож ухаарах замаар судлан эзэмших хэрэгтэй.

Гегелийн улс төрийн сургаалыг хүснэгтээр хялбаршуулж харуулах нь

1. Гегель объектив идеалист философич мөн
2. Бүх юмны анхдагч үндэс бол санаа юм




- | | |
|----------------------|---|
| 1. илрэнэ.Энэ шатанд | Туйлын санаа хөгжлийн хувьсалын гурав дахь шатанд хүн төрөлхтөний хэлбэрээр туйлын санаа өөрийгөө оюун санааны философийн хэлбэрээр танин мэдэж ухамсарлана. |
|----------------------|---|

1. Эндээс Гегелийн объектив идеалист философийн систем нь:

1. Логикийн ухаан
2. Байгалийн философи
3. Оюун санааны философи


гэсэн үндсэн 3 бүрдэл хэсэгтэй болох нь тодорхой болж байна.

2. Гегелийн **Оюун санааны философи** нь дараах бүтэцтэй болно.
Үүнд:



3. Гегелийн нийгэм , улс төр, эрхийн сургаал нь түүний философийн системийн гурав дахь хэсэг буюу оюун санааны философийн объектив оюун санаа гэсэн хэсэгт агуулагджээ.

Объектив оюун санааны бүтэц:



Гегелийн авч үзсэн улс төрийн үзэгдэл, асуудлууд:

1. Иргэний нийгэм, түүний зөрчил

- Иргэний нийгмийн бүтэц, бүрдэл хэсэг (1. Хэрэглээний тогтолцоо, 2.Хууль ёс, шүүх, 3. Цагдаа, Корпораци буюу бүлэгүүд).
 - Иргэний нийгмийг бүрдүүлдэг язгуур бүлгүүд (1.Субстанциал буюу газар эзэмшигч тайж, ба тариачид, 2. аж үйлдвэрийн язгууртан буюу фабрикийн эзэд, худалдаачид, гар урлалчид, 3. Түгээмэл язгууртан буюу төрийн албан тушаалтанууд, түшмэд)
 - Иргэний нийгэм дэх эдийн засаг, хөдөлмөрийн үүрэг
 - Иргэний нийгэм дэх ядуурал
 - Иргэний нийгмийн гадаад харилцаа (төрийн гадаад бодлого)
- 2. Төр, түүний мөн чанар, үүрэг, зорилго**
- Тодорхой, бие даасан төр улсууд

- g. Төр улсуудын хоорондын харилцаа, олон улсын харилцааны эрх зүй
- h. Бүх дэлхийн түүх
- 1. Төрийн засаглал, түүнийг хуваарилах нь**
 - i. Хууль тогтоох засаглал, түүний танхимууд
 - j. Засгийн газрын эрх мэдэл
 - k. Эзэн хааны засаглал
 - l. Хуваарилагдсан засаглалын үйл ажиллагааны зарчим, зорилго
 - m. Засаг, төрийн хэлбэрүүд (ард түмний засаг, бүгд найрамдах засаг, үе залгамжилсан хаант засаг)
- 4. Дайн, энх нь улс төрийн үзэгдэл болох нь**
 - n. Дайн гарах шалтгаан
 - o. Дайны мөн чанар
 - p. Дайны үүрэг, ёс суртахууны утга учир
- 5. Дэлхийн түүх ба түүний илрэл**
 - q. Дорно дахин, түүнд тохирсон төрийн хэлбэр, эрх чөлөө
 - r. Грек, түүний төрийн хэлбэр, эрх чөлөө
 - s. Ром, түүний төрийн хэлбэр, эрх чөлөө
 - t. Герман, түүний төрийн хэлбэр, эрх чөлөө
 - u. Дэлхийн түүх бол бүх дэлхийн шүүлт, шүүх болох нь

Ном зүй

Гегель Г.В.Ф. Логикийн шинжлэх ухаан. Философийн нэвтэрхий толь. 1-р боть. Орчуулсан Ү.Нямдорж. УБ., 2004. 328 хуудас.

Гегель Г.В.Ф. Энциклопедия философских наук. Том 3. Философия духа. Отв. ред. Е.П. Ситковский. М., 1977. -471 с.

Гегель Г.В.Ф. Философия права. Перевод с нем. Б.Г. Столпнера и М.И. Левиной. М., 1990. -524 с.

История политических и правовых учений. Учебник для вузов. Изд. 2-е, стереотип. Под. общ. ред. академика В.С. Нерсесянца. М., 1997. -736 с.

История политических и правовых учений. Учебник для вузов. Под. ред. профессора О.Э. Лейста. М., 2000. -688 с.

История философии. Учебник для вузов. Под. ред. В.М. Мапельман и Е.М. Пенькова. М., 1997. -464 с.

История философии. Учебник для вузов. Ростов-на-Дону, 1999, -576 с.

Мусский И.А. 100 великих мыслителей. М., 2002. -688 с.

Нерсесянц В.С. Философия права. Учебник для вузов. М., 1997. -652 с.

Нерсесянц В.С. Философия права Гегеля. М., 1998. -352 с.

Овсянников М.Ф. Гегель. Орчуулсан А. Энхбаатар. УБ., 1987. 216 хуудас.

Рассел. Б. История западной философии. В 3 кн. 2-е изд., испр. Подгот. текста В.В.Целищева. Новосибирск. 1997. -880 с.

Реале Д., Антисери Д. Западная философия от истоков до наших дней. В 4 - х томах. Том 4. От романтизма до наших дней. Перевод с итальянского С.Мальцевой. Санкт-Петербург. 1997. -880 с.

Скирбекк Г., Гилье Н. История философии. Учебник для вузов. Перевод с англ. М., 2000. -800 с.

ПОЛИТОЛОГИ III

Эрдэм шинжилгээний бичиг ¹ ... (...): 15-18 дахь тал

УЛС ТӨРИЙН ФИЛОСОФИЙГ ТОЙМЛОХ НЬ

Д.Содномгомбо

доктор, зөвлөх профессор
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Асуудлын агуулгыг илэрхийлэхийн тулд философийн тухай ойлголтыг эргэж саная. Философи бол бодит байдал /амьгүй, амьд байгаль, хүний нийгэм, оюун санаа/-ны хамаг юмс, үзэгдлүүдийн үүсэл гарал, оршин тогтнол, өөрчлөлт, хувиралт, заримдаа хөгжлийн объектив зүй тогтол, өөрчлөлт, хувиралт, заримдаа хөгжлийн объектив зүй тогтол, түгээмэл хуулиудын тухай шинжлэх ухааны шинжлэх ухааны гүн гүнзгий мэдлэг, арга зүйн эмх цэгцтэй, нэгдсэн систем мөн. Бодит бололцооны биелэл болсон бодит байдал олон янзын түвшин, төрөл, хэлбэрүүдээр дамжин илэрдэг, илэрсээр ч байна. Бодит байдлыг ахуй ч гэж нэрлэдэг ёсон буй.

Нийгэм бол бодит байдлын нэг харьцангуй том бөгөөд чухаг /нарийн нандин/ салбар мөн дотроо эдийн засаг, улс төр, социаль, оюун санааны гэсэн томоохон хэсэг буюу хүрээнүүдэд ангилагдаж, тэдгээрээс бүрэлдэн тогтож байдаг. Нийгмийн салбаруудын дотроос бид нар гагцхүү улс төрийн салбар, тухайлбал, улс төрийн сонирхож байна. Сонирхож буй сэдвийн судалгааны зорилгыг үнэн зөв томъёолохын тулд түүний объектыг оновчтой тодотгох нь чухал юм. Үүний тулд асуудалд бүхэл бас хэсэг, систем ба элемент, тусгай ба ерөнхий, суурь ба давхарга, материаллаг ба оюун санааны

гэх мэт зүйлийн харьцааны үндсэн дээр онтологи ба гносеологийн арга зүйгээр хандахыг оролдоё.

Нийгэм бол бүхэл, систем, ерөнхий юм. Тэгвэл улс төр нь бүхлийн хэсэг, системийн элемент, ерөнхий тусгай мөн. Нөгөө талаар улс төр нь нийгмийн сууринд тулгуурлан тогтож, үйлчилж байдаг давхаргын хэсэг, материаллаг зүйлсийн оюун санааны тусгал буюу илэрхийлэл юм. Гэвч улс төр бол нийгмийн суурийн идэвхигүй хавсарга буюу дагуул биш, харин суурьт эргэж идэвхитэй, хүчтэй нөлөөлж байдаг нь эдийн засгийн харилцааг төрөөс хэрэгжүүлдэг эрх зүйн зохицуулалт, хяналтаар илэрч байна. Улс төр оюун санааны хийсвэр шинжтэй ч гэсэн цаг ямагт түүний оршин ахуй, үйл ажиллагаа материаллаг систем тухайлбал улс төрийн системээр дамжиж илэрдэг, хэрэгждэг. Үүгээр улс төр бол зөвхөн оюун санааны хийсвэр үзэгдэл биш, харин анхдагч, тодорхойлон тогтоогч увидастай хүч мөн болох нь батлагдаж байна.

Улс төр бол түүхэн үзэгдэл мөн. Энэ нь философийн хувьд орон зай, хөдөлгөөн, цаг хугацааны нэгдэл буюу үргэлжлэл, тасалдлын асуудал юм. Улс төр тодорхой орон зай (газар-улс орон)-д, тодорхой нөхцөл бүрдэж, шаардлага тулгарснаар буй болж, улмаар янз бүрийн олон улс оронд дэлгэрсэн байна. Улс төрийг үүсэн тогтнол, өсөлт-төлөвшил, цэгцрэлт-хөгжилт, өөрчлөлт-шинэчлэлт, халагдал-солигдол гэх мэтээр мөчлөгчилэн (циклэгчилэн) авч үзэж болох юм. Энэ мэтээр улс төрийн үйл явц цаг хугацаа (он жилүүд, зуунууд, бүхэл бүтэн түүхэн эрин үеүд)-гаар хэмжигддэг. Орон зайг эзэлдэггүй улс төр, цаг хугацаагаар хэмжигдэггүй улс төрийн үйл явц байдаггүйгээр улс төрд орон зай, цаг хугацааны хамаарал тайлбарлагдана.

Улс төр диалектик хөгжлийн хуулиар үүсч, дордоос дээдэд, энгийнээс нарийнд, бүрдүүлгээс боловсронгуйд, харгислалаас ардчилалд шилжин дэвшиж хөгжих замаар өрнөж иржээ. Ардчиллын оршин тогтнол, өөрчлөлт, хөгжлийн мөчлөг нэг бүр нь түүний тасалдал, өмнөх мөчлөгүүдийн сөрөг тал, шинжүүдийн орхигдол буюу халагдал, тэдгээрийн дэвшилттэй, шинэ шинж чанарын хадгалагдах, уламжлагдах ёс ба үйл явц бол улс төрийн үргэлжлэлийн илрэл мөн. Улс төрийн үргэлжлэлийн явцад түүний агуулга улам улмаар гүнзгийрч, хэлбэр нь баяжиж ирсэн байна. Үүнийг дэлхийн болон үндэсний баримт, жишээгээр батлан өгүүлж болох юм. Философийн түүхийн үүднээс авч үзвэл улс төрийн эртний Энэтхэг, Хятадын, эртний дэлхийн, Дундад зуун, XV-XVI, XVII, XVIII зууны, Германы сонгодог философийн үеийн, XIX-XX зууны, орчин үеийн гэх мэтээр үечилэн хэлбэршүүлж болох юм. Монголын улс төрийг Хүннүгийн үеэс эхлэн нэгдсэн их Монгол улс байгуулагдах хүртэлх үеийн Монголын жижиг тархай бутархай улс-аймгуудын улс төр, Чингис хаант их Монгол улсын улс төр, Өгөөдэйн хаанчлалаас 1691 онд Манжид дагаар орох хүртэлх үеийн Монголын олон хаадын үеийн улс төр, Манж-хятадын колоничлолын үеийн Монголын улс төр, Богд хаант Монгол улс (1911-1921)-ын улс төр, 1921-1990 он хүртэлх ардчилал, авторитаризм холилдсон үеийн Монголын улс төр, 1990 оноос хойших ардчилсан сэргэн мандалтын Монгол улсын улс төр хэмээн ангилж үзэх үндэслэл бүрэн байна.

Улс төр бол субъект, объектын нэгдэл мөн. Үүнийг бас үндсэн шинжээр нь объектив, субъектив хүчин зүйлийн нэгдэл ч гэж үзэж болох юм. Ийм учраас улс төрийн онтологи (ахуйн тухай сургаал), гносеологи (танин мэдэхүйн тухай сургаал) хандлагын аргаар судлах шаардлагатай юм. Улс төрийг нийгийн тодорхой хэсэг, бүлэг, анги, давхраа, хүчин, тухайлбал улс төрийн намууд, засаглалын төлөөлөгчид боловсруулж, хэрэгжүүлэхийн төлөө тэмцдэг. Эд нар бол улс төрийн субъектүүд юм. Хамгийн гол нь төрийн

бүх шатны байгууллагын төлөөлөгчдийг сонгох сонгуульд оролцогчид, төр засгийн бодлого, шийдвэрийг дэмжих, шүүмжлэх, санал, хүсэлт гаргах, биеэрээ оролцож ажиллах зэрэг хэлбэрээр биелүүлэгчид бол үнэхээр улс төрийн үндсэн, гол субъектүүд мөн.

Улс төрд буюу төр засаг, улс төрийн намын бодлогод өртөгдөж, нөлөөлөгдөж буй эдийн засаг, социал хүрээ, оюуны салбар бол улс төрийн объект юм.

Ингэхлээр онтологи, гносеологи аргын нэгдлийг хангах нь улс төрийн философийн нэг үндсэн шаардлага мөн. Ингээгүйгээс болж өнгөрсөн үеийн улс төр судлаачид алдаа, эндэгдэл гаргах тохиолдол мэр сэр байжээ. Эртний Энэтхэг, Хятад, Грек, Римийн болон Дундад зууны улс төрийн сургаалын нэрт төлөөлөгчид улс төрд ихэвчлэн субъективээр ханддаг байсныг дараа үзэх болно. Энд улс төрд субъективээр хандах, идеалист үзлийн байр сууринаас хандах хандлагууд нэг ижил төрөл шинжтэй боловч зарчмын ялгаатайг анхаарах нь чухал. Харин улс төрд субъективээр хандах нь зарим тохиолдолд волюнтаризм (дур зоргоороо аашлах)-д хальтирч оруулдаг аюултайг умартаж болохгүй.

Одоо улс төрийн тухай тодорхойлолт, тайлбарыг товчхон авч үзье. Улс төр-нийгмийн улс төрийн хүрээн дэх засгийн эрхийг олж авах, хадгалан барьж байх, бэхжүүлэх, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн ухамсартай үйл ажиллагаа мөн. Улс төр бол өнө эртний ойлголтуудын нэг юм. Энэ нь орчин үеийн хэлэнд грекийн /politika/ гэсэн үгнээс зээлдэгдэж орсон бөгөөд уламжлал ёсоор төр, нийгэм, ажил хэргийг болон хүмүүс, нийгмийн бүлгүүд, ард түмэн, үндэстэн, төр-улсуудын хоорондын засаглалтай холбоотой харилцан хамааралтай үйл ажиллагааны хүрээг тэмдэглэж байна. Нийгмийн амьдралын томоохон салбар болсон улс төр түүний субъектүүдийн хоорондын харилцаа, засгийн удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаа, хүмүүсийн зан үйл, тэдгээрийн нийгэм-улс төрийн ашиг сонирхол, хэрэгцээ, сэдлүүд ба уламжлал, улс төрийн институтууд, газар байгууллагуудын үйлчлэл, улс төрийн үзэл, үзэл санаа зэргийг өөртөө багтаадаг. Улс төр нь засаглалтай харилцан үйлчлэх үйл явцад өөрчлөгдөж хүмүүсийн сэтгэл зүйн байдал, шинжүүдтэй, түүнийг хүмүүс хэрхэн ойлгож, хэрэгжүүлж байгаатай салшгүй холбоотой байна. Тэр нь иргэншлийн тодорхой орчинд хэрэгжиж, янз бүрийн хүчин зүйлсийн нөлөөнд өртөгдөж байдаг юм. Улс төр нь соёл-түүхийн тод томруун үзэл, үзэгдэл болон илэрдэг. Түүний үүсэн тогтнол, хөгжил бол улс төрийн үнэт зүйлсийн төлөвшил, үйлчлэл, хадгалалт, уламжлалтай, улс төрийн харилцаа ба удирдлага, туршлагын шинэ хэлбэрүүдийн үүсэн тогтнолтой, хуучирсныг нь шүүмжлэлтэйгээр хэтлэн давах явдалтай, янз бүрийн нийгэм дэх хүний улс төрийн үйл ажиллагааны олон янзын илрэлүүдийн харьцааны нарийн төвөгтэй системүүдтэй даян дэлхийн түүхэн үйл явц мөн. Улс төр хүмүүсийн нийтлэгийн оршин тогтнолын утга санааг илэрхийлж, улс төрийн бүх субъектүүдийн буюу тухайн нийтлэгт оролцогсдын түгээмэл ашиг сонирхлыг илэрхийлж, тэдний хоорондын харилцааны үүрэг, ролийг тодорхойлж, эцэст нь бүх субъектуудад нийтлэг ойлгомжтой (аман ярианы буюу бичгийн, бэлэг тэмдгийн) хэлийг зохион бүтээж, тухайн хамтын нийгэмлэгийн бүх оролцогсдыг үр ашигтай хамтын ажиллагаа, харилцааг хангах чадвартай болгодог юм. Тэр нь цаг хугацааны болон тодорхой түүхэн ба иргэншлийн нөхцлүүдээс, нийгэмд ноёрхогч үзэл суртал, ёс суртахуун, шашны хэм хэмжээнээс, уг хүний болон түүний ертөнцийг үзэх үзэл, соёлын хөгжлийн түвшингээс олонтоо хамаарч байна. Улс төр нийгмийн бүрэн эрх мэдэлтнүүд өөрсдөд нь оногдуулсан шийдвэрийг хүлээн авч, шийдвэрлэдэг хүмүүс,

тэдний үйл ажиллагаа юм. Хүн ба хүмүүсийн хамтын бүлэг ямар байваас улс төр олон талаар тийм байна. Улс төр бол шинжлэх ухаан, урлаг юм. Тэр нь хүнд нийгмийн хөгжлийн хуулиуд тодорхой мэдэгдэх болсон цагаас нааш шинжлэх ухаан гэж тооцогдож иржээ. Хүн тэдгээр хуулийг мэдсэнээр улс төрд чиглэсэн зорилготойгоор нөлөөлж чаддаг байна. Ажил хэрэг нь улс төрийн үйл явцуудын субъектив талтай холбоотой бөгөөд хүний, зөн билэг, бүтээлч зориг, уран зөгнөл зэргийг ашиглах бололцоо олгодог болохоор улс төр бол урлаг юм. Ердийн практик дээр улс төрийг “боломжийн урлаг”, “удирдах урлаг” гэж нэрлэдэг болсон байна. “Улс төр” хэмээх нэр томьёо хэд хэдэн утга санаагаар хэрэглэгддэг. Түүний 1-р ач холбогдол бол хөтөлбөр, арга, үйлдэл буюу түүнд харьцагч хүн ба бүлгийн жинхэнэ үйлдэл юм. Тэрхүү харилцан хамаарал нь нийгмийн өмнө тулгарч буй нэг буюу цогц асуудал байж болох юм. Өөр нэг утга санаагаар “улс төр” гэдэг уг улс төрийн чиглэлүүд, бие хүн буюу өөрийн гэсэн ашиг сонирхол, ертөнцийг үзэл үзэл бүхий бие хүмүүс ба бүлгүүд өрсөлдөж, зөрчилдөж байгаа нийгмийн тэр салбарт хамаарагдана. Улс төрийн 3 дахь утга санаа нь институтчилэгдсэн хэмжигдэхүүн, Үндсэн хууль ба эрхийн дэглэм журам, уламжлалын туслалцаа бүхий баримтлал, нийгмийн засгийн тодорхой зохион байгуулалт, түүний засаглалын аргыг тэмдэглэдэг. Үүний хамтаар тэр нь бүлэглэл нэг бүрийн дотоод дахь хувь хүний харилцан ажиллагааны арга юм. Хамгийн өргөн утга санаагаар улс төрийг шинжлэх ухаан ба нийгмийн амьдрал, хүмүүсийг удирдах, тэднийг жолоодох урлаг гэж ойлгодог. Энд улс төрийн онол, улс төрийн менежментийн тухай өгүүлж байна. Энэ мэтээр улс төр хэмээх ойлголт, засгийн байгууллагууд, иргэдийн нэгдлүүдийн болон төр, анги, үндэстэн, хүмүүсийн томоохон бүлгүүдийн харилцааны салбар дахь тусгай бие хүмүүсийн эрх ашгаа хэрэгжүүлэх, хамгаалахад чиглэгдсэн ба улс төрийн засаглалыг олж авах, эзэмших, ашиглахтай холбоотой үйл ажиллагаа юм. Энэ бол төрийн хэрэгт оролцох оролцоо, түүний үйл ажиллагааны хэлбэр, зорилт, агуулгыг тодорхойлох явдал юм.

Улс төрийн агуулга нийгмийн зонхилогч социал бүлгүүд /хүчин/-ийн ашиг сонирхлоор буюу тэдний холбоодоор тодорхойлогдоно. Хэрэв шийдвэрлэлт нь засаглалын асуудалтай шууд буюу дам холбоотой бол нийгмийн аливаа асуудал ус төрийн шинжтэй болдог. Улс төр нь засаглалын харилцаатай холбоотой бүхнийг хамаарна.

Энэхүү сэдвийн өмнөх хэсэгт улс төрийг танин мэдэх, тайлбарлах, дүгнэх философийн онол-арга зүйн зарим асуудал, улс төрийн тухай ойлголтыг товчхон авч үзэв.

Нийгмийн шинжлэх ухааны түүхэнд улс төр шиг будлиантай, будлианд орсон асуудал бараг нэг ч үгүй юм. Үүний шалтгаан нь судлаачдын бурууд биш, уг асуудлын нарийн төвөгтэйд оршино. Энд ямар боловч улс төр хэмээх категорийг гаргаж тавилаа. Гэвч сэдвийн гол зорилго бол улс төрийг биш, харин улс төрийн философийг тодорхойлон харуулах, түүнийг судалдаг асуудлыг тодотгох явдал мөн.

Улс төр бол философи, түүх, эдийн засаг, улс төр судлал, социологи, сэтгэл зүй, нэг ялангуяа эрх зүйн шинжлэх ухаан зэргийн судалгааны зүйл, өөрөөр хэлбэл нийгмийн олон төрлийн шинжлэх ухааны уулзвар, зангилаа асуудал юм. Шинжлэх ухааны нэрлэсэн салбарууд улс төрийг өөр өөрсдийн зорилго, утга санаагаар томьёолон тодорхойлж, судлан дүгнэж ирсэн байна.

Ингэхлээр философи ертөнцийг үзэх өөрийн үзэл, байр суурь, зарчим, онолын үүднээс өөрийнхөө арга зүйгээр улс төрийг судлахыг улс төрийн философи гэж ойлговол зохино. Бодит байдал дээр философид хамааралгүй юмс, үзэгдэл байдаггүй болохоор философи сонирхож

судалдаггүй нэг ч зүйл байхгүй. Улс төрийн философийн асуудлыг түүний судлах зүйл гэж үзэж болно.

Судлаачид эртний дэлхийн болон хожмын мэргэдийн дэвшүүлсэн философитой харилцан хамааралтай аливаа ойлголт, томъёолол, сургаал зэргийг улс төрийн философи гэж ойлгож, нэрлэж заншсан байна. Орчин үед улс төрд хамааралтай философийн асуудлыг улс төрийн философи буюу улс төржсөн философи гэж нэрлэж байна. Гэтэл улс төрийн философийн нэгдсэн томъёолол, судлах зүйлийн тодорхойлолт гараагүй байна. Өрнөдийн болон Оросын дурьдсан асуудлыг сонирхон судлагч философичид улс төрийн философи гэдэг нэрийн дор философийн урьд, эдүгэгийн сонгодог төлөөлөгчдийн сургаалийн философийн асуудлыг авч үзэж байна.

Тэгвэл зохиогч асуудалд арай өөр өөрийнхөөрөө хандлаа. Минийхээр улс төрийн философи нь: 1. Улс төрийн философийн түүхийн асуудал; 2. философид улс төрийн хамаарагдах асуудлууд гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэл болж байгаа юм.

ПОЛИТОЛОГИ III

Эрдэм шинжилгээний бичиг¹ ... (...): 19-24 дэх тал

НАМ ТӨВТЭЙ УЛС ТӨРИЙН СИСТЕМИЙН ТАЛААРХ ӨРНӨДИЙН ШИНЖЭЭЧДИЙН ҮЗЭЛ БОДОЛ

А.Юндэндорж

доктор (Sc.D), профессор
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Ю.Ганболд

1972-1973 онуудад Америкт “Марксизм, коммунизм болон өрнөдийн нийгэм”¹ нэртэй 8 боть энциклопед нийтлэгджээ. Уг энциклопедийг нийтлүүлэхэд аль аль талаасаа ихээхэн анхаарч хүч төвлөрүүлсэн нь мэдрэгдэж байгаа юм. Энциклопед дээр баруун Германы политологич В. Леонгард, К.Фон Бейме, К. Вестен, Э.Оберлендер, Америкийн профессор Э.Браун, А.Коэн, К.Фридрих, П.Холлендар, В.Эрлих, Английн судлаач

¹Marxism, communism and Western Society. A comparative encyclopedia. N.Y., 1972-1973, 8 vols (ääì èèëýä)

П.Реддауэй, Л.Шапиро нараар толгойлуулсан эрдэмтдийн томоохон баг ажиллажээ.

Энцеклопед онол, арга зүйн хувьд тулгамдсан судалгааны олон асуудалд хариу өгсөний дотор нам төвтэй улс төрийн системийг судлахад голчлон чиглэгджээ гэж ойлгогддог. Энэ нь “Социалист нийгмийн улс төрийн системд” зонхилох үүргийг эрх баригч коммунист нам гүйцэтгэдэг гэдэг утгаар үндсэн асуудалд хандсанаас тодорхой.

1974 онд Францын социологич Франсуа Фейтогийн “Лениний үе”¹ гэдэг бүтээл нийтлэгдсэн бөгөөд уг бүтээлдээ автор социалист байгуулалтын явцад ажилчин ангийн намын үүрэг роль өсөн нэмэгдэх зүй тогтлын талаарх Лениний үзэл бодлыг тайлбарлахыг зорьжээ.

Ф.Фейтогийн бүтээлтэй зэрэгцэн мөн онд Америкийн судлаач Пол Холлендарын “Зөвлөлтийн болон Америкийн нийгэм”² сэдэвт томоохон бүтээл нийтлэгдсэн байна. П.Холлендарын бүтээл Зөвлөлтийн болон Америкийн нийгмийн ижил төстэй болон ялгаатай талуудыг зэрэгцүүлэн тавиад политологи, социологийн шинжлэх ухааны түгээмэл аргачлалын дагуу жишиж тайлбарласан байна.

Дээрхи нийтлэлүүдтэй ижил төстэй бас нэгэн сонирхолтой бүтээлийг Францын судлаач Марк Сапорт, Жорже Сория нар нийтлүүлжээ. “Агуу их дуудлага”³ нэртэй уг бүтээл энцеклопед маягаар зохиогдсон байх агаад агуулгын хувьд мөн л Зөвлөлт, Америкийн улс төрийн системийн үндсэн институтын үйл ажиллагааны зорилго чиглэлийг хооронд нь харьцуулж жиших байдлаар харуулжээ.

Энэ үеэр Америкийн их сургуулиудын профессор Г.Левин, Т. Вольф, С.Блэк, А.Кассоф⁴, В.Аспатурьян, Ж.Кэмпбелл нараар толгойлуулсан социалист гэгдэж байсан орнуудын улс төрийн систем судлалаар мэргэшсэн янз бүрийн чиглэлийн “Төв”-үүд эрчимтэй ажиллаж байв.

Тухайн үедээ “Зөвлөлт” хэлбэрийн нам төвтэй улс төрийн систем судлалаар нэрд гарч байсан Германы судлаач Вольфганг Леонгардын “Антикоммунизм” нэртэй бүтээл нийтлэгджээ. Уг бүтээлдээ автор ажилчин ангийн намын талаарх Лениний сургаал болон ЗХУКН-ын практик үйл ажиллагаа хоорондоо зөрчилдөж байна гэсэн санааг хөндөж тавьжээ.⁵ Тэрбээр бусад орнууд дахь социалист нийгэм болоод тэдгээрт эрх барьж байгаа коммунист чиглэлийн намуудын үйл ажиллагаанд ч дээрхийн адил зөрчилтэй талууд байгааг цохон тэмдэглэсэн байна.⁶ В.Леонгардын тэмдэглэснээр К.Маркс, Ф.Энгельс нар хувьсгалт тэмцэлд ажилчин ангийн гүйцэтгэх үүргийн талаар төсөөлж байснаас бус бүхэл бүтэн нийгмийн амьдралд аль нэг улс төрийн нам хутгалдан оролцох, түүгээр ч барахгүй удирдах боломжтой гэж төсөөлөөгүй байх л даа. Харин Лениний үзэл баримтлалыг хэт их дагаснаас болж “тоталитаризм” болоод “намын засаглал” тогтож, эцэстээ нийгэмд ардчилал зөрчигдөж, улс төрийн системд гажуудал үүсэх үндэс бүрэлдсэн гэжээ.⁷ Эл үзлийг судлаач К.Фридрих, К.Фон Бейли нар ч идэвхитэй дэмжиж байсан талаар судалгааны материалд тэмдэглэжээ.

¹ Fejto F. L'heritage de Lenine. Introduction a l'histoire du communiste mondial. Tournai, Casterman 1974 (ääi ёёёяâ)

² Hollendar P. Soviet and American society. A comparison. N.Y., Oxford, univ. press. 1974 (ääi ёёёяâ)

³ Le grand defi Encyclopedie comparee. USA –URSS. Sous la direction de M.Saporta et G.Soria.P.Robert Laffont. 1968

⁴ Prospects For Soviet society. Ed. By A.Kassot L, Paul Mall press, 1969 (ääi ёёёяâ)

⁵ Leonhard W. Eurokommunismus. Herausforderung Für Ost und West München 1978 (ääi ёёёяâ)

⁶ Ibid., p.82 (i'i öyîä)

⁷ Marxism, communism and Western Society. Vol.1, p.431 (ääi ёёёяâ)

Гэтэл Ф.Энгельс огт өөр байр суурьтай байсан бололтой. Пролетари нарын тэмцлийг ялалтад хүргэхэд ажилчин ангийн эрх ашгийг хамгаалж чадахуйц улс төрийн нам зайлшгүй хэрэгтэй гэсэн санаа “Коммунист намын тунхаг”-т тодорхой байна гэжээ.¹

Гэсэн хэдий ч В.Леонгард өөрийн байр суурийг хамгаалж шинэ шинэ нотолгоог гаргаж тавьсаар иржээ.

Тэдгээрийн нэгэнд дурьдахдаа Маркс, Энгельс нар ажилчин ангийн хувьсгалт тэмцэл ялалтанд хүрсэний дараахь улс төрийн системийг “Иргэдийн өөрөө удирдах ёс”-ний зарчимд тулгуурлах нь зөв гэж үзэцгээж байснаас бус аль нэгэн намын удирдлагыг хэрэгжүүлдэг систем байхаар төсөөлөөгүй² гэсэн санаа байдаг.

Карл Каутский “Пролетарийн диктатур” нэртэй, тухайн үедээ зүүний үзэл баримтлагчдын шүүмжлэлд нилээн өртөөд байсан бүтээлдээ пролетарийн диктатур гэсэн ойлголтыг большевикууд “Намын диктатур”³ болгож бодит амьдралд хэрэгжүүлсэн гэжээ. Үүнтэй агаар нэгтэй дүгнэлтийг Л. Шапиро “Большевикууд”⁴ гэсэн өгүүлэлдээ хийсэн байх юм.

Профессор Пол Холландер бидний өмнө өгүүлсэн “Зөвлөлтийн болон Америкийн нийгэм” гэсэн томоохон бүтээлдээ дурьдахдаа: “ЗХУКН бол засаглалын албан ёсны болон албан бус бүтэцийн хооронд гарсан ан цавыг нөхөх зорилготой, нэг ёсны холбогч хэрэгсэл”⁵ гэжээ. Тэрээр “албан ёсны” бүтэц гэдэгтээ нам төрийн өндөр зиндааны албан тушаалтнуудыг хамааруулж, “албан ёсны бус” гэдэгтээ жирийн олон түмнийг авч үзсэн ажээ.

Английн эрдэмтэн, түүх судлалын профессор Ж.Нэттл “Зөвлөлтийн ололт амжилт” номондоо нам төвтэй улс төрийн систем нь богино хугацаанд өндөр зохион байгуулалтад хүрэх боломжтойн хувьд байж болох хувилбарын нэг гэж үзээд, Зөвлөлтийн хувьд нийгмийнхээ бүх хүрээнд чамлахааргүй ололт амжилтанд хүрснийг жишээ болгон дурьджээ.⁶ Нам төвтэй улс төрийн системд элитүүдийн оролцоо ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг гэсэн санаа түүний дүгнэлтэнд ч байгаа юм. (автор)

XX зууны 70-аад онд ихээхэн нэрд гарч байсан судлаач Франсуа Фейто Францад нийтлүүлсэн “Лениний залгамж халаа” нэртэй номондоо тэмдэглэхдээ: коммунистууд өнгөн дээрээ намынхаа нийгмийн бүрэлдэхүүнд ач холбогдол өгч ярьдаг боловч уг чанартаа үзэл суртлын бүхий л хэрэгслийг ашиглан намынхаа үйл ажиллагаанд “пролетарийн хөдөлгөөн”-ий шинжийг хадгалахыг туйлаас хичээдэг гэжээ.

Асуудлыг сайтар тунгааж үзвэл нарийн ээдрээтэй тал бас байгаа юм шиг санагддаг. Жишээлбэл: намын нийгмийн бүтэц болон ангийн шинж гэсэн асуудлуудын хоорондын уялдаа холбоо болон тэдгээрийн аль нь тэргүүн ээлжинд тавигдах вэ? зэрэг нь тохиолдлын зүйл бас биш бололтой. Түүнчлэн ажилчин анги гэж чухам хэнийг хэлэх вэ? Биеийн хүчний хөдөлмөр эрхэлдэг болгоныг энд хамруулах уу?. Хэрвээ хамруулбал тэдний нийгмийг манлайлах үүрэгтэй тэргүүний хэсэг гэдэг нь юугаар илэрч байна вэ? гэдэг дээр бас бодож үзүүштэй юм. Өнгөн дээрээ асуудал маш энгийн мэт санагдаж байж

¹ Iadoē Œ, Yiaāēūñ Œ, Nī-, Œ.4, n433

² Marxism, communism and Western Society. Vol. 2, p.126 (ääi ēēēyā)

³ Aēōōāēūñā āñōññ nīāōāīāñē ēāāñēāē-āñēē āñōññ. Dāā. Œñ.: Aāāōññā A.ī ē āō. ī., nēēōēāāō, 1980, n. 59

⁴ Iñ ēyā, n.59

⁵ Hollander P. Soviet and American Society. A comparison. N.Y., Oxford univ. press, 1973, p.25 (ääi ēēēyā)

⁶ Nettle G.P. The Soviet achievement. L., 1967 (ääi ēēēyā)

болзошгүй. Гэтэл энэ талаар бэлэн хариулт өгчих судалгааны материал төдийлөн тааралдахгүй байгаа билээ.

Бидний дээр өгүүлсэн судлаач Ф.Фейто болон Австралийн Конберрегийн үндэсний их сургуулийн профессор Т.Г. Ригби нар намд шинээр гишүүн элсүүлж байгаа үйл явцыг тойруулж асуудлыг нилээн хөндсөн байна. Намын эгнээг тэргүүний хүмүүсээр сэлбэж бэхжүүлнэ гэдэг ойлголт сүүлдээ харьцангуй итгэл үнэмшилтэй болсон тал бий. Түүнээс биш ЗХУКН-ын үйл ажиллагааны бүхий л үеүдэд тийм байгаагүй. Түүний бичсэнээр заримдаа бүр золиосны хүмүүс бэлтгэх зорилгоор намд гишүүн элсүүлж байсан тохиолдол ч бий. Тухайлбал хувьсгалын жилүүдэд, улмаар иргэний болоод эх орны дайны жилүүдэд тулалдаанд орох цэргүүдийг олноор нь намд элсүүлж, намын билеттэй хамт винтов буу олгоод амь эрсэдсэн тулалдаанд оруулдаг байсан баримт захаас аван тааралддаг гэж тэмдэглэжээ.¹

Кёльн хот дахь Дорнод Европ судлалын институтын захирлын алба хашиж байсан, эрх зүйн профессор Г.Майскер нам төвтэй улс төрийн системтэй орнуудын тулгуур хуулиудыг судалж үзээд хийсэн нэгэн дүгнэлтэндээ “нэг намын тогтолцоо ардчиллын зарчимд нийцэхгүй”² гэжээ. Энэ үндэслэлээ тайлбарлахдаа тэрээр коммунист намын удирдан чиглүүлэх роль гэдгийн цаана иргэдийн чөлөөт сонголт хийх эрх ямагт хязгаарлагдаж байдаг. Шийдвэрлэх үүргийг эрх баригч нам гүйцэтгэж байдаг ийм нийгэмд төрийн засаглал хүссэн ч хүсээгүй ч “тоталитар” шинжтэй болдог гэж үзсэн.

Америкийн Техассын Их сургуулийн эдийн засаг, түүх судлалын профессор Уолта У.Ростоу “Улс төрийн бодлого ба өсөлтийн үе шатууд”³ бүтээлдээ ардчиллын үнэ цэнэ нь нэгдүгээрт, олонхийн сонирхлыг хамгаалж чадахуйц засаглалын механизмыг тогтоох боломжиндоо, хоёрдугаарт, иргэдийн сонголт хийх бололцоонд ямар нэгэн бэрхшээл саад учруулахгүй байх нөхцөл тухйн нийгэмд бүрэлдсэн эсэхэд байгаа юм. Энэ шалгуураар аливаа нийгмийн тогтолцоог шинжих учиртай гэсэн байр суурийг илэрхийлжээ.

Аль ч нийгэм бүтэцийн хувьд олон янзын сонирхлын бүлгээс бүрэлдэж байгаа нөхцөлд улс төрийн нэг нам тэд бүгдийн эрх ашгийг илэрхийлэгч байх боломжгүй гэж бидний өмнө дурьдсан “Зөвлөлтийн болон Америкийн нийгэм”⁴ бүтээлдээ автор тэмдэглэжээ. Эрх баригч нэг намын системд нам, улсын ажлын зааг ялгааг олоход бэрх. Хоорондоо холилдож, бие биетэйгээ нягт холбогдож сүлжилдсэн байгаа. Улсын чухал албан тушаалд хүн томилох эрх мэдэл төр, засгийн байгууллагад өөрт нь байдаггүй. Бүгд л намын шугамаар хянагдаж, зөвшөөрөгдөж, шийдвэрлэгддэг байна.

Клаус Вестены үзлээр бол коммунист дэглэмтэй орнуудын Үндсэн хуульд намын байгууллагын эрх үүргийн талаар төдийлөн тодорхой заадаггүй. Заасан ч хоёрдмол утгатай, бүдэг заалтууд байдаг.

Намын удирдан чиглүүлэх ролийг хүлээн зөвшөөрч түүнийгээ ил тодоор зарласан байгууллага бол тэдний зэвсэгт хүчин л байдаг.⁵ Энэ чинь чухамдаа төрийн хэрэгсэл шүү дээ. Улс төрийн тийм тогтолцоотой орнуудад коммунист

¹Yō iōin āāēiū ōōiōōōāāā Ćāē°ēēēēī 3 ņāy ēniōiēñō āiū yōñāyā, ōyāīēē yāīyūyā Ćāāō°ā āāēiū āēēēēyāyā 5 ņāy ōēī ēniōiēñō īāīā, āēēēēīyūō yēñēēēēē ī°ōñ°ī īyāyū āāēāāā. (Āāōiō) ņī.: Āāāēīāā Ē.Ē. Ēāīēīēēēī ēōōñī. ī., 1979 ō.7, ņ.16

²Verfassungs und Verwaltungsreformen in den sozialistischen Staaten. Hrsg.von R.V Schröder, B. Meisner. Berlin. Dunker und Humblot, 1979, s.71-72 (āāī ēēēyā)

³Rostow W.W. Politics and the stages of growth. Cambridge univ. press, 1971 (āāī ēēēyā)

⁴Hollander P. Soviet and American society. A comparison N.Y., Oxford univ. press 1973, p.72 (āāī ēēēyā)

⁵Marxism, communism and Western Society. Vol.2, p. 131-135 (āāī ēēēyā)

намын программ, дүрмийн заалтуудыг Үндсэн хуулийнхаа дээгүүр тавьдаг гэжээ.

Мөн чанартаа бол улс төрийн намуудад хүлээх, хүлээхгүй үүрэг гэж байдагчлан оролцох, оролцохгүй асуудал гэж зарчмын хувьд зааглагдсан байх учиртай. Тухайлбал улс орны гадаад, дотоод бодлогын глобаль асуудлууд нь ард түмний сонголтоор итгэл хүлээж гарч ирсэн төрийн институтын бүрэн эрхийн асуудал болох учир улс төрийн нам түүнд оролцоод байх нь зохимжгүй¹ гэж үздэг байна.

Гэтэл эл асуудлаар нам төвтэй улс төрийн системийн төлөөлөгчид арай өөр тайлбар хийж байжээ. Тухайлбал, намаас олон түмэн, олон нийтийн байгууллагатай харьцах асуудлаарх хуучин зөвлөлтийн судлаачдын баримтлаж байсан байр суурийг эргэн харж болох юм. Нийгмийн харилцаа боловсронгуй болох явцад намын үйл ажиллагааны хэлбэр, агуулга ч мөн адил өөрчлөгдсөн. Эрх баригч ангийн /пролетари/ болоод ажилчин анги сонирхлын үүднээс нийгмийн бусад анги болон төрд “диктатурын” аргаар ханддаг байсан Лениний үе аль эрт өөрчлөгдсөн. Нөгөө талаар намын талаарх Лениний концепцийг ч сайтар судалж үзүүштэй байгаа юм. Асуудлыг нарийвчилж үзвэл, нэгдүгээрт, коммунист намын удирдлага чиглүүлэлгүйгээр пролетарийн диктатурыг тогтоох боломжгүй гэснээс биш төрийн засаглалын эрх мэдлийг нам шууд төлөөлөх тухай санаа байгаагүй. Энэ хоёр бол харьцангуй ялгаатай асуудлууд билээ.

Шууд утгаар нь Лениний авч хэрэглэснээр социалист нийгэмд засаглалын эрх мэдэл ажилчин анги болоод хөдөлмөрийн тариачдын мэдэлд байж, төрийн засаглалын хэлбэр нь ажилчид, тариачдын депутатуудын Зөвлөлүүд байхаар төсөөлж байсан болов уу. Хоёрдугаарт, Лениний үед ч, хожмийн үед ч коммунист нам улс төрийн манлайлагчийн үүрэг гүйцэтгэхдээ зөвхөн өөрийнхөө төлөө бус харин ажилчин ангийн, бүр сүүлд “хөгжингүй социализмын” үе шатандаа нийт зөвлөлтийн ард түмний нэрийн өмнөөс асуудалд хандан, тэдний эрх ашиг, сайн сайхны тусын тулд үйлчилж ирсэн² гэж тайлбарлаж байв.

Коммунистууд намаа чадварлаг хүмүүсээр бэхжүүлэх, эгнээнийхээ тооны өсөлтийг хангах талаар байнга анхаардаг нь нэгдүгээрт, нийт ард түмний нам гэсэн бодлого баталгаажуулах, хоёрдугаарт, нам нийт нийгмийг удирдан чиглүүлэгч хүч гэдгээ нотлох зорилго агуулдаг гэсэн санааг хэлж байгаа юм.

Нам улс төрийн системийн “цөм” гэж социалист системд байсан орнуудын Үндсэн хуулинд албан ёсоор хуульчлагдсан байжээ. Тухайлбал ЗХУ-ын 1977 онд батлагдсан Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд болон 1947 оны Үндсэн хуулийн 126 дугаар зүйлд ЗХУКН бол улс төрийн системийн “цөм” бөгөөд нийгмийн удирдан чиглүүлэгч улс төрийн хүчин мөн гэж заасан.

Нам төвтэй улс төрийн системийн судалгаанд анхаарал хандуулсан өрнөдийн судлаачдын өөр нэг хэсгийн төлөөлөгчид болох К.Керниг, П. Шайберг нар хамтран бичсэн “Ленинизм” хэмээх өгүүлэлдээ тэмдэглэхдээ: “Коммунист тогтолцоонд нам, төрийн ажил холилдсон байдаг нь бүр Лениний үеэс эхтэй юм. Тэр намын гүйцэтгэх үүргийн тухай ойлголтыг пролетарийн диктатурын болон төрийн гүйцэтгэх үүргийн тухай ойлголттой ижил хэмжээнд авч үздэг байсан”³ гэжээ.

¹ Hollander P. Soviet and American society. A comparison N.Y., Oxford univ. press 1973, p.72 (аан өөгүй)

² нл: Аеооаеиоа аиоиоо ниаоаиоо еааиоо-аиоо аиооао. Даа. еиооаеу Ааооуна А.і е аооаеа. і., нёооёаао, 1980, н.67

³ Marxism, communism and Western Society. Vol.5, p. 126

Дээрх судлаачдын тэмдэглэлтэй холбогдуулан Зөвлөлтийн эрдэмтдийн хийсэн тайлбараас үзвэл Ленин намын (түүнчлэн Төв хорооны) болон Зөвлөлт засгийн хариуцах ажлын зааг ялгааг илүү тодорхой болгох, ажилтнуудын хариуцлага, сахилга, бие даасан байдлыг дээшлүүлэх шаардлагатайг нэг биш удаа цохон тэмдэглэж байсан бололтой юм. Харин нам (коммунист-большевикуудын) бол Зөвлөлт засгийн байгууллагуудын үйл ажиллагааг бүхэлд нь хянаж, удирдах үүрэгтэй¹ гэсэн санааг шууд утгаар нь илэрхийлсэн байна.

Улс төрийн системийг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй депутатуудын зөвлөл, комсомол, үйлдвэрчний эвлэл, хоршоологчдын эсвэл зэрэг олон сая гишүүд, олон нийтийн байгууллагуудын сонгуульт идэвхитний үйл ажиллагааны талаар судлаачид бас саналаа хэлсэн байдаг.

Өрнөдийн судлаачдын байр суурийг авч үзвэл тэдгээр нь онолын хувьд, бие даасан байгууллагууд. Гэвч тэдгээр байгууллагыг нэг талаар коммунистууд толгойлдог болон нөгөө талаар намын байгууллагын өмнө ажлаа хариуцан тайлагнадаг байхаар эрх зүйн хувьд зохицуулж өгсөн зэрэг нь хэрэг дээрээ намын байгууллагад туслах бас нэгэн хэрэгсэл болгож хувиргасан² гэжээ. Ганцхан жишээ дурьдахад ЗХУКН-ын дүрмийн 63 дугаар зүйлд комсомол бол намын удирдлагын дор ажилладаг, намд туслах, намын залгамж халааг бэлтгэх үүрэгтэй, залуучуудын байгууллага³ гэж заасан байна.

Энд зарим нэг тоон үзүүлэлтийг дурьдаж болох байна. Тухайлбал: өрнөдийн судлаачдын нам төвтэй улс төрийн системийн “эталон” /загвар/ болгон авч үздэг байсан Зөвлөлтийн тогтолцоог уг систем задралд орох үеийн нь тоон үзүүлэлтээр харуулбал 1991 оны байдлаар ЗХУКН эгнээндээ 19 сая гишүүдтэй, тэдний 4.4 сая нь намын сонгуульт идэвхтэн байжээ.

Төрийн сонгуульт байгууллага болох Зөвлөлүүдийн бүх шатны депутатаар 2.2 сая, Зөвлөлүүдийн дэргэд байгуулагдсан төрөл бүрийн салбар, комисс, орон тооны бус хяналтын пост, групп, ижил төстэй байгууллагуудад 30 сая хүн сонгогдон ажиллаж байжээ. Түүнчлэн үйлдвэрчний эвлэлийн сонгуультан 12 сая, комсомолын идэвхтнүүд 6 сая, ардын хяналтын байгууллагуудад 10 сая, нийтийн хэв журам сахиулах үүрэг бүхий ардын сайн дурын нөхөрлөлд 7 сая идэвхитэн ажиллаж байсан баримт бий.⁴

Энэ нь нэг талаар Зөвлөлт нийгмийн элитүүдийн эгнээг харуулсан тоон үзүүлэлт байгаа юм. Нөгөө талаар улс төрийн системийг бүрдүүлж байсан субъектүүдийн бүрэлдэхүүнийг харуулсан чанарын үзүүлэлт гэж ч үзэж болохоор байгаа билээ. Энэ бол асар их хүч нөөц хуримтлагдсан байжээ гэсэн үг. Гэвч нийгмийн тогтолцооны өөрчлөлт шинэчлэлийн давалгааны хүч үүнээс ч илүү байсан бололтой.

Нам төвтэй улс төрийн систем нь түүхэн тодорхой хугацаанд, тодорхой улс орнуудад бодитойгоор оршин тогтнож байсныг хэн ч үгүйсгэхгүй байх. Тэдгээр улс орнуудын дийлэнхи нь уг системээс татгалзсан хэдий ч тухайн үеийнх нь нөхцөл байдлаас авч үзвэл бас бүгдийг буруутгах аргагүй мэт санагдана. Энэ талаар янз бүрийн эрэл хайгуул, шинжилгээ судалгааны ажил үргэжлэн хийгдсээр байх болов уу.

¹ Țăriei A.È ĩieĩ.ĩĩăđ. ĩĩ÷., (5-ĩă ecăăieă) 0.45, ĩ.61

² Marxism, communism and Western Society. Vol.2. p. 117

³ **làoǎoèàèû ŌŌIY ñúǎçää ÊĨÑÑ, ñ.231**

⁴ Nî.: Nîoââi÷îeê îàòòèèîîîî òàâîòîèèà, âûîóñê 16, ñ.456-457

Шинжлэх ухааны өнөөгийн түвшингээс авч үзвэл нийгэмд үйл ажиллагаа явуулдаг олон янзын институт (төрийн, улс төрийн, намын, төрийн бус байгууллагын г.м) байдаг.

Тэдний аль аль нь нийгэмд “зохицуулагч”-ийн үүрэг хүлээх үүднээс эрхийн актууд гаргадаг. Чухамхүү эдгээр актуудын үйлчлэх хүрээ харилцан адилгүй байх асуудал Үндсэн хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бусад салбар хуулиудад тусгагдсан байх шаардлагатай гэдэг байр суурийг ХХ зууны 70-80-аад онуудаас өрнөдийн судлаачид идэвхитэй дэмжиж иржээ.

Ялангуяа төрийн эрх мэдэл хуваарилах зарчим ийм байхыг шаарддаг. Энэ байр сууринаас авч үзвэл засаглалын субъектүүдийн эрх мэдэл, үйлчлэх хүрээ бусад институтээс давуу байх нь дамжиггүй билээ.

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт нийтлэгдэнэ)

ПОЛИТОЛОГИ III

Эрдэм шинжилгээний бичиг ¹ ... (...): 25-35 дахь тал

УЛСТӨРИЙН СОЁЛ: ИНСТИТУЦИОНАЛЬ ХЭМЖЭЭС

Ё.Довчин

доктор, профессор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Улстөрийн соёлын үзэл баримтлал улстөр хэмээх үзэгдлийг бүхэлд нь цогцоор авч үзэх бололцоо олгодоогоороо давуу талтай байдаг. Хэрэв улстөрийн соёлыг мэдрэмж, мэдлэг, үнэлэмж болж хувирсан улстөрийн систем хэмээвээс тэр нь тухайн нийгмийн улстөрийн хүрээний өнгөрсөн

туршлага, өнөөгийн амьдралыг өөртөө тольдон харуулдаг гэж болно. Энэ утгаар улстөрийн соёлын институциональ бүрэлдүүлбэр, түүний дотор монголын эдүгээгийн улстөрийн соёлыг институциональ хандлагын үүднээс задлан ялгаж шинжлэх нь судалгааны чухал чиглэл байх учиртай.

90-ээд оноос манай орон улстөр-нийгмийн ээдрээтэй цаг үеийг туулж байна. Улирч одсон он жилүүдэд улстөр, төр засагт хандах олон нийтийн хандлагад огцом өөрчлөлтүүд гарав. Эл үеийн улстөрийн түүхийн хамгийн гол шинж нь монголын нийгэм хэдийгээр хямралаас бүрэн гарч амжаагүй ч ардчилсан институтууд, үнэт зүйлс нийгэмд ямар нэг хэмжээгээр үндэслэн соёолж нийгэм идээшин дасч байгаад оршино. Гэвч ард хоцорсон арван таван жил улстөр судлаачдад улстөрийн олон олон эгзэгтэй асуудлуудыг судалгаа шинжилгээний өв болгон үлдээсэн бөгөөд өнөөдөр ч тэдгээр нь хариу нэхсээр буй.

Сүүлийн үед төрийн болон төрийн бус институтууд, тухайлбал, улстөрийн намуудад итгэх итгэл алдрах төлөвтэй байна. Улстөрийн лидерүүдэд хандах нь зэвүүцэл дургүйцлээр (*cynicism*) солигдож байна. Олонхийн улстөрийн сонголтыг хүндэтгэхээ болив. Эрх мэдэлд улайрсан тэмцлийн хөлд улстөр хийхийн эцсийн утга учир алдагдаж, тэр ч атугай “зорилго нь аргаа зөвтгөх”-ийн илрэлүүд хүч авах төлөвтэй. Элитийн улстөрийн соёл цэгцрэн ялгарч, эргэж олон түмэнд зохистой нөлөөлж чадахгүй байна. Ер нь л улстөрийн тоглоомын дүрмийг хэн дуртай нь яаж ч зөрчихөөс сийхгүй болж, түүнийхээ төлөө хууль, ёс зүйн хариуцлага хүлээдэггүй нь гэм биш зан болж гэмээр. Энэ бүхэн монголын улстөрийн соёлын суурь өөрчлөлтийн өнгөн талын, түр зуурын шинжтэй үзэгдэл үү, эсвэл улстөрийн нийгэмшил хэт удаан, аль эсвэл буруу замаар будилаад явна уу гэдгийг цаг хугацаа харуулах нь лав. Улстөрийн гүнзгий өөрчлөлтийн үйл явцад институциональ бүтцүүдийн гүйцэтгэх үүрэг, ролийг анхааралтай ажиглаж судлах шаардлага тавигдах нь зүйн хэрэг.

Ийм нөхцөлд шинэ тутам үүссэн ардчилсан институтууд хэр зэрэг тэсэн тогтож, эрийн цээнд хүрч, улстөрийн үйл явц “зөв” голидролоороо өрнөж чадах уу, үүнд ухамсартай рациональ хүчин зүйлийн шийдвэрлэх нөлөө байх уу гэдгийг улстөрийн шинжлэх ухааны онол-арга зүйд тулгуурлан шинжлэх нь чухал хэвээр байна.

М.Веберын үзсэнээр улстөр бол мөн чанар нь засаглалаар илэрхийлэгддэг нийгмийн харилцааны салбар болохын хувьд “улсуудын хооронд ч, улс дотроо ч засаглалд оролцох, аль эсвэл засаглалыг хуваарилахад нөлөөлөх тэмүүлэл” ажээ (*Вебер, 1990, с.646*). Тэрбээр нийгмийн тодорхой макро бүтэц болох улстөрд хүмүүсийн эзлэх байр сууриас хамаарч тэднийг нэгдүгээрт, “тохиолдлын улстөрчид” (*жирийн сонгогчид бид бүхэн*); хоёрдугаарт, “*хавсарсан улстөрчид*” (*жишээ нь, намын идэвхтнүүд, тэдний хувьд улстөр үйл ажиллагааных нь үндсэн салбар болоогүй*); гуравдугаарт, “мэргэжлийн улстөрчид” (*төрийн зүтгэлтнүүд, төрийн албан хаагчид, намын орон тооны ажилтнууд гэх мэт*) гэж гурван үндсэн бүлэгт хувааж үзсэн байдаг. Ийнхүү улстөр бол нийгмийн амьдралын онцлог хүрээ, засаглалын харилцаанд бүх хүмүүст ямар нэг байр суурь, роль ногддог гэсэн түүний үзэл санаа орчин үеийн бүтэц-үүргийн хандлага, түүний дотор Т.Парсонсын системийн онолд нөлөөлсөн ажээ.

Т.Парсонс улстөр нь нийгмийн системийн нэг дэд систем хэмээн үзээд “Улстөрийн амьдрал нийгмийн дэд системийн хувьд зорилго тодорхойлох, шийдвэр гаргах, тэдгээрийг хэрэв шаардлагатай бол улс орны нийт нөөцийг дайчлах замаар хэрэгжүүлэхээс бүрддэг улстөрийн тоглоомын хууль-эрх зүйн дэгийн хүрээнд засаглалын байгууллагуудаар дамжуулан лидерүүд хүмүүст

нөлөөлөх үйлдлүүдийн нэн нарийн нийлмэл цогц мөн” гэж тодорхойлжээ (Парсонс, 1993). Парсонсын улстөр бол нийгмийн амьдралын харьцангуй бие даасан дэд салбар болох тухай үндэслэл системийн шинжилгээний хөрсийг засч өгсөн гэж болно.

Д.Истон улстөрийн систем, түүний гадаад орчин хоёрын хоорондын шууд ба эргэх холбоог судлах үндсэн дээр өөрийн улстөрийн системийн онолоо боловсруулсан байдаг. Түүний загвар ёсоор (Easton, 1986, pp.29-43-д үз) улстөрийн системийн оршин тогтнох механизм, нэгдүгээрт, оролт (*дэмжлэг, шаардлагын хэлбэрээр гадаад орчин улстөрийн системд нөлөөлөх*), хоёрдугаарт, “хувиргалт” засаг төрийн хариуг шийдвэр болгож бэлтгэх, гуравдугаарт, шийдвэр гаргаж түүнийг практикт хэрэгжүүлэх, дөрөвдүгээрт, “гаралт” (*засаг төрийн үйл ажиллагааны үр дүн гадаад орчинд эргэх холбоогоор дамжиж нөлөөлөх*) гэсэн үе шатуудыг багтаадаг. Улстөрийн систем гадаад орчноос байнгын дохио авч байдаг нээлттэй систем юм. Түүний үндсэн зорилго нь орчиндоо дасч зохицох замаар системийн оршихуй, тогтвортой байдлыг хадгалахад оршдог.

Улстөрийн системийн дотоод агуулгыг институциональ бүрэлдүүлбэрүүд, тэдгээрийн хоорондын бүтцийн холбоо, харилцан үйлчлэл, мөн эдгээр холбоо, харилцан үйлчлэлийг зохицуулдаг албан хийгээд албан бус хэм хэмжээнүүд тодорхойлдог. Үүнээс үүдэн улстөрийн системийг гол төлөв зохион байгуулалтын (институтүүд), мэдээлэл-харилцааны (олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, коммуникацийн сувгууд), норматив-зохицуулалтын (хэм хэмжээнүүд), соёл-үзэл суртлын (үзэл санаа, үнэт зүйлс) гэсэн дэд системүүдээр бүдүүвчлэн харуулж болдог. Бүх дэд системүүд харилцан уялдаатай. Аливаа улстөрийн байгууллага өөрийн гэсэн системтэй, тодорхой үзэл суртал баримталж үйл ажиллагаандаа хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаж байдаг билээ. Ийм шүтэлцээ нь нэг дэд системийн бүрэлдүүлбэр “*доголдоход*” нөгөөдөө, түүгээр зогсохгүй нийт системийн хэвийн ажиллагаанд нөлөөлнө гэсэн үг. Эдгээрийн дотроос **ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН** дэд системд улстөрийн засаглал институтижиж, хууль ёсны болж, легитимжиж, хэрэгжиж байдгаараа системийг хадгалахад шийдвэрлэх үүрэгтэй. Гэвч энэ нь бусад бүтцийн чиг үүргийг үгүйсгээгүй нь ойлгомжтой. Тухайлбал, **соёл-үзэл суртлын** дэд систем гэхэд улстөрийн намууд нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхлыг илэрхийлсэн онолын үзэл санаануудын нийлбэр цогцоос бүтсэн тодорхой улстөрийн үзэл суртлыг баримталж байдаг жамтай. Нийгэмд байдаг олон төрлийн үзэл суртал дундаас төр аль нэгэн үзэл суртлыг төрийн хэмээн зарладаггүй ч сонгуульд ялсан улстөрийн хүчин улстөрийн бодлогодоо өөрийн үзэл суртлыг ямар нэг хэмжээгээр баримжаа болгодгыг хүлээн зөвшөөрч таарна. Улстөрийн соёл нь улстөрд хандах хүмүүсийн субъектив хандлага, мэдлэг, мэдрэмж, үнэлэмжийн чиг баримжаа, үйл байдлын хэв загваруудыг илэрхийлээд зогсохгүй, бусад дэд салбаруудын “зан авир” улстөрийн соёлоор нэгтгэн илэрхийлэгддэг байна. Улстөрийн систем бүхэлдээ, түүний институт бүр тодорхой улстөрийн хэм хэмжээнүүдийн үндсэн дээр оршин тогтоно. Иймээс **норматив-зохицуулалтын** дэд систем бие даасан чиг үүрэг биелүүлэх бөгөөд улстөр-эрх зүй, ёс суртахууны хэм хэмжээг багтаадаг. Хэрэв хэн нэгэн үндсэн хуулийн заалт, эсвэл намын гишүүн дүрмээ зөрчвөл хариуцлага хүлээнэ. Харин ёс суртахууныг хөсөрдүүлсэн этгээдэд хүний мөс талаас нь нийгмийн зүгээс хүлээлгэсэн зэмлэл бол хараахан шийтгэл биш юм.

Улстөрийн коммуникацийг нийгмийн системийн янз бүрийн хэсгүүдийг холбож өгч, нэг “бие махбод” болгож өгдөг утгаар нь америкийн нэрт улстөр судлаач К.Дойч түүнийг улстөрийн “цусан хангамж”, түүнчлэн “эхийн сүү”-тэй

зүйрлэсэн нь **мэдээлэл-коммуникацийн** дэд системийн суурь үүргийг онцгойлон үзсэн нь тэр. Шинжлэх ухаан техникийн эрин үед мэдээллийн ач холбогдол урьд өмнө байгаагүй өсч, түүний нөлөөгөөр улстөрийн нийгэмшлийн үйл явцын хурдац нэмэгдэж, хүмүүсийн улстөрийн мэдээллийн төвшин ахисан нь улстөрийн шийдвэрийг сонгох бололцоог улам бүр нээлттэй болгожээ. Нөгөө талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслийг буруу зорилгоор ашиглах, олон түмний санаа бодлыг төөрөгдүүлэх явдал элбэгшив. Улстөрийн коммуникаци дан ганц хэвлэл мэдээллийн хэрэгслээр хязгаарлагдахгүй бөгөөд коммуникацийн бүх төрлийг тухайлбал, албан ёсны хийгээд албан бус, хувь хүмүүс хоорондын (*жишээ нь, цуурхал*) гэх мэтчилэн мэдээлэл харилцааны олон хэлбэрүүдийг багтаадагаараа илүү өргөн хүрээтэй ойлголт юм.

Ийнхүү улстөрийн системийн онолын үүднээс монголын нийгмийн өнөөгийн улстөрийн системийг ажиглавал шилжилтийн ээдрээтэй үеийг туулж байгаа нь илт. Улстөрийн системийн дэд системүүдэд байнга доголдол, “гацаа” үүсч үндсэн гол институтүүд, түүний дотор, тухайлбал, төрт ёс, улстөрийн намууд, намын систем, сонгуулийн систем, иргэний нийгмийн бүрдлүүд буурь сууж төлөвшөөгүй байна. Өөрөөр хэлбэл, улстөрийн шинэ систем нийгэмтэй хэрхэн харилцаж байх, мөн түүний бүрдэл хэсгүүдийн шинж чанар, хэлбэр ямархуу болохыг тааж хэлэхэд эрт байна. Эхний үед шинж чанар, хэлбэр нь либерал-ардчилсан улстөрийн системийг ихэнхдээ санагдуулж байсан бол ойрын үед социаль-демократ чиг давамгайлах хандлага байна. Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын харилцан тэнцвэр, хяналтын зарчим одоо ч бүрхэг буй. Өнгөрсөн жилүүдэд манайд хоёр намын систем батжин бэхжих болов уу хэмээн хүмүүс тааварлаж байсан хэдий ч харин одоогийн хандлага, эрх зүйн орчин олон намын систем бүрэлдэхэд илүүтэй нөлөөлөх шинжтэй. Норматив дэд системийн зохицуулагч хүч мөхөсдсөөр буй нь цаашид ч улстөрийн систем сульдаатай байхын гэрч болно. Хууль болгон эрх зүйт (*шударга*) байж чадахгүй, гарсан хууль хэрэгжихгүй байгаа нь эрх зүйт төр төлөвшихөд чөдөр тушаа болсоор байна. Энэ нь “монголын хууль гурав хоног” хуучин сэтгэл зүй амь бөхтэй хадгалагдаж, хуулийн өмнө бүгд тэгш байх зарчим тунхаглал төдий, нийгэм-улстөрийн харилцаанд танил талын холбоо сүлбээ, жалга довны үзэл зонхилсон хэвээр ажээ. Ийм нөхцөлд клиентелизм, нативизм, непотизмын илрэлүүд хүчтэй байхаас яахав. Улстөрийн ашиг сонирхлыг илэрхийлэх, нэгтгэх үйл явцад патрон-клиентын харилцаа ямар нэг хэмжээгээр байдгийг үгүйсгэх аргагүй ч уг хэлбэр дангаар давамгайлж эхэлбэл нийгмийг ардчилахад ихээхэн уршигтай байх болно.

Гадна орчноос ирж буй дохио сануулгад хариулах улстөрийн системийн уян хатан чанар, чадвар сул байгаа. Хүн амын хэрэгцээ, ашиг сонирхлоос улбаатай санал хүсэлт, шаардлагад тохирсон хариуг тухай бүр шуурхай, итгэл үнэмшилтэй өгч чадахгүйгээс нийгэмд бухимдал үүсэх нь цөөнгүй. Улстөрийн системийн нэг эмзэг тал нь улстөрийн шинэ институтүүд ихэнхдээ өрнөдийн загварыг тэр чигээр нь дуурайж хуулбарласан шинжтэйд оршино. Энэ нь улстөрийн бүтэц, нөгөө талаас соёлын үндэс язгуур хоорондын зөрчлийг үүсгэдэг гэсэн үг. Барууны улстөрийн эрдэмтдийн дунд нэг үе хотжилт, аж үйлдвэржилт, боловсрол, мэдээлэл харилцаа мэтийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн тодорхой “босгуудыг” давж аажим хувьслын замаар ардчилалд шилжин орох ёстой гэсэн үзэл түгээмэл байсан бол, аз болоход ялангуяа ардчиллын гуравдахь давалгааны судлаачид ардчиллын үзэл санаа хөгжлийн ямарч төвшинтэй оронд уламжлалд нь тулгуурлан “*диффуз*”-ын замаар нэвтэрч тархахаар барахгүй ардчилсан институтүүд

уламжлалт бүтцүүдтэй эв зүйгээ олж дасан зохицох бүрэн боломжтой гэж нотлох болсон билээ. Иймд монголын ардчилсан сонголт буруу байгаагүй, ардчилал манайд идээших бодит бололцоо бий гэдэгт эргэлзэх хэрэггүй мэт. Гагцхүү улстөрийн ардчилсан систем бүрдүүлэх нь шинэ бүтцүүд, хэм хэмжээнүүдийн институтжилт төдийгүй уламжлалт соёлын элементүүдийг оновчтой хослуулах тухай асуудал тулгарсаар буй. Монгол хүн "гаднаас харахад тодорхой үзэл санааг хялбархан хүлээн авч буй мэт боловч түүнийгээ нэн өнгөц байдлаар хялбарчлан үздэг. Иймэрхүү хэв загвар монгол хүнийг туйлшралд байнга оруулж байдаг. Иймээс "түүхийг болон нийгмийг цоо шинээр гадаадыг дуурайн байгуулах хүсэлтэй" гэж судлаачийн тэмдэглэсэнтэй санал нийлэхээс аргагүй. Бид өнөөдөр барууны улстөрийн онол, үнэт зүйлсийг судалж, сургаж, сурталчилж, ажил үйл болгох гэж оролдож байгаа нь нэгэнт үнэн учраас алхам тутамдаа монгол менталитет, улстөрийн сэтгэлгээний уламжлалаа санаж бодолцох хэрэгтэй болно.

Хүний эрх, эрх чөлөө, эрх зүйт төр, парламентат ёс, сонгууль, олон намын систем, индивидуал үзэл бүгд улстөрийн сэтгэлгээ, тэмцэл, түүх, соёл, нийгэм-эдийн засгийн тэс ондоо нөхцөлд үүсч бий болсон, олон зуун жилийн жам ёсны хөгжлийн бүтээгдхүүн юм. Хэрэв улстөрийг засгийн эрхийн төлөө ашиг сонирхлын хайр найргүй тэмцэл хэмээн тодорхойлбол өрнөдийн жишгээс их хазайхгүй биз. Чингэж хэлсэнээр нь бид ч тэднийг буруутгаж чадахгүй. Учир нь капиталист нийгмийн туулсан зам, бодит байдал нь тийм байв. Тэгвэл монгол хүн эрхээс үүрэгт, эрх чөлөөнөөс сахилга, дэг журамд, эрх ашгаас эрхэмлэлд, хувь үзлээс хамтын ёсонд, эвдрэлцээнээс эв эед илүүтэй тал өгч ирсэн нь бас түүний буруу биш. Монголын улстөрийн соёлын мөн чанарыг төрт ёс, үүрэг, суртахуун тодорхойлдог гэж болно. "*Төр төмбөгөр, ёс ёмбогор*". Монголчуудын улстөрийн философи ийм. Ёс суртахуунгүй бол хууль биелүүлэх тухай ярилтгүй. Ер нь хүний нэр төр, алдар хүндийг эрх зүйгээр хамгаалах нь маш нарийн асуудал байдаг. Монголчууд төрөө дээдэлдэг ч бас ч бүхнээ түүнд даатгадаггүй. "Эзэн хичээвэл заяа хичээнэ" хэмээн ахмад нь залуудаа, эцэг эх нь үр хүүхэддээ, багш нь шавьдаа үеэс үед сургасаар ирсэн нь нэгийг хэлсэн хэрэг. Харь соёлын үнэт зүйлсийг өөрийн шүүлтүүрээр тунгаан авч, монголын улстөрийн соёл улам олон талт, нийлмэл, баялаг агуулгатай болж, орчин үежиж, шинэчлэгдэж чадваас улстөрийн систем шинэ нөхцөлд түргэн дасч зохицох болно. Бусдын хөгжлийн туршлага, үндэсний соёл уламжлалын онцлогийг тэнцүү харгалзах нь эцсийн дүнд шилжилтийн амжилтыг тодорхойлох болно. Монголын ардчилсан улстөрийн системийн шинж төлөв, загвар чухам үүнээс хамаарах учиртай.

Улстөрийн системийн зохион байгуулалтын дэд бүтэц, түүний дотор төрөөс их зүйл шалтгаалах нь хэн бүхэнд ойлгомжтой. Төр бол онцгой засаглал, бүрэн эрхээр тодорхойлогддог албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн зохион байгуулалтын нийтлэг түгээмэл хэлбэр юм. Улстөрийн шинжлэх ухааны түүхэнд улстөрийн тухай үзэл санааны хөгжилд төр ямагт төв байр эзэлж ирсэн байдаг. Улстөрийн сэтгэлгээнд "*төр төвтэй*" үзэл олон зууныг элээсэн бөгөөд төр хүмүүсийн амьдралыг зохицуулагч дээд засаглал хэмээх парадигм үеэс үед ноёрхож байжээ. Хөгжлийн явцад түүний агуулга өөрчлөгдөж төрийн дангаар захирах ёс төр-иргэний хийгээд иргэд хоорондын харилцан хүлээх үүргийг товойлгож тавих болсныг жишээ нь, "нийгмийн гэрээ"-ний онолын үеэс ажиглаж болно. XX зуун гэхэд "*нийгэм төвтэй*" парадигм улстөрийн онол, парактикт хүчтэй түрж орж ирсэн байдаг. Түүний үндсэн санаа нь төр дангаар ноёрхохын эсрэг плюраль үзэл санаа, нийгмийн янз бүрийн давхарга, бүлгүүдийн нөлөө, хяналтыг сэргүүлэн тавьсанд оршино. Ийнхүү хэдийгээр төрийн тухай номлол цагийн аясаар өөрчлөгдөж

тэр ч атугай төр мөхөх тухай марксизм, төр ерөөс хэрэггүй тухай анархизм гэх мэт улстөрийн үзэл суртлууд чанагш гарч ирсэн ч нийгмийн амьдралыг зохицуулахад төрийн эзлэх байр суурийг төдийлөн ганхуулж чадаагүй гэж болох биз. Учир нь үүнийг бодит байдал “зөвшөөрөх” аргагүй байв. Өнгөрсөн зууны 80-аад оноос улстөрийн шинжлэх ухаанд неоинституциональ хандлага өргөн дэлгэрч, түүний төлөөлөгчид юуны өмнө институцийн макро бүтцийг товойлгон тавьж улстөрийн институтууд, тэдгээрийн зохицуулагч хэм хэмжээнүүдийн хувьсал өөрчлөлтийг шинжлэх замаар улстөрийн хөгжлийн далд механизмуудыг нээж үзүүлэхийг зорьсон бөлгөө. Неоинституционализм улстөрийн институтууд албан ёсны байгууллагууд, албан ёсны дүрэм журмыг төдийгүй засаглалтай холбоо бүхий харилцаануудын зохион байгуулалтын хэлбэрүүд, албан бус хэм хэмжээ, процедурыг багтаадаг гэж үздэгээрээ уламжлалт институционализмаас онцлог юм. Улстөрийн институтууд нь албан хийгээд албан бус хэм хэмжээнүүдээс бүтсэн зохион байгуулалтын нарийн төвөгтэй харилцааг бий болгодогыг неоинституционалистууд үгүйсгээгүй ч улстөрийн субъектүүдийг нэлэнхүйд нь “нийгмийн хүчнүүдийн тусгал” мэтээр үзэхийг эс зөвшөөрч, харин улстөрийн байгууллагууд мэдэгдэхүйц автономи шинжтэй, улстөрийн өөрчлөлтийн бие даасан хөдөлгөгч хүч, нэг үгээр төрийн институтууд бол макро улстөрийн универсум байх учиртай ажээ. Энэ үүднээс өнөөгийн монголын институцийн системийн бүрдэлтийг ажиглахад нэг талаас албан ёсны институтууд, хэм хэмжээ, нөгөө талаас албан бус институтууд, “тоглоомын дүрэм” хоорондын зохистой харьцаа алдагдсан гэж болохоор байна. Тухайлбал, лобби бүлгүүд намын нэрээр ажиллаж, янз бүрийн ашиг сонирхлуудыг зүй ёсоор нь илэрхийлдэг парламентын хэлбэрүүдийн оронд хуурамч корпоратив маягийн бүлэглэлүүдийн нөлөө хүчтэй болж, төрийн захиргааны байгууллагуудын шийдвэр гаргах үйл явц ил тод биш байдгаас нөөцийн дахин хуваарилалт бюрократуудын үзэмжээр шийдэгдэх нь олонтаа. Иймд манайд бүрдэж буй институцийн системийг энэхүү корпоратив-бюрократ тоглоомын дүрмийг харгалзахгүйгээр дан албан ёсны институт, хэм хэмжээний хүрээнд ойлговоос учир дутагдалтай болох нь. Дурдсан “тоглоомын дүрэм” цаашид газар авбал улстөрийн системийн төлөвшилд сөрөг нөлөөлж, түүнийг авторитар-олигархи давамгайлсан дэглэмд хүргэхгүй гэх газаргүй. Ийм байдалд орохгүйн тулд неоинституционалистуудын үздэгчлэн ялангуяа шилжилтийн ээдрээтэй нөхцөлд төр, түүний институцилтийг гойд анхааран авч үзэх шаардлага тулгарч байна.

Дээр өгүүлснээр улстөрийн шинжилгээний “*нийгэм төвтэй*” парадигм 50-60-аад онуудад Америкийн улстөрийн шинжлэх ухаанд ноёрхож байсан бүтэц-үүргийн хандлагын нүүр царай болж байв. Уул хандлага ёсоор бол төр хэмээх ойлголт хуучирсан, тэр нь нэгэнт үеэ өнгөрөөсөн формаль-легал судалгаатай холбоотой гэж үзэж байжээ. Иймд тухайлбал, засгийн газрыг, төрийн бодлого, шийдвэрийг тодорхойлохын төлөө эдийн засгийн сонирхлын бүлгүүд, иргэний хөдөлгөөнүүдийн өрсөлдөөн, тэдгээрийн эвсэл тэмцлийн талбар хэмээн тайлбарлаж байв. Тэгвэл неоинституционалистууд чухам үүний эсрэг өөрсдийн үзэл баримтлалыг гаргаж тавьсан гэж болох юм. Жишээ нь, энэ чиглэлийн гол төлөөлөгчдийн нэг Т.Скокпол “Төрийг эгүүлэн авчирахуй” өгүүлэлдээ төрийг бие даасан, идэвхтэй субъект талаас үнэлж судлах санал дэвшүүлсэн юм. Тэрбээр нэгдүгээрт, төрийн автономи, хоёрдугаарт, төрийн чадамж, тэдгээрийн улстөрд нөлөөлөх үр дагаврын асуудлыг хөндөж тавьсан байна. Төр бол хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээнд бүхэлд нь хяналт тогтоодог байгууллагын хувьд түүний дэвшүүлж хэрэгжүүлж буй зорилго нь ердөө л нийгэм, социаль бүлгүүд, ангиудын ашиг сонирхол, шаардлагын жирийн тусгал байж таарахгүй. Учир нь төр бие даасан зорилго томьёолж

дэвшүүлэх ёстой. Үүнийг л төрийн автономи гэж хэлнэ. Чухамдаа энэ нь төр бол маш чухал субъект гэдгийг харуулж өгч байгаа ажээ. Цаашид нийгэм эдийн засагт нүүрлэсэн бэрхшээл, ялангуяа нийгмийн хүчтэй бүлгүүдийн ил далд эсэргүүцлийг даван туулж албан ёсоор томьёолсон бодлого, зорилгоо хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнийг төрийн чадамж хэмээж байгаа юм (Skocpol, 1996, p.63)

Төрийн институтууд, тухайлбал, засгийн газар сонирхлын бүлгүүдийн шахалт дарамтын дор нөөцийг хуваарилах төдий идэвхгүй үүрэг хүлээж, ашиг сонирхлуудын тэнцвэрийг түр аргацаах замаар цаг өнгөрөөж болохгүй нь тодорхой байна. “Төр төвтэй” тайлбарлалыг тойрч шинэ тутам хөгжиж буй төдийгүй Их Британи, АНУ зэрэг хөгжингүй ардчилсан орнуудад хурц маргаан өрнөж, үүнтэй холбоотойгоор нийгмийн шинжлэх ухаанд ч эдийн засаг, нийгэмд гүйцэтгэх төрийн үүргийг үндсээр нь дахин шүүн тунгаах парадигмын шилжилт болж байгааг судлаачид цохон тэмдэглэж байна.

Төрийн автономи, чадамж юуны өмнө төрийн легитимтэй холбоотой. Монголын төр өнөөдөр онол ёсоор бол Веберын улстөрийн ноёрхлын идеал загваруудын (Вебер, 1990, с.646-647-д үз) хууль ёс-рациональ хэв маягт түлхүү тулгуурлахыг зорьж байгаа ч үр дүн төдийлөн сайн биш байгаа нь илэрхий. Үүнийг монголын нийгмийг үе үе шавхуурддаг улстөрийн тогтворгүй байдал нотолно. Гэхдээ үүгээр монголын төр легитимийн хямралд орсон гэхэд арай эртдэх биз. Улстөрийн огцом өөрчлөлтийн нөхцөлд тогтворгүй байдал үүсч болохыг үгүйсгэхгүй боловч хэрэв түүний давтамж өндөр байвал нийгмийн амьдралд таатай тусах нь ховор. Ер улстөрийн тайван байдал (*Stability*) тогтвортой хөгжлийн (*Sustainable*) үндэс суурь болж байдаг нь улс орнуудын туршлагаар батлагдсан гэж хэлэх үндэстэй.

Төрийн автономи, чадамжийг чухамдаа хураангуйлан илэрхийлэгч нь төрийн түшээд, төрийн албан хаагчид мөн. Улстер бол хүний үйл ажиллагааны онцлог төрлийн хувьд нэг талаас легитим ноёрхлын аппарат, нөгөө талаас нийгмийн бүхий л амьдралд хамаатай тусгайлсан мэргэжлийн үйл ажиллагаа байдаг гэсэн М.Веберын нэн чухал үзэл санааг энд дурдаж болно. Төрийн бюрократ бол харьцангуй бие даасан эрх мэдэлтэй байж, наад зах нь нэгдүгээрт, тэднийг ноёрхогч газар өмчлөгч болон үйлдвэр худалдааны ангиудаас сонгож аваагүй байх, хоёрдугаарт, тэд төрийн албанд дэвшсэнийхээ дараа эл ангиудтай хувийн хийгээд эдийн засгийн шадар холбоо сүлбээ тогтоохгүй байх хоёр нөхцлийг хангаж байх ёстой ажээ. (Trimberger, 1978, p.4). Веберын тодорхойлсноор бюрократын давуу тал нь нийгмийг рациональ удирдлагаар хангаж, шинэтгэлийн оновчтой стратеги бодлого санаачилж, шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээж байдагт оршино. Жишээ нь, улс орны хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулж хэрэгжүүлэх нь төрийн албан хаагчдын хэнтэй ч хуваалцахгүй хийх ажил нь мөн. Шилжилтийн эхэн үед хувьчлалын бодлогод гарсан алдаа завхралын хор уршгийг өнөө хэр нийгэм амссаар байгаа нь бодит үнэн билээ. Төрийн өмчийг задлах нэрийдлээр чанаргүй зээл, банкны дампуурал болгон хувиргах замаар эрх мэдэлтнүүд “ажиллацгааж”, овжин, эрх мэдэл, өмч хөрөнгөд ойр нь завшиж, улмаар нийгмийн тэгш биш байдал хоромхон зуур газар авч, үр дагавар нь ядуурал, хээл хахууль болж үлдсэн юм. Эдгээр үзэгдлийг өнөөдөр, нийгмийн бодлого, хууль тогтоомжоор залруулахыг оролдовч их хугацаа, хүч шаардах нь илт байна. Эцсийн үр дүнгийн тэгш байдлыг хангадаггүй юмаа гэхэд ядаж гарааны харьцангуй тэгш байдлыг хангахад төр тууштай, алсыг харсан бодлого хэрэгжүүлэх учиртай байв. Хялбар аргаар үтэр түргэн хөлжиж болдог юм байна гэсэн нийгмийн сэтгэл зүй давамгайлах болсон нь хүмүүсийг бүтээлч хөдөлмөрийн үр шимд үл

итгэхэд хүргэж, харин зүсэн бүрийн хонжвор, зулгуйдсан шагнал, шалгаруулалт, шоу, мөрийтэй тоглоом, найр наадамд хөл алдаж, уул овоо, хад чулуунд хувь заяагаа даатгах нь нийгэмд дасал болжээ. Залуучууд архи дарс эргүүлэн баар цэнгээнээр цагаа барж, хөнгөн амьдрал, биеийн жаргалыг урьдал болгодог гедонист хандлага, хэрэглээний нийгмийн сэтгэлгээ дэлгэрсэн. *Ёс суртахуунгүй харгис бурангуй санаа бодол нийгмийн гүн рүү улам яргах болов.* Өндөр хөгжсөн орнуудын хөгжлийн бодит үр дүн болж гарч ирсэн постматериалист үнэт зүйлс манай ядмаг эдийн засаг, хүмүүсийн ухамсар, үйл байдал, үндэсний ёс заншилд олигтой тохирохгүй байгааг бодит байдлаас төвөггүй харж болно. Элдэв төрлийн зан үйл, ёслолд төрийн дээд тушаалтнууд ч ямарч бодлогогүй оройлон оролцож улам дэм өгдөг болжээ. Чингис хааны төр улсын хүч чадал нь түүний шадар туслахууд, цэрэг дайчид нэгэн үзүүрт сэтгэлээр төрдөө үнэнч зүтгэж ирсэнд оршиж байсныг гадаадынхан ч онцлон тэмдэглэсэн байдаг. Шилжилтийн гэгдэх жилүүдэд төрийн ажилтны ёс зүйн хувьд ямархуу “чөлөөт уналт” болсныг нуршилтгүй бүгд мэдэх бөлгөө. Хүн бүрийг “улстөрийн амьтан” болгож, тэдний хоорондын харилцааны тодорхой хэм хэмжээ, дүрэм журмыг тогтоож өгч байдаг соёл, уламжлалын үнэт зүйлсийн систем хямрах нь улстөрийн системийн хямралд ч хүргэж болдог. Бидний олигтой урагшлан хөгжиж чадахгүй буйн гол шалтгаан нь залхуу араншин, бэлэнчлэх сэтгэлгээ, “*хуулийг гууль болгодог*” зуршилд оршиж байна гэхэд их буруудахгүй. Монгол өнөөдөр ажиллах хүчээ гадаадад гаргах хүн ам нь багтаж ядсан орон уу гэвэл тийм биш нь тодорхой. Харин ч хийх ажил хамгийн ихтэй улсуудын тоонд багтах биз. Гэвч хүмүүс бүтээн байгуулалтад тэр бүр ханцуй шамлан орохгүй байна. Үүнд төрийн бодлого, зохион байгуулалт ус агаар мэт үгүйлэгдсэн хэвээр байна. Энэ бүхэн төрийн чадамжаас шууд шалтгаалдаг гэж болно.

Төрийн албаны босгыг өндөрсгөж, төрийн аппарат байнга шинэчлэгдэх нөхцлийг даруй бүрдүүлэх хэрэгтэй. Төр хүн, хөрөнгө санхүүгийн дотоод нөөцөө шавхан дайчилж, улс үндэстнээ өөр хэн ч биш гагцхүү монголчууд өөрсдөө л авч явах үүрэгтэй гэсэн зарчмаар бодлого, практик үйл ажилдаа хандах учиртай. Яам, агентлагууд, аймаг сумдыг цэгцлэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтцийг шуурхай өөрчлөх үүднээс төрийн нүсэр бүтцийг задлах, шат дамжлагыг цөөрүүлэх, төсвийн элдэв төрлийн үргүй зардлыг зоригтой багасгахад чиглэсэн төрийн захиргааны шинэтгэлийн сураг нэг сонгуулиас нөгөөд, нэг засгийн газраас дараачийнхад хэсүүчлэхээс үл хэтэрдэг нь төрийн чадамж шавхагдаж, төрийн хууль, шийдвэр үнэгүйдэхэд хүрч байна. Татварын хуримтлалыг үр ашиггүй зарцуулах, төрийн үйлчилгээний чанар доройтох, хүнд суртал, авилга цэцэглэх, төрийн байгууллага, албанд итгэх итгэл унах зэрэг нь төрийн чадамжийг төрийн удирдлагыг өөрчлөн шинэчлэх замаар дээшлүүлэхийг шаардаж байгаа юм. Төрийн захиргаанд менежерил үзэл санааг нэвтрүүлэх нь олон шат дамжлагыг багасгаж, данхар бюрократ аппаратын үр ашиггүй үрэлгэн байдлыг даван туулах зорилготой. Төрийн захиргааны шинэтгэл төрийн удирдлагад зах зээлийн элементүүдийг тусгаж, төрийн бүх шатны байгууллагуудын бүтэц, хувийн болон төрийн секторуудын хүлээх үүргийг дахин авч үзэж, төвлөрлийг сааруулах, бүтэц, чиг үүргийг шилжүүлэх, өөрөө удирдах ёсыг хөгжүүлэхэд чиглэгдэх ёстой. Төрийн захиргааны шинэтгэлээс эдийн засгийн үр ашгийг төдийгүй бас шударга ёсыг хэрэгжүүлэхийг шаарддагыг санах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл төрийн удирдлагад зах зээлийн болон ардчиллын механизмуудыг хослуулах тухай ярьж байна. Нэг үгээр энэ нь төрийн захиргааг улстөрийн хяналт дагалдах ёстой гэсэн үг. Улстөрийн удирдлагын мөн чанар нь гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглалын эрх

үүргийг тов тодорхой зааглахад байдаг. Өнөөгийн парламент, засгийн газар “холилдсон” хувилбар манай бодит нөхцөл байдалд хэр зэрэг нийцтэй байгааг эргэн харах шаардлага буй. Парламентын гишүүд сонгогчдын захиа даалгавар биелүүлэх нэрийдлээр мөнгө хөрөнгө хуваарилуулах, гүйцэтгэх засаглалын өмнүүр орж аж ахуйн аар саар ажлаар хөөцөлдөх нь дээр дурдсан улстөрийн зарчимд нийцэхгүй нь лав. Ер нь ажиглахад Засгийн газар, парламент, Ерөнхийлөгч гэж гурван өөр нэр байх боловч хэрэг дээрээ гурван “засгийн газар” байгаа мэт.

Улстөр бол зөвхөн төрийн удирдлага төдий бус, басхүү түүнд нөлөөлөх тухай асуудал юм. Төрийн өөрийн эрх, чадамжийн талаар ярих нь иргэний нийгмийг үгүйсгэсэн хэрэг огт биш. Иргэний нийгэмгүйгээр ардчилсан төр оршин тогтнож чадахгүй. Хэрэв нийгэм дэх улстөрийн биш гэж болохоор янз бүрийн салбаруудад төр хутгалдан орвол иргэний нийгэм, засаглалын тэнцвэрийг алдагдуулж, улмаар тэр нь тэдгээрийн хоорондын зөрчлийн хүрээг улам тэлдэг жамтай. Төр, иргэний нийгмийн хооронд яриа хэлэлцээр, чөлөөтэй санал солилцол, нээлттэй харилцаа дутагдснаас төрийн засаглал бюрократчилагдаж захиргаадсан шийдвэрүүд гарах, улмаар нийгэмд тогтворгүй байдал үүсэх нэг үндэс болдог. Төрд хүч нөлөөгөө тулгах санаархалтай ашиг сонирхлуудаас ангид байж, асуудлыг шийдвэрлэхэд парламентын механизмыг зохистой хэрэглэх урлагт нухацтай суралцахгүй байгаа нь улстөрийг “гудамжинд” гаргахад хүргэх гэмтэй. Ардчилсан нийгэмд жагсаж цуглах нь хэвийн үзэгдэл. Харин иргэдийн хөдөлгөөнүүд эмзэг асуудал дээр тоглож популизмаар “хөөрөгдөж”, экстремизм рүү хальтираад байх нь тийм ч хэрэгтэй бус. Ард түмнийг зөвхөн улстөрийн тэмцлийн арга хэрэгсэл болгож болохгүй. Юуны өмнө эрх чөлөө гэж юу болох, түүнийг хэрхэн хариуцлагатай эдлэх тухайд ултай эрэгцүүлж тунгаах нь чухал. Эрх чөлөөг дур зоргоос ялгаж салгах хэрэгтэй. Академич В.С. Нерсисянц “Эрх чөлөө бол өөрийн түгээмэл, албан ёсны, эрх зүйн илрэлээрээ чухам юу юм бэ? гэвэл нэгдүгээрт, нийгмийн харилцаанд оролцогчид нэг нь нөгөөгөөсөө хараат бус, өөрийн эрхтэй байдагт, гэхдээ үүний хамтаар хоёрдугаарт, тэд тэрхүү харилцаанд оролцохдоо (*харилцан үйлдэхдээ*) зохицуулалтын нэгдмэл, нийтлэг хэм хэмжээнд адил тэгш байдлаар захирагддагт оршино. Бодгалуудын эрх чөлөө нь тэдний хүсэл зоригийг давхар илэрхийлнэ. Эрх зүй дэх хүсэл зориг бол эрх чөлөөт хүсэл зориг мөн бөгөөд тэрээр эрх зүйн мөн чанарлаг шинжүүдэд нийцэж тохирсон, дур зоргын хүсэл зоргоос ялгаатай, дур зоргын эсрэг байдаг. Эрх чөлөө нь нийгмийн амьдралд эрх зүйн хэлбэрээр оршиж хэрэгжихээс ондоо, ямар нэгэн өөр хэлбэрийг хүн төрөлхтөн одоогоор олж бий болгоогүй л байна” (*Нерсисянц, 2001, 270-272 дахь талд*) гэж бичсэн байдаг нь ардчиллын ач буянаар эрх чөлөөгөө эдэлж буй, эрх чөлөөгөө хязгааргүй эдлэхийг хүсэмжилж буй хэнд ч санууштай зүйл мөн. Иймд эрх чөлөөнд дулдуйдан төрд шаардлага тавьж тэмцэгчид радикал алхмуудыг хэт шохоорхохоос аядуу үйл байдлыг эрхэм болговол ардчилалд илүү өлзийтэй байх болно. Чингэж хэлэхийн учир нь олон түмний улстөрийн идэвхжил хэт өндөр, дороос шахалт дарамт хэрээс хэтэрвээс ардчиллын хэвийн бойжилтыг бусниулж болзошгүй байдагт оршино.

Адам Пшеворски “Ардчилсан өөрчлөлтийг үргэлжлүүлэхэд зохион байгуулагдсан ажилчдын дуулгавар, тэсвэр тэвчээр шаардлагатай “-г нэгэнтээ сануулсан байдаг (*Przeworski, 1986, p.63*). Иймд иргэдийн хөдөлгөөн үр ашигтай төдийгүй нэн чухал, гагцхүү эх адаггүй эмх замбараагүй байдал болж хувирваас ардчилах үйл явцад халгаатай байдгийг анзаарах нь чухал ажгуу.

90-ээд оны улстөрийн тэмцлийн арга хэлбэр, улстөрчдийн имижээр эдүгээ улстөрийг “хөшүүрэгдэхэд” амаргүй болсныг хэлэх хэрэгтэй. Иргэдийн

хөдөлгөөн нөгөө талаас хүн амын нэлээд хэсэг аль нэг тухайлсан намын үйл ажиллагаанд бус, харин нам-улстөрийн системд бүхэлд нь сэтгэл дундуур байгаагийн тусгал болж байна. Ийнхүү легитим засаглал, хэрэг дээрээ нам, төрийн институтүүдэд нийтэд нь үл итгэх байдлаар хандах нь иргэдийн дунд илэрхий ажиглагдаж байгаа билээ.

Намууд улстөрийн ардчиллын амин чухал механизм болж төрийн автономи, чадавхид шууд нөлөөлж байдаг. Өнөөдөр асуудлын гол нь намын тухай бидний төсөөлөл, намуудын хэв маяг, үйл байдал, үйл ажиллагаа олон улсын жишиг, улстөрийн эрчимтэй өрнөлийг дагаж түргэн шинэчлэгдэж чадахгүй байгаад болов уу. Парламентын одоогийн нөхцөлд намын тухай хуучин ойлголтоо дахин эргэцүүлж тунгаах, парламентын намын нарийн чимхлүүр ажлын урлагт суралцах, цаг үе, нийгмээ соргог мэдрэн ажиллах, улстөрийн тоглоомын дүрмийг ягштал баримтлахын оронд лидерүүд нь нэг намын ноёрхлын үеийн монополи эрх мэдлийг санагалзсан явуургүй мөрөөдлөөс салж чадахгүй, ямар ч үнэ цэнээр хамаагүй эрх мэдлийн оройд гарахын төлөө муйхарлан зүтгэдэг нь намууд ардчиллыг урагш хөгжүүлэх бус харин хойш чангаа хүч болж байгаа нь нууц биш. Намын орших, эс оршихуйтай шууд холбоотой түүний санхүүжилтийн бэрхшээлийг овжин ашиглаж, түүнд дөрөөлж мөнгөтэй, зальтай, шударга бусаар хүмүүс төрийн алба өөд хошуурах болсон нь яавч улстөрийн таатай үр дагавар авчрахгүй. Элдэв бүтэлгүй явдалтай орооцолдож олны нүдний өмнө нэр нүүрээ барж, ёс суртахуун, хууль ёсыг хөсөрдүүлсэн этгээдүүдийг намууд өөрийн гишүүн гэдгээр халхавчилж шударга ял шийтгэлээс бултуулдаг нь хэм хэмжээ мэт болсон. Сонгуульд ялсан нам “ялагч бүхнийг авах” зарчмаар хандаж, төрийн албан тушаалыг шан харамж маягаар хуваарилдаг үеэ өнгөрөөсөн систем (*spoils*) үйлчилсээр байна. Эдгээр нь төрийн бие даасан байдал, чадамжийг цаагуураа ноцтой сулруулсаар буй нь тодорхой. Намууд төрийн ажилд хэт хутгалддаг болсноос засаглалын формаль субъект- ард түмний эрх ашгийг тээгч төр засгийн эрхийг хэрэг дээр барьж чадаж байна уу гэдэгт эргэлзэх үе ч бий. Ер саяхан зад шүүмжлэгдэж асан “ангич” хандлага харин одоо “намч” хандлагаар л солигдсноос бус мөн чанар нь хэвээр гэхэд хэтрүүлэг болохооргүй ажээ. Парламентын нөхцөлд сонгуулийн кампанийн явцад улстөрийн намуудын өрсөлдөөн тэмцэл хурцдаж, улстөрийн ажил ид өрнөдөг бол сонгууль хооронд тэдгээрийн үйл ажиллагаа аядуу хүлээцтэй болж, олонхийн сонголтыг хүндэтгэж төр засагт ажиллах боломж олгож, дотоод ажлаа голлон эрхлэх учиртай. Намын нэрт онолч Дж.Сартори “Нам гэдэг бол сонгуульд оролцдог, үүний дүнд өөрийн нэр дэвшигчдийг төрийн байгууллагуудад оруулах чадвартай аливаа улстөрийн бүлэг “хэмээн тодорхойлсон байдаг. Энэ нь нам бүх нөхцөлд бүх цаг үед гагц улстөрийн шалгарсан авангард байхын төлөө “бужигнуулах” ёстой бус гэдгийг нэг талаар сануулсан хэрэг. Өөрөөр хэлбэл, улстөрийн өрсөлдөөнийг ухаалгаар хязгаарлаж сурах хэрэгтэй болно. Гагцхүү чингэснээр “бусдын эсрэг бүгдийн дайнаас” гарч чадна. Уг нь намууд оюуны шавхагдашгүй эх булаг байж, улс орныхоо хөгжил дэвшлийн асуудлаар алсыг харсан даацтай санал онол дэвшүүлж, альтернатив бодлого боловсруулан үзэл бодлоо уралдуулахад илүүтэй анхаарах үүрэгтэй. Гэтэл тулга тойрсон хоосон маргаан, явган хэрүүл, хов жив, хардлага сэрдлэг, огцруулах төдийхнөөр өвөр зуураа толхилцон хүчээ барж, заримдаа улстөрийн түр зуурын ашиг хонжоо хайн үндэсний эрх ашигт сэв суулгах үйл байдал гаргахаас ч буцахгүй төлөвтэй. Америкийн нэрд гарсан транзитологич Растоу ардчилсан шилжилтийн “цорын ганц суурь нөхцөл нь үндэсний эв нэгдэл” гэж заагаад энэ үед улстөрийн зөрчил, тэмцэл хичнээн хурцдавч тэдгээр нь гагцхүү “гэр бүлийн халуухан санал

зөрөлдөөний” хүрээ гортигт баригдах ёстойг тэмдэглэсэн байдаг (*Rustow, 1999, pp.25-29*). Манай намууд хоорондын тэмцэл иргэдээ талцуулан нийгмийн бүтээлч хүч нөөцийг тарамдуулж буй нь нэг талаас туйлшрал, нөгөө талаас плюраль ёсыг хольж хутгаж байгаатай холбоотой. Энэ нь яваандаа улстөрийн амьдралд иррациональ үйл байдал зонхилоход хүргэнэ. Улстөрийн намуудад бүлгийн ашиг сонирхол байх нь мэдээж боловч бодлого, үйл ажиллагааных нь нийгмийн утга учир тэдгээрийг нийтийн эрх ашгийн огтлолцол дээр зайлбаргүй уулзуулж өгдөг. Ардчиллын эдийн засгийн онолыг үндэслэгч Антони Даунс “*Хэрэв өөрийн асуудлуудаа амжилттай шийдвэрлэе гэж байгаа бол аль ч нийгэмд улстөрийн рациональ чанарын өндөр төвшин чухал шаардлагатай*” (*Downs, 1985, p.11*) гээд намуудын рациональ шинж нийгмийн хэмжээний зөвшлөөр хэмжигдэнэ гэж цохож тэмдэглэснийг дурдаж болно. Ардчилал хөгжсөн орнуудын туршлагаас харахад намууд нь эцсийн бүлэгт үндэсний эрх ашиг, эв нэгдлийг эрхэмлэж, экстремизмын аливаа илрэлийн эсрэг тууштай зогсож улстөрийн тогтвортой байдлыг хангахын төлөө байснаараа улс орныхоо хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулсан байдаг.

Бид цагийн ороо бусгаа, замын уртад хэрхэвч мартаж болохгүй зүйл бий. Энэ бол монголчууд улстөрийн ардчилал, зах зээлийг эргэлт буцалтгүй сонгосон явдал. Үүнийг санаж сэрэхийн учир нь бид ардчиллын мөн чанарыг илтгэдэг сонгуулиа шударга зохион байгуулж, олонхийн сонголтыг хүндэтгэн үзэж чадаж байна уу, бүгдээрээ хэлэлцэж олонхоороо баталсан шийдвэрийг цөөнх нь дагаж биелүүлдэг ардчиллын зарчим хэрэгжиж байна уу гэдгийг эрүүл саруул ухаанаар эргэцүүлж байхад илүүдэхгүй. Хэрэв ингэж чадахгүй байгаа бол бид ардчиллыг аман дээрээ дэмжихээс хол хэтрэхгүй байна гэсэн үг. Дэлхий дээр засгийн газрыг бүрдүүлдэг үндсэн хоёр хэлбэр л бий. Олонхийн эсвэл эвслийн. Бидэнд аль алиныг нь туршин үзэх боломж олдсон. Гэвч чухам энэ нь л давуутай юм гэсэн итгэл үнэмшлийг нийгэмд одоо хэр өгч чадахгүй л байна. Хууль ёс, моралийг төрийн хүмүүс ч, жирийн иргэд ч үл тоож, хэн ч хэний ч өмнө хариуцлага хүлээдэггүй бол энэ бидний сонгосон ардчилал мөн үү? Ардчиллын хэмжүүр-улстөрийн өрсөлдөөнийг эсрэг талаа гүжир гүтгэлэг, гутаан доромжлолоор унагаах гэсэн өтөл бэртэгчин үзлээр сольж, “дөрөвдэх засаглал” үүний зэвсэг нь болж хувирвал бид бүхний хүссэн ардчилал мөн үү? Ардчиллын хэмжүүр- улстөрийн оролцоог улстөрийн хийрхэл болгож, зөвшил, зөвшилцлийг зөрчил шийдвэрлэх гол арга хэмээн дэлхий нийтээр үнэлсээр атал хүчирхийллийг урьдал болгох нь ардчилал мөн үү? Бүх намууд нийгмийн халамжийн амлалт, “өгөөмөр зан”-гаар бодлогоор уралдацгааж, нийгмийн бүлэг давхарга бүр, луйвардуулсан бүхэн төртэй тооцоо хийхийг санаархах болсон нь сонгож авсан зах зээл мөн үү?

Ардчилал хэзээ Монголд бэхжилээ олох вэ? гэвэл ардчилал судлаачдын хэлснээр “*ардчилал хот даяар цорын ганц тоглоом*” болсон цагт л гэж хариулъя. Улстөрийн соёлын институциональ бүрэлдүүлбэрүүд бүтэц хэлбэрийн хувьд өсч өндийгөөд зогсохгүй, тэдгээр нь өөр хоорондоо, иргэдтэй харилцахдаа гагцхүү улстөрийн тоглоомын дүрмээ хөдөлбөргүй баримталдаг болох нь ардчиллын хамгийн чухал нөхцөл юм. Улстөрийн элитийн үйл байдлыг хувийн амбици, нууц далд хуйвалдаан тодорхойлдог эргүүлгээс гарч чадахгүй бол ардчилал бэхжих хөгжихөд хэцүү байх болно. Ийнхүү институциональ хүчин зүйл өөрчлөлтийн гол механизм байж, монголын улстөрийн амьдралд зөвшилцөл, эв нэгдэл, хууль ёс, хариуцлага, зохион байгуулалт, тогтвортой байдал улстөрийн соёлын тодорхойлогч параметрууд болсон цагт ардчилал бүрэн утгаараа “ажиллаж” бэхжих болно.

Ном зүй

Нерсисянц В. Эрх зүй бол тэгш байдал, эрх чөлөө ба шударга ёсны зайлшгүй хэлбэр болох нь. Орч. А.Жамбал || Философи Эрхийн судлал. XX боть. УБ., 2006.

Вебер М. Политика как призвание и профессия || Вебер М. Избранные произведения. М., 1990.

Парсонс Т. Понятие общества: компоненты и их взаимоотношения || Thesis.1993. Т.1. Вып.2.

Easton D. The Analysis of Political Systems || Comparative Politics: Notes and Readings. Ed.by B.Brown, R.Macridis. USA, 1986.

Downs A. An Economic Theory to Democracy. USA. 1985.

Prezworski A. Some Problems in the Study of the Transitions to Democracy || Transition from Authoritarian Rule: Baltimore: The Johns Hopkins University Press. 1986.

Rustow D. Transitions to Democracy: Toward a Dynamic Model || Transitions to Democracy. Ed.by L.Anderson. USA. 1999.

Skocpol T. Bringing the State Back in || Comparative Politics: Notes and Readings. Ed. by B.Brown. R. Macridis. Belmont. 1996.

Trimberger E. Revolution from Above N.J. 1978.

МОНГОЛ УЛСАД УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН ҮҮСЭН ТӨЛӨВШИЖ БАЙГАА НЬ

А. Жамбал

ШУА, ФСЭХ-гийн дэд захирал, хүрээлэнгийн профессор

I

Түүхэн баримт сөхөж үзэхэд 1991 оноос эхэлж Монгол Улсад улс төрийн шинжлэх ухааныг албан ёсоор хүлээн зөвшөөрөх болсоноор мэргэжлийн түвшинд зориуд, тусгайлан бичсэн анхны өгүүлэл сэлт нийтлэгдэн гарчээ. Ингэж хэлдгийн учир нь асуудлыг энэ дор авч үзэх явцад өөрөө аяндаа тодорхой болох тул түүнийг энд яаран тайлбарлах нь илүүднэ.

Арван таван жил бол түүхийн хувьд харьцангуй богино хугацаа боловч эл явцад улс төрийн шинжлэх ухаан манай оронд шинэ тутам үүсэж, төлөвших явцад зохих хэмжээний түүх бий болж, ололт амжилт гарч, бас шийдвэрлэвэл зохих олон янзын асуудал, зорилт тулгамдан тавих болжээ. Тэдгээр асуудлыг мэргэжлийн түвшинд зориуд авч үзэж судлах, санал бодол солилцох, нэгтгэн дүгнэж, урагшлах чиг зүг, арга замаа тодруулах хэрэгцээ шаардлага ч зүй ёсоор гарч ирж байна.

Манай оронд түүхэн нөхцөл байдлын эрхээр тогтсон социализмын өвөрмөц загвар дотоод гадаад олон янзын шалтгаанаар 1990 онд нурж унаснаар социализмд харш, хөрөнгөтний гэсэн тодотголтойгоор хэдэн арван жилээр хориотой байсан олон зүйл аяндаа нээлттэй болсны дотор улс төрийн шинжлэх ухааныг жинхэнэ утгаар нь, дэлхийд тогтсон жишигээр үүсгэн хөгжүүлэх бололцоо бий болсон билээ.

Социалист орнууд, тэр дотор манайд улс төрийн шинжлэх ухаан яагаад хаалттай байсныг хэвшил болсон жижүүрийн үгээр, эсвэл бүдүүн тоймоор тайлбарлах нь мэргэжлийн хүрээнийхэнд байж болохгүй зүйл бөгөөд түүний учир шалтгааныг ул үндэстэй авч үзэж үнэн зөв тогтоох хэрэгтэй юм. Социалист бусад оронтой нэгэн адил манай оронд марксизм бүхнийг хамарсан үзэл суртал, нийгмийн оюун санааны амьдрал, тэр дотор нийгмийн шинжлэх ухааны онол, арга зүйн үндэс, утга агуулга болж байлаа. Нийгмийн шинжлэх ухаанд ганцхан үнэн байсан нь марксизм байлаа. Түүний үндсэн гурван бүрдэл хэсгийн нэг болох коммунизм, социализмын онолыг марксизмын нийгэм-улс төрийн номлол мөн гэж үзээд түүний хүрээнд ажилчин ангийн тэмцэл, хувьсгал, төр, пролетарийн диктатур, ардчилал, улс төрийн систем, нам, олон нийтийн байгууллага, үзэл суртал, улс төрийн ухамсар зэрэг улс төрийн үзэгдлийг марксизмын дагуу авч үзэж байв. Энэ бол нийгмийн шинжлэх ухааны бие даасан салбар болох улс төрийн шинжлэх ухааныг социализмын онолоор орлуулж байсан хэрэг юм. Тэгэхдээ марксистууд улс төрийн шинжлэх ухааныг хөрөнгөтний шинжлэх ухаан гэж

үздэг, ортодокс, догматик марксистууд бүүр хөрөнгөтний хуурамч ухаан гэж нэрлэдэг байв.

ЗХУ-д нийгмийн өөрчлөн байгуулалт, улс төрийн шинэ сэтгэлгээ ид өрнөж байсан 1987 онд хэвлэгдсэн "Улс төрийн товч толь" хэмээх нэлээд шинэлэг өнгө аястай толь бичигт "Улс төрийн шинжлэх ухаан (улс төр судлал) гэдэг бол улс төрийн харилцааны салбарыг судалдаг нийгмийн шинжлэх ухааныг нэрлэж хэвшсэн нэр томъёо юм" гэжээ (,345).Эл өгүүлэлд улс төрийн шинжлэх ухаан нь шинжлэх ухааны коммунизмын онолын хүрээнд багтах судалгааны нэгэн чиглэлийг нэрлэсэн нэр томъёо юм гэсэн утга санаа агуулагдсан байна.

Үүний хамтаар социализмын үед марксист философи, социологи, социализмын онол, төр, эрх зүйн онол, МАХН-ын болон улсын түүхийн судалгааны хүрээнд улс төр судлалын чанартай судалгаа хийгдэж байсныг үгүйсгэж бас болохгүй. Тухайлбал манай эрдэмтэн судлагчид ангиудын улс төрийн тэмцэл, хувьсгал, төр, улс төрийн бодлого, улс төрийн систем, нам, олон нийтийн байгууллага, ардчилал, сонгууль, улс төрийн түүх, үзэл суртал, улс төрийн ухамсар, соёлыг социалист гэсэн тодотголтойгоор марксист онолоор авч үзэж, олон тооны ном зохиол туурвижээ. Эдгээр судалгаа онол, арга зүйн хувьд дутагдалтай, хязгаарлагдмал шинжтэй, үзэл сурталжсан, оршин буй бодит байдлыг зөвтгөсөн, магтаж сайшаасан утга агуулгатай байсны зэрэгцээ тэдгээр үзэгдэл, үйл явдлын тухай бодит мэдээлэл, мэдлэг, дүгнэлтийг бас агуулж байсныг хэлэх хэрэгтэй. Социализмын үед энэ талаар хийгдсэн судалгаа, түүгээр мэргэжин бэлтгэгдсэн эрдэмтэн судлагчид хожим нь улс төрийн шинжлэх ухааныг улс орондоо үүсгэж эх үндэсийг нь тавихад нэн түрүүнд идэвхтэй оролцож, чухал хувь нэмэр оруулсан нь зөвхөн манайд төдийгүй социалист байсан ихэнх оронд түгээмэл үзэгдэл байгаа юм.

Манай зарим эрдэмтэн улс төр судлал монголд социализмын үед ч байсан, түүгээр судалгаа хийгдсээр ирсэн гэсэн саналтай байдаг. Бидний бодлоор энэ нь өрөөсгөл санал бөгөөд түүнийг дэмжих аргагүй. Энд нийгмийн ухааны өөр салбаруудын хүрээнд улс төр судлалын шинжтэй хэсэгчилсэн судалгаа хийх, улс төрийн шинжлэх ухаан өөрийн онол, арга зүй, судалгааны арга техникийн дагуу бие дааж хөгжих хоёр нь ихээхэн ялгаатай болохыг анхаарууштай. Шинжлэх ухааны аливаа салбар бие дааж өөрийн ёс жаяг, нийтлэг жишигээрээ хөгжиж буй эсэхийг нотлон тогтоох шалгуур бий бөгөөд тэр нь улс төрийн шинжлэх ухаанд мөн адил хамаарна. Тэр дагуу хандвал социализмын үед манай оронд улс төр судлал байсан гэсэн үзэл санаа шинжлэх ухаанч шалгуурыг даахгүй.

Манай оронд улс төрийн шинжлэх ухаан хаалттай байсан явдал өөрийн бодит шалтгаантай, бас онол - танин мэдэхүй хийгээд улс төрийн практикт хохиролтой, сөрөг үр дагавартай байлаа. Тэр талаар зарим зүйлийг дурдъя.

Аливаа шинжлэх ухааны хамгийн гол зорилго нь судлагдахуунаа үнэн зөв танин мэдэх явдал байдаг. Улс төрийн шинжлэх ухаан манайд хаалттай байсан явдал юуны өмнө түүний өөрт нь хохиролтой байсан бөгөөд тэр нь нийгмийн улс төрийн амьдрал, түүний үзэгдэл, үйл явдалыг шинжлэх ухаанчаар танин мэдэх боломж алдагдаж байснаар илэрч байлаа. Ийм нөхцөлд улс төрийн бодит байдлыг нэг л онол, арга зүйн нэг л тавилаар авч үзэж байв. Судалгаа шинжилгээний ажил оршин үйлчилж буй албан ёсны үзэл суртал, улс төрийн бодлогод захирагддаг байсан учираас гарсан үр дүн, дүгнэлт, үнэлэлт нь ч үзэл сурталжсан, улс төрд үйлчилж нийцсэн шинжтэй байжээ. Нөгөөтөйгүүр судалгаанаас гарсан бодит үнэнийг шууд хэлэх, илэрхийлэхэд үлэмж бэрх байсан бөгөөд хэрэв тийнхүү оролдвол тэр нь тухайн эрдэмтэн судлагч нь мэргэжил, нэр төр, нийгэмд эзэлсэн байр суурь,

амьдралаараа тоглох, дэнчин тавихтай адил хэрэг болдог байлаа. Энд үүнийг нотлох гэж элдэв жишээ баримт дурдах, түүх сөхөх хэрэггүй, тэр нь та бидэнд тодорхой, ойлгомжтой зүйл юм.

Хэрэв норматив хандлагаар хандвал нийгмийн улс төрийн байгуулал, төр засгийн бодлого, субъектуудын улс төрийн үйл ажиллагаа нь тухайн нийгмийн хөгжил дэвшлийг хангахад чиглэгдсэн, нийцтэй, рационал шинжтэй, өөрөөр хэлбэл ухаалаг, зүй зохистой байх ёстой юм. Энэ нь нийгмийн субъектуудыг хатуу дэглэмийн хүч албадлагаар сүрдүүлэх, номлолд оруулж номхон хүлцэнгүй байлгах замаар биш, харин улс төрийн амьдралын бодит хэрэгцээ шаардлага, зүй тогтол, өрнөлийн логикийг үнэн зөв танин мэдэх, нэгтгэн дүгнэх, чиг хандлагыг нь зөв баримжаалан төсөөлөх явдалд үндэслэж байж сая үр нөлөөтөйгөөр хангагддаг жамтай. Гэтэл манайд социализмын үед нэг талаас улс төрийн танин мэдэхүй, түүнээс урган гарах улс төрийн үнэлэлт (оценка), улс төрийн прогнозчлол, нөгөө талаас улс төрийн бодит амьдралын хоорондын байвал зохих амьд хэлхээ холбоо, харилцан нөлөөлөл алдагдаж гаж буруу хэлбэртэй болж байлаа.

Социализмын үед улс төрийн шинжлэх ухаан хаалттай байсан явдал ардчилсан бус дэглэм, улс төрийн буруу практик өөрийгөө зөвтгөж удаан хугацаагаар оршин тогтнох нэг таатай хүчин зүйл болж байв. Өөрөөр хэлбэл улс төрийн ардчилсан бус дэглэм, явуургүй, буруу практик оршин тогтнохын тулд өөрийг нь үнэн бодитойгоор танин мэдэж шүүмжлэн няцаах улс төрийн шинжлэх ухааныг хааж хориглох ёстой байлаа. Үүнтэй холбогдуулж энд нэг зүйлийг дашрамд нь дурдахыг хүсч байна. Тэр юу вэ гэвэл социализмын үед манай нам төрийн удирдлага ч, юм бодож сэтгэдэг сэхээтэн, эрдэмтэн судлагчидын олонхи хийгээд жирийн ард иргэд ч социализмын тухайн үеийн загвар, нийгмийн улс төрийн байгуулал, дэглэм, ардчилал нь дутагдалтай, ер нь буруу, явцгүй гэдгийг мэдэж ухаарахаасаа төдийлөн сайн мэдэхгүй, ухаараагүй, бүхэлдээ социализмд итгэж үнэмшсэн байдал нь давамгайлж байсан гэж би хувьдаа үздэг юм. Энэ нь XX зууны эхэнд дундад зууны төлөв байдалтай байсан монголын нийгэм чухамдаа социализмаар замнах явцад орчин үеийн дүр төрхтөй болж түүхэн дэвшилд хүрсэн, социалист төр хүн ардын амьдралын доогуур ч бай түвшинг баталгаатай хангаж байсан, нийгмийн шудрага ёс, тэгш байдлын зарчим өнөөгийнхтөй харьцуулахад илүү хэмжээгээр хэрэгжиж байсантай багагүй холбоотой байв. Эдийн засаг, нийгмийн хүрээн дэх социализмын ололт нь улс төрийн ардчилсан бус дэглэмийн ноёрхол, иргэдийн эрх, эрх чөлөөний хумигдалыг нэг ёсондоо компенсаци хийж нөхөн төлж байсан гэж үзэж болох юм.

Ардчилсан бус дэглэм тогтож, улс төрийн шинжлэх ухаан хаалттай байсан явдал нь нийгэмд улс төрийн ардчилсан үнэт зүйлс бүрэлдэн төлөвших, иргэд улс төрийн ардчилсан ухамсар, соёл, боловсролтой болж нийгэмших үйл явцыг саатуулсан бөгөөд түүний үр дагаврыг манай нийгэм өнөөдөр зовиуртайгаар амсаж байна.

II

1990 оны ардчилсан хувьсгалын маргашгүй ололт, соёл, шинжлэх ухаан, эрдэмтэд, иргэдэд өгсөн бодит үр өгөөж бол оюун санааны амьдрал, тэр дотор нийгмийн шинжлэх ухаан улс төрийн бодлого ба үзэл суртлын дарамт, хяналтаас чөлөөлөгдөж нийгмийн субъектуудын улс төр, оюуны эрх, эрх чөлөө хангагдсан явдал юм. Энэ нь манай улсад улс төрийн шинжлэх ухааныг үүсгэж төлөвшүүлэх тааламжтай төдийгүй зайлшгүй шаардлагатай нөхцөл, бололцоог бий болгосон билээ. Ингэж хэлдгийн учир бол нийгэм, хүмүүнлэгийн

ухаануудын дотроос чухамдаа улс төрийн шинжлэх ухаан нийгмийн байгуулал, улс төрийн дэглэм, төр засгийн бодлого, үзэл суртал, улс төртэй хамгийн нягт бөгөөд эмзэг, мэдрэмжтэйгээр холбогдсон, улс төрийн танин мэдэхүй, үнэлэмж, шүүмжлэл, прогнозчлол хийгээд практикийн ихээхэн ачаалал, үүрэгтэй, тиймээс ч бүтээлч эрх чөлөөг (академическая свобода) жинхэнэ ёсоор нь шаарддаг шинжлэх ухаан юм.

Бид энд улс төрийн шинжлэх ухаан манай оронд анх үүссэн, эдүгээ төлөвшин буй үйл явцын талаар авч үзэхийн өмнө ер нь дэлхийн орнуудад эл шинжлэх ухаан мөн анх үүсэн төлөвшсөн үйл явцын нийтлэг дүр төрх, загварын талаар хэдхэн өгүүлбэр хэлье гэж бодож байна. Шинжлэх ухааны аль нэг салбар үүсэх, албан ёсны болж зохион байгуулалттайгаар оршин тогтнох зайлшгүй үйл явцыг шинжлэх ухааны өөрийнх нь хэлээр институционализаци гэж нэрлэдэг. Энэ нь улс төрийн шинжлэх ухааны үүсэл төлөвшилд мөн нэгэн адил хамаарна. Түүний зайлшгүй чухал бүрдэл хэсэг, шаардлага болж нэгдүгээрт, улс төрийн мэдлэг, сэтгэлгээ нь өмнөх үеийн ололт амжилт, хүрсэн түвшиндээ тулгуурлаж хөгжлийн зохих шатад аяндаа бие даан ялгарч, тусгай салбар ухаан бүхий мэргэжил болж хувирдаг байна, өөрөөр хэлбэл специализаци явагддаг, хоёрдугаарт, улс төрийн мэдлэгийг бүтээж, сэтгэлгээг тээн авч явсан хувь хүмүүс бүхий хоорондоо салангид сэтгэгчид, эрдэмтэн судлагчдын ганцаарчилсан судалгаа шинжилгээ зохион байгуулалтад орж нэгдмэл, бүхэл салбар бий болдог, гуравдугаарт, улс төрийн шинжлэх ухаанаар тодорхой зорилго чиглэлтэйгээр судалгаа хийдэг эрдэм шинжилгээ, судалгааны бие даасан байгууллага бүхий хүрээлэн, төвүүд байгуулагддаг, дөрөвдүгээрт, улс төрийн шинжлэх ухаанаар мэргэшиж судалгаа хийх, багшлах мэргэжилтэн бэлтгэх факультет, анги салбар их дээд сургуулуудад байгуулагддаг, өндөр мэргэжлийн судлагч, эрдэмтэн бэлтгэх дипломын дараах сургалт бүхий магистрантур, аспирантур, докторантурын сургалтын тогтолцоо, эрдмийн зэрэг хамгаалуулах төрөлжсөн эрдмийн зөвлөлүүд байгуулагддаг, тавдугаарт, улс төрийн шинжлэх ухааны тогтмол хэвлэл бүхий мэргэжлийн сэтгүүл, цуврал бүтээлүүд гардаг, зургаад, улс төрийн шинжлэх ухаан тухайн орнуудад төлөвшин бэхжсэний илрэл болж улс төрийн шинжлэх ухааны үндэсний холбоод байгуулагддаг байна. Улс төрийн шинжлэх ухаан нэг талаар, дэлхийн хөгжилтэй орнуудад бэхжиж хөгжсөний илрэл болж, нөгөөтэйгүүр түүнийг бусад оронд үүсгэж хөгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, чухал асуудлуудыг хамтын оюун сэтгэлгээгээр шүүн хэлэлцэж боловсруулах, нэг үгээр хэлбэл дэлхийн хэмжээний зохион байгуулалтад оруулах хэрэгцээ шаардлагаар 1949 онд Улс төрийн шинжлэх ухааны олон улсын (дэлхийн) холбоо байгуулагджээ.

Улс төрийн шинжлэх ухааны хөгжил өндөр түвшинд гарч гүнзгийрэх явцад сэтгэлгээ, судалгаа шинжилгээний дэг сургууль, онол сургаалийн урсгал чиглэлүүд гарч ирж, бүхэлдээ уламжлал бий болдог байна. Түүнчлэн улс төрийн шинжлэх ухаан өндөр түвшинд гарч хөгжих явцад дотроо харьцангуй бие даасан салбаруудад хуваагдаж ялгарал (дифференциаци) гардаг, тэдгээр нь эргээд нягтарч (интеграци) улс төрийн шинжлэх ухааны нэгмэл, цул чанарыг шинэ агуулгаар баяжуулдаг ажээ.

Түүхэн туршлагаас үзвэл шинжлэх ухааны аль нэг салбар тухайн оронд анхлан үүсэхдээ нэг бол дээрээс, төрийн ивээлээр эхнээсээ зохион байгуулалттайгаар, эсвэл тухайн шинжлэх ухааны төлөө зүтгэсэн эрдэмтэн мэргэжилтнүүдийн хүчин чармайлтаар, доороос санаачлагдан үүсэн төлөвшдэг байна. Тэгэхдээ доороос гарсан санаачилгыг төр засаг дэмждэг ч, төдийлөн дэмждэггүй ч тохиолдол гардагийг XX зууны социалист орнуудын туршлага харуулсан билээ. Манай оронд 1970-аад онд философи, социологи

(мэдээжээр марксист философи, социологи), 1980-аад оны эхээр шинжлэх ухаан судлалыг шинэ тутам үүсгэж хөгжүүлэхэд тэр үеийн нам, төрийн холбогдох дээд байгууллага дээрээс санаа тавьж дэмжсэн, ялангуяа ШУА-ийн удирдлага, түүний Ерөнхийлөгч байсан академич Б.Ширэндав авугай ихээхэн хүчин чармайлт гаргасан байдаг.

Гадаад орнуудад улс төрийн шинжлэх ухаан үүсэж хөгжсөн ерөнхий загвар, түүний үзүүлэлт, үе шат, туршлагыг дээрхи байдлаар тоймлон дурдсаны шалтгаан бол тэдгээр нь манай оронд улс төрийн шинжлэх ухаан анх үүссэн хийгээд эдүгээ төлөвшин зүгширч буй үйл явц, өнөөгийн хүрсэн түвшин, төлөв байдал, ололт, тулгаран буй асуудал, зорилт, цаашдын хандлагыг авч үзэхэд зохих ёсны чиг баримжаа болж байгаад оршино.

Улс төрийн шинжлэх ухаан манай оронд ямар нөхцөл, цаг үед яаж үүссэн вэ ? Эл асуудлыг бодит баримт түшиж, түүхэн тодорхой хандаж, хариуцлагатай авч үзэх хэрэгтэй юм. Учир нь энэ бол манай улс төрийн шинжлэх ухааны түүх бичлэгийн асуудал мөн бөгөөд тэр нь эхнээсээ үнэн бодитой, тодорхой бичигдэх ёстой.

Монголын нийгмийн язгуур шинэчлэлтийн нөлөөгөөр улс төрийн шинжлэх ухааныг улс орондоо үүсгэж хөгжүүлэх нийгмийн ерөнхий хэрэгцээ хийгээд түүнийг хангаж хэрэгжүүлэхэд шаардлагатай, тааламжтай нийгэм, улс төр, оюун санааны дотоод нөхцөл, бололцоо 1990-ээд оны эхэнд нэгэн зэрэг бий болж, хоорондоо онолдон шүтэлцсэн байна. Эл шинжлэх ухааны өөрийнх нь гадаад орчин нөхцөлийн хувьд гэвэл тэр үед дэлхийн улс төрийн шинжлэх ухаан зуу гаруй жилийн түүхэн замналыг туулсан, хөгжлийн өндөр түвшинд хүрсэн байсан бөгөөд бидний зорилт бол түүнийг өөртөө нээж судлан эзэмших, тэрхүү шимтэй, бэлэн хөрсөнд монгол үрийг суулгаж арчлан ургуулах явдал байсан гэж хэлж болно.

Нөгөө талаас эл үед манай эдийн засаг уналтад орсон, түүний улмаас шинжлэх ухааны санхүүжилт буурсан байлаа. Тэгэхдээ нийгмийн шинжлэх ухааны үүсэл хөгжилд байгал, техникийн шинжлэх ухаантай харьцуулахад хөрөнгө мөнгөний зэрэгцээ зохион байгуулалт, удирдлагын анхаарал дэмжлэг, идэвхи санаачлага багагүй ач тустай байдгийг харгалзан тооцох хэрэгтэй. Тэгвэл эл үед боловсрол, шинжлэх ухааныг хариуцан эрхэлж байсан төрийн дээд байгууллага, тухайлбал Үндэсний хөгжлийн яам, Боловсролын яам, Шинжлэх ухааны академийн удирдлагын үйл ажиллагаа, байр суурийг эргэн харахад эдгээр байгууллага улс төрийн шинжлэх ухааныг улс орондоо шинэ тутам үүсгэх талаар төдийлөн хангалттай ажиллаагүй байдал харагддаг юм. Үүнд зарим талын бодит шалтгаан ч байсан бөгөөд тухайлбал шинжлэх ухаан, ялангуяа нийгмийн шинжлэх ухааныг бүхэлд нь удирдан зохицуулж ирсэн намын удирдлага, бодлого өөрөө алдарсан, дээд боловсрол, шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын хуучин тогтолцоо задарч шинэд шилжих шимжилтийн саад бэрхшээл багагүй байжээ.

Ийм нөхцөлд улс төрийн шинжлэх ухааныг шинэ тутам үүсгэж эхлэлийг нь тавих санал санаачилга, ажил хэрэгч анхны бодит алхам доороос гарч хийгдсэн байна. Түүнд тэр үед бүрэлдэн бий болсон улс төрийн амьдралын шинэ орчин нөхцөл, эрч хурдацтай өрнөсөн үйл явдлууд хийгээд бусад хэд хэдэн хүчин зүйл шууд нөлөөлж, улс төр судлал үүсэж төлөвших үйл явцыг идэвхжүүлсний дотроос дараах хоёр зүйлийг онцлон дурдъя.

Нэгдүгээрт, манай оронд 1989 оны эцсээс эхэлж эрч хурдацтай өрнөсөн нийгэм-улс төрийн шинэ үйл явдал, ялангуяа 1990 оноос хойшхи хувьсгалт өөрчлөлт, тухайлбал МАХН, түүний удирдлагад гарсан томоохон өөрчлөлт, цоо шинээр бий болсон олон намын тогтолцоо, анхны ардчилсан чөлөөт сонгууль, улсын ерөнхийлөгчийн институт, байнгын ажиллагаатай парламент,

улс төрийн эрх, эрх чөлөө бодитой хэрэгжих болсон, улс төрийн хуучин системийн язгуур өөрчлөлт, бүхэлдээ нийгмийн социалист байгуулал хийгээд улс төрийн тоталитар дэглэм халагдсан үйл явдлыг марксист философи, төр эрх зүйн онол, социализмын онолоор тайлбарлах аргагүй болсон байна.Тэгэхдээ эдгээр онол, ухаан 1990 оны туршид, мөн түүнчлэн зарим талаараа 1991 онд ч гэсэн өөрийнхөө тогтолцоо, парадигмын хүрээнд ихээхэн шинэчлэгдэж, нийгэм-улс төрийн хувьсгалт үзэгдлүүдийг шинэлэг үзэл сэтгэлгээгээр тайлбарлан ойлгохыг хичээж байсны ул мөр, баримт нь тэр үед манайд онолын сэтгэлгээний гол индэр болж байсан "Намын амьдрал" сэтгүүлийн (эл сэтгүүл 1990 оны долоо дахь дугаараасаа эхэлж "Манай индэр" нэрээр, 1991 оны зургаа дахь дугаараас эхэлж "Бодрол бясалгал" нэртэй болж гарчээ) дугааруудаас тод харагдаж байгаа юм.

1990-1991 оны эхэн үеийн манай тогтмол хэвлэл, тухайлбал „Манай индэр” сэтгүүл, “Үнэн” сонин ба улс төрийн шинэ науудаас гаргах болсон сонин, бусад хэвлэмэл материалыг олдсоны хэрээр гарчиглан үзэхэд 1991 оны дөрөвдүгээр сар хүртлэх хугацаанд улс төр судлал, улс төрийн шинжлэх ухааны талаар зориуд бичсэн тоймтой материал, өгүүлэл сэлт тааралдахгүй байна. Харин 1991 оны дөрөвдүгээр сард “Манай индэр” сэтгүүлийн дөрөв дэх дугаарт Улс төрийн дээд сургуулийн багш, дэд эрдэмтэн А.Цанжидын бичсэн „Улс төр судлалын тухай” нэртэй өгүүлэл (тус сэтгүүлийн 37-40 дэх талд) нийтлэгдсэн нь манай оронд улс төрийн шинжлэх ухааны талаар тусгайлан гарсан анхны дорвитой өгүүлэл байжээ. Зохиогч түүндээ улс төрийн шинжлэх ухааны үүсэл хөгжил, түүний судлах зүйл, бүтэц, судалгааны арга хандлага, эл ухааныг манай оронд үүсгэж хөгжүүлэх хэрэгцээ шаардлага, түүнийг хэрэгжүүлэх зарим асуудал, учрах бэрхшээлийн талаар тодорхой авч үзсэн байна.

Үүний дараа залгаж „Манай индэр” сэтгүүл улс төрийн нам судлал бол улс төрийн шинжлэх ухааны чухал бүрэлдхүүн хэсэг болохыг зааж тав дахь дугаараасаа эхэлж „Нам судлал” гэсэн тусгай булан нээж түүнд доктор Ж.Болдбаатар, А.Цанжид, В.Отгоннасан, Д.Ганхуяг нар нийт найман цуврал өгүүлэл нийтлүүлжээ. Үүнээс хойшхи хугацаанд „Бодрол бясалгал” сэтгүүлд нийгмийн улс төрийн систем, ардчилал, эрх зүйт төр, улс төрийн үзэл суртал, түүний гол урсгал чиглэлүүд, улс төрийн ухамсар зэрэг асуудлуудаар манай эрдэмтэн судлагчдын бичсэн, улс төр судлалын аспекттай сонирхолтой өгүүллэгүүд нийтлэгдсэн байна.Түүнчлэн эл сэтгүүлийн мөн 1991 оны дугааруудад Андраш Ланци („Улс төрийн философи уу, эсвэл улс төр судлал уу”- Бодрол бясалгал, -1991, “1 -10), Ф Лорда-и-Алайс („Засаглал ба түүний олон янз байдал”-Бодрол бясалгал,-1991,-“1 -9),„Алексис де Токвиль („Америк дахь ардчилал”- Бодрол бясалгал, - 1991,-1991,“1 -9”) нарын ном зохиолуудын хэсэгчилсэн орчуулгыг нийтэлжээ.

Дэлхий нийтийн хэмжээний нийгэм - улс төрийн сэтгэлгээний үүсэл хөгжлийн үе шат, түүний аль нэг урсгал чиглэл, түүнчлэн улс төрийн шинжлэх ухаан аль нэг тусгаар оронд анх үүсэж эхэлсэн цаг хугацааг тодорхой сар жилээр тэмдэглэн тогтоож үечлэхэд бэрхшээлтэй, заримдаа боломжгүй байх тохиолдол цөөнгүй гардаг ч гэсэн бүхэлдээ тийнхүү үечлэх, цаг хугацааг тогтоох ямар нэгэн үндэслэл, баримжаа байдаг ажээ.

Бид тийм туршлагыг чиг баримжаа хийж, дээр өгүүлсэн баримтыг иш үндэс болгож монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний хувьд 1990 он бүхэлдээ, түүнчлэн 1991 оны эхэн үе бол тухайн үедээ өөрийн онол, парадигмын хүрээнд ихээхэн шинэчлэгдсэн марксизмын түүхийн материализмын онол, шинжлэх ухааны социализмын онол, марксист төрийн онолоос улс төрийн шинжлэх ухаанд шилжин орох бэлтгэл хийгдсэн

шилжилтийн чанартай зурвас үе байжээ гэсэн санаа бодлыг гарган тавьж тэр талаар та бүхэнтэй санал солилцхыг хүсэж байна. Өөрөөр хэлбэл бид эл логикийн дагуу манай оронд улс төрийн шинжлэх ухаан 1991 оны эхэн үеэс дэлхий нийтийн жишигээр үүсэж эхэлсэн гэж үзэж байна.

Биднийг ийм санал бодолд хүргэж буй, хоёр дахь үндэслэл байгааг товч өгүүлье.

Нийгмийн социалист байгуулал 1990-1991 онд та бидний нүдэн дээр зөвхөн манай оронд төдийгүй дэлхийн социалист системийн хэмжээнд нурсан бөгөөд 1991 оны сүүлчээр ЗХУ задарч оршин тогтнохоо больсон явдал эл үйл явц эргэлт буцалтгүйгээр эцэс төгсгөл болсны гэрч болсон билээ. Социалист нийгмийн нурултыг дагаж түүнийг судлаж, зөвтгөн тайлбарлаж, бас түүгээр урамшин тэтгэгдэж байсан социализмын онол нэр хүнд, нөлөө, учир утгаа аяндаа алдах болсон юм. Үүний нэг тод илрэл бол манай их дээд сургуулийн оюутнууд 1990-1991 оны хичээлийн жилээс шинжлэх ухааны социализмын онол, МАХН-ын түүхийн хичээлийг заахыг эсэргүүцэх болсон явдал юм. Түүнчлэн ШУА-ийн Философи, социологийн хүрээлэнгийн ШУСО-ын сектор хэдийгээр цөөхөн ажилтантай, жижиг нэгж байсан ч гэсэн цагийн аясаар мөн 1991 онд нэр нь өөрчлөгдөж улс төр судлалын хамтлаг нэртэй болсон байлаа. Тэгэхдээ энэ нь социалист үзэл санаа нийгмийн сэтгэлгээнээс арчигдаж алга болсон гэсэн үг биш гэдгийг хэлэх хэрэгтэй. Учир нь нийгэм-улс төрийн сэтгэлгээний хүрээнд янз бүрийн, түүгээр ч үл барам хоорондоо эсрэг тэсрэг утга агуулгатай онол, номлол, сургаалууд зэрэгцэн оршиж байдаг жамтай билээ. Үүнчлэн манай амьдралаас шахагдсан социализмын онолоос үлдсэн орон зай, байр суурийг улс төр судлал эзлэх болсон ч гэсэн манай эрдэмтдийн зарим хэсэг нь социалист нийгэм амьдрах чадвараа бүрэн алдаагүй, түүнд ирээдүй бий гэж 1992 оны үед ч үзэж, өгүүлэл сэлт бичсээр байв. Гэвч социализмын онолын хувь заяа шинжлэх ухааны салбарын хувьд цаашдаа хэрхэх нь 1990-ээд оны эхэнд нэгэнт тодорхой болсон байлаа.

Нийгмийн оюун санааны амьдрал ба нийгэм-улс төрийн сэтгэлгээнд бүрэлдэн бий болсон ийм, шинэ орчин нөхцөлд тэр үед социализмын онол, түүхийн материализм, МАХН ба төрийн түүхээр мэргэшсэн, улс төрийн онолын бэлтгэлтэй, тэр дотор гадаадад сурч ном үзсэн, англи зэрэг гадаад хэлтэй эрдэмтэн багш, судлагчид голлосон бүтээлч хүмүүс барагцаалбал 1990 оны сүүлчээр улс төрийн шинжлэх ухааны талаар ярилцах, түүнийг улс орондоо үүсгэх, судалгаа хийх, их дээд сургуульд бие даасан хичээл болгож заах, мэргэжлийн анги салбар нээх талаар санаачилга гаргах, анхны өгүүлэл сэлт бичиж нийтлүүлэх зэргээр хөдөлгөөнд орсон байна. Үүнтэй холбоотой нэг зүйлийг энд сониучлан дурдахад улс төрийн шинжлэх ухааныг бидэнтэй нэгэн адил 1990-ээд оны эхээр албан ёсоор хүлээн зөвшөөрч шинэ тутам үүсгэсэн ЗХУ, хожимын ОХУ-д түүний үүсэл хөгжилд дээр дурдсан салбар ухааны эрдэмтэн мэргэжилтнүүдийн зэрэгцээ төр эрх зүйн ухааны эрдэмтэд ч идэвхтэй оролцож, багагүй хувь нэмэр оруулсан, зарим нь улс төрийн шинжлэх ухаанд шилжин орж ирж үр бүтээлтэй ажилласан билээ.

Ийм оролцоо манайд хир зэрэг байсан вэ гэвэл 1990 - ээд оны эхэнд төр, эрх зүйн ухааны эрдэмтэн Д. Дашцэдэн, Г. Совд, Б. Чимэд, Д. Лүндээжанцан нар эрх зүйт төр, засаглалын хэлбэр, улс төрийн системийн асуудлыг шинэлэг үзлээр ойлгоход ач тустай, улс төр судлалын аспекттэй өгүүлэл нийтлүүлжээ. Гэвч бүхэлд нь авч үзвэл улс төрийн шинжлэх ухаанд хамгийн ойр байдаг төр, эрх зүйн ухааны эрдэмтэдийн маань улс төр судлал дахь оролцоо, идэвх сул байсан гэж хэлж болно.

Манай оронд улс төрийн шинжлэх ухааныг шинэ тутам үүсгэж төлөвшүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн мэргэжилтнүүд бол тухайн үед шинжлэх

ухааны социализмын онолоор мэргэшсэн их дээд сургуулийн эрдэмтэн багш, ажилтнууд байв. Социализмын онол нь тэдний мэргэшил, хамгийн чухал нь М. Веберийн хэлсэнчлэн тэдний эрхэлсэн хөдөлмөр, амьжиргааны эх үүсвэр нь байлаа. Үүний эрхээр тухайн онол хэрэгцээгүй болж нийгмийн амьдралаас шахагдснаар эл чиглэлийн мэргэжилтнүүдэд шинэ мэргэшил эзэмших, шинэ хөдөлмөр эрхлэх амин чухал зорилт тулгаран тавигдсан юм.

1990 - ээд оны эхэнд социализмын онолоор хичээл заадаг, судалгаа хийдэг, нэг үгээр хэлбэл байнгын идэвхтэй хөдөлмөр эрхэлдэг мэргэжилтнүүдийн тоо улсын хэмжээнд барагцаалбал тавь хүрэхтэй үгүйтэй байжээ. Гэвч тийм цөөхөн ч гэсэн чухамдаа тэд, ялангуяа тэдний идэвх санаачилгатай, бүтээлч хэсгийнхний хүч хөдөлмөрөөр улс төрийн шинжлэх ухаан монголд харьцангуй богино хугацаанд үүссэн юм. Тэгэхдээ улс төрийн шинжлэх ухаан манайд академийн чанартай онолын суурь судалгааны чиглэлээр биш, харин түүнийг их дээд сургуульд тусгай хичээл, мэргэжил болгож заах, тэр дагуу судлан боловсруулах сургалт боловсрол, практик хэрэгцээ шаардлагын чиглэл нь давамгайлсан байдлаар анх үүсэж тэрлэсэн байна.

Манай оронд улс төрийн шинжлэх ухаан үүссэнтэй холбоотой гол үйл ажиллагаа, үйл явдал, хэвлэгдэн нийтлэгдсэн зүйлсийг эргэн харж эргэцүүлэхэд 1990-1992 он бол үндсэндээ эрдэмтэн багш, судлагчид эл шинжлэх ухаантай ерөнхий байдлаар танилцах, үндэсийг нь эзэмших, хичээл заах, өгүүлэл, бүтээл бичихэд өөрийгөө бэлтгэн боловсруулах, мэргэжлийн анги салбар нээх, судалгаа, сургалт боловсорлын нэгж бүхий тасаг, сектор, төв байгуулах бэлтгэл хангасан, зохион байгуулалтын ажил амжуулсан үе байжээ гэж хэлж болохоор байна. Мэргэжилтнүүд энэ хүрээнд улс төрийн шинжлэх ухааны асуудлаар тухайн үед гарсан ном зохиолыг олдсоны хирээр нь уншиж судлах, семинар, ярилцлага зохиох, хичээлийн программ боловсруулах, анхны өгүүлэл, гарын авлага бичих зэрэг чиглэлээр ажиллажээ. Ийм бэлтгэл хангасны үндсэн дээр манай эрдэмтэн багш, ажилтнууд 1993 оноос хойш улс төрийн шинжлэх ухааны орчин үеийн онол, арга зүй, судалгааны аргыг судлан эзэмшихийг зорихын хамт тодорхой асуудлуудаар судалгаа хийж ном бүтээл туурвих, диссертаци бичих, үндэсний сурах бичиг, гарын авлага зохиох, бакалавр, магистрантурын сургалт явуулж хичээл заах, улс төр судлагч мэргэжилтэн бэлтгэх, мэргэжлийн тогтмол сэтгүүл, цуврал бүтээл, эрдэм шинжилгээний бичиг гаргах, олон нийтэд улс төрийн мэдлэг түгээх, гадаадын улс төр судлаачдын ном зохиолоос орчуулах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг үүсгэж бэхжүүлэх зэрэг чиглэлүүдээр байгаа хүч бололцооны хирээр чармайн ажиллаж иржээ. Үүний үр дүнд өнгөрсөн 15 гаруй жилд эрдэм судлал, сургалт боловсрол, хэвлэн нийтлэх үл ажиллагааны дурдсан чиглэлүүдээр багагүй ололт амжилт гарч, улс төрийн шинжлэх ухаан манай оронд нэгэнт үүсэн бий болж цааш зүгшрэн төлөвших шатандаа орж эхэлсэн гэж хэлэх үндэслэл бий.

Манай оронд улс төрийн шинжлэх ухааныг үүсгэхэд идэвхи санаачилгатай хандаж чухал үүрэг гүйцэтгэсэн эрдэм боловсролын цөөн тооны голомт төвийн тоонд юуны өмнө тэр үеийн Улс төрийн дээд сургууль (хуучин Намын дээд сургууль), МУИС-ийн Нийгмийн ухааны факультетын Шинжлэх ухааны социализмын онолын тэнхим хоёр зүй ёсоор орно. ШУА-ийн философи, социологи, эрхийн хүрээлэнгийн хувьд гэвэл түүний Шинжлэх ухааны социализмын онолын сектор 1991 онд улс төр судлалын хамтлаг нэртэй болж монголын нийгмийн улс төрийн системийн асуудлаар судалгаа хийхээр болсоноо төдийлөн удалгүй тодорхой шалтгааны улмаас тарж, тус

хүрээлэнд хэрэг дээрээ 1995 он хүртэл улс төрийн судалгаа хийгдээгүй юм. Харин 1995 онд Улс төр судлалын салбар байгуулагдсан болно.

Улс төрийн шинжлэх ухаан манай оронд үүсэж зүгширэх, түүгээр судалгаа шинжилгээ хийх, сургалт явуулж мэргэжилтэн бэлтгэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гол үйл явдлыг он цагийн дарааллаар тоймлон дурьдвал, **1991 онд:**

- Улс төр судлалын хичээлийг их дээд сургуульд заах талаар Ардын боловсролын яамнаас шийдвэр гаргасан;

- Ардын боловсролын яамны Нийгмийн ухааны зөвлөлөөс эрхлэн “Улс төр судлалын программыг” товхимолын хэлбэрээр нийтлэн гаргасан;

- Дээрхи шийдвэрийн дагуу 1991 - 1992 оны хичээлийн жилээс эхэлж их дээд сургуульд улс төр судлалын хичээл заах болсон;

- МУИС - ийн Нийгмийн ухааны факультетэд Улс төр судлалын тэнхим байгуулагдсан;

1992 онд :

- “Улс төрийн шинжлэх ухааны үндэс” гэсэн анхны гарын авлага хэвлэгдэн гарсан;

1993 онд :

- МУИС - д Улс төр судлалын салбар байгуулагдаж анхны элсэлт авсан;

- Улс төрийн боловсролын Академи байгуулагдсан;

1994 онд :

- Улс төрийн боловсролын Академиас эрхлэж улс төр судлалын анхны тогтмол хэвлэл бүхий “Шинэ толь” сэтгүүлийг гаргаж эхэлсэн;

- А.Юндэндорж ОХУ - ын Москвагийн их сургуульд улс төрийн шинжлэх ухааны докторын (Sc.D) зэргийг монголоос анх удаа хамгаалсан;

1995 онд :

- ШУА - ийн Философи, социологийн хүрээлэн ба МУИС - ийн дунд философи, социологийн ухааны зэрэгцээ шинээр улс төрийн шинжлэх ухаанаар эрдмийн зэрэг хамгаалуулах хамтарсан зөвлөл байгуулагдсан;

- ШУА - ийн Философи, социологийн хүрээлэнд Улс төр судлалын салбар байгуулагдсан;

1996 онд :

- Улс төрийн боловсролын Академиас эрхлэж “Улс төр судлал” сурах бичиг (I дэвтэр, редактор - Б.Дэлгэрмаа)

- Цанжид А. Улс төрийн шинжлэх ухаан (сурах бичиг) хэвлэгдэн гарсан;

1997 онд :

- МУИС - ийн Улс төр судлалын салбарын анхны төгсөлт болсон;

1998 онд :

- УБИС - ийн багш Л. Пүрэвдорж “Улс төрийн хошуучлалын онолын чухал асуудлууд” сэдвээр дотооддоо анх удаа улс төрийн шинжлэх ухааны дэд докторын зэрэг хамгаалсан;

1998 - 2001 онд :

- Манай эрдэмтэдээс улс төрийн шинжлэх ухааны олон янзын асуудлаар хийсэн судалгааны дорвитой үр дүн болж олон тооны нэгэн сэдэвт бүтээл, товхимол, сурах бичиг, гарын авлага гарчээ;

2002 онд :

- БСШУ - ы сайдын тушаалаар Улс төрийн шинжлэх ухаанаар докторын (Ph.D) зэрэг хамгаалуулах анхны төрөлжсөн зөвлөл байгуулагдсан;

- МУИС - ийн Улс төр судлалын тэнхэмээс эрхлэж улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүй, сургалт практикийн мэргэжлийн тогтмол хэвлэл болох “Политологи” сэтгүүлийн анхны дугаарыг гаргасан;

2005 онд :

- Монголын Улс төрийн шинжлэх ухааны холбоо байгуулагдсан байна.

Монгол улсад улс төрийн шинжлэх ухааныг бие даасан байдлаар, дэлхий нийтийн үлгэр жишээг баримжаалж шинэ тутам үүсгэх хамтын үйл хэрэгт Ж. Болдбаатар, А. Цанжид, Д. Содномгомбо, Г. Чулуунбаатар, А. Юндэндорж, Ш. Содном, Ц. Ганболд, Л. Пүрэвдорж, Д. Чулуунжав, Д. Болд - Эрдэнэ, Б. Батчулуун, Ё. Довчин, Д. Ганбат, С. Базарпүрэв, Х. Ганбаатар, Ю. Атар, Ж. Төртогтох, Д. Ганхуяг нар чухал хувь нэмэр оруулсан, одоо ч үр бүтээлтэй ажиллаж байгааг онцлон дурьдвал зохино.

1998 - 2006 онд дотооддоо нийт 12 хүн, Л. Пүрэвдорж, Х. Цолмон, Ю. Атар, Д. Болд - Эрдэнэ, Т.Ганди, Т. Гантулга, Ц. Нүүдэл, Ж. Төртогтох, Д. Загджав, Д. Ганбат, Б. Дашдэмбэрэл, Я. Төмөрбаатар нар монголын нийгмийн улс төрийн амьдралын тодорхой үзэгдэл, үйл явцыг судлан диссертаци бичиж улс төрийн шинжлэх ухааны докторын (Ph.D) зэрэг амжилттай хамгаалсныг хэлэх хэрэгтэй.

Өнөөгийн байдлаар манай улс төр судлаачид улс төрийн шинжлэх ухааны бүтэц, салбар чиглэлд багтаж ордог олон асуудлыг монголын нийгмийн улс төрийн амьдралын жишээн дээр тодорхой хэмжээгээр авч үзэж сургалт - сурталчилгааны өгүүлэл, бакалаврын дипломын ажлаас эхлээд судалгааны нэгэн сэдэвт бүтээл хүртлэх төрөл зүйлээр (жанр) нийтлэн гаргажээ. Манай улс төр судлаачдаас сүүлийн 16 жилд тууригдсан бие даасан ном товхимолын тоо барагцаалбал 100 гаруй байна. Эрдэмтэн судлагчид монголын нийгмийн улс төрийн систем, төр, улс төрийн нам, ардчилал, улс төрийн шинэтгэл, сонгууль, улс төрийн сэтгэлгээний түүхийн асуудлыг түлхүү судалжээ.

Оюутан, сурагч, сонирхогчидад зориулсан улс төр судлалын сурах бичиг, гарын авлага бүхий нийт 6 янзын ном гарчээ. Улс төрийн сэтгэлгээний түүх, харьцуулсан улс төр судлал, нам судлал, парламент судлал, төрийн онол, улс төрийн философи, улс төрийн сэтгэл судлал, элит судлал, олон улсын харилцааны асуудлаар тусгайлсан гарын авлага, сурах бичиг нийтлэгдэн гарсан байна.

Улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүй, судалгааны болон сургалт-заах арга, практикийн олон талтай асуудлыг судлан боловсруулахад зориулагдсан „Политологи” сэтгүүл(МУИС-ийн Улс төр судлалын тэнхим), „Философи,эрхийн судлал” (ШУА-ийн ФСЭХ), „ Шинэ толь”(УТБАкадеми) сэтгүүл тогтмол хэвлэгдэн гарч байна.

Дэлхийн улс төрийн сэтгэлгээний түүхийн эх бичиг, орчин үеийн гадаадын нэрт улс төр судлаачдын бүтээлээс орчуулан гаргах ажлын хүрээнд Аристотель, Платон, Күнз, Ж.Руссо, М.Вебер, К.Поппер, Ф.Хайек, Ж.Орвелл, Р.Даль, З.Бжезински, С.Хантингтон, Ж.Вольф, В.Нерсисянц нарын зарим бүтээл монгол хэлээр нийтлэгджээ.

Манай оронд улс төрийн шинжлэх ухаан төлөвшин хөгжихөд гадаад харилцаа, хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Энэ хүрээнд МУИС-ийн Улс төр судлалын тэнхимээс Дэлхийн улс төрийн шинжлэх ухааны холбоотой харилцаа тогтоож эхэлсэн ба энэ хүрээнд тус тэнхимийн эрхлэгч, профессор Ц. Ганболд 2006 оны 7 дугаар сард Япон улсын Фукуока хотод болсон Дэлхийн улс төрийн шинжлэх ухааны холбооны XX их хуралд монголоос анх удаа төлөөлөгчөөр оролцсон нь чухал үйл явдал боллоо. Манай улс төр

судлагчид АНУ, Их Британи, Герман, БНСУ, Япон, ОХУ зэрэг орны эрдэмтэдтэй хувиараа холбоо тогтоон харилцах, зарим залуу судлагчид гадаадад суралцан мэргэжил дээшлүүлэх, эрдмийн зэрэг хамгаалах зэрэг алхам хийж байгаа нь шинэ чухал ололт юм.

Дээр өгүүлсэн зүйлс өнөөдөр монголд улс төрийн шинжлэх ухаан үүсэл төлөвшлийн аль шатад, ямар байдалтай байна вэ гэсэн асуултад тодорхой хэмжээгээр хариу өгөх боломж олгоно гэж үзэж болно. Түүний үүсэл тэрлэлийн түвшин, төлөв байдлыг үнэн бодитой тогтоох нь цаашид тавих зорилт, шийдвэрлэх асуудлыг зөв тодорхойлж эл шинжлэх ухааныг үр нөлөөтэй хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Энэ талаар эртэмтэд янз бүрийн саналтай байна. Тэдний зарим нь улс төрийн шинжлэх ухаан монголд шинэ зүйл биш, тэрбээр 1990 оноос өмнө ч байсан, түүгээр судалгаа хийгдсээр ирсэн гэсэн саналтай байхад өөр нэг нь эл шинжлэх ухаан монголд дөнгөж үүсч байна, түүнийг манайд юуны өмнө нутагшуулаад дараа нь төлөвшүүлэх, алс хэтдээ хөгжүүлэх тухай ярих нь зүйтэй гэсэн санал хэлдэг. Эдгээр саналын алинд нь ч үнэний хувь бий. Гэхдээ бидний бодлоор та бид 1990 оноос өмнө нийгмийн улс төрийн амьдралыг дан ганц марксист онолоор авч үзэж тайлбарладаг, марксизмын улс төрийн сургаалаас өөр үнэн зөв улс төрийн онол байхгүй, баруунд зуу гаруй жил хөгжсөн улс төрийн шинжлэх ухаан гэгч нь хөрөнгөтний шинжлэх ухаан мөн бөгөөд тэрбээр эклектик, эмпирик шинжтэй, үзэл суртал давамгайлсан, капитализм, хөрөнгөтөнд үйлчилсэн ухаан гэж өөртөө хаалттай байлгаж ирсэн үетэй харьцуулахад эл шинжлэх ухаан өнөөдөр монгол оронд нэгэнт бодот байдал болсон, онол, арга зүй, судалгааны болон заах арга, мэргэжилтэн, хэвлэл мэдээлэл, бүтэц зохион байгуулалтын талаар зохих хэмжээний үндэс суурьтай болсон гэж хэлэх үндэслэл бий. Гэвч цаашдаа хийж гүйцэтгэх ажил үйлс асар их байна. Илтгэлийнхээ төгсгөлд тэр талаар зарим санаа хэлье.

Аливаа шинжлэх ухааны нэгэн адил улс төрийн шинжлэх ухааныг манайд жигдрүүлэн төлөвшүүлэх, цааш хөгжүүлэхэд чадварлаг мэргэжилтэн судлагч, багш бэлтгэх, судалгаа шинжилгээ, сургалт боловсролын байгууллагыг тийм мэргэжилтэн, хүрэлцээтэй орон тоо, санхүү, техник хэрэгсэл, хэвлэл мэдээлэл, зохион байгуулалт, гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар бэхжүүлж хангахыг тэргүүн зэрэгт тавих хэрэгтэй байна. Мэргэжилтэн судлагч, багш нарыг улс төрийн шинжлэх ухаан өндөр хөгжсөн гадаад орнуудад бэлтгэх төр засгийн бодлого, бодит үйл ажиллагаа нэн чухал байна. Улс төрийн шинжлэх ухаанаар улсын төсвөөр судалгаа хийж буй гол байгууллага болох ШУА-ийн Философи социологи, эрхийн хүрээлэнгийн Улс төр судлалын салбар ердөө 7 ажилтантай, тэдний хүч бололцоо тавьсан зорилгод хүрэлцдэггүй, нэг жил нийгмийн улс төрийн амьдралын орчин үеийн асуудлыг судалснаа дараагийн жилд улс төрийн сэтгэлгээний түүх судлах шаардлагатай болдог, үүний улмаас тодорхой салбар чиглэл, асуудлаар дагнан гүнзгийрч мэргэших боломжгүй, дээр нь авдаг цалин бага гэх зэрэг бэрхшээлтэй байгаа нь ижил төрлийн судалгаа хийдэг бусад байгууллагад ч нийтлэг байна.

Улс төр судлагчдыг тодорхой чиглэл, асуудлаар мэргэшүүлэх, тухайн нэг асуудлыг дагнаж гүнзгийрүүлэн судалдаг болгохын хамт монголын нийгмийн улс төрийн амьдралын түүх, уламжлал хийгээд орчин үеийн чухал асуудал, монголын улс төрийн сэтгэлгээний түүхийг хамтын хүчээр судлаж онол практикийн үүднээс нэгтгэн дүгнэсэн хамтын дорвитой бүтээл туурвих хэрэгцээ шаардлага тулгамдан тавигдаж байна. Орчин үеийн улс төрийн шинжлэх ухаан, сэтгэлгээний ололт, үр дүнг тусгасан үндэсний хэмжээний сайн сурах бичиг, гарын авлага зэргийг улс төр судлалын тодорхой салбар

чиглэл, зааж буй хичээл тус бүрээр туурвин бүтээхийг сургалт боловсрол, мэдлэгийн зах зээл хүсэн хүлээж байгааг хэлэх хэрэгтэй. Улс төрийн шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийн үндэсний бааз, сан хөмрөгийг бий болгох, үүний тулд дэлхийн улс төрийн сэтгэлгээний сонгодог бүтээл, эх зохиол, орчин үеийн эрдэмтэн судлагчдын шилдэг чухал бүтээлээс монгол хэлээр орчуулан гаргах, гол ойлголт, нэр томъёог жигдлэж нэг мөр болгох зорилтыг алгуурлуулах, хойшлуулах аргагүй болжээ.

Олон улсын жишиг, туршлагаас үзвэл улс төрийн даяаршил, олон улсын харилцаа, төрийн гадаад бодлого, геополитикийн асуудал нь улс төрийн шинжлэх ухааны судлах объектын тоонд ордог, түүний гол салбар, чиглэлүүдийн нэг болдог байна. Гэтэл манайд эдгээр асуудлаар хийгдэж буй судалгаа, мэргэжилтэн бэлтгэх сургалт, эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөл нь манайд тогтож буй улс төрийн шинжлэх ухааны бүтэц, зохион байгуулалтын тогтолцооноос ангид, үндсэндээ завсарын байдалтай байгааг эргэн үзэж залруулмаар санагддаг.

Бүхэлдээ улс төрийн шинжилгээ, хэвлэн нийтлэх, олон нийтэд мэдлэг түгээх үйл хэрэгт өнөөгийн тоон өсөлтөөс чанарт шилжих, судалгааны онол арга зүйн түвшин, чанар, мэргэжлийн нэр хүнд, судалгааны янз бүрийн байгууллага ба их дээд сургуулиудын холбогдох тэнхимүүдийн хоорондын хамтын ажиллагааг дээшлүүлэн идэвхжүүлэх талаар ахиц дэвшил гаргах хэрэгтэй байна.

Бид улс төрийн судалгаа шинжилгээ, боловсруулалт, сургалтад эхнээсээ онол, арга зүйн баримтлал сайтай, шинжлэх ухаанч зарчмыг тууштай баримтлан хандах ёстой. Шинжлэх ухааны философийн (философия науки) мэргэжилтэн, эрдэмтэдийн үзэж байгаагаар одоо дэлхийн шинжлэх ухаан постнеклассик үедээ явж байгаа бөгөөд онол, арга зүйн хувьд судалгааны нэг объектын тухай шинжлэх ухааны янз бүрийн онол, үзэл баримтлалын аль нэгэд нь биш, харин тэдгээрийн аль алинд нь танин мэдэхүйн боломж хийгээд үнэний хувь бий гэсэн зарчмыг баримтлаж буй ажээ. Тэгвэл ийм зарчим, арга зүйн баримтлалыг улс төрийн шинжлэх ухаанд буулган авч үзвэл нийгмийн улс төрийн амьдралын үзэгдэл, үйл явдлыг улс төрийн аль нэг онол, парадигм, арга зүйгээр биш, харин тэдгээрийг хооронд нь зүй зохистойгоор, шинжлэх ухаанчаар шүтэлцүүлэн уялдуулж, олон талаас нь авч үзэж судлах ёстой гэсэн санал, дүгнэлт гарч байгааг эрдэмтэд зааж тэмдэглэжээ.

Монголын нийгмийн улс төрийн түүх, улс төрийн өнөөгийн амьдрал бол нэг талаар дэлхий дахины улс төрийн түүх хийгээд өнөөгийн амьдралын нэг хэсэг, нөгөөтэйгүүр өөрийн өвөрмөц онцлог, ялгаатай бие даасан судлагдахуун юм. Энэ нь манай нийгмийн улс төрийн хүрээг нийтээр баримтлаж буй орчин үеийн улс төрийн онол, арга зүйгээр судлах ерөнхий бололцоо олгохын хамт түүнийг өөрийн орны онцлогыг нягтлан анхаарч, бүтээлчээр хэрэглэхийг шаардах билээ.

Өгүүллийн хавсралт

Монголын улс төр судлагч эрдэмтэдээс 1990 - 2006 онд нийтлүүлсэн гол бүтээл

А. Судалгааны бүтээл

1. Жамбал А. Хүнд суртал: ноёрхол, хор уршиг, тэмцэл. УБ., 1991

2. Тамир Э. Монголын сэхээтний улс төрийн ухамсар, соёлын төлөвшлийн зарим асуудал (багш сэхээтний жишээн дээр). Ред. Д. Содномгомбо. УБ., 1993.
3. Болд - Эрдэнэ Д. Монгол дахь парламентын сонгуулийн асуудал: онол, таамаглал. УБ., 1995
4. Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил (МЭӨ III - МЭ XX зуун). Тэргүүн боть. Редактор А. Очир, Д. Чулуунжав. УБ., 1995
5. Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил (МЭӨ III - МЭ XX зуун). Хоёрдугаар боть. Редактор А. Очир, Д. Чулуунжав. УБ., 1995
6. Ялалт Ю. Пути достижения легитимности власти в монголии. УБ., 1996
7. Юндэндорж А. Нийгмийн улс төрийн шинэ тогтолцоо. УБ., 1996
8. Юндэндорж А. Төрдөө зөвлөх, түмэндээ туслах үүрэг. УБ., 1997
9. Иргэний нийгмийн онол, практикийн зарим асуудал: Шинэ Үндсэн хууль, Иргэний нийгэм. УБ., 1997
10. Монгол улсын төрийн байгууллагуудын чадавхи: ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэх шаардлага, боломж. Ред Г. Чулуунбаатар. УБ., 1998
11. Чулуунжав Д. Монголын төрийн тогтолцоо, түүний хууль, эрхийн үндсүүд дэх дутагдал, согог, асуудлууд (1990 - 1999). УБ., 1999
12. Чулуунжав Д. Монгол улсын Үндсэн хуулийн эрхийн анхаарал татсан зарим асуудал. УБ., 2000
13. Болд - Эрдэнэ Д. Монголын улс төрийн нам, намын систем. УБ., 2000
14. Монгол улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо. Ред А. Жамбал. УБ., 2000
15. Довчин Ё. Степная политическая культура. Санкт - Петербург., 2000
16. Ганди Т. Улс төр: сэтгэл зүй, мэдээлэл, шүтэлцээ. УБ., 2000
17. Юндэндорж А. Особенности политической системы Монголии в условиях перехода к конституционализму. УБ., 2000
18. Найдансүрэн Ч., Содномгомбо Д. Монгол улсын аюулгүй байдал, түүнийг хангах арга замын асуудал. УБ., 2000
19. Содномгомбо Д. Улс төрийн соёл, түүний монгол дах төлөвшилийн асуудал. УБ., 2000
20. Цанжид А. Ардчилсан социализм: үүсэл, хөгжил, мөн чанар. УБ., 2000
21. Атар Ю. Ардчилсан тогтолцоонд шилжих үеийн төр, нийгмийн харилцааны асуудлууд. УБ., 2001
22. Ганболд Ц. Ардын уламжлал ба эх оронч ухамсар. УБ., 2001
23. Гантулга Т. Улс төрийн зөвшилцөл. УБ., 2001
24. Юндэндорж А. Нийгэм иргэнлэг, ардчилсан хэв шинжийг олоход төрийн институтын гүйцэтгэх үүрэг. УБ., 2001
25. Загджав Д. Монгол дахь иргэдийн улс төрийн оролцоо, өөрчлөлт. УБ., 2002
26. Монголын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний зарим асуудал. Ред Н. Лүндэндорж. УБ., 2002
27. Батчулуун Б. Пост - коммунист нийгэм дэх төр иргэний харилцаа. УБ., 2003
28. Олон улсын терроризм ба монгол улс. Онол практикийн бага хурлын эмхэтгэл. УБ., 2004
29. Чулуунжав Д. Монголын нийгмийн өвөрмөц байдалд тохирох төрийн засаглалын зохистой хэлбэр, хэмжээ, бүтэц, үүргийн асуудалд. УБ., 2004
30. Ganbold Ts. Mongolian politics (Public opinion research) - 2003. УБ. 2004

31. Ганхуяг Д. Хошуучлагчийн улс төрийн имиж, түүнийг бүрдүүлэхүй. УБ., 2004
32. Дашзэвэг Ц. Чагнаадорж Д. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. УБ., 2004
33. Цацрал П. Монгол дахь теократ төр ба хутагт хувилгаадын улс төрийн оролцоо. УБ., 2004
34. Чулуунжав Д. Судалгааны бүтээлийн эмхэтгэл. УБ., 2005
35. Ганболд Ц. Улс төрийн сэтгэл судлал ба хүчирхийллийн сэтгэл зүй. УБ., 2005
36. Пүрэвдорж Л. Улс төрийн хошуучлал. УБ., 2005
37. Атар Ю. Монголын улс төрийн системийн төлөвшлийн онцлогийг судлах нь (Системийн онолын загвараар). УБ., 2005
38. Монгол дахь ардчиллын хөгжил: сорилт боломж. Үндэсний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ., 2005
39. Зүүн Азийн барометр: Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. УБ., 2005
40. Ganbold Ts. Mongolian politics(Public opinion research) - 2004. УБ., 2005
41. Ganbold Ts. Mongolian politics (Public opinion research) - 2005. УБ., 2006
42. Болд - Эрдэнэ Д. Их монгол улсын улс төрийн сэтгэлгээ. УБ., 2005
43. XIII - XIV зууны монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Ред А. Жамбал. УБ., 2006
44. Давааням Р., Сумъяабаатар Ө. Даяаршилт ба Монгол улс. УБ., 2006

Б. Сурах бичиг, гарын авлага

1. Улс төр судлалын программ. Ред Д. Содномгомбо. УБ., 1991
2. Улс төрийн шинжлэх ухааны үндэс. Ред Ц. Гомбосүрэн, А. Цанжид . УБ., 1992
3. Содномгомбо Д. Ардчилал, мөн чанар, түүхэн хэлбэрүүд. УБ., 1995
4. Пүрэвдорж Л, Цэрэн Г. Сонгууль - улс төрийн сонголт. УБ., 1996
5. Цанжид А. Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 1996
6. Лүндэндорж Н. Төрийн онол. УБ., 1997
7. Улс төр судлал. I дэвтэр. Ред. Б. Дэлгэрмаа. УБ., 1997
8. Цанжид А. Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 1999
9. Батчулуун Б. Улс төр гэж юу вэ ? асуулт хариулт. УБ., 1999
10. Дарханбаяр Ж. Улс төрийн лидерийн имиж. УБ., 2000
11. Жамбал А. Улс төрийн сургаалийн түүх. I дэвтэр. УБ., 2001
12. Улс төрийн шинжлэх ухаан. Ред Ц. Ганболд. УБ., 2001
13. Улс төр судлал. II дэвтэр. Ред. Б. Дэлгэрмаа. УБ., 2001
14. Юндэндорж А. Эртний өрнө дорны мэргэдийн улс төрийн онол, сургаал. Тэргүүн дэвтэр. УБ., 2001
15. Юндэндорж А, Атар Ю. Өрнө дорны мэргэдийн нийгэм - улс төрийн онол, сургаал. Дэд, гутгаар дэвтэр. Хөх хот., 2003
16. Тамир Э, Биндэръяа Д. Дундад зууны үеийн өрнөдийн улс төрийн сэтгэлгээний түүх. УБ., 2003
17. Энхболд Б. Улс төрийн шинжлэх ухааны олон улсын холбоо. УБ., 2003
18. Улс төр судлалын бүдүүвчлэлийн цомог (Сургалтын гарын авлага) Эмхэтгэсэн Н. Жалбажав, Д.Тэрбиш. УБ., 2003
19. Харьцуулсан улс төр: хүснэгт, бүдүүвч. Ред Л. Пүрэвдорж. УБ., 2003
20. Отгонбаяр Н. Микромегас II буюу хожуу үеийн улс төр сэтгэлгээний түүх. УБ., 2004
21. Өнөрбаян Г. Улс төрийн PR. УБ., 2004

22. Ганбаатар Х, Тамир Э, Биндэрьяа Д. Өрнөдийн улс төрийн сэтгэлгээний түүх. УБ., 2004
23. Юндэндорж А, Атар Ю. Жам ёсны хөгжлийн талаарх сургаал номлол. УБ., 2004
24. Отгонбаяр Н, Очирсүрэн Л. Орчин үеийн улс төрийн үзэл суртлууд. УБ., 2005
25. Довчин Ё. Харьцуулсан улс төр . УБ., 2005
26. Базарпүрэв С. Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2005
27. Довчин Ё. Харьцуулсан улс төр. УБ., 2006
67. Өлзийсайхан Ч. Элит судлал. УБ., 2006
68. Алтанчимэг Л. Улс төрийн даяаршил. УБ., 2006

В. Орчуулгын ном бүтээл

1. Орвелл Ж. Эзнээ сольсон нь. Орч Д. Чулуундорж . УБ., 1992
70. Бжезински З. Их сүйрэл буюу коммунизм XX зуунд мэндэлж мөхсөн нь. Орч Н. Пүрэвдагва. УБ., 1995
2. Майер Т. Социал - демократ үзэл санаа ба нийгмийн ардчилал. Орч Ц. Сайнсанаа. УБ., 1999
3. Орвелл Ж. Амьтны ферм. Орч Б. Эрдэнэцэцэг. УБ., 1999
4. Вебер М. Улс төр бол мэргэшил мөн, шинжлэх ухаан бол мэргэшил мөн. Орч Ү. Нямдорж. УБ., 2000
5. Руссо Ж Ж. Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд. Орч Р. Янжмаа. УБ., 2002
6. Аристотель. Улс төр. Орос хэлнээс орчуулсан Б. Даш - Ендон. УБ., 2003
7. Нартов Н.А. Геополитик. Орчуулсан Н. Одхүү. УБ., 2003
8. . Даль Р. Ардчиллын тухай. Орч Ганхуяг Д, Энхбат Ч. УБ., 2004
9. Ардчилалын чанар: Судалгааны өгүүллийн эмхэтгэл. УБ., 2005
10. Бийтхэм Д, Брекин С, Кейртон Л, Вейр С. Ардчилалд үнэлгээ өгөх гарын авлага. УБ., 2005
11. Сланн М. Улс төрийн удиртгал: хүйтэн дайны дараах эрин үеийн засгийн газрууд ба үндэстнүүд. Орч Ё. Довчин. УБ., 2005
12. Поздняков Э А. Улс төрийн философи. Орос хэлнээс орчуулсан Ү. Нямдорж. УБ., 2005
13. Алмонд Г, Пауэлл ДЖ, Стром К, Далтон Р. Харьцуулсан улс төр. Орч Ё. Довчин. УБ., 2005
14. Платон. Төр улс. Орч Д. Отгонтуяа. УБ., 2005

Г. Толь бичиг

15. Содномгомбо Д. Улс төрийн товч толь. УБ., 1996
16. Довчин Ё. Улс төрийн үг хэллэг нэр томъёоны толь. УБ., 2005
17. Энхболд Б. Улс төрийн шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь. УБ., 2005
18. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь (хамтын бүтээл) Зохиогчид: С. Баяраа, Д. Ганбат, Ч. Ган - Өлзий, А. Саруул, Д. Төмөртоого, Г. Чулуунбаатар. УБ., 2006

ПОЛИТОЛОГИ III
Эрдэм шинжилгээний бичиг ¹ ... (...): 51-56 дахь тал

**ФРАНЦЫН УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ХӨГЖЛИЙН
ҮНДСЭН ХАНДЛАГА БА УЛС ТӨРИЙН ЗАСАГЛАЛЫН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ**

Г.Цэнд-Аюуш
докторант, ахлах багш
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Франц орон Европ тивийн төдийгүй дэлхийн нийтийн баялаг түүх, соёлыг бүтээхэд хувьсгалт уламжлалаараа гайхуулагдсан орны нэг билээ. Энэ улс өнгөрсөн ба өнөө үед ч улс төрийн дипломат протокол, ёс журам үүсэн бүрэлдэхэд ихээхэн нөлөөтэй орны нэг бөгөөд франц хэл он удтал дипломат бичиг солилцооны болон харилцааны хэл байсан түүхтэй. Энэ бүхэн

нь орчин үеийн улс төрийн ажил хэргийн хэлхээ холбооны франц маягийн төлөвшилд нөлөөлсөн нь тодорхой.

Франц дахь улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн процесс францын нийгмийн хөгжлийн түүх, түүнд гарсан хувьсал хөгжилтэй салшгүй холбоотой юм. Ялангуяа дэлхийн хоёрдугаар дайны дараа францчууд улс төрийн шинжлэх ухааныхаа судалгааны хүрээг өргөтгөж улс төрийн харилцааны болон улс төрийн тогтолцооны бүхий л асуудлыг хамарсан өргөн хүрээтэй судалгаа шинжилгээний ажлыг өрнүүлэх болсон. Анхандаа улс төрийн шинжлэх ухаан францад хөгжиж байсан уламжлалт төр эрхийн шинжлэх ухааны хүрээнээс хальж, жинхэнэ бие даасан шинжлэх ухаан болон хөгжсөн юм. Энэ байдлаас үүдэн бүр тэр үед “улс төрийн шинжлэх ухаан” гэсэн нэр томьёо гарч хэрэглэгдэх болжээ. 1948 онд ЮНЕСКО-гийн ивээл доор олон улсын улс төр судлаач эрдэмтдийн чуулга уулзалтаар санал солилцолт болж, түүнээс гаргасан зөвлөмжид улс төрийн шинжлэх ухааны судлах зүйлийн хүрээ, агуулгыг дараахь байдлаар тодорхойлсон юм. Үүнд:

1. Улс төрийн бодлогын онол (Улс төрийн онол ба улс төрийн үзэл санааны түүх)
2. Улс төрийн институт (улс төрийн байгууллага, Үндсэн хууль, бүс нутгийн болон орон нутгийн удирдлага, нийтийн захиргаа, удирдлагын менежмент, социаль үүргүүд, улс төрийн байгууллагуудыг харьцуулан судлах)
3. Намууд олон нийтийн санаа бодол (улс төрийн нам, бүлгүүд болон иргэдийн оролцоо олон нийтийн санаа бодол)
4. Олон улсын харилцаа (дэлхий дахины бодлого, улс төрийн бодлого ба олон улсын байгууллагууд, олон улсын эрх зүйн хэм хэмжээ)

Энэхүү дээр дурьдсан салбарууд Францын улс төр судлаачдын судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлж байгаа юм.

Хэдийгээр улс төрийн шинжлэх ухааны үүсэл хөгжилд марксист улс төрийн сэтгэлгээний үзүүлсэн зохистой нөлөөг үгүйсгэж болохгүй боловч өрнөдийн улс төрийн сэтгэлгээ зонхилох үүрэг гүйцэтгэснийг судлаачид нотолдог. Энэ нь онол, танин мэдэхүйн төдийгүй нийгмийн тодорхой учир шалтгаантай юм. Учир нь коммунист засаглал бүхий орнуудад улс төрийн амьдралыг дээрээс хатуу хянаж нэг нам, түүнд захирагдсан төрийн заалтаар явуулж ирсэн. Ийм үед иргэдийн сонирхлын ялгааг ил гарган тавьж хамгаалах, засгийн эрхийн төлөө ардчилсан сонгуулиар өрсөлдөх зэрэг улс төрийн жам ёсны үйл явц боогдмол байв. Гэтэл өрнөдийн орнуудад түүний дотор Францад дээрхээс огт өөр нөхцөл байдал аль хэдийнээ төлөвшсөн, улс төрийн олон ургальч үзэл санаа, тэдгээрийн зөрчил өрсөлдөөнд тулгуурласан улс төрийн амьдрал олон жил хэвийн байдлаар үргэлжилж иржээ.

Энэ нь сонгуульд ялах, өөрсдийн үйл ажиллагааны зорилгыг хэрэгжүүлэхийн тулд улс төрийн шинжлэх ухаанд түшиглэх хэрэгцээг улс төрийн хүчнүүдэд аль эрт бий болгожээ. 1945 оноос хойш улс төрийн шинжлэх ухааны чөлөөт сургуулийг өөрчилж Парисын Их сургуулийн дэргэд улс төрийн судалгааны институт бий болгожээ. Иймэрхүү судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд францын бусад Бордо, Гренбол, Лион гэх мэт хэдэн арван хотуудад байгуулагдаад зогсоогүй францын улс төрийн шинжлэх ухааны үндэсний фондын ивээл доор 1949 онд Францын улс төрийн шинжлэх ухааны холбоо байгуулагдаж 1951 оноос эхлэн “Францын улс төрийн шинжлэх ухаан” нэртэй сэтгүүл гаргах болсон. 1956 онд улс төрийн шинжлэх ухаанаар шинжлэх ухааны докторын зэрэг бий болгожээ.

Анхандаа францын улс төр судлаачид энэ шинжлэх ухааны судлах зүйл, судалгааны объектын талаар нилээд санал зөрөлдөж байсан хэдий ч улс төрийн тогтолцооны асуудлаар үзэл бодлын хувьд нэгэн урсгалд нэгдсэн юм.

Франц дахь улс төрийн шинжлэх ухааны объектын талаар үзэл бодлын олон чиг хандлага байдаг. Нэг хэсэг судлаачид улс төрийн шинжлэх ухааны объект бол төр гэж үздэг. Энэхүү хандлага улс төрийн шинжлэх ухааныг Үндсэн хуулийн эрх зүй дэх гол гол асуудлуудыг үзэл бодлын үүднээс тодорхой бий болсон нөхцөл байдалд уялдуулан авч үзэх явдлыг чухалчилж байсан. Жишээ нь: Ж.Бюрдо улс төрийн шинжлэх ухааны үндсэн объект бол Үндсэн хуулийн эрх зүйг судлахад чиглэгдэнэ. Түүний өвөрмөц тал нь объектод биш үзэл бодлын хандлагад байгаа юм. Зарим судлаачид улс төрийн шинжлэх ухааны объект бол зөвхөн аливаа засаглал биш харин тодорхой хэмжээгээр мэргэшсэн улс төрийн засаглалын төрөл байх ёстой гэдэг. Гол төлөөлөгч болсон М.Прело “Институцийн засаглал бол улс төрийн шинжлэх ухааны хамгийн найдвартай хэсэг мөн” гэж үзсэн байдаг. Нөгөө нэг хэсэг судлаачид улс төр бол шинжлэх ухаан, урлаг, практик үйл ажиллагаа мөн гэсэн үзэл санааг гол болгож, ерөнхийлөгч, ерөнхий сайд ер нь улс төрийн бодлоготонд улс төрийн шинжлэх ухаан хамгийн их хэрэг болох зүйл гэж дурьджээ. “Эзэн хаадад” номондоо хэзээ нэгэн цагт улс төр жинхэнэ утгаараа эрх баригчдад бодлогоо хэрэгжүүлэхэд нь хэрэг болох зүйл гээд практик улс төрийн бодлоготон эрдэмтэн байх ёстой гэснийг өргөн утгаар нь хэлсэн байдаг.¹

Нийгмийн амьдрал хоёрдмол шинжтэй байдгийг францын улс төр судлаачид цохон заахын зэрэгцээ түүнд хандах арга зүйн хоёр үндсэн хандлагыг гаргаж тавьсан байдаг. Энэ нь нэг талаас социал ертөнцийг хүнээр дамжуулан тайлбарлах, нөгөө талаас тодорхой хүмүүсээс хамааралгүй объектив хүчин зүйлийн нөлөөллөөр тайлбарлах оролдлого юм. Эхнийх нь нийгмийн үйл явцыг бүтээгч нь хүн байдаг, түүний үйл ажиллагаа энэ үйл явцын өөрчлөлт шинэчлэлийн төвд оршдог, удаах нь хүмүүс хүссэн хүсээгүй гадаад дотоодын нөлөөгөөр нийгэмд бүрэлдэн бий болсон хэм хэмжээ хууль ёсонд захирагдаж байдаг. Энэ хоёр хандлагыг хамтруулан хэрэглэх оролдлого нийгмийн улс төрийн амьдралыг танин мэдэх, янз бүрийн үзэл суртлын өнгө аясаас зайлсхийх боломжийг францын улс төрийн шинжлэх ухаанд олгосон юм.

Францын улс төр судлаачид нийгэм бүрэлдэн төлөвшихөд хөдөлмөрийн хуваарь, харилцан хамаарлын өсөлт, суурьшлын аж төрөх ёс гэх мэт эд өлгийн олон хүчин зүйлсийн ролийг үгүйсгээгүй юм. Ж.Бюрдо хэлэхдээ: “Нийгмийн гол шинж бол нийгмийн ухамсар, хүмүүсийн өөрийн ухамсраас үүдэн гарсан объектив өгөгдөл, нийгмийг сүйтгэх ямар ч хүчинд сөрөн зогсох шаардлагыг ойлгох, ухамсарлах явдал юм гэжээ”. Өөрөөр хэлбэл нийгэм бол оюуны дэглэмийг тогтоосон онцгой феномен мөн гээд нийгмийн бүхэл бүтэн байдлыг хадгалах гол хүчин зүйл бол бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах явдал гэжээ. “Бүх нийтийн сайн сайхан байдал” нийгмийн оршин тогтнох нөхцөл зорилго, тиймээс хүмүүсийн үйл ажиллагаа энэ зорилгод чиглэгдэж захирагдсан байх ёстой. Засаг, төр чухамхүү энэ зорилгыг хангахын тулд оршин тогтнох ёстой. Хүмүүсийн захирах, захирагдах ёс юуны өмнө энэхүү нийтлэг зорилгыг ухамсарлуулахад чиглэгдсэн байх ёстой гээд засаг захиргаадлыг бий болгодоггүй харин засгаас бий болгож

¹ *Нийгмийн амьдрал хоёрдмол шинжтэй байдгийг францын улс төр судлаачид цохон заахын зэрэгцээ түүнд хандах арга зүйн хоёр үндсэн хандлагыг гаргаж тавьсан байдаг.* Энэ нь нэг талаас социал ертөнцийг хүнээр дамжуулан тайлбарлах, нөгөө талаас тодорхой хүмүүсээс хамааралгүй объектив хүчин зүйлийн нөлөөллөөр тайлбарлах оролдлого юм. Эхнийх нь нийгмийн үйл явцыг бүтээгч нь хүн байдаг, түүний үйл ажиллагаа энэ үйл явцын өөрчлөлт шинэчлэлийн төвд оршдог, удаах нь хүмүүс хүссэн хүсээгүй гадаад дотоодын нөлөөгөөр нийгэмд бүрэлдэн бий болсон хэм хэмжээ хууль ёсонд захирагдаж байдаг. Энэ хоёр хандлагыг хамтруулан хэрэглэх оролдлого нийгмийн улс төрийн амьдралыг танин мэдэх, янз бүрийн үзэл суртлын өнгө аясаас зайлсхийх боломжийг францын улс төрийн шинжлэх ухаанд олгосон юм.

байгаа хүлээн зөвшөөрөгдсөн зайлшгүй ухамсарлуулах шаардлага, оюун санааны хүч захирагдлыг төрүүлдэг юм”¹ гэж Дюркгейм үзсэн байдаг.

Иймд Францын улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн засаглалын үзэл баримтлал гол байр суурийг эзэлдэг. Засаглал нь хүний нийгмийн эх суурийн нэг бөгөөд хаана хүмүүсийн тогтвортой нэгдэл байна тэнд засаглал ямар нэг хэмжээгээр байдаг. Энэ утгаараа гэр бүлийн, үйлдвэрлэлийн хамт олон, янз бүрийн байгууллага, газарт бүх оронд засаглал байдаг.

Улс оронд байдаг тэр засаглалын төрлийг бид улс төрийн дээд засаглал хэмээн нэршсэн юм.

Францын улс төр судлаач Ж.Бурдо засаглалын үзэл баримтлалыг дараах хоёр хандлагаар авч үзсэн байдаг.

Нэгдүгээрт, концептуал хандлага:

Хоёрдугаарт, түүхэн хандлага. Нэг дэхь хандлагаар бол засаглал нь нийтийн сайн сайхныг эрж хайх, бүлгийг удирдах зориулалт бүхий социаль ухамсраас төрсөн үзэл санаанд үйлчлэх хүч юм. Үүний зэрэгцээ Бурдо засаглал үзэл санаанд үйлчлэх гаднын хүч төдийгүй, бас өөрөө энэ үзэл санааны хүч юм гэж тэмдэглэн хэлсэн байдаг.

Энэ утгаараа засаглал бол хэн нэгэн бие хүн, хэсэг бүлэг, тэр тусмаа улс төрийн намын эрх ашгаас ангид хэрэгжиж байх ёстой.

Хоёр дахь хандлага нь засаглалын улс төр-социаль аспектиг илтгэн гаргахыг эрмэлзжээ. Засаглал бол юуны өмнө социаль үзэгдэл. Нэг талаар тэр нь социаль харилцаанаас өөрөөр дамжин илрэх боломжгүй учраас нийгмээс ангид үүсэх боломжгүй, нөгөө талаар засаглалгүй бол нийгэм хөдөлгөөнгүй биет зүйл болно, байнгын ажиллагаатай байх үүрэг зорилгоо хангаж чадахгүйд хүрнэ. Энэ социаль үзэгдлийг энгийн улс төрийн биш хэлбэрээс хөгжингүй улс төрийн хэлбэрт хүрсэн угсаатны болон түүхийн материалыг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр тэрээр ийм дүгнэлт хийжээ. Засаглалыг тэрээр нийгэм үүссэнтэй хамт үүссэн гэж үздэг.²

Эхлээд хүний нийгмийн эртний бүдүүлэг үеүдэд тогтож байсан нийтийн засаглалыг дурьдсан байдаг. Тэр нь шүтлэг, бишрэл ёс заншилд суурилсан засаглал бөгөөд тийм засаглалыг улс төрийн биш засаглал гэжээ. Аль нэгэн альтернатив санал санаачлагыг хүлээн зөвшөөрдөггүйгээрээ онцлог. Дараа нь индивидуаль засаглал. Ийм засаглал нийгмийн хөгжлийн нилээд хожмын шатанд үүссэн бөгөөд нийгмийн амьдралын хэмнэл хүчтэй болохын хирээр шийдвэрийг түргэн шуурхай гаргах бодит шаардлага бий болж аль нэг удирдагч, цөөн бүлэг хүмүүсийн индивидуальжсан засаглал бүрэлдсэн байна. Ийм засаглалд легитим чанар үгүйсгэгддэг. Хэн нэгэн удирдагч таалал төгсвөл засаглалын төлөө ах дүү нар нь цус урсгасан тэмцэл хийж тэр нь тухайн бүлгийн өөрийнх нь оршин тогтнолтод аюул учруулж байсан тохиолдол олонтоо гарч байсан.

Гуравдугаарт, Институцийн засаглал Ж.Бурдогийн үзэж байгаагаар тийм засаглал төрийг хууль эрх зүйн хэлбэрээр оршин тогтнож байгааг тодорхойлдог байна. Тэрээр нийгэм-улс төрийн аспектаар засаглалын төвүүдийн олонлог байдлыг гаргаж чадсан юм. Төрд монополь эрх байлгахгүй байх үүрэг бүхий засаглалын энэ төвүүд өөрсдийн эрхийн хэм хэмжээ бий болгож, улс төрийн засаглалыг өөртөө агуулдаг болно. Төрийн засаглал-албан ёсны засаглал, бусад нь жинхэнэ улс төрийн засаглалууд гэж нэрлэгдэх болсон. Жинхэнэ засаглал нь бүлэг бүрийн бий болгодог, гишүүд дэмжигчдийн хүсч буй зорилгод захирагдана. Ж.Бурдогийнхоор дээрх

¹ *Нийгмийн ухааны үндэсний нийгэмлэг* 1982. №195

² *Нийгмийн ухааны үндэсний нийгэмлэг* 1982. №195

бүлгүүдэд эдийн засгийн бүлгүүд, үйлдвэрчний эвлэл, намууд гэх мэт хамаарагдана. Жинхэнэ засаглалууд өөр хоорондоо өрсөлддөг, харилцан үйлчилдэг, эвсэн нэгддэг мөн тэдний харилцан үйлчлэл, төрийн засаглалтай нэгдэх явдал байж болдог тухай тэрээр өгүүлсэн байдаг. Тухайлбал нэг нам төвтэй төрийн засаглалын нөхцөлд ийнхүү жинхэнэ улс төрийн засаглалын роль өсөхийн хамт төрийн засаглалын монополь эрх суларч тэр хэрээр нийгэм ардчилагдана гэж Ж.Бурдо үзжээ.

Орчин үеийн соёл иргэншилтэй ихэнхи улс орнуудад засаглалын энэхүү хэлбэр төлөвшин хөгжиж байгаа. Энэхүү засаглалын ач холбогдол нь төрийн засаглал хэн нэгэн хүний эсхүл хэсэг бүлгийн гарт төвлөрөх бус, бас аль нэг улс төрийн нам үзэл суртлын ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байдагт оршино.

Ийм засаглалын удирдах өндөрлөгүүд болон эрх баригчид нь олон түмнээс чөлөөт сонгуулиар сонгогдон байгуулагдаж, бас солигдож байдаг, олон түмний өмнө үүрэг хариуцлага, үйл ажиллагааны нь эрх, хэм хэмжээ нь бас хянагдаж байдгаараа онцлогтой. Институтжсан засаглалын нөхцөлд засаглал хуваарилах зарчим, засаглалын төвүүдийн хараат бус харилцан тэнцвэртэй байдлыг хангах механизм үйлчилж байх тогтолцооны ач холбогдол өссөөр байна.

Мөн орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд засаглалын үзэл баримтлалд эрх баригчдын болон удирдуулагчдын тухай Л.Дюгийн үзэл санаа их нөлөө үзүүлсэн юм. Тэрээр хэлэхдээ: “хүмүүсийн аливаа бүлгүүдэд хэн нэг нь шийдвэр гаргадаг, нөгөө нь тушаал өгдөг, нөгөө нэг хэсэг нь түүний өмнө бөхөлддөг, хэн нэг нь биелүүлдэг. Эхнийх нь эрх барьж байгаагийн утгыг, сүүлийнх нь удирдуулахын утгыг илтгэж байна”¹ гэжээ.

Мөн Францын эрдэмтэн А.Ориу эдийн засгийн засаглал байдгийг хүлээн зөвшөөрөөд, тэрээр улс төрийн засаглал түүнээс үүсмэл биш зүйл гэж үздэг. Улс төрийн засаглал нийгмийн хүчнүүдтэй харилцах харилцаанд шүүгчийн үүрэг гүйцэтгэдэг. Эдийн засгийн шахалтын янз бүрийн бүлгүүдийн (төрийн энэ тэр шийдвэрт нөлөөлдөг) оршин тогтнол либерал ардчиллын нөхцөлд улс төрийн засаглал нийгэмд зонхилж буй ангийн эдийн засгийн засаглалын илэрхийлэл болж чадахгүй байгааг харуулж байна. Хэрэв эдийн засгийн засаглал, улс төрийн засаглал хосолбол жинхэнэ боолчлолд хүргэнэ сонгодог феодализмын үед ийм байсан. Иймд тэрээр засаглалын үүслийн тухай дурьдахдаа тэр нь хүмүүсийн ухамсарт аль хэдийнээ дассан зүйл “ертөнцөд хүмүүс хур бороо, салхи, нарыг олж хардаг шигээ нийгэмд тэд хаана ч амьдарч байсан засаглалыг олж мэдэрч чаддаг гэжээ.”

М.Дюверже төрийн төрийн засаглалын онцлогийг гаргахыг хичээсэн байдаг. Түүнийхээр тэр нь бусад нийтлэгээс хоёр шалгуураар ялгадаг ажээ.

- онц хүчтэй зохион байгуулалттай институтжсан байгууллагынхаа хувьд;
- түүний гишүүдийн эрчимтэй эв санааны нэгдэлтэй ажиллах чадамж болно.

Төрийн институцийн давуу тал дараах гурван харилцаануудад онцгой илэрнэ.

1. Эрх баригчдын хөдөлмөрийн хуваариар эрх баригчдын тодорхой хэсэг (хууль тогтоогчид) эрх зүйн хэм хэмжээг боловсруулж баталдаг.
2. Зарим нь (захиргааныхан) тэдгээрийг нийгмийн амьдралд хэрэгжүүлдэг.

¹ *Нийгмийн засаглалын үүсвэр*. 1982. №195

3. Нөгөө хэсэг нь шүүхийнхэн юм. М.Дюверже ийм хөдөлмөрийн хуваарь зөвхөн төрд төдийгүй бас өөр байгуулагуудад байдаг гэжээ. Олонх асоциаци, улс төрийн намууд, үйлдвэрчний эвлэлүүдэд их хурал чуулган тогтоол шийдвэр гаргах үүрэгтэй, гүйцэтгэх хороод-захиргааны, зөрөлдөөний (конфликт хяналтын комиссууд-шүүхийн роль гүйцэтгэдэг). Гэвч эдгээр байгууллагад хөдөлмөрийн хуваарь төрийнх шиг төгс төгөлдөр цогц байдлын хөгжил олж чадаагүй байдаг нь олонтаа.
4. Төрд ийм иж бүрэн зохион байгуулагдсан систем байгаа нь нийгмийн бүх гишүүд төрд захирагдах боломж нөхцлийг бүрдүүлдэг.
5. Төр өөрийн шийдвэрийг хэрэгжүүлэх материаллаг том хүчтэй байдаг. Арми, цагдаа онцгой байдлын газар гээд аюулаас хамгаалах байгууллага, ер нь нийгмийн ил мөргөлдөөн тулж ирсэн нөхцөлд “сүүлчийн үг” түүнд оногддог.
6. Үндэсний эв санааны нэгдэл, сонирхлыг ангийн ямар ч ялгарлаас дээгүүрт тавьж үзэх ёстой. Энэ бол итгэл үнэмшлийн хүрээн дэх үзэгдэл.

Засаглалын легитим чанарыг хэрэгжүүлэх асуудал гол бөгөөд түүний хөгжилд эрхийн үзэл баримтлалууд онцгой рольтой юм.

Чухам хууль эрх зүйн хэм хэмжээ л засаглалд институцийн шинжийг олгож, иргэдийн нүдэн дээр засаглалыг легитим шинжтэй болгож байгаа хэрэг. Францын эрдэмтэн М.Крозье засаглалын тухай Роберт Далийн томъёоллыг илүүтэй боловсронгуй болгосон юм. Тухайлбал, Р.Даль “В-г засаглах, А-гийн засаглал гэдэг бол А нөлөөгүй үед В огт хийх ёсгүй байсан зүйлийг В-гээр хийлгэх чадвар мөн” гэжээ. Энэ тодорхойлолтыг М.Крозье улам боловсронгуй болгож засаглалыг дээрхээр тодорхойлоход ухамсартай нөлөөллөөс А, В хоёрын аль аль нь анхаараагүй байж болох санамсаргүй нөлөөллийг ялгах боломжгүй юм гэж үзээд засаглалын харилцаа нь оролцогч талуудын ухамсартай харилцан үйлчлэл, зөвшилцөл дээр тогтох ёстой гэсэн санааг дэвшүүлжээ. Энэ үндсэн дээр тэрээр В-г захирах А-гийн засаглал нь В-тэй хийх зөвшилцөлдөө өөртөө ашигтай нөхцлийг олж авах А-гийн чадвар гэжээ.

Ийнхүү францын улс төр судлаачид нийгмийн улс төрийн амьдралын ээдрээтэй үзэгдлийн нэг болох улс төрийн засаглалын тухай шинжлэх ухааны бүхэл бүтэн цэгцтэй үзэл баримтлалыг гаргаж тавьсан нь улс төрийн шинжлэх ухааны салбар ухаан болсон засаглал судлалын (кратология) номлолын хөгжилд жинтэй түлхэц үзүүлсэн юм.

Төр, нийгмийг нэг нам төвтэй улс төрийн институцууд удирдаж ирснийг халсан Монголын улс төрийн тогтолцоон дахь дэвшилт өөрчлөлт шинэчлэлт нь улс төрийн үйл явцад олон нийт урсгал байдлаар “идэвхитэй” хандах болсон олон арван жилийн нэг хэв загварын зуршмал байдлыг даван туулж, улс орны хөгжлийн зорилтыг шинжлэх ухааны ололт, эрдэмтэн мэргэдийн үзэл баримтлал, олон түмний санаа бодлын чиг хандлагын сонирхолтой уялдуулан хэрэгжүүлдэг болох нөхцлийг бүрдүүлж байна. Энэ нөхцөлд улс төрийн шинжлэх ухаанд суралцах, түүний дотор ардчиллын олон зуун жилийн арвин баялаг уламжлалтай улс орнуудын улс төрийн шинжлэх ухааны арга зүй, засаглалаа хэрэгжүүлж буй арга механизмтай нь танилцах явдал иргэдийн улс төрийн ухамсар, нийгэмшилтэд ихээхэн ач холбогдолтой нь тодорхой билээ. Улс төрийн шинжлэх ухаан иргэд улс төрийн амьдралд оролцохдоо өөрийн сонирхлыг илэрхийлэх, хамгаалах хэрэгцээгээ шууд болон дам хэлбэрээр соёлтой, шудрагаар хангах чадварыг эзэмших, улс оронд

ардчилал төлөвшиж бэхжих, түүний үндсэн дээр нийгмийн тогтвортой байдлыг найдвартай байлгах чухал мэдлэг, мэдээллийн системийг өгдөг. Улс төрийн систем нь харьцангуй тогтворжсон, эдийн засаг нь өсөлттэй, хууль ёс эрх зүйн хэм хэмжээ нь төлөвшсөн, иргэдийн амьдралын түвшин баталгаа нь харьцангуй хангагдсан өрнөдийн орнууд түүний дотор Францад “бүх нийтийн сайн сайхан байдлыг” хангах иргэний ардчилсан нийгмийн хөгжлийн зорилтыг шинжлэх ухааны бүх салбарт ялангуяа улс төрийн судалгааны хүрээнд дэвшүүлэн тавьж байгаа нь санамсаргүй зүйл биш юм.

Эцэст нь нийгэм янз бүрийн бүлгүүдийн ашиг сонирхол дээр үндэслэгддэг бөгөөд улс төрийн тогтвортой байдал, үндэсний эв нэгдэл, эдийн засгийн өсөлттэй бололцоот нөхцөл зэрэг нь “нийтийн сайн сайхан байдлын” үндэс болж байна.

Ийнхүү засаглалын ойлголтыг “нийтийн сайн сайхан байдлын” үзэл санаатай холбож өгсөн нь засаглалыг илүү их легитим шинжтэй болгож байгаа хэрэг мөн.

Ном зүй

Монголын эдийн засаг нийгэм. Статистикийн эмхэтгэл. УБ., 1997.

Даш-Ёндон Б. “Сэтгэлгээгээ шинэчлэх нь хямралаас гарч дэвжихийн үндэс,” *Бодрол бясалгал*, 1993 (1-2).

Ленин В.И. *Полное собрание сочинений*. Боть ҮІ

Современная буржуазная политическая наука. М., 1982.

Социально-политические науки. 1990. ¹ 9, х 95

Тойнби. *Постижение истории*. М, 1997

Цанжид А. *Улс төрийн шинжлэх ухаан* УБ., 1997

Цэнд-Аюуш Г. “Монголын нийгэм дэхь өөрчлөлт шинэчлэлт ба оюутан залуучууд,” *ТИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг*. 1992 (1).

ПОЛИТОЛОГИ III

Эрдэм шинжилгээний бичиг ¹ ... (...): 57-78 дахь тал

**ОРЧИН ҮЕИЙН ТӨРИЙН БЮРОКРАТ УДИРДЛАГА, ТҮҮНИЙ
УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГА**

Ц.Батболд
докторант, багш
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

XVIII - XIX зууны капитализмын хөгжил, аж үйлдвэржүүлэлтийн үйл явцын үр дүнд рациональ бюрократ нь томоохон үйлдвэр компаниудын дотоод удирдлагын хүрээнд үүсэн, улмаар хувийн аж ахуйн болон төрийн салбарын хүрээнд өргөн тархаж эхэлсэн аж. “Бюрократын рациональ загвар нь нийгмийн амьдралын бусад хүрээнд аажмаар тархаж уламжлалт бюрократ буюу удирдлагын патримониаль хэв маягийг шахаж эхэлсэн байна”¹. Макс Вебер “Бюрократ байгууллага бий болсон явдал нь хүн төрөлхтөний хөгжлийн чухал үе бөгөөд нийгмийн шинэ шатанд дэвшсэнтэй адил юм”² гэж үзсэн. Өөрөөр хэлбэл мөнгө ба харилцаа холбооны давуу талгүй хүнд шудрага амьдрах нөхцөлгүй байсан дундад зууны үеийн засаг захиргааны патриархаль болон патримониаль системийг бюрократ зохион байгуулалтаар сольсон нь нийгмийн дэвшил байв. Патриархаль болон патримониаль системийн үед ажил хэргийг авч үзэх хугацаа, журам байхгүй, тэдгээрийг үйлдвэрлэх, хариуцах харъяаллын байгууллагууд нь тодорхой бус, бүх юманд замбараагүй байдал ноёрхож, хувийн үзэл бодол эрх ашгийн үүднээс хандах болон хээл хахуулиар бүх зүйлийг шийддэг байсан. Асуудлыг шийдвэрлэхдээ үнэн зөв талаас нь биш харин эд хөрөнгө, тухайн хүний статус, танил тал, зальхай байдлын үүднээс ханддаг байсан аж. Патримониализмын үед хэрэгтэй хүнтэй танилцсан тохиолдолд ямар ч төвөггүйгээр хуулиас гадуур асуудлыг шийдвэрлэж болох бөгөөд тэдгээрийн хооронд албан ёсны ажлын харьцаа бус, харин найз нөхдийн дотно харьцаа үүсэх тааламжтай нөхцлүүдийг бий болгодог байв. Төр, нийгмийн алив үйл хэрэгт ололт гэхээсээ дутагдалтай талууд нь илүү давамгайлдаг байв.

Капитализмын хөгжил, Аж үйлдвэржилтийн үйл явц нь хувь хүн, хэсэг бүлгийн зүгээс нийгмийн өмнө тулгарч байгаа зорилтыг шийдвэрлэхэд чиглэсэн зохион байгуулалтын зохиомол тогтолцоог үүсгэж эхэлсэн. Ийм тогтолцооны загвар нь төрийн бюрократ удирдлага, түүний аппаратуудыг бий болгосон ажээ. Америкийн судлаач Скотт, Мичел нар “байгууллагын зохион байгуулалт гэдэг бол эрх мэдэл бүхий хүний удирдлагын дор, хамтын зорилгоо биелүүлэхийн тулд хэсэг бүлэг хүний үйл ажиллагааг уялдуулан зохицуулж байгаа систем юм”³ гэж тодорхойлсон байдаг. “Шилж сонгох үүднээс урсгал ажлыг шийдэх өөр орчин үеийн хэлбэр тогтож эхэлсэн нь хөндлөнгийн нөлөөлөлд автахгүй, ажлын зохион байгуулалт сайтай, хууль зүйд бүрэн нийцсэн идэвх зүтгэлтэй, шудрага хүмүүсээр гүйцэтгүүлэх, нэгдсэн дүрэм журамд бүгд тэгш, нэг мөр болгож зохион байгуулах нь тодорхой хүмүүсийн дутагдлын эсрэг байх бөгөөд энэ нь буруугаар ашиглах боломжгүй болгодог нь рационал бюрократын үзэл санааны гол үндэс юм”⁴. М.Вебер “Орчин үеийн капитализмын үзэл санааг авч явдаг ганц зүйл нь мэргэжлийн

¹ Ц.Батболд, Р.А.Амгалан, Тогтоол ажиллагаа нь яахыг Аажмаар /Анхны ололтоо. 1991. 13.

² Ц.Батболд, Тогтоол ажиллагаа нь яахыг Аажмаар /Анхны ололтоо. 1991. 13.

³ Scott James C. 1998. Seeing Like a State: How Certain Schemes to Improve the Human Condition Have Failed (New Haven, CT: Yale University Press).

⁴ Weber.M. The essentials of bureaucratic organization: an ideal-type construction. / Reader in Bureaucracy / New York. 1968. p 25.

мэдлэг, ур чадвар дээр тулгуурладаг бюрократ бөгөөд энэ нь цэвэр хууль ёсны ноёрхол юм”¹ гэж үзсэн. Албан тушаалтны байр суурийг мэргэжлийн статус нөхцөлдүүлж, албан тушаалд томилогдож дэвших нь тухайн хүний гавьяа зүтгэлээр тодорхойлогдож, тэд юуны өмнө ажил нь байнгын шинжтэй учраас улс төрийн ялгаварлалаас хамгаалагдсан байх ёстой аж.

“Бюрократ байгууллага орчин үеийн нийгмийн удирдлагын нарийн зорилтуудыг шийдвэрлэхэд зориулагдсан нилээд оновчтой институтын байгууламж мөн бөгөөд түүний оновчтой байхын үндэс бол түүний үйл ажиллагаа нь эзэнгүй хараат хэлбэрээр явагддаг ба энэ нь тодорхой нэгэн гүйцэтгэгчийн дур зоргоороо байх явдлаас хамгаалагддаг”² гэж үздэг. М.Веберийн үзэж байгаагаар зохион байгуулалтын бюрократ хэлбэрүүд удирдлагын бусад системийг бодвол илүү үр ашигтай байдаг. Яагаад гэвэл, хувь хүнд хандаагүй, тэгсэн мөртлөө бүх хүнд хамааралтай дүрэм зааврууд шийдвэр гаргах үйл явцад ихээхэн тооцоотой, үр дүнтэй байх нөхцөлийг хангаж байгаа билээ. Бюрократ систем хүний хувийн шинж чанараас хол байх тусам, сэтгэл санааны аливаа илрэл, жишээлбэл хайрлах, үзэн ядах, өөрөөр хэлбэл тооцоо судалгаагүй, сэтгэл хөдлөлийн үүднээс хандах аливаа илрэлээс ангид байснаар албан үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэхэд илүү үр дүнтэй байдаг. Удирдлагын бюрократ тогтолцоо бол тогтвортой нягт нямбай байдал, сахилга дэг журмыг тогтооход удирдлагын бусад хэлбэрээс давуу талтай байдаг аж. Ажлын үр ашиг, шийдвэрийн цар хүрээ удирдлагын аливаа зорилтыг хэрэгжүүлэхэд нэн шилдэг хэлбэр гэж М.Вебер үзэж байсан. М.Вебер бюрократ үзэгдлийн тодорхойлогч шинж чанаруудыг аль нэг байгууллагын захиргааны удирдлагын үндсэн хэв шинжийнхэн нь талаас нээн илрүүлжээ. Төр захиргааны мэргэжилтний ур чадвар, мөн түүнчлэн удирдлагын бүх хэрэгслийг эзэмшдгийн хувьд хүнд сурталт засаглал хөгжлийнхөө явцад бүгдийг эзэгнэх болно гэж Вебер үзэж байжээ. ХХ зууны туршид рационал хандлага, бюрократ аппаратын хөгжил дэвшил улс төрийн гол сэдэв болсоор ирсэн нь Веберийн таамаглал үнэн зөв байсныг баталсан билээ³. Удирдлагын зохион байгуулалтын бюрократ хэлбэр нь үр ашигтай болохыг орчин үед нийгмийн ба төр ,засгийн өмнө тулгарч байгаа олон зорилтуудыг шийдвэрлэж байгаа байдлаас дүгнэж болно.

Аж үйлдвэржүүлэлтийн үйл явцын нэг онцлог бол төрд бюрократ аппарат чухал үүрэг гүйцэтгэх болсон явдал юм. Францын эрдэмтэн Клод Хэнри де Сэн Сомон “аливаа төрд шат дараалсан аж үйлдвэрийн хөгжил хэрэгтэй” хэмээн тухайн үедээ бичиж байжээ. Тэр нийгэмд хувийн аж үйлдвэрүүд шаардлагатай хөгжлийг бий болгож чадахгүй байгаа нөхцөлд төр оролцох ёстой гэж үзсэн ажээ. Недерланд, Франц, Их Британы аж үйлдвэржүүлэлтийн хувьсгал нь зах зээлд төрийн нөлөөгүй буюу “үл оролцох” либераль номлолын үед явагдсан. Төрийн өргөн хэмжээний оролцоо нь Европд аж үйлдвэржилт аль хэдийн нь бий болсон үед хэрэгжиж эхэлсэн байна. Төрийн оролцоо нь тодорхой хэмжээнд хөгжлийн төвшингөөр хоцрогдсон төр, улсуудын хувьд аж үйлдвэржсэн төр улсуудтай өрсөлдөх үүднээс бий болсон зүйл аж. Үүний учир тухайн цаг үед дэлхийн цэрэг-улс төрийн тавцанд түрэмгийллийн онол давамгайлж байсанд оршино. Энэ үндсэн дээр төрийн ашиг сонирхол нь, батлан хамгаалах болон өөрийн эрхшээлд бусад орныг дагуулан оруулах зэргийг юуны өмнө тавьдаг байв. Нөгөө талаар эдийн засгийн хөгжлийн төвшин харилцан адилгүй улс

¹ А.А.Ашай-оё 1994. “Ойрорь айнооаонооаамай ойооооай” нод 288.

² Weber, Max. 1968. The essentials of bureaucratic organization: An ideal-type construction. /Merton, Robert K. Gray, Ailsa P. Hockey, Barbara. Selvin, Hanan C. Reader in Bureacracy /, New York, p 24.

³ А.Ашай-оё 1996, Ай-эй эайей ооооо оооооооо, ОА, н 43-46.

орнуудын хооронд эрхийн тэгш бус харилцаа үүсдэг бөгөөд үүнийг эс зөвшөөрвөл, тусгаар тогтнолоо алдах, колони болох зэрэг аюул оршиж байсан. Фредрих Лист 1841 онд хэвлэгдсэн “Улс төрийн эдийн засгийн үндэсний тогтолцоо” номондоо “өндөр соёлтой хоёр үндэстний хоорондох чөлөөт өрсөлдөөн нь тус хоёр орны аж үйлдвэрийн хөгжлийн төвшин нь ойролцоо байгаа тохиолдолд л зөвхөн хоёр талын харилцан ашигтай байх бөгөөд хэрвээ бусдаасаа аж үйлдвэрийн хувьд хоцорч байгаа аливаа орон нь ямар нэгэн хөгжингүй улс оронтой чөлөөт өрсөлдөөнд орох гэж байгаа бол юуны өмнө хүчээ чангатгах ёстой” гэж бичиж байв. Тухайн үеийн олон улсын харилцааны дэг журам нь эдийн засаг дахь төрийн оролцоо, төрийн бюрократ удирдлагын төвлөрлийг нэмэгдүүлэх гол үндэслэл болсон байна. М.Вебер “бюрократ нь өмчийг төрийн болгох үйл ажиллагаатай дотоод гүнзгий холбоотой төдийгүй, нийгмийн зохион байгуулалт болон дэг журмыг тогтоох, нийгэм улс төрийн шаардлагатай ч холбоотой юм”¹ гэж үзсэн нь тухайн цаг үеийн аль ч улс үндэстэний оршин тогтнох нийгмийн шаардлагыг хүлээн зөвшөөрч байсан хэрэг ажгуу.

XIX зууны сүүлч XX зууны эхээр их гүрнүүд нөлөөнийхөө хүрээг дахин хуваахын төлөө тэмцэлд орсон явдал нь төрийн этатист хандлагыг эрс нэмэгдүүлсэн бөгөөд үүний үр дүнд төрийн захиргааны бюрократ аппаратын хэмжээ улам бүр томрох болсон төдийгүй, эрт цагаас чөлөөтэй байсан глобальчлал (хил, гааль, паспорт, виз гэх мэтээр) хумигдаж эхэлсэн. Дэлхийн I дайн, хувьсгал зэрэг дэлхийн цэрэг, улс төрийн олон үйл явц нь чөлөөт зах зээлийг улс төрийн үр дагаваруудаар тодорхой хэмжээнд хязгаарлах (худалдааны гэрээ хэлцлийг олон улсын болон дотоод улс төрийн шалтгааны улмаас төрийн зөвшөөрөл, оролцоотой хэрэгжүүлэх гэх мэт) болсон нь дайны дараах эдийн засгийн сэргэлтэнд сөргөөр нөлөөлж, дэлхийн анхны эдийн засгийн хямралд хүргэжээ. Энэ дашрамд тэмдэглэхэд Монголыг ч энэ үйл явцын нөлөөлөл тойроогүй юм. Төрөөс Хайлар, Хаалган, Хами уруу жин тээдэг чөлөөт худалдааг хориглож, зөвхөн ЗХУ-тай байгуулсан гэрээний дагуу харилцан туслалцах ардын хоршоог хүлээн зөвшөөрсөн явдал, бараа товарын хомсдлыг бий болгож 1932 оны лам, хар ардын бослогод нөлөөлөх олон хүчин зүйлүүдийн нэг нь болсон билээ. 1929-1933 оны аж үйлдвэржсэн орнуудыг хамарсан эдийн засгийн хямрал нь XIX зууны сүүлч XX зууны эхээр ихээхэн эрч хүчтэй болж эхэлсэн улс төрийн намуудыг засаглалын төлөөх тэмцэлдээ, хямралыг зохицуулах амлалтууд өгөхөд хүргэсэн нь төрийн оролцоог нийгэм эдийн засгийн амьдралд эрс нэмэгдүүлэх бас нэг үндэс болсон ажээ. Үүний үр дүнд төрийн зохицуулалттай зах зээлийн тухай Кэнсийн онолыг баримталсан неолибериализмийн урсгал бий болсон төдийгүй, мөн нэг үзэл суртлыг иш үндэс болгосон бүхнийг хянах төрийн бюрократ тогтолцоо бүхий тоталитаризмын баруун, зүүний урсгалыг ч төрүүлжээ. Энэ хямрал нь төрийн этатист хандлагыг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болсоноор төрийн албанд ажиллагсдын тоог эрс өсгөж, төрийн бюрократ удирдлагад намын харьяаллыг оруулж ирэх үндэс болсон аж. Людвиг вон Мюзис 1944 онд бичсэн “Бюрократ” гэдэг номондоо дэлхийн I дайнаас өмнө болон түүнээс хойшхи арваад жилд АНУ болон Европын орнуудын төрийн албанд намын харьяалал бараг байхгүй байсан гэж бичжээ.

Тухайлбал “АНУ-д засгийн газрын тасралтгүй үйл ажиллагааны шаардлага нэмэгдсэнтэй холбоотойгоор илүү нүсэр хэмжээний аппарат шаардагдах болсон бөгөөд 1930 он гэхэд төрийн албан хаагчдын тоо 600

¹ Weber, Max. 1968. *The essentials of bureaucratic organization: An ideal-type construction.* /Merton, Robert K. Gray, Ailsa P. Hockey, Barbara. Selvin, Hanan C. Reader in Bureacracy /, New York., p 26.

мянга хүрсэн нь 1880-аад оныхоос даруй 6 дахин их байв. Зөвхөн “1930-аад оны дундуур ерөнхийлөгч Франклен Рузвельтийн төрийн зохицуулалттай зах зээлийн (New Deal) бодлогын үр дүнд төрийн албан хаагчдын тоо 1.2 сая болтол өссөн байна. Ф.Рузвельтийн хөтөлбөрүүд нь эдийн засгийн хямралын үеийн тодорхойгүй байдал, санхүүгийн бэрхшээлийн дараа амсхийх гэсэн олон нийтийн хүсэл шаардлагаас үүссэн байна. Эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэнээр нийгмийн хамгаалалын зөвлөл, валют, үнэт цаасны хороо зэрэг нийгмийн халамж, санхүү эдийн засгийн байгууллага, газруудыг бий болгох шаардлага гарч ирсэн юм. Үүний үр дүнд Америкчуудын эдийн засгийн байдлыг дээшлүүлэхэд засгийн газрын зүгээс дорвитой арга хэмжээ авах боломжтой болсон байв.”¹ Мөн бүхнийг төрийн хяналтанд байлгах баруун, зүүний тоталитар дэглэм тогтоосон Герман, Итали, ЗХУ-д ч мөн ялгаагүй төрийн албанд ажиллагсадын тоо харьцангуй эрс өссөн. Тоталитар дэглэмийн бүхнийг хамарсан нэг үзэл суртлын хяналтын тогтолцоо нь нүсэр том бюрократ бүтцийг шаардах болсон аж. Нөгөө талаар төрийн зохицуулалт сул, нэгдсэн төвлөрөлд улс орны бүх нөөцийг чиглүүлж чадаагүйгээрээ Франц улс Германы довтолгооныг няцааж чадаагүйгээр барахгүй, тусгаар тогтнолоо хялбархан алдсан. Төрийн зохицуулалт нэмэгдэж, бюрократ аппаратын хүрээ тэлсэн нь олон улсын тавцанд аливаа төр улсуудын аж үйлдвэржүүлэлтийг эрчимжүүлсэн төдийгүй, цэрэг-улс төр, эдийн засгаар өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх гол хэрэгсэл болсон ажээ. Төрийн оролцоо нь улс орон бүрд өөр өөр байдаг бөгөөд хамгийн өргөн оролцоотой нь Орос улс байв. Энэ талаар А.Гершенкрон “төр бол жолоодох хүчин бөгөөд Орос улс үүнийг ашиглаж, барууны эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлийн төвшинд хүрэхийг оролдсон юм”² гэжээ.

XX зууны эхэн үед төрийн хэмжээ далайц, хамрах хүрээ, түүний зардал ямар байсан болон хэрхэн өссөн талаар Иксетерийн Их сургуулийн профессор Боб Льюисийн “Төр ба эдийн засаг” бүтээлийн “Эдийн засаг дахь төрийн үүрэг роль” хэсэгт тодорхой тоо баримтаар дурьджээ.

Европын зарим орнуудын үндэсний орлогод төрийн зардлын эзлэх хувь³

	1913 он	1950 он	1980-аад он
Франц	8.9	27.6	53.6
Герман	17.7	30.4	47.3
Недерланд	11.0	26.8	59.7
Их Британи	13.3	34.2	45.2

XX зууны эхэнд цэрэг, батлан хамгаалахыг эс тооцвол Их Британи болон Европын бусад оронд ч төрийн гүйцэтгэх үйл ажиллагааны цар хүрээ тийм ч өргөн байсангүй. Энэ үед АНУ-д дотоодын нийт бүтээгдэхүүний 10

¹ Thomas E. Patterson “American Democracy” Charter 16 page 442

² Gershenkron A. Economic Backwardness in Historical Perspective. Cambridge, 1962. P. 119.

³ Áiá Eúpeñ. 1999. Yáeéí çàñàà ààðü ò°òeéí ççóyà öíeü ”ò°ò àà Yáeéí çàñàà”. / Áàðüüí öeeíñíòe, öeñ ò°ò, yáeéí çàñàà, ñíoeíeíàeeí ñòààeààà, ñòòààeooní çàðeí àñòóààe. Ðàà È.Çóyààíòæ, В.Öeeeançóyí, I.Àieüò/ ÓÁ, Admon press.

гаруйхан хувь нь төрийн хэвшилд ноогдож байв.¹ Мөн зууны эхэнд АНУ-д төрийн хэвшилд Дотоодын Нийт Бүтээгдэхүүний 10 гаруйхан хувь ноогдож байсан бол 1980-аад онд 50 шахам хувь, (Социаль демократ Шведэд 70 хувьд) хүрсэн байна².

Дэлхийн II дайны дараа бий болсон сэргээн босголт болон цэрэг, улс төрийн бүлэглэлийн хоёр том лагерын өрсөлдөөн нь төрийн этатист хандлагыг эрс нэмэгдүүлсэн. Төрийн төвлөрсөн бюрократ иерархи нь аж үйлдвэржсэн нийгмийн зохион байгуулалтын гол багаж хэрэгсэл болж, хөгжил дэвшлийн эхэн үедээ нийгэм эдийн засгийн өндөр өсөлтийг өгч, үйлдвэрүүдэд сая, сая ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх, харин засгийн газруудад стандартчилагдсан хэвшмэл дэг журмаар сая, сая хувь хүнийг боловсруулах боломжийг олгосон ажгуу. М.Вебер “туршлагаас харахад нэг хүний засаглалын хэлбэр нь захиргааны байгууламжийн хамгийн цэвэр бюрократ төрөл бөгөөд удирдагч нь хамгийн дээд цэгийн эрх мэдлийг өөртөө бий болгож, өөрийн захиргаанд хүн төрөлхтөнийг атгах засаглалын нэг хэлбэр юм. Энэ нь бусад засаглалын хэлбэрүүдээс өөрийн тогтвортой байдал, сахилгын хатуу чанд шаардлага болон найдаж болох итгэл төрүүлдэг талаараа илүү давуутай. Тийм ч болоод энэ нь байгууламжийн удирдлагуудад болон түүнд хамааралтай аль ч шатныханд маш өндөр хариуцлага тооцож байдаг. Бюрократ нь хүчирхэг удирдлага үйл ажиллагааны цар хүрээгээрээ юунаас ч хүчтэй бөгөөд бүх төрлийн удирдлагын үүрэгт үйл ажиллагаанд хэрэглэхийн хувьд бүрэн боломжтой юм”³ гэж тодорхойлсон. Орчин үеийн ямар ч байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бюрократ загварыг захиргааны бүхий л системд хэрэглэж байгаа бөгөөд эдгээр нь хоорондоо бараг ялгагддаггүй. Бюрократчилах үйл ажиллагаа өмчийг төрийн болгох үйл ажиллагаатай дотоод гүнзгий холбоотой болж, нийгмийн зохион байгуулалт болон нийгмийн дэг журмыг тогтоох цэрэг, улс төр, эдийн засгийн цаг үеийн шаардлагад нийцэж байсан аж. Энэ үйл ажиллагаа нь эдийн засгийн болон бусад хүрээнд чөлөөт үйл ажиллагааны элементүүдийг устгах аюулыг төрүүлж байсан бөгөөд төрийн бюрократ нь үйлдвэр, компаниудын дотоод удирдлагад хутгалдаж холилдоод ирэхээр түүний эдийн засгийн үр ашигтай үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж эхэлсэн байна.

Гэвч XX зууны нэг онцлог нь шинжлэх ухаан техникийн хөгжил дэвшлээс гадна М.Веберийн хэлснээр “дэлхийн ямар ч улс орон төрийн бюрократ механизмгүйгээр нэг ч өдөр оршин тогтнохгүй”⁴ нь ойлгомжтой болсон бөгөөд “мэргэжлийн мэдлэгт тулгуурласан тэдний ноёрхол нь зайлшгүй”⁵ байв. Хүч хэрэглэсэн хувьсгал гарах эсвэл гадны улс орнуудад эзлэгдсэн тохиолдолд ч бюрократ машин нь яг урьдын хууль ёсны засгийн газартаа ажиллаж байсан шигээ цаашид ажиллаж чаддаг аж. Асуудлын гол нь хэн тухайн бюрократ машиныг ажиллуулж байгаад л байдаг. Бүхнийг зааварлан зохицуулагч (хууль, дүрэм журмаар) төрийн машинууд түүнд ажиллагсдыг өөрийн эд анги, эрэг шураг болгоод зогсохгүй, нийгмийг нийтэд нь тэрхүү механизмын удирдлаганд оруулсан юм. М.Вебер “капитализмийн эдийн засгийн нөхцөл байдал нь бюрократ удирдлагын хамгийн тохиромжтой хэлбэр юм. Учир нь энэ нь энэхүү удирдлагыг хамгийн оновчтой хэлбэрт

¹ 0ḁḁḁḁḁḁḁ 0ḁḁḁḁḁḁḁ. 0ḁḁḁḁ ḁḁḁḁḁḁḁḁḁ ḁḁ. XXI ḁḁḁḁḁ ḁḁḁḁḁḁḁḁ ḁḁ ḁḁḁḁḁḁḁ ḁḁḁḁ ḁḁḁ ḁḁḁḁḁ. 0ḁ, 2005. ḁ 4

² *Ō.Ōōēōyāiā. Ō°ōēēā āyōæççēyō iū.XXI cōōiū cāñāāēāē āā āyēōēēī ōēīy āyā æōōāi. ŌÁ., 2005, ō4.*

³ Weber.M. The essentials of bureaucratic organization: an ideal-type construction. / Reader in Bureaucracy / New York. 1968. p 25.

⁴ A. IeăoiŃo E. IeăoiŃo, *IŃ÷ei cãeei ò°òeei oăeòăeăăă, ÓÁ.*, 1996, ō 43-46

⁵ Weber, Max. 1968. The essentials of bureaucratic organization: An ideal-type construction. /Merton, Robert K. Gray,Ailsa P. Hockey, Barbara. Selvin, Hanan C. Reader in Bureacracy / . New York.. p 25.

хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгө мөнгөний эх үүсвэрийг тавьж өгдөг талтай. Хөрөнгийн тал дээрээс гадна харилцаа холбоо, тээвэрлэлтэнд чухал ач холбогдол өгөх хэрэгтэй байдаг. Эдгээрийн үнэн зөв байх нь төмөр зам, цахилгаан холбооны үйлчилгээнээс хамаардаг. Социалист зохион байгуулалт ч энэ бүхнийг орхигдуулдаггүй. Харин капиталист нөхцөлд нарийсан хөгждөг шиг, социалист нөхцөлд хөгжих болов уу гэдэг нь л эргэлзээтэй”¹ гэж үзжээ.

Төр засгийн байгууллагын үйл ажиллагааны хүрээ хэт өргөжсөнөөр ажиллагсдын тоо эрс нэмэгдэж, хуулийн хязгаартай байх зарчим алдагдан хувь хүний амьдралын процесст нөлөөлөх хандлагатай болж, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах болсон нь бюрократчиллын сөрөг үр дагавар юм. Үүний үр дүнд төрийн захиргааны эрх мэдэл нь нийгмийн амьдралын салаа, мөчир бүрд өсөн нэмэгдэж, нийгмийн хөгжил дэвшлийг хангах бус харин хүний эрх, эрх чөлөөг улам бүр хязгаарлах, нийгмийн хөгжлийг боомилох хандлагатай болж, авилгын системийг хөгжүүлэх нөхцлийг хангаж, эдийн засгийн салбарт шудрага бус өрсөлдөөн буюу монопольчлолыг нэмэгдүүлсэн ажээ. Энэ нь Итали гэх мэтийн зарим улс орнуудад хууль бус корпоратив бүлэглэлүүд засгийн газарт хүчтэй нөлөөлөл үзүүлэх хэмжээнд хүртэл өсөж байсан тохиолдол байдаг. Мөн шинжлэх ухаан техникийн салбар дахь хөгжлийн ололт нь технократуудыг төрүүлсэнээр бюрократ удирдлагын хэмжээг өсгөх, тэдгээрийн зайлшгүй байдлыг ч улам бүр нэмэгдүүлсэн ажээ. Бюрократчиллын хандлага төр, нийгмийн харьцаа буюу иргэн, засаг захиргааны харьцаан дээр тод илрэх болсон байна. Бюрократчилал нь ирээрхи институтэд хандах олон түмний итгэлийг бууруулсан төдийгүй, бюрократ дахь сөрөг үр дагаварууд нь нийгмийн хөгжилд “чөдөр” болон нөлөөлж эхэлсэнээр олон түмэн түүнийг хүнд суртал хэмээн нэрлэх болжээ.

Бюрократыг судлагчид түүний мөн чанарыг судлан тодорхойлж шүүмжлэх болсон ажээ. Тухайлбал, Р.Мертон бюрократыг “хэт хөшүүн, зоригтой шийдвэр гаргаж чадахгүй байдалд түлхэж, хувь хүний болон хэсэг бүлгийн төвшинд хамгаалалтын байранд шилжүүлэх сөрөг үр дагавартай”² гэж үзсэн бол, П.Сельзник “бюрократууд өөрсдийн зорилгыг бусдынхаас дээгүүр тавих хандлагатай”³ гэжээ. А.Гоулднер “хүнийширсэн дүрэм зааврууд идэвх санаачлагыг өрнүүлэх хөшүүрэг болж чаддаггүй”⁴ гэсэн бол, У.Беннис “уян хатан бус”⁵ гэх мэтээр шүүмжилсэн байдаг. Төрийн зохицуулалт болон бюрократчиллын аюулыг мэдрүүлэхийн тулд Томас Бернхард “Хуучин мастерууд” бүтээлдээ “...сургууль бол залуу хүмүүсийг төр төлөөний хүнээ болгох төрийн сургууль бөгөөд өөрөөр хэлбэл төрийн түшиг тулгуураас өөр юу ч биш юм. Би сургуульд орвол би төрд орлоо гэсэн үг. Төр амьд болгоныг орохыг зөвшөөрдөг юм бол би байгууллага уруу амьд бодьгалуудын зөвшөөрлөөр оржээ./...../ төр бусдыг хүчээр тулгасан шигээ намайг төрд дуулгавартай болгож, намайг төрд үйлчлэх хүн болголоо. Бидэнд харагдаж буй хүмүүс бол төрд үйлчилж буй хүмүүс буюу төрийн зарц юм. Ийм хүмүүс бүх амьдралаа төрд үйлчлэхэд зориулсанаар тэд өөрсдийн амьдралаа ямар нэгэн зүй ёсны бус зүйлд зориулжээ. Хэргийн учир нийгмийн болон улс төрийн соёлтой онцгойгоор холбогдох төрийн оролцоотойгоор зүй ёсоор бүрэлдсэн нийгмийн хуваагдал болон бюрократ иерархид оршино” гэжээ. Энд хувь хүн

¹ Weber, Max. 1968. The essentials of bureaucratic organization: An ideal-type construction. /Merton, Robert K. Gray, Ailsa P. Hockey, Barbara. Selvin, Hanan C. Reader in Bureacracy /, New York., p 25.

² Robert, Merton K. Bureaucratic Structure and Perconality. /Reader in Bureacracy/ New York., 1968.

³ Selznick, Philip. 1957. Leadership in Administration. Evanston: Peterson & Co., p 46.

⁴ Gouldner, Alvin W. 1968. “The Problem of Succession in Bureaucracy.” Reader in bureaucracy. New York, Free press.

⁵ Æ.Íeððíó Ë.Íeððíó, 1996, Íó÷eí çàðeí o’ðeéí óæeðææää, ÓÁ, õ 43-46

Төрийн оролцоог нэмэгдүүлэхэд дараах хүчин зүйлс гол нөлөөлөл үзүүлсэн байна. Үүнд:

2. Дэлхийн I дайны дараах олон улсын улс төрийн тавцан дахь улс орнуудын дайсагнасан харилцааны улмаас үүссэн глобальчлалыг хязгаарлах үйл явц нь 1930-аад оны чөлөөт зах зээл дэх эдийн засгийн хямралыг үүсгэжээ. Энэ хямралаас гарах асуудлыг тоног төхөөрөмж, техникийн шинэчлэлээс гадна төрийн зохицуулалт, түүнийг зохион байгуулах бюрократ аппаратуудыг бэхжүүлснээр шийдвэрлэжээ. Хямралыг давах улс төрийн үзэл баримтлал болсон эдийн засаг дахь эрэлтийг зохицуулах ач холбогдлыг чухалчилсан төрийн зохицуулалттай зах зээлийг удирдлага болгосон неолиберализм болон национализм, коммунизмын үзэл сурталд тулгуурласан тоталитаризмын баруун зүүний урсгал нь төрийн оролцоог нэмэгдүүлсэнээр хямралыг даван туулах үндэслэл болсон ажээ. Тухайн үеийн хуваагдмал ертөнцөд чөлөөт зах зээл оршин тогтнох чадвараа алдсан байв.

XX зууны эхээр ихэнхи улс орнуудад улсын зардал нь дотоодын үндэсний нийт бүтээгдэхүүний 4%-10%-г эзэлж байсан бол 1980-аад онд тэдгээр нь 33%-60% болж, барууны орнуудад дотоодын үндэсний бүтээгдэхүүний үнэ өссөн бөгөөд зарим социалист орнуудад 70%-80% болсон² байна. Төрийн өмчийн өсөлт болон эдийн засагт төрийн хяналт тавих нь эрс нэмэгдсэн явдлыг Р.Инглехарт "...ирээдүйг нөмрөн авах шинж тэмдэг шиг санагдаж байсан боловч, ийм юм болсонгүй, харин ч төрийн оролцооны цаашдын түрэмгий бодлого нь үйл ажиллагааны харилцаанд өргөн хэмжээгээр хүлээн авах ойлголтонд эргүүлэн, өсөлтийнхөө дээд цэгт хүрч буурч эхэлсэн..."³ гэжээ. Орчин үеийн төр, нийгмийн салбарууд дахь аж ахуйн системийн дийлэнх нь өөрийн үр ашигт байдлаа алдах болсон аж. Уламжлалт нийгэм болон аж үйлдвэржилтийн үеийн дэлхий дахины олон улсын

³ ϩ.Èíãëõàóò. Ì°ί όνία. Ĵĩēēñ. Ì.. 19

харилцааны дэг журамд уламжлалт хүчирхийлэлд тулгуурласан эрх тэгш бус харилцаа давамгайлж байсан нь улс үндэстнүүдийн нийгмийн улс төр, эдийн засаг, соёл, оюун санааны бүхий л хүчийг төрөө бэхжүүлэхэд чиглүүлсэнээр тэдний оршин тогтнох баталгаа болж байв. Энэ нь төр төвтэй нийгмүүд оршин тогтнох үндэс болж байсан бөгөөд үүний үр дүнд дэлхийн хоёр дайн гарсан нь олон улсын харилцаанд шинэ эргэлт гарах үндэс болсон ажээ. Дэлхийн II дайны хөнөөлөөс сургамж авсан улс орнууд улс үндэстнүүдийн эрх ашиг, тусгаар тогтнол, хүний эрхийн баталгааг хангах НҮБ-ыг байгуулахад хүрсэн билээ. Гэвч дэлхийн II дайны үед нийгмийн улс төр, эдийн засаг, соёл, оюун санааны бүхий л амьдралыг албадан зохицуулах болсон төр нь, тайван цагт ч сэргээн босголт болон хүйтэн дайны улмаас улс орны хүчирхэг байдлыг хадгалах үүднээс оролцоогоо хязгаарлаагүй юм. НҮБ-ын үзэл санаагаар дэмжлэг авсан колончлолыг эсэргүүцэх хөдөлгөөн Ази, Африкийн орнуудыг хамран, тусгаар тогтносон олон улс орнуудыг бий болгосон. Энэ нь аж үйлдвэржсэн орнуудыг колонийн нөөцөөс нь салгаж, биеэ даасан эдийн засгийн бодлого явуулахад хүргэсэн нь тэдгээр улс орнуудад тус тусын эдийн засгийн бэрхшээлийг бий болгосон бөгөөд үүнийг даван туулахад, хүнд сурталжсан бюрократ тогтолцоог эргэн харахад хүргэсэн ажээ. М.Крозье “Тоглоомын нөхцөл” өөрчлөгдсөн төвшинд, орчин үеийн нийгмийн хяналтын хэрэгсэл тохирохгүй байгаа явдал нь хямралын гол шалтгаан болж байдаг гэж үзжээ. Орчин үеийн нийгмийн хямрал бол зөвхөн засаглалын харьцаанаас гадна юуны өмнө хүнд суртлын хямрал гэж Крозье баталдаг. Тэр бичихдээ: “манай барууны нийгмүүдийн гол асуудал бол удирдлагын загваруудын гүнзгий хямрал (нарийн төвөгтэй байдал ба хүний эрх чөлөө өссөнтэй харьцуулсан) бол, нийгмийн хяналтын хэрэгслэлийн хэсэгчилсэн пезинтеграцийн хямрал юм”¹ гэжээ. Крозье удирдлагын хямралыг бюрократ хямрал гэсэн ойлголттой нягт уялдуулан авч үзэж байсан юм. Түүнийхээр эдгээр ойлголтууд нь харилцан бие биенийгээ нөхөж байдаг. Энэ хоёр төрлийн хямралд засаглалын хямрал буюу засаглалын уламжлалт иерархи харилцааны хямрал илүү ойрхон байдаг.

М.Вебер бюрократуудын онцлогыг дурдахдаа: “Засаглалд тэдний хувийн ба албаны шинж нь холилдсон байдаг бөгөөд өөрсдийн эрх мэдлийн монополь шинжтэй албаны нууц нь мэргэжлийн мэдлэг юм шиг харагдуулдаг онцлогтой. Ийм учраас бюрократ амь бөхтэй энэ бүтцийг устгах хэцүү”² гэжээ. Учир нь нийгмийн олон талт амьдралын салаа мөчир бүрд, төрийн, хувийн болон олон нийтийн бүхий л салбарт хөдөлмөрийн хуваарь, түүнийг зохицуулах мэргэжлийн рационал удирдлага зайлшгүй шаардлагатай байдаг. К.Мангейм “Рациональ бюрократын хөгжлийн ухагдахуун” бүтээлдээ төрийн бюрократыг “улс төрийн бодлогыг захиргааны бодлого болгон хувиргах үйл явц юм” гэж үзсэн байдаг. Үүний нэг шалтгаан нь хууль дүрмийг амьдралд хэрэгжүүлэх ажлыг хэрэг дээрээ зөвхөн тэд эрхэлж байгаад оршино. Ийм ч учраас энэ чиг үүргээ биелүүлэхийн тулд үйл ажиллагааны тодорхой эрх чөлөөтэй байдаг. Орчин үеийн хууль тогтоомж ихэнхдээ ерөнхий шинжтэй байдаг учир түшмэд тэдгээрийг нарийвчилж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон нөхцөлд л үр дүнтэй ажил хэрэг болж чаддаг аж. “Улс төрийн бодлогыг амьдралд хэрэгжүүлэх нь түүнийг бюрократууд хэрхэн тайлбарлаж, практик дээр хэрхэн идэвхтэй, үр нөлөөтэй явуулснаас гол төлөв хамаарна. Гэвч бюрократуудын эрх хэмжээ, бусдын боловсруулсан зарчмуудыг ажил хэрэг болгосноор огт хязгаарлагдахгүй. Хүнс, хөдөө аж ахуй, хөдөлмөр,

¹ А.Э.Норейнмаа. Ардчилалын үндэс. I, 1997. 516,

² I.A.Landman. Our society and the future. A study in the theory of social change. New York, 1967.

батлан хамгаалах, нийгмийн хангамж, боловсролын зэрэг олон яамдуудын дуу хоолой нь ямагт жинтэй сонсогддог сонирхлын бүлгүүдийн тоонд ордог”¹. Америкийн судлаач Ричард Рөүзийн хэлснээр “Ерөнхийлөгч бодлого боловсруулахад оролцох гол нөлөө нь төрийн албадаас ирсэн санаачлагын алиныг нь авч, алиныг нь гээх вэ гэсэн шийдвэрүүдээр хэрэгждэг”² гэжээ. Түүнээс гадна орчин үеийн улс төрийн системүүдэд захиргааны байгууллагууд шүүхийн шийдвэртэй холбоотой цөөнгүй чиг үүргийг биелүүлдэг. Жишээ нь, “татварын байгууллагууд гол төлөв иргэд орлогоо үнэн зөв мэдүүлж төлсөн эсэхийг тодорхойлж, шаардлагатай бол шийтгэл оногдуулдаг. Иргэд зарчмын хувьд энэ шийдвэрүүдийг шүүхийн журмаар маргаж заалдах эрхтэй ч практик дээр энэ нь ховорхон тохиолдоно. Эцэстээ, бюрократууд улс төрийн коммуникацид татагдан ордог. “Улс төрийн элитүүд хууль тогтоох ч бай, гүйцэтгэх ч бай өөрсдийн олон шийдвэрийг засаг захиргаанаас авсан мэдээлэлд үндэслэдэг. Мөн уг мэдээллээс сонирхлын бүлгүүд, улс төрийн намууд, бизнес элитүүд, олон нийт хамааралтай байна”³. Орчин үеийн төрийн бюрократ нь хувь хүний эрхийн гарз хохирлын үнээр нийтлэг эрх ашигт нийцсэн илүү өндөр үр дүнд хүрч байгаа тийм хэлэлцээрийг гүйцэтгэдэг аж. Энэ нь түүнд хэвшсэн ёс журмын тусламжаар мянга, мянган эсвэл сая хүнийг ч өөрийнхөө нөлөөнд оруулж чаддаг. Энэ хүч чадлаараа бюрократ нь нийгэмд хүнд суртал хэмээн нэрлэгдэх бөгөөд хүмүүсийн чөлөөт байдал, шулуун шудрага, хувийн дур сонирхол, шунал, өөрийн бодьгал илэрхийлэл ба уран бүтээлийг ч хөсөр таягдан хаядаг. Түүнээс гадна бюрократ нь хэдэн зуун бүр сая сая хүний хүчийг ч орчин нийгмийн том байгууллагад чиглүүлэх идэвхитэй багаж зэвсэг нь болж өгч байсан. Гэвч түүний үр бүтээмж, тохиромжтой байдал нь одоо нэгэнт үгүй болжээ гэдэг дээр нийгмийн гишүүд болон судлаачдын үзэл санаа давхцдаг. Сүүлийн хоёр зуун жилийн гайхамшигт үзэгдэл бол төрийн бюрократ удирдлагын эрчимтэй өсөлт байлаа. Үйлдвэржсэн нийгэм нь бүр ихээр төвлөрсөн бөгөөд түүний шатлан захирах удирдлага нь улам бүр хүнд суртлын шинжтэй болж ирсэн байна. Нийгмийн бюрокарт ёс журмын уналтын нэг дэх учир шалтгаан нь үйлдвэржсэн нийгмийн эхний үе шатыг бодвол өндөр технологитой орчин үеийн нийгэм дэхь өндөр боловсролтой ажиллах хүчийг дотооддоо бага бүтээмжтэй байлгасанд оршдог. Хоёрт орчин үеийн нийгэм дэхь хүмүүс тэдгээрийн өөрчлөгдөж буй үнэт зүйлсд бюрократ ёс нь итгэл багатай хандсанд оршино.

Төрийн хэт зохицуулалтын үр дүн нь 1970-аад оны “Эрчим хүчний” зарим газар “Газрын тосны” гэгдэх эдийн засгийн хямрал төдийгүй, түүний үргэлжлэл болох социалист системийн нуран унасан үйл явцтай холбогдоно. Дэлхийн эдийн засгийн хямрал нь төрийн оролцоог хязгаарлах хандлагыг бий болгосон аж. Энэ эдийн засгийн хямралын үр дагавар нь неолиберализм болон төрийн зохицуулалттай зах зээлийн тухай Кэнсийн онолыг шүүмжлэх болсон аж. Энэ шүүмжлэл нь капиталист системийн орнуудад үзэл суртлын неоконсерватив урсгалыг төрүүлсэнээр өрнөдийн орнуудад шинэ үзэл баримтлалтай улс төрчид өсөн нэмэгджээ. Тэд 1980-аад оноос Их Британи, АНУ-д төрийн оролцоог багасгах, төрийн салбарт зах зээлийн өрсөлдөөний эхлэл нөхцлийг сайжруулан өргөжүүлэхэд ихээхэн анхаарах болсон “Тэтчеризм”, “Рейганизм”-ийн бодлогыг хэрэгжүүлснээр төрийн төвлөрлийн эсрэг үйлдлийг бий болгосон байна. Энэ үед барууны өндөр хөгжилтэй АНУ, Англи, Недерланд, Швед, Шинэ Зеланд, Австрали гэх зэрэг олон улс

¹ А.Асумиа. А.Яаоүе. Ё.Ноон. В.Аасуон. Оаоуооёёнаі оёё о°о. ОА, 2005. 6 162.

² Patterson Thomas E. 1996. “American Democracy” New York, the McGRAW-HILL companies, INC. p 448.

³ А.Асумиа. А.Яаоүе. Ё.Ноон. В.Аасуон. Оаоуооёёнаі оёё о°о. ОА, 2005. 6 162.

орнуудад төрийн зохицуулалт, засаглалын зардлыг бууруулах зорилгоор төрийн удирдлагын шинэчлэлийг хэрэгжүүлэх үйл явц эхэлсэн юм. Тухайлбал Их Британий эдийн засгийн “Англи өвчин”-ны эсрэг ерөнхий сайд Маргарит Тэтчер хэдэн засгийн газар дамжуулан төрийн салбарын зарим үйл ажиллагааг хувийн секторт гэрээгээр болон хувьчлан шилжүүлэх “Алхам алхамаар”, “Дараачийн алхам”, “Сүүлчийн алхамууд” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр төсвийн зардлыг бууруулж, албан хаагчдын тоог цомхотгож, эдийн засгийн зогсонги байдлыг арилгаж чадсан юм. Их Британид 1979 онд нийт төрийн албаны ажилтны тоо 723.0 мянга байсан бол 1995 оны 1-р сарын байдлаар 550.0 мянга болсон нь 15 жилд 25% -иар буурсан¹ байна. Недерланд, Шинэ зеланд, Скандинавын орнуудад ч засаглалын шинэтгэлийг хэрэгжүүлж эхэлсэн байна. 1980-аад оноос эхэлсэн эхэлсэн засаглалын шинэтгэл нь Скандинавын орнуудад нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын эрх үүргийг нэмэгдүүлж, менежментийн үзэл санааг дэмжихэд чиглэсэн ажээ.

1970-аад оноос төрийн удирдлагын бюрократ аппаратуудын хэмжээ далайц томрох тусам, түүний сөрөг нөлөөлөл болох хүнд сурталтай тэмцэх хандлага дэлхий нийтийг хамарч эхэлсэн нь социалист системийн орнуудад бюрократ дахь хүнд сурталтай тэмцэх хандлага бий болгоход тодорхой хэмжээгээр нөлөөлөх болсон аж. Гэвч эдгээр орнууд нь үндсэндээ нэг намын үзэл суртал дээр суурьлагдаж, тоталитар шинжтэй нийгмийг бүхэлд нь хянасан бюрократ тогтолцоонд тулгуурлаж байсан тул, судалгааны ажлууд нь үзэл сурталжиж явуургүй болсон ажээ. Тийм ч учраас хүнд суртал нь жижиг хөрөнгөтний үзэл бөгөөд түүнийг даван туулах нь социализмын цаашдын зорилгод нийцнэ гэж үзэж байв. Монгол оронд хүнд сурталтай тэмцэх явдал нь 1970-аад оны дундуур түүний үг хэллэгийг шүүмжлэх хэлбэрээр анхлан эхэлсэн ажээ. Энэ үеийн Монгол орон нам, төрийн номенклатур бүхий бюрократад тулгуурлаж байсан бөгөөд энэ нь тоталитар шинжтэйгээр нийгмийн бүхий л амьдралын (улс төр, эдийн засаг, социаль, оюун санааны) хүрээнд хутгалдаж бюрократчилагдсан байв. Бюрократчилалын ноёрхол нь хүний эрх, эрх чөлөө, нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхол, эдийн засгийн эрх чөлөөг тодорхой зохиомол хүрээнд боогдуулж, хүнд суртал, авилгалд автсан нийгмийг бий болгон, оршин тогтнож буй улс төрийн системд гажилт үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлүүдийн нэг болоход хүрчээ. Социализм дахь эдийн засгийн зогсонги байдлын эсрэг 1985 оноос ЗХУ-д эхлэсэн өөрчлөн байгуулалтын нөлөөгөөр Монголд ч бюрократ удирдлага болон түүний хүнд суртлын тухай идэвхтэй шүүмжлэн ярьж эхэлсэн. Тоо төлөвлөгөөний хойноос хөөцөлдөх явдлыг чанарт шилжүүлэх оролдлого хийсэн боловч, энэ нь зах зээлийн эдийн засгийн суурьгүй байсан учраас, хоосон лоозон болон хувирсан. Нөгөө талаар хүнд суртлын мөн чанарыг тодорхойлж чадаагүй бөгөөд учир нь карьерын шалгуур нь нэг догматик үзэл суртал бүхий номенклатурт тулгуурлаж байсан учраас ажлын чадваргүй байдал, чирэгдүүлэлт зэрэг ноогдсон ажлаа хийж чадахгүй бүхий л байдлыг бюрократ дахь хүнд сурталтай хольж хутгасан. Тухайлбал, социалист системийн орнууд задран унасан явдал нь нийгэмчилсэн социалист өмч болон эдийн засаг дахь төвлөрсөн төлөвлөгөө, нийгмийн бүхий л амьдралд нам төрийн номенклатуризмын хяналттай бюрократ бүтэц бүхий төрийн зохицуулалт ноёрхож байсан зэрэг нь нийгмийн хөгжлийн замд тодорхой хугацааны дараа чөдөр болон зогсонги байдалд оруулснаар уг системийн уналтанд гол үүрэг гүйцэтгэсэн аж. Иймээс ч 1990-ээд оны үйл явдал буюу С.Хандингтоны

¹ Ë.Îæññæñêê. Æññóääðñòääííüå ñêóæåå. Ì., 1997.

нэрлэснээр “ардчиллын гурав дахь давалгааны үед ардчиллын төлөө гэхээс дутуугүй “хүнд суртлыг зайлуулъя”, “захиргаадалтын системийг устгая” гэсэн агуулга давамгайлж байв. Ийм учраас нийгмийн амьдрал, удирдлагын зорилго хоёрын зөрчил нь Монгол болон социалист системийн орнуудыг эдийн засгийн зогсонги байдалд оруулахад тодорхой хэмжээнд нөлөөлсөн төдийгүй, түүнээс гарах арга зам болох ЗХУ дахь “өөрчлөн байгуулалт”, түүний нөлөөлөл нь коммунист үзэл суртал, түүний төрийн удирдлагын чадваргүйг харуулсан тул, коммунист дэглэм унахаас өөр гарцгүй болсон ажээ.

XX зууны 80-аад жилийн туршид төр улсуудын нийгмийн харилцааг зохицуулах оролцооны түрэмгий бодлого нь эрх-үүргийн харилцааны хувьд ч тэр, бүх нийтийн хамаарлын утгаар ч тэр, нийгэмд эрхээ эргүүлэн өгөх уналтын цэгт хүрсэн ажээ. Төрийн бюрократ удирдлага эхлээд өрнөдөд улам өсч байгаа улс төрийн эсэргүүцэлтэй тулгарсан, дараа нь дорнод дахь коммунист эвсэлд түүний бүрэн сүйрэл нь дагалдсан ажээ. Аж үйлдвэржүүлэлтийн үе болон XX зууны сүүлчийн хагас хүртэл дээд цэгтээ хүртэл идэвхжсэн төрийн зохицуулалт, бюрократ функционализмын тэлэлт нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, нийгмийн хөгжилд хүнд суртлын саад тотгорыг учруулж, олон улсын харилцаанд глобальчлалыг хязгаарлаж байсан нь капиталист системийн эдийн засгийн хямралаар хурц тод илэрч төрийн засаглалын төвшинд бюрократ удирдлагын төвлөрлийг сааруулах шинэтгэлийг эхлүүлэх үндэс болсон. Мөн төрийн зохицуулалт нь олон улсын харилцааны төвшинд улс үндэстнүүдийн эрх ашиг, тусгаар тогтнол, хүний эрхийн асуудлыг удирдлага болгосон эрх тэгш харилцан ашигтай хамтын ажиллагааны эрин үе эхлэх үндэс болсон аж. Гэхдээ энэ нь шууд бий болоогүй бөгөөд хүйтэн дайны нөлөөгөөр хуваагдсан хоёр эвслийн улс орнуудын дотоодод эрх тэгш харилцан ашигтай хамтын ажиллагаа эвслийг бэхжүүлэх үүднээс зайлшгүй үүсэх үндэс болсон. Энэ үйл явц нь эвслүүдийн цэрэг зэвсгийн болон эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны (НАТО, Варшавын гэрээ, ЭЗХТХН, Европын холбоо гэх мэт) байгууллагуудыг бий болгосон төдийгүй, НҮБ, ЮНЕСКО, АПЕК, АСЕАН зэрэг дэлхийн болон бүс нутгийн, мөн нэг ашиг сонирхлын хамтын ажиллагааны байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх болон заримыг нь шинээр үүсгэсэн байна. Ийнхүү “газрын тосны” гэгдэх дэлхийн эдийн засгийн хямралын дараа аж үйлдвэржилтийн үеийн төр төвтэй нийгмүүд глобальчлал, ардчиллын давалгаанд өртөж, хүрээлэн байгаа эко систем, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн амьжиргааны төвшин, хүмүүнлэгийн зэрэг олон шинэ асуудлуудтай тулгарснаар нийгмийн шинж чанар өөрчлөгдөх эхлэл тавигдсан бөгөөд энэ нь төрд үйлчилдэг рациональ бюрократ загварыг нийгэм төвтэй төрд үйлчилдэг пост бюрократ загвараар солих шаардлагыг бий болгосон ажээ.

Олон улсын харилцааны төвшин өргөжихийн хэрээр төрийн аюулгүй байдал, батлан хамгаалах зардал буурч эхэлсэн бөгөөд улс орнуудын дотоод амьдралд нийгмийн амьжиргааны төвшин, хүний эрх, эрх чөлөө, байгаль орчин зэрэг олон асуудлууд дэвшигдэн гарч ирэх болжээ. Эдгээр нөхцлүүдийн улмаас төрийн өсөн нэмэгдэх хяналт нь өрнөдийн орнуудад шинэ үзэл баримтлалаар өсөж буй улс төрчид болон постбюрократ баримтлалтай тулгарсан ажээ. Постмодернизацийн үр дүн нь нийгмийн эдийн засгийн үр ашгийг бодвол, хувь хүний өөрийн илэрхийлэлд илүү өндөр урьтал өгдөг либераль үзэл, “либертари” нэрээр эргэн ирж буйтай холбоотой аж. Энэ нь уламжлалт бюрократ дахь хүнд суртал ба нийгмийн “харгис” хэм хэмжээтэй холбоотой нийтийн зардлыг хүмүүс хүлээн авах нь бага болж ирдэгээр илэрдэг. Р.Инглхард “Пост модерн: Өөрчлөгдөж буй нийгэм, Үнэт

зүйлсийн солигдолт” бүтээлдээ “Пост модернизаци нь нийгэм дэх шатлан захирах ёс журам, ба нийгмийн хэм хэмжээний уналт, хувь хүний сонголт болон бүх нийтийн оролцооны хүрээний өсөлтөөр тодорхойлогддог” гэж тэмдэглэжээ. Орчин үеийн төр, нийгмийн өмчид тулгуурласан аж ахуйн системүүд нь өөрийнхөө үр өгөөжийг алдаж эхэлсэн нь уламжлалт бюрократ ёс журамд нийгмийн итгэл буурах нэг үндэслэл болсон ажээ.

1980-аад оноос АНУ, Англи, Недерланд, Швед, Шинэ Зеланд, Австрали, Недерланд гэх зэрэг олон улс орнуудад төрийн зохицуулалт, засаглалын зардлыг бууруулах зорилгоор төрийн удирдлагын шинэчлэлийг хэрэгжүүлэх үйл явц эхэлсэн юм. Тухайлбал, Их Британий эдийн засгийн “Англи өвчин”-ны эсрэг ерөнхий сайд Маргарит Тэтчер хэдэн засгийн газар дамжуулан төрийн салбарын зарим үйл ажиллагааг хувийн секторт гэрээгээр болон хувьчлан шилжүүлэх “Алхам алхамаар”, “Дараачийн алхам”, “Сүүлчийн алхамууд” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр төсвийн зардлыг бууруулж, албан хаагчдын тоог цомхотгож, эдийн засгийн зогсонги байдлыг арилгаж чадсан юм. Их Британид 1979 онд нийт төрийн албаны ажилтны тоо 723.0 мянга байсан бол 1995 оны 1-р сарын байдлаар 550.0 мянга болсон нь 15 жилд 25% -иар буурсан¹ байна.

Засаглалын шинэтгэл нь Скандинавын орнуудад нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын эрх үүргийг нэмэгдүүлж, менежментийн үзэл санааг дэмжихэд чиглэсэн ажээ. Гэвч тэд шинэтгэлийг хэсэгчилсэн хэлбэрээр буюу туршилтын журмаар хэрэгжүүлж эхэлсэн. Зарим судлаачид засаглалын шинэтгэлийг бүх шатанд нэгэн зэрэг эхлүүлэх боломжгүй бөгөөд хэрэв чингэвэл нийгмийн сөрөг үр дагаварт хүрнэ гэж үздэг. Тэдний үзэж байгаагаар хууль эрх зүйн орчинг хэрхэн оновчтой тогтооход цаг хугацаа шаардагдах учраас хэсэгчилсэн туршилтын хэлбэрээр эхлүүлэх нь дээр гэж үзжээ. Хятадад Дэн Ся Пиний “социалист зах зээл” хэмээх прагматик шинэчлэл мөн л хэсэгчилсэн хэлбэрээр хийгдэж эхэлсэн бөгөөд Шинжин, Шанхай, Тяньжин гэх мэт нээлттэй бүс арав гаруй жил туршигдсаны эцэст 1992 оноос бүх Хятадад хэрэгжиж эхэлсэн байна.

XX зууны 50-иад оны үед колоничлолын дарлалаас дөнгөж чөлөөлөгдөж байсан орнуудын талаар баримтлах улс төрийн бодлогын онолын суурь үндэс хэлбэрээр анх үүсэж хөгжсөн модернизацийн үзэл баримтлал нь эцэстээ нийт хүн төрөлхтөний соёл иргэншлийн үйл явцын нийтлэг загварын үндэслэл хэлбэртэй болсон бөгөөд шинжлэх ухааны дэвшил, нийгмийн бүтцийн өөрчлөлт шинэчлэлт болон норматив ба үнэт зүйлсийн системд гарсан өөрчлөлтөөс болж, уламжлалт нийгмээс илүү үр ашигтай нийгмийн зохион байгуулалтад шилжих шилжилтийн үйл явцын шинж чанар нь гурван төрлийн шинэчлэлийг бий болгожээ. Үүнд:

- Удаан хугацааны турш явагдсан дотоодын үйл явцын үр дүнд, аажмаар нийгмийн өвөрмөц зүй зохистой зохион байгуулалтанд хүрсэн орнуудын хувьд нийтлэг юм. (Жишээ нь Англи, АНУ, Австрали, Япон, Баруун Европын орнууд) Р.Инглхарт “Тэргүүний үйлдвэржсэн нийгэмд хөгжлийн зонхилох чиглэл нь сүүлийн 25 жилд өөрчлөгдсөн ба өрнөж буй өөрчлөлт нь их суурьтай болохоор түүнийг “ шинэтгэл” биш “постмодернизац” гэж тодорхойлсон”² ажээ.
- Аль нэг шалтгаанаар хоцрогдолд ороод, тэргүүлэх улс гүрнүүд дэх амьдралын төвшин, чанарыг гүйцэхийн тулд тэдгээр орны туршлагыг өргөн ашиглаж хуулбарлан тусгасан улс төрийн шинэчлэл нь ардчилалд

¹ Ё.Іаегапеее. Апоааоноаагаа пёожаа. І., 1997.

² Ёаеоаа. Діаеіа, 1997, Постмодерн: меняющиеся ценности и изменяющиеся общества, Ііеёі, ' 4.

шилжсэн болон дахин сэргээсэн орнуудын хувьд нийтлэг юм. (Жишээ нь Пост коммунист болон Ази, Африк, Латин америкийн ардчилсан засаглалтай орнууд) Эдгээр орнуудад шинэтгэл нь юуны өмнө тухайн нийгмийн эдийн засгийн ба улс төрийн боломж нэмэгддэг процесс юм. (эдийн засгийн өсөлт нь үйлдвэржилтийн, улс төрийнх нь бюрократын нөлөөллөөр хангагддаг байна). Хантингтон, Нельсон нар “Амаргүй сонголт: хөгжиж байгаа орнуудын улс төрийн оролцоо” /1976/ гэдэг номондоо “дотоодын улс төрийн зорилтууд нь нийгэм, эдийн засгийн дэвшил, тогтвортой байдал, эрх тэгш байдал, олон нийтийн оролцоо гэх зэрэг хүчин зүйлүүдтэй зөрчилдөх бус, харин харилцан уялдаатай байж сая хөгжлийн процесс явагдана” гэж үзсэн төдийгүй хэр амжилт гаргах нь ноёрхогч элитийн шинж чанараас хамаарна гэсэн дүгнэлт хийсэн байна.

- Дэг журмыг сахиулсан хатуу дэглэм үндэсний эв нэгдлийг хангаж, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг амжилтанд хүргэж буй тохиолдлууд байгаа бөгөөд энэ нь эцэстээ ардчилалд шилжсэнээр эдийн засгийн хүчин чадлын хувьд эхний төрөлд ойртон, улс төрийн болон засаглалын шинэчлэлийг аажмаар хийх боломжтой болж байна. (Хятад, Сингапур мөн ардчилалд шилжсэн Өмнөд Солонгос, Тайвань, Чили, Бразил, Малайз, Нигери гэх мэт) Шинэтгэл нь нийгэмд ядуу байдлаас баян байдлын боломжийг олгодгоороо их хэмжээний нийтлэгийг агуулсан байдаг. Тэгэхээр шинэтгэлийн процессын гол цөм нь үйлдвэржүүлэлт байдаг. Эдийн засгийн өсөлт нь гол зорилго болдог бөгөөд энэ гол зорилго нь хувийн төвшинд хүрч болох амжилтын учралыг тодорхойлж эхэлдэг. Эдийн засгийн амжилтын өсөлт нь улс төрийн эрх чөлөөг хүсэмжилж эхэлдэг ажээ.

Р.Дарендорф “шилжилт гэдэг нь нэг системийг нөгөө системээр солино гэсэн үг биш бөгөөд тэгэж ч ойлгож болохгүй. Социализмаас капитализмд шилжих нь ямар ч утгагүй юм. Эрх чөлөөнд хүрэх зам нь хаалттай нийгмээс нээлттэй нийгэмд шилжих шилжилт бөгөөд нээлттэй нийгэм гэдэг нь систем биш, харин зөвхөн олон тооны механизмуудыг судлан үзэх механизм юм. Энд улс төрийн асуудал, эдийн засгийн бүтэц тодорхойлогдохгүй ” гэжээ. Аж үйлдвэржилтийн нийгмээс “үйлдвэржсэний дараах нийгэмд шилжих нь “нийгмийн бүх хүрээг оновчтой болгож буй бүхний мэдрэмж”-ээр тодорхойлогддог бөгөөд тэр нь эдийн засаг, улс төр, нийгмийн амьдралд уламжлалт болон ердийн шашны үнэт зүйлсээс зүй зохистой, хууль ёсны үнэт зүйлсийн өөрчлөлтөд хүргэдэг”¹. Пост коммунист орнуудад өрнөж буй өөрчлөлт, шинэчлэл нь шинэчлэлийн хямралын синдромыг нөхцөлдүүлж байгаа улс төр, эдийн засаг, нийгмийн болон уламжлалт үнэт зүйлсийн объектив хүчин зүйлсийг даван туулах арга хэрэгслийн асуудал хурцаар тавигдаж байна. Эдгээр орнуудад үндэсний уламжлалт улс төрийн соёлын үнэт зүйлс, улс төрийн амьдралын хэм хэмжээ нь улс төрийн шинэчлэгдсэн зохион байгуулалттай зөрчилдсөөр байна. Үүнд төрийн бюрократ удирдлагын уламжлалт бүтэц, зохион байгуулалт, арга механизмд шинэтгэл хийх шаардлага зайлшгүй тулгарч байгаа билээ.

Засаглалын шинэтгэл өдгөө ардчилсан болон ардчилалд шилжсэн дэлхийн олон улс орнуудыг хамарч байгаа билээ. Гэвч сүүлийн жилүүдэд засаглалын шинэтгэлийг хэрэгжүүлж буй улс орнуудын төрийн удирдлагад гарсан өөрчлөлтүүдийн ерөнхий чиглэл нь тухайн хүрээнд уламжлал болж ирсэн хэд хэдэн сургаалиудаас татгалзах болсон нь төрийн зохион байгуулалт

¹ Ёйёёёёё. Ёйёёёёё, 1997, Постмодерн: меняющиеся ценности и изменяющиеся общества, Ёёёё, 14.

ба үйл ажиллагаанд зах зээлийн механизм, институтууд ба номлолуудыг нэвтрүүлсэн зэрэг явдалтай холбоотой байв. Нийгмийн үйл ажиллагааны удирдлагын механизмуудын доголдол, татварыг үр ашиггүй ашиглах, үйлчилгээний чанар буурах, бюрократизм өсөх болон авилгал, хээл хахууль, төрийн алба ба засаглалын байгууллагуудад итгэх итгэл алдрах гэх мэтээр илэрхийлэгдэж байдаг, нийгмийн засаглалын хямрал нь төрийн удирдлагын үзэл баримтлалыг дахин авч үзэхэд хүргэсэн байна.

Төр, засаглалын шинэчлэлийг хэрэгжүүлэгч орнуудад захиргаадагч-төрийн оронд эдийн засгийн үр ашигтай менежерийн-төр гарч ирсэн байна. Төрийн салбар дахь санхүүгийн менежментэд хандах хандлага эрс өсч ирсэн бөгөөд нийгмийн мөнгөний үнэ цэнэ ч өссөн аж. Урьд өмнө ямарч бюрократ байгууллага нь улсын төсвөөс аль болох их хэмжээний мөнгө хөрөнгийг авахыг хүсдэг байсан бол, одоо тэдгээр нь өөрийн үйл ажиллагааныхаа үр дүнг өсгөх ба эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхийг илүүтэй сонирхох болсон ажээ. Төрийн алба хаагчдын хөдөлмөрийн хөлсийг тооцох шинэ зарчим бий болов. Ингэж хөдөлмөрийн үр дүнгээр нь тооцох болсон нь төрийн албан хаагч, иргэн хоёрын хоорондын харилцааны системд өөрчлөлт гаргасан байна. Ард иргэдэд үйлчлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах явдал нь засаг захиргааны үйл ажиллагааны үндсэн зорилго болж хувирч байна. Эдийн засгийн хандлага нь хувийн сектортой харьцуулсан төрийн эдийн-засгийн төвшингийн тухай асуудлыг дэвшүүлэн тавьсан бөгөөд төрийн зүгээс эдийн засгийг зохицуулах түрэмгий бодлогыг хязгаарлах шаардлага нэмэгдсэн байна. Мөн төрийн үйлчилгээнд хэрэглэгч (үйлчлүүлэгчийн) -ийн сонирхлыг нэгдүгээрт тавих асуудалд гол ач холбогдол өгөх болсон аж.

Улсын байгууллагуудын монопольт эрхтэй байх зарчим ба нилээд хэд хэдэн төрлийн үйлчилгээ, функцүүдэд шүүмжлэлтэй хандаж ирсэн нь хувийн ба төрийн салбарын эрх, үүргийг, мөн түүнчлэн төрийн байгууллагуудын бүтцийг дахин хянаж үзэхэд хүргэсэн байна. Засаг захиргааны шинэчлэлтээр зах зээлийн өрсөлдөөн, гэрээ, хэлцлийн систем, тендер, маркетинг, зар сурталчилгаа зэрэг болон бусад иймэрхүү зах зээлийн элементүүдийг төрийн удирдлагад нэвтрүүлэх явдал дагалдан явагдаж байв. Менежментийн үзэл санааг төрийн удирдлагад нэвтрүүлэх явдлын үндсэн зорилтуудын нэг бол түүнд шингэсэн байдаг бюрократ иерархийн хүнд сурталт байдлыг даван туулахад оршиж байсан юм. Иймд удирдлагын үйл явцад хийгдэх шинэчлэлт нь бүтцийн болон функцийн төвлөрлийг сааруулахад оршиж, мөн олон шинэ эрх чөлөөтэй агентуудыг бий болгоход чиглэгдэх ёстой болсон аж. Үүнтэй уялдан засаглалын янз бүрийн төвшингүүдийн харьцаа өөрчлөгдсөнөөр орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай хамтран ажиллах зарчмыг хөгжүүлэхэд илүүтэй анхаарах болсон байна. Шинэчлэлт хийх үйл явцад байгууллагын ба албан хаагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлэхэд багагүй ач холбогдол өгөх болсон байна. Үүний зэрэгцээ төр нь түшмэдэд илүү их эрх чөлөө олгож өгсөн аж. Төр ба иргэний нийгмийн хооронд шинэ харилцаа бүрэлдэхийг урьдчилан төсөөлж байв. Нийгэмтэй харилцах харилцаа нь шинэчлэгдсэн утгаараа төрийн зүгээс үзүүлэх байнгын халамж болон хувирсан аж. Үүний зэрэгцээ засаг захиргааны үйл ажиллагаанд тавих иргэний хяналт нь төрийн зүгээс үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулж, ард иргэдийн засгийн газарт итгэх итгэлийг нь өсгөж байлаа. Засаг захиргааны шинэчлэлт нь удирдлагын шийдвэр гаргах ба тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэх шинэ механизмыг бий болгоход чиглэгдэж байсан юм. Энэ нь төрийн бюрократ удирдлага дахь бүтэц ба функцийн хөдөлгөөнтэй байдлыг ихэсгэх, тэдгээрийг байнга өөрчлөгдөж байх нөхцөлд дасгаж хэвшүүлэх, мөн үйл ажиллагааг нь хөгжүүлэх болон соёлын

шинэчлэлтийг үүсгэсэнээр, хөгжлийн стратеги ба улс төр лүү чиглэх чиглэлийг нь бий болгоно гэсэн үг юм. Бүхэлдээ бол удирдлагын үйл ажиллагааны шинж чанар ба арга барил өөрчлөгдөж байна гэсэн үг юм.

Гэвч өрнөдийн улс төрийн шинжлэх ухаанд төрийн менежментийн онолыг явцуу либераль чиглэлтэй гэж шүүмжилдэг нөлөөлөхүйц урсгал байдаг. Нэг хэсэг судлаачид менежментийн онолын хэрэглэх хүрээ хязгаарлагдмал байдаг гэж үздэг байна. Тухайлбал, Л.Терригийн үзэл бодлоор “төрийн менежментийн уламжлалт чиглэл (эсрэг чиглэл) ба тэдгээрийн өөрсдийн нь ханамжтай байдал, дүрэм журмаас татгалзах, хатуу засаглалын бодлого, хэт радикал шинэчлэлтүүд нь ардчилалын зарчмуудтай зөрчилдөж эхлэхэд хүргэдэг байна”¹. Мөн түүнчлэн “зах зээл, монополи ба худалдан авагч гэсэн иймэрхүү эдийн засгийн метаформоор нийгмийн амьдралын утга учрыг хэмжих оюун санааны хэмжүүрүүд дутагдаж байдаг”² гэж Р.Гриин, Л.Хаббел нар тэмдэглэсэн байдаг. Төрийн шинэ менежменттэй тэмцэгчдийн батлан гаргасан “Блэксбургскийн тунхаглалд” (1984) төрийн удирдлага нь нийгмийн оршин тогтнол, бүх нийтийн сэтгэлгээний философид чухал ач холбогдолтой гэдэгт тулгуурласан байдаг. Г.Уомслей ба Дж.Вольф нарын бичсэнээр: “Блэксбургскийн хөдөлгөөний гол шинж нь нормативт стандартуудыг хамгаалах явдал юм”³ гэсэн байдаг. Үүнд “төрийн удирдлагыг бүх нийтийн хамтын ажиллагааны үйл явц ба түүний легитим гэж ойлгодог байна. Тунхаг бичигт өөрийнхөө нэр хүндийг унагаасан төрийн удирдлагын үүрэг ролийн агуулагыг нийгэм хянан үзэж дахин ухамсарлах процесс явагддаг... ба төрийн удирдлагаар урамшуулагдаж байдаг иргэний байгууллагуудын практик ач холбогдлын чухлыг тэмдэглэсэн байдаг. Олон түмний хөдөлгөөн ба нийгмийн сонирхол нь нийгмийн баялаг, төрийн албаны мэргэжлийн байдалд хяналт тавьж, тэдгээрийг ардчилалын үнэт зүйлсийн дунд эзлэх хууль ёсны байр суурийг нь эргүүлэн олгож байдаг”⁴ гэжээ.

Харин Оросын судлаач Л.Сморгунов “улс төрийн сүлжээний концепцийг баримтлагчид төрийн шинэ менежментийн онолд шүүмжлэлтэйгээр ханддаг”⁵ гэж үзжээ. Тэрээр “Улс төр, засаг захиргааны шинэчлэлтийн харьцуулсан судалгаа: төрийн шинэ менежментээс “governance” концепц руу” гэдэг бүтээлдээ “Төрийн менежментийн онолд суурилсан удирдлагын системийн шинэчлэлтийг хөгжилтэй орнуудад хэрэгжиж байсан цар хүрээ, идэвхжилтээрээ ялгагдах онцлогтой байсан ч гэсэн, “шинэ менежеризм” нь удаан хугацаанд давамгайлах хандлагатай байсан ч гэсэн түүний үзэл баримтлал, практик үйл ажиллагааг түүний шийдвэрлэх гэж оролдож байсан бодит асуудлууд дээр нь үндэслэн дүгнэх ёстой. Төрийн шинэ менежмент бол юуны өмнө аврага том төвлөрсөн бюрократ аппарат болон уламжлалт төрийн иерархийг устгахыг зорьж байсан. Тэр нь ямар ч альтернативыг санал болгож байсан ч (технологийн шинжтэй байсан ч гэсэн) гэсэн монополийг хүсэх ёсгүй” гэжээ. Х.Ван Мирло “төрийн менежмент гэсэн уриан доор хийгдсэн

¹ Terry L. 1998. *Administrative Leadership, Neo-Managerialism, and the Public Management Movement*. — *Public Administration Review*, vol. 58. № 3. p 197.

² Green R., Hubbel L. 1996. *On Governance and Reinventing Government*. — Wamsley G., Wolf J. (eds.). *Refounding Democratic Public Administration. Modern Paradoxes, Postmodern Challenge*. Thousand Oaks, L, New Delhi. p 61.

³ Wamsley G., Wolf J. (eds.). 1996. *Refounding Democratic Public Administration. Modern Paradoxes, Postmodern Challenges*. Thousand Oaks, L, New Delhi. p 10.

⁴ Wamsley G., Wolf J. (eds.). 1996. *Refounding Democratic Public Administration. Modern Paradoxes, Postmodern Challenges*. Thousand Oaks, L, New Delhi. p 11.

⁵ Сморгунов Л.В. 2000. *Управление в условиях неопределенности: В поисках моделей устойчивого развития. Сравнительное государственное управление: теория, реформы, эффективность*. СПб № 13-15.

шинэчлэлтийн туршлага нь амжилт ба уналт хоёроор тодорхойлогддогийг зөвшөөрөх нь зүйн хэрэг юм. Шинэчлэлтийг үүсгэгчдийн хүсэж байсан олон зүйл биелэгдээгүй байдаг. Иймд барууны орнуудад ямарч амжилтанд хүргээгүй зарим арга хэмжээнүүд нь төв Европод ашиггүй зүйл байх юм. Гэвч хуучин төрийн системийн удирдлагын шилжилтийн амжилтууд ба дутагдлууд нь судалгааны үнэтэй материал болж болох юм”¹ гэж үзсэн байна.

Гэвч төрийн удирдлагын салбар дахь хувьчлал болон зах зээлийн хандлага нь эдийн засагт мэдрэмжтэй өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, үргүй зардлыг бууруулах боломжтой болгосон. Харин төрийн шинэ менежмент нь төрийн үйл ажиллагаа, нийгмийн эрэлт хэрэгцээ ба үнэт зүйлд тохирч буй эсэхэд тавих хяналтын асуудлуудыг шийдвэрлээгүй нь төрийн удирдлагад зах зээлийн ба ардчилалын механизмуудыг хослуулж хэрэглэх үзэл санааг илүү хүчтэй дэмжих үндэслэл болсон байна. Ийм учраас засаг захиргааны болон улс төрийн харилцааны асуудалд, төрийн удирдлагад тавигдах хяналт, төрийн үүрэг хариуцлага, ард иргэддээ тайлагнах, улс төр дахь олон түмний оролцооны асуудлууд хүчтэй тавигдаж эхэлсэн аж. Энэ талаар М.Мур “Бүх нийтийн тансаг чинээлэг амьдралын төлөөх нийгмийн хямрал (тухайлбал, засаг захиргааны шинэчлэлтийг урамшуулж байсан) нь төрийн шинэ менежментээр мөн л шийдвэрлэгдээгүй бөгөөд эдгээр асуудлуудыг нийгмийн зүгээс дахин дэвшүүлэн тавихад хүргэсэн. Зөвхөн эдийн засгийн үр ашигтай байдал шаардлагатай байгаад зогсохгүй, бас үнэн зөв бодитой байдал шаардлагатай. Менежериализм нь төрийн албаны нээлттэй ба жинхэнэ мэргэжлийн төвшинд хүрсэн байдалд хүрч чадаагүй. Үүгээр ч үл барам төрийн ажилтны тогтворгүй байдлыг дэвэргэж, тэднийг шинэ системийн үед дарга нараасаа илүү их хамааралтай байх байдалд хүргэсэн”² гэж шүүмжилсэн байна.

Төрийн менежментийн шинэчлэлтийн харьцуулсан судалгаа нь судлаачдыг өмнөх парадигмд шүүмжлэлтэй хандаж, шинийг боловсруулахад хүргэсэн ажээ. Орчин үеийн “мэдээллийн нийгэм нь уламжлалт бюрократыг болон төрийн менежментийн зарим чиг хандлагуудыг шүүмжилсэнээр, удирдлагын өөр шинэ хэлбэр зарчмыг бүтээж, энэ нь “good governans” буюу зохистой засаглал гэдэг ойлголтоор тэмдэглэгдэх болсон байна. НҮБ-ын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Хорооны баримт бичигт: “Зохистой засаглал буюу “governance” гэдэг нь засгийн эрх, нэр хүндийг хангасан хуваарилалтын асуудал мөн бөгөөд тэдгээр нь үндсэн хуулийн үнэт зүйлсийг хамгаалах үүрэгтэй”³ гэж тайлбарладаг аж.

Зохистой буюу сайн засаглалын үндсэн ойлголт нь:

- Оролцоо. (Иргэд шийдвэр гаргахад санал өгөх эрхтэй төдийгүй шууд оролцох буюу тэдгээрийн ашиг сонирхлыг төлөөлж байдаг легитим институтээр дамжуулан оролцох. Мөн ийм өргөн оролцоо нь ассоциац ба үгийн эрх чөлөөт байдал болон форум явуулах чадварт үндэслэж байдаг байна.)
- Эрхийг дээдлэх. (Энэ нь эрхийн бүтцүүд бөгөөд өөрөөр хэлбэл, жишээ нь хүний эрхийг хамгаалах байгууллагуудын үнэнч, шударга байдал юм.)

¹ Mierlo H. van. 1998. *Lessons from the Experience of OECD Countries.* — Verheijen T., Coombes D. (eds.). *Innovations in Public Management Perspective from East and West Europe.* Cheltenham, Northampton (MA). p 394-395.

² Maor M. 1999. *The Paradox of Managerialism.* — *Public Administration Review*, vol. 59, No 1.

³ UNDP. 2002. *Good Governance and Sustainable Human Development.* — *Governance for Sustainable Human Development. A UNDP Policy Document* (<http://magnetundp.org>).

- Тунгалаг байх зарчим. (Мэдээллийн эрх чөлөө, түүний бүрэн дүүрэн бүх нийтэд нээлттэй байх.)
- Мэдрэмжтэй байх. (Бүх институцүүд хүний хэрэгцээний төлөө тодорхой үйлчилдэг байх.)
- Шийдвэр нь зөвшилцөлд хүрэхэд чиглэсэн байх. (Зөвлөлдөж буй талуудын сонирхлыг харгалзсан байдал)
- Шудрага байх. (Бүх гишүүд өөрсдийн сайн сайхан байдлаа дээшлүүлэх эрхээр адилхан хангагдсан байх.)
- Үр дүнтэй байх. (Төрийн үйл ажиллагаа түргэн шуурхай, иргэдийн эрэлт хэрэгцээг хангахад нөөцийг дээд зэргийн үр ашигтайгаар ашиглах.)
- Тайлагнах. (Засгийн газар нь хувийн бизнес, иргэний нийгмийн бүтцүүдэд тайлагнах.)
- Стратегийн тодорхой байдал. (Лидерүүд болон төрийн удирдлага нь удаан хугацааны хэтийн төлөвийг хэрэгжүүлж байх.)¹ зэрэг ажээ.

Дээрх “governans”-ын шинжүүд дэх нийгэм, улс төрийн удирдлага нь нийгмийн харилцааны ардчиллын онолтой холбогдох бөгөөд удирдагчид сүлжээний онолын ихэнх хэсгүүдтэй холбогдож, хэсэгчилсэн хэрэгслүүдэд системтэй хандах нөхцөл бүрддэг байна. Гэхдээ энэ нь төрийн үүргийг бууруулахгүй бөгөөд төр нь шийдвэр гаргах гол субъект гэдгийг байнга сануулж байдаг онцлогтой аж. Хэдийгээр асар том, нарийн бүтэцтэй боловч засгийн газар нь нэгдмэл байгуулал хэвээр үлдэж, төр нь үндсэн хуультай зохицон засаг захиргааны эрхийн хэрэгжилтэнд үйлчилнэ. Л.Сморгунов “Орчин үеийн засаг захиргааны шинэчлэлт нь шинэ төрлийн инструментализмын менежментээс бүтээн байгуулахад чиглэсэн буюу засаг захиргааны сэтгэл зүйн ба улс төрийн асуудлуудыг бүрэн тооцоход чиглэсэн системийн хандлагад шилжихэд л эдгээртэй холбогддог. Эдгээр хандлагуудын ялгааг дараах эсрэг тэсрэг тезисуудаас харж болно. Ямар ч удирдлагад хандах хандлага нь эргэлзээгүй өөрийн шинэлэг талаараа хэсэгчилсэн инструментальтай холбоотой ба өөртөө сүлжээний онол, синергетик, нийгэм-төрийн удирдлага, коммунитар төрлийн ардчилалын онолын хэд хэдэн концептуаль эерэг үндэслэлийг агуулж байдаг. Төр нь шийдвэр гаргах гол агентуудын нэг болох бөгөөд төрийн үүрэг ролийг багасгадаггүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм.”² гэж тодорхойлсон байна.

НҮБ-ын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Хорооны илтгэлд...” хэдийгээр засгийн газар нь хэт овортой ба нарийн бүтэцтэй ч засгийн газар нь нэгдмэл байгууллага байсаар байдаг бөгөөд засаг захиргааны эрх зүйн орчинд үндсэн хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байдаг. Харин удирдлагын үр дүн нь улс төрийн бодлогыг боловсруулах, төсвийн үйл ажиллагаа, иргэний байгуулалгуудыг удирдах ба тохирсон улс төр засаг захиргааны соёлын хүрээнд бүх шатандаа тайлагнах ажил хэрхэн жигдэрсэн байдлаас шалтгаалж байна” гэжээ. Төрийн энэ үүргийг онцлох явдал нь “governance” концепцийг хэрэгжүүлэхэд нийгмийн ухамсраар удирдахыг багасгахад хүргэдэг байна. Ж.Пьер, Г.Петерс нар “Хэрвээ улс төрийн сүлжээний онолд нэн тэргүүнд төр засагт хандах сүлжээний автономын асуудлыг тавьдаг бол одоо нөхцөл байдал өөрчлөгдсөн. “Governance”-ыг ихэд сонирхох болсон явдлыг төрийн уналтын үзэлтэй

¹ UNDP. 2002. Good Governance and Sustainable Human Development. — Governance for Sustainable Human Development. A UNDP Policy Document (<http://magnet.undp.org>).

² Нийслэл, 2003. Нийслэлийн агаарын бохирдлын төлөв: 10 жилийн ажлын үнэмлэхүй үнэ “Governans”

холбож болохгүй”¹ гэж үзсэн байдаг. “Governanse”-ын үзэл баримтлалыг судалсан К.Книлла, Д.Лемкуля нарын бүтээлд “зохистой засаглал нь нэн тэргүүнд удирдагдах байдлыг ихэсгэх төрийн шинэ стратегийг хөгжүүлэх чадварыг нь илтгэж байгаа юм”² гэдэг үзэл санааг шингээсэн байна. Энэ бүтээлд шинэ удирдлагын концепцид төр нь өөрөө ч, төрөөс ангид иргэний нийгэм ч тэр, аль аль нь нийгмийн асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааны механизмуудыг бий болгох чадваргүй байдаг гэж тэмдэглэсэн байдаг. Төр нь ч, иргэний нийгэм нь ч тэр нийлээд нэг нэг рүүгээ уусч нэвтрэх шинжтэй байдаг тул хаана дуусч, хаана эхлэж байгааг нь ялгаж хэлэхэд хэцүү. Засгийн газрын ба засгийн газрын бус байгууллагуудын хоорондох үүргийн хуваарилалт тухайн тохиолдол болгонд хэлэлцээрээс эхлэж байдаг гэж үзжээ.

Үүнээс үзэхэд “governance” концепцийн ерөнхий утга санаа бол “төр урьдын хатуу, нарийн, дүрэм журмаар зохицуулагдаж байдаг байдлаа алдаж байгаад оршиж байна. Энэ нь юуны өмнө засгийн газрын байгууллагууд ба иргэний нийгмийн нэгдэл холбоо болон бизнесийн хооронд босоо гэхээсээ илүү хэвтээ харилцаанд суурилсан байх нь давамгайлах аж. Иймэрхүү төрийн удирдлага нь улс төрийн удирдлага, улс төрийн шийдвэрийн эх үүсвэр болж байдаг ердийн засаглал-аас ч тэр, мөн гишүүн бүр өөрийн үр ашгаа өндөр байлгахыг хүсэж байдаг зах зээлийн загвар буюу төрийн шинэ менежментээс ч ялгаатай юм. Ийм засаглал нь хамтын хүчээр харилцан зөвшөөрөлцөж үр дүнд хүрэхийн тулд төрийн ба төрийн бус бүтцийн хоорондын хэлцлийн замаар хэрэгжиж байдгаараа төр нь нийгмийн хэрэгцээг илүү үр ашигтай хангах чадвартай байдаг ажээ. Өөрөөр хэлбэл ийм зохистой засаглалын хэлбэр нь нийгмийн ач холбогдолтой шийдвэрүүдийг гаргах чадвар өндөртэй байдаг байна. Төрийн удирдлага дахь хэвшмэл практикийн эсрэг шинэ концепцийн гол үзүүлэлтүүд нь харилцан тохиролцоонд хүрэх ба гэрээ хэлцэл болж өгдөг. Ч.Броудэг “Уламжлалт засаглал нь ихэнхдээ эрх зүйн ба дүрэм журамд анхаарлаа төвлөрүүлж байсан бол, орчин үеийнх нь хэм хэмжээ, хамтын рекомендаци, үзэл суртлын зөвшилцөлд гол анхаарлаа төвлөрүүлж байдаг байна. Уламжлалт засаглал нь засгийн газар, бюрократ ба парламентаар хэрэгжиж байсан бол шинэ засаглал нь өөрийн хүрээндээ комисс, форум, ардчилалын зарчмаар зохион байгуулагдсан том байгууллагуудаар дамжин хэрэгжиж байдаг. Хэрвээ урьд нь удирдлагын хүрээн дахь мэдээлэл нь төвлөрсөн ба далд байсан бол одоо тэр нь ил тод, бүх нийтэд хүртээлтэй болсон байна”³ гэж үзсэн байна.

Л.Сморгунов “хамтын ажиллагааны асуудал бол сүлжээт нийгмийн удирдлагын онол дахь шинэ сэдвүүдийн нэг юм гэж тэмдэглээд, энэ нь үндсэн гурван онол дээр суурилж байдаг гэж үзсэн байна. Үүнд:

- сүлжээнд оролцож буй бүх акторууд нь ерөнхий бодлоготой ба хувийн ашиг сонирхлыг баримталдаггүй байна.

- акторуудын хооронд урьдчилан ач холбогдол нь мэдэгддэггүй боловч солилцооны процессын үед тодорхойлогдож байдаг нөөцүүдийн солилцоо явагдаж байдаг. Үүнтэй уялдан сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нь шийдвэр гаргахад чухал нөхцөл болж өгдөг.

¹ Pierre J., Peters G. 2000. *Governance, Politics, and the State*. N.Y. p 136.

² Knill Ch., Lehmkuhl D. 2002. *Private Actors and the State: Internationalization and Changing Patterns of Governance*. - *Governance: An International Journal of Policy, Administration, and Institutions*, vol. 15, № 1.

³ Brodhag Ch. 2000. *Information, governance et developement durable* — *International Political Science Review*, vol. 21, № 3. p 320.

- хамтын ажиллагаа гэдэг нь өөрсдийн нөөцийг агуулсан янз бүрийн секторуудын хоорондын харилцан үйлдлийг илэрхийлж байдаг нарийн үйл явц юм”¹ гэжээ.

Тэрээр хамтын ажиллагаа гэдэг нь бүх нийтийн ба хувийн хүрээ хоёрын хоорондын харилцааны онцгой нэгэн хэлбэр юм. Гэрээ хэлцлийн зорилго ба объектуудыг, мөн хоршооллын хэлбэр болон бусад зүйлийг тогтоон өгч байдаг захиргаа бол, гол актор болж байдаг гэж үзсэн. Үүнийг гэрээ хэлцлийн загвартай харьцуулахад, түүнээс эсрэг бөгөөд нэгдсэн нэг эрсдэлтэй ба үр дүнгийн нэгдсэн хариуцлагатай, хамтын ажиллагааны нэгдсэн нэг талбарыг бий болгохыг хэлж байгаа ажээ. Э.Вигодагийн тэмдэглэж байгаагаар “иргэд ба тэдгээрийн нэгдлүүд нийгмийн дараах хэд хэдэн зорилтуудыг шийдвэрлэх онцгой эрхийг авсан тохиолдолд л хамтын ажиллагаа боломжтой болдог. Үүнд: онцгой эрхийг эдэлж эхлэснээр төрийн оролцоогүй иргэдийн чөлөөт аутент эрх чөлөөг урамшуулдаг юм. Засгийн газар нь хувь хүн, бүлэг буюу зохион байгуулалтын институтын идэвхитэй байдлыг хүчтэй байлгах болон гадаад нөхцлийг нь бүрдүүлэх ёстой бөгөөд татан оролцуулах ба хамтран ажиллах программуудыг иргэд удирдах ёстой”² ажээ .

“Governance” гэдэг ойлголт нь иргэний нийгэм ба бүх нийтийн засаглалын хоорондын харилцаан дахь өөрчлөлтүүд болон мөн төрийн дотоод зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтүүдийг илтгэж байдаг байна. Бүх нийтийн шинэ удирдлагын байгууллагуудын хоорондын сүлжээнүүд /хамтарсан байгууллагууд, стратегийн альянсууд, ажлын хэсгүүд, тусгай эрхтэй байгууллагууд, судалгаа шинжилгээний консорциумууд, гэрээний, яам тусгай газар хоорондын ба салбар хоорондын нэгдлүүд гэх мэт/ нь байгууллагын дотоод бюрократ иерархийн сүлжээнүүдээс ялгаатай байдаг. Байгууллага хоорондын сүлжээнд зөрчил гарч байдаг ч гэсэн түүнд харилцан итгэлцэл ба хоршин хамтрах төвшин өндөр байдаг төдийгүй, энэ нь дамжуулах зардлыг нилээд багасгаж, хамтын нөөцийг үр ашигтай ашиглах, шинэчлэлтийг нээлттэй болгон, өөрөөр хэлбэл удирдлагын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд хүргэдэг. Интернет ба мэдээллийн шинэ технологи үүнд түлхэц болж байдаг байна. Гэхдээ Ж.Фонтены тайлбарлаж байгаагаар “бүтэц, системүүд ба менежмент дэх түргэн шуурхай өөрчлөлтийг хийх мэдээлэл технологийн боломжууд бүрэн ашиглагдахгүй буюу цаашид ч ашиглагдахгүйгээр үлдэж болох юм. Судлаачдын тэмдэглэж байгаагаар шинэ мэдээллийн технологи нь үр ашгийг нэмэгдүүлж байсан ч гэсэн шинэчлэлтийн үйл явц заавал эсэргүүцэлтэй тулгарч байдаг”³ гэжээ.

Зохистой засаглал концепци нь бүрэн боловсруулагдсан зүйл гэж ярих асуудал одоохондоо цаг бусын зүйл бөгөөд түүнийг засаг захиргааны болон улс төрийн шинэчлэлтийг хийх явцад ашиглах л үлдэж байна. Энд онол ба практик хамтдаа хөгжиж боловсрох аж. Гэвч зөвхөн орчин үеийн засаг захиргааны шинэчлэлт нь төрийн шинэ менежментээр хязгаарлагддаггүй гэдэг асуудал ойлгомжтой бөгөөд хүрээнээс хальсан асуудал юм. 1990-ээд оны эцсээр шийдвэр гаргах ба тэдгээрийг нэвтрүүлэх асуудал нь тухайн процесс дахь төрийн бус бүтцүүдээс хамааралтай гэдгийг засаглалын институтууд хүлээн зөвшөөрөх болсон. Эдийн засгийн үр ашгийг үр дүнгээр нь үнэлэх /үйлчилгээний үр ашиг ба нөөцийн хэмнэлт/ -ээс үйл явцын үнэлгээ рүү

1 Ntindaofoa, E.A. 2003. Ndaaleoalefuue afaeef neeoeef-aaleleñodoalefuō oāofoi: lo naiaī aīmoaaoñoaāmaī iāiaiaiaōa ē eufāfuē “Governans”

² Vigoda E. 2002. From Responsiveness to Collaboration: Governance, Citizens, and the Next Generation of Public Administration. -Public Administration Review, vol. 62, № 5.

³ Fountain J. 2001. *Building the Virtual State. Information Technology and Institutional Change*. Washington.

/засгийн газрын бодлогыг хэн, хэрхэн яаж боловсруулах/ хандсан хандлага руу өөрчлөлт хийгдэж эхэлсэн байна. Бүх нийтийн удирдлагын онол ба практикт хамгийн түрүүнд улс төрийн асуудлууд тавигдах болсон байна. Төрийн менежмент хадгалагдаж үлдсэн ч гэсэн тэр нь бүрэн хүрэлцээтэй зүйл биш юм. Л.Вайсын тэмдэглэсэнээр төрийн шинэ менежментийн салбар дахь мэргэжилтнүүд “төрийн шинэ менежмент” гэсэн нэр томъёо нь тийм ч их шинэлэг, тодорхой ба ашигтай зохион бүтээгч биш учраас энэ нэр томъёоноос татгалзах нь зүйтэй гэсэн шийдвэрийг 2002 онд хамтран гаргасан байна. Бүх нийтийн засаг захиргааны нормативт эх үүсвэрүүдэд гол анхаарлаа төвлөрүүлэх нь зүйтэй гэсэн уриалга нь эрдэм шинжилгээний бүтээлүүд болон мэргэжлийн нэгдлүүдээс сонсогдох болсон аж. Энэ нь засаг захиргааны шинэчлэлтийн тухай шинэ мэтгэлцээн, маргаан эхлэхийн илрэл юм. 1990 оны сүүлчээр Норвеги ба Шведэд төрийн удирдлагад ардчилалын үйл явц идэвхжиж шийдвэр гаргахад нийгмийн байгууллагуудын нөлөөлөл мэдэгдэхүйцээр өсөж эхэлсэн байна. Эдгээр орны засгийн газрууд “governance” концепцийн элементүүдийг тусгасан хэд хэдэн программыг боловсруулсан ажээ.

Тухайбал, Норвегийн засгийн газрын түшмэлүүд үүсэж буй асуудлаар форум явуулах, мэтгэлцээн маргаанд иргэдийг татан оролцуулах, нийгмийн амьдралын үнэт асуудал ба ёс зүйн хөгжлийн асуудлуудыг урамшуулж байх үүрэг хүлээсэн байна. “Удирдлагын шинэчлэлтийн төлөө үндэсний түншлэл гэсэн АНУ-ын программ нь ард түмний шинэчлэлийн процесст итгэх итгэлийг дээшлүүлэхэд чиглэсэн бөгөөд ард түмэнд үзүүлж буй үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд мэргэжлийн агентлаг ба электрон засаглалыг ашиглахыг илэрхийлж байгаа зүйл юм. Мичиганы Их Сургуулийн тоо баримтаас үзэхэд “Холбооны засгийн газарт итгэх итгэл нь 1994 онд 21 хувь байсан бол 2000 онд 44 хувь болтол өссөн” байна.

XXI зууны удирдлагад шинэ нөхцөл байдлыг бий болгох гэсэн санаачлага нь тэдгээрийн мэргэжлийн төвшинг мэдлэг чадал ба нийгмийн үзэл санааны илэрхийлэгч байх чадвараар нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Зарим орнуудад (АНУ, Норвеги, Швед, Их Британи гэх мэт) энэ чиглэлээр шинэ алхамууд хийгдсэн байдаг. Тухайн комиссын илтгэлд “Бид бүх нийтийн салбарт лидер-тэргүүлэгч хэрэгтэй гэж ярихдаа бид нийгмийн үзэл санаанд нийцэх институт шийдвэрүүдийг дэвшүүлж чадах хүмүүсийг хайж эхэлдэг. Тэргүүлэгч гэдэг нь энэ утгаараа дундыг баримтлагч биш юм. Энэ нь тодорхой суурь үнэт зүйлсэд, үндэсний оюун санаан дахь төрийн хэрэгцээг илэрхийлж байдаг зүйл юм “гэжээ.

Төрийн шинэ менежментийн онолоос “governance” концепцид шилжих нь компаративист эрдэмтэдийн хүч чармайлт ба засаг захиргааны удирдлагын практикаас урган гарсан зүйл юм. Одоогоор “governance” гэсэн ойлголтын хэд хэдэн тайлбар байдаг. Үүний үндсэн дээр нилээд суурь болох зүйл үүсэх эсэхийг цаг хугацаа, шинжилгээ судалгаа ба практикт харуулах болно. Гэвч өнөөдөр шинэ концепцид хандсан орнуудын туршлагыг тооцож үзэхгүйгээр засаг захиргаа-улс төрийн шинэчлэлтийн тухай ярих нь шинэчлэлтийг бүрэн бус ба бүрэн тусгаагүй зүйл гэж буруутгахад хүргэнэ гэсэн болгоомжлол байдаг. Орчин үеийн судлаачдын байр суурь, санал нэгдэж буй зүйл бол төрийн аппаратуудын чадавхи, автономи байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн неоинституционализмын хандлага юм. Концепцын дагуу авч үзэхэд шинэчлэлтийн ерөнхий нэг загвар байхгүй гэдэг нь мэдээжийн зүйл юм. Гэвч ерөнхий хандлага нь бодит зүйл бөгөөд, анхаарал татах ёстой зүйл аж. Энэ хандлагын гол зорилго нь институтүүдийн бүтэц-функционализмын тогтолцоог оновчтой тогтооход чиглэгдэж байна.

Тухайлбал, неоинституционализмын хандлагад зохион байгуулалтын тогтолцоо нь субъектив хүчин зүйлүүдийн нөлөөлөлд өртөн, оновчгүй байх явдал түгээмэл байдгийг шүүмжилж байгаа бөгөөд уламжлалт институциональ хандлага нь удирдагч ба удирдуулагчдын эрх ашгийн тэнцвэрийг хангаж чадахгүй гэж үздэгт оршдог. Учир нь албан ёсны бүх зохион байгуулалт рациональ төлөвлөгөөг бүрдүүлэхийг зорьдог бөгөөд түүний олон улсын болон дотоодын амьдралыг зохион байгуулах оролдлого нь мэдлэг мэргэшил, техник технологийн нөөцөд тулгуурлан, зохион байгуулалтын механизмын төгс хэлбэрийг бүрдүүлэхэд оршдог. Хэдийгээр тийм ч, салангид болон бүхэл системүүд эсэргүүцлийг сөрж, бүгд хоорондоо харилцан хамтран ажиллаж, өөрсдийн тусгай асуудал, зорилго болон зохион байгуулалтын хэв загвар, байгаль орчны дарамт ба бүх нийтийн оролцоо зэргийг харгалзах ёстой байдаг. Өөрөөр хэлбэл, хүссэн хүсээгүй албан ёсны бус сүлжээний бүтэц улам бүр үүссээр байна. Үр дүн нь нийгмийн бүтэц зохион байгуулалтыг тохиромжтой байлгах явдал юм. Үүний ач холбогдол нь нэмэгдсээр байгаа асуудал болох хүрээлэн буй орчин, нийгмийн эдийн засаг, соёл, социаль бүтцийн зохион байгуулалтыг бүрдүүлэх болон улс төрийн амьдралыг хянах зорилгоор нээлттэй байлгахад чиглэгддэг. Марк Нейдел, Фрэнсис Рорк нар үүнийг хэрэгжүүлэгч захиргааны бюрократ механизмыг оновчтой ажиллуулахын тулд, түүнд нөлөөлөх, түүнийг гадна, дотноос нь хянах, төр засгийн болон иргэний нийгмийн байгууллагуудын олон механизм байж болохыг дурдсан ажээ.

Ном зүй

П.П.Гайденко., Ю.Н.Давидов. Проблемы бюрократии у Макс Вебера //Вопросы философии. 1991. ¹ 3.

М.В.Масловский. Теория бюрократии Макса Вебера и современная политическая социология. М.,

Scott James C. 1998. Seeing Like a State: How Certain Schemes to Improve the Human CondiHave Failed (New Haven, CT: Yale University Press).

Weber.M. 1968. The essentials of bureaucratic organization: an ideal-type construction. / Reader in Bureaucracy / New York.

Г.В.Атаманчук “Теория государственного управления” стр 288.

Weber,Max. 1968. The essentials of bureaucratic organization: An ideal-type construction. /Merton, Robert K. Gray,Ailsa P. Hockey, Barbara. Selvin, Hanan C. Reader in Bureacracy /, New York., The Free Press.

Ж.Нигроу Л.Нигроу, 1996, Орчин үеийн төрийн удирдлага, УБ.,

Gershenkron A. 1962. Economic Backwardness in Historical Perspective. Cambridge,

Боб Льюис. 1999. Эдийн засаг дахь төрийн үүрэг роль ”Төр ба Эдийн засаг”. / Европын философи, улс төр, эдийн засаг, социологийн судалгаа, сургалтын зарим асуудал. Ред Л.Пүрэвдорж, Я.Хишигсүрэн, М.Вольф/ УБ., Admon press.

Ф.Фукуяама. 2005, Төрийг бэхжүүлэх нь. XXI зууны засаглал ба дэлхийн шинэ дэг журам. УБ.,

Selznick, Philip. 1957. *Leadership in Administration*. Evanston: Peterson & Co., Gouldner, Alvin W. 1968. "The Problem of Succession in Bureaucracy." Reader in bureaucracy. New York., Free press.

Боб Льюис. Эдийн засаг дахь төрийн үүрэг роль. Temfus (TACIS) "Marko" төслийн илтгэлээс: 1999.

В.И.Спридонова. 1997. Бюрократия и реформа. М.,

Инглхарт. Рональд, 1997, Постмодерн: меняющиеся ценности и изменяющиеся общества, Полис, 14. М.,

Л.Обломовский. 1997. Государственные служба. М.,

Patterson Thomas E. 1996. "American Democracy" New York., the McGRAW-HILL companies, INC.

Г.Альмонд. Ж.Пауэлл. К.Стром. Р.Дальтон. 2005. Харьцуулсан улс төр. Орч Ё.Довчин. УБ.,

Terry L. 1998. Administrative Leadership, Neo-Managerialism, and the Public Management Movement. – Public Administration Review, № 3.

Green R., Hubbel L. 1996. On Governance and Reinventing Government. – Wamsley G., Wolf J. (eds.). Refounding Democratic Public Administration. Modern Paradoxes, Postmodern Challenge. Thousand Oaks, L., New Delhi.

Wamsley G., Wolf J. (eds.). 1996. Refounding Democratic Public Administration. Modern Paradoxes, Postmodern Challenges. Thousand Oaks, L., New Delhi.

Сморгунов Л.В. 2000. Управление в условиях неопределенности: В поисках моделей устойчивого развития. Сравнительное государственное управление: теория, реформы, эффективность. СПб

Mierlo H. Van. 1998. Lessons from the Experience of OECD Countries. – Verheijen T., Coombes D. (eds.). Innovations in Public Management Perspective from East and West Europe. Cheltenham, Northampton (MA).

Maor M. 1999. The Paradox of Managerialism. – Public Administration Review, № 1.

UNDP. 2002. Good Governance and Sustainable Human Development. – Governance for Sustainable Human Development. A UNDP Policy Document (<http://magnet.undp.org>).

Сморгунов.Л.В, 2003. Сравнительный анализ политико-административных реформ: От нового государственного менеджмента к концепции "Governans"

Pierre J., Peters G. 2000. Governance, Politics, and the State. N.Y.

Knill Ch., Lehmkuhl D. 2002. Private Actors and the State: Internationalization and Changing Patterns of Governance. – Governance: An International Journal of Policy, Administration, and Institutions, № 1.

Brodhag Ch. 2000. Information, governance et development durable – International Political Science Review, № 3.

Vigoda E. 2002. From Responsiveness to Collaboration: Governance, Citizens, and the Next Generation of Public Administration. -Public Administration Review, № 5.

Fountain J. 2001. Building the Virtual State. Information Technology and Institutional Change. Washington.,

ПОЛИТОЛОГИ III

Эрдэм шинжилгээний бичиг ¹ ... (...): 79-84 дэх тал

МОНГОЛ ДАХЬ ОРЧИН ҮЕИЙН УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГАЛТ СУДАЛГААНЫ ЗАРИМ АСУУДАЛД

Ц.Ганболд

доктор, тэргүүлэх профессор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхмийн эрхлэгч

Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны үүсэл хөгжлийн тухай яриа мэдээж хэрэг нэлээд эртнээс эхлэх ёстой байх. Наад зах нь монголд төр улс үүссэн тэр цагаас бусад улс оронд улс төрийн шинжлэх ухаан үүсч хөгжсөн ерөнхий хандлага үе шаттай ойролцоо утгаар авч үзэж болох талтай. Тухайлбал, тэнгэрээс ивээлт төрийн тухай сургаал, шашин домгийн шинжтэй номлол монголын улс төрийн сэтгэлгээний түүхэнд тов тодорхой ул мөрөө үлдээсэн байдаг. Энэ мэт сургаал номлол, судалгаа шинжилгээ, сургууль дэг монголын төрт ёсны түүхийн турш өөрийн өвөрмөц өв уламжлалаа үлдээсэн байгаа.

Бид энэхүү өгүүлэлдээ 1990 оноос хойш монголд улс төрийн шинжлэх ухаан хэрхэн хөгжиж ирсэн, түүнийг их дээд сургуулиудад хэрхэн зааж байгаа талаар товч өгүүлэх болно. Тухайн улс оронд улс төрийн шинжлэх ухаан хэрхэн хөгжиж байгааг улс төр судлаачид янз бүрийн аспектаар авч үзсэн байх юм. Жишээлбэл: ОХУ дахь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн тухай тэдний өөрсдийнх нь нэр хүнд бүхий судлаачид ярихдаа ОХУ-ын үндэсний эрдэмтэд олон улсын улс төрийн шинжлэх ухааны дэлхийн

конгресст оролцсон 1955 оноос Оросын улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн шинэ үе-орчин үе эхэлсэн гэж үзсэн байна. Энэ тухай Полис сэтгүүлийн 2006 оны № 1-ээс үзэж болно. Украин, Армен, Белорусс зэрэг пост коммунист орнуудад орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн тухай ярихдаа эрх зүйн орчин, институцийн хөгжил, боловсон хүчний шинэчлэл, агуулгын өөрчлөлт, гадаад харилцааны хөгжил, судалгаа шинжилгээний ажлын цар хүрээ гэх мэт чиглэлүүдээр авч үзсэн байх юм. Азийн орнуудад өөрийнхөө орон дахь улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн тухай өгүүлэхдээ улс улсдаа өөр өөр аспектаар авч үзсэн байх юм. Тухайлбал: Political science in Asia №1, 2005 он сэтгүүлд:

- Японд түлхүүр асуудлууд, тэргүүлэх судлаачдыг танилцуулах байдлаар
- Өмнөд Солонгост судлаачдын тодорхойлолт, судалгааны арга, сэдэв
- Филиппинд улс төрийн шинжлэх ухааны түүх, нийгэмлэг, улс төр судлаачид
- Тайландад түүхчилж үзэхийн зэрэгцээ улс төрийн шинжлэх ухааны нийгэмлэгийн хөгжил
- Хятадад хэрэгжүүлж байгаа төслүүдээр
- Малайзад Улс төрийн судалгаа ба угсаатан судлалын асуудлаар
- Гонконг улс төрийн шинжлэх ухааны үүсэл, одоогийн байдал, судалгааны Ази дахь хандлага гэсэн чиглэлүүдээр авч үзжээ.

Миний хувьд ОХУ болон бусад посткоммунист орнуудад хэрэглэсэн арга зүйг үндэс болголоо. Монгол дахь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн тухай ярихын тулд юуны өмнө улс төр эрх зүйн орчны тухай товч дурьдах хэрэгтэй. 1980-аад оны сүүл үеэс монголд өөрчлөлт шинэчлэлийн уур амьсгал бий болж улс төр эрх зүйн шинэ орчин бүрэлдэж эхэлсэн. Үүний нэг илрэл нь их дээд сургуулийн зарим багш нар МАХН-ын түүхээр улсын шалгалт авдгийг болиулж, түүний оронд философи, шинжлэх ухааны коммунизмын онол, БНМАУ-ын түүхийн хичээлээр улсын шалгалт авдаг болох тухай санал дэвшүүлж, зарим сургуулийн оюутнууд МАХН-ын түүх, ЗХУКН-ын түүх зэрэг хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнөөс хасах тухай санал гаргаж байсан байна. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэж, 1990-1991 оны хичээлийн жилээс МАХН-ын түүх, ЗХУКН-ын түүх, Улс төрийн эдийн засгийн ухаан, шинжлэх ухааны коммунизмын онол зэрэг хичээлийг их дээд сургуулийн хөтөлбөрөөс хасаж эхэлжээ. 1990-1991 оны хичээлийн жилд зарим их дээд сургуулиудад дээрх хичээлүүдийг орохыг зогсоож, шинэ хичээлүүд орох бэлтгэл ажлууд хийгджээ. Ингээд их дээд сургуулийн зарим багш нарыг Польш, ЗХУ-д явуулж мэргэжил дээшлүүлж, МУИС-ийн шинжлэх ухааны коммунизмын онолын тэнхимийн суурин дээр Улс төр судлалын тэнхимийг байгуулах бэлтгэл ажил 1990 онд хийгдэж, тус тэнхимийн багш нар бусад их дээд сургуулийн шинжлэх ухааны коммунизмын онол, ЗХУКН-ын түүхийн багш нар бүтэн нэг хичээлийн жил улс төр судлалын хичээлийн төлөвлөгөө, лекцийг боловсруулж, сургалт семинар хэлэлцүүлэг зохион байгуулжээ. 1992 онд одоогийн Удирдлагын Академийн төрийн удирдлагын тэнхимд богино хугацааны курс зохион байгуулагдаж, түүнд их дээд сургуульд улс төр судлал заах багш нар хамрагджээ. 1991-1992 оны хичээлийн жилд шинжлэх ухааны коммунизмын онолын оронд Улс төр судлал, УТЭЗУ-ны оронд эдийн засгийн онол, марксист-ленинист философийн оронд гүн ухаан, МАХН-ын түүхийн оронд монголын түүх зэрэг хичээлүүдийг заах нь зүйтэй гэж тухайн үеийн БШУЯ-ны сайдын шийдвэр гарсан байна. Ингээд 1991 онд МУИС-ийн захирлын тушаалаар хуучин ШУКО-ын тэнхимийн суурин дээр улс төр судлалын тэнхим байгуулагдаж, тэнхимийн эрхлэгчээр НУФ-ын декан дэд доктор Ш.Содном хавсран ажиллахаар томилогджээ. Улс төр судлалын тэнхимд 7 багш ажиллаж байсан ба тухайн үед Политехникийн дээд сургууль,

УБДС, АУДС, ЦДС, ХААДС зэрэг төрийн өмчийн томоохон их дээд сургууль зарим техникумын улс төр судлалын багш нар МУИС-ийн улс төр судлалын тэнхимд төвлөрч мэргэжлийн сургалт эрдэм шинжилгээний болон заах аргын семинарууд явуулж тус тэнхим улсын хэмжээний сургалт эрдэм шинжилгээний гол төв болж байсан. 1992 онд улс төр судлал, социологи, угсаатан судлалын чиглэлээр судалгаа шинжилгээ хийх зорилгоор нийгмийн судалгааны төвийг байгуулж, төвийн эрхлэгчээр дэд доктор Л.Бат-Очирыг томилж, дараа нь дэд доктор Х.Нямбуу төвийн эрхлэгчээр ажиллаж байгаад хожим угсаатны зүйн тэнхим болон өөрчлөгджээ. 2003 онд МУИС-ийн НШУС-ийн сургуулийн дэргэд нийгмийн судалгааны хүрээлэн, 2004 онд монголын улс төр судлаачдын холбоо, 2005 онд монголын улс төрийн шинжлэх ухааны холбоо, 2006 онд МУИС-д орчин үеийн улс төрийн судалгааны төв байгуулагдлаа.

Улс төрийн шинжлэх ухааныг их дээд сургуулиудад заах эрдэм шинжилгээний ажил эрхлэхээс гадна шинжлэх ухааны академийн Философи социологийн эрхийн хүрээлэн, Улс төрийн боловсролын академи, Төрийн Удирдлагын Академи, УИХ-ын дэргэдэх судалгааны төв, Улс төрийн намуудын дэргэдэх судалгааны байгууллагууд, Монголын залуучуудын холбооны дэргэдэх Полис төв, Зориг сан, Альтернатив төв, Сант Марал сан, Зотол, Социологийн Академи, Сонгогчдын боловсрол төв, Солбицол төв, Зөгий, Жинлүүр, Монголын Лектор төв зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд улс төрийн шинжлэх ухааны тодорхой чиглэлүүдээр судалгаа шинжилгээний ажлууд хийж ирсэн нь энэ салбарын институционал бүтцийн бүрдэл хэсэг болон төлөвшиж байна. Энэхүү бүтцийн хөгжилд Соросын сан, АНУ-ын Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сан, Конрод-Адэнаурын сан зэрэг гадаад орнуудын болон олон улсын байгууллагуудын дэмжлэг, туслалцаа хамтын ажиллагаа чухал нөлөө үзүүлснийг онцлон тэмдэглэж байна.

1993 онд МУИС-д улс төр судлалын салбар байгуулагдсан нь улс төрийн шинжлэх ухааны мэргэжлийн боловсон хүчнийг эх орондоо бэлтгэх анхны том алхам болсон юм. 1996 онд анхны магистр төгсөж, 2003 онд МУИС-ийн багш Д.Бадамдаш, Д.Мөнх-Очир нар АНУ-д мастерын зэрэг хамгаалсан. 1997 онд улс төрийн шинжлэх ухааны бакалаврын дипломтой анхны 15 оюутан төгссөн. Мөн энэ онд /1997/ улс төр судлалын оройн анги, 1998 онд эчнээ анги нээгдэж, 1999 онд анхны докторын шатны сургалт эхэлж, мөн 1999 онд УБИС дээр философи-улс төр судлалын анги 2000 онд Шинжээч-21 дээд сургуульд социологич-улс төр судлаачийн анги, 2003 онд Ховд их сургуульд улс төр судлаачийн анги нээгджээ. Мөн Соёмбо, Чингис хаан, Их засаг зэрэг сургуулиудад ижил төрлийн мэргэжилтэн бэлтгэж байна.

1994 онд Москвагийн Улсын Их Сургуульд А.Юндэндорж улс төрийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж /гадаадад/, 1998 онд УБИС-ийн тэнхмийн эрхлэгч Л.Пүрэвдорж улс төрийн шинжлэх ухааны анхны докторын зэрэг /дотоодод/ хамгаалжээ. 1997-1998 оны хичээлийн жилээс улс төрийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийг ШУА-ийн Философи социологийн эрхийн хүрээлэнд түшиглүүлэн философи, социологи, улс төр судлалаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулагдсан. Энэ зөвлөл дээр Л.Пүрэвдорж, Ю.Атар, Х.Цолмон, Т.Гантулга нар хамгаалсан. 1999 онд МУИС-ийн улс төр судлалын тэнхмийн багш Ё.Довчин Санкт-Петербургийн их сургуульд докторын зэрэг хамгаалсан. 2002 онд БСШУЯ-ны сайдын 2002 оны 32-р тушаалаар улс төрийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалуулах улсын хэмжээний нэгдсэн зөвлөл байгуулагджээ. Энэхүү зөвлөл нь 19 гишүүнтэй, зөвлөлийн даргаар доктор Г.Чулуунбаатар, орлогч

даргаар доктор Б.Алзахгүй, эрдэмтэн нарийн бичгийн даргаар доктор, профессор Ц.Ганболд нар ажиллаж байна. Энэ зөвлөл дээр Д.Ганбат, Д.Загджав, Ж.Төртогтох, Я.Төмөрбаатар, Ч.Сэмжидмаа нар улс төрийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан байна. Ийнхүү монгол улсад улс төр судлалын чиглэлээр бакалавр, магистр, докторын шаталсан сургалт төлөвшиж иржээ. Энэ хугацаанд 10 орчим доктор, 120 орчим магистр, 400 орчим бакалавр төгссөний зэрэгцээ /гадаадад хамгаалсан магистр докторын тоо бүрэн бус байгаа/ Шинжээч-21, Соёмбо, Чингис хаан дээд сургууль, Удирдлагын Академи, Отгонтэнгэр, Орхон, Их засаг, Шихихутаг, Ховд их сургууль зэрэг төрийн болон төрийн бус их дээд сургуулиудад философич-улс төр судлаач, социологич-улс төр судлаач, түүхч-улс төр судлаач, нийгэм судлаач-улс төр судлаач зэрэг хос мэргэжлээр нэжгээд мэргэжилтэн бэлтгэж иржээ.

Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны хөгжилд боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх, давтан бэлтгэх, гадаад дотоодод мэргэжлийг нь дээшлүүлэх, шинэ үеийн боловсон хүчинг бэлтгэх асуудал чухал байр суурь эзэлж ирлээ. Үүнд: Юуны өмнө МУИС-ийн улс төр судлалын салбар, бусад их дээд сургуулиудад үндэсний мэргэжилтэнг бэлтгэж байсны зэрэгцээ Соросын сан, Иргэний боловсролын төсөл /СЕР/, Төв Европийн Их Сургууль /CEU/, Конрэд-Адэнаурын сан, Ханс зайдальн сан, Эйбертын сан, Азийн сан зэрэг гадаад орнуудын болон олон улсын байгууллагууд, ихээхэн туслалцаа үзүүлж байсан нь гадаад дотоодын ижил төрлийн мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоох хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, үндэсний боловсон хүчний мэргэжлийг дээшлүүлэхэд онцгой ач холбогдолтой байлаа. Үүний зэрэгцээ энэ салбарын профессор багш нар, эрдэмтэн судлаачид АНУ, Канад, Герман, Англи, Унгар, Польш, Литва, Казахстан, Киргизстан, Узбекистан, Япон, Солонгос, Хятад, Сингапур зэрэг Ази Европ, Америкийн олон оронд суралцаж, мэргэжил дээшлүүлж, зэрэг цол хамгаалж, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч доктор, профессор Ц.Ганболд олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоонд гишүүнээр элсэж, мөн Японы Фукуока хотод болсон олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны дэлхийн 20-р конгресст урилгаар оролцсон, багш Д.Бадамдаш Америкийн улс төрийн шинжлэх ухааны холбоонд гишүүнээр элсэж, Ж.Төртогтох Азийн улс төрийн судалгааны консерциумтай хамтран ажиллаж, эдгээр олон улсын байгууллагуудын мэргэжлийн сэтгүүлүүд /эх хувиараа шинэ дугаарууд онлайнгаар бүх дугаарууд/ ирж байна. Зөвхөн МУИС-ийн улс төр судлалын тэнхимийн багш нар л гэхэд давхардсан тоогоор 60 гаруй удаа 20 гаруй оронд урт богино хугацаагаар гадаад томилолтоор ажилласан байна. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн багш нар Канадын Британы Колумбын Их сургуулийн улс төр судлалын тэнхимд, Германы Билефельдийн Их сургуулийн улс төр судлалын тэнхимд, мөн Бельгийн Аньверпений Их сургуулийн улс төр судлалын тэнхимд суралцаж мэргэжил дээшлүүлсний сацуу тус тэнхмүүдээс багш нар уригдан сургалт явуулж ирсэн.

Улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны ажлын хөгжилд гадаад дотоодын санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслүүд чухал ач холбогдолтой байсан. Үүнд:

Соросын сангийн шугамаар хэрэгжүүлсэн төслүүд онцгой байр суурьтай. Тухайлбал: МУИС-ийн улс төр судлалын тэнхим магистрын сургалтын төлөвлөгөөгөөг Соросын сангийн дэмжлэгтэйгээр Вильнюст болсон 12 орны мэргэжил нэгт нөхдүүдийн оролцоотойгоор Монмастер хөтөлбөрийг хэлэлцүүлж батлуулсан. МУИС-ийн улс төр судлалын тэнхимд 2001-2005 оны хооронд гадаадын 30 орчим мэргэжилтэн урт богино хугацаагаар ирж

ажилласны дотор 13 зочин профессор жилээс доошгүй хугацаагаар ажиллажээ. Мөн энэ хугацаанд Иргэний боловсролын төсөл /CEP/, академик тэтгэлгийн хөтөлбөр /AFP/, Азийн судалгааны төв /ARC/, Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн /IRI/, Дээд боловсролыг дэмжих хөтөлбөр /HESP/-ийн төслүүд амжилттай хэрэгжсний зэрэгцээ монголд суугаа гадаад орнуудын элчин сайдын яамдууд тодорхой дэмжлэг үзүүлж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Одоо Монгол улсын Боловсролын Их Сургууль дээр Германы Билефельдийн Их сургуультай хамтарсан улс төр судлалын магистрын сургалтыг сайжруулах төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Тус төслийн хүрээнд улс төр судлалын магистрантуудын сургалтын агуулга, арга зүйг шинэчлэх үе шаттай ажлууд хийгдэх бөгөөд жил бүр Германы профессорууд уригдан ирж сургалт явуулах ба мөн тус сургуулийн багш нар очиж мэргэжил дээшлүүлэх юм. Мөн Унгар дахь Нээлттэй нийгэм Хүрээлэнтэй нягт хамтран ажиллаж ирсэн бөгөөд 2001 оноос хойш улс төр судлалын чиглэлд 2 бие даасан судалгааны төсөл, мөн 3 шинэ хичээлийн төслийг хэрэгжүүлсэн.

Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны институционал бүтцэд МУИС болон бусад их дээд сургуулиудад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын харилцааны болон дипломат албаны чиглэлийн тэнхим салбар, төвүүд /Стратеги судлалын хүрээлэн г.м/ мөн хуулийн сургуулиуд дахь төрийн онолын тэнхим төрийн удирдлагын чиглэлийн тэнхим, салбар хүрээлэн төвүүд чухал байр суурьтай.

Ерөнхий улс төр судлалын сургалтын агуулгын тухайд бид одоогоор 4 загварыг үндсэнд нь баримталж байна. Үүнд:

1. ОХУ болон посткоммунист орнуудын шинэчилсэн загвар
2. Сөүл-Токиогийн их сургуулийн Азийн загвар
3. Охфордын буюу Европын загвар
4. Америкийн загвар

Эдгээр чиглэл тус бүрээр одоохондоо монгол хэл дээр сурах бичих нэн ховор байгаа ба нэгдэх загвараар бичсэн бидний сурах бичгүүд шинэчлэх шаардлагатай болж байгааг хэлэх нь зүйтэй.

Мэргэжлийн ангид үздэг үндсэн хичээлүүдээр анхны сурах бичгүүд гарч байна. Үүнд: Ё.Довчингийн “Харьцуулсан улс төр”, А.Жамбалын “Улс төрийн сэтгэлгээний түүх”, Х.Ганбаатарын “Дундад зууны үеийн улс төрийн сэтгэлгээний түүх”, Ч.Өлзийсайханы “Элит судлал”, Ц.Ганболдын “Улс төрийн сэтгэл судлал”, А.Юндэндорж, Ю.Атар нарын “Өрнө дорнын сэтгэгчдийн улс төрийн сургаал номлол” г.м. Үүний зэрэгцээ МУИС-ийн “Политологи” сэтгүүл, УТБА-ийн “Шинэ толь” сэтгүүл, Удирдлагын Академийн “Төрийн захиргаа” сэтгүүл, ШУА-ийн ФСЭХ-ийн эрдэм шинжилгээний бичиг зэрэг мэргэжлийн сэтгүүлүүд сургалтанд хэрэглэгдэж байна.

Улс төрийн шинжлэх ухааны сургалт-эрдэм шинжилгээний ажлын хүрээнд оюутны курсын ажил, дипломын ажил, магистр докторын ажил, багш судлаачдын эрдэм шинжилгээний ажлын бичлэгийн 3 загварыг /стандартыг/ хэрэглэж байна. Үүнд:

1. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичгийн стандарт
2. Альтернатив стандарт /Европ-Америкийн загвар/
3. Харвардын систем

Бид энэ 2006-2007 оны хичээлийн жилээс Харвардын системийг нэвтрүүлэхээр зөвлөмж боловсруулж байна. Үүний нэг давуу тал нь Интернэтээс ашигласан материалд ишлэл зүүлт хийхэд илүү тохиромжтой гэж үзэж байгаа юм. /Бичлэгийн альтернатив стандарт, Харвардын системийг хавсралтаас үзнэ үү/.

Улс төрийн шинжлэх ухааны институциональ бүтцийн хувьд манай оронд зарим нэг буруу хандлага ажиглагдаж байгааг хэлэхгүй өнгөрч болохгүй байна. Тухайлбал, дэлхийн ихэнхи университетүүдэд олон улсын харилцааны салбар нь нийгмийн шинжлэх ухааны бүтэц дотроо багтаж байдаг. Гэтэл МУИС-д Олон улсын харилцааны салбар нь биеэ даасан сургууль байснаа одоо Гадаад хэл соёлын сургууль, Олон улсын харилцааны сургууль болон 2 хуваагдсан байдалтай байна. Мөн НШУС дотор нийгмийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбарууд холилдсон байдалтай оршиж байна. Бүтцийн ийм байдал нь боловсон хүчний болон үүргийн /функц/ буруу тогтолцоо бий болоход хүргэж байгаа юм.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулгад улс төрийн тухай мэдлэг, чадвар нэлээдгүй бий. Ялангуяа 10-11-р ангид үзэх Нийгмийн тухай мэдлэг хичээлийн агуулгад улс төр ай, Монгол ба Олон улсын хамтын нийгэмлэг ай гэж байна. Ер нь Нийгмийн тухай мэдлэг хичээлээр 1990-ээд оноос хойш янз бүрийн зохиогчтой хэд хэдэн сурах бичиг гарсан байдгаас одоо албан ёсоор О.Пүрэв нарын Нийгмийн тухай мэдлэг сурах бичиг ерөнхий боловсролын сургуульд ашиглагдаж байна.

Стандарт болон сурах бичгийн агуулгын тухайд жичэд нь ярилцах шүүмжлэлтэй зүйлс байгааг тэмдэглэх хэрэгтэй.

1990-ээд оны эхээр Ё.Вятр, А.Боднар, Т.Санистебян нарын номыг уншиж, Оросын эрдэмтдийн орчуулгын бүтээлийг ашиглаж, улс төр судлалын анхны лекцүүдийг уншиж байсан үеэ бодоход өнөөдөр монгол дахь улс төрийн шинжлэх ухаан боловсон хүчний хувьд дахин бэлтгэгдэж, шинэчлэгдэж шинэ үе гарч ирж, УТШУ-ны институционал бүтцүүд бий болж, үндэсний холбоо нийгэмлэгүүд, төрийн бус байгууллагууд байгуулагдаж, үндэсний сурах бичиг, гарын авлага, мэргэжлийн сэтгүүлүүд бий болж одоо орчин үеийн олон улсын жишиг хандлагатай хөл нийлүүлэн алхахын дайтай болж төлөвшиж байна.

ПОЛИТОЛОГИ III
Эрдэм шинжилгээний бичиг ¹ ... (...): 85-100 дахь тал

МОНГОЛ ДАХЬ АВИЛГАЛЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС: БАРИМТ БИЧГИЙН БА ТООН СУДАЛГААНЫ АНАЛИЗ¹

Ж.Төртогтох
доктор, дэд профессор
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Д.Оюунчимэг
докторант, ахлах багш
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Ч.Өлзийсайхан
докторант, ахлах багш
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Оршил

¹ Үгүйцэг "Ажлын үр дүнд" нь 2006.04.01-2007.03.31-ийн өмнөх үеийн
МОНГОЛ ДАХЬ АВИЛГАЛЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС
БАРИМТ БИЧГИЙН БА ТООН СУДАЛГААНЫ АНАЛИЗ-ийн
дүнд бичигдсэн бөгөөд түүнийг МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим
ашигласныг үндэслэн авч үзсэн.

Судалгааны хүрээнд авч үзсэн 130 гаруй материалаас харахад авилгалын асуудал нь нийгэмд асар их хор хохирол учруулдаг бөгөөд манай орны өнөөгийн нөхцөлд энэ нь нэн их анхаарал татсан, өргөн цар хүрээг хамарсан үзэгдэл болохын хувьд судлаачид, иргэд, улс төрчид, гадаадын янз бүрийн байгууллагуудын анхаарлын төвд байж, судалгааны ажилд нилээд их хүч хөдөлмөр, санхүүжилт зарцуулагдсан нь харагдаж байна.

Баримт бичгүүдэд анализ хийх судалгааны үйл ажиллагааны хүрээнд тэдгээр баримт бичгүүдийг хэд хэдэн хэсэг болгон ангилж болохоор байна.

Тухайлбал:

- Авилгалын талаарх шинжлэх ухаан-онолын судалгаа анализад тулгуурлан хийгдсэн нэг сэдэвт зохиол бүтээлүүд, нэгдсэн аргачлал, зөвлөмж бүхий гарын авлага;
- Олон улсын байгууллага, сан, төслүүдийн санхүүжилт, дэмжлэгтэйгээр авилгалын талаар хийгдсэн судалгаа, төслүүд, тэдгээрийн тайлан, үр дүнг илэрхийлсэн баримт материалууд;
- Төр засгийн зүгээс батлан гаргасан, хууль эрх зүйн актууд, хөтөлбөр, бодлогын шинжтэй баримт бичгүүд;
- Авилгалтай тэмцэх талаар голчлон хийгдсэн олон улсын хурал, зөвлөгөөний баримт бичгүүд, зөвлөмжийн шинжтэй уриалга, холбогдох бусад материалууд;
- Судалгаа, шинжилгээний зорилго, зориулалттай биш боловч авилгын талаарх ухуулга, сурталчилгаа, нийгмийн танин мэдэхүйн шинжтэй, нийгмийг авилгалаас ангижруулах арга зам эрэлхийлсэн, авилгалтай тэмцэх боломжийн талаар голчлон анхаарсан олон нийтийн мэдээллийн хэрэгслийн материалууд;
- Авилгалтай холбоотой гарсан бусад материалууд зэрэг болно.

Ингэж ангилж үзэхэд авилгалыг гэмт хэрэг гэж үзэж, илрүүлэх, хуулийн хариуцлага хүлээлгэх талаас нь, өмч хувьчлалыг хуудуутай хийж улсын өмчийг үрэн таран хийсэн гэдэг талаас, мөн эрэн сурвалжлах сэтгүүл зүй, авилгалыг арилгахад тэдний нийгэмд гүйцэтгэх томоохон үүргийн талаас анхаарч үздэг нь тодорхой харагдаж байна. Төр засгийн зүгээс ч авилгалтай тэмцэх талаар нилээд арга хэмжээ авдаг нь хуулийн төслүүд, саналууд, батлаж гаргасан хууль, хөтөлбөрүүд, баримт бичгүүдээр нотлогдож байна. Авилгалтай тэмцэх талаар олон улсын хурал зөвлөгөөний материалууд ч нилээд байгаа ба гадаадын улс орнуудын авилгалтай тэмцсэн, өндөр албан тушаалтан, эрх мэдэлтнүүдийн хуудуутай үйл ажиллагааг илчилсэн арга туршлагыг хуваалцсан шинжтэй материалууд чамгүй орчуулагджээ.

Судалгааны зориулалттай биш, харин эрх баригчид, улс төрчид авилгал авч байгаа гэж үзэж нотлохыг оролдсон, нийгэмд учруулсан хор хохиролтой үр дүнгээс нь ургуулан авилга авсан байж магадгүй гэж таамагласан, нийгмээ авилгалаас ангижруулах арга зам хайсан сонин, хэвлэлийн материалууд асар их байна. Магадгүй бараг өдөр бүр хэвлэгдэж байдаг эдгээр материалууд нь авилгалын асуудал монголд бараг бүрэн судлагдсан гэсэн сэтгэгдэл төрүүлдэг байж болох юм. Гэвч нийгэм, улс төрийн амьдралын хүрээнд бүхэлд нь, цогцоор нь гаргах тал дээр учир дутагдалтай байгаа юм.

Бидний төслийн хүрээнд хийгдэж байгаа ажилтай нилээд төстэй байж болох, бидний ажилд нилээд их ач холбогдолтой цөөхөн хэдэн судалгааны ажил байгааг хэлэхгүй өнгөрч болохгүй. Энд юуны өмнө МҮХАҮТ, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн хамтран 2002 онд хийсэн Улс төрийн хүрээний авилгалын индекс судалгаа, Засгийн газрын “Сайн засаглал” хөтөлбөрийн хүрээнд 1999, 2002 онд авилгалын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурийн судалгаанууд нь бидний төслийн ажилд нилээд ач холбогдолтой,

салбарт ажиллагсдад авилгал тохиолдох, түүнтэй холбоотой үр дагаварыг дээрх хүмүүс илүүтэй хүртдэг байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байгаа юм.

Авилгалыг өөгшүүлэгч хүчин зүйлсээс иргэдийн эрх, үүргээ ухамсарладаггүй байдал, хуулийн талаарх мэдээлэл хомс байдал ба төрийн зүгээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний олон шатлалт механизм, түүнээс урган гарах хүнд сурталт тогтолцоо гэсэн хоёр үзүүлэлтийг сонгон авч харьцуулан үзье. Хүснэгт 3 ба хүснэгт 4-өөс харахад иргэд өөрсдөө эрх үүргээ төдийлөн сайн мэддэггүй, хууль эрх зүйн ойлголт, мэдээлэл хомс байгаа нь авилгалыг газар авахад нөлөөлж байна гэдэгтэй судалгаанд оролцогсдын 79,5 хувь нь хүнд сурталт тогтоцоо нь авилгалыг өөгшүүлж байна гэдэгтэй 87,6 хувь нь тус тус санал нийлж байна. Дээд боловсролтой хүмүүсийн 89,3 хувь, төрийн бус байгууллагад ажиллагсдын 96,4 хувь нь буюу бусад салбарын хүмүүсээс хамгийн олон нь хүнд сурталт тогтолцоотой нэг ёсондоо төр, төрийн байгууллага, түүний үйл ажиллагаатай асуудлыг илүү холбож авч үзэж байгаа юм. Энэ нь дээрх хүмүүсийн хувьд төрийн үйл ажиллагааг ойлгож, мэдээллийг хүлээн авч тэдгээрт өөрсдийн дүн шинжилгээг хийдэгтэй холбоотой гэж болох юм. Харин тусгай дунд боловсролтой хүмүүсийн 82,1 хувь, хувийн хэвшилд ажиллагсдын 83,5 хувь нь авилгалыг иргэд өөрсдөө өөгшүүлж байна гэдэгтэй бусдаас илүү санал нийлжээ. Иргэд хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл хангалтгүй тэр хэрээр эрх, үүргээ тэр бүр ухамсарладаггүй байдал гол хүчин зүйл гэж үзэж байгаа нь дээрх хүмүүсийн хувьд энэ асуудлын талаар түлхүү анхаарч, санаа зовж байдгийн нэг илэрхийлэл юм.

Төрийн байгууллагад ажиллагсдын 14,7 хувь, дээд боловсролтой хүмүүсийн 14,2 хувь буюу бусдаас харьцангуй олонх нь авилгалыг өөгшүүлж буй нь иргэдийн мэдлэг, ухамсартай холбоогүй гэж хариулсан нь дээрх хүмүүсийн хувьд мэдээллийн хүртээмж хангалттай байдаг, энэ хэрээр тэд өөрсдийн эрх үүргэ бусдаас илүү мэддэг, ухамсарладаг болохыг харуулж байна. Тэгвэл бүрэн дунд боловсролтой хүмүүс бусдаас илүүтэйгээр төрийн зүгээс иргэдэд үйлчлэх үйлчилгээний шинж байдал авилгалыг дэмжиж байна гэж саналаа өгсөн. Харин сонирхолтой нь мөн л дээд боловсролтой хүмүүс бусдаас илүүтэйгээр энэ тал дээр санал нийлж байгаа явдал юм. Асуудлын учир шалтгааныг ул суурьтай авч үзэж, хандах тал дээр дээд боловсролтой хүмүүс бусад оролцогсдоосоо илүү хандаж байгаа нь зөвхөн дээрх хоёр үзүүлэлтийн дүнгээс харагдаж байгаа хэрэг биш юм.

Авилгалын хэрэг илрүүлэлт хангалтгүй байгаад нөлөөлж буй шалтгааныг судалгаанд оролцогсдын 27% нь “Хүмүүсийн ёс суртахуун доройтож, нийгмээрээ авилгал өгөх, авах сэтгэлгээнд автсан”-аас, 26 % нь “Албан тушаалтнуудад хууль үйлчилдэггүй тогтолцоо хэвшмэл болсон”-оос, мөн 26 % нь “Авилгалыг илрүүлэх төрийн байгууллагууд авилгалд идэгдсэн”-ээс, 20% нь “Авилгалын талаарх хууль эрх зүйн систем бэхжээгүй”-гээс, 1% нь бусад шалтгаанаас гэж үзсэн байгааг хүснэгт 5-аас харна уу.

Санал асуулгын хүрээнд тавигдсан нэг чухал асуудал бол респондентуудын хувьд тохиолдсон авилгал авах, өгөх тохиолдлуудын тандалт юм. Зураг 3-аас харахад танд авилгал өгөх, авах явдал тохиолдож байсан бол ямар байгууллагууд дээр тохиолдож байсан бэ гэсэн асуултанд дараахи байгууллагуудыг нэрлэсэн байна. Үүнд: Судалгаанд оролцогсдын 42,8 % нь “Эрүүл мэндийн байгууллага”, 37,1% нь “Гаалийн байгууллага”, 32 % нь “Боловсролын байгууллага”, 28,4% нь “Хууль сахиулах байгууллагууд”, 26,8% нь “Төрийн захиргааны байгууллага”, 20,3% нь “Татварын байгууллага”, 19,5% нь “Мэргэжлийн хяналтын байгууллага”, 15,8 % нь “Банк санхүүгийн байгууллага” - ыг тус тус нэрлэсэн байна. Үүнийг дан ганц судалгаанд хариулагчдын өгсөн саналын хувиар тайлбарлах нь өнгөц хэрэг болно.

Тухайлбал эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх давтамжыг банк санхүүгийн болон мэргэжлийн хяналтын зэрэг байгууллагатай адилтгаж авч үзэхэд бэрхшээлтэй юм.

Авилгалыг дэмжин дэлгэрүүлэх, өөгшүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар дараахи үнэлгээг өгчээ (Зураг 4-ийг үз). Үүнд судалгаанд оролцогсдын 37,3% нь “Авилгалтай тэмцэх сайн хууль байхгүй”, 30,2% нь “Аль ч шатанд хуулийг дагаж мөрддөггүй”, 25,6 % нь “Авилгалын хэргийг таслан шийдсэн практик байхгүй” байгаа явдал гэж үзсэн бол 6,9 % нь “Хэлж мэдэхгүй байна” гэжээ. Мөн л хуулийн ач холбогдол ямар их болохыг эндээс харж болно. Давтан өгүүлэхэд энэхүү төслийн үйл ажиллагаа “Авлигын эсрэг хууль” батлагдан гарахаас өмнө эхэлсэнтэй холбоотойгоор респондентуудын хариулт нь хуулийн хүлээлт ямар их байсныг давхар нотолж байна.

Харин судалгаанд оролцогсдоос авилгалыг дэмжин дэлгэрүүлэх, өөгшүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхой салбаруудаар ялган тодорхойлсон хариултуудыг задлан авч үзье. Зураг 7-оос харахад авилгалыг дэмжин дэлгэрүүлэх, өөгшүүлэхэд нөлөөлж буй эдийн засгийн хүчин зүйлсийн талаар судалгаанд оролцогсдын 29,6% нь “Иргэдийн орлогын тэгш бус байдал”, 20,3% нь “Эдийн засаг дахь цөөнхийн монопольчлол”, 20,2% нь “Амьжиргааны чадавхи сул”, 17,4% нь “Ажлын байрны эрэлт их”, 11,0% нь “Тендерийн шудрага бус өрсөлдөөн”, 1,4% нь “Хүний шунал хэтэрснээс” гэсэн хариултуудыг өгчээ. Эдийн засгийн хүчин зүйлсийн хувьд бүхэлдээ авилгалыг улам нэмэгдүүлэхэд тэдгээр нь ойролцоо нөлөө үзүүлж байгаа нь энэ дүнгээс харагдаж байна.

Гэхдээ энд хувь хүний хүчин зүйлийг хамгийн багаар холбож үзсэн нь сонирхолтой. Хувь хүний эд, мөнгөний сонирхол буюу шунал авилгал авахад бага нөлөөлдөг гэж шууд хэлж боломгүй. Хэдий судалгааны дүн энэ асуудлын хувийн жин дөнгөж 1,4 хувь байгааг харуулж байгаа ч авилгалд автагдсан гэж олон нийтийн ойлгодог нийгмийн болон төрийн үйлчилгээний салбарт өндөр албан тушаал хашдаг хүмүүсийн хувийн хүмүүжил, соёлын түвшин авилгалыг дэмжихэд нөлөөлөх зайлшгүй хүчин зүйл болох нь гарцаагүй.

Үүнийг авилгалыг дэмжин дэлгэрүүлэх, өөгшүүлэхэд нөлөөлж буй зан заншил, ёс суртахууны хүчин зүйлсийн талаарх олон нийтийн санал бодолтой холбон авч үзэж болно. Судалгааны дүнгээс харахад оролцогсдын дийлэнх олонх нь буюу 60,4 % нь “Ёс суртахууны үүрэг хариуцлага суларсан”-тай авилгалын асуудал нэмэгдэж байгааг холбож ойлгож байгаа нь дээрх таамаглалыг баталж байна. Ёс суртахууны хүчин зүйлсийн бусад хэмжүүрийн хувьд респондентуудын 34,3 % нь “Хүний мөс нинжин сэтгэл алдарсан”, 3,7 % нь “Хэтэрхий нэрэлхүү зантай”, 1,6 % нь “Хүний шунал нэмэгдэж, гар харах өвчтэй болсон” зэрэгтэй авилгал өсөн нэмэгдэж буйг хамаатуулж авч үзжээ (Хүснэгт 7-ийг үз). Хэдийгээр энд хүчин зүйлийн онцлогоос шалтгаалан хэмжүүрүүдийг яльгүй энгийн гэж болох үгсээр илэрхийлсэн боловч үр дүнгээс харахад арга зүйн хувьд тайлбарлаж болох дүр төрх үүссэн нь харагдаж байна. Хүний шунал, нэрэлхүү зан, гар харах, хүний мөс зэрэг ойлголтууд хүмүүсийн дунд ихэвчлэн мөнгөний асуудалтай холбоотой тавигддаг байна. Иймээс авилгал нэгэнт мөнгөнөөс тусад нь авч үзэх боломжгүй зүйл юм бол үүнийг дэмжихэд болон хориглоход ёс суртахууны олон хүчин зүйлийг нийгэм дэх энгийн үг хэллэгээр илэрхийлэх нь арга зүйн хувьд боломжтой юм.

Зан заншил, ёс суртахууны асуудал нь авилгалыг багасгах, хориглоход нөлөөлөх бас нэгэн чухал үзүүлэлт юм. Энэ асуудлыг авилгалыг хориглоход нөлөөлөх эдийн засгийн тодорхой шийдлүүдийн байдалтай холбон авч үзвэл дараах дүр зураг харагдаж байна (Зураг 8-ыг үз). Судалгаанд оролцогсдын 58,0 % нь “Хүн бүхэнд хүн ёсны эрхэмлэх болон цээрлэх ёсыг багаас нь

төлөвшүүлэх”, 44,4 % нь “Хүнээс их хүч хөдөлмөр, мэдлэг ухаан зарж байж олж авдаг нэр хүндийг өргөж явах”, 44,5 % нь “”Ёс суртахууны үндсэн зарчмуудыг аливаа үйл ажиллагаанд эрхэмлэл болгох”, 38,3 % нь “Өөрийн зан байдлыг шүүн тунгаах, өөртөө хандах ёс суртахууны үнэлэлтийг дээшлүүлэх” зэрэг саналуудыг өгсөн байна. Хувь хүний багын хүмүүжил, ёс суртахууны эрхэм байдлаа хадгалж чадах зориг, ухамсар авилгалыг болон ер нь аливаа гэмт үйлдлийг газар авахуулахгүй байх ёс суртахууны гол хүчин зүйл болдог байна. Сонгож авсан үзүүлэлтүүдийн ихэнх нь хоорондоо ойролцоо үр дүнг харуулсан байгаа нь сонирхолтой.

Мөн харьцуулан харах үүднээс авилгалыг багасгах, хориглоход нөлөөлөх эдийн засгийн хүчин зүйлсийг Зураг 8.-д хамтад нь харуулсан. Эдийн засгийн хүчин зүйлсийн талаар судалгаанд оролцогсдын 62,1% нь “Иргэдийн орлогыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах”, 33,1% нь “Төсвийн зөв зохистой зарцуулалтыг бий болгох, хяналтыг сайжруулах”, 27,4% нь “Эдийн засгийн шудрага өрсөлдөөнийг зах зээлд бий болгох”, 23,7% нь “Татварын зөв, зохистой бодлого боловсруулах”, 15,8% нь “Хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх” гэсэн санал дүгнэлтүүдийг тус тус хийжээ.

Ерөнхийдөө эдийн засгийг либеральчлах нь авилгалын эсрэг гол хүчин зүйл гэдэг нь дээрхээс харагдана. Үүнийг чанарын судалгааны дүнгээр улам баталгаажуулсан. Авилгалын асуудлыг олон талаас нь авч үзэхэд олон нийтийн санаа бодлын маш олон сонирхолтой дүр зураг гарч ирэх болмжтойг тоон судалгааны дээрх үзүүлэлтүүд харуулж байна.

Дүгнэлт ба зөвлөмжүүд

Энэхүү төслийн хүрээнд хийгдсэн хэд хэдэн судалгааны дүнгээс харахад Монголын нийгэмд газар авч, олон нийтийн санааг нилээд зовоож байгаа асуудал бол авилгалын асуудал гэдэг нь улам тодорхой болж байна. Ардчилал, чөлөөт зах зээлийн харилцаанд шилжсэнтэй холбоотойгоор албан тушаалын байдал, төрийн өндөр алба хашиж байгаагаа ашиглан хувьдаа материаллаг болон бусад ашиг хонжоо олох зорилгоор бусдаас шан харамж авах явдал нилээд их гарах болжээ. Зах зээлд шилжих шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээл, хууль хяналт шалгалтын систем дутагдалтай байсан нь авилгалын бодит байдлыг улам бүр ноцтой хэмжээнд хүртэл хурцдуулсан ба энэ нь жирийн ард иргэдийн хувьд үнэн шударгаар аж амьдралаа сайжруулах боломжийг улам бүр хааж, төрийн ард түмний төлөө үйлчлэх эрхэм үүргийг ганхуулахад хүрсэн юм.

Авилгалын байдлыг аль нэг нам, улс төрийн хүчнүүд дагнаж хөгжүүлээд байгаа бус, харин нийгэм, эдийн засгийн нилээд гүн гүнзгий учир шалтгаантай байгаа юм. Иймд энэ асуудлыг шийдэхэд зөвхөн жирийн ард иргэд хүсэх нь хангалттай бус, төр засгийн оролцоо, улс төрийн өндөр албан тушаалтнуудын сэтгэл, санаачлага, хариуцлага байж гэмээ нь шийдэгдэх асуудал болжээ.

Авилгалын асуудлыг цаг хугацааны хувьд авч үзвэл чөлөөт зах зээл хөгжиж, өмчийн олон хэлбэр бий болсон тэр үетэй л давхцаж байгааг энэ талаар гарсан олон судалгааны материалууд нотлож байна. Төслийн хүрээнд судалгааны багынхан авилгалын асуудлаар манай орнд хэвлэгдэж гарсан 130 гаруй ном зохиол, судалгааны материалуудыг олж танилцах явцад эдгээр ажлууд нь 1990-ээд оны дунд үеэс л гарч эхэлсэн байх ба жил өнгөрөх тусам энэ талын материал улам их хэвлэгдэх болж янз бүрийн санхүүжилтээр судалгааны ажлууд ч их хийгдэх болжээ. Хэрэв энэ талын материалууд улам олширч, анхааруулга сануулга нь их болж байгааг өнгөн талаас нь авч үзээд дүгнэвэл энэхүү асуудал жилээс жилд харин улам хүчээ авч эрчимжиж байна

гэж хэлж болох юм. Бид авилгалын байдал, түүнийг дэмжигч болон хориглогч хүчин зүйлсийг авч үзэхдээ тоон болон чанарын судалгаандаа түшиглэн үнэлэлт тодорхой дүгнэлтүүдийг хийсэн болно.

Төслийн багийнхан 500 гаруй хүнийг хамарсан тоон судалгаа, 4 фокус группэд хуваагдсан 32 хүн дээр чанарын судалгаа хийсэн. Бидний хийсэн энэ хоёр судалгаанд ч, бидний судалгаанаас өмнө, 1999 оноос эхлэн МННХ, МҮХАҮТ, Транспэренси Интернэйшнл байгууллага, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг зэрэг байгууллагуудын санхүүжилтээр хийгдсэн томоохон судалгаануудад ч оролцогсодын 94%-96.6% нь монголд авилгал газар авсан гэж үзсэн¹ нь өнөөгийн нийгэмд авилга хээл хахуулийн асуудал асар их болж нийгмийн гамшиг гэж хэлж болохуйц хэмжээнд хүрснийг харуулж байна. Авилга хүмүүсийн амьдралын нэг хэсэг нь болж хувирсныг дээрхи асар өндөр хувь хэмжээ нотлон харуулж байна. Тэгэхээр өнөөдөр бидэнд авилгын асуудал хэр зэрэг түвшинд байна вэ гэж тогтоох биш харин яаж газар сайгүй оршчихсон энэ үзэгдлийг арилгах вэ гэдэг л бодох асуудал болжээ.

2006 онд батлагдсан Авилгалын эсрэг хуульд хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсвэл бүртгүүлээгүй буюу санаатай худал мэдүүлсэн бол энэ нь түүнийг албан тушаалаас нь огцруулах, түдгэлзүүлэх, халах үндэслэл болно гэсэн нь өмнөх хуулийн заалтаас илүү оновчтой шийдэл болсон гэж үзүүштэй байна. Мөн дээрхи хуульд хээл хахуулийн болон авилгалын шинжтэй бусад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хуулийн зохих зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ гэжээ. Ийм арга хэрэгслэл нь хир зэрэг үр дүнтэй байж чадах вэ. Олон нийт хуучин захиргаадалт, дарангуйлагч нийгмээ санагалзаад байгаа юм биш биз. Мэдээж хуулийн заалтыг цаг үетэйгээ тохируулж өөрчлөх нь гарцаагүй боловч хүний эрхийг дээдлэдэг нийгмийн байгуулал маань олон түмний хүсээд байгаа шиг тийм хатуу заалт бүхий хуулийг гаргах бололцоо олгохгүй л болов уу. Хийсэн хэрэгтээ ял шийтгэл нь тохирсон байх гэдэг нь ардчилсан төрийн нэг зарчим шүү дээ.

Тэгэхээр бид яах хэрэгтэй вэ?

Үүнд хууль, хяналтын байгууллага үүргээ шударгаар биелүүлдэг байлгах талаар хамгийн их анхаарах ёстой байна. Авилгалаас сэргийлүүлж байх ёстой, хуулиа ягштал мөрдөж байх ёстой энэ байгууллагын үйл ажиллагаанд олон түмэн маш сэтгэл дундуур байдаг нь илт байна.

Авилгалыг илрүүлэх ёстой байгууллага нь өөрөө авилгад идэгдсэн гэж 26.4%, албан тушаалтнуудад хууль үйлчилдэггүй тогтолцоо хэвшмэл болсон гэж 25.6% нь үзэж байгаа нь нийт оролцогчдын 52.0% болж байгаа юм. Бидний судалгаан дээр та өөрөө авилгал өгөх тохиолдол гарч байсан байгууллагыг нэрлэнэ үү гэсэн асуултанд нийт оролцогчдын 28.4% нь хууль сахиулах байгууллагад гэж хариулсан байна. Гэвч энэ хариултанд заавал тооцож үзэх зүйл бол жирийн иргэн бүр хууль хяналтын байгууллагатай орооцолдоод байдаггүй, өөрөөр хэлбэл гэмт хэрэг ч гэх юм уу шүүх цагдаагаар явах шаардлага гараад байдаггүй явдал юм. Тэгэхээр 28.4% гэж байгаа нь энэ байгууллагад авилга бага байгааг харуулах бус харин ч энэ байгууллагаар ажил хөөцөлдөх хэрэгцээ гарсан хүмүүсийн тоотой харьцуулбал маш өндөр байж болох юм. Тэгэхээр энэ байгууллагыг өөрийг нь яаж цэвэрлэх вэ гэдэг нь өөрөө шийдэх ёстой асуудал санагдана. Хэрэв энэ

¹ Г.О.О. Аавчлалын өснө: нөөчлэлд өснө, 2002, Г.О.О. Бизнесийн хүрэн дэх авилгал: нөөчлэлд, 2000, Г.А.О. Аавчлалын өснө: нөөчлэлд өснө, 2005, Г.А.О. Аавчлалын өснө: нөөчлэлд өснө, 2006, Г.А.О. Аавчлалын өснө: нөөчлэлд өснө, 2005.

салбарт байдал сайжирвал нийгэмд авилгал алга болох хамгийн чухал нөхцөл бүрэлдэх юм.

Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм батлаж мөрдөхийг маш их болон их ач холбогдолтой гэж судалгаанд оролцогчдын 84.0% нь үзэж байна. Мэдээж хэрэг төрийн албан хаагчдын хүний гар харсан сэтгэлгээг өөрчлөх ёстой. Гэхдээ энэ нь ямар нэгэн дүрэм журам гаргасанаар шийдэгдэх үү?

Олон нийтийн дунд авилгалыг хориглох талаар сургалт сурталчилгаа сайн хийх нь тодорхой үр дүнд хүрч чадах уу? Судалгаанд хамрагдагсад тодорхой хэмжээгээр ач холбогдол өгч байна. Гэхдээ хатуу чанга хууль батлаж мөрдүүлэх, авилга авч өгсөн нь нэгэнт тогтоогдсон хүмүүст хүлээлгэх шийтгэлийг чангатгах зэрэг асуултанд хариулсан байдалтай харьцуулбал арай бага санал өгч байна. Харин сонирхолтой нь тэд ийм сургалт сурталчилгаа явуулах аргыг авилгалын эсрэг тусгай байгууллага байгуулж ажиллуулахаас ч илүү үр дүнд хүрэх байх гэсэн төсөөлөлтэй байна. Мэдээж, иргэдэд авилгал өгч авалцсанаар нийгэмд, нийгмийн хөгжилд ямар их хохирол учруулж болох, өөрөө болон өрөөл бусдыг ямар хүнд байдалд оруулж болохыг ойлгуулж таниулж байх нь тодорхой үр дүнд хүргэнэ гэж судалгааны багийнхан ч гэсэн үзэж байна.

Хүснэгт ба Зураг

<i>Хүснэгт 1. Судалгааны түүврийн хэмжээ</i>		
Аймгууд	Сум, дүүрэг	Хамрагдсан хүний тоо
Орхон	Баян-Өндөр	36
	Завхан	19
Хөвсгөл	Дөрвөлжин	16
	Мөрөн	29
	Их-Уул	1
	Хатгал	1
Архангай	Жаргалант	36
	Эрдэнэбулган	2
	Цэнхэр	1
	Хашаат	2
Ховд	Жаргалант	43
Говь-Алтай	Жаргалант	14
	Есөнбулаг	21
Дорнод	Хэрлэн	33
Өвөрхангай	Тарагт	24
	Арвайхээр	6
Улаанбаатар	Баянзүрх	14
	Баянгол	78
	Сонгинохайрхан	35
	Чингэлтэй	8

Хан-Уул	9
Сүхбаатар	63
Налайх	1
Багануур	1
Бүгд	493

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд, хүйсээр

Машин тоног төхөөрөмжийн ажилтан/засварчин/жолооч	8.6	0.8	4.7	23
Бусад	4.1	7.2	5.7	28
Мэргэжилгүй	16.0	16.1	16.0	79
Ажил эрхэлж буй салбар				
Төрийн байгууллага	44.3	49.4	46.9	231
Хувийн хэвшил	19.3	20.1	19.7	97
Төрийн бус байгууллага	5.7	5.6	5.7	28
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	19.3	13.7	16.4	81
Ажилгүй	11.5	11.2	11.4	56
Ам бүлийн тоо				
1	6.1	2.0	4.1	20
2-4	50.0	56.2	53.1	262
5 ба түүнээс дээш	43.9	41.8	42.8	211
Өрхийн сарын дундаж орлого				
50000 төгрөг хүртэл	13.9	14.1	14.0	69
50001-100000	31.1	33.3	32.3	159
100001-250000	37.7	40.2	38.9	192
250001-500000	14.8	9.2	12.0	59
500001 төгрөгнөөс дээш	2.5	3.2	2.8	14
Нийт	100.0	100.0	100.0	493

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, иргэдийн эрх, үүргээ ухамсарладаггүй байдал, хуулийн талаарх мэдээлэл хомс байдал нь авилгалыг өөгшүүлэгч нэг хүчин зүйл болж байгаа гэдэгтэй санал нийлж байгаа эсэхээр

Үзүүлэлтүүд	Нийлнэ	Нийлэхгүй	Хэлж мэдэхгүй байна	Нийт	Тоо
Хүйс					
Эрэгтэй	77.5	14.3	8.2	100.0	244
Эмэгтэй	81.5	10.4	8.0	100.0	249
Боловсролын түвшин					
Бүрэн дунд	79.2	9.2	11.7	100.0	120
Тусгай дунд	82.1	10.7	7.1	100.0	84
Дээд	78.9	14.2	6.9	100.0	289
Ажил эрхэлт					
Төрийн байгууллага	77.5	14.7	7.8	100.0	231
Хувийн хэвшил	83.5	10.3	6.2	100.0	97
Төрийн бус байгууллага	78.6	14.3	7.1	100.0	28
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	80.2	11.1	8.6	100.0	81
Ажилгүй	80.4	7.1	12.5	100.0	56
Өрхийн сарын дундаж орлого					
50000 төгрөг хүртэл	78.3	7.2	14.5	100.0	69

50001-100000	81.8	11.9	6.3	100.0	159
100001-250000	78.1	14.6	7.3	100.0	192
250001-500000	79.7	15.3	5.1	100.0	59
500001 төгрөгнөөс дээш	78.6	-	21.4	100.0	14
Бүгд	79.5	12.4		100.0	493

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалыг өөгшүүлэгч хүчин зүйлүүдийн нэг нь төрийн иргэдэд үйлчилэх үйлчилгээний олон шатлалт механизм түүнээс урган гарах хүнд сурталт тогтолцоо гэдэгтэй санал нийлж байгаа эсэхээр

Үзүүлэлтүүд	Нийлнэ	Нийлэхгүй	Хэлж мэдэхгүй байна	Нийт	Тоо
Хүйс					
Эрэгтэй	87.7	7.0	5.3	100.0	244
Эмэгтэй	87.6	5.2	7.2	100.0	249
Боловсролын түвшин					
Бүрэн дунд	83.3	8.3	8.3	100.0	120
Тусгай дунд	88.1	7.1	4.8	100.0	84
Дээд	89.3	4.8	5.9	100.0	289
Ажил эрхэлт					
Төрийн байгууллага	83.5	8.7	7.8	100.0	231
Хувийн хэвшил	92.8	5.2	2.1	100.0	97
Төрийн бус байгууллага	96.4	3.6	-	100.0	28
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	91.4	3.7	4.9	100.0	81
Ажилгүй	85.7	1.8	12.5	100.0	56
Өрхийн сарын дундаж орлого					
50000 төгрөг хүртэл	82.6	8.7	8.7	100.0	69
50001-100000	86.2	5.0	8.8	100.0	159
100001-250000	91.1	5.7	3.1	100.0	192
250001-500000	84.7	8.5	6.8	100.0	59
500001 төгрөгнөөс дээш	92.9	-	7.1	100.0	14
Бүгд	87.6	6.1	6.3	100.0	493


Хүснэгт 5. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалын хэрэг илрүүлэлт хангалтгүй байгаад нөлөөлж буй шалгаан, сонгосон үзүүлэлтүүдээр


Үзүүлэлтүүд	Албан тушаалтнуудад хууль үйлчилдэггүй тогтолцоо хэвшмэл болсноос	Авилгалыг илрүүлэх төрийн байгууллагууд авилгалд идэгдсэн	Авилгалын талаарх хууль, эрхзүйн систем бэхжээгүй	Хүмүүсийн ёс суртахуун доройтож, нийгмээрээ авилгал өгөх, авах сэтгэлгээнд автсан	Бусад
Хүйс					
Эрэгтэй	26.6	26.6	21.7	23.4	1.6
Эмэгтэй	26.1	24.5	18.5	30.5	0.4
Боловсролын түвшин					
Бүрэн дунд	31.7	17.5	15.0	34.2	1.7
Тусгай дунд	25.0	27.4	20.2	26.2	1.2
Дээд	24.6	28.4	22.1	24.2	0.7
Ажил эрхэлт					

Төрийн байгууллага	21.6	24.2	23.8	29.9	0.4
Хувийн хэвшил	24.7	33.0	13.4	27.8	1.0
Төрийн бус байгууллага	25.0	32.1	21.4	21.4	-
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	39.5	21.0	21.0	16.0	2.5
Ажилгүй	30.4	21.4	14.3	32.1	1.8
Өрхийн сарын дундаж орлого					
50000 төгрөг хүртэл	33.3	27.5	8.7	27.5	2.9
50001-100000	25.8	28.3	15.1	29.6	1.3
100001-250000	22.9	23.4	27.1	26.0	0.5
250001-500000	30.5	20.3	23.7	25.4	-
500001 төгрөгнөөс дээш	28.6	35.7	21.4	14.3	-
Бүгд	26.4	25.6	20.1	27.0	1.0

<i>Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгал авдаг төдийгүй өгдөг этгээдэд хүлээлгэх шийтгэл бий болгох гэсэн хүчин зүйлийг үнэлсэн байдлаар</i>					
Хүчин зүйлсийн ач холбогдолыг үнэлсэн байдал					
Үзүүлэлтүүд	Маш их ач холбогдолтой	Ач холбогдолтой	Дунд зэргийн ач холбогдолтой	Ач холбогдолгүй	Хэлж мэдэхгүй байна
Хүйс					
Эрэгтэй	43.9	28.7	9.0	9.4	9.0
Эмэгтэй	48.6	30.5	6.4	8.0	6.4
Боловсролын түвшин					
Бүрэн дунд	43.3	32.5	7.5	10.0	6.7
Тусгай дунд	44.0	28.6	7.1	9.5	10.7
Дээд	48.1	28.7	8.0	8.0	7.3
Ажил эрхэлт					
Төрийн байгууллага	48.9	29.4	7.4	9.1	5.2
Хувийн хэвшил	45.4	28.9	5.2	11.3	9.3

Төрийн бус байгууллага	39.3	35.7	14.3	3.6	7.1
Хувиараа хөдөлмөр					
эрхэлдэг	40.7	24.7	12.3	7.4	14.8
Ажилгүй	48.2	35.7	3.6	7.1	5.4
Өрхийн сарын дундаж орлого					
50000 төгрөг хүртэл	39.1	33.3	2.9	10.1	14.5
50001-100000	47.2	30.8	6.9	8.2	6.9
100001-250000	46.4	30.7	7.8	8.9	6.3
250001-500000	52.5	16.9	15.3	8.5	6.8
500001 төгрөгнөөс дээш	42.9	35.7	7.1	7.1	7.1
Бүгд	46.2	29.6	7.7	8.7	7.7





Ном зүй

Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага хурал.: Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхэтгэл, УБ., 2003

Дэлхийн банк, “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл, УБ., 2004.

Жереми Поуп, Авилгалын эсрэг сурвалж бичиг, УБ., 2003.

ЗГХЭГ-ын Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийг дэмжих төслийн удирдлагын нэгж”, Хяналт-шинжилгээ, үнэлгээ: Шалгуур үзүүлэлт, явц, үр дүн, 2002.

Зориг сан, Авилгал ба төрийн албан хаагчид” төслийн тайлан, УБ., 2001

Зориг сан, Боловсролын байгууллага дахь авилгал, 2006.

Зориг сан, Ерөнхийлөгчийг огцруулсан сэтгүүлчийн нэр их хөдөлмөр:
эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан гарын авлага, 2004.

Зориг сан, “Өнөөдөр эсвэл хэзээ ч ...”, 2002.

Зориг сан, Сайн засаглал, 2002.

Марк Грамбергер, Иргэн түншлэгч болох нь: Бодлого боловсруулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг оролцуулах, 2003.

Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг: тайлан, 2004.

Мораль в политике: хрестоматия, Изд.МГУ., ред. Б.Г.Капустин, М., 2004.

МҮХАҮТ, Авилгалын индекс: судалгааны тайлан, 2002.

МҮХАҮТ, Авилгалын эсрэг тэмцэлд хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоог эрчимжүүлэх нь: товхимол, 2002

МҮХАҮТ, Бизнесийн хүрээн дэх авилгал: судалгаа, 2000.

Нарангэрэл С., Амьд эрх зүй, УБ., 2002.

НҮБХХ, Авилгалтай тэмцэх үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт: харьцуулсан судалгаа, 2005.

НҮБХХ, Авилгалын эсрэг хамтдаа: орон нутагт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, 2006.

Нээлттэй нийгэм форум, Монгол дахь авилгалын асуудалд холбогдох ном зүй, 2005.

ОУХА, Монгол улс дахь авилгалын байдалд хийсэн үнэлгээ: эцсийн тайлан, 2005.

Памела Слуц, Монголд авилга байгаад зогсохгүй улам томорч байна, Өдрийн сонин, Илгээлт, 2005.05.13, ¹ 115, 3-р нүүр.

Самбалхүндэв Ц., Оюунтуяа Ж., “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал” хөтөлбөрийн бодлогын баримт бичиг, 2001

Democratic Club, DK-Dialog, Vol. X, No.1 (English version), Prague, April 2003.

National Statistical Office of Mongolia (2004): Mongolian Statistical Yearbook 2003, 2006.

UNDP, Human Development Report, 2002, 2003

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН СИСТЕМИЙН ӨӨРЧЛӨЛТ БА ЭЛИТҮҮД

Ч.Өлзийсайхан
докторант, ахлах багш
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Улс төрийн систем нь тодорхой цаг үеүүдэд нийгэм бүхэлдээ хүлээн авч байгаа бодлого, чиг үүрэг, харилцааны хэлхээс юм. Улс төрийн системийн талаар Г.Алмонд, Дж.Пауэл, Д.Истон, Р.Даль гэх мэт олон эрдэмтэд өөрсдийн загварыг гаргаж түүний бүтэц, институтуудынх нь харилцан хамаарал, үүргээ гүйцэтгэх арга механизмыг тодорхойлж, харьцуулан судалж байсан билээ. Судлаачид улс төрийн системүүдийн ялгааг тайлбарлахдаа ардчилсан дэглэмүүдийг дарангуйлагч дэглэмүүдтэй, нэг намын системийг олон намын системтэй, парламентын системийг ерөнхийлөгчийнхтэй, тогтвортой засгийн газруудыг тогтворгүйтэй нь гэх мэтээр харьцуулан үзсэн байх нь элбэг. Харин улс төрийн тоталитари системээс ардчилсан системд шилжих шилжилт нь монголын нийгэм, улс төрийн амьдралд, түүний дотор улс төрийн элит давхаргад хэрхэн нөлөөлж байгааг судлах нь манай улс төр судлаачдын өмнө тавигдаж байгаа нэг томоохон асуудал болов уу гэж үзсэний үндсэн дээр үүнд өөрийн өчүүхэн ч болов хувь нэмрийг оруулах гэж энэхүү өгүүллийг бичиж байгаа билээ. Гэхдээ судалгааны ажилдаа тодорхой чиг шугам барих үүднээс, олон зүйл рүү хэт их хальтарч орохгүйн тулд Г.Алмонд, Дж.Пауэл нар улс төрийн системийн өөрчлөлт, бүтэц, чиг үүргийн талаар баримталж байсан тэр хүрээнд асуудлыг авч үзэж, тодруулахыг хичээсэн болно. Үүнд:

- Улс төрийн байгууллагууд засаглалын институтуудын өөрчлөлт
- төрийн институтууд, тэдэнд нөлөөлж байдаг нийгмийн бүлгүүдийн хоорондын харилцаа
- Улс төрийн субъектуудын хоорондын харилцаан дахь хэм хэмжээ
- Улс төрийн үйл байдлын эх үүсвэр болох бие хүний асуудал
- Төр засагт хандах, ашиг сонирхлоос үүдэлтэй хүмүүсийн улс төрийн ухамсар, үйл ажиллагаа

гэсэн хүрээг хамруулсан юм.

Түүхийн янз бүрийн үе дэх улс төрийн систем, түүнд улс төрийн элит давхарга бүрэлдэн тогтох, үүргээ гүйцэтгэх арга механизм, улс төрийн чиг бодлого нь өөр өөр байсан билээ. Монгол улс өөрийн түүхэнд хүн төрөлхтөний нэгэн адил янз бүрийн улс төрийн системийг дамжин хөгжиж байна. Улс төрийн системийн бүтэц, удирдлага, улс төрийн элитүүдийн зорилго

өөрчлөгдсөн нь улс төрийн нэг хэсэг институтуудын оронд өөр институтууд түргэн зуур гарч ирэх үйл явцыг нөхцөлдүүлсэн юм. Улс төрийн системийн бүтэц, түүний өөрчлөлт нь улс төрийн элитүүдийн үйл ажиллагаатай ямар уялдаа холбоотой байж болох вэ?

Энэ асуултанд хариулахын тулд юуны өмнө улс төрийн байгууллагууд, нийгмийн процессийг удирдагч, зохицуулагч олон түмний засаглалын институтууд нь улс төрийн элитүүдэд хэрхэн нөлөөлсөн бэ гэдгийг тодруулахыг хичээе. 1990 оны ардчилсан хувьсгал нь нийгэм улс төрийн тогтолцоог үндсээр нь өөрчлөх эхлэлийг тавьсан билээ. Энэ үйл явцын өрнөлтийн үр дүнд 1990-3-22-нд АИХ-ын чуулганаар “төр нийгмийг удирдан чиглүүлэх хүч бол МАХН мөн” гэсэн үндсэн хуулийн заалтыг хасч, олон намын системийг хүлээн зөвшөөрсөн нь улс төрийн шинэ системийг бүрэлдүүлэн тогтооход томоохон ач холбогдолтой үйл явдал болсон юм. 1990-3-28-нд БНМАУ-ын сонгуулийн тухай хууль батлагдаж, 1990-5 сард төрийн дээд байгууллагын бүтцийг өөрчлөв. 1990-5-16-нд БНМАУ-ын дээд шүүх МАХН, МҮДН, МЧХН, МСДН, МНН-г бүртгэснээр олон намын систем бий болов. Эдгээр өөрчлөлтийн дүнд Монгол улсын төрийн эрх барих дээд байгууллага АИХ, хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах байнгын байгууллага УБХ, Ерөнхийлөгчийн албан тушаалыг бий болгож СнЗ-ийг Засгийн Газар болгон өөрчлөв. Энэ дараалсан том өөрчлөлтүүд нь Монгол Улсын улс төрийн системийг шинэчлэх үйл явцад чухал үүрэг гүйцэтгэсэн үйл явдлууд болсон бөгөөд улс төрийн харилцааны шинэ зохицуулалт нь өөр шинэ харилцааны эх үүсвэр болж улмаар улс төрийн цоо шинэ хэв маягийн элитүүд төлөвшин гарч ирэх үндэс суурь болсон билээ. 1990-ээд оны дунд үе гэхэд улс төрийн хуучин системээс нөгөөд шилжих шилжилтийн үеийг нэгэнт туулж, 1992 оны үндсэн хуулийн шинэ үзэл санаа, шинэ зарчмууд нь улс төр, нийгэм эдийн засаг, соёлын салбарт нэвтэрснээр нийгэм шинэ бүтэц, тогтолцоотой болж ирсэн юм. Орчин үеийн Монгол улсын улс төрийн амьдралын онцлог нь ашиг сонирхлоо хамгаалахын тулд эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх зэргээр чөлөөт үйл ажиллагаа явуулах эрх бүхий иргэдийн олонхийн саналаар, тодорхой хугацаагаар, хязгаарлагдмал эрхтэй сонгогддог хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн нарийн хуваарьт үндэслэсэн тогтолцоо бүхий төр засаг бодитой оршин тогтнох болсноор тодорхойлогдоно. 1990-3-28-нд БНМАУ-ын иргэний эрхийг хохироосон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай хууль батласан нь бюрократ, элит давхаргын зүгээс иргэдийг хохироож мэдэх үйлдлээс олон түмнийг хамгаалах боломжийг олгосон чухал арга хэмжээ болжээ.

1992 онд хуралдсан АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2-р хуралдаан МУ-ын түүхэнд байгаагүй удаан буюу 76 хоног хуралдаж үндсэн хуулиа батласан нь хуучин тоталитари нийгмийн, номенклатур элитүүд ардчилсан шинэ элитүүдэд байраа тавьж өгөх үйл явцыг баталгаажуулж өгөв. Энэ хуралдааны үйл явц нь улс төрийн шийдвэр гаргах үйл явцад эрх баригч элитүүд болон эрх баригч элитийн байр сууринд хэлбэрийн төдий сонгогдсон эрх баригч бус элитүүд гэсэн хоёр өөр бүлгийн зааг ялгааг, шинэ хуучин хоёр өөр улс төрийн системийн ялгааг тодорхой харуулж байсан билээ. Тухайлбал АИХ-ын чуулганд 430 орчим депутат оролцож байснаас 20-иодхон хүн л хамгийн олон удаа үг хэлж өөрсдийн үзэл бодлыг илэрхийлж байсан бол үлдэх хэсэг нь ардчилсан нийгэмд улс төрийн элитүүдэд байх тэр шинжийг төдийлөн өөртөө харуулж чадахааргүй байсан тал ажиглагддаг бөгөөд учрыг олж хужирыг нь тунгаах байдалд зарим талаар хүчин мөхөсдөж байсан болов уу.

УИХ эрх зүйт төрийн хэм хэмжээнд нийцүүлэн төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч бүх бүрдлийн тухай хуулиудыг хэлэлцэн батлаж, тэдгээрийн дагуу уг бүтцүүдийг шинээр бий болгон зохион байгуулж ажиллуулжээ. УИХ төрийн албаны болон төрийн хяналт шалгалтын тухай хуулиудыг батлаж төрийн алба, төрийн хяналтын байгууллагууд үйл ажиллагаагаа эдгээр хуулийн хүрээнд явуулж эхэлсэн байна.

Улс төрийн системийг өөрчлөх үйл явцад чухал үүрэг гүйцэтгэсэн институци болох УБХ-ын сонгуульд ард түмэн нэг талаас шинэ улс төрийн хүчнийг эрэлхийлсэн, нөгөө талаас хуучин эрх баригч элитүүддээ дассан шинжтэйгээр сонгуульд оролцож үр дүнд нь МАХН давуу эрхийг олж авч байсан бол 1996 оны сонгуулиар МАХН цөөнхи суудлыг авав. Энэ нь олон намын тогтолцооны үед аль нэг нам дангаараа байнга ноёрхох бололцоогүй, улс төрийн элитүүд хугацаагүй, үе залгамжилсан байдлаар эрх барих боломжгүй болсныг харуулж, улс орны хувь заяа, эдийн засаг, нийгмийн асуудалд эрх баригч болон сөрөг хүчний байр суурины алинд нь ч шилжиж болох, үүнийг гагцхүү ард түмний сонголт л шийдэж өгөхийг нотлосон юм. Парламентын энэ сонгууль бол нийгмийн цоо шинэ тогтолцоонд орох үеийн хүндрэл бэрхшээлээс түргэн гарах арга замыг эрэлхийлсэн, энэ замд зөв удирдан, чиглүүлж чадах шинэ элитийг эрж хайсан сонголт болсон юм. Энэ сонгууль нь эрх баригч элитээ сонгох иргэдийн эрхийн хэрэгжилт болж ард түмний бүрэн эрхэт байдлыг илтгэж өгч, сонгуулийн шударга шинж, гүйцэтгэх засаглалаа эмхлэн байгуулах үйл явц нь ардчилсан нийгмийн индикаторт бүрэн зохицсон байсан билээ. Ардчиллын институциональ хэмжүүр болох

- Улс төрийн оролцооны өрсөлдөөн
- Улс төрийн оролцооны хяналт
- Гүйцэтгэх засаглалыг бүрдүүлэх өрсөлдөөн
- Гүйцэтгэх засаглалыг бүрдүүлэх нээлттэй байдал
- Гүйцэтгэх засгийн тэргүүний үйл ажиллагааны хязгаарлалт

энэ бүгд сонгуулийн үед болон үр дүнд бодитой зүйл болжээ. Ард түмэн ардчилсан сонгуулийн утга учир, үр ашгийг ойлгох болж шинээр бий болсон төрийн удирдлагадаа дарамт шахалт үзүүлэх эрхтэйгээ ч мэдэрч эхэлсэн билээ. Жишээ нь, Монголын ард түмний шударга тэмцлийг дэмжих түр хороо, Монголын оюуны соёлыг хамгаалах холбоо, Монголын залуучуудын нэгдсэн холбоо, МАСЗХ, Монголын нэгдсэн хөдөлгөөн, Гэр хороололд амьдрагсадын холбоо, Худалдаа нийтийн хоолны ажилтан, ажилчдын холбоо, Монголын эмзэг бүлгийн ажил хэрэгч эмэгтэйчүүдийн холбоо гэх мэт байгууллагууд ард түмнийхээ үгийг сонсдоггүй, ёс суртахууны доройтолд орсон УИХ-ыг тараах, шинээр парламентын сонгууль явуулах, зарим намыг УИХ-аас гишүүдээ татахыг уриалах зэрэг шаардлагуудыг тавьж тэмцэж байв. Эдгээр нь ардчилсан нийгмийн үед эрх баригч элитүүд ард түмний хараа хяналтаас хол байх ямарч аргагүйг нотлож, иргэд нь иргэний болон улс төрийн үндсэн эрхээ эдлэдэг болохыг харуулж өгсөн юм.

Улс төрийн систем дэх улс төрийн элитүүдийн байдлыг тодруульа гэвэл төрийн институтууд, тэдэнд нөлөөлж байдаг нийгмийн бүлгүүдийн хоорондын харилцааг авч үзэхээс өөр аргагүй. Улс төрийн систем бол нийгэм, түүнийг бүрдүүлж байдаг бүлгүүдийн хамтын зорилгыг томъёолж, амьдралд хэрэгжүүлдэг институтууд байгууллагуудын нийлбэр цогц юм. Төр, төрийн байгуулалтыг бүрдүүлж байгаа институтууд нь чиг бодлогыг боловсруулдаг улс төрийн системийн үндсэн гол хэсгүүд юм. Өнөөгийн монголын нийгмийн улс төрийн системийн бүтэц, түүний институтууд, байгууллагуудын хоорондын харилцаа холбоог гаргахдаа 1990 оноос өмнөх үеийнхтэй нь харьцуулж үзвэл ямархуу хэмжээний өөрчлөлт хийгдсэн байна вэ гэдэг нь тодорхой харагдах

юм. 1990 оноос өмнөх үе нь хүнд сурталт, захиран тушаах тогтолцоо нэгэнт бүрэлдэн тогтсон, МАХН-ын нэрээр бамбай хийж төрийн дээд удирдлагад байсан эрх баригчид хяналтгүй захиргаадаж байсан үе юм. Нам, төрийн ажлын зааг ялгаа алга болж төр олон нийтийн байгууллагын бие даасан байдал алдагдаж, нэг намын үйл хэрэгт үйлчлэгчид болсон байв. БНМАУ-ын үндсэн хуульд “БНМАУ-ын төр нийгмийг удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч марксист-ленинист онолыг үйл үйл ажиллагаандаа удирдлага болгодог МАХН мөн” гэж заасан нь МАХН-аас бусад нийгэм дэх янз бүрийн бүлэглэлийн эрх чөлөөг хаасан, нэг намын хязгааргүй ноёрхлыг үндсэн хуулийн хүрээнд баталгаажуулж өгсөн хэрэг байлаа.

Төрийн байгууллагын бүтцийг авч үзвэл төрийн эрх барих дээд байгууллага нь БНМАУ-ын АИХ байв. АИХ нь бүх шатны АДХ-ын системийг толгойлж, улс орныг төрийн зүгээс удирдах бүрэн эрхийг хэрэгжүүлж байв. Төрийн бусад дээд, төв байгууллагуудыг шууд байгуулж, үйл ажиллагааг нь хянаж удирдан, Үндсэн хууль болон бусад хуулийг батлах эрх эдлэж байв. АИХ-ын чуулганы чөлөөт цагт түүний сонгосон байгууллага БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид нь төрийн эрх барих байнгын дээд байгууллагын бүрэн эрхийг хэрэгжүүлж байв. Түүний бүрэлдхүүнд АИХ-ын тэргүүлэгчдийн дарга, орлогч дарга нар, нарийн бичгийн дарга, тэргүүлэгч гишүүд орж байв. Мөн АИХ-д Мандатын комисс, төлөвлөгөө төсвийн, хуулийн төсөл боловсруулах, үндэсний асуудлын, хөдөө аж ахуйн, аж үйлдвэрийн, соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалахын, залуучуудын асуудал эрхэлсэн зэрэг байнгын комисс ажиллаж байсан юм. АИХ-ын тэргүүлэгчид нь АИХ-д ажлаа хариуцан тайлагнах ба түүний эрх хэмжээнд хамаардаг асуудлыг чуулганы чөлөөт цагт шийдвэрлэж байв. Энэ бүтцээс харахад улс төрийн эрх барьж байгаа хамгийн дээд түвшний элитүүд нь АИХ-ын депутатууд мэт харагдаж байна. Энэ нь тухайн үеийн үзэл сурталдаа тохирсон, ард түмэн засгийн эрхээ барьж байгаа гэдгийг харуулах нэг чухал зүйл байв. Гэтэл тэд үнэн хэрэгтээ эрх баригч элитүүд мөн үү гэдэг нь эргэлзээтэй асуудал юм. Үүнд, юуны өмнө эдгээр депутатууд нь өөрсдийн эрхэлсэн ажилдаа л амжилт гаргасан, нийгмийн бүтцийг тусгасан хүмүүс байсан. Тиймээс ч улс орныг удирдаж авч явахад хангалттай мэдлэг боловсролтой хэсэг маш цөөхөн хувийг л бүрдүүлж байжээ. Нарийндаа бол батлаж байгаа хуулийнхаа утга санаа, агуулгыг бүх депутатууд бүрэн дүүрэн ойлгож батлаж байсан гэдэг нь эргэлзээтэй. Нөгөө талаас хууль батлахаар цугларах цугларалт нь маш цөөхөн удаа, хэлэлцэж байгаа цаг хугацаа нь давчуу байдгаас үр дүнтэй, бүтээлч байсан гэхээсээ илүү хэлбэрдсэн шоу маягийн байсан гэдэгт л илүү дөхөж очдог. Мөн АИХ-ын тэргүүлэгчид зарлигаараа нийгэмд үйлчлэх хуулиа нэгэнт батлаад харин дараа нь АИХ-д оруулж баталгаажуулдаг байснаас харахад хууль батлах үйл ажиллагаа АИХ-аас төдийлөн хамааралгүй шийдэгдчихдэг, эрх мэдэл нь тэргүүлэгчидийнх нь гарт бодитойгоор оршиж байсныг харуулдаг.

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо нь дээд, төв, орон нутгийн байгууллага гэсэн хэсгээс бүрдэж, Сайд нарын Зөвлөл нь төрийн гүйцэтгэн захирах дээд байгууллага байв. Сайд нарын Зөвлөл нь гагцхүү БНМАУ-ын АИХ, түүний Тэргүүлэгчдийн өмнө ажлаа тайлагнаж, тэдгээрийн хууль зарлигийг биелүүлэх үндсэн дээр төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагыг нэгтгэн удирдаж байв. Үндсэн хуульд зааснаар Сайд нарын Зөвлөлийг БНМАУ-ын АИХ-ын ээлжит сонгууль бүрийн анхдугаар чуулганаас 5 жилийн хугацаатай байгуулж, бүрэн эрхийн нь хугацаа дуусмагц АИХ-ын чуулган дээр эрхээ шилжүүлж, үйл ажиллагаагаа хэлэлцүүлдэг байв. Сайд нарын Зөвлөлийн бүрэлдхүүнд Сайд нарын Зөвлөлийн дарга, 1-р орлогч дарга, орлогч дарга нар, БНМАУ-ын сайд, Улсын хорооны дарга орж байв.

АИХ нь Сайд нарын Зөвлөлийн өргөн мэдүүлснээр төрийн захиргааны бусад төв байгууллагын эрх баригчийг Сайд нарын Зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж байхаар тусгаж, Сайд нарын Зөвлөлийн эрх хэмжээний нийтлэг асуудал, бүрэн эрхийг Сайд нарын Зөвлөлийн хуулиар, төрийн удирдлагын зохих салбар хүрээнд эдлэх тодорхой бүрэн эрхийг салбарын шинжтэй бусад хууль зарлигаар нарийвчлан зохицуулж байв. Сайд нарын Зөвлөл болон түүний Тэргүүлэгчид нь өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэж байв. Сайд нарын Зөвлөлийн хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа, тэргүүлэгчдийн хуралдааныг шаардлагатай үед хийж хуралдаанаас тогтоол захирамж гаргаж байжээ.

Төрийн захиргааны төв байгууллагад яам зонхилох байр эзэлж байв. Яамд нь АИХ-аас байгуулагдаж Сайд нарын зөвлөлийн гишүүн сайд толгойлон тодорхой салбарыг удирддаг байв. Яамыг Сайд толгойлж тухайн яаманд даалгасан үүрэг зорилтыг хэрэгжүүлэх явдлыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн өмнө биечлэн хариуцахаар заажээ. Мөн төрийн захиргааны төв байгууллагад салбар хоорондын удирдлагыг хэрэгжүүлэгч улсын хороод болон тусгай газар багтаж байв. Улсын хороог АИХ-аас байгуулж төрийн захиргааны төв, орон нутгийн бусад байгууллагыг зохицуулах эрх хэмжээтэй байв. Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх тусгай газар нь төрийн захиргааны төв байгууллагын тогтолцоонд мөн багтаж байв. Эдгээр тусгай газрыг Сайд нарын Зөвлөлөөс байгуулдаг байв.

АДХ нь төрийн эрх барих анхан шатны байгууллага болж байв. АДХ нь тус тусын харьяа нутаг дэвсгэр дээр ажилладаг төрийн байгууллагуудыг толгойлж орон нутгийн эрхийг хэрэгжүүлж байсан юм. Аймаг, хотын АДХ-ын чуулганыг жилд хоёроос доошгүй удаа, сум, хороо, район, хотын АДХ-ын чуулганыг жилд 3-аас доошгүй удаа гүйцэтгэх захиргаанаас зарлан хийлгэж байв. Төрийн захиргааны орон нутгын байгууллагад АДХ-ын Гүйцэтгэх захиргаад, тэдгээрийн хэлтэс, газар, түүнчлэн яаманд шууд харьяалагдаж орон нутагт ажилладаг захиргааны байгууллагууд орж байв. Гүйцэтгэх захиргаад бол АДХ-ын гүйцэтгэн захирамжлах байгууллага бөгөөд АДХ-ын гүйцэтгэх захиргааг дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдхүүнтэйгээр байгуулж байжээ. (Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал, УБ., 1997, х.315-320)

Төрийн захиргааны дээд, төв, орон нутгийн байгууллагын сонгогдож байгаа байдал, үйл ажиллагааны хүрээ, эрх үүргийн хуваарилалт, томилж томилогдож байгаа хүмүүсийн мэдлэг чадвар, улс орны эрх ашигтай холбоотой асуудлыг шийдэх дадлага туршлагыг нь харьцуулахад эрх барих мэдэл нь АИХ-ын депутат, орон нутгийн Ардын Хурлын Депутат нарт төдийлөн оногддоггүй нь харагддаг. Тэднийг сонгохдоо дээр дурдсанчлан нийгмийн сектор бүрийг тодорхой хэсэг төлөөлөх ёстой гэж үзэж төрийн эрх барих институтэд ажилчин, малчин, сэхээтэн бүгдийнх нь төлөөлөл багтаж, боловсролд төдийлөн их ач холбогдол өгөхгүй байлаа. Эдгээр их хурлын гишүүд, депутатууд нь социалист нийгэм байгуулж, хөдөлмөрч ард түмний ардчилсан диктатур нь аажмаар ажилчин ангийн диктатур болон хувирч нийгмийг удирдах болсныг харуулж байна гэж сурталчилж байсан ч монголын нийгэмд эрх баригч элитүүд, нөөц элитүүдийг эгнээндээ багтаасан номенклатурчидын гэж нэрлэгдэх шинэ давхараа бий болж, нэг хүний дарангуйлал тогтож ирснийг хаацайлан өнгөлөн далдалсан хэрэг байлаа. АИХ ч, АДХ ч хуульд заасан бүрэн эрхээ эдэлж чадахгүй, тийм боломж ч үгүй байжээ. Элитийн онолын сонгодог төлөөлөгчийн нэг Г.Моска жинхэнэ эрх мэдэл хэний гарт байдаг вэ гэсэн асуудалд хариу өгөхдөө *de jure* байснаас *de facto* эрх мэдэлтэй байсан нь илүү гэж үзсэн байдаг (Ч.Өлзийсайхан Элит

судлал, УБ., 2006, х.35). Тэгвэл манай АИХ, АДХ-ын гишүүд депутатууд *de jure* байсан болохоос биш *de facto* эрх мэдэл байгаагүй. Нийгэм дэх янз бүрийн бүлгүүдийн хооронд өрсөлдөөн гэхээсээ социализм коммунизм байгуулах үйл хэргийн төлөө ган бат нэгдэл нягтралтай, “антогност” зөрчилгүйгээр хамтын хүчээр урагшлах нэг зорилго нь тэднийг улам ойртуулж байна гэж үзэж байв. Тэр үед нийтийн үйл хэрэг, бодол санаанаас өөрөөр байх, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь ангийн дайсан, социализмын үйл хэргээс урвасан хэрэг байсан юм. Захиргаадах аргаар хүнд суртлын механизм тогтож, нам төрийн дээд эрх мэдлийг төвлөрүүлж, намаас заавал зөвшөөрөл авч байж асуудлыг шийдэх, ард түмэн өөрөө сонгож гаргах ёстой төлөөллийг урьдчилан нэр зааж, өрсөлдөөнгүйгээр “сонгуулах” зэрэг гажуудал бий болжээ.

Тэгвэл 1990-ээд оноос хойш нийгмийн бүлгүүд, төрийн институтууд, улс төрийн элитүүд ямархуу харилцаа холбоотой байна вэ. ЗХУ болон Зүүн Европын орнуудад өрнөж байсан ардчиллын төлөөх тэмцлийн нөлөөгөөр нийгэм улс төрийн тогтолцоонд бий болсон гажуудлыг засах, ардчилал шударга ёс тогтоохын төлөө тэмцэж эхэлсэн нь юуны өмнө төрийн эрх барих байгууллагын тогтолцоог шинээр бүрдүүлэх боломжтой болгосон юм. 1990 оны 5-р сард БНМАУ-ын Үндсэн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж үүгээр нам төрийн үүргийг зааглан, улс төрийн тогтолцооны цөм нь төр байх, түүний чиг үүргийг бүх талаар өндөржүүлж, эрх хэмжээг өргөтгөх, хуулийн үүрэг ролийг хүчтэй болгох, парламентын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх, ардчиллыг хөгжүүлэх чиглэлд том алхам хийсэн юм. БНМАУ-ын АИХ-аас гадна байнгын ажиллагаатай парламент болох БНМАУ-ын Бага Хурал, төрийн тэргүүн Ерөнхийлөгчийн институт бий болгох, зэрэг асуудлыг шийджээ. Сонгуулийн үр дүнгээр шийдэгддэг төрийн өндөр дээд албан тушаалд ардчиллын хэм хэмжээ, зарчмыг мөрддөг болсноор төрийн дээд институтэд ажилчин, малчин, сэхээтэн гэсэн нийгмийн анги давхаргын бүгдийнх нь төлөөлөл багтах ёстой гэсэн муйхар тулгалт алга болж, харин улс төрийн элитэд уг хүн өөрөө хир зэрэг тохирох вэ гэдэг нь илүү чухалчлагдах болжээ. Нийгэм дэх бүлэг бүр нь гишүүнчлэлийн хувьд албадлагын шинжтэй, шатласан бүтэцтэй байсан бол ардчилсан улс төрийн систем нь энэ байдлыг өөрчилж, улс төрийн элитүүд нь аливаа нэг байгууллагын гишүүнчлэлийн асуудлыг өөрсдийгээ дэмжүүлэхийн тулд, өөртөө татахын тулд ашиглаж чадахаас биш албадах боломжгүй болсон байна. Өөрөөр хэлбэл ямар ч улс төрийн элитүүд бүлэглэлүүдийг хянах боломжгүй болжээ. Ингэснээр аливаа сонирхлын бүлгүүд эрх баригч элитээс хамааралгүйгээр ашиг сонирхлын артикуляци хийх боломж нээлттэй болсон байна.

АИХ УБХ-ыг байгуулсан бөгөөд энэ нь хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрх бүхий төрийн эрх барих байнгын дээд байгууллага болов. УБХ нь парламентын үндсэн хэлбэр болж улс төрийн намууд сонгуульд авсан саналын тоонд үндэслэн хуваарилсан мандатын дагуу суудалтай болсноор олон намууд парламентад өөрийн байр суурьтай болжээ. УБХ нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, 50 гишүүнтэй, эдгээрийн дөрөвний гурав нь АИХ-ын депутатын дундаас сонгогдох ёстой байжээ. УБХ-ын дарга нь БНМАУ-ын Дэд Ерөнхийлөгч байхаар тогтоосон юм. УБХ нь АИХ-аас сонгогддогын хувьд түүнд ажлаа тайлагнадаг байв.

Улсын Бага Хуралд төрийн байгуулалтын, эдийн засгийн, нийгмийн, хууль зүйн, эмэгтэйчүүд-хүүхэд залуучуудын гэсэн байнгын хороод ажиллажээ.

Шинэ үндсэн хуулиар засаглал хуваарилах зарчмыг баримтлан төрийн эрх мэдлийг хуваарилснаар төрийн эрх мэдлийн тэнцвэрт байдал хангагдаж

нэг хүний ноёрхол тогтох, ард түмний дээр хэсэг бүлэг хүмүүс хязгааргүй, хугацаагүй ноёрхлоо тогтоох боломжгүй болсон билээ. Төрийн эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлж буй байгууллагууд, тэдгээрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, хоорондын харилцаанд баримтлах журам, эрх хэмжээ, үйл ажиллагааных нь харилцан шүтэлцээтэй байх, бие биенийгээ тодорхой нөхцөлд нөхөн сэлбэх чадвар, шаардлагатай нөхцөлд бие биенийхээ үйл ажиллагаанд хуульд заасан ёсоор тодорхой асуудлаар саад хийх эрхтэй байхаар төрийн эрх мэдлийг хуваарилжээ.

“Монгол Улсын Их хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ-д хадгалана” гэж Үндсэн хуулинд зааж өгөв. УИХ нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч, хуулийн хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд нь хяналт тавигч, төрийн гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлогч, ард түмний эрх ашгийг дээдлэн сахих эрх, үүрэгтэй институт болсон билээ.

1994-12-30-нд батлагдсан Төрийн албаны тухай Монгол улсын хуулиар Монгол Улсын төрийн албаны ангилал, зарчим, төрийн албан тушаал, түүнд тавигдах шаардлага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, төрийн алба хаах болзол, журам, баталгааг тогтоож өгчээ. Уг хуулиар төрийн улс төрийн албан тушаалд Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгуулийн болон, сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажилладаг албан тушаалуудыг хамааруулжээ. Жишээлбэл, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын дэд дарга, гишүүн, Засгийн газрын гишүүн, бүх шатны засаг дарга зэрэг нь улс төрийн албан тушаал болно.

Төрийн албан тушаалын ангилал дахь төрийн захиргааны албан тушаалд УИХ, Ерөнхийлөгч, Засгийн Газар, шүүх, прокурорын байгууллагын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал, яамны төрийн нарийн бичгийн дарга, засаг даргын тамгын газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаалтнууд зэрэг албан тушаал байдаг. Төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэлд- яамны төрийн нарийн бичгийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал, эрхэлсэн түшмэл- яамны газрын дарга, түүний орлогч дарга, тэдгээртэй адилтгах албан тушаал, ахлах түшмэлд- яамны хэлтэс, тасгийн дарга, ахлах байцаагч, ахлах мэргэжилтэн, тэдгээртэй адилтгах албан тушаал, дэс түшмэлд- яамны байцаагч, мэргэжилтэн, тэдгээртэй адилтгах албан тушаал, туслах түшмэлд- яамны туслах байцаагч, туслах мэргэжилтэн, тэдгээртэй адилтгах албан тушаалтан хамаарч байна.

Элитийн онолын сонгодог төлөөлөгчид “хүнийг яг хэдийд залуу байна, яг хэдийд хөгшин болжээ гэж хэлж болдоггүйтэй адилхан улс төрийн албан тушаалтнуудыг чухам яг аль эрх мэдэл дээр очиход нь элит гэх вэ гэдэг нь хэлэхэд хүндрэлтэй асуудал” (Антология мировой политической мысли, М. 1997, Т.2, с. 61) гэж үзэж байсан билээ. Гэхдээ нийгмийн өндөр статус эзэлж, түүнд тохирсон эрх мэдэл эзэмшиж байдаг, тиймээс ч улс төр, нийгэм, эдийн засгийн засаглалын институтын ихэнхэд шийдвэрлэх нөлөө үзүүлэх бодит боломжоор хангагдаж байдаг хэсгийг сонгон авах боломж бий. Тэд ихэнхдээ сайн бэлтгэгдсэн, олон түмний дунд танигдаж мэдэгдсэн, нийгмээс хүлээн зөвшөөрсөн хэсэг юм. Албан тушаалын байдлаас авч үзвэл төрийн улс төрийн албан тушаалд хамаарагддаг Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын дэд дарга, гишүүд, Засгийн газрын гишүүд юуны өмнө орно. Хэдийгээр Төрийн албаны тухай Монгол Улсын хуульд улс төрийн албан тушаал гэж нэрлээгүй ч төрийн албан тушаалын ангилал дахь төрийн захиргааны албан тушаалд орох УИХ, Ерөнхийлөгч, Засгийн Газар, шүүх,

прокурорын байгууллагын ажлын албаны удирдах албан тушаалтнууд, яамны төрийн нарийн бичгийн дарга, засаг даргын тамгын газрын удирдах албан тушаалтнууд нь улс төрийн элитүүдэд нөлөө үзүүлэх боломж асар ихтэй учраас тэднийг анхаарахгүй өнгөрч огт болохгүй юм.

Элит судлалын нилээд ном зохиолд нийгмийн элит бүтцийг улс төрийн эрх мэдлийг гартаа төвлөрүүлсэн эрх баригч элитүүд, элитүүдийн тойрон хүрээлэгсэд, нөөц элитүүд, контр буюу сөрөг элитүүд гэсэн бүтэцтэйгээр авч үзсэн байдаг билээ. Энэ ангилалаар авч үзвэл эрхэлсэн түшмэлд хамаарагддаг яамны газрын дарга, түүний орлогч дарга, тэдгээртэй адилтгах албан тушаалтнууд нь эрх баригч элит гэхээсээ нийгмийн давхаргын иерархид элит давхаргад нилээд дөхөж очсон албан хаагчид гэж үзүүштэй санагдана.

Төрийн тусгай албан тушаалд төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй, албан тушаал, жишээ нь бүх шатны шүүхийн шүүгчид, прокурор, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүн, Зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтнууд Монгол банкны ерөнхийлөгч, тэргүүн, дэд ерөнхийлөгч, Үнэт цаасны хороон дарга, томоохон эрдэмтэд, нөлөө бүхий бизнесменүүд ч улс төрийн эрх мэдэлд нөлөө бүхий байж чадна гэсэн утгаараа элит давхаргад орох нь гарцаагүй. Харин тэдэнд улс төрийн эрх мэдэл яг гарт нь байхгүй байж болох юм. Гэвч тэдний зүгээс нийгэмд нөлөөлөх нөлөөлөл нь улс төрийн эрх мэдэл бүхий байр сууринд жишээ нь парламентад суудал авч чадсан хэн нэгнээс илүү ч байж болох талтай.

Монголын нийгэмд ардчиллын зарчимд үндэслэсэн элитүүдийн сонгуулийн үр дүнгээр байраа солих үйл явц нь элитийн онолын сонгодог төлөөлөгч Г.Москагийн хэлсэнчлэн соёл иргэншлийн түүх нь улс төрийн элитүүд засгийн эрхэнд гарч ирэх, уг эрх мэдлээ өв залгамжлуулах, эсвэл хуучин эрх мэдэлтнийг унагааж шинэ эрх мэдэлтэн гарч ирэх үйл явц юм. Хэрэв нэр алдарт хүрсэн хүмүүс өөртөө олдсон боломжуудаа төгөлдөржүүлж байхгүй бол тэдний эрх мэдэл баталгаатай унахад хүрнэ гэж хэлж байсныг нотлон эрх мэдэлд хүрч, бас халагдаж солигдож, улс төрийн амьдралыг үргэлжлүүлж байна (Антология мировой политической мысли, М. 1997, Т.2,с.131).

Улс төрийн шинэ системд шилжихтэй холбоотойгоор улс төрийн субъектуудын хоорондын харилцаан дахь хэм хэмжээнд ч бас өөрчлөлт гарчээ.

1996 оны сонгуульд МҮАН, МСДН эвсэл болж орсон нь шинээр бий болсон улс төрийн намууд ардчилсан сонгуульд туршлагажиж ирж байгааг харуулж, сонгуулийн тогтолцоондоо тохирсон бодлого явуулж эхэлснийг харуулав. Гэвч 2000 он хүртэл эрх баригч хүчин болсон улс төрийн шинэ хүчнийхэн нэгдсэн нэг нам шиг байр суурьтай байж чадалгүй улс төрийн арвин их туршлага, нийгмийн зүгээс дэмжигч бааз суурь сайтай МАХН-д хоёр сонгуульд дараалан ялагдахад хүрсэн билээ. 1992 оны сонгуульд 70:6-ын харьцаагаар ялж байсан МАХН 1996 онд цөөнхийн суудалд шилжсэн, энэ сонгуульд үнэмлэхүй олонхи болж байсан ардчилсан хүчнийхэн 4 засгийн газраа сольж үүний үр дүнд 2000 онд парламентын сонгуульд ялагдал хүлээсэн, 2004 оны сонгуульд МАХН сөрөг хүчнээ ялах боломж ихтэй байсан ч сонгуулийн технологитоо алдаа гаргаж, олон түмний сэтгэл зүйд төдийлөн тохироогүй сурталчилгаа хийсний улмаас парламентад улс төрийн бусад хүчнүүдтэйгээ тэнцүү суудал авсан зэрэг нь ард олон засгийн эрхийг барьж байгаа элит хэсгийн хариуцлагыг өндөрт байлгахыг ямагт сануулж байх боломжтой болсныг харуулав. Нийгэмд ерөнхийдөө амьдралын түвшин доогуур, амиа аргацаасан байдал асар их байгаа учраас улс төрийн элитүүд ч

энэ байдалд зохицсон бодлого явуулж байна. Улс төрийн намуудын баримтлах үзэл суртал нь өөр өөр байгаа боловч аль нь ч ялгаагүй сөрөг хүчний байр сууринд очихоороо социал-демократ чиглэлийг түлхүү баримтлаж байна. Эрх баригч хүчнийхэн ч олон түмний санаа бодлыг өөртөө татахад социал-демократ байр суурийг баримтлахаас өөр аргагүй байгаа боловч өнөөгийн нийгэмд ажиглагдаж байгаа нэг гаж гэж хэлж болох зүйл нь сөрөг хүчний дэвшүүлж гаргаж байгаа, мөрийн хөтөлбөртөө дэвшүүлсэн нийгмийн хамгааллын талын бодлого дээр эрх баригч хүчнийхэн ихэнхдээ хориг тавих хандлага гаргаж байгаа явдал юм. Улс төрийн оролцоонд фракцын хэлбэр хүчтэй байгаагаас улс төрийн нэг бүлэг эрх мэдлийг авангуутаа өөрийн эрх мэдлээс салах хүртлээ өөрийн өрсөлдөгчдийн улс төрийн эрхийг хязгаарлах оролдлого ч хийх болжээ.

Өнөөг хүртэл явагдаж байгаа сонгуулийн үр дүнд МАХН илүү олон давтамжтайгаар сонгуульд ялж байгааг зарим судлаачид нийгэм эдийн засгийн реформ, түүний үр дагавараас ард түмэн бэрхшээж, хуучнаа санагалзсаны үр дүн гэж тайлбарлах явдал байсан. Гэвч бодит байдал дээр ард түмний 87% нь ардчилал, зах зээлийн харилцааг хэвшүүлэх талд байгааг судалгаагаар нотложээ. Харин сонгуулийн үр дүн нь улс төрийн элитүүдийн явуулах бодлогын стратеги, тактик нь цаг үе болон ард түмний хэрэгцээ шаардлагад хир зэрэг нийцтэй байна вэ гэдгээс, мөн боловсон хүчний нөөц, нийгмийг удирдах туршлага, намын доторхи эв нэгдэл, улс төрийн лидерүүдийнх нь нийгмийн зүгээс авч байгаа үнэлгээ зэрэг олон зүйлээс шалтгаалж байгаа билээ. Аль ч нам нь парламентад олонхи болж засгийн газраа байгуулсан ч өмнөх нийгмийнх шиг албадах эрх мэдэл байхгүй болсон. Гэвч засгийн газрын үйл ажиллагаагаар дамжуулж засаглалын нөөцийн хуваарилалт өөрсдөд нь ашигтай байгаагаар далимдуулан олон түмнийг өөртөө татах, олон нийтийн мэдээллийн хэрэгслэлийг ашиглан өөрсдийн үйл ажиллагааг сурталчилах бодлогыг эрчимтэй явуулах болжээ.

Улс төрийн намууд, янз бүрийн сонирхлын бүлгүүд парламент, засгийн газарт шаардлага хүргүүлэх, улс төрийн бодлого, шийдвэрт нөлөөлөхийг оролдох явдал жирийн үзэгдэл болжээ. Нийгэм дэх сонирхлын бүлгүүд гишүүдийнхээ эрх ашгийг илэрхийлж чадаж байгаа боловч эрх баригч нарт ямар ч нөлөө үзүүлж чадахгүй байгаа тохиолдол нилээд байна. Өөрөөр хэлбэл нэгэнт эрх баригч болсон элит хэсгийнхэн олон түмний шаардлагуудад зохистой хариу өгөх явдал л асар их дутагдалтай болж ирж байна. Иймээс эрх баригч элитүүдийг эсэргүүцсэн, үйл ажиллагааг нь хянах гэсэн, улс төрийн тавцнаас зайлуулах гэсэн шаардлагууд маш их хэмжээгээр гарах болж байна.

Ардчилалын үндсэн зарчмууд нэгэнт нийгмийн амьдралын хэм хэмжээ болсон учраас улс төрийн элитүүд олон түмнийг өөрсдийн хүссэн загвараар барьж байх боломж үгүй болсон. Харин тэд Засгийн газрын бюрократ сувгуудыг өөрсдийн хяналтандаа байлгах талаар маш шаргуу ажиллах болсон байна. Үүний тодорхой жишээ нь 1996, 2000, 2004 оны сонгуулийн дараах халгаа сэлгээ юм. Гэвч нийгэм эрх баригчдын хурууны үзүүрээр хөдлөх нь ардчиллын нөхцөлд таарахгүй гэдгийг ойлгож эрх зүйт төрийн хэм хэмжээг баримтлан үйл ажиллагаагаа явуулахыг шаардах болсон байна. 1996 оны сонгуулийн дараа удирдах албан тушаалын хүмүүс бараг толгой дараалан ажлаасаа халагдаж, ингэхдээ ардчилсан нийгэм ийм л юм байлгүй гэсэн сэтгэлгээгээр хүлээцтэй хандаж байсан бол 2004 оны сонгуулийн дараах халгаа сэлгээнд маш их эсэргүүцэл гарч үндслэлгүйгээр ажлаас халлаа гэж шүүхэд хэндсан тохиолдол эрс нэмэгджээ.

Нийгэм хөгжихийн хирээр янз бүрийн бүлгийн зүгээс улс төрийн бодлогод нөлөө үзүүлэх боломж бас өсч улс төрийн бодлого боловсруулахын

өмнө засгийн газар дахь болон нийгэм дэх хувь хүмүүс, бүлгүүд улс төрийн бодлогоос юу хүсч юу олж авахыгаа тодорхойлж, ашиг сонирхлоо илэрхийлэх буюу артикуляци хийх боломж нээлттэй болж иржээ. Ардчиллын үр дүнд иргэдийн улс төрийн оролцоог хязгаарлах боломж багасч харин ч ард олон хүсэх, гуйх, шаардах, олон нийтийг дайчлах, удирдлагад дарамт шахалт үзүүлэх зэргээр эрх баригчдын үйл ажиллагаанд нөлөөлж байна. Хувь хүмүүс, сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааны арга барил, санхүүжилт, нийгмийн дэмжлэг зэргээрээ хоорондоо нилээд ялгаатай юм. Институтжсэн сонирхлын бүлгүүдийн ар талд улс төрийн нам, намуудын доторхи янз бүрийн бүлгүүд, бизнесийн бүлэглэлүүд ч байна. Өөрсдийн хэрэгцээ шаардлагаасаа болоод сонирхлын бүлгүүд улс төрийн бодлогын тодорхой салбаруудаар дагнах хандлага их байна. Тэдний ашиг сонирхлын артикуляци хийх үйл ажиллагаа нь илүү зохион байгуулагдсан, санхүүгийн чадвар сайтай, асуудалд мэдлэг боловсролтой шинжээр хандсан, гэхдээ бас чинээлэг давхаргынханд ашигтайгаар шийдэгдэх тал руу хэлбийсээр л байна.

Улс төрийн системийн өөрчлөлт нь засаг төрд болон ашиг сонирхолдоо хандах хүмүүсийн улс төрийн ухамсарыг маш өөр түвшинд гаргаж тавив.

Улс төрийн системүүд нь тухайн улс орны дотоод нөхцөл байдал төдийгүй гадаад хүрээлэлд оршиж, уг хүрээлэл нь улс төрийн сонголт, нийгмийн хөгжил дэвшилд хүрэх арга замыг хязгаарлаж, эсвэл илүү боломжтой болгож байдаг билээ. 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш иргэд өөрсдийн өдөр тутмын амьдралын асуудлаар төр засагтаа шаардлага тавих эрх чөлөөтэй болж нөгөө талаар улс төрийн элитүүд ард түмний өмнө хариуцлага хүлээж, өөрсдийн үйл ажиллагааг үнэлүүлж цэгнүүлж байх шаардлагатай болжээ. 1992 оны багш нарын ажил хаялт, 1994-4 сарын МоАХ, МОХ-оос зохион байгуулсан жагсаал цуглаан, Монголын тусгаар тогтнолыг хамгаалах ард түмний 281-ийн холбооны тэмцэл, 2000 оноос хойш бол Эрс шинэчлэл, Миний Монголын газар шороо, Даяар монгол, Ард түмний Их Хуралдай гэх мэт олон тэмцэл хөдөлгөөнүүд гарч тухайн үеийн эрх баригчдыг шүүмжилж, Засгийн газар хөтөлбөрөө биелүүлсэнгүй, төр, засгийн өндөр албан тушаалтнууд ёс зүйн алдаа гаргалаа, албан тушаалаа урвуулан ашиглалаа гэж эсэргүүцлээ илэрхийлж байв. Эдгээр тэмцэл нь эрх баригч элитүүдийн явуулж буй бодлогын хомсдол, зохион байгуулалтын алдаа, боловсон хүчний буруу сонголт, ёс зүйн доголдол, эрх барьж байсан улс төрийн хүчний дотоодын хагарал, сөргөлдөөнийг шүүмжилсэн өнгө аястай байсан юм.

Тоталитари улс төрийн системийн үед эрх баригч элитийг шүүмжлэх явдал хаалттай байж, энэ үйлдэл нь улс орны эрх ашиг, аюулгүй байдал, тусгаар тогтнолын эсрэг шинжтэй гэсэн үнэлгээн дээр бууж нухчин дарагдаж байсан цаг үе нэгэнт дуусчээ. Шилжилтийн үеийн улс төрийн засаглалын легитим байдал нь тухайн үеийн хүндрэл бэрхшээл, ардчилсан системийн онцлогыг өөртөө тусгаж байлаа. Ялангуяа эрх баригч элитүүдийн нийгмийн хамгааллын талаар явуулж буй бодлогыг ихээхэн шүүмжлэх болжээ. Энэ нь баялгын хомсдол, амжиргааны түвшний доройтол, хүнд байдлаас гарах арга зам хайлт, цаг үеийн хүнд бэрхшээлтэй байдал, сөрөг хүчин нь эрх баригчдыг шүүмжилсэн үйл ажиллагаа явуулах болсон зэрэг олон нөхцөл байдалтай холбоотой байв.

Ер нь эрх баригчдын үйл ажиллагааг эрс эсэргүүцсэн, улс орныг донсолгосон давалгаа, үйл явдлууд 1990-1992 онд дээд цэгтээ хүрч, 1993-1994 оны үед саарч, 1995 оны үеэс харьцангуй тогтвортой болж эхэлсэн. Гэвч 2000, 2004 оны парламентад МАХН үргэлжлүүлэн эрх баригч нам болж

парламентад давуу байдал олж авсантай зэрэгцэн ашигт малтмал, лицензтэй холбоотой асуудал, цагаач иргэдийн асуудал, тэтгэвэрийн хүмүүсийн амжиргааны хүнд хэцүү байдал, хот зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудал ор тас орхигдсон, зарим томоохон компаниудын буруутай үйл ажиллагааны улмаас олон зуун хүний аж амьдрал хохирсон, үүнд эрх баригчид шийдвэртэй арга хэмжээ авахгүй байгаа, авилга хээл хахуулийн асуудал нийгмийн хямралт байдалд хүргэхүйц хэмжээнд хүрлээ гэсэн эмзэг асуудлуудын улмаас улс төрийн үйл явцаас шахагдаж, цөхөрсөн иргэд идэвхийн аномик хэлбэрт шилжиж, хүчирхийллийн арга замыг сонгоод ч болов эрх баригчдад нөлөөлөхийг оролдох явдал ихээхэн гарч ирэв. Нэг талд тэгш бус байдал, дороос гарсан санал хүсэлт замхардаг байдал, нөгөө талд хүчирхийлэл, өөрсдийн хүсэлт шаардлагыг тэмцлийн ямарч аргаар хамаагүй төр засгийн өндөрлөгт хүргэх гэсэн оролдлого хоёр шууд хамааралтайгаар өсч байгааг үйл явдлын статистик нотлож байна.

Өөрийн улс төрийн статусыг тогтоох явцад илрэн гарч байдаг субъектуудын нийгмийн идэвхи, үйлдлийн янз бүр байдлыг харуулах улс төрийн бодлого, үйл ажиллагаа улс төрийн системээс хамаарч яаж өөрчлөгдөж байна вэ

Мах Вебер “Улс төр бол мэргэшил мөн” хэмээх зохиолдоо “улс төр гэдэг нь засаглалд оролцох, эсвэл төрүүдийн хооронд ч бай, төрийн дотор бүлэг хүмүүсийн хооронд ч бай засаглалыг хуваарилахад нөлөөлөх эрмэлзлэл юм” (Макс Вебер, Улс төр бол мэргэшил мөн. Шинжлэх ухаан бол мэргэшил мөн. УБ., 2000, х.17) гэжээ. Монголын улс төрийн элитүүдийн нийгмийн идэвхи, үйлдлийн янз бүрийн байдлыг задлан шинжилвэл, тэд эрх баригчид байна уу, эсвэл сөрөг хүчний байр сууринд байна уу гэдгээс хамааран гаргах шийдвэрүүд нь янз бүрээр хувирч өөрчлөгдөж байгаа нь ажиглагдаж байна. Мөн улс орны нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудал, нийгмийн сэтгэл зүйтэй холбоотойгоор олон түмэн ч ямар хэв шинжтэй элитүүдэд итгэл хүлээлгэх вэ гэдэг нь өөрчлөгдөх болжээ. Жишээлбэл 1990 оны үед өөрчлөлт шинэчлэлтийн давалгаан дунд МАХН хэдийгээр шүүмжлэлийн бай болж байсан ч өөрийн эв нэгдлээ хэвээр хадгалаж чадсан нь улс төрийн хоосон орон зай үүсгэж олон жижиг нам, хөдөлгөөнүүдийн тэмцэл улс орныг хэт замбараагүй болгож нийгмийг удирдах чадваргүй хийрхсэн бүлэглэл бий болгох боломж олгоогүй. МАХН-ын дээд эрх баригчид ардчилсан хүчнүүдийг хүлээн зөвшөөрөхдөө асуудлыг хурцатгаагүй нь эрх баригч элитүүдийн болон сөрөг хүчний хооронд хурц тэмцэл бий болголгүй үндэсний эв нэгдлийг хангаж чадсан юм.

1992 оны УИХ-ын сонгуулиар МАХН 76 суудлаас 71-ыг авсан нь нийгмийн эрх баригч элитүүдийн дунд МАХН-ын гишүүд дийлэнхи олонхи байгааг харуулах боловч тэд нийт сонгогчдын саналын 56,8% саналыг авсан нь ардчилсан хүчин хэдийгээр өөрийн боловсон хүчний нөөц багатай ч олон түмэн тэдний төлөө сонголт хийж, шинэ хэв маягийн элит бүтцийг хүсэн хүлээж байсныг харуулдаг. Өөрөөр хэлбэл сонгуулийн системийн онцлог нь авсан суудлын тоо, санал авсан байдлыг хэт их зөрөөтэйгээр тогтоож тухайн үеийн монголын нийгэм, улс төрийн байдалд төдийлөн их тохирч өгөөгүй юм. Ийм ч учраас сонгуулийн системийг боловсронгуй болгох тухай асуудал улс төрчдийн дунд ч, эрдэмтэн судлаачдын дунд ч, жирийн иргэдийн дунд ч байнга яригдаж байдаг, төдийлөн оновчтой шийдлийг өнөө хэр нь олоогүй байгаа асуудлуудын нэг юм. Ер нь улс төрийн систем бүр эрх баригч элитүүдээ гаргаж ирэх өвөрмөц арга механизмтай. Жишээлбэл, 1949 онд хуралдсан “БНМАУ-ын IX их хурал БНМАУ-ын сонгуулийн системийн ардчиллыг цаашид улам хөгжүүлэх тухай” асуудал хэлэлцэж угаасаа

хэлбэрийн төдий эрх баригчдыг яаж хэлбэрдэн сонгохыг үндсэнд нь зааж энэ нь улс төрийн системийн онцлогоос шалтгаалан улам нэг загварт орон хөгжсөн юм.* Тэгвэл шинэ улс төрийн системийн шаардлагатай уялдан сонгуулийн шинэ систем хэрэглэх болсон бөгөөд энэ нь хуучин сонгуулийн системтэй харьцуулахад асар их дэвшилттэй байгаа боловч өөрийн гэсэн дутагдалтай болохоо харуулсаар байна. Хамгийн оновчтой, улс орны нөхцөл байдал, онцлогт тохирсон сонгуулийн хууль батлуулах явдал нь нилээд бэрхшээл, урт удаан зам туулах шинжтэй байна. Үүнд нөлөөлж байгаа зүйлүүдэд юуны өмнө манай улс ийм хэлбэрийн ардчилсан сонгууль явуулж байсан туршлага харьцангуй багатай, нөгөө талаас нам, бүлэглэл хувь хүмүүсийн зүгээс өөрсддөө тохиромжтой сонгуулийн хууль батлуулахын тулд нийт ард түмэн, сонгогч олны хувь заяаг гаргуунд нь хаях явдал байгаатай холбоотой юм. Эрх баригч элитүүд улс төрийн системд чухал нөлөө үзүүлэх сонгуулийн хуулийг батлах талаар тухайн үеийн нөхцөл байдал, сонгогчдын санаа бодол, хүсэл шаардлага, сөрөг хүчний байдал зэргээс хамаарч янз бүрийн сонгуулийн тухай хуулийн төсөл дэвшүүлж байв. 1993 онд УИХ-ын гишүүн Д.Ганболд, Р.Гончигдорж, С.Зориг, А.Ганбаатар нарын өргөн мэдүүлсэн УИХ-ын сонгуулийн хуулийн төсөл, 1995-4-р сард гишүүн Ж.Жадамбаа, М.Зэнээ, О.Шаалуу нарын өргөн мэдүүлсэн УИХ-ын сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 1995-6 сард Ерөнхийлөгчөөс өргөн барьсан сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 1996-1-15-нд УИХ-ын ажлын хэсгийн боловсруулж, чуулганы хуралдаанд танилцуулсан үзэл баримтлалын төсөл, 2006 онд батласан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль зэргийг энд дурьдаж болно. Эдгээр хууль, хуулийн төслийг хэлэлцэж байх явцад эрх баригч элитүүд зарим тохиолдолд Монгол эх орон, Монголын ард түмэн гэсэн эрхэм дээд зорилгоос өмнө өөр өөрсдийн нам, хөдөлгөөний явцуу хүсэл сонирхлыг илүүтэй үзэж байгаа тал харагддаг байсан юм.

Сүүлийн үеийн парламентын сонгууль ч, ерөнхийлөгчийн сонгууль ч адилхан элит хэсгийнхэн сонгуулиар ард түмний санал авахын тулд сонгуулийн нарийн технологи ашиглах, олон түмний санаа бодолд нийцсэн мөрийн хөтөлбөр дэвшүүлэх, тэгш боломжоор хангагдах зэрэг ардчиллын хэм хэмжээний дагуу үйл ажиллагаа явуулах болсон билээ.

1990 оноос хойш шинэ улс төрийн системийн онцлогтой холбоотойгоор монголын улс төрийн элитүүдийн үйл ажиллагаанд нь ихээхэн өөрчлөлт оржээ. Тоталитари улс төрийн системийн үед төрийн өндөрлөгүүд, эрх баригчиддаа итгэж, тэдэнд хувь заяагаа бүрмөсөн даатгасан шинжтэй байсан цаг үе нэгэнт өнгөрч ардчилсан системийн бараг байнгын дагуул гэж хэлж болох удирдлагаа шүүмжлэх үл итгэх байдал бараг хэвийн зүйл болж, улс төрийн элитүүд ч үүндээ дасан зохицож эхэлжээ. Жишээ нь, 2002 онд МҮХАҮТ, Монголын Нээлттэй нийгэм хүрээлэнтэй хамтран явуулсан “Улс төрийн хүрээний авилгалын индекс” судалгаагаар судалгаанд хамрагдагсадын 83,5% нь улс төрчид болон төрийн өндөр албан тушаалтнууд албан тушаалаа ашиглан олж авсан авилгаараа хөрөнгө мөнгө олж авдаг гэж үзсэн байна.

Улс төрийн хүчнүүдийн үйл ажиллагаагаа явуулах эрчим, цаг үетэйгээ зохицох байдал нь тэдний төлөөлөл засаглалд ямар байр суурь эзлэхийг нь бас шийдэх болсон байна. Жишээ нь 1996 оны сонгуульд МАХН ялагдсан шалтгаан нь энэ улс төрийн нам ард түмний бодол сэтгэлгээ, хүсэл мөрөөдөл, амьдрах арга хэлбэрийг олон жил нэг загварт барьсан коммунист онол,

* БНМАУ-ын Есдүгээр Их Хурлын илтгэл, хууль, тогтоолууд. УБ., 1949, х. 95, 100-107.

социалист үзэл санаа гэгчийг зэрэмдэглэсэн байдлаар хэрэглэж, дараа нь төв үзэл гээч цаг үедээ зохицоогүй бөөрөнхийлсөн үзэл баримтлалыг нэг гаргаж үзэж өмнөх үеэ хамгаалж ч чадахгүй хагацаж салж ч чадахгүй хоёрын хооронд байж намын байгууллагуудын урьдын эмх цэгц, дэг журамтай байдал алдагдаж, УИХ, Засгийн Газарт сул хүмүүс орж нам үүнд нь зохицоод өнгөрөх аялдан дагалдах хандлага гаргаж байсан нь намын нэр хүндийг доройтуулсан явдал байв. Мөн олон түмний аж амьдрал хүнд хэцүү байхад дайчин шуурхай ажиллахгүй байдлыг харах, аялдан дагалдах шинжтэй байсан нь мөн ийм үр дагаварт хүргэсэн юм.

Сөрөг хүчин энэ мэт сул талыг гярхай ажиглаж сөрөг сурталчилгаа сайн хийж МАХН-ын төв үзлийг баримтласан гэх үлбэгэр байдлыг нь ашиглан сонгуульд ялалт байгуулсан юм.

Улс төрийн сонирхлыг авч явагч, улс төрийн үйл байдлын эх үүсвэр болох бие хүн улс төрийн системээс хамаарч хэрхэн өөрчлөгдөж байна, улс төрийн амьдралд ямар үүрэг гүйцэтгэж байна вэ гэдэг нь бас нэг анхаарал татсан асуудал мөн.

Улс төрийн систем нь дотоод, гадаад хүрээлэлд оршиж, мөн энэ хүрээллээ төлөвшүүлж, өөрөө түүний нөлөөлөл дор хөгжиж байдаг. Жижиг буурай улс орны хувьд улс төрийн систем нь гадаад хүрээллийн хүчтэй нөлөөллийг гарцаагүй амсах бөгөөд дотоод хүрээллийг гаднын хүчтэй нөлөө үлгэр жишээний дор, өөрөө тодорхой хэмжээгээр зохицуулах боломжтой байх тийм л бодит байдал 1921-1990 он хүртэлх түүхэн үед үндсэндээ ноёрхож байв. Энэ үеийн Монголын улс төрийн систем нь Зөвлөлт Орос Улсын асар их нөлөөлөл, шахалтан дор хэлбэршин тогтож, уг системийн гол субъект болох улс төрийн хамгийн дээд түвшний элитүүд нь бараг эхнээсээ л зөвлөлтийн удирдлагын үзэмжээр сонгогдох болсон байдаг. Өөрөөр хэлбэл улс төрийн элитүүдийн нийгэмд эзлэх байр суурийн асуудал нь өөрсдийн өрсөлдөөнөөр гэхээсээ урьдаар гадаад нөлөөллийн хүчээр шийдэгдэж байжээ. Улс төрийн системийн гол цөм байх ёстой төрийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол нь МАХН гэсэн субьекттэй харьцуулахад хоёрдугаар зэргийн шинжтэй болсон байна. Элитийг сонгон шалгаруулах механизм, тэдэнд тавигдах шалгуурууд нь аливаа нийгмийн байгуулалд байдаг шилдэг байх гэсэн гол зарчмыг мөрдлөг болгодог ч үүн дээр үзэл сурталжсан шаардлагууд нэмэгдэж байсан юм.

Харин 1990-ээд оноос хойш улс төрийн элитэд орох бие хүний асуудал өмнөх далан жилийнхээс эрс өөр болж ирэв. Шинэ нөхцөл байдал элит давхаргынханд янз бүрээр нөлөөлж эхэлсэн бөгөөд үүнд зохицон өөрчлөгдөж буй бие хүмүүст шинэ нийгмийн ч, хуучин нийгмийн ч аль алиных нь онцлог, мөр улбаа хүчтэй нөлөөлж байв. Жишээлбэл, МАХН нь урьд нь аж ахуйн ажлаар голлон хөөцөлдөж ирсэн тул улс төрийн тэмцлийн арга, улс төрийн үйл ажиллагааны идэвхи султай байв. Тэдэнд үзэл суртлыг түгээн дэлгэрүүлэх үүрэг л оногдож байснаас бус нүүр тулан улс төрийн өрсөлдөөнд орох асуудал байгаагүй. Иймээс ч МАХН-ын гишүүд шүүмжлэлээс их айдаг онцлогтой, нэг л шүүмжлүүлсэн бол зориг нь шантарч ажил алба, алдар хүндээс татгалзахад хүрдэг өмнөх системийн онцлог нь хэдийгээр улс төрийн систем бүхэлдээ өөрчлөгдчихсөн үед ч хүмүүсийн сэтгэхүйгээс салж өгөхгүй тогтсоор байв. Жишээ нь, 1991-1-16-ны өдрийн АИХ-ын хуралдаан дээр Ерөнхий сайд Д.Бямбасүрэн албан тушаалаасаа огцрох санал тавьжээ. Тэрээр огцрох болсон шалтгаанаа тайлбарлахдаа “Ардын эрх” сонинд гарсан социологийн судалгаагаар депутатуудын 60-77%, үүний дотор өөрийн намын парламент дахь бүлгийн 75% нь огцруулах саналтай байна гэж гарсан байна гэжээ. Энэ нь огт шүүмжлүүлж үзээгүй байсан өмнөх нийгмийн эмзэг байдлаар асуудалд хандаж байжээ гэж үзэхээс өөр аргагүй. Одоо бол аль нэг социологийн

судалгаа байтугай хоёр гурван зуун мянган хүний гарын үсэг цуглуулчихсан байсан ч байр сууриа тавиад өгчих тийм улс төрчид, эрх баригчид алга болжээ. Жишээ нь 2006 онд “Эрс шинэчлэл - Иргэний хөдөлгөөнийхөн” ашигт малтмалын хуулийг эсэргүүцэж, мөн парламентыг тараах шаардлагуудыг тавьж 300 000 гаруй хүний гарын үсгийг орон даяар явж цуглуулж Их Хуралдайгаар Ашигт малтмалын тухай хуулийг цуцлах, Ерөнхийлөгчийг огцруулах, УИХ-ыг тараах зэрэг шаардлагуудыг тавьж бас л гурван өдрийн дотор 10 000 гаруй хүний саналыг авч чадсан боловч тэмцлийн үр дүн төдийлөн харагдахгүй өнгөрсөн билээ. Ер нь хэн нэгэн хүн шүүмжлэгдэнэ гэдэг нь пролетарийн интернационализм, коммунист зарчмаас ямар нэг байдлаар хазгай гишгэсэн гэсэн үг байв. Иймээс ч 1990-ээд оны зааг дээр энэ сэтгэлгээнд хүлэгдсэн байсан эрх баригч элитүүдийн болгоомжилсон байдал нь нийгэмд хүлээгдэж байсан чухал шийдвэрүүдийг гаргаж чадахгүйд хүргэсэн юм.

Ардчилалын үндсэн дээр улс төрийн элитүүдийг сонгон шалгаруулж гаргаж ирэх болсон нь өмнөх тоталитари улс төрийн системийн үеийн шалгаруулалтаас маш их дэвшилттэй зүйл ихтэй байсан ч зарим талаар дутагдалтай талуудтай байгаа бөгөөд үүнд юуны өмнө хувь хүмүүс төрийн өндөр албан тушаалд очсон ч үүргээ ухамсарлах тал дээр муу байх нь ажиглагддаг байлаа. Ялангуяа ардчилсан хүчний гэгдэх залуучуудад УИХ-ын хуралдаан, байнгын хороодын хуралдаанаас хоцрох таслах явдал асар их байв. Хэдийгээр шүүмжлэх зүйл олонтой ч элитийг сонгон шалгаруулах гильдийн систем нь хүмүүсийг урт удаан хугацааны турш ажлын хариуцлага, чадвар, өндөр албан тушаал хаших найдвартай байдлыг сорьдог байсан тул энэ тал дээр дутагдал бага байсан байж болох талтай.

Тоталитаризмаас ардчилалд шилжих үеийн улс төрийн систем нь гаднах хэлбэрийн хувьд нилээд хөгжингүй шинж чанартай байсан боловч тодорхой, үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадвар муу байв. Төр засгийг бүрдүүлж байгаа нэгжүүд нь хоорондоо уялдаа холбоо муутай, сул, хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ шаардлагыг хангах, зохицуулах чадвар тааруухан байсан юм. Энд хөгжингүй системийн тухай үзэл санаа нь харьцангуй хурдан бий болдог боловч, нийгэм, соёлын нөхцөл нь асар их бэрхшээлийг туулж байж бүрэлдэн тогтдогтой холбоотой. Үүний нэг тодорхой жишээ нь ардчилсан үзэл санааг дэлгэрүүлэгч шинэ хүчний залуучууд маань өөрийн үүргээ гүйцэтгэх тал дээр төдийлөн үлгэр жишээ үзүүлэхгүйц байж чадахгүй байсан явдал юм. 1994 намрын чуулганд УИХ, Байнгын хороодын хуралдааныг хамгийн их тасласан гишүүдэд : А.Ганбаатар 235 цаг, Д.Ганболд 179 цаг, С.Зориг 145 цаг, Ж.Уртнасан 59 цаг, Ц.Элбэгдорж 60 цаг, Т.Эрдэнэбилэг 68 цаг нийт 34 хүн 1001 цаг таслажээ. Гишүүдийн ирц хүрэхгүйн улмаас УИХ-ын нэгдсэн хуралдаан, байнгын хороодын хуралдаан хуралдахгүй байх тохиолдол бараг жирийн үзэгдэл болж ардчилсан хүчнийхэн дараагийн сонгуульд ялагдахад нөлөөлсөн нэг чухал хүчин зүйл болжээ.

Шинэ цаг үе шинэ элитүүдийг шаардаж байсан боловч Монголын ардчилагчид мэдлэг чадвар сайтай боловсон хүчинтэй болж, дэмжигчид олширсоор байсан хэдий ч тэдний дотор улс орныг бүхэлд нь удирдахаар сайн мэргэшиж дадлагжсан нөөц хүрэлцээгүй хэвээр байв. Иймээс 1990-ээд оны дунд үед гэхэд Энхсайхан, Гончигдорж, Элбэгдорж, Да.Ганболд, Баабар, Зориг гэх мэт арай туршлагатай хэдийгээ УИХ, Засгийн Газарт гол гол албан тушаалд тавиад зарим яам, тусгай газар, аймгуудыг хэнээр удирдуулах гэх мэт бодитой асуудлуудын өмнө Ардчилсан Холбоо эвсэл хүнд байдалд орж ирсэн юм. Энэ нь төрийн өндөр албан тушаалд хэдийгээр чадвар муутай ч аль

арга зальтай хүмүүс нилээдгүй шургалах болсон таагүй үйлдлийн эх суурь болж өгсөн ч байхыг үгүйсгэхгүй байна.

Аль ч нийгэмд улс төрийн элитийн байр сууринд хүрэх нэг чухал арга хэрэгслэл нь хувийн холбоо сүлбээ, тухайлбал гэр бүл, сургууль, айл хөршийн болон нийгмийн бусад хэлхээ холбоо байдаг. Монголд ч энэ зүй тогтол бас л харагдаж байна. 1990 оноос хойшхи улс төрийн элитүүдийн бүтцийг харахад аймаг, сургууль, нэг үеийнхэн, төрөл садны холбоо нилээд их ажиглагддаг. Энэ нь хүн ам хэт цөөн, танил талаа түших нь хялбар байдаг зэрэг онцлогуудтай ч бас холбоотой байж болох талтай.

Людвиг фон Мизес “хүмүүсийг жинхэнэ хэрэг дээр адил тэгш болгоё ч гэсэн бүх хүн төрөлхтөний хүч хүрэлцэхгүй” гэж хэлжээ. (Людвиг фон Мизес, Либерализм, УБ, 2004, х.44) Хүмүүс хэзээ ямагт тэгш биш байсан, үргэлж л тийм байх нь үнэн билээ. Иймээс ардчиллын зарчмууд бодит зүйл болохтой зэрэгцээд тэгш бус чадварын тухай, нийгмийн иерархид эзлэх байх суурийг нь зохистой юу, үгүй юу гэсэн үнэлгээ гарч ирэх нь гарцаагүй зүйл байв. Улс төрийн системийн өөрчлөлт нь тухайн цаг үед тохирсон хүнийг тохирох байр сууринд тавих явдал руу л байнга чиглэгдэж байдаг бөгөөд ардчиллын хөгжил нь үүнийг улам л илүү харуулж байна. Зорилгодоо хүрэх хамгийн дөт замыг сонгосон, уг байр сууринд тохирох хүн гарч ирэх бүрт өөрийн байр суурийг бэхжүүлэх янз бүрийн арга хэмжээ авч эхэлдэг бөгөөд хүчтэй нь ялалтанд хүрдэгийг нотолж өгдөг бол төрийн өндөр албан тушаалд тохирохгүй хүн тавигдах бүрт нийгэмд шуугиан дэгдэж байдаг. Социализмын үед дээд газрын шийдвэр нь заавал үг дуугүй биелүүлэх тулгалт байдаг байсан тул шийдвэрийг хэн ч хэлэлцэн шүүмжилдэггүй, зөвхөн шууд л хүлээн авдаг байсан бол ардчилал бодит зүйл болмогц энэ байр сууринд хэн нь тохирох, хэн нь тохирохгүй тухай асуудал хамгийн их сонирхон хэлэлцэх зүйлийн нэг болж ирсэн байна. Монгол улсад улс төрийн шинэ систем бүрэлдэн тогтох үйл явц нь зөвхөн дээд түвшний улс төрийн элитүүдийг улс төрийн тавцнаас буулгаснаар л бүрэн шийдэгдчихсэнгүй, энэ нь маш их ээдрээ түвэгтэй хүнд бэрх замын эхний алхам л байв. Энэ хүндрэл бэрхшээлийг ч, хөгжил дэвшилийг ч төрийн түшээд, улс төрийн эрх баригчдаас салган авч үзэх боломжгүй. Улс төрийн эрх мэдлийг гартаа төвлөрүүлсэн хэсэг олон түмний итгэлийг олж авах, байр сууриа бэхжүүлж байхын тулд янз бүрийн арга хэрэглэх болов. Жишээ нь саар муу бүхнийг нөгөө улс төрийн хүчнийхнийх, ололт дэвшил бүхэн минийх, биднийх гэх гэж үзэгдэл түгээмэл болсон байна. 1990 оноос хойш Монгол Улсын Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга, УБХ-ын гишүүд, дарга, Ерөнхий Сайд, Тэргүүн шадар сайд, Шадар сайд, Банк, санхүүгийн том албан тушаалууд, Хотын дарга, Аймгийн дарга, орлогч дарга гэх мэт өндөр албан тушаалыг Ардчилсан хүчнийхэн ч барьж л байсан, МАХН-ынхан ч барьж л байсан. Иймээс ч нийгэм улс төрийн өөрчлөлт, улс орны хөгжил дэвшил нь ганцхан тэднийх гэх боломж огт байхгүй. Харин бие хүмүүс өндөр албан тушаал хашихад өөрийн чадвар, чадавхи мэдээж чухал боловч өнөөгийн монголын нийгэмд аль нам бүлэглэлд хамаарагдах нь түүнтэй адил, магадгүй зарим тохиолдолд түүнээс ч илүү үүрэг гүйцэтгэж байна. Гэхдээ энэ гэж үзэгдлийг тооцохгүйгээр авч үзвэл хувь хүний өөрийн оюун ухаан, чадвар нь аль улс төрийн хүчнийх вэ гэдгээс төдийлөн хамаарахгүй нийгмийн аль нэг давхаргад байр сууриа эзлэхэд нь түлхүү нөлөөтэй байсаар байна. Жишээ нь 1990 оноос өмнөх болон хойшхи нийгмийн байдлын өөрчлөлт социологийн судалгаанд ямархуу байдлаар харагдаж байгааг социологч Х.Гүндсамбуу “Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага” номондоо харуулсан байдаг.

1990 оноос өмнөх нийгмийн байдал	Одоогийн байдал					Бүгд
	дээдэс	Дээгүүр дунд	Ердийн дунд	Доогуур дунд	Доодос	
Дээдэс	28,6	23,8	33,3	--	14,3	100%
Дээгүүр дунд	2,6	32,5	58,8	6,1	--	100%
Ердийн дунд	0,5	9,3	63,3	24,9	2,0	100%
Доогуур дунд	--	0,8	14,9	66,7	17,5	100%
Доодос	--	11,1	11,1	22,2	55,6	100%

Хүснэгтээс харахад 1990-ээд оноос өмнө нийгмийн дээд давхарга, дээгүүр дунд давхаргад хамрагдаж байсан хүмүүсийн ихэнх нь шинэ улс төрийн системийн үед мөн л дээдэс, дээгүүр дунд давхаргад түлхүү орж ирсэн, үгүйдээ л ердийн дунджийн хэмжээнд байхад өмнөх нийгэмд доогуур дунд, доодосын давхаргад хамрагдаж байсан хүмүүсийн дийлэнх олонхи нь шинэ нийгмийн үед мөн л энэ давхаргадаа хэвээр байх тал ажиглагдаж байна. Тэгэхээр монголын нийгмийн элит давхаргын бүтэц нь нэг талаас ерөнхийдөө уламжлагдах, үеэс үед дамжих шинжтэй байгааг, нөгөө талаас угаасаа элит давхаргад орох эсэх нь хүмүүсийн чадвараас, оюун ухаанаас ихээхэн хамааралтай байгааг харуулж байна. Харин энэ үзүүлэлт дээр нэмэгдэн, сүүлийн үед маш их нөлөөлж байгаа хүчин зүйл нь намын харьяалал, бүлэглэлийн харьяалалын асуудал болж байгааг дээр дурдсан билээ. Энэ нь хүний чадвар, мэдлэг боловсролоороо эрэмблэгддэг байдлыг эвдэхэд ч хүргэж байгаа юм.

Улс төрийн системийн өөрчлөлт нь улс төрийн субъектууд засаглалаа хэрэгжүүлэх явцад бие биетэйгээ харилцах харилцаандаа шинэ норм, хэм хэмжээг гарган ирэхэд хүргэж байна.

1992 оны үндсэн хууль энэ шинэ зарчмын үндэс суурь болж, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын салбарт гүнзгийрүүлж нэвтрүүлснээр нийгэм шинэ бүтэц, тогтолцоотой болж амьдрах арга эвээ олжээ.

УИХ эрх зүйт төрийн хэм хэмжээнд нийцүүлэн төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч бүх бүрдлийн тухай хуулиудыг хэлэлцэн батлаж, тэдгээрийн дагуу уг бүтцүүдийг шинээр бий болгон зохион байгуулж ажиллуулсан юм. Энэ хэм хэмжээний дагуу улс төрийн засаглалаа хэрэгжүүлэх явцад улс төрийн субъектуудын хоорондын харилцаанд шинэ норм, хэв маяг бий болон тогтов. Тэрхүү шинэ норм, хэв маяг нь эрх зүйт төрийн хэм хэмжээнд зохицсон нь ч бий, бас ардчилал гэсэн нэрийн дор түүний үндсэн зарчмуудыг хөсөрдүүлсэн нь ч бий.

1992 онд батлагдсан шинэ үндсэн хуулийн дагуу олон намын систем, сонгуулийн альтернатив хувилбар, өрсөлдөөн, улс төрийн элитүүдэд хариуцлага тооцох байдал зэрэг ардчиллын хэм хэмжээнүүд нэгэнт бодит зүйл болов. 1990-1992 оны үеэс л эдийн засгийн байдал эрс уналтанд орсны улмаас энэ хариуцлагыг Улсын Бага Хурал, Засгийн Газар, тэдгээрийн эдийн засгийн бодлогыг хариуцсан хороо, дарга, гишүүд, сайдууд хариуцах ёстой гэж үзсэн уур амьсгаа бий болж, сонгуулиар тооцоо хийх болж ирсэн нь тоталитари улс төрийн системийн үед огт байгаагүй шинэ үйл явдал болов. Тиймээс ч улс төрийн элитүүдийн эрх мэдэл, байр сууриа олж авах гэсэн өрсөлдөөн нь өмнөх сонгуулиудад огт байгаагүй янз бүрийн амлалт,

сурталчилгаа, өрсөлдөгчөө зогсоо зайгүй муучлах гэсэн шинэ арга технологийг хэрэглэж эхэлжээ. Энэ нь шинэ улс төрийн системийн цаашдын хөгжлийн явцад сайн саар аль алиныг нь өөртөө шингээж сонгуулиас сонгуульд улам л боловсронгуй болсоор байна.

Сонгуулийн шинэ хэв маяг төлөвшин тогтохтой зэрэгцэн олон түмний санаа бодлыг өөртөө татах гэсэн улс төрийн нам, хөдөлгөөний өрсөлдөөн ширүүсч, улс төрийн элитүүд ч нэг улс төрийн хүчнээс нөгөө рүү шилжих явдал нилээд гарах болжээ. Энэ нь ялангуяа улс төрийн нэг намд нөлөөлөө тогтоож чадахгүй бол шинэ улс төрийн хүчинд шилжих юмуу, шинэ улс төрийн нам байгуулах замаар өөр арга зам, боломж хайсан шинжтэй, эсвэл, төрийн өндөр албан тушаал жишээлбэл, Ерөнхийлөгч, парламентын гишүүний сонгуульд өрсөлдөх боломжийг алдахгүй гэхдээ ингэж шилжих явдал нилээд ажиглагдах болсон юм.

1996 оны сонгуулийн дараа улс төрийн элитүүдийн хоорондын харилцаанд шинэ гэж хэлж болохуйц үйл явдлууд бий болов. Үүнд юуны өмнө МАХН түүхэндээ анх удаа сөрөг хүчний байр сууринд очиж ингэснээр өөрийн эгнээндээ боловсон хүчний хамгийн их нөөцтэй улс төрийн хүчин улс орны амьдралд гол үүргийг гүйцэтгэх эрхээ шилжүүлэхэд хүрсэн юм. Гэвч олон улсын жишигт парламентын дэд дарга нь сөрөг хүчний төлөөлөл байдаг тул УИХ-ын дэд даргыг МАХН-ын бүлгээс сонгуулах, УИХ-ын төрийн байгуулалтын болон төсөв, санхүү, мөнгө зээлийн асуудал эрхэлсэн байнгын хороон даргыг МАХН-ын бүлгээс сонгуулах зэрэг шаардлага тавьж УИХ-ын чуулганы үйл ажиллагааг тасалдуулахад хүргэж байв. Энэ нь МАХН, түүний удирдлага улс төрийн бодлогоос ор тас хүнийсгэгдсэн бус, харин тухайн үеийн үндсэн хуулинд зааснаар УИХ-ын үйл ажиллагаанд томоохон нөлөө үзүүлж чадах хэвээрээ байгаа гэдгийг харуулав.

1996 оны сонгуулиас хойш монгол оронд бараг уламжлал болон нэг шинэ хэв жаяг тогтов. Энэ нь парламентад олон суудал авсан, эрх баригч болсон нам нь нөгөө улс төрийн намуудын гишүүдийг өндөр албан тушаалаас хомроглон халах, эсвэл өндөр албан тушаалд томилохоос татгалзах болсон явдал юм. Ажил төрлөө зохих ёсоор гүйцэтгэж байсан улс төрийн биш, сонгуулийн үр дүнгээр солигдох учиргүй олон арван албан тушаалтан ажлаасаа халагдах болов. Энэ халаа сэлгээ 3 янзын хувилбартайгаар явагджээ.

1. Улс төрийн албанд ажиллаж байгаад сонгуулийн үр дүнгээр ажлаа өгсөн УИХ-ын гишүүд, сайд, дэд сайдууд ямарч ажилгүй хоцров. Ингэснээр тэдний оюун ухаан, арга туршлага нийгэмд ашиглагдахгүй өнгөрөхөд хүрнэ.

2. Сонгуулийн үр дүнгээс болж албан тушаал нь өөрчлөгдөх учиргүй олон арван албан тушаалтнуудыг халж сольж, төрийн хууль, хүний эрхийг зөрчиж байжээ.

3. Яам тамгын газарт шинээр томилогдон очсон сайд дарга нар очсон газар болгондоо бужигнуулж, мөн л санаанд тохирохгүй, үзэл бодол нийлэхгүй, нам улс төрийн гэх зэрэг шалтгаанаар халж сольж эхлэв. Энэ үед шинээр томилогдсон дарга, захирлууд халаа сэлгээ хийхгүй удвал хуучин сэтгэлгээтэй, өөрчлөлт шинэчлэлт хийхгүй хүн санамсаргүй байдлаар томилогдчихлоо гэж эргэлзэх байдал ч гарч байв. Гэхдээ энэ халаа сэлгээ нь бас өөрийн гэсэн учир шалтгаантай байсан болов уу. Үүнд, улс төрийн шинэ хүчин нэгэнт эрх баригч болсон болохоор өөрийн мөрийн хөтөлбөр, зорилгыг биелүүлэх чадвартай хүнийг чухал албан тушаалд тавих сонирхол байсан нь гарцаагүй. Нөгөө талаар МАХН 1990 оноос ард түмэн илүү итгэл найдвар хүлээлгэсээр байтал дорвитой өөрчлөлт хийж чадахгүй, ард түмний аж байдал доройтсон. Энэ хэрээр хуучин догматик улс төрийн хүчин юу ч хийж

чадахгүй нь гэсэн сэтгэлгээ ард түмний дунд ч, шинэ залуу ардчилсан хүчний дунд ч хүчтэй байсан тул энэ царцанги байдлаас гарах арга зам нь шинэ боловсон хүчнийг зохих газарт нь байршуулснаар асуудал шийдэгдэнэ гэсэн үзэл бодол давамгайлах их болсонтой холбоотой болов уу. Гуравдугаарт, нэгэнт эрх баригч болсон улс төрийн хүчний удирдлагад байсан хүмүүс өөрийн танил тал, найз нөхөд, санаа нийлэх хүмүүсээ өндөр албан тушаалд тавих сонирхол их байсан нь гарцаагүй. Энэ үед сайд, дэд сайд, Засгийн Газрын агентлаг, яамдын газар хэлтсийн дарга нар, томоохон сонин, телевизийн удирдлага, төрийн өмчийн компаниудын захирал, татварын газрын дарга гэх мэт нийгэмд чухал нөлөөтэй албан тушаалтнууд бараг бүгд солигджээ. Бүрэн бус тоогоор 1996 онд 1200 орчим хүн ажлаасаа халагдсан байна. Энэ үйл ажиллагаагаар зарим тохиолдолд оновчтой, эрх хүчтэй хүмүүс чухал албан тушаалд томилогдож байсан нь үнэн ч өндөр түвшний мэдлэг, чадвартай боловсон хүчнүүд хэлмэгдсэнийг бас үгүйсгэх аргагүй. Энэ хомроглон халах үйл ажиллагааг ганцхан ардчилсан хүчний талынхан хийснээр дуусгавар болсонгүй, 2000 оны сонгуулиар МАХН эрх баригч хүчин болсноор бас дахин давтагдсан юм. Ардчилсан зарчмын үндсэн дээр өрсөлдөөнтэйгээр сонгууль явуулах болсонтой холбоотойгоор эрх баригч болон эрх баригч бус элитүүдийн хооронд бас нэг шинэ таагүй харилцаа бий болж ирлээ. Энэ нь эрх баригч хүчин нь сонгуулийн кампанит ажил дөхөөд ирэхээр сөрөг хүчиндээ бололцоо олгохгүй, буланд шахсан, хэвлэл мэдээлэлд хяналтаа тогтоодог, үнэн бодит мэдээллийг нуун дарагдуулдаг төсвийн мөнгийг сурталчилгаандаа ашигладаг зэрэг үйлдэл их гаргах болжээ. Энэ нь 2004 оны сонгуулийн үед онцгой их хэмжээтэй ажиглагдсан бөгөөд МАХН сурталчилгаагаар ард түмний бялууртал нь булж, сөрөг хүчин өөрсдийгөө сурталчлах боломжгүй болгосон нь ард түмний зүгээс сөрөг хүчнийг өрөвдөх, дэмжих байдалд хүргэсэн билээ.

Улс төрийн системийн өөрчлөлт нь улс төрийн элитүүдийн үйл ажиллагаа, сонгон шалгаруулалт, хоорондын харилцаа, шинэ харилцаан дахь бие хүний асуудал, улс төрийн ухамсарын асуудал зэрэгт хэрхэн нөлөөлж байгааг өнөөгийн байгаа байдлаар харуулахад иймэрхүү дүр төрхтэйгээр бууж байна. Цаг үе, нөхцөл байдал өөрчлөгдөхөд энэ бүх харилцаа нь шинэ өнгө, шинэ түүх, шинэ зохицуулалтаар баяжин өөрчлөгдөж судлаачидад дахин шинэ боломж дэлгэн гаргах нь дамжиггүй.

Ном зүй

БНМАУ-ын Үндсэн хууль УБ., 1960

Монгол Улсын Үндсэн хууль УБ., 1992

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, УБ., 2006

Төрийн албаны тухай Монгол улсын хууль УБ., 1994

“Монгол Улсын Их Хурлын I удаагийн сонгуулийн төгсгөлийн чуулганы хуралдаан дээр УИХ-ын дарга Н.Багабандийн хэлсэн үг

“Орон нутгийн сонгуулийн үр дүн, түүнээс хийх сургамж” МАХН-ын Бага хурлын хуралдаанд Ерөнхий нарийн бичгийн дарга Н.Энхбаярын тавьсан илтгэл

“БНМАУ-ын сонгуулийн системийн ардчиллыг цаашид улам хөгжүүлэх тухай”, УБ., 1949.

БНМАУ-ын ерөнхий сайдын орлогч нөхөр Ю.Цэдэнбалаас БНМАУ-ын 9-р Их Хурал дээр 1949-2-17 нд илтгэсэн илтгэл

Г.Алмонд, Дж.Пауэл, К.Стром, Р.Далтон Харьцуулсан улс төр. Онолын хүрээ., УБ., 2005

Антология мировой политической мысли, М. 1997, Т.2

Антони Гидденс Социологи, УБ., 2006

Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал, УБ., 1997

Х.Гүндсамбуу Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага. ХХ зуун, УБ., 2002

Людвиг фон Мизес, Либерализм, УБ, 2004

Макс Вебер, Улс төр бол мэргэшил мөн. Шинжлэх ухаан бол мэргэшил мөн. УБ., 2000

Ч.Өлзийсайхан Элит судлал, УБ., 2006

Монголын тусгаар тогтнолыг хамгаалах ард түмний 281-ийн холбооны сонордуулга, “Засгийн газрын мэдээ” сонин, 1176, 1994-4-18

МАХН-ын Удирдах зөвлөлөөс “МАХН-ын гишүүдэд” хандаж гаргасан уриалга, Үнэн сонин, 1996-7-3

Зөвшилцөх тухай” УИХ дахь МАХН-ын бүлгээс МҮАН, МСДН-ын “Ардчилсан холбоо” эвсэлийн удирдлагад хандаж гаргасан мэдэгдэл, Үнэн сонин, 1996-7-17

Шинэ маягын хэлмэгдүүлэлт, Үнэн сонин, 1996-9-17

“МҮАН, МСДН, МАХН, МУНН-ын дарга нар болон нийт гишүүдэд” хандаж гаргасан баримт бичиг, Үнэн сонин, 160, 1998-8-12

МҮХАҮТ, МННХ, “Улс төрийн хүрээний авилгалын индекс” судалгааны материал, УБ., 2002

ПОЛИТОЛОГИ III
Эрдэм шинжилгээний бичиг¹ ... (...): 120-126 дахь тал

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН СИСТЕМИЙН БҮРДЭЛЖИЛТ

Ю.Атар
доктор (Sc.D)
МУБИС, ТНУС, Нийгмийн ухааны тэнхим

Монголын улс төрийн системийн түүхэн уламжлал бол Төв Азийн нутаг дэвсгэр дээр олон үеийн турш оршин сууж, хөдөлмөрлөн бүтээж ирсэн манай ард түмний эх түүхийн нэгэн тодорхой хэсэг бөгөөд монголчуудын оюуны соёлын төлөвшин боловсорч ирсэн түүхэн төлөв, залгамж холбоог илтгэн харуулна. Улс төрийн систем гэдэг бол төрөө байгуулж байгаа болон сэргээж байгаа улс орны түүхэн хөгжлийг илэрхийлэгч онцгой шинж болдог байна. Тэр нь нийгмийн ололт, хөгжлийн үзүүлэлт төдийгүй мөн төрийг хөгжүүлж хамгаалах, улс төрийн системийг төгөлдөржүүлэхэд чиглэсэн үзэл суртал, улс төр, ёс суртахууны тодорхой шалгууртай байдаг бололтой.

Үйлдвэрлэх хүчний хөгжил, анги ялгарал, феодалжих үйл явц ахиц олохын хэрээр угсаатан бүрэлдэх явдал түргэсч, Монголын нэгдсэн төр улс байгуулагдах урьдчилсан нөхцөл бүрдэж ирсэн талаар манай түүхчид өөрсдийн судалгааны бүтээлд өгүүлж иржээ¹.

Монголын улс төрийн системийн үүсэл, бүрэлдэл, төлөвшил 2200 орчим жилийн түүхтэй юм. Бүр МӨЭ 209 онд Түмэн шаньюгийн хүү Модун (Маодунь) эцгээсээ засгийн эрхийг булаан авч, Хүннү улсыг байгуулснаар Монгол туургатны гэгдэх өвөрмөц улс төрийн систем бүрэлдэх эхлэл тавигдаж, дараа нь Сяньби, Нирун, Түрэг, Кадан улсууд оршин тогтож байсан түүхэн сурвалж бичгүүдээс тодорхой. Тухайлбал Л.Н.Гумилев нарын эрдэмтэд улс төрийн системийн цөм ойлголт болох монголын эртний улсуудын төрийн байгууламжийг судлаад нийгмийн байгууллыг ангийн бус аймгийн холбоо гэж нэрлээд засаглалын хэлбэрийг «цэргийн ардчилал»² гэсэн байдаг.

Эртний улсуудын нийгэм, төрийн байгуулал нь дотоод харилцан уялдаа, амьд холбоос бүхий бүхэл бүтэн тогтолцоо, тэр үеийн дэлхий дахины түүхэн үйл явцын салшгүй бүрэлдэхүүн хэсэг байсан гэж³ судлаачид үздэг.

Эртний Хүннү, Сяньби, Нирун, Түрэг, Уйгар, Кидан зэрэг монголын эртний төр улсуудын төрийн байгууламж, ардчиллын түүхэн өвөрмөц хэлбэрүүдийг судалсан манай эрдэмтдийн судалгааны суурь бүтээлүүдийг анхааралтай судлан үзвэл эртний улсуудын төрт ёсны түүхэнд байсан улс төрийн системийн анхны хэлбэрүүдийн талаар дор дурьдсан санааг дэвшүүлж болмоор санагдана.

Үе залгамжлан сонгогддог хаан нь төрийн тэргүүний шинжийг олж, төрийн удирдлагын хаант засгийн хэлбэр сонгодог утгаараа хэрэгжсэн. Эртний улсууд нь цөм төрийн байгууламжийн хувьд нэгдмэл төвлөрсөн хэлбэрийн улсууд байсан бөгөөд Хүннүгээс эхлээд улсаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваариар баруун, зүүн гар, төв хэсэг хэмээн захирч иржээ. Энэ тогтолцоо нь жирийн ард буюу цэрэг хүн төрд хандаж, төрийн хэрэгт оролцох анхны алхам нь аравтын ахлагчаас эхэлж, зуут, мянгат, түмтийн ахлагч гэх мэтээр шатлан дамжсаар улсын хаанд хүрэх дараалалтай болж байв.

Түүнчлэн эртний улсууд овог аймгийн байгууллын үеийн ард нийтийн хуралдаан -Эе, Хүннүгийн үеийн их, бага хуралдаан зэрэг янз бүрийн хурал чуулган байсан. Улмаар ард нийтийн хурлаас ноёлох язгууртны явцуу хуралдаанд шилжиж, хожмын их хуралдайн суурийг⁴ алхам алхамаар тавьсаар байжээ.

Эртний төр, улсуудын нийгмийн байгууллын тогтолцоонд зан заншлын хэм хэмжээнүүдийн зэрэгцээ төр, төрийн түшээгээ эрхэмлэн дээдлэх ёсны уламжлал чухам энэ үеэс үүсэн бүрэлдсэн бололтой. Тухайлбал, «эвэр зүүх

нь нэг талаар овгийн байгууллын уламжлалыг тусгасан, нөгөө талаар тэдгээрийн тушаал, эрх мэдэл, сүр хүчийг бусад түшмэдээс нь ялгаруулсан тодорхой зүйл болов»⁵.

Монгол улсын төрт ёс, улс төрийн амьдралын түүхэн замналын талаарх олон талын цогцолбор судалгааны дүнгээс үзэхэд эртний улсуудын төр, нийгмийн байгууламжийн хүрээнд үндэс суурь нь тавигдсан улс төрийн систем нь монголын эзэнт гүрний үе, юань улс, улс төрийн бутралын үеүдэд зарчмын өөрчлөлт ороогүй боловч, түүхэн цаг үеийн шаардлага, нийгмийн дэвшлийн бодит өөрчлөлтийг тусгаж, нэгэнт буй болсон уламжлалаа тууштай хадгалах үндсэн дээр шинэчлэгдэн ирсэн гэж үзэж болно.

Тэгэхээр монголын төрт ёсны язгуур эх үндэс нь ямар нэг харийн соёл шашны номлол гэхээсээ илүү монголчуудын төрж өссөн өргөн уудам газар нутаг нүүдлийн иргэншил соёлоор нөхцөлдөж нэн тогтвортой оршин уламжилсан онцлог бүхий болно. Энэ тухай Л.Н.Гумилев «Хүннүгийн төрийн шинж, бүтэц зохион байгуулалт нь XIII зуун хүртэл бараг өөрчлөгдөөгүй хадгалагдаж ирсэн» гэж тэмдэглэсэн байна.

Монголын төрт ёсны уламжлал Төв Азийн өндөрлөгт оршин байсан Хүннү, Сүмбэ, Нирун зэрэг өвөг нүүдэлчин улсуудаас эх үндэстэй гэдэг нь өдгөө нэгэнт тогтоогджээ гэхийн хамт монголын төр бэхжиж тогтсон үеийн тухайд нэг мөр дүгнэлтэд хараахан хүрээгүй байна. Судалгааны бүтээлд Хүннү (МЭӨ III-МЭ II)-ийн төрийг анхны монгол төр гэж үзсэн бол нэг хэсэг судлаачид Чингис хааны «Их монгол улс» (1206 он) бол Монгол гэдэг улсыг дэлхийн түүхэнд баттай оруулсанаараа монгол төрийн анхны хэлбэр болж байдаг гэж үзнэ. Эдгээр санал дүгнэлтэд өөр өөрийн үндэслэл байгаа ч түүх хийгээд төрийн онолын үүднээс нарийвчлан шинжлэх шаардлагатай бөгөөд харамсалтай нь дагнасан судалгаа энэ хир хийгдэхгүй байна. Монгол нутагт оршиж байсан нүүдэлчин угсаатнуудын (Хүннү, Сяньби, Нирун) төр улс үүсэх, ээлжлэн солигдох, мөхөх явцад язгуурын монголчуудын байр суурь ямагт өргөжин тэлж нягтран бэхжиж байсны үр дүнд нүүдэлчин улсуудын хаан угсааны овгийн ерөнхий нэрээр нэрлэсэн хамаг Монголын хаант улс Их Монгол улсын босгон дээр оршиж байсан билээ.

Хамаг монгол улсад бие даасан төр улсын шинж төрх байсан эсэх талаарх асуудал маргаантай байна. Түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн болон түүхийн шинжлэх ухааны үүднээс судалсан бүтээлүүдээс эрэгцүүлэхэд Нирун улс (330-350)-ыг задарсны дараах үеийн ханлиг улсуудыг төрийн онол арга зүйн үүднээс авч үзвэл бие даасан улсын шинжийг агуулсан байсан гэж хэлж болохоор байна.

Энэ үеийн ханлиг улсуудад төрийн үндсэн шинж болох нутаг дэвсгэр хүн ам нийтлэг засаг байгаагүй гэж батлахад нэн бэрх юм. Үүнээс үндэслэж монгол төрийн хөгжлийн анхны үеийг Хүннү эсхүл Их Монгол улстай бус харин хамаг Монголын хаант улстай холбон үзэж болох талтай. Хамаг монголын хаант төр, өвөг монгол улсуудын төрт ёсыг тасралтгүй уламжилсан нь түүний төрийн бүтэц, зохион байгуулалт, төрөө засах арга ухаанаар илэрч байсан байна. Үүгээр монголын хаант төрийн түүхэн үе эхэлсэн гэж ойлгож болох талтай.

Монголын нэгдсэн тулгар төрийг байгуулж, түүний үүрэг ач холбогдлыг тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийг өмнөх тогтолцооноос улам нарийсгаж, хууль цаазыг буй болгон мөрдүүлж, үлгэр жишээ болохуйц цэрэг арми байгуулан бэхжүүлж, хатуу чанга сахилга журам тогтоож, төрийг байнга хүндэтгэн бэхжүүлэхийн чухлыг бүх талаар үндэслэсэн Чингис хааны төрт ёсны үзэл нь тэр үеийн монголын улс төрийн системийн бас нэг онцлог болж байжээ.

Монголын нэгдсэн төр байгуулагдсанаар монгол угсаатны олон аймаг нэгдэж⁶, монгол угсаатан бүрэлдэх үйл явц үндсэндээ дууссан нь монголын улс төрийн системийг бэхжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Монголын улс төрийн системийн нөгөө нэг онцлог шинж нь төрт ёсоо шүтэн дагаж төлөвшсөнийх гэж үзэж болох талтай.

XIII зууны эхээр бүрэлдэн тогтсон монгол угсаатны их улсын төрийн удирдлагын хэлбэрийг тодорхойлон бичвэл хүн төрөлхтний соёл иргэншлийн дундат үеийн феодал ёсон бүхий хаант засагт угсаа залгамжлах замаар өргөмжлөгдсөн хаан төрийг тэргүүлэн, төрийн дээд эрх мэдлийг гартаа төвлөрүүлж, улсаа жолоодон захирах шийдвэрийг эцэслэн гаргадаг их эрх мэдэлтэй байх нь нийтлэг шинжтэй байсан бөлгөө.

Засгийн бүх эрх мэдэл нэг хүн буюу хаанд төвлөрч, тэр нь төрийн байгуулалт, хууль цаазаа тогтоон, улсын дотоод гадаад бодлогоо гардан барьж, цэрэг армийг удирдах, шүүн таслах хэргийг шийдвэрлэх талаар дээд эрх эдэлж байсан ажээ. Энэ үүднээс үзвээс Монголын нэгдсэн улсын хааны хувьд нэлээд онцлог буй бөлгөө.

Хуралдай бол Монголын нэгдсэн хаад, ноёдын хуран чуулах гол хэлбэр-төрийн чуулган байжээ. Энэ нь эзэнт гүрний үед их хуралдай нэртэйгээр хүн төрөлхтний түүхэнд парламентат ёсны үндсийг тавьсан. Төр, эзэн дээдсээ эрхэмлэн хүндэтгэх уламжлалт үзэл, олон жилээр үе залгамжлан хөгжсөн ардын зан үйл, ёс заншил, эртний төр улсын хөгжлийн түүхийн явцаар буй болсон хэв хуулийг сайтар харгалзан тооцсон төрийн анхны томоохон тулгуур хууль их засаг хуулийг боловсруулан мөрдөв.

Энэ хоёр томоохон үйл хэргийг дэлхийд анхных байсан гэж эрдэмтэд баттайгаар бүрэн үндэслэж чадаагүй байгаа боловч эдгээр нь зөвхөн монголын ард түмний хувьд төдийгүй нийт хүн төрөлхтний улс төр, эрхийн сэтгэлгээний гайхамшигт ололт гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрөх үндэслэл байгаа билээ.

Монголын тулгуур төрийг бэхжүүлэн хөгжүүлэх үйлсэд Чингис хааны анхны залгамжлагч Өгэдэй хааны оруулсан хувь нэмэр их бөгөөд тэр хаан нүүдлийн амьдрал эрхлэхийн зэрэгцээгээр бас засгийг дээд эрх баригчдад ойртуулах, худалдаа, газар тариалан, хотын амьдралыг эрхлэх хандлагад орж байсан нь түүний улс төрийн системийн хэв шинжид гарсан чухал ач холбогдол бүхий шинэ зүйл байжээ. Монголын нууц товчоонд тэмдэглэснээр тэр үеийн монголын төрт ёсны үзэлд улс төрийн мандан бадрах цаг болбоос эзэн гэгээн, сайд мэргэн, түмэн иргэн эевэргүү, харин бууран доройтох цаг болбоос зусар зулхай сайд, янаг дотно хатан эрх барилцаад улс гэрийг самууруулах буюу хэмээсэн эртний үгийг эш үндэс болгож, мандах төрийн сайд өөрийн гэмээ илэрхийлэн үзүүлмой, буурах төрийн эзэн түшмэд өөрийн гэмийг халхлан аргалмой хэмээх үзэл санаа хүчтэй үйлчилж байв.

Төр тогтвортой, түмэн олон дээдлэн хүндэтгэж байх нийгмийн шалтгаан хүчин зүйл ч байсан. Нийгмийн үндсэн бүтэц зохион байгуулалтанд цусан төрлийн холбоонд тулгуурласан хүмүүсийн нийтлэг зонхилж байсны улмаас ахас дээдсийг ямагт хүндэтгэж тэдний үг сургаалыг хэлбэрэлтгүй мөрдөгдөх хэм хэмжээ мэт байсан юм. Чингис хааны билигт «эцгийн үгийг үр хүүхэд, ахын үгийг дүү нар нь үл сонсох, нөхөр нь эхнэртээ итгэхгүй байх, эхнэр нь нөхрийн үгийг үл дагах, бэр нь хадам эхийгээ үл хүндэтгэх, ахмад хүмүүс бага залуусыг хүмүүжүүлэхгүй байхыг үл тэвчинэ» гэж сургасны учир ийм буюу.

Хамаг монголын хаант төр- монгол угсаатныг нэгтгэх замаар хаант төрөө бэхжүүлэхийг зорьж байсан бол Их Монгол [тухайн цагтаа дэлхий дахиныг] амар тайван байлгахын тулд хүн төрөлхтнийг нэгэн толготой болгох

бодлого явуулж байсан байна. Үүгээр Чингис [Тэмүүжин 1162-1227] болон түүний залгамжлагчдын хийсэн их аян дайны зорилгыг тодорхойлж⁷ болох юм.

Хубилай хааны улс төрийн байр суурь «Арван буянт номын цагаан түүх» хэмээх дурсгал бичигт тодорхой тусгагдсан байна. «Цагаан түүх» бол Хубилай хааны үеийн урьд хождын тогтоон нийтэлсэн хууль цаазны эмхэтгэл бөгөөд судалж үзвэл тэр нь монголын улс төрийн системд төр шашин гэсэн хоёр ёсыг тэгш хослон явуулах тухай хууль цааз, дүрэм тогтоолын цоморлиг гэж үзэж болох юм. Хубилай хаан эртний Энэтхэг, Түвдийн хаадын ёсоор «эдүгээ би бээр түүнчлэн хоёр ёсыг тэгшээр явуулсугай»⁸ хэмээн төвдөөс Пагва ламыг залан ирүүлж, сүм хийд олныг байгуулжээ. Тэгээд шашин, төр хоёр ёсыг тэгш явуулах хэмээх нь шашны ёс, төрт ёс хоёрын харьцааг зөв тогтоож, тэгш хослон барих явдал гэж үзжээ.

Энэ тухай Цагаан түүхэнд: «Номын засаг үгүй бөгөөс амьтнууд тамд унаж, хааны засаг үгүй бөгөөс улс аймаг эвдрэх больюу» хэмээн өгүүлжээ. Үүний цаана хүмүүсийн сүсэг бишрэл, шашин шүтлэгийг ашиглан улс төрийн засаглалыг чангаруулах, түүний үндэслэлийг тодорхойлох зорилго агуулсан нь илэрхий. Энэ бүгдээс үзэхэд Монголын тулгар төрийг үндэслэн байгуулсан эзэн Чингисийн улс төрийн үзэл нь түүний үйл хэргийг цааш залгамжлан үргэжлүүлсэн үр ач нарынх нь үед ч уламжлагдаж байсны зэрэгцээ тухайн нөхцөл байдлын дагуу зохих өөрчлөлтүүд хийж байсан бөгөөд нягталж үзвэл уг төр нь цэргийн засаглалаас иргэний засаглалд улам бүр шилжих болсон нь илэрхий байна. Ялангуяа Монголын төрийг цааш бататган бэхжүүлэхэд чухал түлхэц өгсөн шашин төр хоёр ёсыг тууштай хэрэгжүүлэх арга зам хийгээд зохион байгуулалтын олон асуудлыг нягтлан боловсруулж, дотоод холбоог тал бүрээс нь гүнзгий тодорхойлсон нь өгүүлэн буй үеийн монголын улс төрийн системийн төлөвшлийн чухал онцлог болж байжээ.

Төр хүчтэй байхын үндэс- хаан хүний үйл мөр зөв агаад мэргэн байх явдал хэмээн үзэж хаан хүний гурван үйл [номд мэргэн, төрийн эрдэмд төгс, цэргийн урлагт мэргэжсэн], дөрвөн их төр [энэрэн туслах, эеийг эрхэмлэх, төрийн түшээ нарыг төрд үнэнч, шударга ажиллуулах], зургаан их үлгэр [үлгэр дууриалттай бурхны зарлигийг үнэнч биелүүлэх төрт ёсыг түвшин барих, дураар үл авирлах зэргээр төрийг засах арвилан хэмнэх дууриалтай байх], долоон их бин [гүн ухаан, угтан харах чадвар, нээн таних ухаан, одоог ухаарах, бусдын санаа зоргийг мэдэх, аян авын явдал болон таван ухааныг нэгтгэх], есөн их бэлгэ [хар туг, улаан бүрээ, хуур, шар шүхэр, илд, эмээл, хүнд бүс, асар түших цэргийн нөхөд]-ийг хаан төрийн хатуу журам болгон мөрдөж байсан⁹ нь Монголын төр тогтвортой дээдлэн хүндэтгэх нэг үндэс болж байжээ.

Улс төрийн бутралын үед «Монголын төр хэлбэрийн хувьд хаант засагтай боловч, эрхийн талаар хязгаарлагдмал шинжтэй байлаа. Өөрөөр хэлбэл, тэр үед хэмжээгүй эрхт хаант засаг сонгодог утгаараа хараахан үйлчилж чадаагүй юм»¹⁰.

Их хуралдайн оронд Ноёдын чуулган хийдэг болсон бөгөөд энэ нь нийт улсын хэмжээнд чуулж төрийн хэргийг хэлэлцдэг байлаа. Мөн үүний зэрэгцээ цаг үеийн яаралтай асуудал гарахад отог, хошуудын аль нэгэнд ноёд, түшмэдүүд цуглан хуралдаж хэрэг шийддэг цуглааны хэлбэр ч байсныг эрдэмтэн түүхч Х.Пэрлээ агсан тэмдэглэсэн байна¹¹.

Ноёдын чуулган болон цуглааны аль аль нь эхэн үедээ хаанд зөвлөх шинжтэй байсан бөгөөд хааны эрх мэдэл сулран улмаар алдагдах болсноор эцсийн шийдвэр гаргадаг болсон байна. Энэ бол тухайн түүхэн цаг үеийн улс төрийн системийн гол хэлбэр болсныг харуулж байгаа юм.

Гэвч эзэнт гүрний эрх баригчдын явуулж байсан үндэсний хатуу бодлогоос шалтгаалан их гүрний дотор эсэргүүцэл хөдөлгөөн ихсэж, яваандаа эзэнт гүрэн задран унах хандлагатай болж иржээ. Энэ нь монголын их гүрний дэвсгэр нутаг хаадын үр ач нарын эзэмшилд хуваагдаж, тэдгээр нь том ноёд монголын их хааны зарлигийг биелүүлж, түүнд захирагдах нь суларч эхэлснээс тодорхой харагдаж байна. Тэр ч байтугай эрх ямба, эзэмшлийнхээ төлөө хоорондоо хямралдан тэмцэлдэх болсон нь яваандаа манжийн эзлэгчдээс монгол дахь улс төрийн засаглалыг өөрийн эрхэндээ оруулах явдлыг нөхцөлдүүлэх нэг шалтгаан болсон байж болзошгүй.

Манж нараас Монголыг эзэлсний дараа монгол улсыг манж гүрний зах хязгаарын дарлагдмал мужуудын нэг болгон хувиргаж, эзэн хааны эрх мэдэл нь үлэмж хэмжээгээр хязгаарлагдан хэрэг дээрээ манж дайчин улсын хааны гарт шилжжээ. Тэр үед монголын улс төр, хууль цааз, гадаад харилцааг удирдах дээд эрх мөн л манж нарын мэдэлд байв. Тэр цагт монголын хаан, манж эзэн хааны зарлигийг үг дуугүй биелүүлэгч хараат этгээд нь болжээ.

Монголд ламын шашин дэлгэрч, тэр нь манж нарын түрэмгийллийн эзвсэг болоод, төрийн хэрэгт шашны оролцоо нөлөөтэй болмогц монгол улсыг угсаа залгамжилсан хаан захирахаа болиод, шашин төрийн эзэн гэгдэгч Богд гэгээнийг манж хааны талархал, түвдийн далай ламын өргөмжлөлөөр суулгах болжээ. Богд гэгээн хэдийгээр шашин төрийн эзэн гэгдэх боловч түүний улс төрийн эрх мэдэл нь манжийн хааны хяналтанд байлаа. Энэ нь нэг талаар үзвэл феодалын монгол улс бусдад эзлэгдээд, улс төрийн бие даасан байдлаа алдсаныг өгүүлж байгаа билээ.

Монгол улсын тусгаар тогтнол алдагдаж манжийн эрхшээлд орсон түүхийн ээдрээтэй үед ч монголын төрт ёсны хөгжил бүрэн алдраагүй юм. Монгол улсыг Манж чин гүрний эзэн хаан Бээжингээс жолоодож байв. Колоничлолын үеийн Монгол дахь засаг захиргааны албан тушаалуудад хэнийг нь томилох, огцруулах, хэнийг нь шийтгэх асуудлыг Манжийн хааны айлтгалаар шийддэг байв.

Манжийн хааны шууд нөлөөнд Гадаад монголын төрийг засах яам, манж жанжны газар, аймгийн жасаа, аймаг, хошуу, сум, баг, арван гэр гэсэн засаг захиргааны шаталсан бүтэц бий болжээ. Манж жанжны хяналтан дор тухайн аймгийн бүх асуудлыг зөвлөлдөн шийдвэрлэх эрх бүхий аймгийн чуулган ажиллаж байв. Тэрчлэн шашны хутагт хувилгаадүүд засаг захиргааны зарим эрх эдэлж төрийн тамга түшиж байсан учраас энд улс төрийн системийн өвөрмөц хэлбэр үйлчилж байсан гэх үндэслэл байна.

Гэвч монголын ард түмэн манжийн түрэмгийллийг эсэргүүцэн үндэснийхээ улс төрийн бүрэн эрхт байдлыг сэргээн тогтоохын төлөө тасралтгүй тэмцсээр ирсэн билээ.

Манжийн эзлэгчид монгол төрийн зохион байгуулалтанд зарим өөрчлөлт хийж, манж хааны төлөөний түшмэлийн хяналтын дор эзэмшин захирах эрхийг монголын зарим түшмэдэд үлдээж, тэднээр дамжуулан улс орныг ноёрхож байсан юм. Ингэхлээр манжийн ноёрхол дахь монголын төрийн удирдан захирах хэлбэр нь уг чанартаа феодалын хэмжээт эрхт теократ¹² улс төрийн систем¹³ байсан байна.

Дэлхийн улс орнууд шинэ зууны босгыг алхахдаа хөгжлийн янз бүрийн түвшинд оршиж байв. XX зуун хөгжил дэвшлийн эрин үе болж, улс үндэстэн маань улам цэцэглэнэ хэмээн Англи, АНУ, Францын хэвлэлүүд итгэл төгс бичиж байлаа. Гэтэл Монгол орон өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудаас хэдэн зуунаар хоцорсон, хамжлагат ёс хуваарьгүй ноёрхсон, Манж Чин улсын колони, алс бөглүү хязгаар нутаг байв. Чин улс XX зууны босгон дээр «шинэ засгийн бодлого» гэгчийг зарлаж, Монголд хятад иргэдийг үй олноор

шилжүүлэн суурьшуулах, Монголын тал нутгийг тариалангийн газар болгон хагалбарлах, монголчуудыг хятадчилах, хятадын засаг захиргаанд шууд харъяалуулах бодлого явуулах болсон юм. Энэ нь монголчуудын язгуур эрх ашигт шууд харшилж, үндэснийхээ эрх чөлөөний төлөө босон тэмцэхэд хүргэжээ. Харийн дарангуйлалаас ангижирсан цагт улс орноо сэргээн мандуулах боломж нээгдэнэ гэж монголын нийгмийн дэвшилт хүмүүс үзэж байв¹⁴.

1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнгээр мөн оны 12-р сарын 29-нд Богд Жавзандамба хутагтыг тусгаар улсын хаанд өргөмжилж, Монгол Улсын тусгаар тогтнолыг тунхагласнаар XX зууны монголын улс төрийн түүхийн цоо шинэ үе эхэлсэн билээ.

Тусгаар тогтносон Монгол улсын төрийн байгуулал нь шашин-төрийг хосолсон хамжлагат ёсны хэмжээгүй эрхт хаант төр байлаа. Түүнчлэн Улсын дээд ба доод хурлаар хууль тогтоох эрх мэдлийг, Ерөнхий сайд, Бүгд ерөнхийлөн захирах яам болон төрийн бусад яам гүйцэтгэх эрх мэдлийг, Шүүх яам шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байсны зэрэгцээ шашин төрд туслах яам улс төрийн системд онцгой байр суурь эзэлж байлаа. Гэхдээ төрийн дээд эрх мэдэл эзэн хаанд хадгалагдаж байснаараа онцлог шинжтэй байв.

Олноо өргөгдсөн үед [1911-1920] ч Монголд феодалын хэмжээгүй эрхт теократ улс төрийн систем тогтож байлаа. Тэр үед Монголын улс төр, хууль цааз, цэрэг, дотоод харилцаа, шашныг удирдах бүх эрхийг Монголын хаан Богд Жавзандамба мэдэж байлаа. Гэхдээ гадаад харилцааны асуудлыг Богд Жавзандамба, түүгээр толгойлуулсан засаг бие даан шийдвэрлэж чаддаггүй байсан. Монгол улс феодалын маш хоцрогдмол орон байсан төдийгүй, гадаадын империалист орны гол өрсөлдөөний газрын нэг байлаа. Энэ учраас манжаас тусгаарласан Монгол улс гадаад гүрнүүдийн шахалтанд орж, гадаад харилцааны эрх мэдлийн шийдвэрлэх хэсгийг хаант Орос, Япон, Хятадын эрх баригчид булааж, тэд голлон шийдвэрлэдэг болсон байлаа.

Энэ бүгдээс үзэхэд монголд оршиж байсан феодалын төлөвийн улс төрийн системийн хэлбэр нь түүний түүхэн төлөвшлийн явцад монголын нийгэм дэх улс төрийн хүчний харилцаа, хоорондын тэмцлийн өсөлт өөрчлөлт болон гадаад нөхцөл байдлаасаа шалтгаалан өөрчлөгдөж ирсэн нь илэрхий.

Монголын нийгмийн улс төрийн системийн төлөвшлийн ирээдүйн их өөрчлөлтийг тодорхойлоход юуны өмнө тус улсын тусгаар тогтнол, эрх чөлөөний асуудал хөндөгдөж байсан бөгөөд тодорхой нөхцөл байдлын улмаас Монгол орон XX зууны эхээр аль нэг их гүрнийг түшихээс түүний хувьслын чиг хандлага хамаарах байлаа. Монголчуудад бусдын шахалтанд өртөж улс төрийн системийн олон зууны уламжлалаас хазайхад хүрч байсан үе нэг биш удаа тохиолдож байсан билээ.

Монгол орон 1921 оны босгон дээр гадаадын хэд хэдэн булаан эзлэгчдийн дажин самууны хөлд өртөгдсөн, улс төрийн систем нь задран унасан, улс төрийн бие даасан байдал алдагдсан, нийгэм, соёл, эдийн засаг, үйлдвэрлэх хүчний хувьд туйлын дорой, ард олны аж амьдрал ихээхэн ядуу зүдүү байдалтай байсан нь тодорхой юм. Чухамхүү ийм түүхэн нөхцөл байдлаас эхлэлээ тавьсан Монгол улсын 20-иод оны шинэтгэх алхам 90-ээд оныг хүртэл 70 гаруй жилийн хугацаанд амаргүй замыг туулсаар одоо цагийн хэмжээ, түвшинд хүрч ирээд байгаа билээ.

Ишлэл, зүүлт

- ¹ Жишээ нь энэ тухай: Доржсүрэн Ц. Умарт Хүннү. УБ., 1961; Сэр-Оджав Н. Эртний Түрэгүүд [ҮІ-ҮІІІ]. УБ., 1970; Монголын эртний түүх. УБ., 1977; Пэрлээ Х. Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь. УБ., 1959; Монгол улсын түүх. УБ., 1999. зэрэгт үзнэ үү.
- ² Гумилев Л.Н. Хунну. М., 1964, с.71.
- ³ Болдбаатар Ж., Лүндээжанцан Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997, 42 дахь тал.
- ⁴ Мөн тэнд. 18 дахь тал.
- ⁵ Дашням И. Монгол улсын төр, эрх зүйн түүх. (МЭӨ 209-МЭ ХІІІ зууны дунд үе). Тэргүүн боть. УБ., 2005, 51 дэх тал.
- ⁶ Монгол гүрэнд тэр үед монгол үндэстнүүд өөрөөр хэлбэл монгол туургатнууд бүхэлдээ хамрагдаж байсан. Өөрийн гэсэн засаглалтай бас төрт ёсны уламжлалтай, өөрийн соёлтой, бэлчээрийн нүүдлийн мал аж ахуйтай өвөрмөц сэтгэл зүй, ёс заншилтай, бусад орны халдлагаас улс орноо хамгаалах үлэмжийн чадалтай ийм гүрэн оршин тогтнож байв.
- ⁷ Монгол улсын түүх. УБ., 1999, 63-68 дахь тал.
- ⁸ Энэ талаар: Баярсайхан Б. Монгол улсын арван буянт номын цагаан түүх. УБ., 2002; Жалан-Аажав С. Арван буянт номын цагаан түүх. УБ., 1998; Арван буянт номын цагаан түүх. Хөх хот, 1981, 81-82 дахь талд үзнэ үү.
- ⁹ Арван буянт номын цагаан түүх. Хөх хот, 1981, 47-48 дахь тал; Жалан-Аажав С. Арван буянт номын цагаан түүхийн тухай. УБ., 1998; Баярсайхан Б. Монгол Улсын арван буянт номын цагаан түүх. УБ., 2002 үзнэ үү.
- ¹⁰ Болдбаатар Ж., Лүндээжанцан Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997, 109 дэх тал.
- ¹¹ Пэрлээ Х., Бира Ш. Монгол ба Төв Азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг. УБ., 1974, 110 дахь тал.
- ¹² Тео бурхан гэсэн грек үг. Шашин номын болон сүм хийдийн тэргүүн засгийн эрхийг эрхшээлдээ оруулмагц бурханы засаглал тогтлоо гэж үздэг. Өөрөөр хэлбэл шашны ёс, төрийн ёсыг хослон барих.
- ¹³ Атар Ю. Ардчилсан тогтолцоонд шилжих үеийн төр, нийгмийн харилцааны асуудал. УБ., 2001, 47 дахь тал.
- ¹⁴ Монгол ардын хувьсгалт намын түүхэнд холбогдох товчоон. УБ., 2001, 3 дахь тал.

ЗАЛУУЧУУД БА ЗАСАГЛАЛ¹

Г.Цэнд-Аюуш
докторант, ахлах багш
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

ОХУ-ын судалгааны “ЦИРКОН” группийн хэсэг судлаачдын “Залуучууд ба засаглал: харилцан түшилцэхийн эрэл хайгуулд” төслийн хүрээнд 2005 оны 6-7 сард 16-24 насны бүх Оросын залуучуудын дунд явуулсан судалгааны үр дүнгийн талаархи арга зүй-танин мэдэхүйн бидний сонирхол татсан шинжилгээний тайлангийн материал² “Полития” ¹⁴ (39) сэтгүүлд нийтлэгдсэнийг миний бие чадан ядан товчилж утгачилан орчуулахыг эрмэлзэв.

Судалгааны ажлын үндсэн хэмжүүрүүд

Бүх Оросын залуучуудын судалгааг түүврийн дагуу 1866 залуучуудыг хамруулан явуулсан байна. ОХУ-ын 16-24 хүртэлх насны залуучуудын хүйс, хөдөлмөр эрхлэлт, оршин суугаа газрын (хот, тосгон, суурин) болон ОХУ-ын зарим холбооны тойргийн бүтэц, бүрэлдэхүүнийг тусгаж түүврийн ерөнхий хэмжээг тогтоосон байна.

Москва хотод хүн ам хамгийн нягтралтай байдгийн онцлогийг харгалзан түүврийн ерөнхий хэмжээг 362 хүнээр тогтоожээ.

Мэдээлэл цуглуулах ажлыг судалгаанд оролцогчдын оршин суугаа газарт нь очиж тусгай боловсруулсан анкетийн дагуу шууд сурвалжлага авах замаар гүйцэтгэжээ.

Зарим тусгай бүлэг хэрэглэгдэхүүн болгож бэлтгэхийн тулд горимын шинжтэй нэмэлт судалгааны үр дүнгүүдийг ашигласан байна. (Тухайлбал: санал асуулгын явцад ОХУ-ын ерөнхийлөгчийн болон түүний засаг захиргааны ажилтнуудын хэлсэн үг, хийсэн мэдэгдэлд залуучуудын зүгээс хэрхэн хандаж байгаа талаар санал асуулгын болон шинжээчдийн дүгнэлт тайлбар залуучуудын улс төрийн идэвхи, засаглалыг дэмжих боломжит сэдэл, хөшүүргийн цуглуулгыг олж авах зорилгоор залуучуудтай мэтгэлцээний фокус бүлгийн удаа дараагийн ярилцлага гэх мэтийг)

Судалгааны судлагдахууныг дараахь байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Засаглалд хандах харилцааг дараахь хэмжүүрүүдээр тусгагджээ.

Үүнд: итгэх итгэл, үйл ажиллагааны үнэлэлт, сонгогчдын дэмжлэг,

¹ ОХУ-ын “Оросын нийгэм-улс төрийн төв” сангаас эрхлэн гаргадаг “Пёёёёё” сэтгүүлийн 2005-2006 оны 4 (39) дугаарт нийтлэгдсэн “Молодежь и власть: в поисках взаимной опоры” хэмээх эрдэм шинжилгээний өгүүллийн МУИС-ийн улс төр судлалын тэнхимийн ахлах багш Г.Цэнд-Аюушийн орчуулснаар та бүхэнд толилуулж байна.

² Сааидеи Е.А. О’пёёёёё буюуаёсёёуа+ аёоёёёё оёёёаа+ аёёсёё:
Оёаёёа Е.А. Еёёёаёёа А.А. Оёёёёёа А.А.
Саёёёаа А.А. Яёоёёёа А.А. (Оёёёаааё аёёёёёаёаё оёёёуу+)

- засаглалын санаачлагыг дэмжих, засаглалын төлөө эсхүл эсэргүүцсэн идэвхитэй үйлдэлд бэлэн байх чанарыг тодорхойлох.
2. Засгаас өөртөө ашигтай орчин бүрэлдүүлэх чиглэлээр зохион байгуулж буй үнэт зүйлс үзэл суртлын өнгө аясад хандах харилцаа
3. Улс төрийн идэвхитэй чанар, оролцоо (улс төрд сонирхох байдал, улс төрийн байгууллага, үйл явдалд оролцох, улс төрийн оролцооны хэлбэрүүд)
4. Улс төрийн идэвхитэй чанарын сэдлүүд (засаглалыг дэмжих, эсхүл засаглалыг эсэргүүцэх улс төрийн үйл байдал)
5. Үнэт зүйлсийн хуваарилалт, засаглалд хандах харилцааны шалгууруудаар ангилсан залуучуудын янз бүрийн бүлгийн нийгэм-хүн ам зүйн болон бусад тодорхойлолтууд.

Судалгааны зорилго ба түлхүүр ойлголтууд

Судалгааны гол зорилго бол Оросын залуучуудын янз бүрийн бүлгийн (тоон болон чанарын хэмжүүр дэх) одоо үйл ажиллагаагаа явуулж буй засаглалын “талынхныг” ялган тодорхойлохын зэрэгцээ мөн түүнийг “эсэргүүцэгч”, “замын хань” болох бүлгүүдтэй харьцуулсан дүгнэлт гаргахад оршино.

Тухайн төсөлд “засаглалын талынхан” гэсэн ойлголтыг дараах хоёр үндэслэлээр тодорхойлогдож буй бие хүмүүсийн цогц хэмээн авч үзэгдсэн болно.

Нэгд; Одоо үйл ажиллагаагаа явуулж буй засаглалд үг хэл яриагаараа идэвхигүй үйл байдлаа илэрхийлэх (ёсчлогдсон итгэх итгэл, сонгогчийн дэмжлэг, идэвхитэй үйлдэлд дэмжлэг үзүүлэхэд бэлэн байх чанар гэх мэт) эсхүл идэвхитэй бодит үйл байдлаар (саналаа өгөх, цуглаанд болон засгийн байгууллагуудын ажилд оролцох өөрөөр хэлбэл үйл байдлын эв санааны илэрхийллийг шингээсэн эерэг харилцаа)

Хоёрт; засгаас “өөрийн дүр зургийг” төлөвшүүлж буй үнэт зүйлс, үзэл суртлын өнгө аясыг хуваалцах (тэр тусмаа үйл байдлын түвшинд) үнэт зүйлсийн эв санааны илэрхийлэл. Тиймээс уг төсөлд дэвшигдсэн зорилгыг хангахын тулд дээр дурьдсанчлан хоёр үндэслэлээр Оросын залуучуудыг ангилах оролдлого хийсэн байна. Ерөнхийлөгчийн засаглалд хандах харилцааны талаар залуучуудын орчинд янз бүрийн бүлгүүдийг ялгаруулах (засаглалын талынхан, эсэргүүцэгчид, төвийг сахигчид); Засаглалаас төлөвшүүлж буй үнэт зүйлсийн талаар (засаглалын үнэт зүйлсийг хуваалцдаг) “эв санааны талынхан”; засаглалын үнэт зүйлсийг үл хуваалцдаг, хүлээн зөвшөөрдөггүй эсхүл ямар ч ялгаагүй байдлаар ханддаг янз бүрийн байр суурьтай бүлгүүдийг залуучуудын дунд ялгаруулах хоёр үндэслэл бүхий ангиллын үр дүнд Оросын залуучуудын хэд хэдэн бүлгийн ялгарлыг тогтоож харуулах боломж гарсан байна. Үүнд:

1. Засаглалын талынхан-засаглал түүний үнэт зүйлсэд тааламжтай эерэг ханддаг залуучууд.,
2. Засаглалын нөхцөлт талынхан-засаглалд тааламжтай ханддагч түүний үнэт зүйлсийг хуваалцдаггүй. (замын хань нар).,
3. Засаглалын потенциал талынхан- тухайн нөхцөл байдалд засаглалд төвийг сахисан байдлаар хандахаа мэдэгддэг хэдий ч түүний үнэт зүйлсийг хуваалцдаггүй.,

4. Ерөнхийлөгчийн засаглалыг эсэргүүцэгчид (сөрөг хүчин) - засаглалд эсрэг байрнаас хандах бөгөөд засаглалын үнэт зүйлсэд эсрэг үнэт зүйлсийг сөргүүлэн тавьдаг.,
5. “намаг”- тухайн нөхцөлд засаглал, түүний үнэт зүйлсэд хандах харилцаа нь тогтоогүй өөрөөр хэлбэл тодорхойгүй залуучууд тодорсон байна.


Ерөнхийлөгчийн засаглалд хандах залуучуудын хандлага

Судалгааны үр дүнг шинжлээд үзэхэд Оросын залуучуудын дийлэнхи нь ОХУ-ын өнөөгийн Ерөнхийлөгч В Путинд итгэл үзүүлэх байдал 72%, түүний үйл ажиллагаагаа явуулж буйг дэмждэг 74% гэсэн дүн гарсан байв.

Сонирхол татаж буй нэг зүйл бол энэ параметрээр Путины засаглалд (ялангуяа итгэл үзүүлэх түвшингээр) 16-24 насны залуучуудын саналын үзүүлэлт Оросын хүн амын санал өгсөн байдалтай харьцуулахад өндөр байв. (Диаграмм 11-ыг үз)

Ерөнхийлөгч Путинд итгэл үзүүлэх түвшин

- А. Оросын залуучууд
- Б. Москва хотын залуучууд
- В. Оросын нийт хүн ам




Ерөнхийлөгч Путинд хандах харилцааны янз бүрийн хэмжүүрүүдийн (итгэх итгэл, үйл ажиллагааны үнэлэлт, сонгогчдын сэтгэл ханамж г.м) нийлбэр цогцод тусгайлсан анализ хийх үндсэн дээр санал асуулгад оролцогчдыг Ерөнхийлөгчид хандах харилцааны хэв маягаар нь гурван бүлэг болгож ангилсан байна. Тэдгээр нь;

1. Путины талынхан
2. “Нелояльные” тааламжтай бус талынхан (сөрөг хүч)
3. Төвийг сахигчид буюу тодорхойгүй хүмүүс юм.

Судалгаанаас харахад Путины засаглалыг дэмжигч талынхны хувь Оросын залуучуудын дунд 51%, түүний эсрэг талын харьцаатай залуучуудын эзлэх хувь ердөө 14% байв. (Диаграмм 12 үз)

Оросын янз бүрийн бүлгийн залуучуудын Ерөнхийлөгч Путинд хандах харилцааны хувь хэмжээ



Путины засаглалд хандах харилцааны асуудлаар залуучуудын бүлгүүдийн нийгэм- хүн ам зүйн бүрэлдэхүүнд хийсэн шинжилгээнээс харахад зарчмын ялгарал харагдахгүй байв.

Засаглалаас хэвшүүлж буй үнэт зүйлсэд Оросын залуучуудын хандах байдал

Судалгааны бас нэгэн зорилго бол өнөөгийн Оросын залуучууд засаглалын зүгээс иргэд залуучуудад тодорхой “үнэт зүйлсийн” дүр төрхийг төлөвшүүлэхэд хэрхэн яаж хандаж байгааг тодорхойлох явдал байсан байна. Засаглалын үнэт зүйлсийн цуглуулгыг бүрдүүлэхийн тулд шинжээчдийн баг (улс төр судлаачид, улс төрийн технологичид, засаглалын асуудлыг судалдаг онолын болон практик ажилтнууд, ерөнхийлөгчийн дэргэдэх залуучуудын байгууллагын лидерүүдээс бүрдсэн) ажилласан ба мөн Ерөнхийлөгчийн болон түүний засаг захиргааны төлөөлөгчдийн ОНМХ-д өгсөн ярилцлагууд, В.Путины Холбооны хуралд илгээсэн илгээлтүүдэд контент-анализ хийх үндсэн дээр доорхи 12 зүйлийн суурь үнэт зүйлсийн цуглуулгыг бүрдүүлсэн байна.

Таблиц 1: Засаглалын “үнэт зүйлс”-ийн дүр зураг

1. хүчтэй төр (хүчтэй засаглал)
2. төрийн тусгаар тогтнол
3. эх оронч үзэл
4. ардчиллын үнэт зүйлс, иргэдийн эрх, эрх чөлөөг хангах
5. нийгмийн шударга ёс
6. иргэдийн сайн сайхан байдал, нийгмийн халамж хамгаалал,
7. либерал эдийн засгийн үнэт зүйлс (зах зээлийн шинэтгэл, хувийн өмчийн халдашгүй байдал)
8. Оросын геополитикийн хүч чадал, Орост хүндэтгэлтэй хандах хандлагыг сэргээх
9. хууль ёс, дэг журам
10. үндэсний шинэчлэл (модернизаци)
11. Улс орны аюулгүй байдал
12. Тогтвортой байдал

Мөн тэрчлэн “эх оронч” үзлийн үнэт зүйлстэй холбоо бүхий 30 ойлголтыг ашиглан залуучуудын сэтгэл хөдлөлийн хандлага (тааламжтай, тааламжгүй, төвийг сахисан) ямар байгааг тандсан байна.

Таблиц -2: Дараах ойлголтууд танд аль нь илүү тааламжтай, эсхүл тааламжгүй мэдрэмж төрүүлж байна вэ? Алинд нь төвийг сахисан байдлаас хандав?

1	Ойлголт	Тааламжтай	Тааламжгүй	Төвийг сахисан хандлага
1	Орос орон	91	2	6
2	Эх орон	87	2	9
3	Дэг журам	83	7	9
4	Аюулгүй байдал	83	6	9
5	Тогтвортой байдал	82	6	10
6	Шударга ёс	82	8	8
7	Хүчтэй төр	80	5	13
8	Хууль ёс	77	8	12
9	Ерөнхийлөгч	74	5	19
10	Уламжлал	78	4	15
11	Эх оронч үзэл	71	9	17
12	Ёс суртахуун	64	12	19
13	Шинэчлэл	62	7	22
14	Их гүрэн	62	8	24
15	Үндэстэн	61	11	24
16	Бизнес	61	12	24
17	Хувийн өмч	60	15	24
18	Тусгаар тогтнол	59	7	23
19	Үйлдвэр худалдаа эрхлэх	54	11	32
20	Ардчилал	53	17	24
21	Засаглал	51	20	25
22	Зах зээл	50	15	31
23	Арми	46	27	24
24	Өрсөлдөөн	43	22	30
25	Улс төр	38	21	36
26	Доллар	34	27	34
27	ТТУХН	34	16	41
28	Өөрийгөө удирдах ёс	32	26	33
29	Хувьсгал	15	59	20
30	Хээл хахууль	10	75	13

Эндээс харахад ойлголт-үнэт зүйлсүүдийн “рейтинг” өвөрмөц байдалтай байгаа бөгөөд оросын залуучуудын дийлэнхи нь (70%-90% санал асуулгад оролцогчдыг) “Гүрний-консерватив” үнэт зүйлсэд тааламжтай хандсан хариулт өгчээ. Тэр нь: Орос орон, Эх орон, Дэг журам, Аюулгүй байдал, Тогтвортой байдал, Шударга ёс, Хүчтэй төр, Уламжлал, Хууль ёс, Эх оронч үзэл, Ерөнхийлөгч (өөрөөр хэлбэл хүчтэй төрийн илэрхийлэл болсон ойлголтууд) юм.

Тийм ч учраас Оросын залуучуудын үнэт зүйлсийн чиг баримжаа төр улс, эх оронч тал дээрээ ахимаг насны иргэдийнхээс илүү үзүүлэлттэй байна гэсэн зарим судлаачдын дүгнэлт батлагдаж байна.

Судалгаанаас харахад Оросын залуучуудад “либериал-ардчилсан” үнэт зүйлсэд хандах хандлага таатай байгаа бөгөөд (судалгаанд хамрагдагсдын 46-60%) ардчилал, бизнес, хувийн өмч, үйлдвэр худалдаа эрхлэх, зах зээл, өрсөлдөөнийг дэмжсэн хариулт өгчээ. Эдгээр үнэт зүйлсийн талаар тааламжгүй ханддаг гэсэн сөрөг хариултууд нилээдгүй байгаа ч “төвийг

сахисан” байр суурьтай гэсэн хариултууд санал асуулгад оролцогчдын тааламжгүй ханддаг гэсэн хариулт өгөгчдөөс олон байгааг тэмдэглэх хэрэгтэй.

“Шинэчлэл” хэмээх ойлголтыг санал асуулгад оролцогчид эерэгээр хүлээж авах, үнэт зүйлсийн төвшингөөр нь (тогтвортой байдал, уламжлал) дутуу үнэлсэн нь сонирхол татаж байна. “Хувьсгал” буюу үндсээр нь өөрчлөх хэрэгтэйн тухай асуудлыг Оросын залуучууд тааламжтай бусаар хүлээн авах байгаа нь хамгийн сүүлчийн өмнөх (29 дэхь) рейтингэд тэмдэглэгджээ.

Мөн судалгаагаар эсрэг тэсрэг хос бодомжуудаас рациональ сонголтыг Оросын залуучуудаас ялгаруулж үзэл оролдлого хийсэн байна. Таблиц 3-ыг үз:

Та дараахь хос бодомжуудаас аль бодомжтой нь илүү их санаа нийлж байна вэ?

	ОХУ-ын бүх иргэдээс I	Хариулагдагсдаас II	
		ОХУ-ын	Москва хотын
<u>- Хүчтэй төр (хүчтэй засаглал)</u> Орос улсын хүчин чадал, нөлөөг сэргээх явдал төрийн засаглалыг бэхжүүлэхгүйгээр боломжгүй	62	67	72
Орос улсын хүчин чадал, нөлөөг сэргээхэд төрийн засаглалыг бэхжүүлэх хэрэггүй, харин хүмүүст эрх чөлөө, санаачлагыг улам илүү олгох хэрэгтэй.	31	33	28
Хариулахад төвөгтэй байна	7	-	-
Холбооны төв Оросын бүх бүс нутгуудад хяналтаа хүчтэй болгох ёстой	52	57	60
Оросын бүс нутгуудад холбооны төвөөс илүү бие даасан байдал, эрхийг олгох ёстой	39	43	40
Хариулахад төвөгтэй байна	8	-	-

Орос улсын геополитикийн хүч чадлыг сэргээн тогтоох, дэлхийд Орос улсын нэр хүнд байр суурийг бэхжүүлэхэд

Аугаа их хүчирхэг гүрэн гэдэг үүднээс Оросын хүчин чадлыг сэргээн тогтоох нь зайлшгүй. Зөвхөн тэр цагт л дэлхий дахинаараа Орос улсыг хүндэтгэж харьцах болно	ОХУ-ын бүх иргэдээс I	Хариулагдагсдаас II	
		ОХУ-ын	Москва хотын
	53	57	57
Орос улс их гүрний статуст эрмэлзэхгүй өөрийн ашиг сонирхлоо хамгаалж соёлт ертөнцийн харилцаанд бусад улс орнуудтай адил тэгшээр орох хэрэгтэй	40	43	43
Хариулахад төвөгтэй байна	7	-	-
<u>- Эх оронч үзэл</u> Улс орноо аврахын төлөө би хувийн зүйлээ золиосломгүй байна	45	50	55

Хэрэв улс орны ирээдүйд надаас шаардагдах хэрэгтэй зүйл байвал би юугаа ч хайрлахгүй	44	50	45
Хариулахад төвөгтэй байна	10	-	-
- <u>Нийгмийн шударга ёс</u> Төрөөс янз бүрийн татварыг тогтоож орлогыг дахин хуваарилах замаар ядуучууд, баячуудын амьдралын төвшний хоорондын хэт ялгаатай байдлыг багасгах хэрэгтэй	58	63	48
Иргэн бүр өөртөө байгаа боломжийн хирээр орлоготой болох хэрэгтэй. Төр иргэдийн олсон орлогыг хянах ёсгүй	34	37	52
Хариулахад төвөгтэй байна	8	-	-
- <u>Иргэдийн нийгмийн сайн сайхан байдал</u> Төрийн засаглалын гол анхаарал бол иргэдийн сайн сайхан, ая тухтай байдлыг хангах явдал мөн	59	63	52
Төр дэг журам, хууль ёсыг хангах ёстой. Өөрсдийн сайн сайхан байлын төлөө иргэд бие дааж анхаарах хэрэгтэй.	34	37	48
Хариулахад төвөгтэй байна	7	-	-
- <u>Либериаал эдийн засгийн үнэт зүйлсүүд</u> Төр бизнесийн үйл ажиллагаанд илүү чанга хяналт тавих хэрэгтэй	51	57	47
Төр бизнесийн үйл ажиллагаанд илүү их эрх чөлөө олгох хэрэгтэй	39	43	53
Хариулахад төвөгтэй байна	10	-	-
Нийгмийн баялгийг шударгаар хуваарилах явдлыг хангахад зөвхөн зах зээлийн эдийн засаг чадвартай	43	51	48
Зах зээлийн эдийн засаг баян ядуугийн хоорондын ялгааг нэмэгдүүлэх, томоохон корпорациудын монополыг тогтооход хүргэж байна	42	49	52
Хариулахад төвөгтэй байна	15	-	-
- <u>Үндэсний шинэчлэл (модернизаци)</u> Орос орны амжилттай хөгжилтөд өнөөдөр амьдралын бүх хүрээнд шинэчлэл хийж, орчин үеийн шинийг эрэлхийлэх явдал зайлшгүй хэрэгтэй	64	71	63
Улс орны амжилттай хөгжлийн үндэс нэгэнт бүрэлдэн тогтсон зан үйл, уламжлал мөн	27	29	37
Хариулахад төвөгтэй байна	9	-	-
- <u>Ардчиллын үнэт зүйлс, бие хүний эрх, эрх чөлөөг хангах</u> Хэдийгээр ардчилсан системд учир дутагдалтай асуудлууд, доголдууд байдаг ч тэр нь одоо хэрэгжиж буй засаглалын хэлбэрүүдээс хамгийн сайн нь	48	55	55


Засаглалын ардчилсан хэлбэрт сайн гэхээсээ илүү олон дутагдалтай зүйл байдаг, дэг журам сул, хоосон чалчаа амлалт хэтэрхий ихтэй.	39	45	45
Хариулахад төвөгтэй байна	13	-	-
Төр, нийгмийн эрх ашгийн үүднээс бие хүний зарим эрх, эрх чөлөөг хязгаарлаж болно	33	36	41
Бие хүний эрх, эрх чөлөө бол хүний эрхэм зүйл, төр, нийгмийн эрх ашгийн үүднээс ч түүнийг хязгаарлаж үл болно	58	64	59
Хариулахад төвөгтэй байна	8	-	-
- <u>Хууль ёс, дэг журам</u> Сайн хууль, муу хууль мөн үү биш үү гэдгээс нь үл хамааруулан хууль бүхнийг сахих хэрэгтэй	62	68	50
Хэрэв муу хууль бол түүнийг мөрдөх албагүй	29	32	50
Хариулахад төвөгтэй байна	10	-	-
- <u>Тогтвортой байдал</u> Орос орон “хувьсгалыг” цаашид тэсэхгүй тиймээс сайн тийш хийх өөрчлөлт аажмаар урьдын туршлагаасаа сургамж авч хийгдэх ёстой	57	62	50
Сайн тийш хийх өөрчлөлт Орос орны хувьд зайлшгүй хэрэгтэй, тийм өөрчлөлтгүйгээр Орос мөхнө, тиймээс бүх арга хэрэгслийг ашиглан цаг алдалгүй өөрчлөлтийг хэрэгжүүлэх ёстой	35	38	50
Хариулахад төвөгтэй байна	8	-	-
- <u>Төрийн тусгаар тогтнол</u> Орос улс Европи, Азийн бусад улсуудтай (юуны түрүүн ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудтай) интеграцид орох хэрэгтэй, энэ харилцаа Оросын тусгаар тогтнол, бие даасан байдлын зарим хязгаарлалттай холбоотой байсан ч хамааралгүйгээр	44	51	49
Орос улс өөрийн бие даасан байдлыг боломжтой бүх хүчээр хамгаалах ёстой. Тусгаар тогтнолоороо хохирох явдлыг ямар ч нөхцөлд (хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудтай интеграци тогтоох зорилгын нөхцөлд ч) үл тэвчих ёстой	42	49	51
Хариулахад төвөгтэй байна	14	-	-
Орос орон төр хүн ам нь ёс журмаараа баялагаа эзэмшихэд хэтэрхий том орон. Тиймээс зарим тохиолдолд Оросын газар нутгийн тодорхой хэсгийг худалдаж, түүнээс олсон мөнгийг иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд зориулахад болох талтай	23	25	27
Ямар ч тохиолдолд Оросын нутаг дэвсгэрийн ямар ч хэсгийг худалдах явдал байж	68	75	73

болшгүй зүйл. Тэр нь улс орны тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг эвдэх оролдлого болно.			
Хариулахад төвөгтэй байна	9	-	-

Дээрх үнэт зүйлсийн чиг баримжааг тодорхойлох чиглэлээр явуулсан санал асуулгын дүнгээр засаглалын үнэт зүйлсэд хандах респондентуудыг 3 бүлэг ангилалд хуваах боломж гарсан байна.

1. Засаглалын үнэт зүйлсэд “эв санааны” нэгдэлтэй байдаг
2. Засаглалын үнэт зүйлсийг хүлээж авдаггүй, бас хуваалцахыг хүсдэггүй
3. Тодорхойгүй залуучууд

Диаграмм 3: Засаглалын үнэт зүйлсэд хандах байдлаараа залуучуудын янз бүрийн бүлгийн тоо хэмжээ (эзлэх хувийн жин)



Диаграмм 3: Эндээс харахад Засаглалын үнэт зүйлсийн талаар хандах харилцааны хэв маягаараа респондентууд эзлэх хувийн жингээрээ тун ойрхон 3 бүлэгт хуваагдсан байна. Тэгсэн атлаа “тодорхойгүй” (41%) хүмүүсийн бүлэг хамгийн том нь, засаглалын үнэт зүйлсийг дэмждэг буюу “эв санааны нэгдэлтэй” бүлэг ба түүнийг “үл хуваалцдаг” бүлгийн хувь (30% ба 29%) бараг ижилхэн гарсан байна.

Оросын залуучуудын дунд 51% нь В.Путины дэмжигчид, засаглалын үнэт зүйлсийг хуваалцагчдын хувь харагдахуйц бага буюу 30% байна.

Энэ юуг харуулж байна вэ? гэвэл Ерөнхийлөгч Путиныг дэмжигчдийн дотор засаглалын үнэт зүйлсийг дэмждэг “эв санааныхан”, түүнийг “үл хуваалцдаг” бас “тодорхойгүй” бүлгийн хүмүүс орж байна. Энэ нь мөн тэрчлэн Ерөнхийлөгчид тааламжгүй ханддаг залуу респондентуудын бүлэгт хамааралтай болно.

Судалгаанаас гаргасан үндсэн дүгнэлтүүд

1. Оросын залуучуудын дунд Ерөнхийлөгчийн засаглал сүрхий дэмжлэг хүлээсэн нийгмийн хөрс дэвсгэртэй байна. Оросын төр, засгаас баримтлаж буй улс төр, эдийн засгийн бодлогод сэтгэл ханамжтай хандсан дүгнэлт гарч байна. Оросын судалгаанд хамрагдсан залуучууд ахимаг насны нутаг нэгтнүүдээсээ илүү эх оронч, төрт ёсоо дээдлэх чанартай болохоо харуулсан байна.
2. “Засаглалын түшиг” болох залуучуудын ангилалд социаль-хүн ам зүйн гэхээсээ соёлын хүчин зүйлс (хүмүүжил, үе тэнгийнхний хоорондын харилцаа, боловсролын хэв маяг, мэдээллийн уг сурвалж, соёлын тогтонги хэв маяг) илүүтэй нөлөөлж байна.
3. Судалгаанаас харахад Оросын залуучуудын нийгэм, улс төрийн идэвхитэй чанар төдийлөн дээгүүр биш байгаа нь харагдлаа. Улс

төрийн амьдралд оролцохгүй байгаагаа залуучууд “асуудал” биш гэж үзэж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Залуучуудын улс төрийн оролцооны болон үл оролцооны боломжит сэдлүүд тун олон янз. Залуучуудыг олон тоогоор нэгтгэсэн олон нийтийн голлох сэдэл, хөшүүргүүд дутагдалтай байна.

4. Улс төрийн тогтворгүй байдлаар дамжуулж Оросын залуучуудын олон нийтийн улс төрийн дайчилгааг хангаж чадна. Өөрөөр хэлбэл чухам тийм доргилттой нөхцөл байдал залуучуудыг “субъектын” (бие даасан) байдлаар улс төрд оролцох, нийгмийн босоо шатаар өгсөж өөрийгөө харуулах эрмэлзлэлийн “өдөөгч” нь болох магадлалтай.
5. Өдгөө залуу Оросуудад ажил төрөл, гэр бүлийн хүрээнд нь улс төрийн биш гайгүй зөв чиг хандлага ажиглагдаж байна. Учир нь Орос орны хувьд “сайн үр дагавар авчраагүй хувьсгалууд” (Гүржийн эсхүл Киргизийн хэв маягийн) аль хэдийнээ цаг үеэ өнгөрөөсөн, харин “сайн сайхны төлөөх хувьсгал”-ын (1968 оны Францын залуучуудын хөрөнгөтний эсрэг чиглэсэн тэмцлийн хэв маягийн) боловсрох цаг нь болоогүй байна.

УЛС ТӨРИЙН АСТРОЛОГИ - УЛС ТӨРИЙН ПРОГНОЗЧЛОЛЫН АРГА БОЛОХ НЬ

Д.Мягмарсүрэн
докторант, багш
ШУТИС, ХУС, Улс төр-стратегии судлалын профессорын баг

Хураангуй

Улс төрийн астрологи нь улс төрийн үзэгдэл, үйл явцад сансар огторгуй, од эрхсийн хөдөлгөөн, нарны идэвхжлийн үзүүлэх нөлөөллийг судалдаг улс төрийн шинжлэх ухааны салбар юм. Уг хүрээнд гараг дэлхийн хөдөлгөөн хийгээд дэлхий дахины болон тодорхой улс орныг хамарсан түүх-улс төр, нийгэм-эдийн засаг, угсаатны болон газарзүйн үйл явц, улс төрийн субъектүүдийн хоорондын уялдаа холбоо, хэмнэл давтамжийг судалдаг. Улс төрийн астрологи нь дотроо дэлхийн астрологийн ерөнхий зарчим, үндэсний төр улсын астрологи улс төрийн нөхцөл байдлын астрологийн прогноз, улс төрийн үйл явцын сонгомол астрологи гэсэн чиглэлд хуваагддаг.

Түлхүүр үг: *улс төрийн астрологи, прогноз, дэлхийн астрологи*

Улс төрийн астрологийг шинжлэх ухааны тодорхой үндэслэл, нотолгоо багатай хуурмаг шинжлэх ухаан бөгөөд шүтлэг бишрэлийн шинжийг ихээр агуулдаг гэж зарим судлаачид шүүмжилдэг. Гэвч улс төрийн үзэгдэл, үйл явцыг тайлбарлах өвөрмөц аспект цаашлаад улс төрийн бодлого, үйл ажиллагааны ирээдүйн үр дагаврыг таамаглах нэг арга болохын хувьд улс төрийн астрологийг авч үзэх нь онол, арга зүйн хувьд ач холбогдолтой юм. Улс төрийн астрологийг улс төрийн шинжлэх ухааны салбар бөгөөд улс төрийн шинжлэх ухааны судлагдахуун болох үүднээс хийсэн судалгаа шинжилгээ, ялангуяа манай орны хувьд хомс хязгаарлагдмал, түүнчлэн улс төрийн астрологийн орчин үеийн шинжлэх ухаанаас “хол хөндий” шинж чанараас шалтгаалан уг өгүүлэлд авсан жишээ нь баримт сэлтээр мөчид, эрдэм шинжилгээний шалгуурыг давах тал дээр учир дутагдалтай болсныг хэлэх хэрэгтэй.

Улс төрийн мөн чанар ирээдүйд чиглэсэн, ирээдүйн хөгжил дэвшил, сайн сайхан байдлыг хангахад оршдог бөгөөд энэ үүднээс нийгмийн хэтийн хандлага, нийгэм-улс төрийн удирдлагыг боловсронгуй болгох замаар түүнийг шийдвэрлэх хамгийн сайн арга замыг илрүүлэх, цаашлаад хүссэн хийгээд эс хүссэн бүхий л нийгэм-улс төрийн үйл явдлыг урьдаас таамаглах шаардлага тулгардаг. Нийгмийн үзэгдэл үйл явцын мөн чанар, илрэлийг тайлбарлах замаар ирээдүйг урьдчилан таамаглах оролдлого нь гүн гүнзгий түүхэн үндэстэй бөгөөд үүнд шашны зан үйл, мэргэ төлөг, од гарагийн хөдөлгөөнийг тайлбарлах, таних чадвар болон зурхайн мэдлэг, өнгөрсөнд тулгуурлан дараагийн алхмаа тооцох амьдралын туршлагаас аваад орчин үеийн шинжлэх ухааны онол, арга зүйг боловсруулан үзэгдэл, үйл явцыг рационал үүднээс тайлбарлах зэрэг бүхий л аргууд багтана.

Төр улсыг удирдах үйл хэрэгт ирээдүйг урьдаас харах эрмэлзэл хийгээд идэвх чармайлт нэн эртний уламжлалтай. Эртний улс гүрнүүдийн хаад, язгууртнууд ирээдүйг таамаглах, өөрийн бодлого, шийдвэртээ ирээдүйг онож заах нөхцлийг бүрдүүлэхийг эрмэлзэж, энэ зорилгоор олон янзын арга хэрэгслийг ашиглаж ирсэн байна. Тэд бөө, зурхайч, мэргэч төлөгч, далдыг харагчдыг дэргэдээ суулгаж, зүүд манах, билиг совин тайлах, ховлого татах, дал шатаах зэрэг шашны болон аж байдлын иррациональ шинжтэй арга хэрэгслийг өргөнөөр ашиглан, улс орны хувь тавилан хийгээд өөрийн үйлдлийн ирээдүйн үр дагаврыг тааварлах улмаар улс төрийн шийдвэр, үйлдлийнхээ ончтой эсэхийг бататгах замаар үйлс хэргийнхээ ирээдүйг тодорхойлохыг эрмэлздэг байжээ. Эрт үед “зурхайчгүй хаан гэрэлгүй шөнө мэт” гэж хэлэлцдэг байсан нь улс төрийн аливаа үйл ажиллагаанд тэдний эзлэх байр суурь хэр чухал байсныг харуулж байна.

Өдгөө ч улс төрийн бодлоготон, шийдвэр гаргагчид шинжлэх ухааны арга аргачлал, шинжилгээ судалгаанаас гадна улс төрийн шийдвэр гаргах, улс төрийн прогноз дэвшүүлэхдээ астрологийн арга, интуитив хандлага, оккультизм, мистик болон парапсихологийг ашигласаар байна. Тухайлбал, ОХУ-д 1992-1996 оны хооронд Ерөнхийлөгчийн аюулгүй байдлын албаны бүрэлдэхүүнд парапсихологи, далдыг харах (телекинез), оккультизмыг улс төрийн практикт ашиглах нөхцөл боломжийг судалдаг тусгай алба үйл ажиллагаа явуулж байгаад 1998 оноос астрологийн мэдээ баримт боловсруулах үндсэн дээр ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны ирээдүйн үр дагавар, хэрэгжилт болон эрсдлийн талаар прогноз хийхэд чиглэсэн “Хэмнэл Зүйн Судалгааны Төв” болон өөрчлөгджээ. Түүнчлэн Францын ерөнхийлөгч асан Франсуа Миттеран улс төрийн чухал шийдвэр гаргахдаа далдыг харагчид, астрологчдын зөвлөгөөг харгалзан ажил төрлөө зохицуулдаг байжээ [10]. Манай орны хувьд ч Монгол Улсын ерөнхийлөгч асан П.Очирбат дэргэдээ үзмэрч Дашцэрэнг ажиллуулж байжээ.

Социалист нийгмийн вед ард иргэдийн сэтгэхвйд шашингвйн вэлийг суулгаж, ер бусын аливаа вэзэгдлийг вгвйсгэн няцааж байсан төрийн машин хэрэг дээрээ энэ вэзэгдлийн учрыг олж, вэл суртлын зорилгоор ашиглахыг хичээж байв. Зөвлөлт засаг хел дээрээ тэнцэж амжаагвй шахам байхдаа Энэтхэг, Тевд, Монгол зэрэг дээд бясалгалд нэвтрэгсэд олонтой орнууд руу судалгааны баг нэрээр тагнуулчид илгээхийг хичээж эхэлжээ. Тэдний зорилго нь бясалгалын хвчээр олон нийтийн санаа бодолд нөлөөлж болох эсэхийг мэдэх явдал байлаа. Октябрийн хувьсгалын удирдагч В.И.Ленин хвртэл энэ асуудалд санаа тавьж, шашныг коммунизмд ашиглах телевлегеег далдуур дэмжиж байжээ [16]. И.Сталин алдартай астрологч Гурджиевийн зөвлөгөөг хувийн карьераа өсгөхөд ч, дэлхийн хувьсгалын үйл хэрэгт ч ашиглаж байжээ. Гурджаевийн зөвлөснөөр Сталин төрсөн өдрөө албан ёсны бичиг баримт дээр

1878 оны 12 сарын 18 гэснийг 1879 оны 12 сарын 21 болгон өөрчилсөн нь далд үзэгдлийг судлаачдын тайлбарласнаар карьераа өсгөхөд түлхэц өгсөн үйлдэл ажээ [9].

Түүгээр зогсохгүй социалист нийгмийн үед манай улсын улс төрийн товчооны гишүүд ажил амьдралаа харуулан, зам мөрөө засуулж даатгах тус бүрийн ламтай байсан тухай дотоодын хамгаалах яамны ажилтан дэд хурандаа н.Баттулга хуучилсан юм.

Улс төрийн ирээдүйг таамаглах буюу прогноз хийх оролдлогод астрологи чухал байр суурь эзэлдэг төдийгүй улс төрийн астрологийг улс төрийн шинжлэх ухааны нэг салбар болохыг улс төр судлаачид хүлээн зөвшөөрдөг. Улс төрийн астрологи нь улс төр судлал ба астрологийн завсарт үүссэн хавсарга салбар юм.

Улс төрийн үзэгдэл, үйл явц ялангуяа улс төрийн үйл байдалд од гарагийн байрлал, нарны идэвхжил, сарны таталцал зэрэг сансар огторгуйн хүчин зүйлийн нөлөөллийг улс төрийн астрологи судалдаг байна. Гэхдээ тухайн шинжлэх ухааны гэх олон дүгнэлтүүд нь нилээд эргэлзээтэй бөгөөд таамагласан шинжтэй боловч зарим нэг баримтлалыг тухайлбал, олон түмний улс төрийн идэвхи ба үйл байдалд нарны идэвхижилт нөлөөлөх асуудлыг улс төрийн практикт, ялангуяа улс төрийн хямралт байдлын судалгаанд анхааран үзэх нь зохистой [1] тухай МУИС-ын Улс төр судлалын тэнхимээс гаргасан “Улс төрийн шинжлэх ухаан” номонд тэмдэглэсэн байна.

Нарны идэвхжил, од гарагийн сүйрэл, галактикийн шилжилт хийгээд од гарагийн байршил, дэлхийн соронзон орны шууд болон дам нөлөөллөөс улс төрийн үзэгдэл, үйл явц, түүний өөрчлөлт хувьсал, олон түмний үйл байдал, улс төрийн хошуучлагчийн дүр байдал хамаардаг болохыг тогтоох замаар сансар огторгуй ба улс төрийн амьдралын хоорондын холбоо хамаарлыг судалж тодорхойлохыг улс төрийн астрологи эрмэлздэг. Улс төрийн астрологи од эрхсийн хөдөлгөөнөөр нийгэм-улс төрийн ирээдүйг таамаглах үйл явцыг судлахын зэрэгцээ улс төр дэх оккультизм, мистик, парапсихологи, психотроны асуудлыг бүхэлд нь авч үздэг салбар хэмээн судлаачид үздэг.

Улс төрийн астрологитой холбогдох астрологийн дараах чиглэлүүд байна. Үүнд:

Дэлхийн астрологи (mundane) нь түүх, нийгэм, нийгэм-эдийн засаг, угсаатны газар зүйн үйл явцтай сансрын хүчин зүйлийн хоорондын холбоо хамааралд зурхайн үүднээс дүн шинжилгээ хийхэд чиглэдэг. Тус чиглэл нь судалж буй нийгэм, хот суурин газар, төр улсын бүрэлдэх үеийг тодорхойлон мөн чанарыг судалдаг, энэ зорилгоор астрологийн өвөрмөц карт ашигладаг байна. Дэлхийн астрологи нь дотроо төр улсын астрологи, улс төрийн астрологи, астро цаг уур судлал, санхүүгийн астрологи, бизнесийн астрологи гэсэн чиглэлд хуваагддаг. Астрологичид тус хүрээнд гарагийн хөдөлгөөн болон глобал түүх-улс төр, нийгэм-эдийн засаг, угсаатны газарзүйн үйл явц ба дэлхий дахины “театрын тайзны дүрд тоглогчид”-ын хоорондын уялдаа холбоо, хэмнэл давтамжийг судалдаг. Дэлхийн астрологи нь ард түмэн, улс орон болон засгийн эрх баригчид, хот суурингийн түүх, хувь тавиланг судлаад ирж буй гамшиг сүйрэл, цаг бусын аюул, дайны талаар урьдчилан мэдэгдэх, тэрчлэн тухайн эрх баригчид, нийгэм төр засгийн үйл ажиллагаа болон томоохон ач холбогдол бүхий үйл явдлын өрнөл, үр нөлөөг таамагласнаар дэлхийн хамтын нийгэмлэгээс тухайн үйл явдлын өрнөлд нөлөөлөх, дайн мөргөлдөөнөөс зайлсхийх, цаг бусын аюул, гамшиг сүйрлийн үед нийгэмд учрах сөрөг үзэгдлийг таслан зогсоох, аюултай бүсээс цаг тухайд нь гарах, өвчин тахал болон бусад олон зүйлд урьдчилан сэргийлэх боломжийг олгодог гэж үздэг. Астрологичдын нотолж байгаагаар дэлхийн

астрологийн тусламжтайгаар францийн аугаа хувьсгал, оросын Октябрийн хувьсгал, 1907 оны АНУ-ын санхүүгийн хямрал, 1933 оны их хямрал, түүнчлэн 1904 оны орос-японы дайн, Дэлхийн 1, 2-р дайн, 1985 оны “өөрчлөн байгуулалт”-ийн эриний эхлэлийг урьдчилан хэлж байжээ.

Астрогеограф (астро газар зүйн)-ийн астрологи нь эх газар, далай тэнгис, ландшафт ба бүс нутгийн амьдрал хийгээд сансар огторгуйн хэмнэлийн хоорондын холбоо хамаарлыг судалдаг. Улс төрийн астрологийн нэг чухал үндэс нь астро газар зүйн астрологи юм.

Түүхэн улс төрийн астрологи. Энэхүү чиглэлийн хүрээнд өнгөрсөн үеийн янз бүрийн нийгэм, улс төрийн бүлэглэл, улс төрийн лидер ба тодорхой улс төрийн үйл явц хоорондын уялдаа холбоог астрологийн үүднээс судлан тодорхойлохыг оролддог. Түүх-улс төрийн астрологийн судалгаа нь ретроспектив шинжтэй байдаг.

Прогностик астрологи нь тодорхой хувь хүн хийгээд нийгмийн хүрээний хөгжлийн чиг хандлагыг прогнозчлох арга зарчимд үндэслэнэ. Энэ чиглэлд улс төрийн прогностик астрологи багтана.

Электив буюу сонгомол астрологи нь төлөв байдлын өрнөлд хамгийн тааламжтай цаг хугацааг онож тогтооход чиглэдэг. Эхлээд төлөв байдлыг судлаад дараа нь төлөвлөж буй ажил хэргийн зурлагыг зохионо. Монголчуудын төр засаг, улс төрийн нам хүчний хийгээд хувь хүний аливаа арга хэмжээ, үйл ажиллагааг эхлэх, өрнүүлэх, дуусгах зурхайн зурлага, сайн өдөр цагийг товлонх нь энэ чиглэлийн хүрээнд багтдаг байна.

Санхүү-эдийн засгийн астрологи нь XX зууны эхээр дэлхийн эдийн засгийн тогтолцооны хямралтай холбоотойгоор хүчтэй хөгжих болсон ирсэн. Уг салбар нь зах зээлийн хэмнэлт чанар (ритмик), бүтээгдэхүүн ба үйлчлүүлэгчийн сэтгэлгээний динамик харьцааг судлахад чиглэдэг. Зар сурталчилгааны кампаний төлөвлөлт, маркетингийн судалгаа явуулах, биржийн үйл ажиллагааг хангахад тус астрологийн аргуудыг ашигладаг ажээ.

Астрологи одон орон судлал, математик, геометр, физик зэрэг байгалийн шинжлэх ухааны арга, арга зүйг өргөнөөр ашиглаж, авч үзэж буй асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй болохыг батлахыг эрмэлзэлдэг.

Улс төрийн астрологийг дараах чиглэлд хуваана. Үүнд:

- Дэлхийн астрологийн ерөнхий зарчим
- Үндэсний төр улсын астрологи
- Улс төрийн нөхцөл байдлын астрологийн прогноз
- Улс төрийн үйл явцын сонгомол астрологи

Орчин үед улс төрийн астрологийн асуудлыг дагнан мэргэшсэн судлаачид бий болсноор энэ чиглэлийн судалгаа шинжилгээ улам өргөжих хандлагатай болсон. Тухайлбал, АНУ-ын судлаач, эрдэмтэн Ч.Картер “Улс төрийн астрологи” (1951) нэг сэдэв бүтээл, В.Веташ “Астрологи ба домог зүй” (1991), Энэтхэгийн астрологи судлаач Б.В.Раман “Хүний үйл хэрэгт гариг ертөнцийн үзүүлэх нөлөө” (1992), Оросын судлаач В.Гужов “Зөвлөлт засгийн үеийн оккультизмын тухайд” (1993) зэрэг бүтээлүүдийг энд дурьдаж болох байна.

Улс төрийн астрологчид тухайн үеийн улс төрийн бодлого цаашлаад тухайн нийгмийн санаа бодол нь улс төрийн астрологиор урьдаас тааварласан харилцааны нөлөөлөл дор оршдог гэж үздэг. Хүрээлэн буй орчин, сансар огторгуйн зүгээс нийгмийн амьдралд үзүүлэх тодорхой нөлөөлөл, харилцан үйлчлэл бий бөгөөд хүний үйл ажиллагааны улс төрийн хүрээ хэмнэлт үйл явцаас (ритм) гадуур зүйл биш юм. Хэмнэлийн эхний үндэс бол сансар огторгуй дараагаар нь галактик, од эрхэс, гариг дэлхий цаашлаад биологийн организм, ноосфер, нийгмийн үйл явц тус бүрийг багтаасан цогц

системийн хэмнэлийн тухай ярих шаардлагатай. Тухайлбал, Хаант Оросын үед гарч байсан томоохон бослого хөдөлгөөнүүд нь өвлийн эцсээс хаврын эхэн үе буюу хүнсний нөөц дуусах үед гол төлөв өрнөдөг байжээ. Зөвлөлт засгийн үед буюу 1970-аад оны нэгэн судалгаагаар Мурманск хотод гэмт хэргийн тоо туйлын зун болон өвлийн эцсээр дээд цэгтээ хүрдгийг тогтоосон байна [11]. Тэрчлэн монголд иргэдийн улс төрийн үйл ажиллагаа хавар идэвхждэг тухай асуудлыг астрологийн үүднээс судлан тодорхойлвол сонирхолтой үр дүн гарахыг үгүйсгэхгүй юм.

Оросын судлаач Е.Наклуешев “Түүхийн учир битүүлэг хэмнэл” бүтээлдээ компьютер тооцооллыг ашиглан оросын түүхэн дэх 3, 4, 12 жилийн давтамжтай мөчлөгийн үзэл санааг дэвшүүлсэн бол “бүтцийн хороскопын” онолын үндэслэгч А.Кваша 1881-2025 оны хоорондох “эзэнт улс”-ын мөчлөгийн онолоо гаргасан байна. Квашагийн үзэж буйгаар Орос дахь төр засаглалын өөрчлөлт 36 жилийн мөчлөгтэй бөгөөд Оросын түүхийн гол эрин 1917, 1953, 1989, 2025 он юм байна. Түүний үзэж буйгаар 2025 оноос дахинд шинжлэх ухааны дэвшил зогсож, амьдралын үндсэн нөөц хомсдон, хүн амын хэт өсөлт, үйлдвэрлэлийн хэмжээ буурах үйл явц зайлшгүй тохиолдоно. Ирээдүйд хүн төрөлхтөнд тулгамдах гол асуудал нефть биш харин ус, агаарын хомсдол байх ажээ [13].

Ертөнцийг үзэх материалист үзлийн үүднээс материаллаг баялаг нийгмийн хувьсал өөрчлөлтийн шалтгаан, үйлдвэрлэлийн харилцаа нь түүхэн үйл явцын гол хөдөлгөгч хүч байдаг. Судлаач А.Кудрявцев, В.Гужов нарын үзэж буйгаар нийгмийн хөгжлийн үе шатуудын шилжилтэд шууд буюу гол нөлөөг үзүүлдэг зүйл бол “астрологийн эрин үе”¹-ийн объектив шилжилт юм. Соёл иргэншил, нийгмийн формацийн шилжилт чухамдаа тасралтгүй хувьслын үйл явц биш юм. Шинэ соёл бий болох, устах хийгээп нийгмийн хувьсгал буюу түүхэн эрс өөрчлөлт “астрологийн эрин үеийн” нөлөөллөөр шийдвэрлэгддэг, түүний шилжилттэй давхцдаг үйл явц юм [13].

Сансар огторгуйн болон гарагийн гажилт өөрчлөлт биосферт цаашлаад этногенезд нөлөөлдөг тухай Л.Гумилёвын “пассионар”-ын онол нь улс төрийн астрологийн хувьд хүндтэй байр суурь эзэлнэ. Түүний үзэж буйгаар гариг ертөнцийн хөдөлгөөн, нарны энерги чухамдаа хүн төрөлхтөн, үндэстэн угсаатны ухамсар цаашлаад хөгжил өөрчлөлтийн шалтгаан болдог байна. Тэрээр угсаатан, үндэстний өсөлт, хөгжил, уналт нь дотроо хэд хэдэн үеллийг багтаасан 1200-1300 жилийн давтамжтай үечлэлийн асуудлыг гарган тавьжээ.

Улс төрийн астрологчдын улс төрийн бодлого шийдвэр гаргахад ашиглаж байсан тухай түүхэн баримт олон байдаг. Тухайлбал, Нацист германы толгойлогч А.Гитлер хувийн астрологч, далдыг харагчтай байжээ. 1930-аад оноос герман оронд ер бусын буюу ид шидтэй холбоотой асуудал “төрийн” ашиг сонирхлын хүрээнд багтах болжээ. Улмаар Гуравдугаар Рейхийн үеэс “улс төрийн астрологи” хөгжлийн дээд оргилдоо хүрсэн байна. А.Гитлер нууц далдын шинжлэх ухааныг ялангуяа дорно дахины мистицизм (агь тарнийн ёс)-ийг сонирхон шүтэж, бодлого шийдвэртээ харгалздаг байжээ. Тухайн үед олон тооны астрологичид национал-социалистуудад үйлчилж байсан хэдий ч тааламжгүй этгээд гэж тооцогдсон төлөгчдийг устгах эсвэл Заксенхаузены хорих лагерь луу илгээх болсноос үүдэн шинэ Рейхт зориулан юуг урьдчилан хэлэх, хэлэхгүйгээ урьдаас тооцох хэрэгтэйг ойлгосон байна. Тэр үеийн шилдэг астрологчоор Гитлерийн хувийн зөвлөх зөнч Отто Гануссен тооцогдож байлаа. Түүний зөн билигт буусан фюрерийн алдаа төөрөгдөл

¹ Өмнөд зүгтэй тухайн үеийн астрологийн үзэл санааг дэвшүүлсэн бол “бүтцийн хороскопын” онолын үндэслэгч А.Кваша 1881-2025 оны хоорондох “эзэнт улс”-ын мөчлөгийн онолоо гаргасан байна. Квашагийн үзэж буйгаар Орос дахь төр засаглалын өөрчлөлт 36 жилийн мөчлөгтэй бөгөөд Оросын түүхийн гол эрин 1917, 1953, 1989, 2025 он юм байна. Түүний үзэж буйгаар 2025 оноос дахинд шинжлэх ухааны дэвшил зогсож, амьдралын үндсэн нөөц хомсдон, хүн амын хэт өсөлт, үйлдвэрлэлийн хэмжээ буурах үйл явц зайлшгүй тохиолдоно. Ирээдүйд хүн төрөлхтөнд тулгамдах гол асуудал нефть биш харин ус, агаарын хомсдол байх ажээ [13].

хийгээд Германы ялагдал, задралын тухай төлөг эцсийн дүнд амиа алдахад нь хүргэжээ [2].

ОХУ-ын ерөнхийлөгч асан Б.Ельциний тойрон хүрээлэгчдийн нэг “Кремлийн астрологич” нэрээрээ алдаршсан ЗХУ-ын КГБ-ын хошууч генерал асан Георгий Рогозин зөвлөлт засгийн үеэс ер бусын үзэгдэл, хүний өвөрмөц чадварыг судлан, астрологийн аргыг эзэмшиж, төрийн бодлого шийдвэрт зориулан тусгай зөвлөмж боловсруулж өгдөг байжээ.

Их зөнч гэгдэх М.Нострадамус, Ванга, Сен-Жермен гvн, Калиостро нарын зөн сургаалыг улс гүрнүүд улс төрийн бодлогодоо харгалзан үзэх, ашиглах оролдлого гарч байсан тухай жишээ олон байгаа бөгөөд өдгөө ч тэдний бүтээлийг тусгайлан судалж, дүн шинжилгээ хийхэд чиглэсэн судалгааны төв, хүрээлэн барууны орнуудад ажиллаж байна. Өдгөө зүүн европ, тэр дундаа ОХУ-д астрологийн чиглэлээр олон хувь хүмүүс, төвүүд ажиллаж, тусгай ном, сэтгүүл хэвлэгдэн, ОНМХ-ээр өгүүлэл, нийтлэл хэвлэгдэх болсон төдийгүй астрологчоор олон хүн бэлтгэгдэж, судлаачид энэ сэдвээр эрдмийн зэрэг хамгаалах болсон. Улс төрчид, эрх баригчид бодлого судлаач, шинжээчдээс гадна астрологч, парапсихологчдыг зөвлөгчөөр ажиллуулан, улс төрийн бодлого, үйл ажиллагааны амжилт, азгүйтлийн бодит хийгээд далд учир шалтгааныг тайлахыг хичээх болсон байна.

Нийгмийн үзэгдэл болохынхоо хувьд нийгмийн хөгжил өөрчлөлтөөс шалтгаалан астрологи нийгэмд түгэн тархах юмуу хүрээ нь хумигдаж байдаг. Нийгэм-улс төрийн тогтворгүй үед олон түмэн ирээдүйдээ итгэл алдрах, эргэлзэх зэрэг нь астрологи түгэн тархах нэг нөхцөл болдог байна. Нийгмийн тогтвортой байдал алдагдснаар хүмүүс далдын хүч, сансар огторгуйн зүй тогтолд итгэж биширч эхэлдэг гэсэн үг юм. Посткоммунист шилжилт хийж буй орнуудад уг үзэгдэл ихээр газар авч байсан нь дээрхийн нэг нотолгоо биз ээ. Өөрөөр хэлбэл хямралын үед астрологи нийгэмд сэтгэл заслын үүрэг гүйцэтгэж эхэлдэг байна.

Шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар сэлт, таамаглалаас гадна хууран мэхлэх, ашиг хонжоо хайх арга хэрэгсэл байдлаар улс төрийн астрологийг ашиглах явдал түгээмэл байдгийг хэлэх хэрэгтэй. Тухайлбал, Дэлхийн I дайны дараагаар Герман улсад элдэв телегч, шидтнийг бишрэн шvтэх явдал газар авч 1940 оны эхээр 50.000 зурхайч, шидтэн, телегч, алхимик болон 12.400 оточ-экстрасенсууд бүртгэгдсэн байна. Жирийн иргэдийн талаас илvv хувь тэдэнд ханддаг төдийгүй Германы армийн цэргvvд дайнд явахдаа "залбирлын захиа", "хамгаалах vнэмлэх" зэрэг олон сахиусыг сумнаас хамгаалдаг хэмээн биеэсээ салгадагvv байсан ажээ. 2006 онд ОХУ-д элдэв шидтэн ховсчин гэх 500.000 хүнийг терел бүрийн аппаратаар шинжихэд тэдгээр хvmvvсийн 98% нь худлаа дүвчигнэдэг, 47% нь сэтгэхvйн гажигтай, худал ярин ашиг хонжоо хайдаг хvmvvс болохыг тогтоожээ.

Астрологчид төр засгийн хувьд хамгийн чухал этгээд болж байснаас гадна хавчигдан хөөгдсөн явдал түүхэнд /Эртний Ром, Визант болон Баруун Европын орнуудад/ олонтаа тохиолдож байв. Эрх баригчдын зүгээс астрологийг сонирхох сонирхол буурч, түүнийг худал хуурмаг зүйл гэж үзэхээсээ илүү гудамжны луйварчид, хууран мэхлэгчдийн эсрэг тэмцэж, тэднийг шахан зайлуулахад чиглэж байжээ. Тэрчлэн уг шахалт хавчилт нь /тухайлбал, Ром гүрний эрх баригчид/ астрологид итгэдэг ч хаан язгууртны хувь тавиланг тааж мэдэх, үүнийгээ хар буруу зорилгоор тухайлбал, төрийн эргэлт хийхэд ашиглахаас туйлаас айдаг байсантай холбоотойгоор тайлбарлаж болно. Тухайлбал, Ромын император Тиберий астрологиор бүхий л хувь тавиланг шийдвэрлэж болно гэдэгт хатуу итгэдэг байсан ч жирийн хүмүүсийг хөндлөнгийн гэрчгүйгээр нууцаар мэргэч төлөгчтэй харьцахыг хатуу

хориглож, хувийн астрологчоосоо бусдыг нь Ромоос хөөн гаргаж байжээ.

Астрологийг улс төрийн манипуляци болгон ашиглах нь бий. Тухайлбал, МЭӨ 104-99 оны сицилийн боолын хоёр дахь бослогын үеэр бослогын тэргүүн Атенион астрологчийн нэр хүндийг ашиглан бослого гаргавал амжилт зайлшгүй гэдгийг боолуудад итгүүлж чадсан байна. Тэрээр од ивээж, бурхан түүнд Сицилийн хаан болох замыг нээсэн гэдэгт итгэж байжээ. Их Монгол улсын хаан Чингис, Тэмүүжин бол “бүхний” хаан, дээд тэнгэрээс заяат болохыг ард түмэнд итгүүлэн үнэмшүүлэх зорилгоор Хөхчүү бөөгийн айлдварыг ашигласан байж болох талтай.

Нөгөө талаар астрологи билэгдэл зүйн утга агуулдаг. Улс төрийн астрологийн үүднээс өрнийн зурхайн 12 орд тус бүр өвөрмөц утга санааг илэрхийлдэг байна. Тухайлбал ангараг гараг цэрэг цагдаа болон дайн түрэмгийлэл, терроризмыг, санчир гараг тогтолцоо, институт, эдийн засаг, консерватизм ба бюрократизм, дэд бүтэц, хууль хяналт зэргийг билэгддэг байна [14]. Тэрчлэн 2007 оны 03 сарын 19-ний нарны хиртэлтийг астрологийн үүднээс олон янзаар тайлбарласан байдаг. Тухайлбал, Исламын шашны телегчид энэ онд Америк Иран руу довтолж их цус асгарсан дайн эхлэхийг зөгнөлөө гэсэн бол Христийн шашны вивангард үзүүлэгчид энэ удаагийн хиртэлт байгалийн асар том гамшиг ирэх зун тохиохыг сануулсан гэж тайлбарлажээ. Японы Зэн буддизм болон Түвдийн шашны мэргэч нарын зүгээс нар хиртэлт цөмийн зэвсэг дэлбэрэх юм уу түүнтэй эн зэрэгцэх их осол сүйрэл гарахыг зөгнөсөн гэж үзжээ. Монголын улааны шашны зурхайч лам нар Монголд шашин бурханыг түгээн дэлгэрүүлэх гайхамшигт хувилгаан хүүхэд мэндэлснийг билэгдэнэ гэж тайлбарласан байна [15].

Улс төрийн астрологийг улс төрийн шинжлэх ухааны судлагдахуун болох үүднээс дараах асуудлуудыг тоймлон авч үзэж болно.

- Улс төрийн үзэгдэл, үйл явц, нийгмийн санаа бодол нь улс төрийн астрологиор урьдаас тааварласан харилцааны нөлөөлөл дор оршдог тухай үзэл санааны үүднээс улс төрийн бодлого, бодлогын ирээдүйн үр дагаврыг прогнозлоход харгалзах зарим нэг үндэслэл бий.
- 1990 оны нийгэм-улс төр, сэтгэлгээний өөрчлөлт манай оронд хаалттай байсан олон зүйл тэр дундаа талаас дорнын уламжлалт ухаан, сэтгэхүйн далд чадвар, тэр дундаа астрологийн асуудал нийгэмд ил нээлттэй болсон нь сайшаалтай хэрэг. Нөгөө талаас жирийн иргэд төдийгүй улс төрийн элитүүд астрологи, зурхай, мэргэ төлөгт ихээр автаж, бодлого, үйл ажиллагаа бүрийг астрологийн үүднээс үнэлж цэгнэх билигт сайн эсвэл муу өдрөөс шалтгаалан аливаа үйлдэл хийх эсэхээ шийдвэрлэх болсон нь туйлширсан хандлага юм. Чухамдаа ардчилсан монголын хувь заяа, хүмүүсийн амьдрал ахуй бидний өөрсдийн хичээл зүтгэл, идэвх чармайлтаас, нийгэм-улс төр, эдийн засгийн хөгжил, ард түмний боловсрол мэдлэгээс шалтгаалдаг болох нь үнэн юм.
- Улс төрчдийн зүгээс улс төрийн астрологийг ашиглан өөрийн бодлого чиглэлээ тодорхойлохоос гадна тухайн бодлого шийдвэр хамгийн оновчтой бөгөөд хэрэгжих зайлшгүй шалтгаантай болохыг үндэслэх замаар олон түмнийг араасаа дагуулах, итгүүлэх манипуляци арга хэрэгслээр ашиглах явдал бий.
- Астрологийн үүднээс од эрхэс, сансрын нөлөө хувь хүмүүс, улс орон, хүн төрөлхтний амьдрал хувь заяанд шууд болон дам нөлөөтэйг үгүйсгэхгүй бөгөөд хүмүүсийн хувьд астрологийн таамаглал, үзэл санаа нь сэтгэл зүйн эерэг, сөрөг нөлөө үзүүлдэг нийгэм-сэтгэл зүй, соёл, шашны үзэгдэл юм.

- Нийгэм, хүмүүс улс төрийн астрологид автах явдал нийгэм-улс төр, эдийн засгийн хямралтай нөхцөл, улс орны удирдагчид, төрийн эрх баригчдийн чадварлаг бус байдал, төрийн легетим чанар алдагдсан үед үлэмж тархдаг. Энэ утгаараа улс төрийн астрологи нь нийгэм-улс төрийн өвөрмөц үзэгдэл юм.

Дүгнэлт

Улс төрийн астрологийн асуудлыг хөндсөний шалтгаан нь улс төрийн астрологи нь улс төрийн шинжлэх ухааны салбар бөгөөд нийгэм-улс төрийн үзэгдэл үйл явцыг тайлбарлах арга, ирээдүйг таамаглах аргачлалын өвөрмөц хэв маяг болохыг авч үзэхэд оршино. Улс төрийн үзэгдэл, үйл явц цаашлаад тодорхой бодлого, шийдвэр, бодлогын прогнозчлолд улс төрийн астрологийн зарим үндэслэлийг харгалзах шаардлагатайг үгүйсгэж болохгүй юм.

Цаашлаад монголчуудын хувьд улс төр, эдийн засгийн хүрээний бодлого, үйл ажиллагаа, хувь хүмүүс, улс төрчдийн аливаа асуудалд зурхай, астрологи, шашны шинжтэй олон арга хэрэгсэл, зан үйлийг ихээр ашиглах болсныг эрдэм шинжилгээний үүднээс судлан тодорхойлох, дүн шинжилгээ хийх шаардлага байгааг хэлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл улс төрийн астрологийг нийгэм, улс төр, соёл, шашин, шинжлэх ухааны зааг дээр авч үзэн, судлах шаардлагатай байна.

Ахуй ертөнцийг өөрчлөн төгөлдөржүүлэхэд шийдвэрлэх үүрэг ролийг гариг ертөнцийн хөдөлгөөн, өрнөл бус харин хүний ухамсар, оюун ухаан, шинжлэх ухааны ололт дэвшил, улс төрийн хүрээнд шийдвэр гаргаж буй субъект гүйцэтгэдэг нь тодорхой хэдий ч гариг ертөнц хийгээд улс төрийн үзэгдэл, үйл явцын хоорондын холбоо хамаарлыг судлах, тэдгээрийн онол, практикийн учир холбогдлыг тодорхойлох нь эрдэм шинжилгээний чухал учир холбогдолтойг тэмдэглэх хэрэгтэй.

Ном зүй

Улс төрийн шинжлэх ухаан Ред. Ц.Ганболд УБ., 2001.

Богданов В. “Гитлер знал день своей смерти, за что и уничтожил своего астролога,” *Российской газете*, 8 мая 2003 г., № 86 (3200).

Картер Ч. *Политическая астрология* (пер. с англ. Колесникова А.)
www.goroskop.su/astrologia_na_sluzhbe_gosudarstva.htm

Кудрявцев А, Гужов В. *Теория и история астрологических эпох*
<http://lib.luksian.com/textr/forttell/053/>

Куталёв Д. “Астрология как историко-культурный феномен”
Диссертация на соискание учёной степени кандидата наук
http://lib.druzya.org/Astrology/kutalev/.view-Kutalev_disser.txt.full.html

Куталёв Д. *Астрология и общественно-политическая жизнь*
<http://www.astrologic.ru/culture/society.htm>

Пугачев В.П., Соловьев А.И. *Введение в политологию*. - М., 1999.

Романов Б. “Астрология на службе государства” Симонов К.В.
Политический анализ -М.: Логос 2002.

Симонов К. В. *Политический анализ* -М.: Логос 2002. с-6

Странник Г. *Политическое прогнозирование - утопия или знание ритмов* <http://lib.luksian.com/texttr/forttell/090/>

Астрология и причины ее популярности.
<http://www.refcity.ru/content/13316/5.html>

Время политической астрологии www.warweb.ru/astro_882002.html

Wikipedia, the free encyclopedia.com

Нар хиртэлт юуг зөгнөв www.olloo.mn Нийтэлсэн: 2007-03-22 , Мэдээний дугаар: #50961

Сэтгэхүйн дайныг зураглахуй www.olloo.mn Нийтэлсэн: 2007-01-24, Мэдээний дугаар: #45914

ПОЛИТОЛОГИ III

Эрдэм шинжилгээний бичиг ¹ ... (...): 145-151 дэх тал

СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО БА УЛС ТӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ШҮТЭЛЦЭЭНИЙ АСУУДАЛД

Б.Энхмандах

доктор

Монгол Улсын Байгаль Орчны дэд сайд

“Монгол орон ардчиллын замаар эргэлт буцалтгүй замнаж, улс төрийн тэмцлийн туршлага, улс төрийн соёлын хувьд Зүүн Европийн зарим орнуудаас ч илүүтэй болж, сонгогчид маань сонгууль өгч сурчээ” гэж бид бахархан ярих дуртай. Үүнийгээ бид нотолж, ардчилсан парламентын чөлөөт сонгуулиа 4 дэх удаагаа явуулаад байна. Тэгвэл өнгөрсөн сонгуулиудаар юу болоод өнгөрчих вөө? Улс төрийн тогтолцоонд сонгуулиуд юу авчирав аа? Өнөөгийн Монголын нийгмийн улс төрийн амьдралд өнгөрсөн сонгууль хэрхэн нөлөөлсөн бэ? Зэрэг олон асуултын хариулт дараагийн сонгууль ойртож байгаа энэ үед улс төр судлаачдад төдийгүй, сонгогч олон түмэнд сонирхолтой байгаа юм. Үүнд он дарааллаар нь хөөж хариулт өгөхийг оролдоё.

Нэг: Эрх баригчдын бардамналын уналт, сөрөг хүчний ялалтын цочирдол буюу савлагаат хуулийн гажиг үр дүн¹

УИХ-ын 1996 оны сонгууль дөхөж байлаа. 1992 оноос хойш цөөхөн “цөөнх”-ийн зовлонг амссан улс төрийн залуу хүчнүүд суудлаа нэмэгдүүлэх томоохон зорилтыг өмнөө тавьж сонгуулийн тактикаа боловсруулж байв. Энэ цаг үе нь улс орны эдийн засгийн шилжилтийн шинж чанартай хямралт нөхцөл байдал, түүнээс үүдээд сонгогчдын сэтгэл зүйд улс төрийн шинэ хүчнийг дэмжих сэтгэлгээ давамгайлж байсан үе байлаа. “Залуучуудад өгөөд үзье. 90 оноос хойш гуйсан юм. Шинээр сэтгэж, юм хийх ч юм бил үү. Тэгээд улс орон гялалзаад босоод ирэх ч юм бил үү” гэсэн улс төрийн хүлээлт бүр 1995 он гэхэд Монголын сонгогч олон түмний дотор бий болж, сонгуулийн үр дүн сөрөг хүчний талд үйлчлэх төлөвтэй болоод байв. Ийм нөхцөл байдалд сонгуулийн хуулийг “оролдох” зүрх зориг гагцхүү тухайн үеийн олонхид байлаа. Тэд ч олонхийн хүчээр үүнийгээ хийсэн, эцэст нь цөөнх болж, “савлагаат” хуулийнхаа анхны горыг нь бас амссан. Түүхийг бяцхан сөхвөл, 1994 оны дунд үеэс эхлээд УИХ-ын сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал МАХН-ын удирдлагын түвшинд яригдаж эхэлсэн бөгөөд хэд хэдэн хувилбар яригдаж байлаа. Тухайлбал,

- Сонгуулийн олон мандаттай 26 томсгосон тойрог бүхий мажоритари тогтолцооны хуучин хэлбэрийг хадгалах,
- Тус бүр 2 мандаттай 26 тойрогтой, үлдсэн 24 суудлыг намын нэрээр авсан хувиар хуваарилах мажоритари болон пропорциональ тогтолцооны холимог хувилбарыг сонгох /Жич: Тойрог, хувь тэнцүүлэн хуваарилах суудлын тооны хувьд харилцан адилгүй байр сууриуд байсан/,
- Нэг мандат бүхий 76 тойрогтой мажоритари тогтолцоо /одоогийн хуулийн номлол/-г шинээр батлах гэсэн үндсэн 3 байр суурь тэр үед яригдаж байлаа.

Мэдээж хэрэг хувилбаруудыг дэмжигчид өөр өөрийн үндэслэгээ, тайлбарыг хийж, хамгаалж байсан нь зүйн хэрэг.

Улс төрийн шинэ хүчнийхний шахалтын дор УИХ-ын Сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь эргэлт буцалтгүй болсон тохиолдолд асуудал сүүлийн хоёр хувилбар дээр яригдаж эхэлсэн билээ. Сонгуулийн хуулийн өөрчлөлтийн асуудлыг МАХН-ын Удирдах Зөвлөлөөр нийт 7 удаа авч хэлэлцсэн санагдана.

Тухайн үед хийгдэж байсан социологийн судалгаануудын дүнд үзэл суртлын өнгө аясгүйгээр хандаж, дүнд шинжилгээ хийж үзэхэд МАХН, түүний байгуулсан Засгийн газар, орон нутгийн өөрөө удирдах болон захиргааны удирдлагуудын нэр хүнд тийм ч сайнгүй байсан бөгөөд сонгууль дөхөх тусам рейтинг нь буурах хандлагатай болж байлаа. “Залуучуудад өгөөд үзэх” сэтгэлгээ ч улам бүр газар авч байв. МАХН-ын гишүүн ахмадууд хүртэл “Өгөөд үзье л дээ. Чадахгүй бол сольчихно л биз” гэж огт бодлогогүй хэлдэг болсон байв. Ийм нөхцөлд “Бид ялагдах нээ” гэж удаа дараа сануулж байсны төлөө “Манай намын залуу удирдлага яагаад ийм гутрангуй байдаг байна аа” гэж зарим хүнээр хэлүүлж л явлаа. Ялагдаж болзошгүй байгаа учраас УИХ-ын сонгуулийг холимог хувилбараар хийх нь сонгуулийн үр дүнд гарах савлагаанаас сэргийлж, хүчний харьцааг харьцангуй бодитой тусгаж, парламент дахь хүчний тэнцвэрийг хангах боломжтой гэж үзэж, энэхүү хувилбарыг сонгох саналыг миний бие тавьж, уг хувилбарын давуу болон дутагдалтай талуудын талаар намын Удирдах Зөвлөл дээр сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх бүрт удаа дараа тайлбар хийж,

уг хувилбараар сонгуульд орсон тохиолдолд 39-43 суудал авах боломжтой байж болзошгүй гэсэн улс төрийн таамаглал дэвшүүлж байсан. УИХ-ын зарим гишүүд энэ хувилбар, байр суурийг дэмжиж байсансан. Нэгэн үе асуудал нилээд нааштай эргэж, МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Даш-Ёндон улс төрийн бусад намуудын удирдлагуудтай зохих зөвшилцөлд хүрч, Ерөнхийлөгч П.Очирбатын дэргэд УИХ-ын 1996 оны Сонгуулийг холимог хувилбараар хийх тохиролцоонд гарын үсэг зурсан юм. Гэтэл намын зарим гишүүдийн дотроос Б.Даш-Ёндон, Б.Энхмандах нар сөрөг хүчинд буулт хийж, улс төрийн шинэ залуу намуудад УИХ-ын суудал сул өгөх гэлээ” гэсэн улс төрийн алсын хараагүй хандлага, сэрдлэг гарч, “Үнэн” сониноор хүртэл шүүмжилж эхэлсэн нь намын Ерөнхий нарийн бичгийн даргыг өөрийн байр сууринаас буцахад хүргэж билээ. Эцэст нь УИХ-ын нэр бүхий 3 гишүүн санаачлан УИХ-д нэгэнт өргөн барьсан 76 тойргийн хувилбарын талаар эцсийн шийдвэр гаргах хүндхэн асуудал 1995 оны өвөл НУЗ-д тулгарсан юм. Энэ хурал бол МАХН-ын 1996 оны сонгуулийн хувь заяаны эргэлтийн буюу сонгуулийн ялагдлыг нөхцөлдүүлсэн хурал байлаа. Нэгэнт намын Удирдах Зөвлөлийн шийдвэргүйгээр өргөн баригдсан энэхүү хуулийн төслийг дэмжиж, УИХ дахь намын Бүлэгтээ хуулийг дэмжин батлах чиглэл өгөх сүүлчийн энэ хурал дээр миний бие “жигжэрүүлсэн” /нэг мандаттай/ сонгуулийн мажоритари тогтолцооны сул талын талаар дахин сануулаад, саналаа өгөхийн өмнө Б.Даш-Ёндон даргаас “76 тойрогтой хувилбараар сонгуульд ороод ялагдсан тохиолдолд хариуцлагыг хуулийн төслийг Намын Удирдах Зөвлөлийн шийдвэргүй дур мэдэн өргөн барьсан 3 гишүүн хүлээх үү? Намын Удирдах Зөвлөл өөрөө хүлээх үү?” гэж асууж байж билээ. Ерөнхий нарийн бичгийн дарга маань гүн сэтгэгчийн хувьд удтал дуугүй сууж, бодолхийлэн байснаа “Ялсан ч, ялагдсан ч Намын Удирдах Зөвлөл л хариуцлагаа хүлээж таарах биз ээ” гэж сулхан хэлсэн нь хэдхэн сарын дараа биелэлээ олж, МАХН-ын Удирдах Зөвлөл бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч билээ. Миний бие өөрийн байр сууриа өөрчлөхөөс татгалзаж, 1:10 саналаар ялагдаж, олонхийн саналаар УИХ-ын сонгуулийг 76 тойргоор явуулах чиглэлийг УИХ дахь намын бүлэгтээ өгсөн нь архивын шар хуудаснаа тэмдэглээтэй байгаа. 1996 оны сонгуулийн шинэ хуулийн үр дүн суудлаа нэмэх бодолтой байсан. Эвслийн зүгт “савалж”, тэд 50 суудалтай эрх баригчид болж хувирав. Төр, засгийн эрх мэдлийг мөнхөд барих юм шиг санаж байсан эрх баригчид ялагдлын “шок”-д орж, эрх барих тухай бодол ч байгаагүй залуучууд ялсан эхний өдрөөс эхлээд сэтгэлийн хөөрөлд автаж, эрх мэдэлдээ толгой нь эргэж, улс төрийн тогтворгүй байдал, засаглалын хомсдол үүсгэн, улс орны хөгжилд түлхэц биш, ухралт хийснийг монголчууд бид хараахан мартаагүй.

Хоёр. Эрх баригчдын “нялхасын” алдаа, сөрөг хүчний төгс ялалт буюу савлагаат хуулийн гажиг үр дүн^{1 2}

2000 он. Ардчилсан нийгмийн жаяг ёсоор сонгуулиа хийж, ээлжит 4 жилд төрийн эрх барих улс төрийн хүчнийг сонгох сонголт ард түмний өмнө ахиад л тулгарав. Энэ удаад тэдэнд сонголт хийхэд хялбар байсан. Учир нь эрх баригч байсан “Ардчилсан Холбоо” эвслийнхэн төр барих чадвар сул, туршлага суугаагүйгээ өөрөө өөрсдийнхөө үйл ажиллагаагаар харуулчихсан байв.

1996 онд сонгогчид тэнцвэржүүлж чадалгүй “алдаа хийснээ” ухаармагц бараг сонгуулийн маргаашнаас эхлээд “Ардчилсан Холбоо” эвслийн Засгийн газрын эсрэг санаа бодлоо илэрхийлж эхэлсэн бөгөөд

цаашид тэнцвэржүүлэхийн тулд сөрөг хүчнийг дэмжихээс өөр замгүй болсон байлаа.

Энэ нь ч дараа дараачийн сонгуулиудын үр дүнгээс харагдаж байсан юм. Тухайлбал, Ерөнхийлөгчийн 1997 оны сонгууль болон УИХ-ын 21, 37, 53 дугаар тойргуудад болсон нөхөн сонгуулиар ард түмэн МАХН, түүнээс нэр дэвшигчдийг тууштай дэмжиж байсан явдал гэж хэлж болно.

УИХ-ын 2000 оны ээлжит сонгуулийн өмнөх Монголын нийгмийн улс төрийн сэтгэлгээний уур амьсгалыг судлан үзэхэд “МАХН улс орныг удирдахын хувьд арай дээр байсан юм байна. Засгийн эрхийг тэдэнд өгөх нь зөв юм. Гэхдээ сөрөг хүчин байхгүй бол бас болохгүй ээ” гэсэн бодол давамгайлж байсан билээ.

Энэ нөхцөлд эрх баригчдын зүгээс сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах санаа оноо гарч, олонхи дотроо ч нилээд хэлэлцэж ярилцсан, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд чамгүй хүчин чармайлт гаргасан байх. Тэр үед парламентын сонгуулийг пропорциональ, эсвэл холимог, эсвэл томосгосон тойрогтой мажоритари тогтолцоогоор явуулах аль аль хувилбар нь бас л яригдаж байсан. Нөхөн сонгуулиудын үр дүнд парламент дахь байр сууриа бэхжүүлж хүчтэй сөрөг хүчин болж чадсан МАХН-ын цөөнхийн бүлгийн зүгээс тойрог томосгох хувилбарыг дэмжиж сонгуулийн хуульд өөрчлөлт оруулахыг эсэргүүцээгүй юм. Гэвч олонхийн бүлгийнхэн өөр хоорондоо учраа ололгүй байсаар сонгуультай золгосон. 4 жилийн турш сөрөг хүчин байж үзсэн МАХН ч сонгуульд ихээхэн бэлтгэлтэй оролцож сонгогч олныхоо нийгмийн захиалгыг сайтар мэдэрч, хийж бүтээх эрмүүн зорилттойгоор сонгуульд оролцсон нь сонгогчдод бас таалагдах шиг болсон. Иймээс сонгогч түмэн сонгуульд МАХН-ыг дэмжсэн гэхдээ 72:4 гэсэн дүн гарна гэж бас бодоогүй байх аа. Тиймээс ч бараг сонгуулийн маргаашнаас эхлээд “Хэтрүүлчихлээ” гэсэн яриа гарч байсныг хүн бүхэн санаж байгаа байх. “Тэнцвэржүүлж” чадсангүй бас дахиад л “Савлуулчихжээ”! энэ яриа дараагийн савлагааны эхлэл байсан ажгуу.

Гурав. Сөрөг хүчнийг тэнцвэржүүлэх тактик буюу эрх баригчдын хүлээгээгүй гажиг үр дүн ¹ 3

2000 оны сонгуульд ялалт байгуулсан эрх баригч МАХН-ынхан зүгээр суусангүй. Тэд эдийн засгийг эрүүлжүүлэхэд ахиц дэвшил гаргаж хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг өрнүүлж гадаад, дотоод өр төлбөрөө барагдуулж олон улсын хэмжээнд нэр нөлөөгөө өсгөх бодлого баримтлан түүнийгээ эвтэйхэн гээч хэрэгжүүлж чадсан байна. Өөрөөр хэлбэл улс орныг хэрхэн удирдаж болдгийг урьдын эрх баригчдад харуулж чадаж байгаагаараа энэ удаагийн сонгуулийн үр дүн өөрт нь ашигтай байх хөрсийг сайн боловсруулчих шиг болсон. “МАХН ч юм хийж байна шүү. Ах нартаа өгөх ёстой “их өр”-өө дарчихлаа. Гадаад валютын нөөц ч овоо өслөө. “Мянгуужин”-ийн гээд байсан “мянганы зам” -аа эхлүүлчихлээ. Эдийн засгийн өсөлт буй боллоо. Барилга, байшин ч нэмэгдэх төлөвтэй. МАХН ч 2004 оны сонгуульд айхгүйгээр авдрандаа хийгээд авах шиг боллоо” гэсэн нийгмийн сэтгэл зүй үндсэндээ бүрэлдсэн байв. Үүний зэрэгцээ “Сөрөг хүчин жаахан хүчтэй байхгүй бол болохгүйсэн. Даанч өөр хоорондоо сөргөлдөж, өвөр түрүүндээ хөлөө хийлцээд” гэсэн сонгогчдын сэтгэлгээний хэв загвар нилээд түгээмэл бөгөөд төлөвшмөл байдалтай байсан. 2003 оны сүүлчээр эрх баригчдын нэр хүнд харьцангуй өндөр байгаа энэ цаг үеийг ашиглаад УИХ-ын сонгуулийн хуульд зохих өөрчлөлт оруулж харьцангуй тэнцвэртэй парламент бүрэлдүүлдэг сонгуулийн “савлагаагүй” тогтолцоог сонгон авах ховорхон

боломж парламент дахь МАХН-ын олонхид олдож байв. “УИХ-ын сонгуулийн тухай” хуульд сонгуулийн тойргийг томосгох, эсвэл сонгуулийг холимог тогтолцоогоор явуулах чиглэлээр “гар хүрэх” тухай эрх баригч нарын дотор яригдаж эхэлсэн. Энэ бол алсын хараатай, Монголын улс төрийн тогтолцооны төлөвшилд зайлшгүй чухал алхам байсан. Харамсалтай нь хэрэгжүүлж чадаагүй. Үүнийг хийж чадсан бол сонгууль бүрээр нэг тийшээ савлаад байдаг мажоритари тогтолцооны “Савлагаат” байдлыг арилгаж харьцангуй тэнцвэртэй олонхи цөөнх бүхий парламенттай орон болж Монголын улс төрийн намуудын төлөвшилтөд ч хэрэгтэй байсансан. Гэтэл өөрсдөд нь ашигтай байж болох талтай сонгуулийн хуулийн өөрчлөлтийн эсрэг парламентын цөөнх, тэдний төлөөлсөн намууд эцэст нь шинэ тутам байгуулагдсан эвслийн зүгээс хатуу байр суурь баримтлаж байсныг одоогийн байгаа хуулийн “савлагаат” чанарыг дахин нэг ашиглах сонгуулийн стратегийн бодлогыг “Эх орон-Ардчилал” эвлийн зүгээс баримтлажээ гэж хэлэхээс өөрөөр тайлбарлах аргагүй юм. “сөрөг хүчин ч хэрэгтэй шүү” гэсэн сонгогч олон түмний “Тэнцвэржүүлэх сэтгэлгээ” -н дээр “тоглож”, сонгуулийн дүнг өөрсдийн талд ашигтайгаар “савлуулж” чадвал хүчтэй цөөнх ч биш бүр 1996 оных шиг эрх баригчид ч болох юм бил үү гэсэн тактикийн бодол байсан учраас урьд өмнө нь өөрсдийнхөө ярьдаг, хүсдэг байсан сонгуулийн хуулинд хийх өөрчлөлтийн эсрэг зогсох логик муутай боловч хожоотой байж болох байр суурийг эвслийн удирдлагын зүгээс баримтласан ажээ.

Эрх баригчдын өндөр рейтингийг эвдэж сонгуульд ялалт байгуулахад сөрөг хүчинд хүнд болж байсан тул тэдэнд шийдвэртэй ашиглах хоёрхон гарц л үлдсэнийг тэд овжин олж харсан байна. Үүнд:

1. Эн тэргүүн МАХН-ын эсрэг бүх улс төрийн хүчнүүдийг улс төрийн өнгө, будагаас хамаарахгүйгээр нэгтгэн, нэгэн “Эвсэл” бүрэлдүүлэх нь чухал зорилт байсан. Ардчилсан нам, МАШСН-ын “Эх орон-Ардчилал” эвсэлд ИЗ-БНН нэгдэн орсоноор үүнийгээ ч үндсэнд нь шийдсэн. Энэ бол засгийн эрх барьж үзсэн ардчилсан намынханд эрх барьж үзээгүй МАШСН, ИЗ-БНН-ын давуутай тал, шинэ нэрийг ашиглан дахин улс төрийн эрхэнд гарах нэг арга зам байв. Өөр арга зам тэдэнд байгаагүй. Ингэж ашиглуулахад МАШСН, ИЗ-БНН бэлэн байсан нь бас ховорхон завшаан болсон.
2. Нөгөө нэг гарц бол сонгогчдын сэтгэхүйд байгаа “Сөрөг хүчин хэт цөөн байх шиг байна. Жаахан нэмээд өгөхсөн” гэдэг буюу “Тэнцвэржүүлэх сэтгэлгээ” -г дээд зэргээр ашиглаж өөгшүүлэх явдал байсан юм. Тэгэж байгаад сонгуульд ороход сонгогч хүнд өөр ямар ч хувиларгүй, цорын ганц сонголт хийх боломж олгодог сонгуулийн мажоритари тогтолцооны согог эвсэлд нааштай үйлчилж, хүн бүр “МАХН тэртээ тэргүй ялах юм чинь би сөрөг хүчинд саналаа өгч, парламент дахь хүчний харьцааг тэнцвэржүүлбэ” гэж бодож саналаа өгсөнөөр жинхэнэ “савлагаа” үүсч, сонгуулийн дүн эцэстээ эвсэлд ашигтайгаар эргэх болов уу хэмээн тооцсон өөрсдийгөө “өрөвдүүлэх” арга зам байв. Сонгуулийн хуулийг өөрчлөхгүй байхад нөлөөлсөн бас нэгэн хүчин зүйлийг дурьдалгүй орхиж болохгүй санагдана. Энэ бол хувь хүний хүчин зүйл. УИХ -д нэр дэвших боломжтой гэж өөрийгөө үзэж, өнгөрсөн 4 жилийн туршид сонгогдож болзошгүй тойрогтоо чамгүй их мөнгө зарцуулж “ажилласан” зарим хүмүүсийн хувьд хийсэн бүхэн нь үргүй хоосон ажил болж болзошгүйгээс тэд сонгуулийн хуульд өөрчлөлт орж, томосгосон буюу холимог тогтолцоогоор сонгууль явуулахаас эмээж байсан нь зүйн хэрэг. Ийм байдал сөрөг хүчнийхэнд төдийгүй эрх

баригчдын дотор ч ажиглагдаж байсан. Эдгээр учир шалтгааны үүднээс үзэхэд сонгуулийн хуулийн өөрчлөлтийг дэмжих алхамыг эвслийн зүгээс хүлээх нь үнэхээр утга учиргүй зүйл байжээ. УИХ-ын сонгуулийн хуульд өөрчлөлт оруулж чадаагүйгээс 2004 оны сонгуулийн дүн бас нэг талдаа “Савласан” дүн л гарлаа. УИХ дахь суудлын тооны хувьд ойролцоо олонхигүй парламент, эвслийн Засгийн газар байгуулагдах нөхцөл байдал үүссэн нь сонгуулийн хуучин хуулийн “савлагаат” чанарын үр дүн гэдэг нь хэнд ч тодорхой асуудал. Хамгийн гол нь “Савлагаа” эрх баригч хүчнийг дахин өөрчлөхөд хүргэсэн. Энэ удаад улс төрийн хоёр гол хүчнийг хоёуланг хамтарч эрх барихаас өөр аргагүй байдалд хүргэв. Сонгуулийн үр дүн хийж бүтээснээрээ нэр хүнд нь харьцангуй өндөр байсан МАХН-ын талруу “савлах” уу? Эрх баригчдад хяналт тавих хэмжээнд суудал өгөхийг сонгогчдоос гуйж байсан эвслийн талруу савлах уу? гэдгийг сонгуулийн өдөр 2004 оны 6-р сарын 27-нд сонгогчдын үзэгний үзүүр тэг дундуур нь “Савласан” байдалтай шийдвэрлэсэн.

Дөрөв. Сонгуулийн хуулийн гажигийг ашигласан ба ашиглуулсан түүх оршвой

“Савлагаа” -г урьдчилан тооцож сонгуулийн хуулийн дутагдалтай талыг ашиглан сонгуулиар авах суудлынхаа тоог нэмэгдүүлэх боломжгүй шахам зорилтыг амжилттай шийдвэрлэж чадсан. “Эх орон-Ардчилал” эвслийн сонгуулийн менежментийг үнэлэхээс аргагүй. Тэд юу хийж чадсан бэ? гэвэл:

- Тойргуудын сонгогчдын судалгааг маш эртнээс нухацтай хийж тэдний ашиг сонирхлыг цэгийг зөв олж тогтоож чадсан.
- Судалгаан дээрээ үндэслэн сонгогчдын “Хөвөгч” хэсгийг зөв тодорхойлж тэдэнтэй “Тулж” ажилласан.
- Суудал авч чадаж л байвал хэн нь ч хамаагүй гэсэн бодлогын үүднээс жижиг тойрог дээр мөнгө хаяж, ялахын тулд юу ч хийхээс буцахгүй бизнесменүүдийг улс төрийн тэмцэл, өрсөлдөөнд хатуужсан, хашир, тулхтай улс төрчдөөсөө ч дээгүүр тавьж тэдэнд олон тойрог зоригтой хуваарилсан.
- Сонгуулийн сурталчилгааны ажлыг их даруухан эхэлж хөрөнгө мөнгөгүй мэт аяглан, мөнгөө сурталчилгааны самбар, радио телевизийн нэвтрүүлэг, урлагийн тоглолт, шоу зэрэгт “Хоосон” зарцуулалгүй далд байдалтайгаар сонгогчдод “Хүнд нь хүргэж зарцуулсан” нь үр дүнгээ өгсөн.
- Эрх баригчдын сонгуулийн эхэн дэхь өндөр рейтинг, сурталчилгааны хэт давшингүй өндөр давтамжтай байдал, сонгуулийн сурталчилгааны алдаатай тактикийг соргогоор ашиглан, улам өрөвдүүлэх “чимээгүй” сурталчилгааг сайн хийсэн.
- Улс орноо хөгжүүлэх цэгцтэй бодлого бүхий хөтөлбөргүй атлаа нийгэмд давамгайлах болсон бэлэнчлэх буюу хэрэглээний сэтгэлгээг хөөрөгдөн ашиглаж “Хүүхэд бүрт сар бүр 10000 төгрөг” өгөхөөр амлах, “Гар цайруулах” аргыг чадварлаг хослуулах замаар сонгогчдыг өөртөө татаж чадсан.
- “МАХН, түүний удирдлагын зүгээс дарангуйлал тогтоох гэж байна” гэсэн сөрөг сурталчилгаа нь олон нийтийг айлган, эмээлгэх зорилгодоо хүрсэн.
- “Зорилго нь арга хэлбэрээ зөвтгөдөг” гэдэгчлэн сонгуульд ялж л байвал сонгуулийн “хар” арга ч хамаагүй гэдэг зарчмыг ичихгүйгээр сайтар ашиглаж чадсан.

Эцэст нь нэгэн зүйлийг хэлэхгүй орхиж болохгүй. Д.Баасанхүү гэгчийн “бүгдээрээ миний санаа биш” гэж мэдүүлж байсан. “АН-ын сонгуулийн сурталчилгааны ажилд анхаарах зүйл” нь нэг хүн зохион бичсэн гэхээсээ сонгуулийн олон арван жилийн туршлагатай мэргэжлийн байгууллага бэлтгэж, ардчилсан намын гишүүд, идэвхитнүүдэд аман хэлбэрээр түгээсэн ажлын удирдамж гэвэл үнэнд илүүтэй нийцэх нь тэнэг хүнд ч тодорхой. Гагцхүү үүний жинхэнэ эзэн нь, эзэд нь одоо хүртэл тодроогүй байгаагаас үзэхэд Монголын чөлөөт, ардчилсан сонгуульд нилээд хүчтэй гар оролцсон байж болох талтай. Харин эрх баригчдын зүгээс сонгогчдын сэтгэл зүйд гарсан өөрчлөлтийг дутуу мэдэрснээр сонгуулийн компанит ажлын тактикаа буруу сонгож, сурталчилгааны ажлын эхлэлийн өндөр далайцаа хадгалахын тулд хүч, хөрөнгө, цага хугацаа ихээхэн зарцуулсан боловч үр дүн нь зорилгодоо хүрээгүй байдал ажиглагдаж байна. Үүний гол учир шалтгаан нь сонгуулийн хуулийн гажигийг олж хараагүй, харсан ч тоогоогүй, түүнийг өөртөө ашигтайгаар ашиглах боломжийг өрсөлдөгчиддөө олгосонд оршино. Тэдний:

- Өнгөрсөн 4 жилийн хугацаанд хийсэн бүтээсэндээ эрдэж, МАХН-ын нэр хүнд харьцангуй өндөр байгаа нь сонгуульд ялалт байгуулах боломж олгож байна гэж үзэж сонгуулийн сурталчилгааны “Хэт давшингүй” тактик баримтласан нь ядарсныг нь өрөвдөх сэтгэлгээтэй монголчуудыг эвслийн зүг эргэхэд хүргэсэн.
- Сонгуулийн сурталчилгааг Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад нэр дэвшигчээ тойруулсан байдалтай зохион байгуулдаг Япон, АНУ-ын намуудын сонгуулийг тактикийг ашиглах гэсэн оролдлого нь монголчуудын уламжлалт сэтгэл зүйд тохирсонгүй.
- Сонгуулийн сурталчилгааны хөрөнгө мөнгөө реклам, самбар, тоглолт, шоу, радио, телевизийн сурталчилгаанд хуулийн дагуу зарцуулсан нь олон түмэнд хэт ил тод байж тэр хэрээр асар их мөнгө үргүй зарж байна гэсэн буруу ойлголтыг өрсөлдөгчид нь чадварлаг хөөрөгдсөн.
- Зарим болчимгүй хүмүүсийн бодлогогүй үйлдлээс болж Монгол улсын Ерөнхийлөгч болон намын тухайн үеийн удирдлагын хооронд зөрчил хагаралтай байдал үе үе ажиглагдаж байсан нь МАХН-ын дотоодод зарим ойлгомжгүй байдал бий болгосны хамт сонгогчдын зарим хэсгийг “МАХН маань ийм ч билүү дээ” гэж гутрахад хүргэсэн.
- Нэр дэвшигч бүр компанит ажилдаа жигд бэлтгэгдээгүй, сонгуулийн тойргоо дутуу судалснаас сонгогчдын янз бүрийн бүлгүүдтэй ялгавартай ажиллах арга, хэлбэрээ зөв сонгож, сурталчилгааны ажлаа сайн зохион байгуулж чадаагүй.
- МАХН-ын дотоод ажил суларснаас гишүүд, дэмжигчид орон нутгийн байгууллагуудынхаа хүчийг төвлөрүүлэн зохион байгуулж тэднийг нэр дэвшигчийн багтай холбон ажиллуулахад доголдол гаргасан зэрэг алдаа эндэгдэл сонгуулийн үр дүнд нөлөөлснийг үгүйсгэх аргагүй юм.

Гэвч гол нь сонгуулийн хуулийн гажигийг дутуу үнэлсэн нь эрх баригчдын гол алдаа гэж хэлж болно. Үүгээр миний бие сонгуулийн үр дүнд бүхэлд нь задлан шинжилгээ хийхийг зориогүй бөгөөд гагцхүү сонгуулийн хуулийн “Савлагаат” чанарыг чухам юу өөгшүүлсэн болохыг олж харахыг оролдсон болно.

*

*

*

УИХ-ын 2008 оны сонгууль хаяанд ирлээ. Ирэх сонгууль томосгосон мажоритари хувилбараар явагдах нь бараг гарцаагүй болсон. Энэ тохиолдолд сонгуулийн хуулийн үр дүнгийн савлагаат чанар багасч улс төрийн нөлөө

бүхий хүчнүүдийн харьцангуй тэнцвэртэй бөгөөд тогтвортой тогтолцоонд шилжих эхлэл тавигдах бололцоо гарч ирэх биз ээ.

Түүнээс гадна мөнгөтэй хүн жижиг тойрогт мөнгө, хөрөнгө цацаж, санал худалдан авах гаж үзэгдэл хумигдаж, улс төрийн ноён нуруутай, төрийн ажлын дадлага туршлагатай, олон түмэнд танигдсан “төрийн хар хүн” парламентад сонгогдох боломж нэмэгдэж, улс төр, бизнес хоёр холилдсон төрийн гаж тогтолцоо засрах буй заа хэмээн найднам.

ПОЛИТОЛОГИ III

Эрдэм шинжилгээний бичиг ¹ ... (...): 152-164 дэх тал

ЯДУУРАЛ, ТЭГШ БУС БАЙДАЛ НИЙГЭМ - УЛС ТӨРИЙН МӨРГӨЛДӨӨНИЙ СУРВАЛЖ БОЛОХ НЬ

Р. Болд
докторант

Хураангуй

Орлогын ядуурал, нийгмийн тэгш бус байдал бол нийгэм - улс төрийн мөргөлдөөн үүсэх шалтгаан нөхцөл болох талаар шилжилтийн үеийн Монгол орны жишээн дээр тайлбарлахыг эрмэлзсэн болно.

157

хөгжлийн эргүүлэг хэдийчинээ огцом ширүүн байх аваас энэ үйл явцыг дагалдан нийгмийн мөргөлдөөн төдийчинээ их гардаг бололтой. Нийгмийн хөгжлийн гол урсгал түргэн өөрчлөгдөх нь нийгэмд эргүүлэг цүнхэл үүсгэн нарт хорвоо дээр шинэ байр суурь олж авахын төлөө тэмцэлд урьд нь сөргөлдөнө тэмцэлдэнэ гэж бодоогүй байсан хүмүүсийн том том бүлгийг татан оруулдаг байна.

Нийгмийн өөрчлөлт юуны өмнө нийгмийн амьдралд бүтцийн өөрчлөлтийг дагалдуулдаг учир мөргөлдөөнд хүргэдэг юм. Бүтэц эвдэрч, нийгмийн зарим бүлэг нийгэмд шинэ байдалтай болох нь урьд байсан хэлхээ холбоо, харилцааг эвдэж, шинэ харилцаа тогтоохыг шаарддаг болохоор үүнийг дагалдан нийгмийн олон мөргөлдөөн үүсдэг байна. Тийм мөргөлдөөн нь чухамхүү нийгэмд нийтлэг шинжтэй харилцан зохицох, бие биеийнхээ аяыг дагах хэлбэр болдог юм. Урьдын цагт бие биенээсээ салангид тусгай овог аймаг, үндэстэн ястан хоорондоо хавиралдахад бие биеэ таних, харилцан нөлөөлөх үеийг бараг ямагт дайрч гардаг, үүнийг дагалдан их, бага ямар нэг хэмжээний мөргөлдөөн үүсдэг байжээ. Иймэрхүү нөхцөл байдал одоо үед ч дахин давтагдах мэт байдаг боловч харин нийгмийн өөрчлөлтийн үйл явцад шинээр үүссэн нэгдэл, бүлэг, байгууллагын бүтцийн харилцан үйлдэлд ийм явдал гардаг аж.

Нийгмийн харилцаан дахь өөрчлөлтийг дагалдан нийгэм - улс төрийн мөргөлдөөн үүсэх хүрээ урьд хожид үзэгдээгүй өргөжив. Манайд хүн амын янз бүрийн бүлгээс үүдэлтэй зөрчил бүхий шаардлагууд байнга нэмэгдсээр байна. Тоталитар дэглэмийн мөхөх болон бүрэлдэн тогтох үед нийгмийн амьдралд ямагт эрс огцом, үлэмжхэн өөрчлөлт гарч, улмаар түүнийг дагалдан нийгмийн мөргөлдөөний тоо, цар хүрээ мэдэгдэхүйц нэмэгддэг бололтой.

Өнөөгийн нийгэм - улс төрийн мөргөлдөөн нь өмнөх үеийн эдийн засаг, нийгэм ба үзэл суртлын зөрчлийн зүй ёсны үргэлжлэл мөн. Нийгмийн улс төрийн хөгжил нь нийгмийн өөрчлөлт ба түүнд улс төрийн системийн дасан зохицох чадвар хоорондын, нийгэм, эдийн засгийн шинэ шаардлага ба түүнийг хангах нийгмийн боломж хоорондын зэрэг зөрчлүүдийг шийдвэрлэх хэлбэрээр явагддаг. Эдгээр зөрчил нь мөргөлдөөний хэлбэрээр илрэхүй. Харин нийгмийн янз бүрийн бүлэг давхрааны төрөл бүрийн шаардлагыг улс төрийн систем хангаж байвал түүнийг дэмжих нь идэвхжиж, тогтвортой байдлыг нь бэхжүүлнэ.

Шилжилтийн үеийн Монгол оронд хүн амын орлогын ялгаа, ядуурал хийгээд нийгмийн тэгш байдал, шударга ёс алдагдсантай холбоотойгоор үүссэн ард иргэд болон засаглалын субъект хоорондын мөргөлдөөн багагүй гарах болов. Эдгээрийн талаар товчхон авч үзье.

Ядуурал

Мөргөлдөөн бол нийгмийн амьдралын аливаа нарийн үзэгдлийн нэгэн адил үүсэж, өрнөж байгаа нийгмийнхээ бүтэцтэй мянга түмэн шижмээр холбоотойг бид дээр дурьдсан. Нийгэмд өөрөөс нь, түүний бүтцийн болон үүргийн онцлог, нийгмийн системийн ерөнхий хэв шинж болон нийгмийн бусад хэд хэдэн магадлуураас шалтгаалан ил юм уу далд зөрчилт шинж оршиж байдаг. Юуны өмнө зөрчилт шинжийн ерөнхий байдалд нийгмийн системийн бүтцийн шинж төлөв тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байна. Иймд нийгмийн социал бүтэц бол нийгэм-улс төрийн мөргөлдөөний нэг гол эх булаг мөн.

гишүүдтэй харьцуулахад урьд өмнө нь түүнд юу байснаар хэмжигдэнэ” гэжээ¹.

Ядуучууд ба баячуудын хоорондын орлогын харьцааг үнэлэхэд ихэвчлэн децилийн коэффициентийг ашигладаг. Энэ нь нийгмийн гишүүдийн хамгийн баян 10%, хамгийн ядуу 10%-ийн хоорондын орлогын харьцааны үзүүлэлт юм. Өрнөдийн улс төр судлаачид, социологчдын үзэж байгаагаар децилийн коэффициент 10-аас хэтрэхэд нийгэмд эсэргүүцэл, үймээн самуун үүсэх бодит аюул занал бий болдог байна. Мэргэжилтнүүдийн албан бус үнэлгээгээр энэхүү үзүүлэлт манайд 1996 онд 6 : 1 байсан бол 2006 онд 19 : 1 болж өөрчлөгджээ. Ганцхан жишээ дурьдахад “ядуу” ангилалд багтах дөрвөн хүнтэй нэг өрх жилд дунджаар 960 мянган төгрөгний орлого олж байхад харин “баян” хэмээх ангилалд багтсан УИХ-ын нэгэн эрхэм гишүүний гэр бүл 150 сая төгрөгөөр үнэлэгдэх орд харшид амьдарч, 60 саяын жип машин унан, төрөөс олгодог 6 саяын цалин, хангамжаас гадна янз бүрийн ноогдол ашиг, хадгаламжийн хүү мэтээс жилдээ 110 сая төгрөгний нэмэгдэл орлого олдог байна². Дээрх хоёр өрхийн орлогын харьцаа гэхэд л 120 : 1 байх жишээтэй.

Өнөөгийн энэ баян хоосны ялгаа туйлшрал нь 1990-ээд онд явагдсан өмч хувьчлалын гажуудалтай салшгүй холбоотой. Өмч хувьчлалыг судалгаа тооцоогүй, кампанчилан явуулснаас улс орондоо эдийн засгийн ихээхэн хохирол учруулж, нийгмийн шударга ёсыг алдагдуулсан. Өмнөх үеийнхний бий болгосон өмчийг хувьчлах гэж ёстой л “хар бор арга” хэрэглэжээ. Хувьчлал, нийгэмчлэл хоёр нь зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг тал; эхнийх нь билгийн, хоёр дахь нь аргын тал, тэдгээрийн аль нэгийг нь өрөөсгөлөөр хийвээс алдаа эндэгдэлд орно, улс орноо доройтуулна; улс орны тухайн үеийн байдалд нь тохируулж, тэдгээрийн шүтэлцээний хир хэмжээг зөв ухаарч хувьчлал, нийгэмчлэлийг хийх учиртай аж³.

Хүн амыг ядууралд хүргэж буй үндсэн шалтгаан бол ажилгүйдэл. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 75, 6 %- д нь ажил албагүй хоёр хүн амьдарч байна. Үүнээс үзэхэд манайд хөдөлмөрийн чадвартай насанд хүрсэн хүмүүсийн тал хувь нь ажилгүй байгаа бөгөөд ажилгүйчүүдийг тэжээж буй өрх нийт өрхийн дотор түүнээс ч илүү хувийг эзэлж байгаа нь харагдаж байна⁴. Өөр нэг судалгаагаар нийслэлийн дүүргүүдэд эдийн засгийн идэвхтэй хүн амын 15-30 хувь нь ажилгүйчүүд байв⁵.

Ажилгүйдэл, ядуурал манай нийгмийн хамгийн хар бараан зүйл болж түмэн олны сэтгэл зүйг эзэмдэн улмаар тэмцэл мөргөлдөөнд хүргэх болов. Мөргөлдөөн юуны өмнө хэрэглээний хомсдол болон энэхүү хэрэглээг хангах хэрэгслийг олох хүсэл тэмүүллээр тодорхойлогдож байна.

Өндөр хөгжилтэй чинээлэг орнуудад үндэсний орлогыг хуваарилахтай холбоотой эдийн засгийн шинжтэй мөргөлдөөн харьцангуй бага гардаг бол аж ахуй, санхүүгийн хувьд бэл бэнчин муутай улс оронд эдийн засгийн агуулгатай, үр дагавраараа нэлээд хор уршигтай мөргөлдөөнүүд гарах нь элбэг байна. Яг л Кеннет Боулдингийн (*Kenneth E. Boulding*) хошигнон хэлсэнчлэн загасны түрсний төлөөх мөргөлдөөн бол талхны төлөөх мөргөлдөөнөөс бага ач холбогдолтой байдаг аж⁶.

¹ Нийслэлийн А. хамгаалагчид, 1992. о. 273.

² Өмч-ийн хувьчлалын үр дагаврыг судалгаа.

³ Өмч. Л. Нийслэлийн хамгаалагчид, 2005. о. 553.

⁴ Хамгаалагчид. А. тал, Ibidem, Нийслэлийн - 7, 10-ийн 265 (35), 2006. о. 118.

⁵ А. тал, 10-ийн 265 (35), 2006. о. 48.

⁶ Boulding K.E., Conflict and Defence. A General Theory. New York, 1962. о. 324-325.

Польшийн нэр хүндтэй судлаач Ежи Вятр (*Jerzy Wiatr*) хүний эрэлт шаардлага нь түүнийг хангах боломжоос илүү их өсөн нэмэгдэж буй үед үүсдэг болзолт депривацийн тохиолдлыг онцлон тэмдэглэжээ. Яг ийм үед депривацийн буруутан гэж тооцогдсон нийгмийн буюу улс төрийн системийн эсрэг чиглэгдсэн түрэмгий зан үйлийн хандлага тодоор илэрдэг байна ¹.

Харин донсолгоон гарахаас урьдчилан сэргийлэх нь эрх баригчдын зүгээс нийгмийн янз бүрийн давхаргын хэрэгцээг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, түүнийг хангах буюу нөхөх хэрэгслийг олох, хөгжлийг урагшлуулах болон хэрэгцээг хангасан хэмжээгээрээ нийгмийн тэгш бус байдлыг нийгмийн хэм хэмжээний түвшинд барьж байх нөхцөлд бололцоотой юм.

Иймд төр засгаас юуны түрүүнд ажлын байр олноор бий болгох, хөдөлмөрийн хөлс, тэтгэвэр тэтгэмжийг боломжийн хэмжээнд амь зуух хүртэл нэмэгдүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна. Хуулийн хүрээнд эд баялаг, эрх мэдлийг дахин хуваарилах нь сэргэлдөөнт нөхцөл байдлыг зөөлрүүлдэг талтай. Хүүхдийн мөнгө олгох, залуу гэр бүлийг дэмжих зэрэг нь багагүй нөлөөтэй болой. Гэхдээ л хүмүүст загасыг өгөх бус, загас барих аргыг зааж өгөх, улмаар өөрсдөөр нь бариулдаг нөхцөл бололцоог бүрдүүлж өгөх нь хамгийн чухал бодлого билээ.

Ажлын байр бий болгох, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд албан татварын бодлого, зээлийн хүүгийн түвшин чухал нөлөөтэй. 2007 оноос өмнө манай татварын тогтолцоо ихээхэн гажигтай, төрөлх эдийн засгаа боймлоход хүргэж байв. Өөрөөр хэлбэл татвар маань гадаадын худалдаачдад ээлтэй, дотоодын үйлдвэрлэгчдэд халтай байлаа. Нийт эдийн засагт үзүүлэх татварын дарамт 2000 онд 24.9%, 2001 онд 26.0%, 2002 онд 28%, 2003 онд 29.9% болж байсан. Харин одоо нижгээд төрлийн татварын хувь хэмжээ 30 хүртэл хувиар буурч, бүтэц нь сайжирсан нь аж ахуй эрхлэгчдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх, ажлын шинэ байр бий болгох найдлага төрүүлж байна.

Харин банкны зээлийн хүү дорвитой буурахгүй байгаа. Өнөөдөр жижиг дунд бизнес эрхлэгчид олсон ашгийнхаа 41 хувийг зээлийн хүүгийн төлбөрт өгч буй нь үнэхээр хүнд дарамт ². Ийм нөхцөлд шинээр ажлын байр олноор бий болох, улмаар ажилгүйдэл, ядуурал тууштай буурах боломж муутай.

Олон улсын туршлагаас үзэхэд ядуурлаас гарах нэг нөхцөл бол эдийн засгийн өсөлтийг хүн амын өсөлтөөс ядаж хоёр дахин илүү байлгах ёстой юм байна. Гэхдээ энэ нь зөвхөн сайн засаглалтай улс оронд хэрэгжих боломжтой. Сайн засаглалгүй, өөрөөр хэлбэл бүтээж байгаа баялгаа тэгш зөв хуваарилахгүй, баялгийнхаа зарим нэг хэсгийг нь халаасандаа хийдэг дарга нартай бол гурав дахин их байх ёстой гэнэ. Монголын хувьд сайн засаглалтай гэж хэлэхэд хэцүү тул хүн амын өсөлт хоёр хувьтай байхад эдийн засгийн өсөлт гурав дахин илүү буюу 6 %-иас дээш байж ядуурлаа бууруулах хөрс дөнгөж бүрдэж эхлэх юм байна.

Нийгмийн мөргөлдөөнийг сэрэмжлэх зорилгоор олон судлаач, улс төрчид хүн амын хэрвээ ихэнхийг биш гэхэд нэлээд хэсгийг багтаах дунд ангид ихээхэн найдлага тавьдаг. Өрнөдийн стандартаар энэхүү нийтлэг нь жижиг бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчид, мэргэжлийн болон боловсролтой ажилчид, цэцэглэн хөгжиж буй хөдөөгийн хувийн аж ахуйтан, фермерүүд, өндөр цалин, орлоготой албан хаагчид, жүжигчид, дуучид зэрэг хүмүүсийг

¹ Wiatr Jerzy, *Socjologia stosunkow politycznych*, Warszawa. 1977.

² *Ийнхүү бодогдож, аж төрөхөөрөө байдалтай нийцэхээр агаа.*

хамардаг. Тэдний ашиг сонирхол, эрх ашиг зарим талаар нийлдэг бөгөөд орлого, боловсролын түвшин, гэр бүлийн болон үнэт зүйлсийн эрхэмлэл нэг их биш ялгаатай байдаг нь нэгтгэх хүчин зүйл болдог аж.

Дунд анги тогтворжуулагч хүчин зүйлийн хувьд байж болох юм гэсэн барууны томъёоллыг Монгол оронд хэрэглэе гэхэд наанадаж эргэлзээтэй бөгөөд тэгэж үзэх цаг нь болоогүй байна. Дунд ангийн томоохон төлөөлөл байж болох багш, эмч, хуульч, конторын албан хаагч зэрэг “саарал захтнууд”-ын ихэнх нь төрийн албанд ажилладаг. Гэтэл эдгээр мэргэжилтнүүдийн амьдралын түвшин, авч байгаа цалин хөлс нөгөөх ядуу хэсгээсээ овойж товойтол илүү гарчихсан юм алга. Тэд үндсэндээ цалингаас цалингийн хооронд амь зууж байна. Түүнчлэн жижиг бизнес эрхлэгчид, багавтар дэлгүүр мухлаг, гуанз, үйлчилгээний газар ажиллуулагсдын орлого зарлагын харьцаа олигтой ялгарч өгөхгүй, өсөлт хөгжил, төлөвшил тогтворжилт нь удаашралтай байгаа нь энэ ангид тавих найдлагыг бууруулж буй.

Нийгмийн тэгш байдал, шударга ёс

Монгол дахь нийгэм - улс төрийн мөргөлдөөний асуудалтай холбогдуулан бидний сонирхох ёстой нэг сэдэв бол нийгмийн тэгш байдал (үнэндээ тэгш бус байдал) болон шударга ёсны асуудал юм.

Тэгш бус байдал бол хүний нийгмийн байнгын дагуул. Хүмүүний нийгэмд тэгш бус байдлын маш олон янзын хэлбэр, төрөл зүйл байх агаад тэдгээрийн дотроос бид бодгалын байгалиас заяагдмал тэгш бус боломж болон хүмүүсийн нийгмийн статустай холбоотой тэгш бус байдлыг онцлон авч үзэж болно. *Хүн болгон адилгүй, хүлэг болгон жороогүй* гэдэг. Үүнтэй адилаар бодгаль бүр дүр төрх, зан араншин, авьяас чадвар, хүч чадал зэргээрээ өөр хоорондоо ялгаатай байдаг. Үүнийг товчхондоо бодгалын заяагдмал буюу байгалын тэгш бус байдал гэж хэлнэ.

Түүнчлэн хүмүүс эд хөрөнгө, эрх мэдэл, статус зэргээрээ ялгагддаг. Ийм ялгаа нь нийгмийн тэгш бус байдлын илрэл хэмээн ойлгогдох нь бий.

Дээр дурьдсан хоёр төрлийн тэгш бус байдал нь хоёулаа мөргөлдөөний шалтгаан болно. Гэвч нийгмийн тэгш бус байдал нь өргөн хүрээтэй мөргөлдөөний голомтыг илүү ихээр агуулдаг юм. Учир нь ихэнх хүмүүс байгалиас заяагдмал байдлыг ерөнхийдөө хэвийн зүйл мэтээр хүлээн авдаг билээ. Жаахан зөөлрүүлж хэлбэл *шударга тэгш бус байдлыг* ойлгож зөвшөөрдөг юм. Харин *“шударга биш тэгш бус байдал”*-д хүмүүс эсрэгээр ханддаг. Бид *шударга биш тэгш бус байдлыг* юуны өмнө нийгмийн тэгш бус байдалтай холбож ойлгож байна. Гэхдээ энд анхаарвал зохих асуудал байгаа. Юу гэвэл, хүмүүс хөдөлмөр, хичээл зүтгэлээрээ бусдаасаа илүү их эд хөрөнгө, алдар хүндтэй болохыг шударга явдал хэмээн голдуу үздэг бөгөөд ингэж “шударгаар” бий болсон тэгш бус байдлыг мөн л хүлээн зөвшөөрдөг юм. Ер нь шударгаар бий болсон тэгш бус байдал нь хөгжлийн хөдөлгөгч хүч болой. *Тэгш бус байдал бол муу муухай бүхний баялаг эх сурвалж төдийгүй мөн бас сайн сайхан болгоны үндэс мөн* гэж Иммануэл Кант онцлон тэмдэглэжээ.

Нийгмийн тэгш бус байдлыг нийгэм - улс төрийн мөргөлдөөнд хамааруулж үзвэл бие хүмүүс ба нийгмийн бүлэгт хөгжлийн эх сурвалж болсон нөөц баялгууд тэнцүү биш ноогдож байна гэсэн үг. Тийм учраас мөргөлдөөний мөн чанарын тодорхойлолтод нийгмийн зорилгоо хэрэгжүүлэх хэрэгсэл болсон нөөц баялгийн асуудал багтана.

Хүмүүсийн ахуй амьдралын байдал, түүнээс үүдэн гарах нийгмийн хангалтын түвшин нь зөн билгээр бус, харин бусад хүмүүстэй харьцуулснаар

тодорхойлогдоно. Зарим хүмүүст амьдралын тааламжтай түвшин мэт санагдаж байгаа нь нөгөө хэсэг хүмүүст үгүйрэл хоосролын түвшин мэт санагдаж болно. Хэрэгцээ өөрөө чухал биш харин түүнийг хангах хэрэгсэл, түүнтэй уялдсан нийгмийн байгууллагаас бүрдүүлж өгдөг тодорхой үйл ажиллагаанд хүрэх явдал чухал юм. Чухам энэ холбоон дээр зөвхөн баялаг эзэмшсэн түвшнээрээ тэгш ба тэгш бус байдлын тухай төдийгүй нийгмийн янз бүрийн бүлгийн амьдралын боломжийг харьцуулах тухай асуудал босч ирж байгаа юм. Бидний амьдарч байсан социалист нийгмийн туршлагаас үзэхэд бүх нийтийн тэгш байдал руу тэмүүлэх нь өөрөө баялаг болж чадахгүй, энэ нь бүтээлч үйл ажиллагаа, санаачлагын урмыг унтрааж, адил тэгш идэвхгүй, унтаа байдалд хүргэмүй. *Бүх нийгэм тэгш хөдөлмөрлөдөг, тэгш цалин авдаг нэгдмэл нэг байгууллага, нэгдмэл нэг үйлдвэр болж хувирна* гэсэн Ленин багшийн сургаалийн үр дагаврыг бид тодорхой хэмжээгээр амсаж мэдсэн билээ. Ерөөс хүмүүсийн хөдөлмөрийн үр дүнг тэгшитгэх нь өөрөө шударга бус явдал болой.

Ральф Дарендорф (*Ralf Dahrendorf*) нийгмийн тэгш байдал гэдгийг иргэний тэгш байдал, статусын тэгш байдал гэж хоёр ангилсан. Иргэний тэгш байдал бол хуулийн өмнө тэгш байх, улс төрийн тэгш эрхтэй байх төдийгүй сурч боловсрох, орлого олох, нийгмийн халамжаас хүртэх тодорхой хэмжээний тэгш боломжтой байхыг хэлнэ. Ийм төрлийн тэгш байдал нь юуны өмнө нийгмийн амьдралд оролцох бие хүний оролцооны мөн чанарыг хөндөнө.

Харин статусын тэгш байдал нь бие хүний нийгэм дэх оршино тогтнолын арга хэлбэрийг хөндөнө. Үүнийг өргөн утгаар авч үзвэл бие хүний орлого, нэр хүнд олох, сурч боловсрох тэгш боломж юм. Эндээс харахад, дээрх хоёр төрлийн тэгш байдал нь харилцан нөхцөлдсөн (ууссан), статусын тэгш байдлын тодорхой “хүрээ” нь иргэний жинхэнэ тэгш байдлыг бий болгоход зайлшгүй зүйл аж. Тэрхүү “хүрээ” аль болох их байх ёстой гэж Дарендорф үзсэн байна ¹.

Тэгэхлээр нийгмийн *шударга биш тэгш бус байдал* гэж чухам юуг хэлэх вэ. Үүнийг юуны өмнө *хүсэж буй үр дүнд хүрэх тэгш бололцооны зарчим алдагдах, хуулийн өмнө хүн бүр тэгш байх эрх зүйн хэм хэмжээ зөрчигдөх* зэрэгтэй холбож ойлгох болов уу. Чухамхүү эдгээр шалтгаанууд монголын нийгэмд мөргөлдөөн үүсгэх томоохон голомт болж байна.

А. Тэгш бололцооны зарчим алдагдах

Өнөө цагт хүмүүс өөрийнхөө янз бүрийн чадварыг хангах ижил нөхцөлтэй (тэгш бололцооны) нийгмийг шударга гэж тооцох болжээ. Түүнчлэн хүн бүрийн үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээнд тэгшитгэсэн бус, харин бодит хандлага (“шударга тэгш бус байдал”) - аар хандахыг мөн л шударга хэмээн үзэхүй. *Тэгш бололцооны зарчмыг* хүлээн зөвшөөрөх нь монголчуудын үзэл суртлын нэгэн өвөрмөц итгэл үнэмшил болох төлөвтэй байна. Иймээс ч тэд энэхүү чухал зарчмыг хамгаалж мөргөлдөөн үүсгэх нь ихэслээ.

Манайд ялангуяа бизнесийн болон боловсролын салбарт тэгш бололцооны зарчим алдагдах нь их байна. Нэг хэсэг нь эрх мэдэлд дулдуйдаж бизнес хийж байна, нөгөө хэсэг нь бор зүрхээрээ бизнесээ явуулж байна. “Эрх мэдэлд дулдуйдсан” албан тушаалтан - бизнесмэн болон дулдуйдаагүй “бор зүрхтэй” бизнесмэн хоёрын уг үйл ажиллагаандаа

¹ Dahrendorf. R., *Essays in the Theory of Society*, London. 1970, x. 152.

зарцуулж буй хүч хөдөлмөр, олж буй ашиг орлого газар тэнгэр шиг ялгаатай байна. Эрх мэдэлгүй бизнесмэн ихээхэн хөдөлмөр зарцуулж байж багахан орлого олж байхад албан тушаалтан - бизнесмэн төрийн эрх мэдэл, холбоо сүлбээгээ ашиглан багаахан хүч зарж ихээхэн орлого олж байна.

Албан тушаалтан - бизнесч төрөөс өөрт нь итгэж өгсөн эрх мэдлийг ашиглан хөрөнгө мөнгө олох замаар өөртөө илүү их эрх чөлөө, дархан эрхийг бий болгож байна. Энэхүү эрх, эрх чөлөө бол бусдын эрх, эрх чөлөөг хууль бусаар хязгаарлаж бий болсон зүйл. Тодруулж хэлбэл бусдын эрх чөлөөг дээрэмдсэн гэсэн үг. Төрийн төлөөлөгч, эрх мэдэлтэн маань ёстой нөгөө Хаекийн хэлсэнчлэн хүмүүст бурхнаас заяагдмал эрх чөлөөг нь булааж аваад өөрөөсөө “бэлэглэдэг” аж. Тэрхүү бэлгийг өгсөн “буянтай” гараа олон түмэн, хэвлэл мэдээллийнхэнд байнга харуулахыг оролдох бөгөөд харин иргэдийн эрх чөлөөг хумсалсан “бохир” гараа харуулахгүйг хичээнэ.

Ногоон гэрлийн аж ахуйн нэгж бий болох, хахууль өгөөгүй бизнесмэний компаний өмнө улаан гэрэл асч байдаг, хэрвээ ногоон гэрлээр гарахыг хүсвэл мөнгө төлөх хэрэгтэй болно. Бизнесменүүд татварт төлсөн мөнгөнийхөө 15 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг авилгалд зориулдаг нь судалгаагаар тогтоогдсон. Гааль, татварын албадын “тогтоосон” авилгын тариф аж ахуй эрхлэгчдийн дунд тэгш бололцооны зарчим алдагдах гол хүчин зүйл болж байна.

Иймд эрх мэдлийг хуулиар нарийн чанд тогтоох, аль болохоор хязгаарлах шаардлагатай. Уг нь зах зээлийн тогтолцоо нь хэн нэгний хүсэл тэмүүллийг бусад хиймэл тулгах, тэдний сонголтыг хичээр хязгаарлах эрх мэдлийг хазаарладаг, түүнтэй үл зохицдог мөн чанартай билээ. Тодруулж хэлбэл, зах зээлийн тогтолцоонд зөвхөн эрх зүйт төр л тохирно. Эрх зүйт төр л өөрийн эрх мэдлээ хязгаарлах механизмыг бий болгох чадвартай.

Сүүлийн үед манай улс төрийн хүрээнийхэн нийгмийн тэгш бус байдлыг арилгана, нийгэмд тэгш байдал тогтооно гэх мэт зүйл их ярих болжээ. Харамсалтай нь тэд энэ гоё үгээ ард иргэдийн мөнгөн орлоготой холбогдуулж юм уу түүн рүү гол анхаарлаа хандуулж хэлнэ. Харин тэгш бус байдлын хамгийн шударга биш төрөл болох **тэгш бололцооны зарчим алдагдах, хуулийн өмнө хүн бүр тэгш байх эрхийн хэм хэмжээ зөрчигдөх** талаар дуу гарах нь бага байна.

Хүн бүр адилхан орлоготой байна, хүн бүрийг нэг ижил орлоготой болгоно гэдэг санаа бол үл биелэх зүйл. Ердөө л гэнэн улс төрч юм уу, хувьсгалчийн мөрөөдөл. Аль эсвэл гэнэхэн иргэдийн санал авах гэсэн зальжин улс төрчийн үг.

Эд баялаг, орлогыг хүн бүрт хөдөлмөр хийсэн, хийгээгүй ялгаагүй тэгш хуваарилвал хөдөлмөрийн бүтээмж буурна, хүн гээч амьтан ажил хийхээ болино. Бид ийм балай юм ярьж хийж байгаад социализм, коммунизмаа булшилсан шүү дээ. Хүмүүсийн “нийгмийн ялгаа, баялаг болон орлогын зөрлөг илрээд арилгах”, “нийгмийн хөгжлийн хөдөлгүүрийг унтраах, эдийн засгийн холбоос тулгууруудыг салгах оролдлого” хийдгийнх нь төлөө тэдгээр улс төрчдийг онцгой аюул заналтай этгээдүүд гэж ихэвчлэн учиртай, тэдний хийж буй ийл ажиллагаа гагцхүү “эрх мэдлийн хэт төвлөрөлд л хиргэнэ”.

Харин засгийн газар аливаа нэг шийдвэр гаргахдаа тухайн шийдвэрт хамаарч буй бүх хүний сайн сайхан байдал, ашиг сонирхлыг адил хэмжээгээр харгалзах ёстой гэсэн зарчмыг аль болохоор баримтлах учиртай. Тэгэж баймааж нь нийгмийн тэгш бус байдлыг хязгаарлах болно.

Нийгэм хийгээд улс төрийн бодлого чөлөөт эдийн засгийн системд шилжиж эхлэнгүүт, мөн ардчилсан институт батжиж эхлэнгүүт л зах зээлийн тогтолцооны урамшуулж өгдөг нөөц баялагт хүрэх тэгш бололцооны зарчимт

байдал үүсч, улмаар иргэдийн улс төрийн нэн тодорхой тэгш байдлыг төрүүлэх суурь өөрчлөлтүүд хэрэгжиж эхэлдэг ажгуу.

Б. Хууль шүүхийн өмнө хүн бүр тэгш эрхтэй байх зарчим зөрчигдөх

Судалгаанд оролцогчдын 73, 5 хувь нь хууль шүүхийн өмнө хүмүүс тэгш байж чаддаггүй хэмээн хариулсан байна ¹. Өөрөөр хэлбэл, манай хууль хүн бүрт алагчлахгүй үйлчилдэггүй, дарга мяндагтанд нэг өөр, жирийн иргэнд бас нэг өөрөөр үйлчилдэг байна. Энэ нь нөгөөх л эрх мэдэл, авилгал, хээл хахууль, арын хаалгатай холбоотой аж.

Янз бүрийн байгууллагаас өөр өөр хугацаанд явуулсан судалгаагаар хуулийг хүн бүрт жигд, ялгаваргүй үйлчлүүлэх үүрэгтэй цагдаа, прокурор, шүүхийн байгууллагууд авилгалд өртөж буй үзүүлэлтээрээ тогтмол эхний байрыг эзэлж буй нь яах аргагүй анхаарал татна. Эдгээр байгууллагуудын ажилтнуудтай холбогдолтой албан тушаалаа урвуулан ашигласан хэрэг маргаан нь судалгааны дүнг улам бүр нотолгоотой болгож байна.

Төрийн байгууллагуудад авилгал ямар түвшинд байна вэ гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 54,5 - 65,7 хувь нь прокурор, цагдаа, шүүхийг нэрлэжээ. Мөн авилгал хамгийн их авдаг байгууллагад бизнесийн хүрээнийхний дүгнэлтээр хоёрдугаарт шүүх (41,6 %), дөрөвдүгээрт нь цагдаа (30,7 %) орсон байв ². “Цагдаагийнхан хэргийн бүрдэл, нотлох баримт, гэрчийн болон сэжигтний мэдлэг боловсрол, сэтгэл зүй дээр, харин шүүхийнхэн нэг зүйл анги дахь ялын хувилбар, хорих ялын хугацааны дээд доод хязгаар дээр тоглох нь нийтлэг ба эдгээр хүчин зүйлс нь авилгал үүсэх уут болж байна” ³.

Хуулийн байгууллагууд авилгалд өртсөнөөр иргэдийн халдашгүй байх, хууль шүүхийн өмнө тэгш байх, шударга шүүхээр шүүлгэх, хохирлоо нөхөн төлүүлэх эрхүүд ямар ч баталгаа, хамгаалалтгүй болж, зөвхөн хөрөнгө мөнгөөр, танил талаар аливаа асуудлыг шийдвэрлэхэд хүрч байна. Мөнгө санхүү, улс төрийн нөлөөллөөс хараат бус, бие даасан, нийгмийн хүндэтгэл хүлээсэн, шударга шүүх засаглалыг тогтоох (ардчилсан арга замаар бүрдүүлэх), шүүх эрх мэдлийг зохих ёсоор хэрэгжүүлэх цаг болжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 1-р зүйлийн хоёрт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж зааснаараа төрөөс улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын аль ч асуудлаар бодлого боловсруулах, хууль тогтоох, гүйцэтгэх, хэрэгжүүлэх зэрэг бүхий л шатандаа эрх зүйн тэгш байдал, шударга ёсны зарчмуудыг чандлан мөрдөх үүрэг, хариуцлагатай болохыг баталгаажуулан хуульчилсан билээ.

Гэтэл улс төрийн тогтолцоог иж бүрнээр бүрдүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлж байгаа сонгуулийн мажоритар системийн дутагдалтай талууд нь УИХ-ыг сонгох, Засгийн газрыг бүрдүүлэх явцад тэгш байдал, шударга ёсны зарчимд үл нийцсэн үйлдэл хийх боломж бүрдүүлдэг, сонгогчдын сонгох эрх, эрх чөлөөг зөрчдөг, улмаар иргэдийн тэгш эрхийг зөрчсөн хууль, бодлого шийдвэрийг гаргадаг, шийдвэр гаргагч, хууль боловсруулагч цөөнхийг үл хүндэлдэг, ардчилсан институцийн үйл ажиллагаанд олонхийн дарангуйллыг тогтоодог, иргэний нийгмийн зарчимд үл нийцсэн олон бусармаг алхмуудыг

¹ Огцлүүлалт. А. Өгөөжөөдөөй цааеи ауйо буюдааеи “Н”-ёо, буюуаеуёоёеи іеёаіеіі нооооі оц-еі цсёеі, нїөіеііаеіі үоуё, оаёаооё, Оеіу Оіеи, ' 57, 00АА. 2006. 6. 70.

² Оіеіеё үооёеі сіауїіеё өїөїїїі өёоауё, 2003 н.

³ Огцлүүлалт. А. Өгөөжөөдөөй цааеи ауйо буюдааеи “Н”-ёо, буюуаеуёоёеи іеёаіеіі нооооі оц-еі цсёеі, нїөіеііаеіі үоуё, оаёаооё, Оеіу Оіеи, ' 57, 00АА. 2006. 6. 69.

хийдэг, тухайлбал ил тод бус, хариуцлагагүй, иргэдийн санал хүсэлтийг хариулах чадваргүй, аливаа асуудлыг хамтран шийдэх чиг хандлага, тэгш байдлын зарчмыг үйл ажиллагаандаа баримталдаггүй тийм улс төрийн тогтолцоог бий болгоход нөлөөлж байна.

Энэ нь иргэдийн болон улс орны аюулгүй байдал, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдралд амин чухал байр суурь эзлэх асуудлуудад гоомой хандан улс төрийн нэг нам, эдийн засгийн жижиг бүлгүүдийн явцуу сонирхолд нийцсэн шийдвэр гаргах, улмаар хээл хахууль, авилгалд ергөн хүрээнд автагдах үндсэн нөхцлүүдийг бүрдүүлж байгаагаараа онцлогтой. Ийм тогтолцоотой төр нэг талдаа шударга бус явдалтай тэмцэхийн төлөө байгаа юм шиг харагдаж байгаа боловч, нөгөө талдаа шударга бус байдал, авилгалыг дэмжих улс төр, эдийн засаг, нийгмийн суурийг нь хууль, эрх зүйн хүрээнд бүрдүүлж, ингэснээрээ олон нийт, иргэдийг төсөөгдүүлэх, шударга ёс, тэгш байдал, ардчилалд итгэх тэдний итгэлийг алдуулах хор уршигтай байна.

Одоогийн улс төрийн тогтолцооны шинж байдлыг авч үзэхэд хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын эрх мэдлүүд холилдсон буюу хууль тогтоох, тогтоосон хуулиа өөрсдөө хэрэгжүүлэх, өөрсдөө хянах гэх мэтээр хэмжээгүй эрх мэдлийг хууль тогтоогчид өөрсдөдөө бүрдүүлсэн байна. Үүний нэг жишээ бол хууль тогтоогчдын “хүсэлд нийцсэнээр” Засгийн газар нь УИХ-ын гишүүн бүрт “хуулийн хүрээнд” эхлээд 10 сая, дараа нь 100 сая төгрөгийг олгосон явдал юм. 2007 онд энэ мөнгийг улам ихэсгэн тойрог бүрт “тойруу замаар” 250 саяыг зарцуулах асуудал Үндсэн хуулийн цэц хүртэл яригдаж байна.

Бидний дээр өгүүлсэн “шударга биш тэгш бус байдал” нь шударга ёс хэмээх ойлголттой нягт холбоотой болой. Шударга ёс гэдэг бол аливаа нийгмийн нэн чухал үндэс суурь бөгөөд нийгэм нь шударга ёсны хуулийг зохистой дагаж мөрдөхгүйгээр оршин тогтноход тун бэрхтэй. Карл Поппер (*Karl Popper*) шударга ёсыг хүмүүнлэгийн үүднээс “... (а) иргэний ачаа үүргийг тэгш хуваарилах, өөрөөр хэлбэл, нийгмийн амьдралд зайлшгүй шаардлагатай эрх чөлөөний хязгаарлалтыг тэгш байлгах; (b) иргэн бүр хуулийн өмнө эрх тэгш байх; чингэхдээ, (c) хууль нь хувь иргэн, бүлэг этгээд, ангийн эрх ашгийн төлөө буюу эсрэг тухайлан чиглээгүй байх; (d) шүүх тал хардаггүй шударга байх; (e) төрөөс тухайн нийгмийн гишүүнийнх нь хувьд иргэддээ олгох давуу талыг (зөвхөн ачаа үүргийг бус) тэгш хуваарилах” гэж тодорхойлсон байдаг ¹. Хэрвээ шударга ёсны эдгээр зарчмууд нийгмийн харилцаанд үл мөрдөгдвөл дургүйцэлд, цаашлаад мөргөлдөөнд хүргэсээр байх болно.

Монголын нийгэм - улс төрийн мөргөлдөөнийг тоталитар, ардчилсан дэглэмүүдийн мөргөлдөөний ялгааны талаас авч үзвэл “завсрын” байдалд байна. Манай өнөөгийн нийгэм нь тоталитаризмаас ардчилалд хүрэх шилжилтийн хэв маягийн бүх шинжийг агуулахуй. Өөрөөр хэлбэл, иргэний нийгмийн сул дорой төлөвшил, ингэхлээр ардчилсан институтуудын “түшиг тулгуургүй байдал”, тэрчлэн улс төрийн “дээдчүүд”-ээс хууль номыг гажуудуулах, хуйвалдан завших, дур зоргоороо аашлах тоталитар уламжлалын үлдэгдэл нөлөө, тэрхүү эрхмүүдтэй улс төрийн хариуцлага тооцдоггүй явдал, тэд ч хариуцлагаас яаж ийгээд бултаж дөнгөдөг байдал, нийгэм дэх үнэт зүйлсийн задрал гэх мэт шинжүүд байсаар байна. Түүнчлэн нийгэм - улс төрийн мөргөлдөөний эмх замбараагүй, тогтворгүй байдал,

¹ *Имлоо Ёаоё, Iyyeoooye ieeäyi, oociee ääeñioä. I äioü, OÄ. 2006. ö. 93.*

зохицуулах, шийдвэрлэх процедурын боловсронгуй биш байдал ч үүнтэй холбоотой.

Ном зүй

Гидденс. А., *Социологи*, УБ. 2006

Гүндсамбуу. Х., *Нийслэлийн ажил эрхлэгчдийн нийгмийн хөрөг*, Шинэ Толь, 1 57, УТБА. 2006.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хөвсгөл аймагт хэлсэн үгээс, 2007 оны 3 дугаар сар.

Поппер Карл, *Нээлттэй нийгэм, түүний дайснууд*. I боть, УБ. 2006.

Сорокин П. А., *Человек-цивилизация-общество*, Москва, 1992.

Түмэннаст. Г., *Шилжилтийн үеийн гэмт хэргийн өсөлт, цэцэглэлтийн нийгмийн суурь хүчин зүйлс, социологийн эрэл, хайгуул*, Шинэ Толь, 1 57, УТБА. 2006.

Хавх. Н., *Монголчуудын нүүдлийн соёл иргэншлийн гүн ухаан*, УБ. 2005.

Хүний эрхийн үндэсний комиссын илтгэл, 2003 он.

Чимиддулам. Д. нар, *Ядуурал ба өрхийн хүнсний хангамж баталгаа*, Социологи - 7, МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг 1 265 (35), 2006.

Чимиддулам. Д. нар, *Ibidem*, Социологи - 7, МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг 1 265 (35), 2006.

Boulding K.E., *Conflict and Defence. A General Theory*. New York, 1962.

Dahrendorf. R., *Essays in the Theory of Society*, London. 1970

Wiatr Jerzy, *Socjologia stosunkow politycznych*, Warszawa. 1977.

ПОЛИТОЛОГИ III
Эрдэм шинжилгээний бичиг¹ ... (...): 165-171 дэх тал

ЭМЭГТЭЙ УЛС ТӨРЧИЙН ИМИЖ БҮРДҮҮЛЭЛТ

Д.Оюунчимэг
докторант, ахлах багш
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Улс төрд эмэгтэй хүн орж байгаа нь өвөрмөц үйл явдал бус харин тэдний орох гэж байгаа улс төрийн үйл явц нь эмэгтэй хүний байгалаас заяасан өрөвч нигүүлсэнгүй сэтгэлээс маш өөр ертөнц юм. Улс төр - хүн төрөлхтөний аль ч үед эрчүүдийн хатуу ширүүн тэмцлийн талбар байсаар ирсэн. Улс төрд орохоор шийдсэн эмэгтэй хүн бүр уг хуулийг маш сайн ойлгох ёстой болдог. Өөрийн олон талын мэдлэг, ажил албаны дадлага туршлагадаа найдан улс төрд орж, амжилт олно хэмээн өөрийгөө дахин дахин боловсруулж суугаа эмэгтэйчүүдэд, “Амжилт, алдар хүндийг залбирч эсвэл хөлсөө асгаруулж олж авдаг биш харин зохион бүтээдэг” /1/ тэр зарчим бодитойгоор тулгарч ирдэг. Гэтэл эмэгтэй улс төрчдийн олонхийн гаргадаг хамгийн том алдаа бол юм мэддэггүй ч юмуу, чадваргүйдээ биш, харин “юу ч хийдэггүйд” л байдаг байна. Эмэгтэйчүүд улс төрч болохын тулд, бусдаас ялгарахын тулд, давуу болохоо харуулахын тулд, улс төрийн намынхаа дотор нэр нөлөөтэй болохын тулд, олон түмэнд танигдахын тулд, сонгогчид саналаа өгдөг болохын тулд чухам юу юу хийж байна вэ? ямар арга технологийг ашиглан үүнийгээ хэрэгжүүлж ямар үр дүнд хүрэв? гэдэг эрэгтэй улс төрчидтэй харьцуулахад эрс өөр байсаар байна.

Имижмейкерийн зүгээс эмэгтэй улс төрчийн имижийг бүрдүүлэхдээ улс төрч хүн ямар байх ёстой наад захын шалгуурууд дээр суурилж ажлаа эхлэх шаардлагатай болдог. Эмэгтэй хүн улс төрч болохын тулд бүхнийг мэдэгч, чадагч байх албагүй. Гагцхүү юуг хийхгүй байх, юуг хийх ёстойг ойлгож мэдэрдэг, цаашилбал өнөөгийн шинжлэх ухааны ололт амжилтыг хэрэглэж чаддаг, улс төрд зүтгэх, хийж бүтээх үнэнхүү хүсэл эрмэлзэлтэй байх шаардлагатай. Улс төрчийг амьдарсан хугацаа, албан тушаалаар нь тодорхойлдоггүй, харин авьяас чадвар, ажлын туршлагатай нь холбон үздэг. Хэн ч улс төрч болж төрдөггүй, харин улс төрч болж шалгарч гарч ирдэг. Улс төрч хүн бусдын төлөө хариуцлага хүлээж чаддаг байх ёстой. Тэрээр өөрөө ажиллаж, бусдыг ажиллуулж, хүмүүсийн харилцааг зохицуулж, тэднийг ололт амжилтын дээд түвшинд хүргэж чаддагт мөн чанар нь оршино. Улс төрч бие хүний онцлог нь түүний үйл байдал, зан байдлыг нөхцөлдүүлэгч сэдлүүд болон хэрэгцээ шаардлагууд, голлох итгэл үнэмшлийн тогтолцоо, өөрийнхөө талаархи бодол үнэлгээ, шийдвэр гаргах хэв маяг, бие хүн хоорондын харилцааны хэв маяг, сэтгэл түгшилтийг даах чадвар, даван туулах арга механизм зэрэг шинжүүдээр /2/ нийгмийн бусад бүлгийн төлөөлөгчдөөс ялгарч байдаг байна. Улс төрч хүнийг тодорхойлдог өөр нэг үзүүлэлт бол бол түүний соёлын түвшин. Энэ нь ерөнхий соёл, мэргэжлийн соёл, дипломат харилцааны туршлагаар тодорхойлогдоно. Улс төрийн амьдралын онцлогоос шалтгаалаад улс төрчийн эзэмшвэл зохих чадварын нэг бол “Ялан дийлэх чадвар” юм. Авьяас чадвараа бүрэн дүүрэн ашиглаж, хийж бүтээхийн тулд улс төрч хүн хувийн зохион байгуулалт сайтай, аливаа асуудалд ул суурьтай ханддаг, байх шаардлагатай. Жирийн хүн амьдралын өдөр тутмын асуудалтай зууралдаж байдаг бол улс төрч хүний сонирхдог зүйл өөр. Ялан дийлэх чадварыг их сургууль, академид сурч эзэмшдэггүй, харин ажил, амьдралын сургуулиар, туршлагаар олж авна.

Сэтгэл зүйч Антонио Менегетти “улс төрч бүтээлч удирдагч байхын тулд нэн тэргүүнд хүний өөрийн орчин, гэр бүлийн орчин, мэргэжлийн буюу хамтран ажиллагсдын орчин, нийгмийн орчин гэсэн дөрвөн орчинд үйл ажиллагаагаа зохицуулах шаардлагатай болдгийг тэмдэглэсэн байдаг. /3/ Улс төрч хүн эдгээр орчнуудад өөр өөр дүрд тоглодог бөгөөд тэдгээр нь хоорондоо эрс зөрчилдвөл түүний имиж хүнд байдалд ордог.

Төлөөллийн ардчиллын механизмаар дамжуулан төр засгийн үйл ажиллагаанд оролцох, ашиг сонирхлоо илэрхийлэх зэрэг олон түмний

харилцааны улс төрийн хүрээн дэх үйлдлүүд нь тодорхой “бие” хүнээр илэрдэг. Энэхүү харилцаа нь субъектив болон объектив хүчин зүйлийн харилцан үйлчлэлийн үр дүнд үүснэ. Иймд улс төрийн засаглалд өөрийн байр сууриа бататган бэхжүүлэх гэсэн субъект тодорхой арга хэрэгслийн тусламжтайгаар объектоо хянах шаардлагатай байдаг төдийгүй өөрөө бас объектоо хянуулах болдог. Тэрхүү улс төрийн субъект объектоо хянаж байх арга хэрэгслийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь тухайн субьектийн имиж юм. Имиж бол урт удаан хугацааны туршид бүрэлдэж, өсөж, унаж, сарниж, бүдгэрч, тодорч байдаг үйл явц юм. Имиж нь гадаад шинж байдлаас илүүтэйгээр дотоод шинж байдал, мөн чанарыг илэрхийлсэн ухагдахуун. “Имиж хувь хүн юмуу байгууллагын мөн чанарыг төвлөрсөн хэлбэрээр илэрхийлдэг бөгөөд зарим тохиолдолд чухамхүү имиж л объектын тухай үндсэн мэдээлэл болох нь ч бий. Энэ нь улс төрд илүү их тохиолддог”/4/. / - ийг судлаачид тэмдэглэдэг. Имиж өнөөгийн нийгмийн бүх хүрээнд оршин үйлчилж байдаг зүйл бөгөөд ямар имижтэй байгаагаас тэдгээр субьектуудын ажил үйлс, амжилт ихээхэн шалтгаалж байдаг. Хамгийн гол нь имижийг амжилттай, зөв бүрдүүлнэ гэдэг хэцүү зорилт байдаг бол харин нэгэнт бүрдсэн имижийг үгүй болгох нь маш амархан бөгөөд хэдхэн хормын асуудлаар ч шийдэгдэж болох эмзэг зүйл юм.

Улс төрчийн имиж нь олон түмэнд тааламжтай эерэг харилцааг бий болгоход голлон чиглэгддэг. Өнөөгийн олонхи сонгогч сонгуульд саналаа өгөхдөө нэр дэвшигч аль нам, бүлгийг төлөөлж буй төдийгүй түүний хувийн шинж чанар, харизмыг мөн харгалзаж байна. Улс төрчийн имиж гэдэгт түүний талаархи сонгогчдын таньж мэдсэн бүх зүйлийг багтаан ойлгож болох бөгөөд үүнд, тухайн зүтгэлтний дүр төрх, бусдад ойлгогдсон төсөөлөл, нэр хүнд, бусдаас өгсөн үнэлгээ зэрэг багтана. Сонгогч улс төрчдийг яг байгаагаар нь бүрэн таньж мэдсэн учраас бус, харин өөрийн ойлголт, төсөөлөл, үнэлгээгээ үндэслэн түүний “имиж”-д саналаа өгдөг гэсэн үг юм. Аливаа хүн өөрт таалагдсан хүнтэй хамтран ажиллах, түүнийг дэмжин, сонгохыг хүсч байдаг. Иймээс улс төрийн зүтгэлтнүүд, улс төрийн намууд олон нийттэй харилцаа холбоо тогтоож тэдний санаа бодолд эерэгээр нөлөөлөхийг эрмэлздэг. Үүний тулд улс төрийн зүтгэлтнүүд, сонгуульд нэр дэвшигчид, улс төрийн намууд өөрсдийн имижийг зөв бүрдүүлэхэд онцгой анхаардаг. Сонгуульд өрсөлдөж буй нэр дэвшигч болон улс төрийн намд ялалт байгуулахад төдийгүй улс төрийн аливаа үйл ажиллагааг амжилттай явуулахад имиж маш чухал үүрэг гүйцэтгэж байна.

Судлаачид, “имиж “ хоёр үндсэн хандлагаар бүрэлдэн бий болж байна гэж үзэж байна. Үүнд жам ёсны үүсэл нь шашин шүтлэг, ёс заншил зэрэг янз бүрийн хүчин зүйлстэй холбогдон үүсдэг бол харин зохиомлоор үүсгэх буюу имиж бүрдүүлэх нь мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар, шинжлэх ухааны үндэстэйгээр явагдна.

Хүмүүс “таныг хэн хамгийн сайн мэдэх вэ?” гэсэн асуултанд ихэвчлэн “би өөрийгөө сайн мэднэ” гэж хариулдаг. Гэхдээ хэн ч сэтгэл зүйч, үсчин, хуулийн зөвлөх гэх мэт хүмүүст хандахдаа би өөрөө өөрийгөө илүү мэднэ гэсэн сэтгэлгээгээр ханддаггүй. Учир нь эд бүгд мэргэжлийн хүмүүс учраас өөрийг нь өөрчлөхөд өөрөөс нь илүү тус нэмэртэй гэж үздэг учраас тэдэнд ханддаг. Үүний адил өөрөө өөртөө имижмейкер байх нь төдийлөн амжилтанд хүрэхгүй, гагцхүү мэргэшсэн имижмейкер л имижийг зөв бүрдүүлэх арга, хэрэгслийг ялган тодорхойлж, нарийн технологийн дагуу явуулж байж л үр дүнд хүрэх болно.

Улс төрийн хүрээн дэх имижмейкер бол шууд утгаараа улс төрийн тодорхой субьектэд имиж бүрдүүлэхийн тулд чиглэсэн зорилготой үйл

ажиллагаа явуулдаг мэргэжлийн улс төр судлаач. Тэрээр тодорхой субъектын имижийг зориуд зохион байгуулалтайгаар засварлан өөрчилж, ялгаруулан таниулж, түүнийг өсгөн тодотгож “хайрцаглаж” өгдөг мэргэжлийн уран бүтээлч. Өргөн утгаар авч үзвэл мэргэшсэн имижмейкерийн зэрэгцээгээр уг субъектын багийн гишүүд, хамтран ажиллагсад, гэр бүл, найз нөхөд нь болон нэр нөлөө бүхий хүмүүс ямар нэг хэмжээгээр имижмейкерийн үүрэг гүйцэтгэж байдаг. Имижмейкерүүд имиж бүрдүүлэх шаардлагатай хүмүүстэй ажиллахдаа тэднийг хэд хэдэн бүлэгт хуваан авч үзэж ажиллана. Тухайлбал :

- Дэлхий нийтийн хэмжээнд болон улс орны хэмжээнд, олон нийтэд алдартай хүмүүс. Тэдэнд имиж бүрдүүлэх эсэх талаар нилээд хүмүүс эргэлздэг. Нэгэнт тэд олон нийтэд нэр хүндтэй, өндөр имижтэй байдаг учраас тэдэнд имиж бүрдүүлэх шаардлагагүй гэж зарим хүмүүс үздэг. Гэхдээ тэд хэдийгээр олон түмэнд танил болсон, өндөр нэр хүндтэй хүмүүс ч гэсэн аливаа үйл явдалд тэр тусмаа улс төрийн үйл ажиллагаа, улс төрийн сонгуульд оролцох шаардлага тулгарвал тэдний уламжлалт имижээс гадна улс төрийн имижийг бий болгох, олон нийтийн дунд тэднийг улс төрийн байр суурь, мэдлэг чадварыг таниулах шаардлага шинээр гарч ирдэг.

- Тухайн албан тушаал, байр сууриа хадгалахыг эрмэлзсэн, шинэ өрсөлдөгчдөөс болгоомжилсон, сэтгэл зүйн хувьд түгшсэн байдалтай хүмүүс. Тэдэнд өөрсдийн имижийг өсгөн нэмэгдүүлэх, имижээ шинээр баяжуулах шаардлага зүй ёсоор тулгарч байдаг.

-Имижийн талаар зохих хэмжээний мэдэгдэхүүн байхгүй буюу эсвэл өөртөө имиж, имижмейкерийн туслалцаа хэрэггүй гэж үздэг хүмүүс. Гэвч өнөөдөр ийм үзэл бодолтой, үүнийг ойлгодоггүй хүмүүс тийм ч олон биш болсон байна. Энэ бүлгийн хүмүүстэй ажиллахад дээрхи хоёр бүлгийн хүмүүстэй ажиллахаас илүү хүндрэл тохиолдож болох юм.

Дээрхи ерөнхий бүлэг тус бүрийн нэр дэвшигчдийн имижийг бүрдүүлэх арга, технологи эрс ялгаатай төдийгүй нэг бүлгийн доторхи хүмүүстэй ажиллах, тэдний имижийг бүрдүүлэхэд тэдний сэтгэл зүйн онцлог, нийгмийн байр суурь, өөрсдийнх нь сонирхол, идэвхи чармайлт, үнэт зүйлс, үнэлэмж нь өөр өөр байх учир харилцан адилгүй байна.

Английн судлаач Элери Семпсон аливаа хүн амжилт гаргахад: “ажлаа сайн хийх -10 %, имижээ зөв бүрдүүлэх - 30%, нийтийн мэдээллийн хэрэгсэлд тусгагдсан таны амжилт, энэхүү амжилтаа найз нөхөд, ажил төрлийн холбоонд илтгэн харуулах - 60%” нөлөөлдөг” гэж үзэж байв. /5/ Хэрэв үүнийг үнэнд ойрхон гэж үзвэл улс төрчийг олон нийтэд ажиглагдахуйц болгогч гол хүчин зүйлүүдийг удирдаж болно гэсэн нэгэн чухал дүгнэлт хийж болох юм. Имижийн стратеги нь “юуг”, “ямар байдлаар” гэдгийг тусгадаг бол тактик нь “хэнд”, “хэзээ” гэдгийг илэрхийлнэ.

Нэр дэвшигч эмэгтэй байна гэдэг сул тал уу? аль эсвэл давуу тал уу? Хэрэв сул тал гэж хүлээн зөвшөөрч байгаа бол үүнийг давуу тал болгох боломж байна уу? зэрэг олон асуудал улс төрд хүчээ сорихоор шийдсэн эмэгтэйчүүдийн өмнө тулгарах нь зайлшгүй. Олон зууны туршид эмэгтэйчүүдийг “сайн ээж, сайхан хань” гэж үзэхээс “төрийн хүн” хэмээн ойлгож хүндэлж ирсэн уламжлал нэн ховор. Угаас ард түмний дунд эрэгтэй хүн удирдах ажилд илүү гэж үзэх уламжлал аль эртнээс л байсан. Аристотель энэ тухай “Ямар нэгэн хэвийн бус гажиггүй л бол эр хүн эмэгтэй хүнээс илүүгээр удирдах заяатай байдаг... боолд шийдвэрлэх чадвар угаасаа байдаггүй, энэ чадвар эмэгтэй хүнд байдаг боловч хэрэгждэггүй, хүүхдэд бас буй боловч хөгжин боловсорч гүйцээгүй байдаг” хэмээн тэмдэглэсэн байдаг. /6/ Иймээс олон түмний ухамсар консерватив шинжтэй. Үүнтэй уялдан

эмэгтэй улс төрчийн имижийг бүрдүүлэх нь имижейкерүүдэд маш хүнд зорилт болдог.

Ажил үүрэг гүйцэтгэж, албан тушаал хашихад хүний мэдлэг, ур чадвар, хариуцлага чухал болохоос хүйсийн ялгаа онцын ач холбогдолгүй. Нэрт эдийн засагч М.Фридманы тэмдэглэсэнчлэн “Хүний чадавхиас өөр юу ч, тухайлбал ар гэрийн байдал, үндэс угсаа, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс ба бусад ямар ч хүчин зүйл хувь хүний өмнө нээлттэй бүх бололцоог тодорхойлох учиргүй” юм. /7/ Гэвч амьдрал дээр гайхалтай мэдлэг чадвартай эмэгтэйчүүд хэнд ч анзаарагдамгүйгээр арын алба хашиж байхад зарим эрэгтэйчүүд, тэр дундаа залуучууд мэдлэг чадвараар тэднээс илүүгүй боловч асар хурдан хугацаанд олон нийтэд танигдаж, албан тушаал ахиж байдаг. Үүний нууц нь юу вэ? Энэ бол тэд имижээ зөв бүрдүүлсний хүч юм. Энэ нь эмэгтэйчүүд өөрсдийн улс төрийн имижээ бүрдүүлэх талаар дорвитой зүйл хийхгүй байсаар байхад, тэдгээр хүмүүс хийсэн бүтээсэн зүйл төдийлөн ихгүй ч чухам энэ тал дээр л ихээхэн зүйлд анхаарсан байж болох юм.

Эмэгтэй улс төрч ямар байвал илүү зохистой вэ? Ямар ч байж болох боловч амжилт олоход нь саад болохгүй байх шаардлагатай. Имижейкерүүд эмэгтэй улс төрчдийн имижийг бүтээхдээ эмэгтэй хүний характер бага байхаар тооцдог. Гэвч зүй зохистой уялдуулж чадахгүй бол нилээд тохиолдолд алдаанд ордог. Жишээ нь “эрэгтэй хүний мэргэжлийг сонгосон учраас гадаад үзэмжээ өөрчилж, хувцас хунар, үс гээгээ эрэгтэй хүн шиг засуулж, янзлуулах ёстой гэж имижейкерүүд зөвлөдөг” /8/ хэмээн бичжээ. Үүнийг шууд утгаар нь ойлгоод эрэгтэй хүн шиг хувцаслаж, эрэгтэй хүн шиг авирлавал зохистой гэвэл томоохон эндүүрэл болно. Эмэгтэй хүн “эмэгтэй хүнээрээ” байх нь улс төр дэх тэдний дутуу орон зайд өөрийн гэсэн байр сууриа эзлэхэд нь саад болох учиргүй. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс оюун ухааны хувьд ялгаагүй боловч сэтгэлзүйн хувьд ялгаатайг хүлээн зөвшөөрөх нь улс төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцоход нь бэрхшээл бус харин ч давуу тал болох боломжтой байдаг байна. Ф.А Хаек “Боолчлогдох зам” бүтээлдээ “... янз бүрийн үзэл баримталдаг бие хүмүүсийн ийм харилцан үйлчлэх үйл явц нь сэтгэлгээний хөгжлийн үндэс болдог юм. Ийм учраас хүний оюун ухааны нийгмийн уг шинж нь янз бүрээр сэтгэхийг шаарддаг” хэмээн тэмдэглэжээ. /9/ Монголчуудын уламжлалт зан заншилд ч эр, эм нь ялгагдахгүй хүнд төдий л таааламжтай байдаггүй. Эмэгтэй хүн улс төрч болхоороо огт гоёдоггүй гэсэн үг бус юм. Гагцхүү хаана, хэзээ, хэрхэн уялдуулан зохицуулахад, түүнчлэн мэдлэг, чадвар, гоо сайхан хоёрынхоо алин дээр нь “гэрэл тусгах” вэ? гэдгийг зөвөөр шийдвэрлэж чадаагүйн улмаас хүссэн үр дүндээ хүрэхгүй байх тохиолдол байдаг. Тиймээс энд зохист төвшинд тохируулах, донжийг нь олох гэдэг хичнээн чухал болох нь харагдаж байна. Нийгэм бүхэлдээ эрэгтэйчүүдээр бүх асуудлаа шийдүүлэхийг хүсэхгүй нь мэдээж хэрэг юм. Эмэгтэй улс төрчийн гадаад төрх, дуу хоолой, ярианы өнгө, хувцас хэрэглэл нь түүний хувийн зан чанар, байр суурь, мэдлэг боловсролыг ямар нэг хэмжээгээр илэрхийлдэг гэж үздэг нь хүнийг “Хувцсаар нь угтаж, ухаанаар нь үддэг” гэдгийн илрэл юм. Энд хувцас гэдгийн цаана зөвхөн өмссөн хувцас орохгүй мөн тухайн улс төрч эмэгтэйн нүүр будалт, үс засалт, гоёл чимэглэл, хувцаслалт, хэрэглэж буй зүйлс / цүнх, үзэг, дэвтэр, нэрийн хуудас г.м./, биеэ авч яваа байдал зэрэг олон зүйлийг багтаан ойлгоно. Энэ бүхэн түүний тухай үггүй мессежийг бусдад илгээж байдаг. Имиж бүрдүүлэлтэд хувцаслалт, гадаад төрх зэрэг нь төдийлөн жин дарах хүчин зүйл бус боловч “анхны сэтгэгдэл” гэдэг утгаар ихээхэн нөлөөтэйг судлаачид онцлон тэмдэглэдэг. Хэтэрхий хамаагүй байдал нь жирийн л нэг байдаг л хүн байна гэсэн хайш яйш сэтгэгдэл төрүүлэхгүйн тулд гарцаагүй үүнд анхаарах ёстой.

Имижмейкер, тухайн субъектын имижийг тодорхой хэв маягуудад ангилсны үндсэн дээр дэвшүүлсэн зорилго, түүнд хүрэх арга зам, нөөцдөө тулгуурлан тодорхой технологийн дагуу оновчтой ажиллаж байж зохих үр дүнд хүрэх болно. Ямар ч улс төрчийн имиж дангаараа бүрэлддэггүй, оршин байдаггүй, түүний имиж ямагт нас, хүйс, ажил мэргэжил, албан тушаал, улс төрийн нам, бүлгийн зэрэг олон янзын бүлгүүдийн имижтэй харилцан сүлжилдэн бүрэлдэж, оршин үйлчилж байдаг онцлогтой. Гэтэл өнөөдөр манайд бүлгийн имижд тавих анхаарал харьцангуй сул байна. Жишээ нь эмэгтэй улс төрчдийн имиж “эмэгтэй хүн” гэдэг имижээс ангид байх аргагүй. Тэгвэл өнөөдөр эмэгтэй хүний ямар шинж чанарыг олон нийт илүү тод хүлээн авч байна вэ? гэдгийг анхаарахгүйгээр саланги тусгай орон зайд хэн нэгэн эмэгтэй имижээ бүрдүүлж цойлон гарна гэдэг боломжгүй зүйл бус боловч улс төр нийгмийн өвөрмөц нөхцөлийг шаардсан хүндхэн зорилт юм.

Олон түмний санаа бодол, хандлага хэрхэн өөрчлөгддөг вэ? Түүнийг өөрийн хүссэнээр өөрчлөхийг хүсэж байна уу? Манай орны хувьд төдийлөн судлагдаагүй шмнжлэх ухааны шинэ салбар болох PR үүнд хариулт өгнө. Улс төрийн PR нь нийгмийн тухайн салбарт амжилт гаргах арга замыг зааж өгдөг төдийгүй ялалтанд хүргэдэг бас унагадаг, улс төрийн нам, бүлэглэл, улс төрчийг эерэг сөргөөр ойлгуулахад чиглэгдсэн, төлөвлөгөөтэй, зохион байгуулагдсан, ухуулан сэнхүүлэх өвөрмөц сурталчилгаа төдийгүй шинжлэх ухаан, урлагийн тогтолцоо юм.

PR-ийн үндсэн гол үүргийн нэг бол бүлгийн имижийг хийж өгөх явдал.

Өнөөдөр улс төрийн намуудад улс төрийн маркетинг, менежмент, PR-ийн үйл ажиллагаа харьцангуй дутагдалтай байна. Улс төрийн намуудын үйл ажиллагааны шинжлэх ухаанч чанар дээшлэх нь сонгуульд ялалт байгуулахад төдийгүй, намын дотоод ардчилал, санхүүжилт зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд, улс төрийн систем дэх намын үүрэг ролийг дээшлүүлэхэд ихээхэн ач тусаа өгнө. Нөгөө талаас энэхүү цогц шинжлэх ухаан иргэд сонгогчдод үйлчлэх бөгөөд ингэснээр “улс төр бол бохир зүйл гэж үзэх, улс төрөөс зайлсхийх хандлагад эерэгээр нөлөөлөх болно.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, имиж бол зөвхөн анхаарлыг татах хэрэгсэл биш, өөрийн сонгогчдийн хүсэл, шаардлагыг мэдрэх арга юм.

Улс төрч болохыг хүсэж буй эмэгтэйчүүд богинохон хугацаанд хүссэн алдар нэрээ хэрхэн олж авах вэ? Амжилт, алдар хүндийг залбирч эсвэл хөлсөө асгаруулж олж авдаг бус харин зохиож бүтээдэг бөгөөд хүн бүр өөрийнхөө хувь заяаг зохиох боломж дунд амьдарч байдаг гэж үздэг. Иймээс улс төрч болохыг хүсэж буй эмэгтэйчүүд ямар амжилт гаргахыг хүсэж буй тэрхүү мөрөөдлийн байр сууриа тодорхойлж, улмаар түүндээ хүрэх ямар ямар нөөц өөрт тань байгааг тодорхойлон гаргахаас ажил тань эхлэнэ. Амжилт гаргахын тулд хамтран ажиллах цоо шинэ хүрээ хэрэгтэй болно Үүнд мэргэшсэн мэргэжилтнүүдийн туслалцааг авах, найз нөхдийн хүрээгээ өргөтгөх, мэдээллийн, эдийн засгийн зэрэг бүхий л нөөцөө тодорхойлж түүнийг нэмэгдүүлэх боломж, арга замуудыг судлан ажиллах шаардлагатай.

Амьдрал бол тэмцэл хэмээдэг бол улс төр бүрч хурц тэмцлийн талбар. Тэр талбараас ухарч няцвал амжилт олоход нэн бэрх. Олонхи эмэгтэйчүүдэд улс төрд оролцоход “зорьсондоо хүрэх шаргуу чанар, өрсөлдөгчдөө ялах “дайчин чанар” дутмаг байдаг байна. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдийн нилээд хэсгийн гаргадаг алдааны нэг бол тэд албан тушаал, нэр төрийн төлөө тууштай бус бөгөөд “боломж олдвол улс төрд зүтгээ, олдохгүй бол тэр л биз” хэмээн ямар нэг аз завшааныг хүлээж суудаг явдал юм. Эрчүүд эмэгтэй хүнийг өөрөөс нь хэд дахин чадварлаг нөхцөлд л хүлээн зөвшөөрдөг гэсэн

явган яриа байдаг нь эмэгтэйчүүдийг илүү хүчин чармайлт гаргах хэрэгтэйг сануулж байна.

Өнөөдөр улс төрийг шинжлэх ухааны үндэсгүй, хар ухаанаар явуулах нь үр дүнд хүрч, улмаар амжилтын тавцанд тэсвэрлэн үлдэж чадахгүй болох нь нэгэнт тогтоогджээ. Иймээс амжилт олъё гэвэл имижээ өөрчил гэсэн дүрмийг ямагт санаж ажиллах нь зүйтэй юм.

Улс төр эмэгтэйчүүд оролцохгүй бол хэцүүдчих гээд, эсвэл эмэгтэйчүүд улс төрд оролцохгүй бол хэцүүдчих гээд байгаадаа хэргийн учир оршиж байгаа бус бөгөөд гагцхүү хүн төрөлхтөн угсаа гарвал, баян хоосон, арьсны өнгө зэргээр ялгаварлан гадуурхаж ирсэн үзэгдлүүдийг даван туулснаар нийгэм алдаагүйг өнөөдөр Кофи Анан, Кондализа Райс нарын олон арван чадварлаг улс төрчид, нийгмийн зүтгэлтнүүдийн хийж бүтээсэн хийгээд хийж бүтээж буйгаас харж болно.

Улс төрийн хүнд ачааг дан ганц эрчүүдээ үүрүүлэх бус эмэгтэйчүүд зах зухаас нь үүрэлцэх нь ардчиллын нэгэн чухал үзүүлэлт бөгөөд нийгмийн өөрийнх нь “хүний нөөцөө дайчлах” чадвар юм. Эмэгтэйчүүд та бүхийг улс төр хүлээж байна. Үүний тулд улс төрч болох наад захын шаардлагыг хангасан байх хэрэгтэй бөгөөд бүхнийг мэдэгч, бүхнийг чадагч байх албагүй. Гагцхүү танд улс төрд зүтгэх, хийж бүтээх хүсэл эрмэлзлэл хангалттай байх шаардлагатай.

Нэгэн өгүүллийн хүрээнд имиж судлалын нарийн ширийн зүйл рүү орох боломжгүй. Нөгөөтэйгүүр бүх өвчинд таарах жор үгүйн адил бүх улс төрчдөд таарах нэгэн ижил жор байх боломжгүй. Энэ талаар эрт, эдүгээд ч эрдэмтэд тэмдэглэсээр иржээ. Аристотель бүтээлдээ, “...эмэгтэй хүн, эрэгтэй хүний даруу чанар адилгүй, Сократын бодож байгаагаар, эр зориг, шударга ёс ч тус тусдаа янз янз, даргад тохирсон эр зориг нэг, зарцад тохирсон эр зориг өөр. ...”дуугүй байх нь эмэгтэй хүний чимэг” гэж эмэгтэйчүүдийн тухай хэлсэн яруу найрагчийн үг бий, энэ нь, ер нь бүх эмэгтэйчүүдэднэгэн адил хамаатай атлаа эрэгтэйчүүдэд угаасаа тохирохгүй” /10/ гэсэн бол Людвиг фон Милс “Либерализм бүтээлдээ “...хүн төрөлхтөний бүх гишүүд адил тэгш гэдэг шиг үндэслэл муутай нотолгоо байхгүй. Хүмүүс огт адил тэгш биш байдаг. Ах, дүү хоёр хүртэл биеийн чадал тэнхээ, оюун ухааны байдлаар мэдэгдэхүйц ялгаатай. Байгаль эх өөрийн бүтээлийг хэзээ ч давдаггүй, Байгалийн урлангаас гарч ирсэн хүн бүр хосгүй өвөрмөц бодгаль чанарыг биедээ шингээсэн байна” /11/ хэмээсэн нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн имиж бүрдүүлэлт арга, технологийн хувьд өөр өөр төдийгүй хүн бүрийнх хоорондоо дахин давтагдашгүйг онцлон тэмдэглэжээ.

Өнөөдөр хэн гэдэг улс төрч, хэн гэдэг мэргэжилтэнтэй хэрхэн хамтран ажиллаж байгааг бодит баримтаар дурьдах нь зохимжгүй юм. Ингэх ч учиртай. Монголын бодит жишээнүүдээс бичсэн бол сонирхолтой байх нь ойлгомжтой. Гэвч өөрийн үйлчлүүлэгчдийнхээ нууцыг ямагт хадгалдаг байх нь имижмейкерийн ажлын үндсэн үүрэг. Имижмейкерийн үйл ажиллагаа шинжлэх ухааны үндэстэй судалгаан дээр үндэслэж явагддаг байхаас гадна Монголын онцлогийг маш сайн мэдэж байх нь чухал. Чухам энд л өмнөх сонгуулиудын алдаа гарч байсан. 2008 оны сонгуульд нэр дэвших эмэгтэйчүүд сонгуулийн бэлтгэлээ одооноос системтэй, үр дүнтэй, оновчтой явуулахгүй бол үндсэндээ оройтсон. Гэвч юм хийе гэсэн хүнд цаг хугацаа харьцангуй байна. Улс төрийн намууд, нэр дэвших эмэгтэйчүүд сонгуулийн хуулинд тусгагдсан 30 хувийн квотыг үр дүнтэй ашиглахын тулд багагүй зүйлийг хийх шаардлагатай тулгарч байна.

Хүний эрхийн төлөө цогтой тэмцэгч Мартин Лютер Кинг хэлэхдээ, “Би мөрөөдөж байна. Боол, боолчлогч байсан хүний хөвгүүд Жоржийн улаан толгод дээр нэгэн ширээнд ахан дүүсийн адил сууцгаах тийм өдөр ирнэ гэж би мөрөөдөж байна...Би мөрөөдөж байна. Нэгэн цагт миний дөрвөн булбарай хүү

арьсныхаа өнгөнөөс болж биш, буруу зүйл хийснийхээ төлөө бусдын адил шийтгэл хүлээдэг тийм оронд амьдарна гэж би мөрөөдөж байна.” хэмээсэн лугаа өнөөдөр аль ч улс төрийн хүчний эмэгтэй улс төрчид, сонгогчид нь “улс төрчдийг эр хүн, эмэгтэй хүн гэдэг талаас бус, хүн гэдэг талаас хардаг” тийм улс оронд ажиллаж амьдрахыг мөрөөдөж байна. Энэ мөрөөдөл гагцхүү улс төрийн PR, имиж судлалын шинжлэх ухааныг үр дүнтэй хэрэгжүүлснээр биелэлээ олох боломжтой. Улс төрийн PR, имиж судлалын шинжлэх ухааны үр шимийг ашиглаж амжилтанд хүрч улс төрч болох боломж эмэгтэйчүүдийг хүлээж байна.

Зүүлт

- 1.”Афродита“ сонин, 2004 оны “Имидж” дугаар.
2. Почепцов Г.Г
- 3.Антонио Менегетти
- 4.Д.Ганхуяг. Хошуучлагчийн улс төрийн имиж, түүнийг бүрдүүлэхүй, 5-р тал.
- 5.Sampson E. The Image Factor. A Guide to Effective Self-presentation for Career Enhancement. London. 1994.
- 6.Аристотель. Улс төр /орч/ Б.Даш-Ёндон, УБ., 2006 24, 26-р тал.
- 7.М.Фридман. Хувь заяагаа сонгох нь. УБ., 2001. 106-р тал.
- 8.Г.Өнөрбаяр. Улс төрийн PR. УБ., 2004, 133-р тал
- 9.Ф.А Хаек. Боолчлогдох зам. УБ., 2004, 134-р тал.
- 10.Аристотель. Улс төр. /орч/ Б.Даш-Ёндон. УБ., 2006, 26-р тал.
11. Людвиг фон Милс. Либерализм. УБ., 2004, 31-р тал.

ОЛОН УЛСЫН УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ХОЛБООНЫ ДЭЛХИЙН ХХ ИХ ХУРАЛ

Ц.Ганболд

доктор, тэргүүлэх профессор
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхмийн эрхлэгч

Миний бие 2005 онд олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоонд гишүүнээр элсэн орсон бөгөөд 2006 онд олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоо надад Японы Фукуока хотод болох тус холбооны дэлхийн ХХ Их хурлын урилгыг явуулсан юм. Ингээд 2006 оны 07-р сард Монголоос анх удаа олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны дэлхийн их хуралд оролцсон бөгөөд энэхүү өгүүлэлдээ олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны тухай болон дэлхийн ХХ конгрессийн талаар та бүхэнд мэдээлэх зорилго тавьлаа.

1948 онд ЮНЕСКО-ийн санаачлагаар улс төрийн шинжлэх ухааны асуудлаар олон улсын бага хурал Парист болсон явдал нь Францад төдийгүй бусад орнуудад улс төрийн шинжлэх ухааны судлах зүйлийн хүрээ нэг талаас нарийсан гүнзгийрч, нөгөө талаас цэгцрэн хөгжихөд чухал нөлөө үзүүлсэн юм. Үүнд:

1. Улс төрийн шинжлэх ухаан гэж нэрлэгдэх бие даасан салбар бий болж, улс төрийн шинжлэх ухаан бол улс төрийн бодлогын онол мөн гэсэн нэгдсэн дүгнэлтэнд хүрчээ. Улс төрийн бодлого бол олон сая хүний хувь заяатай холбоотой байдаг тул түүнийг хэн нэгэн нь өөрөө зохиогоод шийдэж болохгүй. Тиймээс улс төрийн бодлого нь онолын үндэслэлгүйгээр хэрэгжих ёсгүй. Тийм ч учраас улс төрийн бодлоготнууд улс төрийн шинжлэх ухаанд суралцах ялангуяа улс төрийн онол ба улс төрийн үзэл санааны түүхийг судалж мэдсэн байх ёстой гэж үзжээ.
2. Улс төрийн шинжлэх ухааны судлах зүйл бол Үндсэн хуулиас эхлээд засаглалын харилцаанд оролцогч улс төрийн институт болно. Тиймээс улс төрийн шинжлэх ухаан бол улс төрийн институцийн онол юм.
3. Улс төрийн шинжлэх ухаан бол бүлгийн болон олон нийтийн санаа бодлыг судалдаг. Өөрөөр хэлбэл, бүлгүүд, хүмүүс, нийгэмлэгийн сонирхлыг судалдаг. Нийгэмд ажиллаж, амьдарч байгаа хүмүүс маш олон янзын сонирхолтой. Үүнээс сонирхлын бүлгүүд гарч ирдэг. Сонирхол нь зөрчилдсөн нөхцөлд тэр сонирхлын бүлэг зарим нөхцөлд шахалтын бүлэг болж хувирдаг. Иймээс олон нийтийн оролцоо ба санаа бодлыг судлах явдал нь улс төрийн шинжлэх ухааны чухал чиглэл мөн.
4. Улс төрийн шинжлэх ухааны зайлшгүй судлах нэг зүйл бол Олон улсын харилцаа /Олон улсын байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагаа юм. Парист болсон энэхүү бага хурлын дараа 1949 онд Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоо гэсэн бүхэл бүтэн

олон улсын байгууллага бий болжээ. Тиймээс 1948 оны Парисын хурлыг “Зохион байгуулалтын хурал” байсан гэж үздэг.

Улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, түүний ололт амжилтыг дэлхийн бүх улс орон, өнцөг булан бүрт хүргэх ерөнхий зорилгын үүднээс Улс Төрийн Шинжлэх Ухааны Олон Улсын холбоо байгуулагдсан юм.

Улмаар уг холбоо нь жинхэнэ шинжлэх ухааны олон улсын холбоо болох үүднээс өөрийн гэсэн хууль, дүрмийг баталж гаргасан бөгөөд гол зохицуулах эрх зүйн эх сурвалж нь улс төрийн шинжлэх ухааны Олон Улсын холбооны Үндсэн хууль бөгөөд үүнийгээ анх Францын бүгд найрамдах улсын 1939 оны 04-р сарын 12-нд батлагдсан Үндсэн хуулинд тулгуурлан бичсэн байна.

Тус холбоо нь албан ёсоор Парис хотноо бүртгэлтэй байдаг ба анхлан үндэслэгчид нь үндэстнүүдийн холбоод байсан бөгөөд голчлон АНУ, Канад, Франц мөн Энэтхэгийн улс төрийн шинжлэх ухааны холбоод байсан. Ийм маягаар 1950 онд улс төрийн шинжлэх ухааны Олон Улсын холбооны эгнээнд дээрх дөрвөөс гадна Израйл, Польш, Швед, Их Британи мөн 1951 онд тус холбоонд Австри, Бельги, Грек, Мексик гэх зэрэг улсууд, 1952 онд Бразил, Финлянд, Герман, Итали, Япон, Югослав улс нэгдэн орсон юм.

1950-иад оны сүүл гэхэд 10 гаруй, үндэсний улсуудын улс төрийн шинжлэх ухааны холбоод улс төрийн шинжлэх ухааны Олон Улсын холбоонд нэгдсэн байна. Тухайлбал: Австрали, Нидерланд /1956 онд/, Шриланк, Куба, ОХУ /1955 онд/, Египит, Норвеги /1956 онд/, Испани /1958 онд/, эцэст нь Швейцари /1959 онд/ нэгджээ. Гэхдээ мэдээж өнөөг хүртэлх хугацаанд эдгээр бүх улсууд Олон улсын холбооны гишүүд хэвээрээ байгаад байгаагүй, тэдний зарим нь Олон улсын холбооноос эргээд гарсан тохиолдлууд байдаг. Гэвч Олон улсын холбооноос гарсан гишүүн орнуудын тоо Олон улсын холбоонд нэгдэн орсон гишүүдийн тооноос цөөн байсан тул түүний гишүүнчлэл аажим аажмаар өссөөр байна. Яг одоо нийт 44 улсын улс төрийн шинжлэх ухааны холбоод Олон улсын холбооны гишүүнчлэлд байна.

Гишүүнчлэлийн хувьд Олон улсын холбоо нь өсөн нэмэгдэхийн хажуугаар түүний үйл ажиллагаа эрчимтэй хөгжиж байна. Тухайлбал Олон улсын холбоог анх байгуулахад судалгааны хороод байгаа бол яваандаа Олон улсын холбооны 8-р бүгд хурлаас эхлээд ерөөсөө дэлхийн хэмжээнд тусгайлан зохион байгуулагдсан судалгааны хороод байх хэрэгтэй гэж үзэж анхны судалгааны хороог байгуулсан. Одоогийн байдлаар Олон улсын холбоонд судалгааны нийт 48 хороод сургалт, судалгааны үйл ажиллагаа явуулж байна.

Олон улсын холбоо нь судалгааны ном зохиол, эрдэмтдийн тавьсан илтгэл, өгүүллийг хэвлэн гаргахад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг ба цаашлаад энэхүү хэвлэн нийтлэх үйл ажиллагааг бодлогын хэмжээнд системтэйгээр авч үзэж, дүрэм зааврыг хүртэл гаргадаг болсон байна. Энэ үйл явц нь 1951 оноос эхэлсэн бөгөөд хамгийн анхны хэвлэл нь “Олон улсын улс төрийн шинжлэх ухааны товч агуулга” гэсэн сэтгүүл байсан ба энэ нь одоо ч гэсэн жилд 4 удаа нийтлэгдэн гарсаар байгаа бөгөөд 1995 оноос CD-ROM-ын хэлбэрээр гарах болсон байна.

Улс төрийн шинжлэх ухааны Олон улсын холбооноос салбарлан улс төрийн шинжлэх ухааны чиглэлээр суралцагч оюутнуудын Олон улсын холбоо, Улс төрийн шинжлэх ухааны Олон улсын судлаачдын холбоо байгуулагдсан юм.

Улс төрийн шинжлэх ухааны Олон улсын холбооны Их хурлуудын болсон газар, улсуудыг ажиглавал ихэнх нь Герман, Бельги, Франц, Австри, Итали зэрэг баруун европийн орнуудад мөн АНУ, Канад, Аргентин зэрэг

америк тивийн улсуудад болж байсан байна. Өөрөөр хэлбэл ази, /анх удаа Сөүлд болсон/, африкийн улсуудад бараг болж байгаагүй гэсэн үг. Харин эдгээр хурлуудаас 1979 оны 11-р их хурал их онцлогтой харагдаж байна. Учир нь Франц, Герман, Америк г.м өрнийн орнуудад болж байсан уг хурал нь 1979 онд л анх удаа социалист системийн улс болох ЗХУ-д болсноороо дэлхий нийтийн улс төрийн шинжлэх ухааны их хурал гэж хэлэгдэх болсон юм.

Улс төрийн шинжлэх ухааны Олон улсын Их хурлаар тухайн үед түүнд судлаачид улс төрчдийн анхаарлыг хандуулж улс төрийн шинжлэх ухаанд тулгамдаад байгаа зангилаа асуудлуудыг авч үзэж, ирээдүйд түүнийг нааштайгаар шийдвэрлэх гарцыг олохыг чухалчилдаг. Ийм ч учраас дээрх хурлуудын өмнөө тавьсан уриа буюу хэлэлцсэн асуудлын ерөнхий сэдвээс харахад уг асуудал нь тухайн цаг үетэйгээ, тухайн болж байгаа газар оронтойгоо их холбоотойгоор дэвшигдсэн байна. Тухайлбал: 1979 оны 08-р сарын 12-18-нд Москвад болсон 11-р Их хурал нь “Дэлхийн улс төрийн бодлого, системийн өөрчлөлт, хөгжлийн бодлого, 1949 оноос хойшхи улс төрийн мэдлэгийн хуримтлал” гэсэн ерөнхий 3 асуудлын хүрээнд болжээ.

Тухайн үед дэлхий ертөнц 2 системд хуваагдсан байсан ба хамгийн тулгамдаад байгаа асуудал бол олон улсын харилцаа, дэлхийн бодлогын хүрээнд байсан тул уг хуралд дээрх сэдвийг авч хэлэлцсэн байна.

Улс Төрийн Шинжлэх Ухааны Олон Улсын Холбооны Дэлхийн Их Хурлууд

№	Хэзээ болсон	Хаана болсон	Нийт оролцогч судлаачдын тоо	Оролцогч орнуудын тоо	Авч хэлэлцсэн асуудлын ерөнхий сэдэв
1	1950	Швейцари Цюрих	80	23	
2	1952	Нидерландын Гааг	220	31	
3	1955	Швейцарийн Стокгольм	275	36	
4	1958	Италийн Ром	320	31	
5	1961	Францийн Парис	425	46	
6	1964	Швейцар Женев	495	43	
7	1967	Бельгийн Брюсель	745	56	
8	1970	Германы Мюнхень	894	46	
9	1973	Канадын Монтриал	1044	56	
10	1976	Их Британы Единбург	1081	56	
11	1979.08-12-18	ОХУ-ын Москва	1466	53	Дэлхийн улс төрийн бодлого, системийн өөрчлөлт хөгжлийн бодлого 1949 оноос хойшхи улс төрийн мэдлэгийн хуримтлал
12	1982.08.09-14	Бразилын Рио де Жанеро	1477	49	1980 оноос хойших иргэний нийгэм
13	1985.07.15-20	Францын Парис	1763	66	Өөрчлөгдөж буй улс болон үндэстэн ба олон улсын нийгэмлэгийн харилцаа
14	1988.08.28-09.01	АНУ-ын Вашингтон	1700	65	Глобаль улс төрийн шинжлэх ухааны зүг
15	1991	Аргентины Буэнос-Айрес	1400	55	Улс төрийн шийдвэр гаргах үйл явц: үндэстнүүдийн харьцуулсан болон олон улсын бодлого
16	1994	Германы Берлин	1884	73	Ардчилалын нөхцөл дэхь хүйсийн зүй зохист байдал
17	1997	Өмнөд Солонгосын Сөүл	1470	72	Сайн засаглал, хүний эрх, эрх чөлөө

18	2000.08.01-16	Канадын Квебек	1849	73	Дэлхийн капитализм нь мянган жилийн нэгдлийн удирдлага, ерөнхий чанар юм.
19	2003.06.29-07.04	ӨАБНУ-ын Дурбан	1011	69	Ардчилал, тэсвэр хүлцэл, шударга ёс буюу зүй зохист байдал
20	2006	Японы Фукока	2000	118	Ардчилал хэрэгжиж байна уу?

Японы Фукуока хотод болсон Олон Улсын Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбооны 2006 оны Дэлхийн Чуулган нь тус холбооноос явуулж буй 20 дахь их хурал юм. Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны 50 гаруй жилийн түүхнээ анх удаа Японд энэ удаагийн Дэлхийн Чуулганыг чуулж Гүйцэтгэх хорооны зүгээс Фукуокаг сонгож авсаны гол учир нь уг бүс нутгийн бүхий л эрдэмтэн судлаачдыг хамруулах, мөн түүнчлэн Японы улс төр судлаач эрдэмтэн мэргэдтэй хамтран судалгаа шинжилгээний ажил хийж, хамтын харилцаагаа өргөтгөх зорилго тавьсан болно. Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны гол зорилго болсон соёлын ялгаатай байдал, хүний эрх, сайн засаглал, ардчиллын үнэт зүйлсийг хөхүүлэн дэмжих явдал бол энэхүү хамтын судалгааны ажлын тэргүүн чиг шугам байх болно гэж үзжээ.

Энэ удаагийн Дэлхийн чуулганд 120-иод орноос 2000 орчим төлөөлөгчид оролцсон нь олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны түүхэнд тэмдэглэгдэх том чуулган боллоо. Чуулганы хөтөлбөрийг маш их шүүн тунгаасны эцэст боловсруулсан бөгөөд 3000 гаруй санал хүсэлт хүлээн авсанаас 1859 эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцэж үлдсэн илтгэл мэдээллийг бусад хэлбэрээр сонсож яриа маргаан, ярилцлага өрнүүлсэн болно.

Цаашлаад энэхүү чуулганаар Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны зүгээс мэргэжил нэгт улс төр судлаач нөхдөө дэмжих зорилгоор 30 орны 29 эмэгтэй, 35 эрэгтэй судлаачдад уламжлал болсон тэтгэлгийг олгов. Энэ удаагийн чуулганаараа “Ардчилал хэрэгжиж байна уу?” хэмээх сэдвийн дор ардчилагдах үйл явц, ард иргэд өөрийн биеэр болон өөрсдийн төлөөлөгчөөрөө дамжуулан улс төрийн бодлогыг боловсруулах үйл явцад хэрхэн оролцож байна вэ? гэсэн асуудлыг онцлон авч үзлээ.

Уг их хурлын сэдэв нь өнөөдрийн ардчиллын сул тал болон давуу талыг авч үзэхэд зориулагдсан юм.

Ардчилал улс төрийн систем болохын хувьд урьд өмнөхөөсөө илүү түгээмэл болж байгаа бөгөөд энэ нь хуучин ардчилсан орнуудаас уламжлагдан тархаж байна. Шинээр ардчилагдсан орнууд ардчиллын үндсийг шинэ бордоо ашиглан суулгахдаа сорилт бэрхшээлтэй тулгараад байна. Ардчилал өнөөдөр хэрхэн ажиллаж байгааг тодруулах нь бидний энэ их хурлаар тавьсан зорилт юм. Ардчиллыг яаж дэмжиж, сайжруулах вэ? Юу нь сайн ажиллаж байна вэ?, ардчилал судлаач эрдэмтэд, шийдвэр гаргагчид, олон түмний анхаарлыг татсан ямар зүйл байна вэ? зэрэг асуудал хурцаар тавигдаж байна.

Уламжлалт судалгаа шинжилгээний асуудлуудаас гадна е-ардчилал, ICT зэрэг судалгааны шинэ салбарууд нэмэгдэн орж ирлээ.

20 гаруй жилийн өмнө эрх зүйт төр, зах зээлийн эдийн засаг, мөн нийтийн сайн сайхны төлөө төрийн зарим нэг хувилбар дээр суурилсан плюралист ардчиллын барууны загвар үндэсний төр улсуудад тохирох хамгийн шилдэг загвар мэт санагдаж байлаа. 1990 оны үеэс Зүүн европт коммунизм мөхөх анхны шинж тэмдэг илрэхэд уг үзэл баримтлал түгээмэл, энгийн зүйл боллоо гэж бодоцгоож байлаа. Гэвч энэ нь эртэдсэн дүгнэлт

болох нь харагдсан юм. Нэгдүгээрт, коммунизмын сэргөлдөгч болох систем дотор плюралист ардчилалд тохирох улс төрийн байгууллагууд /бүтэцүүд/ удаан оршиж чадаагүй бөгөөд ард түмэн болон эрдэмтэд ардчиллын үйл явцыг хэрэгжүүлж буй дотоодын байгууллагуудаас илүүтэйгээр түүний хэврэг болж буй байдал өө сэв, дутагдал, сайжруулах сонголтон дээр анхаарлаа төвлөрүүлж байна. Хоёрдугаарт: амиа хорлон бөмбөг дэлбэлэх мэтийн аль нэг улсаас зохион байгуулаагүй террорист үйл ажиллагаа нь тогтсон үзэл баримтлалыг хэмх цохиж, хүчирхийллийн бус арга замаар мөргөлдөөнийг зохицуулах ямар арга зам байгааг эрэлхийлэх явдал өнөөдөр зайлшгүй чухал болоод байна. Дэлхий дахиныг хамарсан электрон харилцаа холбооны хэрэгсэл дээр суурилсан нээлттэй нийгмийн үнэт зүйлсийн талаар Карп Поппер эдгээр үнэт зүйлсийг хэрэгжүүлэн хүртэхийг хүсэхгүй байгаа нийгмүүдэд бэрхшээл тулгарна хэмээн хэлсэн байдаг.

Энэхүү тулгамдсан асуудал улс төрийн шинжлэх ухааны олон улсын холбооны дараагийн дэлхийн их хурлын сэдэв болж болох юм. Фукуокад болж буй “Ардчилал хэрэгжиж байна уу?” сэдэвт энэхүү их хурал нь ардчиллын талаархи нэгдсэн ойлголт, төсөөлөл, болон эмпирик ул үндэсийн асуудал, мөн орчин үеийн ардчилалд тулгарч буй шинэ сорилтууд, хүн ам зүйн өөрчлөлт, нийтийн сайн сайхны төлөө төрийн ирээдүй, үндэсний төр улсуудын уналт зэргийг илүү сайн мэдэж авахыг зорьж байгаа юм. Мөн түүнчлэн асуудал дараахи байдлаар тавигдах хэрэгтэй бөгөөд үүнд: ямар үнэт зүйл эрхэм чухам болж байна вэ? улс төрийн байгууллагууд ямар үнэт зүйл дээр суурилж байна вэ?, мөн ямар сонголтууд ардчилсан орнуудад байна вэ? гэдгийг авч үзэх хэрэгтэй.

Дэлхийн бүх орон, бүх шатан дахь улс төрийн харилцаанд гарсан гол тулгуур өөрчлөлт болон хөгжлүүд нь ардчиллын талаар дахин нэг сайтар бодож үзэхэд хүргэсэн. Өнөөдөр олон хүмүүс төлөөллийн ардчилал хямралд орсон мөн олон нийтийн байгууллагуудад итгэх итгэл алдарсан гэж үзэж байна. Улс төрд итгэх олон нийтийн итгэл алдрахад нөлөөлсөн олон хүчин зүйлүүд байна. Тэдгээрт улс төрийн өрсөлдөөний үргэлж өсөн нэмэгддэг зардлууд, шийдвэр гаргахад оролцох, оролцооны асуудал засгийн газрын төвлөрөл, улс төрийн лидерүүд ард түмнээсээ холдож байгаа зэрэг олон асуудлууд хурцаар тавигдаж байна.

Энэхүү маргаанд манай одоогийн боловсролын байгууллагууд ардчилсан иргэдийг бэлтгэж чадаж байна уу? гэсэн асуудал бас анхаарал татаж байсан ба ардчилсан иргэншил боловсрол хоёрын хооронд ямар холбоо байгааг ч анхаарах ёстой гэж ярьж байна.

Засгийн газар болон зайны ардчиллын хөгжил нь ардчиллын хямралын шалтгаан болж байгаа юм биш биз?. Нас, хүйс, арьс өнгө, анги давхарга, гарал угсаа, шашин шүтлэгтэй холбоотой ардчиллын хомсдлыг технологийн шинэчлэл хир хэмжээнд хүртэл шийдэж чадах вэ? гэдэг асуудал их хурлын анхаарлыг татаж байлаа.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хүмүүсийн ухамсарт нөлөөлөхөд амин чухал үүрэг гүйцэтгэдэг ба дэлхий нийтийн хэвлэл мэдээллийн сүлжээний хүчирхэгжилт нь олон нийтийн үзэл бодолд тодорхой зөрчлийг бий болгодог.

Угсаатны, бүс нутгийн, үндэсний, олон улсын зэвсэгт мөргөлдөөн нь ардчиллын байгууллагуудын үйл ажиллагаа, оршин тогтнолд нилээд хүнд даваа болдог.

Ардчиллын бүтээлч чадамж хир вэ?.

Дэлхий дээр гарч буй мөргөлдөөнүүдийн учир шалтгаан, хэв маяг, үр дагавар нь юу вэ? Эдгээр мөргөлдөөнийг шийдвэрлэхэд ардчиллын чадамж

хир вэ? Мөргөлдөөнийг шийдэх болон зохицуулахад ардчиллын хэм хэмжээ бидэнд туслах уу?

Ямар төрлийн мөргөлдөөнийг ардчилал шийдэж чадах вэ? Мөн асуудлын ямар төрөл ардчилсан шийдвэр гаргахад орохгүй вэ? Өөрөөр хэлбэл ямар асуудлыг бид ардчиллын зарчмаар шийдэж чадах буюу эс чадах вэ?, Яагаад зарим улс ардчилсан системийг хүчирхэгжүүлэх болон оршин тогтноулахад амжилт олж байна вэ? Олон улсын системийг ардчилах асуудлыг бид ярих ёстой юу?. Ямар хэм хэмжээнд хүрэхээрээ ардчилал нь улс төрийн болон соёлын өөр өөр уламжлалуудыг холбогч болж харагдах вэ? Эсрэг тэсрэг ертөнцөд ардчилсан хэрэглээний ойлголт нь шийдэл олоход тус болох болов уу? Умард болон Өмнөдийн хоорондын эдийн засгийн ялгааг ойртуулахад ардчилал тусалж чадах болов уу? Бүрэлдэн тогтсон ардчилалууд тодорхой хугацаанд хямралд ордог, тэр хугацаатай адил хугацаанд шинээр бүрэлдэн тогтсон ардчилсан улсууд урьд байсан тогтолцооноосоо ангижирдаг гэж үздэг судлаачид байна гэх мэт олон асуулт бидний дунд яригдаж байна.

Ардчилал үйлчилж чадаж байна уу гэдгийг үнэлж дүгнэхдээ бид бүхэн мэдээж одоогийн сонгуулийн систем, улс төрийн намуудын үр бүтээмжийг хянан үзэхээ үргэлжлүүлэх ёстой.

Сүүлийн жилүүдэд өөр маягийн бодлого ялангуяа терроризмийн бодлого нь ардчилсан нийгэм болон түүний удирдлагуудад нилээд төвөг учруулсан. Энэхүү үзэгдлийг авч үзэж судлах нь ардчиллын хүч чадал болон сул талруу гэрэл тусгахтай адил юм.

Өнөөдөр ашиг сонирхлын илэрхийлэл өөрийнхөө хүрээнээс илүү гарсан ба бусад иргэний нийгмийн байгууллагууд шийдвэр гаргах үйл явцад хагас нөлөөлсөн байдалтай оролцож байна.

Олон нийтийн удирдлага нь ардчилсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд чухал байдаг ба бүхий л ардчилсан үйл ажиллагаа нь хүнд суртлын асуудалтай тулгарч байна. Ийм нөхцөлд иргэний нийгэм нь бодлого боловсруулах үйл явцад аль түвшин хүртэл оролцдог вэ? Ямар боломж, арга зам байна вэ? гэх мэтчилэн ардчилалтай холбоотой маш олон асуулт гарч болох ба их хурал дараахь зургаан гол дэд сэдвүүдэд анхаарлаа хандуулсан юм. Үүнд:

1. Ардчиллын хямрал ба чадамж, үндэсний болон олон улсын хэтийн төлөв
2. Ардчилал ба дэлхийн шинэ дэг журам
3. Байгууллагын хууль ёс, сонирхлын төлөөлөл ба ардчилсан үйл явц
4. Иргэдийн оролцоо, үнэлэмж
5. Төрийн бодлого, хүнд суртал болон ардчиллын чанар
6. Сайн ардчиллын онол, мэдлэг зэрэг болно.

Эдгээр 6 чиглэлээр нийтдээ 1800 гаруй илтгэл тавигдсан бөгөөд улс төрийн шинжлэх ухааны Олон улсын холбооны дэлхийн ХХ их хурал дээр тавигдсан бүх илтгэлийн абстрактыг зохиогчийн нэр, илтгэлийн нэр, зохиогчийн e-майл хаягийн хамт МУИС-ийн улс төр судлалын тэнхимээс авч болно.

Түүнчлэн бүх хурлын дараа болон хүссэн үедээ надаас эдгээр илтгэлийн абстрактыг сонирхож болохын зэрэгцээ олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбооны сэтгүүл, үндэсний улсуудын улс төрийн шинжлэх ухааны холбооны сэтгүүлүүд, зарим илтгэлийн эх хувийг манай тэнхимээс авч хэрэглэж болно.

ПОЛИТОЛОГИ III
Эрдэм шинжилгээний бичиг¹ ... (...): 179-183 дахь тал

МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ХӨГЖИЛ, УЛС ТӨР СУДЛААЧ БЭЛТГЭХ АСУУДАЛД

С.Базарпүрэв

доктор, профессор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Улс төрийн сэтгэлгээ олон зуун жилийн турш хөгжин дэвжих явцдаа арвин сан бүрдүүлэн улмаар улс төрийн мэдлэгийн их өв хуримтлагдаж, XIX зууны хоёрдугаар хагаст шинжлэх ухааны “дүр төрх” олон, төлөвшин XX зууны 50-иад оны эхээр нийгмийн шинжлэх ухааны “албан ёсны” нэг төрөл болон тунхаглагдсан байна.

Монголд XX зууны 90-ээд оны эхэн үеэс улс төр судлалын суурь тавигдаж, сургалт эрдэм шинжилгээний ажил хийх болжээ. Гадаад орны улс төрийн шинжлэх ухааны өв сан болон өөрийн орны нийгмийн ухааны эрдэмтдийн бүтээсэн онолын мэдлэг дээр тулгуурлан манай оронд улс төр судлалын эх тавигдсан юм.

Улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн дэлхийн түүхийг тунгааж үзэхэд улс төр судлал коллеж, университетэд төвлөрөн төлөвшиж, боловсорч иржээ. Өнөөдөр ч гэсэн энэ практик уламжлан эрч хүчээ алдалгүй хэрэгжиж нийгэм-улс төр, эдийн засгийн амьдралын үр ашгийг дээшлүүлэхэд хүчин зүтгэж байна. Улс төрийн шинжлэх ухааны сан хөмрөг бүтээхэд идэвхтэй хувь нэмэр оруулсан судлаачид дэлхийд нэр алдар нь түгсэн университетийн эрдэмтэн профессор байсан одоо ч байсаар байгаа билээ. Монгол ч гэсэн энэ жишгээс гажаагүй. Манай орон дахь улс төрийн шинжлэх ухааны үүсэл гарал МУИС-тай холбоотой энд л эрчимтэй хөгжих ёстой. Оюуны чадвартай мэргэжилтэнг бэлдэж, нийгмийн хөгжилд түүнийг ашиглах нь орчин үеийн боловсролын бодлогын гол агуулга юм.

1993 онд МУИС-д улс төр судлалын салбар нээгдэж анхны элсэлтээ авч мэргэжлийн улс төр судлаачийг бэлдэж эхэлсэн. МУИС болон бусад дээд сургуульд мэргэжлийн улс төр судлаач бэлдэх болсноор шинжилгээ, судалгааны ажил идэвхжихэд түлхэц болсон төдийгүй улс төр судлалын мэргэжсэн институт бий болоход хүчтэй нөлөөлсөн билээ. Тодорхой тооны сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний бүтээл, мэргэжлийн сэтгүүл, нэг сэдэвт судалгаа хийгдэх болж, гадаадын нэртэй эрдэмтдийн болон сонгодог бүтээлийг орчуулах ажлыг эхлүүлжээ.

Эрдэм шинжилгээ, сургалтын үйл явц ардчилагдаж, аливаа үзэл суртал, улс төржсөн, төрийн дарамтнаас ангижирч шинжилгээний олон төрлийн арга, хэрэгслийг чөлөөтэй ашиглан бичсэн ном товхимолд бүтээгч, зохиогчийн “эрхийг” эдлэж, улс төрийн шинжлэх ухааны судлагдахууныг өөрсдийн “дураар” тодорхойлж, томъёолох болжээ. Тухайн нөхцөл Монголд улс төрийн шинжлэх ухаан хөгжих үлэмж таатай хөрс болсон юм.

Улс төр судлаачдын нэг хэсэг нь улс төрийн субъектыг голлон судлаж байхад нөгөө нь эдийн засаг улс төрийн харилцан хамаарлыг шинжилж байх жишээтэй. Гуравдахь нь улс төрийн соёл, нийгмийн сэтгэл оюуны хүрээг онцлон анхаарч байна. “Цэвэр” суурь онол бүтээгчдийн зэрэгцээ хавсрага

шинжлэлийг түлхүү үздэг судлаачид байхад улс төрийн технологи боловсруулах чиглэл сүүлийн үед эрчимтэй хөгжиж байна. Тухайлбал, улс төр судлалын арга зүй, сонгуулийн систем судлал, улс төрийн имиж шинжлэл зэргийг нэрлэж болно. Гэсэн хэдий ч орхигдсон огт хөндөөгүй судалгааны сэдэв багагүй байна.

Улс төр нийгмийн харилцааг зохицуулан түүний уур амьсгалыг тодорхойлж байдгийн хувьд нийгмийн амьдралын бүх салбарт нэвтрэн орж хүн бүртэй харилцан хамаарлыг бүрдүүлдэг учраас улс төрийг шинжлэн судлах ажиллагаа улс төр судлалын дагнан “өмчилсөн” ажил биш гэдэг нь тодорхой байна. Салбар дундын шинжилгээний хамтарсан үйл ажиллагааг өрнүүлж, нийгмийн болон хүмүүнлэгийн ухааны судалгааны арга хэрэгсэл, хүч нөөцийг идэвхтэй ашиглаж, шаардлагатай гэж үзвэл байгалийн, техникийн шинжлэх ухааны дэвшил, технологийн ололтыг судалгаандаа хамруулах нь бидний хүсэн хүлээсэн, бодит шаардлагад нийцсэн үр дүнд хүргэх юм.

Өнөөгийн Монголын нөхцөл байдалд бий болсон улс төр, нийгэм-эдийн засгийн хүндрэлтэй асуудлыг шуурхай шийдвэрлэхийн тулд эрдэм шинжилгээний ажлыг идэвхжүүлэн чанаржуулах бодит шаардлага манай орны улс төр судлаачдын өмнө тулгараад байгаа билээ. Түүнд шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар өгөх амин чухал хэрэгцээ байна. Үүнийг хийж чадваас ололт амжилт, дутуу дулимаг хийснээ олж харах, цаашид хийх шинжилгээ, судалгааны ажлын мөрийн хөтөлбөр тодрох болов уу.

Монгол дахь улс төрийн амьдралд бугшаад буй асуудлыг шийдэж чадахгүй байгаа нь улс төр судлаачид тэдний мэргэжлийн ур чадвартай ямар нэгэн байдлаар холбоотой юм. Улс төр манай оронд зүй зохистой жам ёсоор хөгжих мөн түүний хувь заяаг тодорхойлох гол хүчин зүйл нь мэргэжлийн улс төр судлаач ажээ. Түүнийг хэр зэрэг чанартай бэлдэж, “бүтээж” чадна төдий чинээ улс төрийн шинжлэх ухаан Монголд хөгжин мөн нийгэмд гүйцэтгэх үүргээ амжилттай биелүүлэх боломж нээгдэнэ.

Уг үйл ажиллагааны үр дүнд оюутан улс төрийн мөн чанарыг идэвхтэй таньж мэдэх мэргэжлийн ур чадвар эзэмших, бодит байдалд дүйцсэн улс төрийн ухамсар төлөвших мөн улс төрийн соёл түүнд тохирсон улс төрийн зан үйлийн хэм хэмжээ суух учиртай билээ.

Гүнзгийрүүлсэн сургалт, олимпиад зохион байгуулж түүнээс шалгарсан шилдгүүдийг улс төр судлалын ангид элсүүлэх нь чанартай судлаач бэлдэх эхлэл болох юм.

Улс төр судлаачдыг бэлтгэх сургалтын философи хүмүүнлэгийн үнэт зүйлс дээр тулгуурлан хийгддэг гэдгийг онцлон тэмдэглэх ёстой. Ялангуяа хүний эрх, эрх чөлөө түүний жам ёсны эрхийг эрхэмлэн дээдэлсэн зарчмыг оюутан залууст суулгах нь юунаас ч илүү чухал юм. Ирээдүйн улс төр судлаач зөвхөн улс төрийн үзэгдэл, үйл явцыг шинжлэхээс гадна олон нийт нийгэм-улс төрийн байгуулалтыг зүй зохистой дүгнэх, улс төрийн эрхээ ухамсарлан улс төрд эзлэх байр сууриа ойлгоход үнэтэй хувь нэмэр оруулах үүрэг хүлээсэн байдаг гэдгийг бид сургалтын үйл явцдаа онцгой анхаарах шаардлагатай байна.

Улс төр судлаач улс төрийг дагнан судалдаг гэвэл туйлын өрөөсгөл болох юм. Улс төр судлаач нийгэм судлаач байж улс төрийн мөн чанарыг зүй ёсоор нь таньж мэдэн, улс төрийг хүний ёсны хэмжүүрт оруулан судлан шинжлэсээр нийгэмд үр ашгаа өгөх болно гэсэн байр суурь сургалт эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны анхаарлын төвд ямагт байх учиртай.

Оюутан хүн төрөлхтний бүтээсэн эрдэм мэдлэгийн тодорхой системийг нөхөн эзэмшихээс гадна улс төрийн үйл явцыг ойлгон тайлбарлаж, улиран

өнгөрсөн болон өнөөгийн улс төрийн хөгжлийн үнэн дүр төрхөд бодит дүгнэлт хийх онол арга зүйн чадвар мөн мэргэжлийн үйл ажиллагаанд зайлшгүй хэрэгцээтэй шинжлэх ухааны баримтлалыг төлөвшүүлэх нь мэргэжилтэн бэлтгэх сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын зорилт юм.

Ийм бодит зорилтын зэрэгцээ онолын болон хавсрага судлалыг “зүгшрүүлэх”, судлагдахууныг тодорхойлон томъёолох аргачлал боловсруулах, ойлголтын аппаратыг зохистой бүрдүүлэх, шинжилгээний агуулгыг тодруулах, арга зүйн асуудалд анхаарах улс төрийн шинжлэх ухааныг институтжуулах, тэнхимд эрдэм шинжилгээний ажил эрхлэх нөхцөл бий болгох зэрэг хийх ёстой олон ажил, мэргэжлийн тэнхимийн өмнө тулгараад байна.

Өнөөдөр өрнөж байгаа улс төрийн үйл явцыг өнгөц эсвэл огт авч үзэлгүй, туйлын бүдүүвч хэв шинжтэй онолын тодорхой системийг оюутанд тулгах хандлага улс төрийн талаар хуримтлагдсан мэдлэгийг дамжуулах явцад давамгайлж, өрнөдийн улс төр судлалын өв соёл хичээлийн хөтөлбөрт түлхүү багтжээ. Тухайн мэдлэгийн системд багшийн сэтгэлд элгэмсүү улс төрийн үнэт зүйлс илүү ачаалагдан заагдах байдал ажиглагдаж байна. Нийгэм-эдийн засгийн хүчин чадал дорой цагт хүн амын дунд эрс шинэчлэлийн үзэл санаа газар аван үндсэрхэг үзэл, экстремист үзэл сурталд автах аюул нүүрэлж байгаа өнөө үед улс төр судлаачийг бэлтгэх сургалтанд аливаа нэг үзэл суртлыг удиртгал болгохоос зайлс хийх хэрэгтэй юм. Мөн үүний нэгэн адил сургалтыг намчирхах явдлаас хамгаалж, улс төржүүлэхгүй байх нь бидний баримтлах нэн чухал зарчим билээ. М.Вебер хичээлийн танхимд улс төр судлалын салбарын оюутан, багш аль нь ч улс төржихийг хатуу цээрлэж, хорьсон байна. Тэрээр улс төр судлал, намын байр суурь, улс төрийн удирдамж зэрэг нь хоорондоо эрс ялгаатай өөр зүйл гэдгийг сануулжээ (Вебер М. Избранные произведения. М., 1990).

Улс төрийн шинжлэх ухааны эмпирик тал, улс төрийн амьдралын практик хүрээ хичээлийн хөтөлбөрт бага тусгагдсан байна. Сүүлийн үед гарсан сурах бичиг, гарын авлага социологизмын зарчимд захирагдан бүтээгдэж, нийгмийн сонирхолд хөтлөгдсөн учир шалтгаант үйл явц хэмээн улс төрийн амьдралыг тайлбарлах сонгодог шинжлэх ухааны хандлага зонхилж байгааг тэмдэглэх нь зүйд нийцнэ. Үүний зэрэгцээ улс төрийг “улс төрийн хүний” үйл ажиллагаа гэж ёс төдий авч үзэх антропологийн баримжааны сонгодог бус шинжлэх ухааны чиглэл сургалтанд нэвчин хэрэгжих болсон.

Нийгмийн үнэт зүйлсийг эрхэмлэсэн, хэнээс ч хараат бус байх хандлага улс төрийн шинжлэх ухааны гол зорилго юм гэж судлаач, эрдэмтэн Л.Пул тодорхойлсон байдаг (Some Facts About Values.-“Political Science”, 1970). Энэхүү хандлага нэг талаас нийгэмд ноёрхож буй институтэд захирагдах аюулаас улс төрийн шинжлэх ухааныг “авардаг”, нөгөө талаас улс төрийн шинжлэх ухааны үндсэн баримтлал, дүгнэлтийг төр, засгийн байгууллага төдийгүй мөн нийгэм-улс төрийн бусад систем ашиглах бүрэн боломжтой. Өөрөөр хэлбэл улс төрийн шинжлэх ухаан нийгмийн эрх ашиг, сонирхолд үйлчлэх зориулалттай юм.

Монголын нийгмийг судлахгүйгээр улс төрийн шинжлэх ухаан Монголд хөгжих үндэсгүй юм. Монгол судлал нь улс төр судлалын үндсэн сэдэв билээ. Дэлхийн улс төр судлалын түүхийг харьцуулж үзвэл өөрийн орны буюу дотоод нийгэм судлалыг нэн тэргүүнд тавьж шинжлэх зорилго агуулсан байдаг нь улс төр судлалыг прагматик шинжлэх ухаан гэдгийг батлаж байна. Үүнээс үүдэн монголын түүх, эдийн засаг, соёл, уламжлал, газарзүй зэрэг монгол гэсэн тодотголтой бүх л зүйлийг нягт уялдаатай судлах бодит нийгэм-улс төрийн хэрэгцээ урган гарч байгаа билээ.

Монгол дахь улс төрийн үйл явцыг өнөөдөр хэсэгчилсэн маягаар судалж, тэр нь эрдэм шинжилгээний шалгуур, зарчим, ёс зүй нь хэмжүүрт хүрэхгүй зарим тохиолдолд тэнцэхгүй байх ч тал бий. “Баруунжих” мөрийн хөтөлбөрт хэт автсан уур амьсгал манай улс төрийн ертөнц, боловсролд ноёрхоод нилээд хугацаа өнгөрч Монголд улс төр судлал төлөвшихөд хүчтэй нөлөөлсөн гэдгийг тэмдэглэхийн ялдамд Монголд улс төрийн шинжлэх ухааныг онцлон анхаарч хөгжүүлэх цаг ирснийг зориуд сануулан хэлэх ёстой болоод байна.

Арав гаруй жил МУИС-д “улс төр судлаач” гэсэн ерөнхий нэртэй мэргэжилтэн бэлтгэж ирлээ. Харин өнөөдөр улс төрийн шинжлэх ухааны тодорхой чиглэлээр мэргэшүүлэх сургалт эрдэм шинжилгээний программ руу шилжин идэвхтэй үйл ажиллагаа явуулах шаардлага тулгараад байна. Улс төрийн философич, улс төрийн социологич, улс төрийн психологич, улс төрийн антропологич, улс төрийн институт судлаач, олон улсын улс төр судлаач, улс төрийн түүхч, улс төрийн газарзүйч, геополитикч, улс төрийн аналитик, онолч, арга зүйч зэрэг professional бэлдэх цаг үе ирээд байна. Үүнийг хэрэгжихэд философи, социологи, түүх, газарзүйн болон монгол судлалын бусад салбарын судлаач эрдэмтэн, тэнхимтэй хамтран ажиллах нь илүү үр дүнд хүргэх болно.

Улс төр судлалын суурь тэнхмээс гадна нарийн мэргэжлийн дэд салбар байгуулж өргөжих бодит хэрэгцээ бас байна. Энэ үйл явц үр ашигтай өрнөх гол нөхцөл нь орчин үеийн сургалт эрдэм шинжилгээний стандартанд нийцсэн эрдэмтэн багш нараар тэнхим бүрдүүлэн сургалт, судалгаа хийх санхүүгийн болон материалаг нөхцлөөр хангах явдал юм.

Багш нарыг эрдэмжүүлэх үйл явцыг зохион байгуулалтанд оруулж эрдмийн зэрэг хамгаалж, тодорхой чиглэл, сэдвээр эрдэм шинжилгээний ажил хийх зохистой орчин, боломж бүрдүүлэхэд онцгой анхаарах нь үлэмж ач холбогдолтой байна. Оноосон сэдвээр эрдэм шинжилгээний ажил эрхэлж, судалгааг тогтвортой тогтмол хийж нийгмийн эрх ашигт нийцсэн шийдэл боловсруулах зорилгод захирагдах нь мэргэжлийн тэнхимийн үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл юм.

Улс төр судлалын салбарын оюутны сургалтын оновчтой уян хатан хөтөлбөр боловсруулж, магистар, докторантын эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөө гарган зохион байгуулж, судалгааны үйл явцыг тасралтгүй өрнүүлж, багш нарыг дагалдуулан судалгаа, шинжилгээний арга барилд сурган, эрдэм шинжилгээний хурал, семинар хийснээр шинжээч судлаачдын эгнээг нөхөн сэлбэх, чадвартай шинжлэх ухааны хүч бэлдэж гаргана гэсэн үг.

Улс төр судлаачдыг бэлтгэн гаргах сургалт эрхэлж буй бусад институттэй сургалт эрдэм шинжилгээний хамтын ажиллагааны гэрээ хийн холбоо тогтоож, Монголд улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх бодлого боловсруулан зохион байгуулалтанд оруулан түүний үйл ажиллагааг зохицуулах нэгдмэл үндэсний төв байгуулах шаардлага байна. Энэ нь эрдэм шинжилгээ эрхэлж буй бие даасан төвийн амбицийг хөдөлгөж, судалгаа сургалтыг ардчилах үйл явцтай харшлахгүй гэж үзэж байна.

Монголд улс төрийн шинжлэх ухаан хөгжих нэг нөхцөл бол улс төрийн шинжлэх ухаан түлхүү хөгжсөн улс оронтой сургалт эрдэм шинжилгээний харилцаа, холбоо тогтоож ажиллах мөн олон улсын конгресс, конференц, семинарт санаачлага гарган оролцож, бүх талын хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэх явдал юм. Өнөөдөр ийм бололцоо бий болсон, зөвхөн бидний хүч чармайлтаас их юм шалтгаална.

Улс төрийн шинжлэх ухаан төр засгийн албан ёсны төлөөлөлтэй хамтран ажиллах явдал өнөөдөр нэн чухал юм. Иймэрхүү оролдлого хийгдэж байгаа ч эхлэл төдий, ахиц муутай байна. Шинжлэх ухааны дүгнэлтэнд тулгуурласан

төр засгийн шийдвэр нийгэмд ач тусаа өгч байхад төрийн мэдээлэл, захиалга нь улс төрийн шинжлэх ухааныг хөгжихөд түлхэц болох хоёр талын ач холбогдол байна. Хөгжилтэй улс орны практикт төр засгийн үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө өгөх бүтэц ажиллаж засгийн газраас санхүүждэг. Үүнийг бид хэрэгжүүлэхэд санаа санаачлага гаргах л үлдээд байна.

Улс төрийн шинжлэх ухааны хөгжилд үлэмж нөлөөтэй дэмжлэг үзүүлдэг хүчин зүйл нь улс төрийн “захиалагч” хүчин зүйл юм. Судалгааны үр дүнд улс төрийн шинжилгээний бүтэц, агуулгыг эрдэмтэн эхэлж тодорхойлдог ч “захиалагч” тодорхой нөлөө үзүүлж, шинжээчийн үйл ажиллагааны стратегийг боловсруулж “захиалагчийн” эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлдэг байна. Шинжээч “захиалагчийн” сонирхолд хариулт өгөх зорилгоор улс төрийн үзэгдэл, нөхцөл, байдалд шинжлэх ухааны тайлбар хийж, практик зөвлөмж боловсруулдаг байна. Иймээс зөвхөн шинжээч л шинжлэх ухааны үнэлэлт дүгнэлтийг захиалагчийн сонирхолтой нийцүүлж чадна.

“Их сургууль нь эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын... хэв шинжтэй байна” гэж Монгол Улсын “Боловсролын тухай” хуульд заасан байдаг. Тиймээс ч университет нь юуны өмнө шинжлэх ухааны институт бөгөөд түүнийг арилжааны “байгууллага” болгох үйл явцыг илт туйлшруулсан тохиолдолд академик соёлын үнэ цэнэ буурах, прагматизмыг хэт шүтэх, оюуны чадвар шахагдахад хүргэж үүний үр дүнд эдийн засгийн ашиг олохоосоо илүү хэтдээ их хор урхагтай гэдгийг анхааран сэрэмжлэх цаг болсныг хэлэхэд илүүдэхгүй байх.

Монголын нийгмийн улс төрийн амьдралд гарч буй үзэгдэлд шинжлэх ухааны үндэслэлтэй дүн шинжилгээ хийж, олон нийтийн байгууллагын үйл ажиллагаа, улс төрийн хөдөлгөөнд шинжээчийн байр сууринаас хандаж бодит дүгнэлт гаргаж өгөх ажлыг улс төрийн шинжлэх ухаан гүйцэтгэдэг учир Монголд улс төрийн шинжлэх ухаан хөгжүүлэх бодит хэрэгцээ байгааг харуулж байна.

ИТГЭЛ АЛДРАХУЙ¹: ЭМЭГТЭЙЧҮҮД БА ГҮЙЦЭТГЭГЧ

Я.Төгөлдөр
докторант, ахлах багш
ШУТИС, ХУС, Улс төр-стратегии судлалын профессорын баг

Хураангуй

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эдийн засаг, нийгэм улс төр ба соёлын амьдралын онцлог шинж чанар, боломж бололцоог тодорхойлдог жендерийн тухай өгүүлэхийн зэрэгцээ хүмүүсийн харилцаанд элбэг тохиолддог эмэгтэйчүүдийн эрх, үзэл бодолд таатай бус хандах байдал нь тэдэнд итгэл алдрахуйн нигуур болж байна. Үүнд эмэгтэйчүүд өөрсдөө даван туулах арга замаа хамтдаа тодорхойлж, үг дуугүй даган биелүүлэгч, хямд гүйцэтгэгч биш байх боломж байгааг харуулахыг оролдов.

Түлхүүр үг: жендерийн тэгш эрх, феминизм, ардчилал, итгэл алдрах, хямд гүйцэтгэгч

Эмэгтэйчүүд нийгмийн аль ч шатанд ямар нэг талаараа шахагдаж байгаа баримт жишээ, бүр онол ч түгээмэл оршсоор байгаа нь сүүлийн үед анхаарал татдаг болсон. Заримдаа энэ байдлыг дүгнэж, хэт феминист болоод байгаа юм болов уу ч гэж боддог. Учир нь бидний одоогийн хамгийн сайн нь гэж нэрлээд байгаа нийгэм улс төрийн ардчилсан тогтолцооны онолд ч, хүмүүсийн аж төрөх ёсонд ч эмэгтэйчүүдийн тэгш эрхийн асуудал зөрчигдөж байдгийг нуух юун. Ялангуяа эмэгтэйчүүд бид өөрсдөө энэ байдалтай эвлэрэх эрх байхгүй. Учир нь эвлэрэх үүдийг бид нээлттэйгээр нь үлдээж, эвсэн суугаад байвал мөнхийн асуудалтай сэдэв байсаар л үргэлжилнэ байх. Тэмдэглүүштэй нь сүүлийн үед эмэгтэйчүүд тэр тусмаа баруун европын эмэгтэйчүүд энэ эвлэрэн суух байдалтай эрс тэмцэж багагүй амжилт олж

¹ Сюзан Мендус / Susan Mendus/ нь Английн Ёркийн их сургуулийн улс төрийн философиин профессор юм. Тэрээр улс төрийн философиин асуудал болох тэвчээрийн тухай ихээхэн судалдаг бөгөөд, сүүлийн жилүүдэд феминизмийн тухай ихээхэн судлаж, хурцаар бичиж турвиж байгаа эмэгтэй юм. Профессор Мендус нь Их Британийн болоод бусад гадны орнуудын дунд нэрээрээ хаяглагдсан олон сонирхолтой илтгэл бичиж алдаршжээ. Сюзан Мендусийн бичсэн Ардчилал: төгсөөгүй аян номонд бичсэн “Итгэл алдрахуй: феминизм ба ардчилал” гарчигтай өгүүллээс хэсэгчилэн авсан нийтлэлийг уншаад энэхүү илтгэлийг бичсэн.

байна. Магадгүй европи эмэгтэйчүүдэд энэ эрхээ олж авах, тэмцэл хийх боломжоо арай эрт эхэлсэн нь ахуй амьдралтай нь ч холбоотой байх.

Яагаад эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд байр суурь, оролцоо нь бага байна вэ? яагаад эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөөд байна вэ? яагаад эмэгтэйчүүд эрчүүдийн нэгэн адил эрхээ тэгш эдэлж болохгүй байна вэ? гээд л олон асуултын цаана нэг л утга байдгийг мэднэ. Мэдээж энэ бол жендерийн асуудалтай тулдаг. Гэхдээ хариулт нь нэлээд янз бүрийн хариулт гардаг.

Жендер гэдэг үг ч хөгжлийн түүхэндээ хэрхэн хэрэглэгдэж ирсэн нь сонирхолтой байдаг юм.

Жендер нь англи хэлний *gender*, латин хэлний *genus* гэсэн үгнээс гаралтай бөгөөд ихэнхи утга нь төрөл, анги, янз, хэв маяг зэрэг утга агуулдаг. Ер нь 14 зуунаас хойш л жендер гэдэг үг эмэгтэй эрэгтэй хүйсийн тэгш эрхийн агуулгаар ашиглагдаж эхэлжээ¹. Гэхдээ энэ үгийн хэрэглээ бөгөөд одоогийн жендерийн утгыг агуулах талаар багагүй саад учирч байсныг дурдах хэрэгтэй. Магадгүй энэ бол хүйсийн тэгш эрхийн асуудал өөрөө асуудалтай тулгардаг байсны гэрч байх. Тухайлбал 1900 он гэхэд энэ үгийн хэрэглээ нэлээд тоглоом шоглоомоор хар ярианы харилцаанд хэрэглэгдэж байжээ. Тэрч байтугай 1926 онд Павловын орчин үеийн англи хэлний хэрэглээ номонд жендер бол зөвхөн хэл зүйн дүрмийн санд ашиглагдах үг болно гэж гарчээ. Мөн жендерийн өөр утга нь хүмүүсийн ярьдаг тэрхүү эмэгтэй эрэгтэй хүмүүсийн сексийн утгыг хар ярианд хэрэглэгддэг бүдүүлэг хэллэг мэтээр бичжээ.

Аристотелийн үзсэнээр Грекийн философич Протагораас анхлан хэл зүйн дүрмийн нэр үгсийн аймагт жендерийг эр үг, эм үг, саармаг гэсэн хүйсийн утгаар нь оруулж ирсэн байна.

Чухамдаа 1950аад оноос л нийгмийн шинжлэх ухааны зарим салбаруудад жендерийн тухай хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд 1980 он гэхэд жендер гэдэг үгийн хэрэглээ биологийн категорит хэрэглэхээсээ илүүтэйгээр нийгмийн ухаанд илүү хэрэглэх болжээ. Энэхүү жендер гэдэг үг одоо тайлбаргүйгээр хүйсийн тэгш эрхийн утгаар хэрэглэгдэж, басхүү нийгмийн шинжлэх ухааны нээлтийг ч нэгээр нэмж байгаа юм.

Миний бодлоор тэгш эрхээ эдлэх эмэгтэйчүүдийн боломж нь нэгэнт тэгш бус заяагдсан үүргээсээ улбаалан ялгаатай байдлаа хүлээн зөвшөөрүүлэхэд оршино гэж бодож байна. Хэрвээ ялгаа байгааг хүлээн зөвшөөрвөл, онцлон харгалзан үзэх учиртайг гаргаж өгөх. Сүүлийн үед алхам хийгдэж байгаа ч учир дутагдалтай байна. Тухайлбал нэгэн тодорхой жишээ дурдахад, жирэмслэлтийг өвчлөлтийн ижил үзэж, жирэмсний чөлөө авахыг өвчний улмаас эмчийн акт авахтай адилтган үзэх нь түгээмэл байдаг. Ингэсэнээр жирэмсэн эмэгтэйчүүд өвчтэй эсвэл хөдөлмөрийн чадвараа түр алдсан эрчүүдтэй утга нэгээр үзэж, тэдэнд тэгш байдал эдлүүлэх оролдлого нь угтаа тэднийг чадвараа алдсан эрчүүдтэй дүйцүүлэн үзэх үнэлгээнд суурилдаг.

Энэ стратегийн дагуу эмэгтэйчүүд жирэмсний тэтгэлэг авах, ШУТИС ийн шилдэг багш шалгаруулах төрөлд эмэгтэй багш нар гэж оруулж чадсан гэх зэргээр тэгш бус байдлын заримыг залруулж байгаа ба юу ч үгүй байснаас дээр. Гэхдээ тэтгэлэг нь практик утгаараа чухал авч эл стратеги нь уусган шингээх, эмэгтэйчүүдийн хүйсийн тэгш эрхийг хөндөж байдгийг нуух учиргүй. Эмэгтэйчүүд тэгш байдлын хувьд ахихдаа тэд болон эрэгтэйчүүдийн хоорондох ялгаанд эмэгтэйчүүд доогуур байдаг гэсэн санааг бий болгосон баримтлалыг тойрч бус, дайрч гардаг.

¹<http://en.wikipedia.org/wiki/Dictionary>

Улмаар энэ нь жирэмслэх хүүхэд төрүүлэх, ажил эрхлэхтэй холбоотой практик зохицуулалтын талаар гомдоллоод байгаа зүйл төдий биш юм.

Судалгаанаас харахад нийгэмд эмэгтэйчүүдийн байр суурь, оролцоо, ажил эрхлэлтийг аваад үзэхээр ихэнхи нь үйлчилгээний болоод үйлдвэрлэлийн шинжтэй бүтээлч ажлын салбарт эмэгтэйчүүд ажилладаг байна. Үнэндээ эрэгтэйчүүдийг бодвол илүү нягт нямбай гэж тайлбар хэлэх боловч чухамдаа эмэгтэйчүүд бол эрчүүдийн хамгийн найдвартай гүйцэтгэгч болоод байгаа юм. Хаана ч тэр аливаа асуудлыг шийдвэрлэх, шийвдэр гаргах үйл явцад эрчүүд голлож, түүний хүнд хүчирийг голлон нугалах хүч нь эмэгтэйчүүд болоод байна. Гэтэл тэрхүү ажлын ач гавъяа эрчүүдээр тодорч, эмэгтэйчүүдийн бүтээлч ажиллагаа нь хүний нүдэнд бага тусч, эрчүүдийнхээс ч багаар үнэлэгддэг.

Иймээс эмэгтэйчүүдийн итгэл алдархуй илээр хурц явагдахгүй байгаа ч далд нүүрлэсээр байна. Тодруулбал эмэгтэйчүүд эрчүүдийн адил ажил эрхлэлтийн боломж, нөхцөл, гавъяа шагналд хүрэх нь зарим нэгэн зүйлээсээ татгалзах алхамд хүргэдэг. Энэ нь эцэстээ далд байдлаар эмэгтэйчүүдийг дараах зүйлд хүргэж байна. /аборт ихсэх, хожуу төрөх, цөөн хүүхэд гаргах, гэрлэхгүй байх гэх зэрэг/

Жирэмслэлт, хүүхэд төрүүлэх гэдэг бол эмэгтэйчүүдийн хувьд ажлын байрны амжилтаа алдаж байгаатай утга нэг болоод байна. Нэгэнт чөлөө аваад /ЭМХуулинд зааснаар 2 жилийн чөлөө олгоно/ ирэхэд өмнө ажилласан түүний ажлын үр дүн шууд баларуулагдах болно. Дахин өөрийн ажлын чадвар чадамжаа цоо шинээр эхлэхэд үлдэнэ гэж ойлгож болно. Эсвэл амьдралын хуулиар явах процесоо /хүүхэд гаргахгүй байх, цөөн хүүхэдтэй байх, хүүхдээ гаргаад л шууд ажилдаа орох гэх зэрэг/ эвдэн байж эрчүүдийн адил амжилт гаргах үлдэнэ. Тиймээс үүнийг даван туулах арга зам нь нэгэнт байгаа ялгаатай байдлыг харгалзан үзсэн тусгай зохицуулалтыг шаардах хэрэгтэй юм.

Түүнчлэн олон зууны турш жендерийн технологийн үндсэн тулгуур нь хэл яриа, шашин, боловсрол хүмүүжил байжээ¹. Монголын эмэгтэйчүүд мэдлэг боловсролынхоо амжилтанд тулгуурлан мэргэжилтэй боловсон хүчний нөөцийн салшгүй хэсэг болжээ. Гэхдээ боловсролын шат ахих тусам хүйсийн тэгш бус байдал нэмэгдэж байгааг анхаарч үүнд эмэгтэйчүүдийн төрөлхийн чадамж эрчүүдийнхээс дор болохыг харуулж байна уу эсвэл нийгмийн болон өөр ямар нэг хүчин зүйл нөлөөлж байна уу? гэдгийг харьцуулан үзэх ёстой юм. Мөн эмэгтэйчүүд бид эрэгтэйчүүдийн тоглоом шоглоомын бай болох, үл хүндэтгэсэн байдал, бүдүүлэг үг ярианд нь өртөж байгаагаа мэдэхгүй өнгөрөөвөл үүний эсрэг хэдэнтээ ч оролдого хийгээд утгагүй юм. Хэрэв иймэрхүү дарангуйлалд өртөж байгаагаа мэдрэх л юм бол асуудалд бодитойгоор хандаж өөрийгөө хамгаалж сурах хэрэгтэй.

Үүнд жишээ болгож эмэгтэйчүүдийг дарангуйлдаг тоглоомд эрчүүд бас эмэгтэйчүүд ч дассан байдаг учир ухамсартайгаар болоод ухамсаргүйн түвшинд илэрдэг дараах Шведийн парламентын гишүүн асан Berit as-ын “Эмэгтэйчүүдийг дарангуйлах таван тоглоомын”² учирт сайтар дүгнэлт хийж, хандах хандлагыг ч өөр болгох учиртай юм. Үүнд:

1. Үзэгдэхгүй болгох: Аливаа шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүд санал бодлоо илэрхийлэхэд түүнд хариулт өгөхөөсөө илүүтэйгээр үл тоомсорлох, тоглоом тохуу хийж өнгөрөөх, санаа зоригийг нь мохоох, сарниулах зэрэг явдал түгээмэл харагддаг байна. Мөн

¹ Ардчиллын тухай түүвэр. Сюзен Мендус. Итгэл алдрахуй: феминизм ба ардчилал. УТБА. УБ. 2006. 30-35х

² С. Баасанбат “Жендер” гэр бүлийн харилцаанд нөлөөлөх нь. УБ. 2005 он. 31-35х

эмэгтэйчүүдийн эрх ашгийг хөндсөн баримт бичиг боловсруулахад ч тэдний оролцоо бага байхын зэрэгцээ голдуу эрчүүдийн үзэл бодол, боловсрол туршлаганд үндэслэгдэнэ. Энэ нь эмэгтэйчүүдэд үзэл бодлоо илэрхийлэхдээ өөртөө итгэлгүй болох, санаа зовох, дуугүй сууж, байгаа байхгүй нь мэдэгдэхгүй байдалд хүргэдэг байна.

2. Нэр хоч өгч тоглоом хийх. Тэдний нас, биеийн галбир, дуу хоолой, зан чанар, бие авч яваа байдлаар нь хандаж үнэлдэг. Мөн эмэгтэйчүүдийн амжилтанд хүрэх, албан тушаал ахих зэрэг нь хэн нэгэн эрх мэдэлтэй эрэгтэй хүнээс хамааралтайгаар “татаас дэмжлэгийн хүчинд” гарч ирсэн хэмээн бодох, бодуулах. Хэрэв хөгжилтэй зантай бол “сээтгэнүүр”, өөрийн үзэл бодлоо шууд хэлдэг, зарчимч бол “чөтгөр шулам” шиг гэх, бухимдалаа эсэргүүцэн илэрхийлэхэд “хэрүүлч, ховч, тулга тойрсон яриа ярьдаг” зэрэг нэр хоч өгөх нь тун төвөггүй байдаг. Харин эрчүүд ийм зан гаргах тохиолдолд “эмс хүүхнүүд шиг” хөгшин авгай шиг” гэж эмэгтэйчүүдтэй зүйрлүүлэн нэр өгдөг. Эсвэл бүр эсрэгээрээ ийм эрчүүд нь үзэл бодолдоо тууштай, зарчимч, хатуу байр суурьтай гэж дүгнэгдэх болно.
3. Мэдээллээс тусгаарлах. Эмэгтэйчүүд системтэй нягт мэдлэг мэдээлэл авахад эрчүүдтэй харьцуулахад амаргүй байдаг. Учир нь тэдний чөлөөт цаг нь ажил болон гэр бүлийн таатай орчин бүрдүүлэхэд зарцуулагддаг. Гэтэл эрчүүд шар айраг уух, биллард тоглох зэрэг үедээ хоорондоо чухал мэдээллээ солилцож амждаг байна. Энэ ч эрчүүд бие биенээ ойлголцох алхамд нэмэр болж, эмэгтэйчүүдэд бие биенээ үл ойлголцсон, хардсан, хов яригч болгож хувиргадаг.
4. Давхар ачааллаар дарах. Нэг талаас гэр бүлдээ “сайн ээж, сайн эхнэр” байх, нөгөө талаас ажилдаа очоод таны гэр бүлийн асуудал бидэнд хамаагүй, ажил чухал “сайн ажиллах, сайн ажилтан бай” хэмээн зэмлүүлж, давхар дарамт, шийтгэл зэмлэлд өртдөг. Энэ нь эмэгтэйчүүдэд аливаа зүйлд морь мэт зүтгэж, нохой мэт үнэнч байх шаардлагатай дүйж, тэдэнд стресс өгч, бусдаас ичих, бас гутрах, итгэл алдрач идэвхгүй зүгээр л “гүйцэтгэгч эмэгтэй” болоход хүргэдэг.
5. Буруушааж, ичмээр эвгүй байдалд оруулах. Эмэгтэйчүүд эрчүүдтэй мөр зэрэгцэн амжилт гаргаж, өөрийгөө илэрхийлэх хамгаалах боломж хягаарлагдмал байх шалтгаан байгааг үл харгалзан шууд л “муу байна” “Ямаа туйлаад янгиа эвдэхгүй, Янчгар хатан зарга шүүхгүй” хэмээн басамжлах нь эмэгтэйчүүдийг илт эрчүүдээс доогуур тавьж, тэдний мэдлэг боловсролд үл итгэх байр суурийг бий болгодог байна. Энэ нь тэднийг зүгээр л хий гэснийг хийгээд л явж байя, хошуу дүрэхээр хуруугаа дүрээд гэгчээр номхон гүйцэтгэгч болгоход хүргэдэг

гэх зэрэг бидний эргэн тойронд элбэг тохиох эрчүүдийн дээрэнгүй, басамжлах, бүдүүлэг сэтгэлгээг эмэгтэйчүүд бид хүрээндээ хааж боож, өөрийгөө хамгаалж сурахгүй бол уг жендерийн болоод феминимстүүд гэж шүүмжлэгдээд байгаа эмэгтэйчүүдийнхээ өмнө буруутан болно. Тиймээс ч орчин үеийн жендерийн судалгааны тулгуур технологи болсон боловсролтой хэсэг болох боловсролын салбарт ажиллаж буй бид бүхэнд эмэгтэйчүүд давамгайлсан давуу талаа ашиглан уламжлалт домгийн шинж бүхий жендерийн асуудалд эрс шүүмжлэн, нийгмийн хөгжил цэцэглэлтэнд оруулах хувь нэмрээ улам хүчтэй болгож “нийгмийн тогтсон дизайн” ийг өөрчлөх боломжтой юм.

Түүнчлэн жендерийн асуудлыг сайн засаглал, ардчиллын зарим онолчдын үзэл санаанд илэрхийлэгддэггүй бөгөөд гэхдээ сүүлийн үеүүдэд байнга гаргадаг үндэслэлүүдийн талаар санаа тавьж эхэлж байгаа юм. Ардчиллыг хөгжүүлэн бэхжүүлэхэд нийт хүн амын тал хувийг эзэлдэг эмэгтэйчүүдийн оролцоо зайлшгүй юм. Гэхдээ яагаад шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн байр суурь оролцоо бага байдгийг тодруулахад дараах зүйлийг дурдах болох нь.

Роберт Даль¹, ардчиллын талаар бичиж ирсэн бүх гол зохиогчид өөрсдийнхөө онолд эмэгтэйчүүдийг багтаадаггүй байсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн байх авч түүний хариулт нь аливаа философич амьдарч буй үеийнхээ бүтээгдэхүүн байдгийг л гэрчилж буй гээд, тиймээс бүх хүн гэснийг “эрэгтэй, эмэгтэй бүх хүн”, эсвэл бүх насанд хүрэгсэд” гээд солиод биччихвэл асуудал хялбархан шийдэгдчихнэ гэхгээд байдаг. Иймд бүх юм сайн сайхан болчихлоо гэдгийг тэмдэглэхийн тулд тэрээр ингэж бичсэн байдаг: “Ихэнхи оронд эмэгтэйчүүд сонгох эрхээ энэ зуунд л олж авсан байдаг ба зарим оронд эмэгтэйчүүд сонгох эрхээ дэлхийн II дайны дараа л олж авсан байдаг. Үнэхээр, бүх (эсвэл бараг бүх) насанд хүрэгсдийг эрхийнх нь хувьд бүгдийг нь демос дотор багтаах учиртай гэсэн итгэл үнэмшил манай зуун гарсны дараа ардчиллын онол, практикт тусгалаа олж эхэлсэн байдаг. Ингэж хэлсэнээр орчин үеийн ардчилсан улс орон дахь эмэгтэйчүүдийн ролийн тухай түүний яриа дуусгавар болчихож байгаа юм.

Цаад утгаараа, ардчиллын онолд эмэгтэйчүүд нь ердөө л нэгэн ерөнхий боловч засварлаж болохуйц асуудлын өвөрмөц жишээ л болдог. Тунхаг бичгийн гол зохиогч Томас Жефферсон ардчиллын онолд тэгш эрхийн тухай номлогч мөртлөө өөрөө боол эзэмшигч байсан ба эмэгтэйчүүдийн тэгш эрхийн асуудлыг анхнаасаа хүнд засагдсан тэгш байдалтай холбон тайлбарлаж байжээ⁶.

Феминистүүд үүнтэй санал нийлдэггүй бөгөөд²: Тэднийхээр бол эмэгтэйчүүд өөр байдаг нь эдийн засаг, нийгмийн эрх мэдэл байдаггүйтэй холбоотой бус, харин түүхийн туршид ардчилсан орны иргэний ангиллаас улаан цайм хасч ирсэнтэй холбоотой. Тиймээс иргэд гэгдэх хүмүүсийн эдийн засгийн эрх мэдлийг өргөжүүлэх нь ардчилалд чухал боловч эмэгтэйчүүдийг (хүүхэд, сэтэгцийн согогтой хүмүүсийн нэгэн адил) иргэний ангиллаас хасч ирсэн нөхцөлд тэдний эдийн засаг, нийгмийн эрх мэдлийг өргөжүүлэх асуудал ихэнхи тохиолдолд тавигдсаар ирсэн нь аргагүй. Үүнийг ардчилсан нийгэм дэх түүхэн баримтуудыг дэлгэж тавьсан байр суурь байна хэмээн үзэх нь түгээмэл авч угтаа ардчиллын онолыг шүүмжлэх гол үүр болох юм.

Тэгэхээр эмэгтэйчүүдийн итгэл алдрах явдал нь миний бодлоор дараах хоёр асуудалд илэрч байна гэж үзлээ. Нэгдүгээрт: феминистүүдийн үзэж буйн адил эмэгтэйчүүдийн амьдралыг бодитойгоор тусгахуйц улс төрийн онол бий болгож чадах эсэхэд итгэхгүй байгаатай холбоотой юм. Энэ асуудлын шийдэл нь уг ялгааг хүлээн зөвшөөрсөн, ялгааг багтаан агуулсан байдлаар ардчиллын онолыг шинэчлэн бичихэд оршино.

Хоёрдугаарт: хүмүүсийн харилцаанд элбэг тохиолддог эмэгтэйчүүдийн эрх, үзэл бодолд таатай бус хандах байдал нь тэдэнд итгэл алдрахуйн нигуур болж байна. Үүнд жендерийн механизм болсон боловсролын гүйцэтгэх үүрэг асар их бөгөөд боловсролтой, чадвартай эмэгтэйчүүд өөрсдөө даван туулах арга замаа хамтдаа тодорхойлж, үг дуугүй даган биелүүлэгч, хямд гүйцэтгэгч биш байх боломж байгааг дээрх жишээ баримтаар харуулахыг оролдов.

¹ Роберт Даль. Ардчиллын тухай. УБ. 2005. 56-61х.

² Ардчиллын тухай түүвэр. Сюзен Мендус. Итгэл алдрахуй: феминизм ба ардчилал. УТБА. УБ. 2006. 30-35х

Ном зүй

Роберт Даль. Ардчиллын тухай. УБ. 2005.

Современная политическая теория. М.2001.110-114стр

С. Баасанбат “Жендер” гэр бүлийн харилцаанд нөлөөлөх нь. УБ. 2005.

Ардчиллын тухай түүвэр УТБА. УБ. 2006.

<http://en.wikipedia.org/wiki/Dictionary>

ТӨРИЙН ЗҮТГЭЛТНИЙ СУДАЛГААНЫ АСУУДАЛД

Б.Долгор
доктор, дэд профессор
ШУТИС, ХУС, Улс төр-стратегии судлалын профессорын баг

Хураангуй

Төрийн зүтгэлтний асуудал бол хүний нийгэм дэх улс төр-сэтгэл зүйн шинж төлөвт түүхэн тодорхой үзэгдэл. Төрийн зүтгэлтэн нь нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагаар төрөн гардаг төдийгүй, тэдний үйл хэрэг тухайн нийгмийн хөгжлийн үр дагавар үнэт зүйл болон өвлөгдөж байдаг онцлогтой. Иймээс төрийн зүтгэлтний асуудлыг философийн шинжлэх ухааны үүднээс авч үзэхдээ "бие хүний" категорт тулгуурлан төрийн зүтгэлтний дүр төрх бүрэлдэхэд нөлөөлөх нийгмийн хүчин талаас нь, улс төр судлалын шинжлэх ухааны хувьд төрийн зүтгэлтний имиж, имижийн бүрэлдэлтэнд улс төрийн нам, олон нийтийн сонгууль, хэвлэл мэдээллийн хэрэгслэлийн гүйцэтгэх талаас нь, түүхийн шинжлэх ухааны хувьд намтар зүйн хөрөг талаас нь үзэх зэргээр олон шинжлэх ухааны уулзварт авч үзэх нийлмэл асуудал болов уу?

Түлхүүр үг: Уламжлал, бихевиоризм, арга барил, шийдвэр, тулх эрхэмсэг шинж

Түүхэн тодорхой соёл иргэншил бүр нь бие биенээсээ ялгагдах онцлогтой төрийн зүтгэлтнүүдийг төлөвшүүлэн хөгжүүлж ирсэн билээ.

Монгол оронд ардчилал шинэчлэл өрнөсний үр дүнд төрт ёсны уламжлал сэргэж, эрдэмтэд судлаачид төдийгүй ард түмэн нийгмийн ухамсарын энгийн түвшинд өнөөгийн төрийн зүтгэлтэн гэж хэн бэ? Тэд нийгэмд ямар үүрэг гүйцэтгэж байна? гэдэгт ихээхэн анхааралтай хандах боллоо.

Нөгөөтэйгээр "Шилдэг сайн" удирдагчийн тухай зохиомол домог маягийн төсөөлөл хүмүүсийн санаа сэтгэлийг эзэмдэж монголын их хаадын шинж төрхийг өнөөгийн төрийн зүтгэлтнүүдтэй харьцуулах замаар тэдний явуулж буй үйл ажиллагаанд эерэг, сөрөг байдлаар хандах, үнэлэлт дүгнэлт өгөхдөө туйлшрах байдал түгээмэл ажиглагдах байна.

Аливаа улс үндэстний хөгжлийн салшгүй асуудлын нэг бол тухайн нийгмийнхээ амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг субъектуудийг илрүүлэн тодруулах явдал билээ. Төрийн зүтгэлтэн бол нийгмийн сэтгэл зүйн харилцан

нөлөөлөлд тулгуурлан гарч ирсэн түүхэн тодорхой нөхцөлд, олон түмний нэгдмэл сонирхлыг илэрхийлэгч хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн өвөрмөц бие хүн юм.

Сэтгэгчдийн үзэл баримтлалаас үзэхэд төрийн зүтгэлтэн нь нийгмийн захиалгаар “усан дээрх навч” мэт өөрөө “хөвөн” гарч ирдэг тухай дурьдагдсан бий. /1/ Энэ нь хэдий анхаарууштай боловч төрийн зүтгэлтний дүр төрх бүрэлдэх үйл явц олон хүчин зүйлээс хамааралтай. Өөрөөр хэлбэл нийгмийн хөгжлийг өөд татах чин хүсэл, тодорхой эрх мэдлийг эзэмших, бусдаар өөрийгөө хүндлүүлэх, олны талархал хүлээх, хэрэгцээгээ хангах, амьдралаа сайжруулах зэргээс хамааралтай хэмээн үзэж болох бөгөөд энэ нь тэдний дотоод ертөнц рүү өнгийн харах хэрэгтэйг анхааруулж буй хэрэг.

Өнөөгийн нөхцөлд монголын төрийн зүтгэлтний уламжлалт дүр төрхийг судлах, социализмын үеийн төрийн зүтгэлтний эерэг, сөрөг шинж төрхийг анхааран үзэж сургамж авах, иргэний нийгмийн үеийн төрийн зүтгэлтнүүдийн дүр төрх бүрэлдэх онцлог, төлөвшил хөгжлийн асуудалд анхаарах нь нийгмийн амьдралд бодитой хандахад тодорхой ач холбогдол өгөх буй заа.

Төрийн зүтгэлтний судалгаа нь өнө эртнээс эх улбаатай. Ийм учраас эрдэмтэд мэргэдийн хийсэн судалгааны үр дүнтэй танилцах, нийгмийн тодорхой үе шатанд бүрэлдэн тогтсон бие хүний өвөрмөц дүр төрхийг судлан тэдгээрийн ололт дутагдлыг тунгаан үзэх шаардлагыг зүй ёсоор бий болгож байгаа юм.

13-р зуунаас үндэс суурь нь тавигдаж ирсэн Чингисийн алтан ураг судлал, нөхөд ба анд судлал зэрэг шилэгдмэл идэвхтэй бүлгийн судалгаанаас үзэхэд нүүдэлчин монголын язгууртанууд, алтан ургынхны нийгэм - улс төрийн дүр төрхийг товойлгон тодорхойлох явдал төрт ёсны салшгүй хэсэг байсаар иржээ. /2/

Манай орны хувьд төрийн зүтгэлтэн судлал нь орчин үеийн утгаараа төдийлэн хөгжөөгүй хэдийч энэ талаар түүхийн сурвалж, судалгаа арвинтай бөгөөд тэдгээрийг нэгтгэн дурьдвал:

1. Монголын төр улс, хаадын түүх, цадиг шастирууд
2. Гүн ухаан, шашны бүтээлүүд
3. Археологи, угсаатны зүйн материалууд
4. Хууль цаазны эх сурвалжууд
5. Гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээл, аялагчдын дурсамж , тэмдэглэл
6. Түүхэн уран зохиол зэргийг нэрлэж болно.

Аливаа төрийн зүтгэлтний судалгаа нь ямагт тухайн цаг үедээ шинэлэг бөгөөд хүн төрөлхтний мэдлэгийн санд өвөрмөц хувь нэмрийг оруулсаар иржээ.

Одоогоор төрийн зүтгэлтний судалгааг дараах хоёр түвшинд ангилан үзэж байна.

1. Төрийн зүтгэлтний загварыг онол-арга зүйн түвшинд боловсруулах
2. Хэрэглээний чиглэлээр эмпирик судалгаа хийх гэсэн үндсэн хоёр чиглэлээр хөгжиж байна.

Дээрх судалгааг харьцуулж үзвэл тоо хэмжээний хувьд эмпирик судалгаа нь давамгайлж байдаг. Энэ нь нийгмийн сэтгэлгээний хамгийн түгээмэл хэлбэр болох “бусдад дүн тавих”-тай холбоотойгоор уг төрийн зүтгэлтнийг төрийн өндөрлөгөөс нь буусны дараа түүний үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч ирсэн байна.

Нөгөөтэйгээр ямар нэгэн судалгааны үр дүн нэг талаар цаг хугацааны бүтээгдхүүн учраас энэ утгаар нь төрийн зүтгэлтний судалгааг эртний, дундад, орчин үеийн гэж хувааж болох юм.

Эртний үед хаад, язгууртнуун сурвалжтнуудын намтар зүйд тулгуурласан “аугаа их хүний” үзэл санаа зонхилон хөгжиж байв. Иймээс тухайн үеийн судалгаа нь домог зүй, шашин, түүхэн хандлагуудад тулгуурлан хөгжиж байв. Сурвалжаас үзэхэд монголын төр ёсны эртний сэтгэлгээнд ч ийм хандлага олонтоо ажиглагддаг. Жишээ нь: Сүмбийн удирдагч Таньшихуайгийн эх мөндөр залгиснаас түүний төрүүлсэн домог, Алунгоо эх Нируны дээд өвгийг гэрлийн туяанаас хэвлийдээ олсон зэрэг домгийн үзэл санаа нь нь тухайн цаг үеийн удирдагчидийг гүрэн улсаа нэгтгэн захирах “дээд тэнгэрээс заяат” гэдгийг тайлбарлахтай холбоотой нийгмийн сэтгэлгээний үр дүн юм.

Дундад үед төрийн зүтгэлтнийг хувийн шинж төрх, шашны үнэт зүйлс, бүтцийн онолуудаар голлон тайлбарлаж иржээ. Иймээс хаад ноёдуудын удам угсаа, эрх ямба, байр суурь, шилдэг шинжүүдийг тайлбарлахад ихэвчлэн анхаарч байлаа.

Орчин үед төрийн зүтгэлтний судалгаа олон шинжлэх ухааны зааг дээр хөгжих болсныг дээр дурьдсан билээ.

Орчин үед төрийн зүтгэлтний судалгаанд доорхи түгээмэл хандлага байгааг авч үзье. /3/

1. Сэтгэлгээн дэх “уламжлалт хэв маяг”-ийн хандлага. Энэ нь тухайн улс үндэстний ёс заншилд тулгуурласан удам гарлаар шинжих ёс. М.Веберийн боловсруулсан сонгодог хэв шинжийн тухай үзэл баримтлал буюу харизматик, уламжлалт, рациональ удирдагчийн тухай асуудал юм.
2. Ерөнхий зэрэглэлийн шинжилгээ. Энэ чиглэл нь төрийн зүтгэлтний асуудлыг судлахдаа засаглалын институтцийг голчлон анхаардаг.
3. Бодьгалын намтар зүйн хандлага. Иж бүрнээр бичигдсэн үнэн бодит намтрыг судлан шинжлэхэд голлон анхаарах зэрэг болно.

Манай орны хувьд төрийн зүтгэлтний судалгаа нь ерөнхийдөө ажил хэргийн хүрээгээр хязгаарлагдаж гүйцэтгэх засаглал, төр засгийн үйл ажиллагаанд тухайн бие хүний гүйцэтгэж ирсэн түүхэн үүргийг судлахад голлон анхаарч ирсэн.

Төрийн зүтгэлтний судалгаанд байгаа нийтлэг дутагдал бол элит, лидерт хэтэрхий анхаарал тавиад энэ нь бүлгийн харилцаанд хамаарах асуудал гэдгийг орхигдуулдаг явдал юм. Уламжлалт төр ёсны жаягт их хаадын шадар туслахууд, түшмэл, тайж нар, цэргийн жанжид зэрэгт анхаарал ихээхэн тавьж байсан нь дээр дурьдсан бүлгийн асуудалд анхаарч байсныг харуулж байна.

Өнгөрсөн зуунд төрийн зүтгэлтний талаар хэд хэдэн үзэл баримтлал боловсрогдон хөгжиж ирсний хамгийн түгээмэл баримтлал нь бихевиоризмын арга зүйн асуудал юм. Энэ арга нь хүмүүсийн зан байдал, харилцаа, үйлдлээр төрийн зүтгэлтний шинж төрхийг тодорхойлох, тайлбарлах хандлагатай.

Хоёр дахь гол үзэл баримтлал нь дагачдын сэтгэл зүйн онол. 1930-аад оноос К. Левин, Р. Липпит, Р.Вайт нар төрийн зүтгэлтнүүд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ дагачдаа доорхи арга барилийг хэрэглэн удирддаг хэмээн үзжээ.

1. Авторитари арга барил. Төрийн зүтгэлтэн шийдвэр гаргаж, дагачдаа чанд хянахыг үйл ажиллагааныхаа гол механизм болгон хэрэглэдэг. Мөн түүнчлэн ажиллах нөхцөлийг нь бүрдүүлэх, хүнээ зөв сонгох, үүрэг даалгаварыг оновчтой хуваарилах зэргийг зайлшгүй нөхцөл хэмээдэг.

2. Ардчилсан арга барил. Төрийн зүтгэлтэн аливаа асуудлыг оролцооны арга хэлбэрээр шийдвэрлэхийг голчилдог. Өөрөөр хэлбэл хүн бол угаасаа ажилсаг, санаачилга идэвхтэй учраас удирдлагын зүгээс нөхцлийг бүрдүүлээд өгвөл бүтээж туурвих чадвартай гэж үздэг.
3. Чөлөөт уян хатан арга барил. Төрийн зүтгэлтэн аливааг эхлэх санаачлагыг өдөөх, сэдэл тэмүүллийг төрүүлэхийг анхаардаг. Энэ нь нийгмийн амьдралд хүмүүсийн бие даасан сэтгэлгээг нэмэгдүүлж идэвх зүтгэлийг нь өрнүүлдэг гэж үздэг.

Төрийн зүтгэлтний талаархи гурав дахь үндсэн үзэл баримтлал нь нөхцөлт хошуучлалын онол юм. Хошуучлагчийн шилдэг шинж чанарууд, арга барилд тулгуурлан төрийн зүтгэлтний шинж төрхийг судлах арга юм. Ф.Фрейдлерийн онолоор ардчилсан ба ардчилсан бус дэглэмтэй улс орны төрийн зүтгэлтний гаргаж байгаа шийдвэр нь уг төрийн зүтгэлтний мөн чанарыг тодорхойлно гэж үзсэн.

Ардчилсан бус шинж				Ардчилсан шинж		
Төрийн зүтгэлтэн шийдвэрээ өөрөө мэдэж гаргадаг	Төрийн зүтгэлтэн шийдвэрээ худалдаг	Төрийн зүтгэлтэн саналаа хэлээд асуудал тавихыг хүсдэг	Өөрчилж болох шийдвэрийнхээ төслийг танилцуулна	Шийдвэрлэх асуудлыг танилцуулаад шийдэж болох саналуудыг авч шийдвэрээ гаргадаг	Шийдвэр гаргах хүрээг тодорхойлох шийдвэрийг дагагчид гаргана	Төрийн зүтгэлтэн тодорхой хүрээнд дагагчдаар чөлөөтэй шийдвэр гаргуулдаг

Төрийн зүтгэлтний үйл ажиллагааг тодорхойлох нь улс төрийн үйл явцын гол зангилаа асуудлын нэг бөгөөд энэ нь нийгэмшилтийг системчлэлийн аргаар судлахад хүргэдэг. Төрийн зүтгэлтний шинж төрхөд нөлөөлөх нийгмийн хүчин зүйлийг авч үзвэл:

1. Нийгмийн хөгжлийн түвшин
2. Улс төрийн системийн төлөв байдал, бүрдэл
3. Улс төрийн соёл, хэм хэмжээ зэрэг болно.

Нийгмийн амьдралыг зохион байгуулна гэдэг бол хүний үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг төдийгүй үүрэг юм. Энэ үүрэг нь хүний өөрийнх нь үйл ажиллагаа, зан байдал, араншин, үзэл бодол, авьяас билэг, боловсрол, идэвх санаачлага, зоригийн шинж зэргээр дамжин төрийн зүтгэлтний төрхийг бүрдүүлэх боломжуудыг үүсгэдэг.

Бие хүний төрөлхийн чадварууд, сэтгэл зүйн давуу чанарууд, бусадтай адилсгах болон ялгарах шинжүүд нь тодорхой харьцаанд оршин байж сая манлайлан тэргүүлэх ажиллагааны дүр төрх болон тодордог ажээ. Бие хүний шинж чанар нь нийгмийн хэрэгцээнд тохирч байвал тэрээр субъектлэг чанар ихтэй төдийгүй зохистой, хүчтэй илэрдэг байна. /4/

Иргэний ардчилсан нийгэм өөрөө төрийн зүтгэлтний үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч баталгаажуулах нийгэм-улс төрийн таатай нөхцөл юм. Аливаа төрийн зүтгэлтэн нийгмийн шалгуураар шалгагдаж ард түмнээс дараах нөхцлөөр хүлээн зөвшөөрөгддөг болов уу?

1. Үзэл санааны нөхцөл. Нийгмийн гишүүд плюралист үзэл санаагаар харилцан хүлээн зөвшөөрч байгаагийн бодит илэрхийлэл. Энд төрийн зүтгэлтэн бол үзэл бодлоороо нэгдсэн бүлгийн “эцэг” болж байдаг. Иймээс төрийн зүтгэлтэн хүн тухайн тодорхой нөхцөл байдалд юу нь зөв болохыг тодорхой мэдрэх, нийгэм-улс төрийн хэм хэмжээг дагах төдийгүй, бусдыг зөв шийдэлд хүргэхэд нь тус дөхөм болох төрөлхийн соргог мэдрэмж туршлага, зөн билэгтэй байх ёстой ажээ.

2. Иргэний нөхцөл. Нийгмийн улс төрийн тогтолцоотой давхцсан юмуу, эсвэл “тогтолцооны доторхи тогтолцоо” маягтай иргэдийн нийгмийн ухамсар, улс төрийн соёлын түвшингийн тогтсон хэв маягаас хамаардаг. Ард түмэн дээрх засаглагч субъектуудыг иргэнлэг шинжтэй байхыг шаарддаг.

3. Үйл ажиллагааны нөхцөл. Иргэний нийгмийн “гүйцэтгэгч” субъект болох төрийн зүтгэлтнүүдийн үйл ажиллагаа нь нийгмийн амьдралын бүхий л салбарт хүрч ажиллах бодит боломж хэр байгааг, тэднийг явуулж буй үйл ажиллагаа хэр үр ашигтай байгааг илэрхийлж байдаг.

4. Арга барилын нөхцөл. Шийдвэр гаргах, хэрэгжүүлэх явц дахь арга механизмын тал юм. Нийгмийн бүлгүүдийн сонирхол байнга хувьсан өөрчлөгдөж байдаг тул нийгэмшилт, бүтээлч үйл ажиллагааны үр дагавар болон илэрдэг. Иймд төрийн зүтгэлтэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ нийгэм - улс төрийн үйл явцын олон шинж төлвийг өөрийн мэдлэг боловсрол, амьдралын туршлага, арга барилдаа тулгуурлан явуулдаг.

Өрнийн улс төрийн үзэл санаанд төрийн зүтгэлтнийг байгалийн саад бэрхшээлийг даван туулж зогсоолдоо хүрэхийг тэмүүлж буй хөлөг онгоцны ахмадтай зүйрлэсэн байдаг бол монголчууд тэр “төрийн хөлөг онгоц”-ыг залуурдахдаа төр ёсны уламжлалыг чанд хадгалсан төрийн гүйх ухаан /хар ухаан/, тулх шинж, эрхэмсэг чанарыг нь өөрийн удирдлагын гол хэмжүүр болгож ирсэн түүхэн уламжлалтай. Өөрөөр хэлбэл манай эх сурвалжуудад “ажил үйлийн дүр”-ийг голлон үзэж функциональ хандлагад тулгуурлан төр, цэргийн зүтгэлтнүүдийн үйл ажиллагаанд ёс жаяг, нарийн чанд дэг, эмх журам, зэрэг дэв, авъяас чадварыг харгалзан үзэхийг үйл ажиллагааны механизм гэж үздэг./5/

Төрийн зүтгэлтэн бол өөрийн засаглалтай дээд түвшингийн өвөрмөц дүр болохынхоо хувьд энэ дүрийн эзэн байна гэдэг хэн хүнд тохиодог хувь тавилан биш юм. Төрийн зүтгэлтэний эрхэмлэн үзэх бүх шинжийг агуулсан ямар нэгэн сул талгүй тийм бодит хүн амьдралд байдаггүй боловч төрийн хүн “алдаа гаргах эрхгүй” байх ёстой.

Түүхэн сурвалж, хаадын цадиг, дээдсийн угийн бичгүүд дэх төрт ёсны үнэт эх сурвалжуудыг цаашид нарийвчлан судалж, сэргээн хөтлөх нь монголчууд бид төрийн уламжлалыг хадгалан бэхжүүлэх, төр улсаа хөгжүүлэх, төрийн ёс жаягаа дээдлэхэд чухал ач холбогдолтой болох буй заа. Ер нь уламжлалт төрт ёсны үед түүхэн бичлэг нь төрийн албаны шаардлагаар гол төлөв хийгдэж байсан бөгөөд дэлхий дахинаараа глобалчлагдаж байгаа орчин үед төрийн зүтгэлтний судалгааг улам бүр хөгжүүлэх нь онол - арга зүйн төдийгүй төр улсын тусгаар тогтнолын асуудалд чухал ач холбогдолтой болно хэмээн үзэж байна.

Ном зүй

Монголын төрийн байгуулал улс төрийн сэтгэлгээний хөгжил. 1,2-р дэвтэр УБ.,1995 /1/

Ч. Жүгдэр Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг. УБ., 1990 /2/

Л.Пүрэвдорж Улс төрийн хошуучлал бол Монголын төрт ёсны чухал бүрдэл мөн. ШУА-ийн мэдээ . 1994 . 14 /3/

Г.Киссенжер Удирдагч нарт хэрэгтэй сургамж “Бодрол бясалгал “ сэтгүүл.1992 16 34-37 дахь тал /4/

Блондель .Ж. Политическое лидерство М., 1992 /5/

Ч. Жүгдэр 19-20-р зууны зааг дахь Монголын нийгэм улс төр философи сэтгэлгээний хөгжил. УБ., 1972

Ч. Лхагважав Дарангуйлал Авторитаризм УТБА Лекцийн эмхтгэл 1995 12 20-48 дахь тал

П. Наранцэцэг Улс төрийн манлайлалын тухай Шинэ толь . 1997 12 36-40 тал

Р.Эрдэнэбаатар Монголын төрийн түшээ бэлтгэж байсан уламжлалаас . “Шинэ толь” 1995 11, 36-39 дахь тал

Авцинова.Г.В Политическое лидерство “Государство и право “ 1993, 15

Дай. Р. Т, Зиглер. Х . Л Демократия для элиты. М ., 1984

Дашпүрэв Д. Этапы модернизаций монгольского общества М . .,1995

УЛС ТӨР СУДЛАЛЫН СУРГАЛТЫН АГУУЛГА, ХӨТӨЛБӨР: СӨҮЛИЙН ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР

Ж.Төртогтох
доктор, дэд профессор
МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

Оршил

Энэхүү өгүүллээр БНСУ-ын Сөүлийн Үндэсний Их Сургуулийн Нийгмийн шинжлэх ухааны коллежийн сургалтын агуулга, цар хүрээ, түүн дотроо улс төр судлалын салбарын сургалтын буюу зааж буй хичээлүүд, тэдгээрийн агуулга зэрэг асуудлыг авч үзэх болно.

Эхлээд, Сөүлийн Үндэсний Их Сургуулийг товч танилцуулъя. БНСУ-ын Сөүлийн Үндэсний Их Сургууль нь 1946 оны 8 дугаар сарын 22-ны өдөр байгуулагдсан бөгөөд статусын хувьд үндэсний буюу бидний хэвшсэн ойлголтоор улсын сургууль юм. Шанхай Жиао Тонг Их Сургуулийн дэргэдэх Дээд Боловсролын Хүрээлэнгээс гаргасан дэлхийн их сургуулиудын чансааг зэрэглэх олон шалгуурт аргачлал бүхий судалгаагаар Сөүлийн Үндэсний Их Сургууль нь үндэсний рейтингээр 1-т, Ази Номхон далайн бүс нутагтаа 9-т, дэлхийн их сургуулиудаас эхний 100-д багтан орсон байна. (Institute of Higher Education, Shanghai Jiao Tong University)

Сөүлийн Үндэсний Их Сургуулийн хичээлийн шинэ жил 3 дугаар сарын 1-нд эхлэх бөгөөд бүртгэл нь 2 дугаар сарын сүүлээр явагдаж дуусдаг. Хичээлийн жилийн эхний өдрүүдэд нээлттэй хичээлүүд явагдаж, энэ үеэр оюутнууд хичээлийн сонголтоо хийж, хувийн хичээлийн төлөвлөгөө, хуваариа гаргаж авдаг.

Сөүлийн Үндэсний Их Сургуулийн сургалтын нэг онцлог нь зуны сургалтыг албан ёсоор зохион байгуулан явуулдаг бөгөөд энэ үеэр хичээл

сонгон судлахаар бүртгүүлсэн оюутнууд судалсан хичээлээ кредитдээ тооцууж болдог байна. Зуны сургалт, хичээлийн бүртгэл 5 дугаар сарын эхээр явагддаг.

Хичээлийн жилийн эхний семестрийн хичээл 6 дугаар сарын сүүлээр дууссанаар зуны амралт эхлэнэ. Мөн энэ үеэр зуны сургалт эхэлдэг. Зуны сургалт 7 дугаар сарын сүүлээр хичээллэж дуусна. Хичээлийн жилийн 2 дугаар семестр намар эхлэх ба бүртгэл нь 8 дугаар сарын сүүлчээр явагдаж дуусна. 2 дугаар семестрийн хичээл 9 сарын 1-нд эхлэх ба эхний долоо хоногт багтааж оюутнууд анги, хичээлийн сонголтоо хийж дуусгадаг. Өвлийн амралт 12 дугаар сарын сүүлээр эхлэнэ.

Тус сургуулийн Нийгмийн Шинжлэх Ухааны Коллеж нь 1975 оны 7 дугаар сард үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд тус улсын анхны нийгмийн ухаанаар төрөлжсөн коллеж болжээ.

Нийгмийн Шинжлэх Ухааны Коллежэд нийгмийн ухааны олон хүрээ салбарыг хамарсан эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулдаг хүрээлэн төвүүд харьяалагдан ажилладаг байна. Тухайлбал, Нийгмийн ухааны төв, Нийгмийн хөгжил ба бодлого судлалын хүрээлэн, Эдийн засгийн судалгааны хүрээлэн, Харилцаа холбооны судалгааны хүрээлэн, Олон улс судлалын төв, Солонгосын бүс нутаг судлалын хүрээлэн, Сэтгэл зүйн шинжлэх ухааны хүрээлэн, Жендэр судлалын хүрээлэн зэргийг энд дурьдаж болно. Эдгээрийн зэрэгцээ, Нийгмийн ухааны төв нь дотроо Соёл судлалын хүрээлэн, Солонгосын улс төр судлалын хүрээлэн, Нийгмийн Халамжийн Хүрээлэн ба Дэлхийн эдийн засгийн хүрээлэн зэрэг нэгжүүдийг багтаадаг байна.

Нийгмийн шинжлэх ухааны коллежийн удирдлага нь декан ба хоёр орлогч деканаас бүрдсэн деканы газар юм. Одоо тус коллежийн деканаар профессор Пак Сам Ок, орлогч деканаар профессор Хонг Ки Хюн, Квон Сокман нар ажиллаж байна. Орлогч деканы нэг нь сургалтын асуудал нөгөө нь оюутны асуудал тус тус хариуцан ажилладаг.

Өмнө дурдсан судалгаа, эрдэм шинжилгээний төв, хүрээлэнгүүдээс гадна Улс төрийн шинжлэх ухаан, Олон улсын харилцаа, Эдийн засаг, Социологи, Антропологи, Сэтгэл судлал, Газар зүй, Нийгмийн халамж, Мэдээлэл холбооны гэсэн нийт 9 тэнхим ажилладаг байна.

Одоо Улс төрийн шинжлэх ухааны тэнхимийн үүсэл, хөгжлийн түүх, эрдэмтэн багш нарын бүрэлдэхүүн, сургалт судалгааны онцлог, үндсэн чиглэл зэрэг асуудлыг дэлгэрүүлэн авч үзье.

Улс төрийн шинжлэх ухааны тэнхимийн бүтэц, бүрэлдэхүүн, сургалт, судалгааны чиглэл

Улс төрийн шинжлэх ухааны тэнхим нь Сөүлийн үндэсний Их Сургуультайгаа нас чацуу буюу тус сургууль 1946 онд анх үүсэн байгуулагдахад үйл ажиллагаагаа эхэлсэн ууган тэнхмүүдийн нэг юм. Тус тэнхим үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөг хүртэл улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны гол төв байсаар ирсэнтэй холбоотойгоор БНСУ дахь улс төрийн шинжлэх ухаан тус тэнхимтэй салшгүй уялдаатай хөгжиж иржээ.

Улс төрийн шинжлэх ухааны тэнхимийн сургалт, судалгааны чиглэл, сонирхол өнгөрсөн хугацаанд хэд хэдэн удаа өөрчлөгдөж ирсэн байна. Тухайлбал:

1. 1960-аад оныг хүртэлх буюу тэнхим байгуулагдсан эхний жилүүдэд, тэнхимийн багш нар гол төлөв өрнөдийн улс төрийн сэтгэлгээ,

нийтийн эрх зүй, өрнөдийн орнууд дахь улс төрийн институтууд, улс төрийн түүх, эдийн засаг зэрэг хичээлийг зааж байжээ.

2. 1960-1970 аад оны үед тэнхим үйл ажиллагааны хувьд шинэ үе шатанд шилжсэн гэж болох юм. Энэ үеийг сургалтын агуулга, кинрикулум ба судалгааны чиглэл, зорилгын аль аль нь америкийн улс төрийн шинжлэх ухааны нөлөөнд хэт автсан үе гэж болно. Чухамхүү, энэ үед гол төлөв америкийн их сургуулиудад докторын зэрэг хамгаалсан бөгөөд харьцуулсан улс төрөөр мэргэжсэн, модернизаци ба улс төрийн хөгжлийн онолын асуудлаар мэргэжсэн шинэ багш нар солонгосын улс төрийн шинжлэх ухаанд биевиорализмийг нэвтрүүлсэн гэхэд болно.

3. 1970-аад оны сүүл үеэс тэнхим улс төрийн эдийн засгийн чиглэлээр сургалт судалгааны ажилд гол анхаарлаа хандуулж ирсэн байх юм.

Нийгэм, хүмүүнлэгийн ухааны бусад тэнхмүүдтэй судалгааны төсөл, салбар дундын сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох тал дээр тэнхим идэвх санаачлагатай ажиллаж ирсэн юм. Түүнчлэн, мэргэжлийн болон эрдэм шинжилгээний хувьд дээд зэргийн боловсон хүчнээр хангаж ирсэн билээ.

Одоо улс төрийн шинжлэх ухааны тэнхимд 11 багш ажиллаж байгаа бөгөөд бакалаврын болон магистр, докторын сургалттай уялдсан 6 дэд салбарт ажиллаж байна. Эдгээр 6 дэд салбар нь:

- Улс төрийн сэтгэлгээ, улс төрийн философийн дэд салбар
- Улс төрийн онол ба арга зүйн дэд салбар
- Харьцуулсан улс төрийн дэд салбар
- Улс төрийн үйл явцын дэд салбар
- Солонгосын улс төрийн дэд салбар
- Олон улсын улс төрийн дэд салбар зэрэг болно.

МУИС-ийн НШУС-ийн улс төр судлалын тэнхмийн санаачилгаар тус тэнхим болон НШУС-ийн социологийн тэнхмийг хамруулсан “Нийгмийн ухааны сургалтыг боловсронгуй болгох төсөл”-ийн хүрээнд хийгдсэн нэг ажил бол тэнхим тус бүрийн дотоодод болон хамтын бүрэлдэхүүн бүхий дэд салбаруудыг байгуулан ажиллуулсан явдал юм. Тэдгээр дэд салбарууд нь тухайн салбарын хүрээнд оюутнуудыг илүү мэргэшүүлэн бэлтгэх зорилгоор байгуулагдсан бөгөөд дэд салбаруудын нэр, чиглэл зэрэг нь дээр дурьдсан Сөүлийн Үндэсний Их Сургуулийн улс төрийн шинжлэх ухааны тэнхмийн дэд салбаруудтай төстэй байгаа юм. Өөрөөр хэлбэл МУИС-ийн НШУС-ийн төслийн хүрээнд хэрэгжүүлсэн дэд салбарын үйл ажиллагаа нь олон улсын жишгийг харгалзсаны нэг нотолгоо нь энэ болж байна. Гэхдээ дэд салбарын байнгын ажиллагаа, хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, мэргэшүүлэх хичээлийн болон дагнасан судалгааны ахиц дэвшлийн хувьд Сөүлийн Үндэсний Их Сургуулийн жишгийг анхаарахад илүүдэхгүй мэт.

Одоогийн байдлаар тус сургуулийн улс төрийн шинжлэх ухааны салбарт бакалаврын шатанд 160 оюутан, магистр, докторын шатанд 50 магистрант, докторант тус тус суралцаж байна. Оюутны болон багшлах боловсон хүчний бүтэц бүрэлдэхүүний хувьд МУИС-ийн улс төр судлалын салбартай харьцуулахад бакалаврын шатанд суралцагсадын тоо цөөн боловч магистр, докторын оюутны тоо хэд дахин илүү байгаа юм. Энэ нь их сургуулийн гол шалгуурын нэг болох төгсөлтийн дараах шатны сургалт, судалгаанд ихээхэн ач холбогдол өгдөг болохын нэг илрэл болов уу.

Салбарын бүрэлдэхүүн, сургалтын агуулгын уялдаа холбооны хувьд СҮИС-ийн улс төрийн шинжлэх ухааны тэнхим профессорын системд тулгуурласан зохион байгуулалттай. Профессорын дагнасан судалгааны үр дүн тухайн мэргэшүүлэх дэд салбар болон оюутны хичээл ба профессор

сонголттой нягт холбоотой байдаг байна. Профессоруудын судалгааны чиглэл нь тэдгээрийн урьд өмнө хийсэн улс төрийн шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаанууд, эрдмийн зэрэг хамгаалсан чиглэл, одоо удирдаж буй судалгааны төслүүд зэрэгт үндэслэгддэг. Тухайлбал, тус тэнхмийн профессор бөгөөд СҮИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны коллежийн Солонгосын улс төр судлалын хүрээлэнгийн захирал профессор Пак Чан-Үгийн хувьд докторын зэргээ парламентын сонгуулийн асуудлаар хамгаалан одоо энэ чиглэлээр дагнан судалгааны ажлаа хийж байна.

СҮИС-ийн улс төрийн шинжлэх ухааны тэнхмийн сургалт, заагддаг хичээлийн агуулгыг бакалавр, магистр, докторын шат тус бүрээр дэлгэрэнгүй авч үзье.

Бакалаврын сургалтын агуулга, онцлог

Бакалаврын шатанд үздэг хичээлүүдийг дараах хэд хэдэн бүлэгт ялган авч үзэж тайлбарлая. Дашрамд хэлэхэд эдгээр бүлэг ангилал нь тухайн сургуулийн хичээлийн агуулгыг зааглан ялгасан албан ёсны ангилал биш юм.

Улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүй. Энэ хэсэгт хамаарах хэд хэдэн хичээлийг үзэж судалдаг. Эдгээр хичээл нь улс төрийн шинжлэх ухаанаар цаашид үргэлжлүүлэн суралцах, улс төр судлаачаар улам мэргэшихэд гол үндэс суурь нь болдог байна.

1. Улс төрийн шинжлэх ухаан I, II. Тус хичээлээр оюутнууд улс төрийн шинжлэх ухааны онолын үндсийн талаар суралцана. Ингэхдээ эхний семестрт улс төрийн үйл явц, улс төрийн бодлогын онолууд, улс төрийн философи, харьцуулсан улс төр ба Солонгосын улс төрийн үндсэн онолуудыг авч үзэхэд сургалтын агуулга чиглэгдэнэ. Хоёр дахь семестрт олон улсын бодлогын онолуудыг авч үзнэ. Энэ хичээлийг нэгдүгээр курсэд ордог.
2. Улс төрийн шинжлэх ухааны судалгааны аргууд. 1960-аад оны үед, бихевиоризм улс төрийн шинжлэх ухаанд хувьсгал гаргасан гэж болох юм. Үүнтэй холбоотойгоор, улс төр судлаачид системийн арга хандлагыг сонгон авсан гэж болно. Энэ хичээлээр оюутнуудад бихевиоризмын үндсийг заадаг.
3. Орчин үеийн улс төрийн онолууд. Орчин цагийн нийгмийг танин мэдэх, тайлбарлахад чиглэгдсэн улс төрийн онол, парадигмуудын талаар энэ хичээлээр үзэж судлана.
4. Үзэл суртал. Улс төрийн гол үзэл суртлуудын талаар авч үздэг.
5. Нийгэм, улс төрийн орчин үеийн онолууд. Орчин үеийн нийгэмд дүн шинжилгээ хийхэд оюутнуудыг сургах нь энэ хичээлийн гол зорилго юм.
6. Улс төрийн шинжлэх ухааны сэдвүүд. Дэлхий ертөнц улам бүр өөрчлөгдөн хөгжиж байгаа шиг улс төрийн шинжлэх ухаан ч мөн адил хурдацтай өөрчлөгдөж байна. Улс төрийн шинжлэх ухааны шинэ шинэ онолуудыг ойлгох, танин мэдэхийн чадвартай байхын тулд оюутнууд өргөн хүрээтэй мэдлэгтэй байх хэрэгтэй.
7. Улс төрийн хөгжлийн онолууд. Дэлхийн II дайны дараа олон улс орнууд шинээр тусгаар тогтнон, улмаар модернизацилагдаж ирсэн билээ. Энэ хичээлээр гуравдагч ертөнцийн гэгдэх орнуудын туршлагад үндэслэн модернизацийн олон янзын хэв шинжид анализ хийх юм.
8. Улс төрийн эдийн засаг. Улс төрийн эдийн засгийн онолын талаар энэ хичээлээр үзнэ.

9. Төрийн онол. Төрийн үүсэл, чиг үүрэг, төрийн онолын сургаалуудын талаар авч үзнэ.

Улс төрийн сэтгэлгээ, улс төрийн философи. Энэ хэсэгт хамруулж болохоор дараах хичээлүүдийг үзэж судалдаг. Үүнд:

1. Өрнөдийн улс төрийн сэтгэлгээ. Хүн төрөлхтний зан байдал, хүний нийгмийн шилдэг загвар, хэлбэрийн талаарх өрнөдийн гүн ухаанчдын үзэл сэтгэлгээг танин мэдэх нь тус хичээлийн зорилго юм.
2. Дорнын улс төрийн сэтгэлгээ. Зүүн Азийн соёлын нэгэн хэсэг болох Солонгос нь энэ талаар хуримтлуулсан мэдлэг туршлага нэн арвин юм. Энэ хичээлээр оюутнууд дорнын философийн нэрт сэтгэгчдийн талаар болон Солонгосын Чосон династаас өнөөг хүртэлх нийгэм, соёлын талаар авч үзнэ.
3. Орчин цагийн улс төрийн сэтгэлгээ. ХҮІ зууны үеийн нийгмийн хувьсгал ба ХҮІІІ зууны үйлдвэржилтийн хувьсгал зэргийн үр дүн бол өнөөгийн нийгмийн үндсэн дүр төрх юм. Аж үйлдвэржилтийн хувьсгал нь феодалын нийгмээс ангижрах үндсэн хөшүүрэг болох талаар уг хичээлээр авч үздэг.
4. Улс төрийн философи. Платон, Аристотель зэрэг улс төрийн нэрт сэтгэгчидтэй энэ хичээлээр танилцан улс төрийн философийн үндэстэй танилцана.

Харьцуулсан улс төр. Энэ хэсэгт хамаарах дараах хоёр хичээл орж байна. Үүнд:

1. Харьцуулсан улс төрийн систем. Энэ хичээлээр эртний грекийн түүхэн ба философи үеэс хойшхи улс төрийн байгууламж, бүтцийн загваруудыг заадаг. Орчин үеийн ардчиллын онолуудтай уялдуулан янз бүрийн улс төрийн байгуулалд дүн шинжилгээ хийдэг.
2. Харьцуулсан улс төр. Энэ хичээлээр харьцуулалтын арга зүйг ашиглан улс орнуудын улс төрийн байгуулал, соёлын асуудлыг судалдаг. Олон улс орнуудын улс төрийн байгуулал, соёлыг харьцуулсны үндсэн дээр Солонгосын өнөөгийн ба ирээдүйн нөхцөл байдлын загварыг дүрслэх нь энэ хичээлийн үндсэн зорилго юм.

Харьцуулсан улс төрийн чиглэлээр эдгээр хоёр хичээлийг үздэг байна. Улс төрийн шинжлэх ухааны нэгэн биеэ даасан гэж болох салбар бол харьцуулсан улс төр. Харьцуулсан улс төрийн системийн асуудлыг тусад нь бие даасан хичээл болгон судлан үзэж байгаа туршлагыг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Гадаад орнуудын улс төр. Харьцуулсан улс төрийн практик хэсэг гэж болох энэ бүлэгт дараах хичээлүүдийг үзэж судалдаг. Эдгээр нь БНСУ-ын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүдтэй шууд уялдаатай байгааг анзаарна уу.

1. Бүс нутаг судлалын сэдвүүд: Улс төр ба төр засаг. Бүс нутаг судлалын арга зүй, гуравдагч ба дөрөвдөгч ертөнцийн орнуудын талаар авч үзнэ. Энэ хичээл нь түүнчлэн оюутнуудын харьцуулсан улс төрийн практик болж өгөх юм.
2. Японы улс төр ба төр засаг. Япон бол өрнөдийн бус орнуудаас модернизацчилагдах процесс амжилттай явагдсан орны нэг юм. Үүнтэй холбогдуулан Японы улс төрийн байгуулал, соёл, философийг танин мэдэх нь уг хичээлийн зорилго юм.
3. Америкийн улс төр ба төр засаг. Хичээлээр харьцуулсан арга зүйг ашиглан ХХ зууны хамгийн хүчирхэг гүрэн гэгддэг АНУ-ын улс төрийн байгуулал, соёл ба ардчиллын загвар онолуудын талаар авч

үзнэ. Үүнтэй уялдаад оюутнууд ардчиллын тулгамдсан асуудлууд ба орчин үеийн хэлбэрийн талаар танин мэддэг. Түүнчлэн, оюутнууд Солонгосын улс төрийн байгуулал, соёлыг дээшлүүлэхэд оролцох талаар суралцдаг.

4. Хятадын улс төр ба төр засаг. Харьцуулсан улс төрөөр эзэмшсэн онолын хэрэгслүүдийг ашиглан орчин үеийн Хятадын улс төрийн байгуулал, философи, соёл, улс төрийг судлахад энэ хичээлийн зорилго чиглэгдэнэ. Нэгэн цагт зүүн Азийг хамарсан эзэнт гүрэн болж байсантай холбоотойгоор уг хичээлээр Зүүн Азийн улс төрийн нийтлэг соёлын талаар авч үзнэ.
5. Орос ба Дорнод Европын улс төр, төр засаг. Харьцуулсан улс төр хичээлээр олж авсан олон улс орны улс төрийн байгууллыг харьцуулах арга зүйдээ тулгуурлан Орос ба зүүн Европын орнуудын өнөөгийн улс төрийн нөхцөл байдал, улс төрийн соёлын талаар энэ хичээлээр үзнэ. Хуучин социалист орнуудад улс төрийн өөрчлөлт хэрхэн явагдаж байгаа болон улс төрийн соёлын тулгамдсан асуудлуудыг зүүн Европын орнуудын жишээн дээр авч үзэх нь энэ хичээлийн зорилго юм.
6. Умард Солонгосын нийгэм, улс төр. Өмнөд ба Умард Солонгосын хуваагдлын тухай асуудал нь Солонгосын улс төрийн шинжлэх ухааны нэг чухал судлагдахуун юм. Оюутнууд энэ хичээлээр умард Солонгосын улс төрийн нийгмийн чиг үүрэг, байгууламжийн асуудлыг үзэж судлана.

Солонгосын улс төр. Солонгосын улс төрийн дэд салбар буюу дотоод улс төрийн асуудал бол улс төрийн шинжлэх ухааны гол хэсэг байдаг. Улс төрийн шинжлэх ухаанд суралцагч хэн бүхний мэдэх зайлшгүй чухал асуудал бол өөрийн орныхоо улс төр, төр засаг, улс төрийн харилцаа, сэтгэлгээний асуудлыг танин мэдэх явдал юм. Энэ чиглэлд чухал ач холбогдол өгөн нарийвчлан судалдаг болохыг дараах хичээлүүдийн гол агуулгаас харна уу.

1. Солонгосын улс төрийн удиртгал. Энэ хичээлийг Солонгосын улс төрийн онолоор мэргэшиж байгаа оюутнуудад 3 дугаар курсэд заадаг. Солонгосын улс төрийн үндсэн агуулга ба улс төрийн түүхийг заах замаар оюутнуудыг Солонгосын улс төрийн талаар суралцах цаашид судалгаа хийхэд бэлтгэхэд тус хичээл чиглэгдэнэ.
2. Солонгосын улс төр ба төр засаг. Солонгос дахь улс төрийн шинжлэх ухааны сургалт судалгааны хамгийн гол зорилго бол Солонгосын нийгэм, Солонгос оронд ардчилал, хөгжлийг авчрахад оршдог. Энэхүү зорилготой холбоотойгоор, хичээлийн агуулга Солонгосын ардчилал болон ардчиллын онолын үндэсийг хамрана. Мөн орчин үеийн Солонгосын улс төрийн нөхцөл байдалд анализ хийдэг.
3. Солонгосын улс төрийн сэтгэлгээ. Солонгосын улс төр бол солонгосын соёлын түүхэн хөгжлийн бүтээгдэхүүн юм. Өнөөгийн Солонгосын улс төрийг бүрэн гүйцэд танин мэдэхийн тулд оюутнууд уламжлалт улс төрийн сэтгэлгээнд суралцах хэрэгтэй юм.
4. Солонгосын улс төрийн соёл. Энэ нь Солонгосын улс төр ба төр засаг хичээлийн ахисан түвшний хичээл юм. Энэ хичээлээр оюутнууд Солонгосын соёлын өвөрмөц шинжийг судлах замаар Солонгосын нийгмийг танин мэдэхэд анхаарна. Энэ нь Солонгосын улс төрийн шинжлэх ухааны онолын хөгжлийн үндэс суурь болох юм.

Нийтийн захиргаа. Нийтийн захиргаа буюу ихэнх тохиолдолд бидний төрийн удирдлага хэмээн нэрлэж хэвшсэн салбар ухаан улс төрийн шинжлэх ухаанд хамаарагддаг билээ. Тус дэд салбар нь улс төрийн шинжлэх ухаан ба эрх зүйн шинжлэх ухааны зааг дээр байдаг гэж болох юм. Энэ хэсэгт дараах хичээлүүдийг үзэж судалдаг байна. Үүнд:

1. Нийтийн захиргааны удиртгал. Улс төрийн ач холбогдол улам бүр захиргааны чиг хандлага болж буйтай холбоотойгоор энэ хичээлээр оюутнууд захиргааны асуудлыг нарийвчлан судлах юм.
2. Нийтийн захиргааны ажилтны удирдлага. Тус хичээл нь Нийтийн захиргааны удиртгал хичээлийн нэмэлт хичээл юм.
3. Байгууллагын удирдлага, зохион байгуулалт. Энэ бол Нийтийн захиргааны удиртгал хичээлийн ахисан түвшний хичээл юм. Энэхүү гүнзгийрүүлсэн курсээр оюутнууд захиргааны байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар суралцана.
4. Орон нутгийн захиргаа ба улс төр. Ардчиллын хамгийн хөгжсөн загвар бол орон нутгийн бие даасан байдал буюу нутгийн өөрөө удирдах ёсны тухай асуудал юм. Энэ хичээлээр нутгийн өөрөө удирдах ёсны хөгжлийн загваруудын талаар үзнэ. Мөн Солонгосын орон нутгийн бие даасан байдлын голлох хэв маягуудыг судлана.

Улс төрийн үйл явц. Энэ хэсэгт хамаарах дараах хичээлүүд байдаг.

Үүнд:

1. Улс төрийн үйл явц. Захиргаа, парламент, улс төрийн намууд, мэдээлэл зэрэг нь орчин үеийн улс төрийн систем, байгууллын гол төрх болоод байна. Энэ хичээлээр оюутнууд иргэний эрх ба үзэл бодол хэрхэн ардчилсан систем, улс төрийн үйл явцын дүнд системчлэгдэж буй талаар суралцана. Мөн бодлого төлөвлөх үйл явцын талаар авч үзнэ.
2. Улс төрийн нам. Улс төрийн намууд бол орчин цагийн улс төрийн бүтээгдэхүүн юм. Өрнөдийн ардчилсан орнуудын парламентын систем нь улс төрийн намуудын хөгжлийн үр дүн гэж болно. Чухам энэ үзэл онолтой холбоотойгоор оюутнууд тус хичээлээр улс төрийн намын хөгжлийн түүх ба улс төр дэх намуудын үүрэг ролийн талаар үзэж судлана. Түүнчлэн, Солонгосын улс төр, улс төрийн байгуулалд намуудын стратеги хэрхэн уялдаж буй талаар судлах юм.
3. Нийтийн сонголтын онолууд. Улс төрийн нам, улс төрийн үйл явцын хоорондын хамаарал, сонгогчдын үйл байдал, үндэсний аюулгүй байдал зэрэг практик асуудлыг нарийвчлан судлах нь тус хичээлийн зорилго юм.
4. Улс төрийн биехвиор. Биехвиоризм нь 1960-аад оноос улс төрийн шинжлэх ухаанд хүлээн зөвшөөрөгдсөн. Энэ хичээлээр оюутнууд хүмүүсийн улс төрийн үйл байдлаар дамжуулан биехвиоризмыг танин мэдэхэд суралцана.
5. Нийтийн санхүүгийн удирдлага. Улс орнууд эдийн засгийн асуудлуудыг шийдэх сорилттой тулгараад байна. Үүнтэй холбоотойгоор оюутнууд тус хичээлээр улсын төсөв, санхүүг хэрхэн зохицуулах, удирдан зохион байгуулах бодлогыг хэрхэн явуулах талаар суралцдаг.
6. Улс төрийн анализ. Улс төр бол огт хувиршгүй царцанги, үхмэл зүйл биш харин ч амьд динамик организм юм. Энэ хичээл нь 4 дүгээр курсын оюутнуудад зориулагдсан бөгөөд нийгэм улс төрийн үйл явцад оюутнуудыг анализ хийж сургахад хичээлийн зорилго оршино.

Магистр, докторын сургалтын агуулга, онцлог

Улс төрийн шинжлэх ухааны сургалтын дараагийн үе шат бол магистр, докторын түвшний сургалтын агуулгын асуудал юм.

Магистр, докторын шатанд үздэг хичээлүүд нь ерөнхийдөө бакалаврын түвшинд олж авсан оюутны мэдлэг, чадварыг улам гүнзгийрүүлэхэд чиглэхийн зэрэгцээ улс төрийн шинжлэх ухааны практик салбар буюу хавсарга улс төрийн асуудлуудыг нэлээдгүй хамран үзэж судалдаг. Иймээс магистр, докторын шатанд суралцагсадад судалгаанд тулгуурласан сургалтыг явуулахад голлон анхаарах бөгөөд суралцагсад нь улс төрийн шинжлэх ухааны суурь мэдлэг, мэдээллийг зайлшгүй эзэмшсэн байх шаардлагатай байдаг байна. Магистр, докторын түвшинд үздэг хичээлүүдийг бакалаврын түвшинд үздэг хичээлүүдийн ангилалд тулгуурлан дараах байдлаар зааглан тодорхойлж болох юм. Энэ нь мөн албан бус байдлаар ангилсан ангилал болохыг анхаарна уу. Түүнчлэн энэхүү ангилал нь дэд салбаруудад шууд уялдаатай биш юм.

Улс төрийн сэтгэлгээ. Улс төрийн сэтгэлгээний түүхийн асуудал нь улс төр судлалын орчин үеийн тулгамдсан асуудлуудыг түүх, философийн үүднээс нь судлаж үзэх боломжийг энэ хэсгийн хичээлүүд олгож байна. Ингэхдээ өрнө, дорнын улс төрийн мэргэдийн сургаал, номлолыг харьцуулан авч үзсэнээрээ суралцагсад улс төрийн сэтгэлгээний өргөн цар хүрээ бүхий мэдлэг, мэдээлэл эзэмшдэг ажээ.

1. Маркс, Гегелийн улс төрийн сургаал. Оюутнууд энэ хичээлээр орчин үеийн улс төрийн философийн гол чиглэлүүдийн нэг бөгөөд социализм, коммунизмын формацийн гол сургаал болох марксист улс төрийн философитой танилцах юм. Уламжлалт марксист философи нь диалектик үзэл сурталд үндэслэсэн германы философи, социализмын агуулга бүхий францын нийгмийн философи, хөдөлмөрийн үнэт зүйлийг эрхэмлэсэн британийн уламжлалт улс төрийн эдийн засгийн сургууль зэрэгт тулгуурлан боловсрогдсон юм. Марксист үзэл сургаалын дотоод бүтцийн талаар болон Гегелийн философитой Марксын улс төрийн философи хэрхэн холбоотой талаар мөн судалж үзнэ.
2. Улс төрийн сэтгэлгээ. Гоббс, Локк, Руссо, Миллс болон бусад улс төрийн сэтгэгчдээс эхлээд улс төрийн сэтгэгчдийн түүхийг тэдний бичсэн бүтээл зохиолоор дамжуулан энэ хичээлээр үзэж судлана.
3. Дундад зууны улс төрийн сэтгэлгээ. Аврелий Августинээс Макиавелли хүртэлх дундад зууны үеийн баруун Европын улс төрийн сэтгэгчдийн талаар энэ хичээлээр тусгайлан үзэж судлана.
4. Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны семинар. Оюутнууд улс төрийн сэтгэлгээ, улс төрийн философийн мэдлэгээ энэ хичээлээр дээшлүүлнэ.

Улс төрийн онол, арга зүй. Хэдийгээр улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүйн асуудлыг бакалаврын сургалтын шатанд цөөнгүй тооны хичээлээр дамжуулан дэлгэрэнгүй үзэж судалдаг боловч магистр, докторын түвшинд ч онол, судалгааны арга зүйн асуудлыг ахисан түвшинд үргэлжлүүлэн судлах зайлшгүй шаардлагатай байдаг. Энэ шаардлага, хэрэгцээг дараах хичээлүүдийн агуулгыг эзэмшүүлэх замаар бүрдүүлж өгдөг байна.

1. Улс төрийн институтын онол. Нео-институциональ хандлагын хүрээнд системийн гарал үүсэл, үр нөлөө, тогтвортой байдал зэрэг асуудлыг авч үзнэ. Нео-институциональ онолын арга зүйд анализ хийнэ.

2. Улс төрийн шинжлэх ухааны арга, цар хүрээ. Улс төрийн шинжлэх ухааны судалгааны янз бүрийн аргуудыг харьцуулан авч үзнэ. Тухайлбал, статистик анализ, хайгуул судалгааны арга техникийн талаар нарийвчлан авч үзнэ.
3. Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны сэдвүүд. Дэлхийн II дайны дараах улс төрийн гол гол онолуудыг авч үзнэ. Гол сэдэв бол гуравдагч ертөнцийн орнуудын ардчилал ба нео-консерватизмын асуудал юм.
4. Улс төрийн засаглалын онол. Парето, Михельс нараас Далийн полиарх хүртэлх улс төрийн засаглалын уламжлалт онолыг судлана.
5. Төрийн онол судлал. Төрийн хэв шинжийн боломжит чиг үүргүүдийн талаар авч үзнэ. Марксист, бюрократ, плюралист төрийн онолуудын талаар мөн авч үзнэ.
6. Орчин үеийн улс төрийн философи. Франц, Англи, Америкийн өнөөгийн нөхцөл байдалтай философийн шинэ чиг хандлагуудыг холбон авч үзнэ.
7. Орчин үеийн улс төрийн онол. Энэ хичээлээр оюутнууд АНУ ба Оросын хоёр туйлт ертөнц хэрхэн цэрэг эдийн засгийн өрсөлдөөнд голлох үүрэг рольтой хэвээр байгаа асуудлыг судлана.

Олон улсын бодлого, орон судлал. Бакалаврын шатанд гадаад орнуудын улс төр, төрийн тогтолцооны талаар болон харьцуулсан улс төрийн онол, арга зүйн хэсгээр үзсэнээ гүнзгийрүүлэн судлах боломжийг энэ бүлгийн хичээлүүд олгодог байна.

1. Японы улс төр. Эдийн засгийн хувьд дэлхийн супер гүрэн болсон Японы амжилтын шалтгааныг олохын тулд оюутнууд энэ хичээлээр хоёр үед анхаарлаа хандуулан судлана. Энэ нь дэлхийн II дайны өмнөх ба дараах үеийн Мейжийн засаглалын үе юм.
2. Хятадын улс төр. Хятадын улс төр, улс төрийн соёлын асуудлыг хятадын гол сонгодог бүтээлүүдтэй танилцах үндсэн дээр судлана.
3. Баруун Европын улс төр. АНУ ба бусад өрнөдийн орнуудын өнөөгийн улс төрийн нөхцөл байдалд анализ хийн, дэлхийн улс төрийн чиг хандлагыг танин мэдэхэд энэ хичээл туслана.
4. Умард Солонгосын улс төр. Энэ хичээлээр оюутнууд харьцуулсан улс төрийн аргуудыг ашиглан Умард Солонгосын төвлөрсөн улс төрийн байгуулал, засаглал, үйл явц, үзэл суртлын талаар судлана. Энэ хичээлийн гол сэдвүүд нь Умард Солонгосын улс төрийн философид тулгуурласан улс төрийн үйл явц, гэр бүл төвт корпоратизм, Чучхе философи, болон национализм зэрэг юм.
5. Олон улсын улс төрийн систем ба үйл явц. Энэ хичээлээр олон улсын харилцаа, бодлогод хамгийн чухал нөлөө бүхий зөрчил, мөргөлдөөн, дайн зэрэг асуудлыг шийдвэрлэх хувилбаруудын талаар суралцана. Тухайлбал, хоёр Солонгосын зөрчлийн талаар авч үзнэ.
6. Улс төрийн хөгжил судлал. Зүүн Азийн орнууд тухайлбал, Хятад, Япон, Солонгосын улс төрийн хөгжлийг харьцуулан авч үзнэ. Мөн энэ бүс нутгийн орнуудын улс төрийн хөгжлийн стратегийг гүнзгийрүүлэн судлана.
7. Харьцуулсан улс төрийн бодлого судлал. Олон улсын хамтын ажиллагаа болон хоёр талт харьцуулалтын талаар энэ хичээлээр үзнэ. Түүнчлэн, өрнөдийн улс төрийн байгуулал дахь Европын халамжлагдсан улс үндэстэн, корпоративизм, нео-консерватизм, реформацийн зөрчлүүдийн талаар мөн судлана.

Дотоод улс төр. Дотоод улс төрийн асуудлаар мэргэшиж буй суралцагсадын үздэг дараах хичээлүүд нь өөрийн орны улс төрийн үйл явцад дүн шинжилгээ хийх чадвар давхар эзэмших бололцоо олгодгоороо улс төрийн үйл явцын бүлэг хичээлүүдтэй нягт уялдаатай байдаг.

1. Солонгосын улс төрийн сэтгэлгээ судлал. Орчин үеийн Солонгосын улс төрийн сэтгэлгээний асуудлыг улс төрийн бодлоготой холбон авч үзнэ.
2. Солонгосын улс төр. Орчин үеийн Солонгосын түүх нь Солонгосын либералчлалаас эхэлсэн 3 жил ба анхдугаар бүгд найрамдах улсыг байгуулсны дараах үе гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваагддаг. Үүнээс уялдаад Солонгосын улс төрийн нэгдсэн хэв шинжид анализ хийнэ.

Улс төрийн институт, улс төрийн үйл явц. Нийгмийн харилцааг удирдан зохицуулах үүрэг, роль бүхий улс төрийн институтууд, улс төрийн үйл явцтай холбогдох асуудлуудыг нарийвчлан судлах, улмаар улс төрийн анализ хийж сурахад мэргэшихэд нь энэ бүлгийн хичээлүүдийн агуулга чиглэгдэж байгаа юм.

1. Улс төрийн үйл байдал судлал. Ардчилсан үйл явц, санал өгөх, улс төрийн соёл, сонгууль зэргийн үеэр иргэдийн улс төрийн үйл байдал, идэвхитэй оролцоо ямар байгааг судлах нь энэ хичээлийн зорилго болно. Ингэхдээ оюутнууд тоон судалгааны арга зүй, шинжилгээтэй давхар танилцах юм.
2. Улс төрийн үйл явц судлал. Улс төрийн байгууллын динамизмын шалтгааныг танин мэдэхийн тулд оюутнууд энэ хичээлээр сонгууль, сонирхлын бүлгийн бүрдэлжилт, бодлого төлөвлөх процесс зэрэг асуудлуудад анализ хийнэ.
3. Парламентын бодлогын семинар. Энэ хичээлээр дэлхийн улс орнуудын голлох намын систем ба парламентын системийн асуудлыг харьцуулан судлана. Түүнчлэн, парламентын системүүд, үйл явц, бодлого төлөвлөлт, гүйцэтгэх засаглалын хяналт, болон Баруун Европын орнууд ба АНУ дахь улс төрийн системийн бусад үйл ажиллагааны талаар үзнэ.
4. Улс төр ба дипломат ёс. “Үндэсний эрх ашиг”-ийг шинжилгээний арга хэрэгсэл болгон Солонгосын өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан олон улсын харилцааны онолтой холбогдуулан дипломат хүчин зүйл тохиолдлуудад дүн шинжилгээ хийхэд хичээлийн агуулга оршино.
5. Нийтийн сонголтын онолын семинар. Судалгаанд холбогдолтой мэдээлэл цуглуулах, нийгмийн байгууллагуудын үйл байдал, улс төрийн оролцоо, сонгуулийн судалгааны дүнд анализ хийхэд суралцана.

Улс төрийн шинжлэх ухааны тэнхимийн сургалт, заагддаг хичээлүүдийн ерөнхий дүр төрхийг харуулахад ийм байдалтай байна. Тус тэнхим дэх дэд салбаруудын бүтэц нь ерөнхийдөө МУИС-ийн улс төр судлалын тэнхим дэх дэд салбаруудтай ижил төстэй байдал харагдаж байгаа юм. Харин магистр, докторын түвшинд заагддаг хичээлүүд манай тэнхимд заагддагаас тооны хувьд болон салбар чиглэлүүдийг хамрах хүрээний хувьд илүү өргөн агуулгатай бөгөөд сонголт арвинтай байгаа юм. Иймээс бакалаврын дараах түвшний сургалтанд, ялангуяа, хичээлийн сонголт, суралцагсдын нарийн мэргэших боломжийг хангалттай гаргаж өгөх тал дээр цаашид анхаарвал зүйтэй санагдана.

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Ухааны Факультет, Оюутны гарын авлага (оюутнуудад зориулав), Улаанбаатар, 2001.

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Ухааны Факультет, Магистр докторын сургалтын гарын авлага, Улаанбаатар, 2002.

Institute of Higher Education, Shanghai Jiao Tong University, Academic Ranking of World Universities 2005, URL: <<http://ed.sjtu.edu.cn/rank/2005/ARWU2005TopAsia.htm>>.

Park, Chan Wook, Political Science in Korea, in *Political Science in Asia*, Volume I No.1, Winter, 2005.

Seoul National University, Political Science Department Curriculum in brief.

Seoul National University.Bulletin 2004-2005.

НИЙТЛЭЛИЙН ШААРДЛАГА, СТАНДАРТ

Эрдэмтэд, судлаачид Та бүхнийг Политологи сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, илтгэл, шүүмж өгүүлэл зэргээ нийтлүүлэхийг урьж байна.

Сэтгүүлийн зөвлөл нь тухайн бүтээлийг зөвхөн зохиогчийн зөвшөөрлийн дагуу албан ёсоор хүлээн авсны дараа сэтгүүлийн агуулга, зорилгод нийцүүлэн сонгон шалгаруулж нийтлэнэ.

Бүтээлээ ирүүлэхдээ хэвлэмэл 1 хувийг сэтгүүлийн хаягаар, түүнчлэн электрон файлаар ccpr@num.edu.mn хаяг руу хавсаргах шаардлагатай.

Бүтээлд тавигдах шаардлага:

- Сэтгүүлд ирүүлэх бүтээл нь урьд өмнө хэвлэгдээгүй байх
- Бүтээлийн хураангуй нь 150-иас ихгүй үгтэй байх ба монгол, орос, англи хэлний аль нэг дээр байх.
- Бусдын бүтээлээс текст, зураг, график зэргийг ашигласан бол эх сурвалжийг тодорхой дурьдах
- Бүтээлийн өмнө зохиогчийн нэр, эрдмийн зэрэг, цол, эрхэлж буй ажил, ажлын газар, бүтээлийн гарчиг зэргийг бичих

Сэтгүүлд нийтлэгдэх бүтээлтэй холбоотой аливаа асуудлыг
зохиогч өөрөө хариуцна.

Сэтгүүлийн зөвлөл

ПОЛИТОЛОГИ III

Улаанбаатар хот, Залуучуудын өргөн чөлөө
МУИС-ийн хичээлийн II байр
Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Улс төр судлалын тэнхим
Орчин үеийн улс төрийн судалгааны төв

Утас: 312659, 318641
Факс: 976-11- 328890

©2007 CCPR